

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 14 (201)

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Хөтөлбөр батлах тухай*
- *Олон улсын хурал зохион байгуулах тухай*
- *Малын гоц халдварт өвчний цагийн байдалтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай*

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ:

- *Улсын Их Хурал Үндсэн хуульд тайлбар хийсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн зарим заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2001 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2001 оны дөрөвдүгээр сарын 13 №14 (201)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

168. Хөтөлбөр батлах тухай Дугаар 26 355

169. Үйлдвэр худалдааны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх тухай Дугаар 27 365

170. Байгаль орчны яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх тухай Дугаар 29 370

171. Олон улсын хурал зохион байгуулах тухай Дугаар 30 378

172. Нэмэлт арга хэмжээ авах тухай Дугаар 32 378

173. Малын гоц халдварт өвчний цагийн байдалтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Дугаар 33 379

174. Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын 2001 оны төсөвт зардлыг батлах тухай Дугаар 34 380

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

175. Улсын Их Хурал Үндсэн хуульд тайлбар хийсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн зарим заалтуудыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай Дугаар 01 381

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 2 дугаар сарын 11-ний өдөр **Дугаар 26** **Улаанбаатар хот**

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Ноос" дэд хөтөлбөрийг 1 дүгээр, хөтөлбөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээг 2 дугаар хавсралт ёсоор батлуулсугай.

2. "Ноос" дэд хөтөлбөрийн зорилтын биелэлтийг ханган, үр дүнг жил бүрийн 1 дүгээр сарын 15-ны дотор Засгийн газарт тайлагнаж байхыг Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзоригт үүрэг болгосугай.

3. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг 2002 оноос эхлэн жил бүр улсын төвлөрсөн төсвөөс гаргах, үйлдвэр, аж ахуйн нэгжийн үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтын төслийг гадаад орон, олон улсын зээл, тусламжид хамруулахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД **Ч.ГАНЗОРИГ**

Засгийн газрын 2001 оны 26 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

"НООС" ДЭД ХӨТӨЛБӨР

Нэг. Ноос боловсруулах салбарын өнөөгийн байдал

а/ Түүхий эдийн нөөц

Манай улс нь 1999 оны дүнгээр 25.7 мянган тонн ноосон түүхий эдийн нөөцтэй байна. Үүнээс 17.8 мянган тонн буюу 69.2 хувийг хонины ноос, 1.7 мянган тонн буюу 6.8 хувийг тэмээний ноос, 2.7 тонн буюу 0.01 хувийг ямааны ноос, 2.5 мянган тонн буюу 9.8 хувийг ямааны хялгас, 420 тонн буюу 1.6 хувийг сарлагийн хөвөвр, 350 тонн буюу 1.4 хувийг сарлагийн хялгас, 35 тонн буюу 0.13 хувийг сарлагийн сүүл, 790.8 тонн буюу 3.2 хувийг адууны хөвөвр, 63.2 тонн буюу 0.2 хувийг адууны сүүл, 3.8 мянган тонн буюу 3.9 хувийг адууны дэл, 956 тонн буюу 3.7 хувийг үхрийн хөвөвр эзэлж байна.

Хонины ноосны 1.2 хувь буюу 208.8 тонн нь нарийн, нарийвтар ноос, 18.9 хувь буюу 3375 тонн нь нутгийн шилмэл үүлдэр, омгийн хонины ноос, 79.9 хувь буюу 14250.1 тонн нь монгол хонины ноос байна.

Нарийн, нарийвтар ноост хонины тоо 1999 онд 1990 онтой харьцуулахад 64.5 хувиар буурч, 55.1 мянган толгой болжээ.

1999 онд түүхий эдийн экспорт 1989 оныхоос 32.7 хувиар өсч, үйлдвэрлэлд ашигласан түүхий эдийн хэмжээ 17.5 хувиар буурсан байна.

Сүүлийн жилүүдэд ямааны ноос, хялгас, адуу, үхэр, сарлагийн хөвөрийг үйлдвэрлэлд ашиглах явдал бүрэн зогсож, арьс шир боловсруулах үйлдвэрээс гарсан ноос, үс хаягдах боллоо.

б/ Хүч чадлын ашиглалт

Ноос боловсруулах салбарт 1989 онд 13 үйлдвэр ажиллаж, жилдээ 15 мянган тонн хонины ноос боловсруулан 10 мянган тонн угаасан ноос, 5 мянган тонн ээрмэл, 2.5 сая хавтгай дөрвөлжин метр хивс, 1.3 сая ширхэг сүлжмэл, 650 мянган метр эсгий, 600 орчим мянган хос эсгий гутал үйлдвэрлэж, 1.9 сая хавтгай дөрвөлжин метр хивс болон төрөл бүрийн ноосон эдлэл экспортолж байсан бол 2000 он гэхэд угаасан ноосны үйлдвэрлэл 84.3, эсгий гутлын үйлдвэрлэл 37.9 хувиар бууралд байна.

Тус салбарт 1989 оноос хойш тодорхой хөрөнгө оруулалт хийгдээгүй ч Эрдэнэт хивс, Улаанбаатар хивс, Ээрмэл зэрэг зарим хувьцаат компануид өөрийн хөрөнгөөр угаах жижиг цехийг үйлдвэрийнхээ дэргэд байгуулснаар ноос угаах хүч чадал 1999 онд 1989 оныхоос 2.3 хувиар өсжээ.

1999 оны байдлаар ноос боловсруулах салбарт угаах чиглэлийн 3 цех, 3 үйлдвэр, ээрэх чиглэлийн 1 үйлдвэр, 4 цех, хивсний 3 үйлдвэр, ноосон нэхмэлийн 1 үйлдвэр, эсгий, эсгий гутлын 2 үйлдвэр, орон нутагт 30 гаруй цех, нэхээсгүй эдлэлийн 1 үйлдвэр байна.

Улаанбаатар хивс, Эрдэнэт хивс ХК-уудаас бусад үйлдвэрүүд хүч чадлын 10 хүрэхгүй хувийг ашиглаж, ноосон нэхмэлийн үйлдвэрлэл зогссон ба сүлжмэлийн үйлдвэр өөрийн зориулалтыг өөрчлөн зөөлөн оёдлын үйлдвэр эрхэлж байна.

в/ Салбарын өрсөлдөх чадвар

Технологийн дамжлагаар өөр хоорондоо холбоотой үйлдвэрүүдийг салган хувьчилсан нь салбарын үйл ажиллагааны цогцолбор байдлыг алдагдуулж, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын цэгцтэй бодлогыг төлөвлөн хэрэгжүүлэхэд хүндрэл учруулсаар байна.

Хөрш зэргэлдээ орнууд Монгол улсаас экспортолж буй ноосон бүтээгдэхүүнд 50-иас дээш хувийн гаалийн татвар тогтоосон нь салбарын бүтээгдэхүүний зах зээл хумигдах нэг гол шалтгаан болж байна.

Ноосон бүтээгдэхүүнийг Европ, Азийн бусад орнуудын зах зээлд борлуулах боломж

байгаа боловч бүтээгдэхүүний чанар олон улсын стандартын шаардлагад нийцэхгүй, нэр төрөл цөөн байгаа нь экспортод саад болсоор байна.

Ноос боловсруулах үйлдвэрүүдийн бүтээгдэхүүний үнэ хэт өндөр, хүн амын худалдан авах чадвар, амьжиргааны түвшин доогуур байгаагаас шалтгаалан дотоодын үйлдвэрүүдийн бүтээгдэхүүний борлуулалт, хөрөнгийн эргэлт удаан байна.

Түүнчлэн урьд өмнө үүссэн өр авлага салбарын үйлдвэрүүдийн санхүү, эдийн засгийн чадавхи доройтоход хүргэж байна.

Монгол хонины ноос нь бусад орны ижил төрлийн ноостой харьцуулахад ширүүн, бүдүүн, хялгас үс ихтэй тул манай оронд хивс, эсгий, эсгий гутал, нэхээсгүй эдлэл, ноосон цэмбэний үйлдвэрлэлийг дэмжин хөгжүүлэх нь илүү оновчтой.

Сүүлийн жилүүдэд дотоодын үйлдвэрүүдэд үйлдвэрлэдэг ижил төрлийн импортын барааны татварыг тэглэх буюу бууруулах бодлого явуулснаар дотоодын захаа эзэлийг импортын бараа эзлэх болж, хивсний үйлдвэрлэл 4 дахин буурахад хүрээд байна.

1989 онд жилдээ 649.7 мянган метр эсгий, 592.3 мянган хос эсгий гутал үйлдвэрлэж хүн амын хэрэгцээнд нийлүүлж байсан бол 1999 он гэхэд эсгийний үйлдвэрлэл 84.3, эсгий гутлын үйлдвэрлэл 97.9 хувиар буурсан байна.

2000 онд эсгийний үйлдвэрлэл 1999 оныхоос 10.4, эсгий гутлын үйлдвэрлэл 65.0 хувиар өссөнөөс үзэхэд дотоодын захаа эзэлд эсгий бүтээгдэхүүний багагүй хэрэгцээ байна.

Хоёр. Ноос боловсруулах салбарын эрхэм зорилго, хөгжлийн стратеги

Ноос боловсруулах салбарын эрхэм зорилго нь шинжлэх ухаан, техникийн ололт, амжилтад тулгуурлан монгол малын ноосон түүхий эдийг түүний нөөцтэй уялдуулж үр ашигтай, оновчтой аргаар боловсруулан бүтээгдэхүүний чанарыг олон улсын захаа эзэлийн хэрэгцээнд нийцүүлж, өрсөлдөх чадварыг сайжруулах замаар салбарын тогтвортой өсөлтийг хангахад оршино.

Ноос боловсруулах салбарын хөгжлийн стратеги нь дараахь үндсэн хоёр чиглэлээс тогтоно:

а/стратегийн зорилтоор хөгжүүлэх үйлдвэр;

б/захаа эзэлийн зорилтоор хөгжүүлэх үйлдвэр.

Хонь, тэмээний ноос, сарлагийн хөвөрөөр хийсэн нэхмэл, сүлжмэл эдлэл, хивс, эсгий, нэхээсгүй эдлэлийн үйлдвэрлэлийг стратегийн зорилтоор хөгжүүлэх үйлдвэр.

Адуу, ухрийн дэл, сүүл, хялгас, ямааны ноосоор хийсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг захаа эзэлийн зорилтоор хөгжүүлэх үйлдвэр гэх тус тус үзнэ.

Гурав. Хөтөлбөрийг боловсруулах үндэслэл

1. Хөтөлбөрийг боловсруулах үндэслэл нь

а/Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр;

б/Монгол Улсын Засгийн газрын 1998 оны 157 дугаар тогтоолоор батлсан "Аж үйлдвэрийг сэргээх, хөгжүүлэх бодлого"-ын 2 дугаар хэсгийн 3 дугаар заалт болно.

Дөрөв. Хөтөлбөрийн зорилго, зорилт

2. Хөтөлбөрийн зорилго нь ноос боловсруулах салбарын эрхэм зорилго, хөгжлийн стратегийн үндсэн чиглэлтэй уялдуулан үйлдвэрүүдийн хүч чадлын ашиглалтыг сайжруулах замаар салбарын үр ашиг, өрсөлдөх чадварыг дээшлүүлэхэд оршино.

3. Хөтөлбөрийн зорилгыг хэрэгжүүлэх хүрээнд дараахь зорилтуудыг шийдвэрлэнэ:

а/түүхий эд бэлтгэлийн нэгдсэн системийг зах зээлийн нөхцөлд зохицуулан зохион байгуулж, бэлтгэн нийлүүлэгч, үйлдвэрлэгчдийн аль алинд нь зохимжтой, түүхий эдийн экспортыг бууруулах, орон нутгийн захиргааны байгууллагын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах;

б/үйлдвэрүүдийн санхүү, эдийн засгийн чадавхийг сайжруулж, тогтвортой ажиллагааг хангах;

в/салбарын үйлдвэрүүдийн хүч чадлын ашиглалтыг дээшлүүлж, үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх;

г/бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг сайжруулж, зах зээлийг өргөжүүлэх.

Тав.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд баримтлах үндсэн зарчим

4.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үндсэн зарчим нь төр, салбарын мэрэжлийн холбоод, төрийн бус засад байгууллага, үйлдвэр, аж ахуйн нэгж, бизнес эрхлэгчдийн хамтын ажиллагааны нэгдэл болно.

5.Үйлдвэрлэл хөгжүүлэх бодлогыг түүхий эдийн нөөцийн ашиглалттай дараахь чиглэлээр уялдуулах бодлого баримтална:

а/нарийн, нарийвтар ноост хонины одоо байгаа цөм сүргийг хадгалан хонины ноосны чанарыг сайжруулахад ашиглах;

б/нутгийн шилмэл үүлдэр, омгийн хонь, монгол хонины ноосыг хивс, эсгий, эсгий гутал, нэхээсгүй эдлэлийн үйлдвэрлэлд түлхүү ашиглах чиглэл баримтлах;

в/Дорнод, Хэнтий, Сүхбаатар зэрэг зүүн 3 аймгийн хонины ноосыг орчин үеийн дэвшилтэт аргад тулгуурлан боловсруулж, түүхий эдийн чанарыг сайжруулах;

г/Шинжлэх ухаан, технологийн олөлтод тулгуурлан тэмээний ноосны боловсруулалтын түвшинг дээшлүүлж, зах зээлийн шаардлага хангасан бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах;

д/бод, бог малын хөвөр, хялгас, бусад төрлийн ашиглагдаагүй түүхий эдийг ашиглах, түүнийг боловсруулах шинэ технологи бий болгох.

Зургаа.Хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээ

6. Хөтөлбөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээг хавсралтаар үзүүлэв.

7. Хөтөлбөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээ нь хөтөлбөрийн нэг ба хоёдугаар үе шатны зорилтыг хэрэгжүүлэхэд чиглэж байгаа бөгөөд гуравдугаар шатны зорилтыг тухайн үеийн нөхцөлд тохируулан боловсруулж, арга хэмжээг тодотгох замаар хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийг хангана.

Долоо.Хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт, хяналт

8. Хөтөлбөрийн зорилтын хэрэгжилтийг хангах арга хэмжээг Монгол улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, улсын төсөвт жил бүр тусгах замаар Үйлдвэр, худалдааны сайдын удирдлагын дор зохион байгуулна.

9. Хөтөлбөрт заасан арга хэмжээг холбогдох яам, байгууллагын удирдах хүмүүс хариуцан хэрэгжүүлэх ба биелэлтэд Үйлдвэр, худалдааны сайд хяналт тавина.

10. Үйлдвэр, худалдааны сайд нь хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний биелэлтийг холбогдох байгууллагуудаас улирал тутам авч, нэгтгэн үр дүнг жил бүрийн 1 дүгээр сард Засгийн газарт тайлагнана.

11. Хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах зорилгоор Үйлдвэр, худалдааны сайд нь холбогдох байгууллагын төлөөлөгчид оролцуулсан ажлын хэсэг байгуулан ажиллаж болно.

Найм.Хөтөлбөрийн санхүүжилт

12. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд дор дурдсан санхүүгийн эх үүсвэрийг ашиглана:

а/улсын төсөв;

б/орон нутгийн төсөв;

в/гадаад орон, олон улсын байгууллагын зээл, тусламж;

г/үйлдвэр, аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн өөрийн хөрөнгө;

д/бусад.

Ес.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

13. Хөтөлбөрийг 2001-2010 онуудад дараахь үе шаттайгаар хэрэгжүүлнэ:

Нэгдүгээр үе шат. 2001-2002 он. Салбарын тулгамдсан асуудлыг шийдвэрлэх, үйлдвэрлэлээ хэвийн өсөлттэй явуулах нөхцөлийг бүрдүүлэх, өрсөлдөх чадварыг сайжруулах арга хэмжээг хэрэгжүүлж эхлэх.

Хоёрдугаар үе шат. 2003-2004. Салбарын үйлдвэрүүдийн хүч чадлын ашиглалтыг дээшлүүлж, бүтээгдэхүүний үйлдвэрлэл, экспортыг тогтвортой нэмэгдүүлэх.

Гуравдугаар үе шат. 2005-2010. Ноосон түүхий эдийн нөөцийг бүрэн ашиглах, шинээр бий болсон технологийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх арга хэмжээ авч салбарын хөгжлийн стратегийн үндсэн зорилтыг хангах.

Арав.Хөтөлбөрийг хэрэгжүүлснээс гарах үр дүн

14. Хөтөлбөрийн нэг ба хоёрдугаар шатны зорилтыг хэрэгжүүлснээр дараахь үр дүнд гарна:

а/ноос боловсруулах салбарын бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2004 он гэхэд 1999 оныхоос дунджаар 25 хувиар өснө;

б/ноосон бүтээгдэхүүний экспорт 1999 оныхоос 63.4, улсын нийт экспортод тус салбарын бүтээгдэхүүний эзлэх хувь 4.7 хувиар тус тус нэмэгдэнэ;

в/түүхий эдийн боловсруулалтын түвшин сайжирч эцсийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл 1999 оныхоос 18.8 хувиар өснө;

г/үйлдвэрүүдийн хүч чадлын ашиглалт 1999 оныхоос 43.1 хувиар өсөж, ажлын байр нэмэгдэн ажилгүйдэл буурна.

15.Хөтөлбөрийн гуравдугаар шатны зорилтыг хэрэгжүүлснээр:

а/улсын хэмжээнд байгаа түүхий эдийн нөөцийн ашиглалт 2010 он гэхэд 2000 оныхоос 29.5 хувиар өснө;

б/ашиглагдаагүй байгаа түүхий эдийг боловсруулах шинэ технологи бий болж, салбарын үйлдвэрүүд хүч чадлаа бүрэн ашиглах нөхцөл бүрдэнэ.

"НООС" ДЭД ХӨТӨЛБӨРӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Д/д	Зорилт	Арга хэмжээ	Хугацаа	Санхүүжилт					Хариуцах, хянапт тавих байгууллага
				сая төгрөг				Эх үүсвэр	
				2002	2003	2004	ДҮН		
1	Түүхий эд бэлтгэлийн нэгдсэн системийг зах зээлийн нөхцөлд зохицуулан зохион байгуулж, бэлтгэн нийлүүлэгч, үйлдвэрлэгчдийн аль алинд нь зохимжтой, түүхий эдийн экспортыг бүрдүүлэх, орон нутгийн захиргааны байгууллагын үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээ авах.	1/ Түүхий эдийн бэлтгэлийн нөөцийн мэдээг ноосны төрөл, ангилал, чанар, үнийн үзүүлэлтээр аймаг, сум бүрээр сар бүр гаргаж, мэдээллийн сүлжээнд оруулах, байнгын товхимол хэвлэн гаргах, радио, телевизээр сурталчлах, үйлдвэрлэгч, хэрэглэгчийг мэдээллээр тогтмол хангах.	2002-2004	3.59	3.59	3.59	10.77	Улсын төсөв	ҮХЯ, ХХААЯ, Үндэсний статистикийн газар
		2/ Түүхий эд хүлээн авах төвлөрсөн цэгийг Улаанбаатар хот, Орхон, Баян-Өлгий аймгуудад Монноос, Улаанбаатар хивс, Эрдэнэт хивс, Дорнод ноос, Хэрлэн хивс, Нэхээсгүй эдлэл, Эсгий гутал ХК-уудыг түшиглэн байгуулж, байнгын ажиллагаатай болгох.	2002-2004	-	-	-	-	-	Тухайн үйлдвэр, аж ахуйн газрууд
		3/ Улаанбаатар хотын "Цайз" болон аймгийн төвүүд дэх захын үйл ажиллагаат биржийн хэлбэрт оруулах асуудлыг судалж, боөний худалдааны сүлжээ байгуулах асуудалд түсган хэрэгжүүлэх.	2001-2004	-	-	-	-	-	ҮХЯ, аймаг,нийслэлийн Засаг дарга
		4/ Хонины ноосыг газар дээр нь хүлээн авах нэгжийг аймаг, сумдад байгуулах, тэдгээрийн үйл ажиллагаат үйлдвэр, аж ахуйн нэгжтэй холбох, стандартын шаардлага хангасан түүхий эдээ үйлдвэрт өгөөн малчин, хоршоо, аж ахуйн нэгжийг урамшуулах эдийн засгийн механизмыг бүрдүүлж, хэрэгжүүлэх.	2003-2004	-	-	-	-	-	ҮХЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга, үйлдвэр, аж ахуйн газрууд
		5/ Түүхий эд, бэлтгэлийн чанарыг сайжруулах зорилгоор дор дурдсан стандартыг дахин хянаж, боловсронгуй болгох:							
		а/ Сартуул, Үзэмчин, Барга болон бусад нутгийн шилмэл үүлдэр, омог, хэсгийн хонины стандарт;	2001-2004	1.95	1.95	-	3.9	Улсын төсөв	ХХААЯ
		б/ Нарийн, нарийвтар ноост хонины стандарт;	2001-2004	-	3.25	3.25	6.5	Улсын төсөв	ХХААЯ

		в/ Хонины бүх төрөл нөөсны бэлтгэлийн стандарт.	2004	-	-	2.3	2.3	Үлсын төсөв	ХХААБҮ УХЯ
		б/ Түүхий эдийн чанарт тордолт хийх арга амилгаганд маягчид, бэлтгэн нийлүүлэгчийг сургах үзүүлэх сургалт зохион байгуулах.	2002-2004	1.34	0.4	0.4	2.14	Үлсын төсөв	УХЯ, Монголын нөөс, ноолуурын холбоо
		7/ Малд лак тооны будагаар тавихаас гарах хор хохирол, эдийн засгийн алдагдлыг малчдад ойлгуулах суртачилгаг зохион байгуулах.	2001-2004	-				-	Монголын нөөс, ноолуурын холбоо
		в/ Малд тэмдэг тавих тусгай зориулалтын будгийг зах зээлээс олж, нийлүүлэхэд дэмжлэг үзүүлэх.	2001-2004	-				-	ГХОГХА, МХАҮТ
2	Үйлдвэрүүдийн санхүү, эдийн засгийн чадавхийг сайжруулж, төгөөртэй ажиллагаг хэлгах	1/ Хивсний үйлдвэрүүдийн Австрийн ерийн асуудлыг шийдвэртэх.	2001	-				-	УХЯ, СЭЗЯ, Худалдаа хөгжлийн банк
		2/ Зарим үйлдвэрүүдэд түүхий эдээ бэлтгэхэд нь санхүү, зээлийн дэмжлэг үзүүлэх.	2001-2004	"Түүхий эдийн сан" байгуулах тухай Засгийн газрын тогтоолын төвлөд зээлийн тоон хэмжээг тооцож тусгасан болно.				Хөнгөлөлтэй зээл	УХЯ, СЭЗЯ, Монгол Банк
		3/ Дотоодын үйлдвэрүүдийн зах зээлийг хамгаалах, экспортыг нэмэгдүүлэх зорилгоор дараахь чиглэлээр холбогдох хуулийн төслийн санал боловсруулж шийдвэрүүлэх:							
		а/ экспортод гарч буй үзэсгэн нөөсыг хүн амын орлогын албан татварын дүнд суутгалаас чөлөөлөх;	2001	-				-	УХЯ, СЭЗЯ
		б/ хивс, хивсэнцэр, эсгий, зулхай, дэвсгэр зэрэг дотоодын үйлдвэрүүдэд үйлдвэрлэдэг ижил төрлийн импортын бүтээгдэхүүнд 30 хувийн гаалийн татвар тогтоох.	2001	-				-	УХЯ, СЭЗЯ
		в/ химийн мэндэс, олоон болон хөвөн утас, нөөс боловсруулах зориулалт бүхий будаг, химийн материалыг гаалийн татварааас чөлөөлөх.	2001	-				-	УХЯ, СЭЗЯ
3	Үйлдвэрүүдийн хүч чадлын ашиглалтыг дэмжлэгүүлэх, үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх.	1/ Хэрлэн хивс ХК-ийн түүхий эдийн чанарыг сайжруулах, бүтээгдэхүүний нэр төрлийг олшруулах зэмээр үйл ажиллагаат нь сэргээх.	2001-2004	973.9	779.1	194.8	1947.8	Хөнгөлөлтэй зээл	УХЯ, Худалдаа хөгжлийн банк

		2/ Нэхэгсүй эдлэл, Эрдэнэт хивс ХК-ийн үгаах цехийг ерөнхий.	2002-2004			-		ерөнхий хэрэнте	Нэхэгсүй эдлэл, Эрдэнэт хивс ХК, УХЯ, СЭЗЯ, Ариунжаны банк
		3/ Эрдэнэт хивс ХК-ийн будгийн цехийн тоног төхөөрөмжийг шинэчлэх	2003	-	319.3	-	319.3	Хөнгөлөлттэй зээл	УХЯ, СЭЗЯ, Ариунжаны банк
		4/ Эрмэл ХК-ийн самнах цехийн тоног төхөөрөмжийг шинэчлэх	2002-2004			-		ерөнхий хэрэнте	Эрмэл ХК
		5/ Эрмэл ХК-ийн тэмээний ноосон зэрмэлийн шугамыг тосе үйлдвэрлэх чиглэлээр ерөнтөх	2003-2004	-	986.8	986.7	1973.5	Хөнгөлөлттэй зээл	УХЯ, СЭЗЯ, Ариунжаны банк
		6/ Өөнө дүгуу бэлтгэдэг үйлдвэрүүдийн асуудлыг судалж, шийдвэрлэх.	2001-2004			-		-	УХЯ, Төрийн өмчийн хороо
4	Бүтээгдэхүүний ерөөлдөх чадварыг сайжруулах зах зээлийн ерөнхүүлэх	1/ Түүхий эд, бүтээгдэхүүний чанарыг сайжруулах зорилгоор дор дурдсан технологийн шинэчлэл бий болгож, үйлдвэрлэлд нэвтрүүлэх. Үүнд:							
		а/ хонины ноосноос ноолуур ялган авч түүхий эдийн чанарыг сайжруулах,	2001-2004	„Хэрлэн хивс" ХК-ийн зардлын тооцоонд орсон				Хөнгөлөлттэй зээл	Худалдаа хөгжлийн банк
		б/ карактай эсгий үйлдвэрлэх.	2001-2004			-		ерөнхий хэрэнте	Нэхэгсүй эдлэл ХК
		в/ тэмээний ноос цайруулах.	2002-2003	7.0	7.0	-	14.0	Улсын төсөв	УХЯ, СЭЗЯ, БСШҮЯ
		г/ зөгдөр боловсруулах.	2002-2003	7.1	7.1	-	14.2	Улсын төсөв	УХЯ, СЭЗЯ, БСШҮЯ
		д/ хивсний сэвэ, хэлтэсыг багасгах.	2002-2003	6.3	6.2	-	12.5	Улсын төсөв	УХЯ, СЭЗЯ, БСШҮЯ
		е/ хэлтэсан бүтээгдэхүүн үйлдвэрлэх.	2003-2004	-	7.6	7.6	15.2	Улсын төсөв	УХЯ, СЭЗЯ, БСШҮЯ
		ж/ сарлагийн хөөвөөр цэмбэ үйлдвэрлэх.	2002-2004	1550.5	1550.5	1550.5	4651.5	Хөнгөлөлттэй зээл	УХЯ, СЭЗЯ, Ариунжаны банк

з/ ямаанц ноос боловсруулах.	2003-2004	-	8.2	8.1	16.3	Улсын төсөв	ҮХЯ, СЭЗЗГ, БСШУЯ
2/ Даразхь чиглэлээр судалгаа явуулж, стандарт боловсруулж, мөрдөх. Үүнд:							
а/ бөтгө, тохоймны ноос;	2001			-		-	СХЗҮГ, Нэхмэлийн хүрээлэн
б/ тэмээний эм ноос;	2001			-		-	СХЗҮГ, Нэхмэлийн хүрээлэн
в/ эсгэр;	2002			-		-	СХЗҮГ, Нэхмэлийн хүрээлэн
г/ сарлагийн хөөвөр;	2003			-		-	СХЗҮГ, Нэхмэлийн хүрээлэн
д/ ямааны ноос;	2004			-		-	СХЗҮГ, Нэхмэлийн хүрээлэн
е/ ядууны дээл, сүүл;	2004			-		-	СХЗҮГ, Нэхмэлийн хүрээлэн
жүхээр, адууны хөөвөр.	2004			-		-	СХЗҮГ, Нэхмэлийн хүрээлэн
3/ Хонины ноосны шинж чанарын улсын нэгдсэн ангилал тогтоох.	2002-2004	333.3	333.3	333.4	1000.0	Зээл, тус-лажх.	ҮХЯ, СЭЗЗГ, Нэхмэлийн хүрээлэн
4/ Ачхан шаяны боловсруулалт хийсэн бүдүүн, бүдүүлэг ноосны стандартыг дахин хянах.	2002			-		-	СХЗҮГ, Нэхмэлийн хүрээлэн
5/ Ноосон бүтээгдэхүүний олон улсын зах зээл, хэрэглэгчийн судалгаа хийж, мэдээллийн сүлжээнд тусгай ЧЧЕВ* хуудас нээж ажиллуулах.	2002-2004	1.2	1.2	1.2	3.6	Техник-кийн тус-лажх.	ҮХЯ
6/ Монгол улсын хийсэн бүтээгдэхүүнийг олон улсын ЧЧОЛМАРК* чанарын тэмдэгтэй болгох асуудлыг судлан хэрэжүүлэхэд дэмжлэг үзүүлэх.	2001-2004			-		-	СХЗҮГ, Хивсний үйлдвэрүүд
7/ Сайбэрын үйлдвэрүүдийн бүтээгдэхүүний ЧЧЕВ* хуудсаар сурталчлах.	2001-2004			-		-	ҮХЯ, МХАҮТ

		8/ ОХУ-ын үргэлж өрөнд үгаасан ноос, хивс, тэмээний ноосон хөнжил өгөх асуудлыг шийдвэрлэх.		2001-2004	-			-	ҮХЯ, СЭЗЯ
		9/ ОХУ-ын Улаан-Үд, Тува, Чита, Горно-Алтайск мужийн ижил төрлийн үйлдвэрүүдтэй хамтран ажиллах асуудлыг судлан хэрэгжүүлэх, хил худалдааг өргөжүүлэх.		2001-2004	-			-	ҮХЯ, СЭЗЯ
		10/ Дотоодын болон олон улсын үзэсгэлэн яармагт салбарын үйлдвэрүүдийг оролцуулж, бүтээгдэхүүнийг сурталчлах ажлыг зохион байгуулах.		2001-2004	-			-	ҮХЯ, МХАҮТ
		11/ Салбарын техник мэргэжлийн сургалтын төв байгуулан ажиллаж, ажилчдын мэргэжлийн ур чадварыг сайжруулах арга хэмжээ авах.		2001-2204	-			-	БСШУЯ, ҮХЯ, сонирхогч байгууллага
		12/ Орон нутгийн жижиг үйлдвэрлэгчдэд зориулан эсгийгээр өргөн хэрэглээний бүтээгдэхүүн үйлдвэрлэх, гар эдмэл, хивс, дэвсгэр хийх байнгын сургалт зохион байгуулах.		2001-2004	-			-	БСШУЯ, ҮХЯ, сонирхогч байгууллага
		13/ Монгол хонины ноос ашиглан техникийн эсгий хийх үйлдвэрлэлийг өргөжүүлж, ОХУ болон бусад оронд экспортлох асуудлыг судлан хэрэгжүүлэх.		2001-2004	-			-	Холбогдох аж ахуйн нэгжүүд
5	Хөтөлбөрийн зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг сурталчилах	-		2001-2004	0.4	0.4	0.4	1.2	-	Улсын төсөв
		ДҮН			**3166.6**	**4295.9**	**3372.2**	**10834.7**		
		ҮҮНЭЭС	Улсын төсөв		307.7	325.7	305.6	939.0		
			Хөнгөлөлттэй зээл,тусламж		2858.9	3970.2	3066.6	9895.7		

Тайлбар: 1. Ээрмэл, Моннэхмэл ХК-уудийн технологийн тоног төхөөрөмжийн шинэчлэлтэд шаардлагатай хөрөнгө нь "Ноолуур" хөтөлбөрт заасан зэрэх хүчин чадлыг нэмэгдүүлэх хөрөнгө оруулалтын зээлийн тооцоонд хамт орсон тул уг тооцоог салбар бүрээр тодруулах зорилгоор "Ноос" дэд хөтөлбөрт дахин тусгасан болно.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 2 дугаар сарын 11-ний өдөр Дугаар 27 Улаанбаатар хот

Үйлдвэр, худалдааны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Зөвшөөрсүгэй.

"Үйлдвэр, худалдааны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-ийг хавсралт ёсоор

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД Ч.ГАНЗОРИГ

Засгийн газрын 2001 оны 27 дугаар тогтоолын хавсралт

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР

1.0. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Оршил

Үйлдвэр, худалдааны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр /цаашид "Хөтөлбөр" гэх/-т Үйлдвэр, худалдааны сайдын болон Засгийн газрын Танхимын шийдвэрийг боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн стратегийн төлөвлөлт, бодлого боловсруулах, бодлогын хэрэгжилтийг зохицуулах удирдамж, төрийн захиргааны удирдлага, зохицуулалтаар хангах, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ / мониторинг/ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх асуудлыг хамарсан Үйлдвэр, худалдааны яамны үйл ажиллагааны стратегийн болон бүтцийн загварыг тодорхойлов.

1.2. Үндэслэл

Хөтөлбөрийг боловсруулахдаа Улсын Их Хурлын 1996 оны 38 дугаар тогтоолоор зөвшөөрсөн "Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого"-ын баримт бичиг, Засгийн газрын 1996 оны 205 дугаар тогтоолоор зөвшөөрсөн "Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр", Засгийн газрын Удирдлагын хөгжлийн хөтөлбөрийн "Төрийн захиргаа, төрийн албаны өөрчлөлт, шинэчлэл" бүрэлдэхүүн хэсгийн МОН/94/102 тослийн хүрээнд боловсруулсан "Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн ерөнхий загвар" төслийн тайлан, Засгийн газрын 1997 оны 131 дүгээр тогтоолоор батлсан "Хөдөө аж ахуй, үйлдвэрийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр", энэхүү стратеги, бүтцээр ажиллах хугацаанд хуримтлагдсан туршлага, Засгийн газрын 2000 оны 131 дүгээр тогтоолоор батлсан "Үйлдвэр, худалдааны яамны зохион байгуулалтын бүтэц", "Агентлаг байгуулах тухай" Засгийн газрын 2000 оны 139 дүгээр тогтоолоор Үйлдвэр, худалдааны сайдын эрхлэх ажлын хүрээнд байгуулсан Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагийн бүрэлдэхүүний тус тус үндэслэв.

1.3. Хууль тогтоомжийн орчин

Хөтөлбөрийг дор дурдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;
- Монгол Улсын Төрийн албаны тухай хууль;
- Ашигт малтмалын тухай хууль;
- Газрын хэвлийн тухай хууль;
- Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль;
- Дэлхийн худалдааны байгууллагын олон талт худалдааны хэлэлцээний Урагвайн үе шатны дүнд байгуулсан эрх зүйн баримт бичгүүд;
- Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр;
- Бусад хууль тогтоомж.

1.4. Арга зүй

Хөтөлбөрийг боловсруулахад олон улсын туршлага, өөрчлөлтийн удирдлага, үйл ажиллагаа /бизнес/-ны төлөвлөлт болон дахин инженерчлэл, байгууллагын өөрчлөлтийн аргачлал зэрэг арга зүйг хэрэглэв.

1.5. Чиглэлийн яамны үүрэг хариуцлагын ерөнхий хуваарь

Үйлдвэр, худалдааны яам нь Засгийн газрын үйл ажиллагааны стратегийг хэрэгжүүлэх талаар үүрэг хариуцлага хүлээж Үйлдвэр, худалдааны сайд, дэд сайд, Засгийн газрын Танхимд бүх талын зөвлөлгөө, дэмжлэг үзүүлнэ.

Үйлдвэр, худалдааны яам нь Засгийн газрын стратегийн бодлоготой уялдуулан салбарын бодлого, төлөвлөлт болон төсвийн зарцуулалтын тэнцвэр, харилцан уялдаа холбоог хангах асуудалд Засгийн газар, яамны өндөрлөгөөс өргөн хүрээтэй хандаж, зөв зохистой удирдахад анхаарлаа төвлөрүүлнэ.

Засгийн газрын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэг бүхий чиглэлийн яамдын нэг болох Үйлдвэр, худалдааны яам нь Засгийн газрын үйлдвэр, худалдааны зөвлөхийн үүрэг хариуцлагыг хүлээнэ.

1.6. Стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр

Үйлдвэр, худалдааны яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр, нэн ялангуяа үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийг зөв тодорхойлох нь тус яамны үйл ажиллагааны стратегийг үндэслэл сайтай тогтооход чухал ач холбогдолтой юм.

Энэ хэрэгцээний эх үүсвэрт дор дурдсан үйлчлүүлэгч буюу хэрэглэгч хамаргдана:

УЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ ЯАМНЫ СТРАТЕГИЙН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЦЭЭНИЙ ЭХ ҮҮСВЭР



Үйлдвэр, худалдааны яамны үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгч нь Үйлдвэр, худалдааны сайд, дэд сайд, Засгийн газрын Танхим байна.

Үйлдвэр, худалдааны яамны стратегийн удирдлага, зохицуулалт нь дээр дурдсан хэрэгцээний эх үүсвэр, ялангуяа үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг хангахтай холбогдон үүсэх олон төрлийн нарийн төвөгтэй харилцааг зохицуулахад чиглэнэ.

Үйлдвэр, худалдааны яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээг хангах үйлчилгээний хүрээ, төрөл, хэлбэрийг хэрэгцээний эх үүсвэр бүрээр тогтоон тус яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн зорилт, чиг үүрэг, төрийн албан хаагчын ажлын байр /албан тушаал/ -ны тодорхойлолтод нарийвчлан тусгаж хэрэгжүүлнэ.

2.0. ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ

2.1. Үйл ажиллагааны стратегийн мөн чанар

Үйлдвэр, худалдааны яамны үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь Засгийн газрын үйл ажиллагааны төрүүлэх чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Үйлдвэр, худалдааны сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн Үйлдвэр, худалдааны сайдын үйл ажиллагаанд өндөр мэргэшлийн, цаг үеэ олсон, шуурхай

зөвлөлгөө, бүх талын дэмжлэг үзүүлэхэд оршино.

2.2. Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

Үйлдвэр, худалдааны яам нь дор дурдсан үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй ажиллана:

1. Үндэсний үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлэх;
2. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлж ажлын байрыг нэмэгдүүлэн өргөн хэрэглээний барааны үйлдвэрлэл, хангамжийг сайжруулах, хэрэглээний аюулгүй байдлыг хангах;
3. Нутаг дэвсгэрийн геологийн региональ судалгааны чиглэл, ашигт малтмал, газрын тосны ордын байршлын зүй тогтлыг тодорхойлох, улс орны эдийн засгийн хөгжлийн бодлого, зах зээлийн эрэлт хэрэгцээтэй уялдуулан ашигт малтмалын ордын нөөц өсгөх болон орд газрыг дэвшилтэт технологиор ашиглах;
4. Бүтээгдэхүүн, үйлчилгээний дэлхийн зах зээлд өрсөлдөх чадварыг сайжруулж экспортыг нэмэгдүүлэх, импортын болон эх орны үйлдвэрийн бараа, түүхий эдийн бөөний худалдааны сүлжээг бүс нутгийн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэх, алслагдсан хэрэглэгчдийг хангахад чиглүүлэн байгуулах;
5. Гадаад худалдааг хөгжүүлэх, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих;
6. Дэлхийн худалдааны байгууллагын гэрээ, хэлэлцээрээр Монгол Улсын хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх;
7. Удирдлагын орчин үеийн дэвшилтэт арга барил, туршлагыг нэвтрүүлэх, үндэсний технологийг хөгжүүлэх, дэлхийн тэргүүний техник, технологийг нутагшуулах, бүтүүлийн өөрчлөлтийг гүнзийрүүлэх.

2.3. Үйл ажиллагааны эрхэм зорилго

Үйлдвэр, худалдааны яамны үйл ажиллагааны эрхэм зорилго

Эдийн засгийн өсөлтийг ханган хүний чиглүүлэн үндэсний үйлдвэрлэлийг сэргээн хөгжүүлэх, экспортыг нэмэгдүүлэх, худалдаа, гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих

2.4. Үйл ажиллагааны стратегийн зорилт

Үйлдвэр, худалдааны яам нь эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааны стратегийн дор дурдсан зорилтыг хэрэгжүүлнэ:

1. Үйлдвэр, худалдааны салбарын хөгжлийн стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар ханган, бодлогын хэрэгжилтийг зохицуулахад цаг үеэ олсон зөвлөлгөө, бүх талын дэмжлэг үзүүлэх.

2. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг ханган.

3. Үйлдвэр, худалдааны салбарын бодлогын хэрэгжилтийн явц байдалд хяналт-шинжилгээ /мониторинг/ хийх, үнэлгээ өгөх.

2.5. Үйл ажиллагааны гол зорилт

Үйлдвэр, худалдааны яамны стратегийн зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны дор дурдсан гол зорилтыг дэвшүүлэн ажиллана:

1.0. Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд:

1.1. Салбарын хөгжлийн урт, дунд, богино хугацааны стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар ханган;

1.2. Салбарын хөгжлийн хөтөлбөр, төсөл боловсруулах;

1.3. Салбарын гадаад хамтын ажиллагааг хөгжүүлэх;

1.4. Хөгжлийн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл, хамтын ажиллагааны хэрэгжилтийг нэгтгэн зохицуулах.

2.0. Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд:

2.1. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг ханган;

2.2. Хүний нөөцийн удирдлагын манлайллыг ханган;

3.0. Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд:

3.1. Салбарын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээр, теслийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ /мониторинг/ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх;


3.2. Салбарын мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох, мэдээллийн сан бүрдүүлэх, хэрэглэгчдийг мэдээллээр хангах.

2.6. Үйл ажиллагааны зорилт

Үйлдвэр, худалдааны яамны үйл ажиллагааны гол зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны зорилтуудыг тус яам тодорхойлж хэрэгжүүлнэ.

2.7. Үйл ажиллагааны стратегийн загвар

Үйлдвэр, худалдааны яамны үйл ажиллагаа /бизнес-ны стратегийн загварыг дор дурдсанаар тодорхойлж байна:



1.0. Үйлдвэр, худалдааны яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, санал болгож буй зохион байгуулалтын бүтэц, тэдгээрийн үүрэг, чиг үүрэг

1.1.Бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримтлах зарчим

Үйлдвэр, худалдааны яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, санал болгож буй зохион байгуулалтын бүтцийг боловсруулахад дор дурдсан зарчмыг баримтлав:

1.Засгийн газрын үйл ажиллагааны стратегитэй уялдуулан яамны үйл ажиллагааны стратегийг тусгасан байх зарчим /яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц нь тус яамны үйл ажиллагааны стратегийн зорилттой уялдсан байх/;

2. Эрх мэдлийн ялгаа зааг нь тодорхой, итгэл хүлээхүйц байх зарчим /бүтцийн нэгжүүд, тэдгээрийн удирдах албан тушаалын түвшин, нэр нь аль нэгж ямар асуудал эрхэлдэг, аль албан тушаал ямар эрх мэдэлтэй болохыг тодорхой мэдэж болохүйц байх, тэдгээрийн ажлын уялдаа, ажиллах чадвар нь итгэл хүлээхүйц байх/;

3.Үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх зарчим /байгууллагын нэр, бүтцээс түүний үйл ажиллагааны дүр төрх харагдахүйц байх, тухайлбал яамны бүтцийн нэгжийн нэр нь түүний үйл ажиллагааны стратегийг тусгасан байх/;

4. Бүтцийн хувьд энгийн байх зарчим /яамны Төрийн нарийн бичгийн даргаас хамгийн доод нэгжээ хүртэл 3-аас дээшгүй шат дамжлагатай байх/;

5. Тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтоох зарчим /яамны үйл ажиллагааны стратеги,

өлсэн зөвхөн байгуулалтын бүтцийн нэгж, түүний
дсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 2
гаар зорилтын хүрээнд төрийн захиргааны
ирдлагын болон хүний нөөцийн удирдлагын
анлайллыг хангах үндсэн үүргийг хүлээж, ямны
ил ажиллагаанд удирдлагын шилдэг туршлага
ршлага, арга зүйг нэвтрүүлэх, хүний нөөцийн
ирдлага, хөгжлийн асуудлыг шийдвэрлэх, ажлаа
йлагнах, жариуцлага тооцох тогтолцоог хөгжүүлэх
рэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь цомхон,
дварлаг төрийн албан хаагч бүхий төрийн
ихиргааны мэргэжсэн албаны хүчээр ямны
сралтгүй, хэвийн жигд ажиллагаат хангахад
ялнэ.

Энэ нь Үйлдвэр, худалдааны сайд, дэд
йд, ямны Төрийн нарийн бичгийн даргад болон
мны аппаратад шийдвэр боловсруулан гаргах,
рэгжүүлэхэд эрх зүйн болон дотоод үйлчилгээ
үүлэх, шаардлагатай мэдээлэл, зөвлөлгөө,
мжлэгээр хангах, удирдлагын соёл, чадавхийг
ышлүүлэх, тэргүүний арга барил, туршлагыг
втрүүлэх., төрийн захиргааны албан хаагчдыг
ргаж хөгжүүлэх, тэдний үйл ажиллагаа,
ргэшлийн түвшинг нь үнэлж дүгнэх, ажиллах
эхцөл, нийгмийн баталгаат хангах, ёслол
оготколын үйл ажиллагаа эрхлэх замаар
рэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн
рэглэгч нь Үйлдвэр, худалдааны сайд, дэд сайд,
мны Төрийн нарийн бичгийн дарга, зохион
йгуулалтын бүтцийн нэгжүүд, төрийн захиргааны
бан хаагчид байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ
лчилгээг хэрэглэгч нь Засгийн газрын
хируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, аж ахуйн нэгж,
сад хэрэглэгч байна.

Энэ нэгжийн үйлчилгээг үзүүлэхэд оролцох
үүнш нь Хууль зүй, дотоод хэргийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, боловсрол, сургалтын болон эрдэм шинжилгээний байгууллага байна.

3. Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны 3 дугаар зорилтын хүрээнд бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ /мониторинг/ хийх, үнэлгээ өгөх үндсэн үүргийг хүлээж, үйлдвэр, худалдааны салбарын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээр, төслийн хэрэгжилтийн явц байдалд болон Үйлдвэр, худалдааны сайдын эрхлэх ажлын хүрээний тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагуудын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ /мониторинг/ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, салбарын мэдээллийн сүлжээ байгуулах, мэдээллийн сан бүрдүүлэх, хэрэглэгчдийг мэдээллээр хангах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь ямны бодлого боловсруулах, түүний хэрэгжилтийг зохицуулах, төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чиглэнэ.

Энэ нь бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилт, үр дагаварыг ажиглах замаар ямны бүтцийн нэгжүүд, хэрэгжүүлэгч болон тохируулагч агентлагууд, бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцож байгаа удирдах, гүйцэтгэх албан тушаалтны үйл ажиллагаат сайжруулахад чиглэсэн зөвлөлгөө, дэмжлэгээр цаг тухайд нь хангах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Үйлдвэр, худалдааны сайд, дэд сайд, ямны Төрийн нарийн бичгийн дарга, ямны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, Засгийн газрын холбогдох агентлаг байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, бусад хэрэглэгч байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, сургалт, эрдэм

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

01 оны 2 дугаар **Улаанбаатар**
рын 11-ний өдөр **Дугаар 29** **хот**

Байгаль орчны ямны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ

1. "Байгаль орчны ямны үйл ажиллагааны
ратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-ийг
всралт ёсоор зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан
айгаль орчны ямны үйл ажиллагааны стратеги,
тцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх, тус ямны бүтцийг батлах тухай" Засгийн газрын 1997 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 140 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД **У.БАРСБОЛД**

бүтэц хоёрын зөв зохистой тэнцвэрийг хангах замаар аль болох хялбар удирдах, хянах боломжтой байх, үйл ажиллагааны стратегийн зорилтыг аль болохоор оновчтой бүлэглэх замаар бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтцийг тогтоосон байх, энэ нь удирдлагын чиг үүрэг, хүн хүчний болон бусад нөөцийг зөв хуваарилан хэрэглэгчийнхээ хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлсэн байх/;

6. Улс төрийн хувьд төвийг сахисан байх зарчим /ямны төрийн захиргааны албан хаагч нь сайд, Засгийн газрын Танхим, бусад үйлчлүүлэгч буюу хэрэглэгчдэд улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүйгээр төвийг сахиж өндөр мэргэшлийн зөвлөлгөө, бүх талын дэмжлэг үзүүлэх/;

7. Хангалттай чадавхи, бодитой үйл ажиллагааны зарчим /үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар, зохион байгуулалтын бүтэц нь чадавхиа бүрэн дүүрэн илүүлэхээр чиглэсэн, хэрэгжихүйц бөгөөд ажиллах чадвартай байх/.

3.2. Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар

Дээр дурдсан зарчим болон Үйлдвэр худалдааны ямны үйл ажиллагаа /бизнес/-ны стратегийн загварыг үндэслэн тус ямны үйл ажиллагааны бүтцийн дор дурдсан ерөнхий тогтолцооны загварыг санал болгож байна:

Үйлдвэр, худалдааны ямны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар



3.3. Зохион байгуулалтын бүтэц

Үйлдвэр, худалдааны ямны үйл ажиллагаа /бизнес/-ны стратегийн болон бүтцийн ерөнхий тогтолцооны загварт үндэслэн тус ямн зохион байгуулалтын бүтцийн дор дурдсан нэгжүүдтэй байна:

1. Стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, бодлогын хэрэгжилтийг зохицуулах асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, тэдгээрийн үндсэн үүрэг, чиг үүрэг

Эдгээр нэгжүүд нь үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд Үйлдвэр, худалдааны сайдын эрхлэх асуудлын хүрээний бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах, бодлогын хэрэгжилтийг зохицуулах үндсэн үүргийг хүлээж; үйлдвэр, худалдааны салбарын урт, дунд, богино хугацааны стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, хөтөлбөр, төсөл боловсруулах, гадаад хамтын ажиллагаа хөгжүүлэх, Дэлхийн худалдааны байгууллагын гэрээ, хэлэлцээрээр хүлээсэн үүргийг хэрэгжүүлэх, бодлогын хэрэгжилтийг болон Үйлдвэр, худалдааны сайдын эрхлэх ажлын хүрээний хэрэгжүүлэгч, тохируулагч агентлагуудын үйл ажиллагаа зохицуулах, төсөв, санхүүгийн болон бусад нөөцийг оновчтой хуваарилах замаар бодлого хэрэгжүүлэхэд оролцож байгаа бүх байгууллагатай түншийн харилцаа тогтоож, тэдний үйл ажиллагаа бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглүүлэн зохион байгуулах, зохицуулах зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Эдгээр нэгжийн үйл ажиллагаа нь Үйлдвэр, худалдааны сайд, дэд сайд, Засгийн газрын Танхимын үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэнэ.

Энэ нь Үйлдвэр, худалдааны сайд, Засгийн газрын Танхимаас стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, зохицуулахтай холбогдсон шийдвэр боловсруулан гаргах механизмд дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын гишүүн, Үйлдвэр, худалдааны сайд, дэд сайдыг шаардлагатай мэдээлэл, өндөр мэргэшлийн, цаг үеэ олсон шуурхай зөвлөлгөө, үйлчилгээ, бүх талын дэмжлэгээр хангах замаар хэрэгжинэ.

Эдгээр нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Үйлдвэр, худалдааны сайд, дэд сайд, ямны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын Танхим байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь бусад ямны, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагуудын захиргааны байгууллага, аж ахуйн нэгж болон хэвлэл, мэдээлэл, олон нийтийн байгууллагууд иргэд байна.

Энэ үйлчилгээ үзүүлэхэд оролцох гол түнш нь Санхүү, эдийн засгийн ямн, Гадаад хэргийн ямн, Хууль зүй, дотоод хэргийн ямн, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар байна.

2. Төрийн захиргааны удирдлагын асууд

Засгийн газрын 2001 оны 29 дүгээр тогтоолын хавсралт

БАЙГАЛЬ ОРЧНЫ ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР

1.Нийтлэг үндэслэл

1.1 Оршил

Байгаль орчны яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр /цаашид "хөтөлбөр" гэнэ/-т Байгаль орчны сайдын болон Засгийн газрын Танхимын шийдвэрийг боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамж, төрийн захиргааны удирдлага, зохицуулалтаар хангах, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ (мөниторинг) хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх асуудлыг хамарсан үйл ажиллагааны стратегийн болон бүтцийн загварыг тодорхойлов.

1.2 Үндэслэл

Хөтөлбөрийг Улсын Их Хурлын 1996 оны 38 дугаар тогтоолоор зөвшөөрсөн "Монгол улсын Төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого"-ын баримт бичиг, Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5-ын 4-т заасан Байгаль орчны сайдын эрхлэх ажил, Засгийн газрын 1996 оны 205 дугаар тогтоолоор зөвшөөрсөн "Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр", Засгийн газрын Удирдлагын хөгжлийн хөтөлбөрийн "Төрийн захиргаа, төрийн албаны өөрчлөлт, шинэчлэл" бүрэлдэхүүн хэсгийн МОН/94/102 төслийн хүрээнд боловсруулсан "Байгаль орчны яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн ерөнхий загвар" төслийн тайланг тус тус үндэслэн боловсруулав.

1.3 Хууль тогтоомжийн орчин

Хөтөлбөрийг дор дурдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ:

-Монгол Улсын Үндэсэн хууль;
-Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;
-Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн
нэгж, түүний удирдлагын тухай хууль;
-Монгол Улсын Төрийн албаны тухай хууль;
-Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль;
-Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал;
-Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал;
-Төрөөс экологийн талаар баримтлах бодлого;
-Бусад хууль тогтоомж, хөтөлбөр, бусад бодлогын баримт бичиг.

1.4 Арга зүй

Хөтөлбөрийг боловсруулахад олон улсын туршлага, байгууллагын өөрчлөлтийн удирдлага, үйл ажиллагаа /бизнес/-ны төлөвлөлт болон дахин инженерчлэл, байгууллагын өөрчлөлтийн зэрэг арга зүйг хэрэглэв.

1.5 Чиглэлийн яамны үүрэг хариуцлагын ерөнхий хуваарь

Чиглэлийн яамдын нэг болох Байгаль орчны яам нь Засгийн газрын үйл ажиллагааны стратегийг хэрэгжүүлэх талаар үүрэг хариуцлага хүлээж, Байгаль орчны сайд, Засгийн газрын Танхимд бүх талын зөвлөлгөө, дэмжлэг үзүүлнэ.

Байгаль орчны яам нь стратегийн бодлого, төлөвлөлт, тэдгээрийн хэрэгжилт болон салбарын төсвийн зарцуулалтын тэнцвэр, харилцан уялдаа холбоог хангах асуудалд Засгийн газар, яамны өндөрлөгөөс өргөн хүрээтэй хандаж, зөв зохистой удирдахад анхаарлаа төвлөрүүлнэ.


Засгийн газрын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэг бүхий чиглэлийн яамдын нэг болох Байгаль орчны яам нь Засгийн газрын байгаль орчны зөвлөхийн үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

1.6 Байгаль орчны яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр

Байгаль орчны яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр, нэн ялангуяа үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийг зөв тодорхойлох нь тус яамны үйл ажиллагааны стратегийг үндэслэл сайтай тогтооход чухал ач холбогдолтой юм.

Энэ хэрэгцээний эх үүсвэрт дараахь загварт харуулсан үйлчлүүлэгч буюу хэрэглэгч хамрагдана:

Байгаль орчны яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр



Байгаль орчны яамны үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгч нь Байгаль орчны сайд, Засгийн газрын Танхим байна.

Байгаль орчны яамны стратегийн удирдлага, зохицуулалт нь дээр дурдсан хэрэгцээний эх үүсвэр, ялангуяа үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг хангахтай холбогдон үүсэх олон төрлийн харилцааг зохицуулахад чиглэнэ.

Байгаль орчны яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээг хангах үйлчилгээний хүрээ, төрөл, хэлбэрийг хэрэгцээний эх үүсвэр тус бүрээр тогтоон тус яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн зорилт, чиг үүрэг, зааг хүрээг тодотгож төрийн албан хаагчдын ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтод нарийвчлан тусгаж хэрэгжүүлнэ.

2.0 БАЙГАЛЬ ОРЧНЫ ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ

2.1 Үйл ажиллагааны стратегийн мөн чанар

Байгаль орчны яамны үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, Хүний аюулгүй байдлыг хангах сайн засагчал хөтөлбөр, Байгаль орчны сайдын эрхлэх асуудлын хүрээнийг зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн Байгаль орчны сайдын үйл ажиллагаанд өндөр мэргэжлийн, цаг үеэ олсон, шуурхай зөвлөлгөө, бүх талын дэмжлэг үзүүлэхэд оршино.

2.2.Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

Байгаль орчны яам нь дор дурдсан үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй ажилдана:

1.Тогтвортой хөгжлийн зорилгод нийцсэн экологийн бодлого, стратегийг улс орны эдийн засаг, төсөв, санхүүгийн нөөц, олон улсын хамтын ажиллагааны бодлоготой уялдуулан төлөвлөж хэрэгжүүлэх;

2.Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, өөрийн харьяа байгууллага, аж ахуйн нэгжүүд болон чиглэлийн яам, нутгийн захиргааны болон Засгийн газрын бус байгууллагуудын хамтын ажиллагаг дэмжин хөгжүүлж, тэдгээрийн үйл ажиллагаг бодлогоор уялдуулан зохицуулах;

3.Байгаль орчны яамыг төрийн хэргийг мэргэжлийн өндөр түвшинд явуулах чадвар бүхий цомхон байгууллага болгох;

4.Байгаль орчны төлөв байдал, хувьсал өөрчлөлтийн чиг хандлагыг ажиглан шинжлэх, байгаль орчныг хамгаалах үйл ажиллагаанд хэрэглэж буй арга механизм, нөөц баялгийн зохистой ашиглалт, нөхөн сэргээлтийн бодлого, чиглэл, экологийн тэнцлийг хангах шаардлагад хэрхэн нийцэж буй талаас нь үнэлж цэгнэж стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах ажлын арга, технологийг сайжруулах.

2.3.Үйл ажиллагааны эрхэм зорилго

Байгаль орчны яамны үйл ажиллагааны эрхэм зорилго нь: Иргэний эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгод нийцүүлэн экологийн тэнцлийг хангаж тогтвортой хөгжлийн үндсийг бүрдүүлэх

2.4.Үйл ажиллагааны стратегийн зорилт

Байгаль орчны яам нь эрхэм зорилгынхоо хүрээнд үйл ажиллагааны стратегийн дор дурдсан зорилтыг хэрэгжүүлнэ:

1.Байгаль орчны стратегийн төлөвлөгөө, бодлогын удирдамжаар хангах;

2.Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах;

3.Байгаль орчны бодлогын хэрэгжилтийг зохицуулах;

4.Байгаль орчны стратегийн төлөвлөгөө, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ (мониторинг) хийж, үр дүнд нь үнэлгээ өгөх;

5.Байгаль орчны салбарт гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх.

2.5 Үйл ажиллагааны гол зорилт

Байгаль орчны яамны үйл ажиллагааны зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн дор дурдсан үйл ажиллагааны гол зорилтыг дэвшүүлэн ажиллана:

1.0.Үйл ажиллагааны стратегийн нэгдүгээр зорилтын хүрээнд:

1.1.Тогтвортой хөгжлийн зарчим, зорилгод нийцсэн экологийн нэгдмэл бодлого явуулах үзэл баримтлал, эрх зүйн таатай орчин бүрдүүлэх;

1.2.Байгаль орчны стратегийн төлөвлөлтийн чадварыг сайжруулах;

1.3.Байгаль орчныг хамгаалах, орчны доройтлыг бууруулах хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, төсвийн төслийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх.

2.0.Үйл ажиллагааны стратегийн хоёрдугаар зорилтын хүрээнд:

2.1.Байгаль орчны удирдлагын чадавхийг сайжруулах;

2.2.Байгаль орчны салбарын хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх;

2.3. Байгууллагын удирдлага, санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох.

3.0.Үйл ажиллагааны стратегийн гуравдугаар зорилтын хүрээнд:

3.1.Бодлогын хэрэгжилтийг зохицуулах үйл ажиллагаат төлөвшүүлж хөгжүүлэх;

3.2.Хууль тогтоомж, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн зохицуулалтыг сайжруулах.

4.0.Үйл ажиллагааны стратегийн дөрөвдүгээр зорилтын хүрээнд:

4.1.Байгаль орчны бодлогын төлөвлөлт болон хэрэгжилтэд хяналт-шинжилгээ (мониторинг) хийх, үр дүнд үнэлгээ өгөх;

4.2.Байгаль орчны мэдээллийн тогтолцоог хөгжүүлэх ажлыг зохион байгуулах.

5.0.Үйл ажиллагааны стратегийн тавдугаар зорилтын хүрээнд:


5.1.Байгаль орчны хоёр талын болон олон улсын хамтын ажиллагаат бодлого, чиглэл боловсруулж хэрэгжүүлэх, уялдаа холбоо, зохицуулалтыг сайжруулах.

2.6.Үйл ажиллагааны зорилт

Байгаль орчны яамны үйл ажиллагааны гол зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны зорилтыг тус яам тодорхойлж хэрэгжүүлнэ.

2.7 Үйл ажиллагааны стратегийн загвар

Байгаль орчны яамны үйл ажиллагаа / бизнес/-ны стратегийн загварыг дор дурдсанаар тодорхойлж байна:


ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИЙН ЧИГЛЭЛ
Эрхэм зорилго
Үйл ажиллагааны стратегийн зорилт
Үйл ажиллагааны гол зорилт
Үйл ажиллагааны зорилт
Иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгод нийцүүлэн экологийн тэнцлийг хангаж тогтвортой хөгжлийн үндсийг бүрдүүлэх
1.Байгаль орчныг хамгаалах үйл ажиллагааны стратегийн төлөвлөгөө, бодлогын удирдамжаар хангах
Тогтвортой хөгжлийн зорилгод нийцсэн экологийн нэгдмэл бодлого явуулах үзэл баримтлал, эрх зүйн таатай орчин бүрдүүлэх
Байгаль орчны стратегийн төлөвлөлтийн чадварыг сайжруулах
Байгаль орчныг хамгаалах, орчны доройтлыг бууруулах хөтөлбөр, төсөл, арга хэмжээ, төсвийн төслийг боловсруулахад дэмжлэг үзүүлэх
2.Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах
Байгаль орчны удирдлагын чадавхийг сайжруулах
Байгаль орчны салбарын хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх
Байгууллагын удирдлага санхүүжилтийн тогтолцоог боловсронгуй болгох
3.Байгаль орчны бодлогын хэрэгжилтийг зохицуулах
Бодлогын хэрэгжилтийг зохицуулах үйл ажиллагаат төлөвшүүлж хөгжүүлэх
Хууль тогтоомж, хөтөлбөр, төслийн хэрэгжилтийг сайжруулах
4.Байгаль орчны үйл ажиллагааны стратегийн төлөвлөгөө, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх
Байгаль орчны бодлого, төлөвлөлт болон хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх
Байгаль орчны мэдээллийн тогтолцоог бүрдүүлж хөгжүүлэх
5.Байгаль орчны гадаад харилцаа хамтын ажилла-гааг хөгжүүлэх
Хамтын ажиллагааг хөгжүүлж, бодлого, чиглэл боловсруулж, хэрэгжүүлэх
Олон улсын төслийн хэрэгжилтийн үр дүнг дээшлүүлэх, зохицуулалтыг сайжруулах

БАЙГАЛЬ ОРЧНЫ ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЦИЙН ЕРӨНХИЙ ТОГТОЛЦОО, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ, ТЭДГЭЭРИЙН ҮҮРЭГ, ЧИГ ҮҮРЭГ

3.1.Бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримтлах зарчим

Байгаль орчны яам нь үйл ажиллагааныхаа бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтцэд дор дурдсан зарчмыг баримтална:

1.Засгийн газрын үйл ажиллагааны стратегитэй уялдсан тухайн яамны стратегийн зорилтыг тусгасан байх зарчим /тухайн яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц нь тус яамны үйл ажиллагааны стратегийн зорилттой уялдсан байх/

2.Эрх мэдлийн ялгаа, зааг нь тодорхой, итгэл хүлээхүйц байх зарчим /бүтцийн нэгжүүд, тэдгээрийн удирдах албан тушаалын түвшин, нэр нь аль нэгж ямар асуудал эрхэлдэг, аль албан тушаал ямар эрх мэдэлтэй болохыг тодорхой мэдэж болохүйц байх, тэдгээрийн ажлын уялдаа, ажиллах чадварын хувьд итгэл хүлээхүйц байх/

3.Үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх зарчим / байгууллагын нэр, бүтцээс тухайн байгууллагын үйл ажиллагааны дүр төрх харагдахүйц байх, тухайлбал яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн нэр нь түүний үйл ажиллагааны стратегийг тусгасан байх/

4.Бүтцийн хувьд энгийн, ойлгомжтой байх зарчим /яамны Төрийн нарийн бичгийн даргаас хэлтсийн доод нэгжээ хүртэл аль болох цөөн / гурваас дээшгүй/ шат дамжлагатай байх/

5.Тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтоосноод дехөмтэй байх зарчим /байгууллагын үйл ажиллагааны стратеги, бүтцийн зөв зохистой тэнцвэрийг хангах замаар аль болох хялбар удирдах, зохицуулах, хянах боломжтой байх, үйл ажиллагааны стратегийн зорилтыг аль болох оновчтой бүлэглэх замаар бүтцийн ерөнхий тогтолцоог тогтоосон байх, энэ нь удирдлагын чиг үүрэг, хүн хүчний болон бусад нөөцийг зөв хуваарилан хэрэгцээчийнхээ хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэх боломжийг хангасан байх/


6.Улс төрийн хувьд төвийг сахисан байх зарчим /тухайн яамны төрийн захиргааны албан хаагч нь тухайн сайд, Засгийн газар /танхим/-т улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй, төвийг сахисан өндөр мэргэшлийн зөвлөлгөө, бүх талын дэмжлэг үзүүлэх/

7.Хангалттай чадавхи, бодитой үйл ажиллагааны зарчим /үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар, зохион байгуулалтын бүтэц нь чадавхиа бүрэн дүүрэн илүүлэхэд чиглэсэн хэрэгжихүйц бөгөөд ажлын үр дүнг үнэлж, худалдан авах боломжтой байх/

3.2 Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар

Дээр дурдсан зарчим болон Байгаль орчны яамны үйл ажиллагаа /бизнес/-ны стратегийн загварыг үндэслэн тус яамны үйл ажиллагааны бүтцийн дор дурдсан ерөнхий тогтолцооны загварыг санал болгож байна:

Байгаль орчны яамны үйл ажиллагааны ерөнхий загвар



3.3 Зохион байгуулалтын бүтэц

Байгаль орчны яамны үйл ажиллагааны стратегийн болон бүтцийн ерөнхий тогтолцооны загварыг үндэслэн тус яамны зохион байгуулалтын бүтцийг тодорхойлж байна:

1.Стратегийн төлөвлөлт, удирдлагын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн нэгдүгээр зорилтын хүрээнд Байгаль орчны сайдын эрхлэх ажлын хүрээний стратегийн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл боловсруулах үндсэн үүргийг хүлээж, байгаль орчны стратегийн төлөвлөлтийг сайжруулах, орчны доройтлыг бууруулж нөхөн сэргээх ажлын бодлогыг тодорхойлох, байгаль орчны болон олон улсын хамтын ажиллагааг бодлогын удирдамжаар хангах зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Нэгжийн үйл ажиллагаа нь Байгаль орчны сайд, дэд сайд, Засгийн газрын Танхимын үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэнэ.

Энэ нь Байгаль орчны сайд, дэд сайд, Засгийн газрын Танхимын стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангахтай холбогдсон шийдвэр гаргах механизмд дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын гишүүн, Байгаль орчны сайдыг шаардлагатай мэдээлэл, өндөр мэргэжлийн цаг үеэ олсон, шуурхай зөвлөлгөө, үйлчилгээ, бүх талын дэмжлэгээр хангах замаар хэрэгжинэ.

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Байгаль орчны сайд, дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газар / Танхим/ байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь бусад яам, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, төрийн холбогдох бусад болон орон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж болон хэвлэл, мэдээлэл, олон нийтийн байгууллага, ард иргэд байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Санхүү, эдийн засгийн яам, Гадаад хэргийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, бүх шатны Засаг дарга нар, тэдгээрийн Тамгын газар байна.

2. Төрийн захиргааны удирдлагын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн хоёрдугаар зорилтын хүрээнд төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах үндсэн үүргийг хүлээж хүний нөөцийн удирдлага хөгжлийн асуудлыг шийдвэрлэх, яамны үйл ажиллагаанд удирдлагын шилдэг туршлага, арга зүйг нэвтрүүлэх, ажлаа тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог хөгжүүлэх, ергөдөл, гомдлыг барагдуулах, байгууллагын удирдлага, санхүүжилтийг боловсронгуй болгож бэхжүүлэх зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Нэгжийн үйл ажиллагаа нь чадварлаг төрийн албан хаагч бүхий төрийн захиргааны мэргэжлээн, цомхон албаны хүчээр яамны тасралтгүй, хэвийн, жигд ажиллагааг хангаж бодлого боловсруулах, түүний хэрэгжилтийг зохицуулах үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чиглэгдэнэ.

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Байгаль орчны сайд, дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, төрийн захиргааны албан хаагчид байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг, нутгийн захиргааны байгууллага, ард иргэд, бусад хэрэглэгч байна.

Энэ нэгжийн үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Төрийн захиргааны албаны зөвлөл, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Санхүү, эдийн засгийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, сургалтын болон эрдэм

шинжилгээний байгууллага, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар байна.

Энэ нэгжийн бүтцэд санхүү, аж ахуйн асуудал эрхэлсэн нэгж ажиллана.

3.Бодлогын хэрэгжилтийг зохицуулах асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь яамны үйл ажиллагааны стратегийн гуравдугаар зорилтын хүрээнд байгаль орчны бодлогын хэрэгжилтийг зохицуулах үндсэн үүргийг хүлээж, бодлогын хэрэгжилтийг зохицуулах үйл ажиллагаа төлөвшүүлж хэрэгжүүлэх, тусгай хамгаалалттай газар нутгийн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийн зохицуулалтыг сайжруулах зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Нэгжийн үйл ажиллагаа нь байгаль орчны бодлого, байгалийн нөөцийн болон экологийн тэнцвэрт байдлыг хангах үйл ажиллагааны уялдаа холбоог хангахад чиглэнэ.

Энэ нь нөөцийг оновчтой хуваарилах замаар бодлого хэрэгжүүлэхэд оролцож байгаа бүх байгууллагатай түншийн харилцаа тогтоож, тэдний үйл ажиллагаанд бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглүүлэн зохион байгуулах, зохицуулах замаар хэрэгжинэ.

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Байгаль орчны сайд, дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь бусад яам, төсөвт байгууллага, аж ахуйн нэгж, олон нийтийн байгууллага, иргэд, гадаад орон, олон улсын байгууллага зэрэг бусад хэрэглэгч байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түүнш нь Санхүү, эдийн засгийн яам, Гадаад хэргийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Үйлдвэр, худалдааны яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Эрүүл мэндийн яам, нутгийн захиргааны байгууллага байна.

Энэ нэгжийн бүтцэд Тусгай хамгаалалттай газар нутгийн удирдлагын асуудал эрхэлсэн нэгж ажиллана.

4.Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн дөрөвдүгээр зорилтын хүрээнд байгаль орчны бодлогын хэрэгжилт, төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл, хамтын ажиллагааны гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ /мониторинг/ хийх, үр дүнд үнэлгээ өгөх үндсэн үүргийг хүлээж, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх ажлыг зохион байгуулах, байгаль орчны мэдээллийн санг бүрдүүлэх, дотоод сүлжээ байгуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Нэгжийн үйл ажиллагаа нь яамны бодлого боловсруулах, түүний хэрэгжилтийг зохицуулах, төрийн захиргааны удирдлагын мэдлэйллыг хангах үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чиглэнэ.

Үүнийг бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилт,үр дагаварт хяналт тавих замаар яамны бүтцийн нэгжүүдийн болон бодлого боловсруулах, хэрэгжилтэд оролцож байгаа бүх байгууллага, удирдах, гүйцэтгэх албан тушаалтны үйл ажиллагааг сайжруулахад чиглэсэн зөвлөлгөө, дэмжлэгээр цаг тухайд нь хангах замаар хэрэгжүүлнэ.

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Байгаль орчны сайд, дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь бусад яам, төсөвт байгууллага, аж ахуйн нэгж, олон нийтийн байгууллага, иргэд, гадаад орон, олон улсын байгууллага зэрэг бусад хэрэглэгч байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Санхүү, эдийн засгийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, нутгийн захиргааны байгууллага байна.

5.Хамтын ажиллагаа эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь байгаль орчны салбарын гадаад хамтын ажиллагааны бодлогыг хэрэгжүүлэх, зохицуулалт хийх, олон улсын төсөл боловсруулан санхүүгийн гадаад эх үүсвэр олж хэрэгжилтийг хангах, манай улсаас байгаль орчны салбарт нэгдсэн конвенци, гадаад орнуудтай байгуулсан гэрээ, хэлэлцээрүүдийг биелүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Нэгжийн үйл ажиллагаа нь байгаль орчны салбарын олон улсын хамтын ажиллагааг цаашид хөгжүүлэх, үр өгөөжийг дээшлүүлэхэд чиглэнэ.

Нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Байгаль орчны сайд, дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь олон улсын байгууллагууд, гадаад орнууд, олон улсын төслийн үр ашгийг хүртэгсэд байна. Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Гадаад хэргийн яам, Санхүү, эдийн засгийн яам байна.

Энэ нэгжийн бүтцэд олон улсын төслийн баг ажиллана.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 2 дугаар сарын 11-ний өдөр Дугаар 30 Улаанбаатар хот

Олон улсын хурал зохион байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-мэдээллийн "МОНЦАМЭ" агентлагийн 80 жилийн ойн үеэр Ази, Номхон далайн улсуудын мэдээллийн агентлагуудыг нэгтгэсэн олон улсын байгууллага-ОАНА-гийн гүйцэтгэх хорооны ээлжит хуралдааныг Улаанбаатар хотноо хийлгэх саналыг дэмжсүгэй.

2. Уг арга хэмжээнд зориулж 15,0 (арван таван) сая төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 2 дугаар сарын 15-ны өдөр Дугаар 32 Улаанбаатар хот

Нэмэлт арга хэмжээ авах тухай

Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Иргэний хамгаалалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3, 6 дахь хэсэг, Засгийн газрын 1994 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан "Иргэний хамгаалалтын бэлэн байдлын зэрэг, тэдгээрт шилжих журам"-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Дорнод аймгийн Баяндун, Баян-Уул, Чулуунхороот сумын нутаг дэвсгэрт мал, ан амьтанд гоц халдварт өвчний шинж тэмдэг илэрсэнтэй холбогдуулан тус аймгийн нутаг дэвсгэрт 2001 оны 2 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн бүхэлд нь хорио цээрийн онцгой дэглэм тогтоосугай.

/1-р зүйлийг ЗГ-ын 2001оны 33-р тогтоолоор хүчингүй болсонд тооцсон/

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Иргэний хамгаалалтын бэлэн байдлын зэргүүдэд шилжүүлэх тухай" Засгийн газрын 2001 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 31 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлийн "Дорнод аймгийн Хөлөнбуйр, Хэрлэн, Булган, Баянтүмэн, Чойбалсан, Матад" гэснийг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ БӨГӨӨД ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД Ц.НЯМДОРЖ

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД Ж.ГҮРРАГЧАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 2 дугаар сарын 8-ны өдөр **Дугаар 33** **Улаанбаатар хот**

Малын гоц халдварт өвчний цагийн байдалтай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Иргэний хамгаалалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3, 6 дахь хэсэг, Засгийн газрын 1994 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан "Иргэний хамгаалалтын бэлэн байдлын зэрэг,тэдгээрт шилжих журам"-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Малын гоц халдварт өвчний цагийн байдалтай холбогдон Сүхбаатар, Дорнод аймгийн нутгийн захиргааны бүх байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хамгаалалтын албадыг иргэний хамгаалалтын бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, 2001 оны 2 дугаар сарын 18-ны өдрөөс эхлэн хорио цээрийн онцгой дэглэм тогтоосугай.

2. Сүхбаатар, Дорнод аймгийн нутаг дэвсгэрт хорио цээрийн онцгой дэглэм тогтоосонтой холбогдуулан эдгээр аймагтай хил залгаа нутаг дэвсгэрт харуул, хамгаалалтыг чангатгаж, Улсын байнгын онцгой комиссоос зөвшөөрөгдсөнөөс бусад бүх төрлийн тээврийн хэрэгсэл, зорчигчид дээрх аймгуудаас нэвтрэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг Хэнтий аймгийн Засаг дарга Ч.Эрдэнэбаатар, Дорноговь аймгийн Засаг дарга Ж.Батсуурь, Говьсүмбэр аймгийн Засаг дарга Ж.Баянмөнх нарт үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Иргэний хамгаалалтын бэлэн байдлын зэргүүдэд шилжүүлэх тухай" Засгийн газрын 2001 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 31 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйл, "Нэмэлт арга хэмжээ авах тухай" Засгийн газрын 2001 оны 2 дугаар сарын 15-ны өдрийн 32 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД Ж.ГҮРРАГЧАА

шийдвэр гаргавал зохих хууль, зарлиг, батламж, шийдвэр хүчингүй болно" гэж заасныг Үндсэн хуулийн Цэц эдгээр асуудлаар маргааныг эцэслэн хянан шийдвэрлэж тогтоол гаргамагц зохих хууль, зарлиг, батламж, шийдвэр хүчингүй болно гэж ойлгоно;

2."Үндсэн хууль зөрчсөн тухай маргаантай холбогдох хууль, зарлиг, Улсын Их Хурлын болон Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ нь Үндсэн хуулийн Цэцийн тогтоол гартал хүчин төгөлдөр үйлчилнэ гэж ойлгоно" гэсэн нь Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн нэгдэх хэсгийн 4, Жарандөрвөдугээр зүйлийн 1, 2, Далдугаар зүйлийн 1, Хоринтавдугаар зүйлийн 1-ын 1, Дөчиндолдугаар зүйлийн 1, 2 дахь заалтуудыг тус тус зөрчсөн гэж үзэж байна.

"Улсын Их Хурал ийм байдлаар Үндсэн хуульд тайлбар хийж байгаа нь уг тайлбар Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхээс үл хамааран Үндсэн хуулийн дээрх заалтуудыг зөрчиж байна"гэжээ.

Иргэн Д.Ламжав 2001 оны 3 дугаар сарын 13-нд Үндсэн хуулийн Цэцэд гаргасан нэмэлт тайлбартаа:

Улсын Их Хурлын 2000 оны 7 дугаар сарын 26-ний өдрийн 10 дугаар тогтоолыг хуулийн тодорхой заалттай харьцуулан үзвэл Улсын Их Хурал хууль дээдлэх явдлаас гадна хоцрох, туслаг хэм хэмжээг тогтоож өгснийг ажиглаж болно. Ердийн шүүхэд Үндсэн хуультай нийцээгүй хуулийг хэрэглүүлэхгүй байх механизмыг шүүгчдийн итгэл үнэмшлээр дамжуулан бүрдүүлсэн атал, шүүх эрх мэдлийн оргил хэмээх Цэцийн дунд суудлын хуралдаанаас тухайн эрх зүйн акт Үндсэн хуульд нийцээгүй байна гэсэн мэргэжлийн шийдвэр гарчихсан байлаа ч хамаагүй, Улсын Их хурал болохоор түүнийг хэрэглэж болдог юм байна. Эндээс хууль дээдлэх Үндсэн хуулийн зарчим Улсын Их Хуралд хамаарахгүй болжээ гэж дүгнэхэд бүрэн болохоор байна.

Улсын Их Хурал Үндсэн хуульд албан ёсны тайлбар хийж байгаа нь (уг тайлбар Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхээс үл хамааран) өргөдөлд иш татсан 50.1.4, 64.1, 70.1 заалтуудаас гадна, Үндсэн хуулиар тодорхойлсон Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхийн тухай Хоринтавдугаар зүйлийг зөрчиж, эрх мэдлээ хэтрүүлж байгааг нотлон тайлбарлая:

Үндсэн хуульд албан ёсны тайлбар хийх тухай асуудал Үндсэн хуулийн төслийг боловсруулах, хэлэлцэх явцад хууль тогтоогчдын анхаарлыг татсаар ирсэн.

Үндсэн хуульд албан ёсны тайлбар хийх эрхийг Цэцэд олгохыг НҮБ-ын Хүний эрхийн төв эрчимтэй зөвлөсөн боловч тэр үеийн парламент уг эрхийг Цэцэд олгоогүй, тэх тусмаа бусад этгээдэд олгоогүй түүхтэй. Энэ нь нэг талаас нэгэнт байнгын ажиллагаатай парламенттай болсон тул шаардлагатай үед хуулийн аргаар шийдвэрлэх бүрэн боломжтой болсныг тооцсон, нөгөө талаас Үндсэн хуулийн шүүх болох Цэц гэгч энэ шинэ этгээдэд албан ёсны тайлбар хийх эрхийг олгохоос болгомжилсонтой холбоотой байх. Үндсэн хуульдаа албан ёсны тайлбар хийхийг зөвшөөрдөггүй улс бол ганц Монгол биш. Австри зэрэг нэлээд улс байдаг юм байна. Улсын Их Хурал Үндсэн хуульд албан ёсны тайлбар хийж байгаа нь түүнд олгогдоогүй бөгөөд хүн төрөлхтний соёл иргэншлийн ололтыг хүндэтгэн үзэх үүднээс олгогдох ёсгүй эрхийг эдэлж байна. Тайлбарын үлдсэн хэсэгт бүрэн эрхээ ийнхүү хэтрүүлсэн явдал нь Үндсэн хуулийн тодорхой заалтуудыг зөрчихөд хүргэсэн гэдгийг нотлох болно.

"Хувь хүн хуулиар хориглоогүй зүйлийг, төрийн байгууллага хуулиар зөвшөөрсөн зүйлийг хийж болно" гэсэн гүнзгий агуулгатай эрх зүйн зарчим байдаг. Энэ зарчим нь нэг талаас хүний үндсэн эрх, эрх чөлөөг хамгаалахад чиглэсэн, нөгөө талаас төрийн бүрэн эрхийг хязгаарлахад чиглэсэн байдаг. Үндсэн хууль болон бусад хуулийг хийсэн техник ч энэ зарчимд нийцэж байх ёстой байдаг.

Монгол Улсын дээд шүүх Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах бүрэн эрхтэй гэж Үндсэн хуулийн Тавьдугаар зүйлийн 1-ын 4-т заажээ. Энэ нь хуулийн албан ёсны тайлбарт хамаарах Үндсэн хуулийн цорын ганц ил заалт юм. Үндсэн хуулийг тайлбарлах эрхийг ямар ч этгээдэд олгоогүй байхад Үндсэн хуулийн албан ёсны тайлбар гарч байгаа нь уг тайлбар Үндсэн хуулийн

Тавьдугаар зүйлийн 1-ын 4 дэх заалтыг, улмаар Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино гэсэн Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх заалтыг зөрчиж байна.

Парламент Үндсэн хуулийг албан ёсоор тайлбарлах нь ямар муу үр дагаварт хүргэж болохыг Улсын Их Хурын 2000 оны 10 дугаар тогтоолын жишээнээс харж болно.

Үндсэн хуулийн Хоринтавдугаар зүйлд Улсын Их Хурал хууль тогтоох бүрэн эрхийнхээ хүрээнд ямар ч асуудлыг санаачлан хэлэлцэж болохыг заагаад түүний онцгой бүрэн эрхийг дэлгэрэнгүй тооцон бөгөөд энд Үндсэн хуульд албан ёсны тайлбар хийхийг зөвшөөрсөн заалт үгүй байна. Энэ нь Үндсэн хууль бол бусад хуульд албан ёсны тайлбар хийх бүрэн эрхийг өгдөг юм бол Үндсэн хуулийн шүүх болох Цэц буюу Улсын Дээд Шүүхээс өөр этгээдэд өгөх ёсгүй гэсэн Үндсэн хуулийн төрийн бүрэн эрхийг хуваарилах зарчмаас урган гарч буй зүй ёсны үр дагавар юм. Ийнхүү Үндсэн хуулийн албан ёсны дээр дурдсан хоёр тайлбар нь Үндсэн хуулийн 70. 1 болон 25 дугаар зүйлийн заалтыг зөрчиж байна" гэжээ.

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Ц.Оюунбаатар Үндсэн хуулийн Цэцэд гаргасан тайлбартаа:

"Иргэн Д.Ламжавын нэхэмжлэлд дурдсан Үндсэн хуулийн 50.1.4 "Монгол Улсын Дээд Шүүх Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах бүрэн эрхтэй" гэсэн заалт нь Улсын Дээд Шүүхэд Үндсэн хууль тайлбарлах эрх олгогуй болохыг тодорхойлж байна. Нөгөө талаас хэдийгээр бусад хуулийн талаар тайлбар гаргах эрхийг Улсын Дээд Шүүхэд өгсөн ч гэсэн тэдгээр хуулийн талаар ч шаардлагатай бол Улсын Их Хурал өөрөө тайлбарыг гаргах эрхээ хадгалж үлдэнэ.

64.1. Монгол Улсын Үндсэн хуулийн Цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн гэсэн заалтыг нэхэмжлэлд иш татаж, Үндсэн хуулийн энэ заалт зөрчигдөж байгаа гэсэн нь ойлгомжгүй, Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих үүрэгтэй энэ байгууллагын үүргийг тов тодорхой заасан бөгөөд энэ заалтыг Улсын Их Хурал Үндсэн хуулийн тайлбар гаргасан асуудалтай шууд холбож үзэх үндэсгүй.

Улсын Их Хурлаас тогтоолын хэлбэрээр гаргасан тайлбар нь Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхийг Цэц өнөөдөр шүүн хэлэлцэж байгаа нь үүргээ гүйцэтгэж Үндсэн хуулийн хяналтаа хэрэгжүүлж байгаагийн илрэл шүү дээ.

Иргэн Н.Хайдав нь гаргасан нэхэмжлэлдээ Улсын Их Хурал Үндсэн хуулийн 25.1.1-ийн Улсын Их Хурал "хууль батлах, нэмэх, өөрчлөлт оруулах онцгой бүрэн эрхтэй", 47.1-ийн "Монгол Улсад шүүх эрх мэдлийг гагцхүү шүүх хэрэгжүүлнэ", 47.2-ын "ямар ч нөхцөлд хуулиас гадуур шүүх байгуулах, шүүх эрх мэдлийг өөр байгууллага эрхлэн хэрэгжүүлэхийг хориглоно", 64.2-ын "Үндсэн хуулийн Цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна" гэсэн заалтыг зөрчсөн гэсэн нь хуулийг эсрэг утгаар нь тайлбарлахыг оролдсон, эдгээр заалтууд нь харин ч Улсын Их Хурал хууль тогтоох эрх мэдлийг хэрэгжүүлэгчийн хувьд өөрөө аутент тайлбар гаргах субъект гэдгийг нотолсон заалтууд байх юм.

Монгол Улсын Үндсэн хуулийг тайлбарлах үүргийг Үндсэн хуулийн Цэцэд ч / 64.1/, Улсын Дээд Шүүхэд ч /ҮХ-ийн 50.1.4/ олгоогүй нь тодорхой. Иймэ тохиолдолд Үндсэн хуулийн Гуравдугаар бүлгийн Хорьдугаар зүйлд: "Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.

Иргэн Д.Ламжав, Н.Хайдав нарын нэхэмжлэл үндэслэлгүй тул хэрэгсэхгүй болгохыг хүсье" гэжээ.

Иргэн Д.Ламжав Үндсэн хуулийн Цэцийн хуралдаанд оролцож, мэтгэлцээний явцад хийсэн тайлбартаа: "Монгол Улсын Үндсэн хуулийг тайлбарлах эрхийг Үндсэн хуулиар ямар ч субъектэд олгоогүй байхад "олгогдоогүй бүрэн эрх"-ийг Улсын Их Хурал эдлэж байгаа нь хуль дээдлэх зарчмыг зөрчиж буй хэрэг юм. Монгол

Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн эрх барих төлөөлөгчдийн байгуулагаараа уламжлан энэ эрхээ эдэлдэг. Гэтэл Үндсэн хуулийн Хоринтавдугаар зүйлийн 1-д "Улсын Их Хурал төрийн дотоод гадаад бодлогын аль ч асуудлыг санаачлан хэлэлцэнэ" гэсэн нь "хязгааргүй бүрэн эрх"-ийг Улсын Их Хурал олгож буй хэрэг биш юм" гэжээ.

Мөн иргэн Н.Хайдав "Улсын Их Хурал тогтоол гаргаж Үндсэн хуулийг тайлбарлаж байгаа нь Үндсэн хуулийг "хэрэглэгч" болох Үндсэн хуулийн Цэцэд албан ёсны тулгалт хийж буй хэрэг юм. Дээд шүүх, бусад шүүх нь Үндсэн хуульд нийцээгүй, албан ёсоор нийтлээгүй хуулийг хэрэглэх эрхгүй байдаг төдийгүй Улсын Дээд Шүүхийн тайлбар хуульд харшилбал хуулийг дагаж биелүүлэх Үндсэн хуулийн заалт ч бий" гэжээ.

Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч Ц.Оюунбаатар "Шийдвэр гаргасан байгууллага нь тухайн шийдвэрээ тайлбарладаг эрх зүйн онолын ерөнхий ойлголтын үүднээс асуудалд хандах ёстой. Иймд Үндсэн хуулийг тайлбарлах эрх Улсын Их Хуралд хадгалагдаж байна" гэжээ.

ХЯНАВАЛ:

1.Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд хамаарах асуудлыг тодорхойлсон Монгол Улсын Үндсэн хуулийн Хоринтавдугаар зүйл болон Улсын Их Хурлын үйл ажиллагаатай холбоотой Үндсэн хуулийн бусад заалтаас үзэхэд Монгол Улсын Үндсэн хуульд албан ёсны тайлбар хийх эрх хэмжээ Улсын Их Хуралд Үндсэн хуулиар олгогдоогүй байна.

2.Иймд Улсын Их Хурал Үндсэн хуульд тайлбар хийж байгаа нь уг тайлбар Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхээс үл хамааран Үндсэн хууль зөрчиж, олгогдоогүй эрх хэмжээг Улсын Их Хурал эдлэж байна гэсэн иргэн Д.Ламжав, Н.Хайдав нарын гомдлыг ханган үндэслэлтэй байна.

3.Иргэн Д.Ламжав, Н.Хайдав нарын өргөдөлд дурдсан Улсын Их Хурал Үндсэн хууль тайлбарлахдаа Үндсэн хуулийн Жарандөрөвдүгээр зүйлийн 1, 2, Дөчиндолдугаар зүйлийн 1, 2, Тавьдугаар зүйлийн 1-ийн 4 дэх хэсгийг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаранзурагдугаар зүйл, Үндсэн хуулийн Цэцийн тухай хуулийн Арванесдүгээр зүйл, Үндсэн хуулийн Цэцэд Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн Гучингуравдугаар зүйлийг удирдлага болгон **ТОГТООХ нь:**

1.Монгол Улсын Их Хуралд Үндсэн хуульд албан ёсны тайлбар хийх эрх хэмжээ Үндсэн хуулиар олгогдоогүй байх тул Үндсэн хуулийн Гучдугаар зүйлийн 2, Жаранзургадугаар зүйлийн 4 дэх заалтуудыг тайлбарласан Монгол Улсын Их Хурлын 1993 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн 27 дугаар тогтоол, 2000 оны 7 дугаар сарын 26-ны өдрийн 10 дугаар тогтоолууд нь Монгол Улсын Үндсэн хуулийн Хоринтавдугаар зүйл, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн заалтуудыг зөрчсөн байна.

2.Улсын Их Хурал Үндсэн хууль тайлбарлахдаа Үндсэн хуулийн Дөчиндолдугаар зүйлийн 1, 2, Тавьдугаар зүйлийн 1-ийн 4, Жарандөрөвдүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байх тул иргэн Д.Ламжав, Н.Хайдав нарын дээрх зүйлтэй холбоотой гомдлыг хэрэгсэхгүй болгосугай.

3.Үндсэн хуулийн Цэцийн энэхүү дүгнэлтийг Улсын Их Хурлын чуулганы ажиллагаа эхэлсэн өдрөөс хойш 15 хоногийн дотор хэлэлцэн хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГА **Н.ЖАНЦАН**

ГИШҮҮД **Ж.БЯМБАЖАВ**

Ж.БОЛДБААТАР

Д.ЧИЛХААЖАВ

В.УДВАЛ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн эдэлбэл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 15 (202)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Гэрээ, хэлэлцээр, протокол соёрхон батлалсан тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *Нөхөн сонгууль зарлах тухай*
- *"Монгол Улсын Байгаль орчны гавьяат ажилтан" цол бий болгох тухай*

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

- *Төрийн захиргааны зарим албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв олгох тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалт батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2001 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2001 оны дөрөвдүгээр сарын 20 №15 (202

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

176. Гэрээ соёрхон батлах тухай (2001-4-5-ны хууль) 385
177. Гэрээ соёрхон батлах тухай (2001-4-5-ны хууль) 386
178. Гэрээ соёрхон батлах тухай (2001-4-5-ны хууль) 386
179. Хэлэлцээр соёрхон батлах тухай (2001-4-5-ны хууль) 386
180. Протокол соёрхон батлах тухай (2001-4-5-ны хууль) 386

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

181. Нөхөн сонгууль зарлах тухай Дугаар 25 386
182. Нөхөн сонгуулийн зардлын хэмжээ тогтоох тухай Дугаар 26 387
183. "Монгол Улсын Байгаль орчны гавьяат ажилтан" цол бий болгох тухай Дугаар 27 387

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

184. Уильям Бикалесийг "Найрамдал" медалиар шагнах тухай Дугаар 73 388
185. Д.Алтангэрэлийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай Дугаар 75 388
186. Зарим шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийг томилж, чөлөөлөх тухай Дугаар 79 388
187. Төрийн захиргааны зарим албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв олгох тухай Дугаар 80 388

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

188. Хөтөлбөр батлах тухай Дугаар 35 389
189. Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалт батлах тухай Дугаар 36 402
190. Тогтоол хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Дугаар 37 408
191. Эрүүл мэндийн улсын хяналтын дүрэм батлах тухай Дугаар 38 411

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр **Улаанбаатар хот**

ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын хооронд 2001 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр гарын үсэг зурсан Иргэн болон аж ахуйн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Гэрээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр — Улаанбаатар хот

ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын хооронд 2001 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр гарын үсэг зурсан Гэмт этгээдийг шилжүүлэн өгөх тухай Гэрээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлалсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 4 дүгээр сарын 5–ны өдөр — Улаанбаатар хот

ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улс, Бүгд Найрамдах Энэтхэг Улсын хооронд 2001 оны 1 дүгээр сарын 3-ны өдөр гарын үсэг зурсан Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх тухай Гэрээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлалсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр — Улаанбаатар хот

ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улаанбаатар хотноо 1998 оны 6 дугаар сарын 5-ны өдөр гарын үсэг зурсан Орлого ба хөрөнгийн татварыг давхардуулж ногдуулахгүй байх, татвар төлөхөөс зайлсхийх явдлаас урьдчилан сэргийлэх тухай Монгол Улсын Засгийн газар, Люксембургийн Вант Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээрийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлалсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 4 дүгээр сарын 5-ны өдөр — Улаанбаатар хот

ПРОТОКОЛ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Чикаго хотноо 1944 оны 12 дугаар сарын 7-ны өдөр батлагдсан Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцийн өөрчлөлт болох Монреаль хотноо 1977 оны 9 дүгээр сарын 30-ны өдөр гарын үсэг зурсан Олон улсын иргэний нисэхийн тухай Конвенцид нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Протоколыг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлалсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 4 дүгээр сарын 5–ны өдөр — Дугаар 25 — Улаанбаатар хот

Нөхөн сонгууль зарлах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3, Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн 42 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 22 дугаар тойрогт нөхөн сонгуулийг 2001 оны 4 дүгээр сарын 5-ны өдрөөс товлон зарласугай.

2. Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 22 дугаар тойрогт явуулах нөхөн сонгуулийн санал хураалтыг 2001 оны 5 дугаар сарын 20-ны өдөр явуулахаар тогтоосугай.

3. Энэ тогтоолыг 2001 оны 4 дүгээр сарын 5-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 4 дүгээр сарын 5–ны өдөр **Дугаар 26** **Улаанбаатар хот**

Нөхөн сонгуулийн зардлын хэмжээ тогтоох тухай

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Сонгуулийн ерөнхий хорооноос ирүүлсэн саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 22 дугаар тойрогт явуулах нөхөн сонгуулийн улсын төвлөрсөн төсвөөс санхүүжүүлэх зардлын хэмжээг 4553100 төгрөгөөр тогтоож, сонгуулийн зардлыг Засгийн газрын нөөцөөс санхүүжүүлэхийг Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай.

2.Энэ тогтоолыг 2001 оны 4 дүгээр сарын 5-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 4 дүгээр сарын 5–ны өдөр **Дугаар 27** **Улаанбаатар хот**

"Монгол Улсын Байгаль орчны гавьяат ажилтан" цол бий болгох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн хорин тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 13 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1."Монгол Улсын Байгаль орчны гавьяат ажилтан" цол бий болгосугай.

2."Монгол Улсын Байгаль орчны гавьяат ажилтан" цол хүртээх дүрмийг хавсралт ёсоор батлуулсугай.

3.Энэ тогтоол гарсантай холбогдуулан БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэрүүлэгчдийн 1967 оны 174 дүгээр зарлиг, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэрүүлэгчдийн 1973 оны 203 дугаар зарлиг, БНМАУ-ын Ардын Их Хурлын Тэрүүлэгчдийн 1978 оны 232 дугаар зарлигийг цаашид дагаж мөрдөхгүй байхаар тогтоож, эдгээр зарлигаар гавьяат цол өмнө олгогдож байсан хүмүүсийн хувьд үг цол нь хүчинтэй хэвээр байхаар тоодсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

Улсын Их Хурлын 2001 оны 27 дугаар тогтоолын хавсралт

"МОНГОЛ УЛСЫН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАВЬЯАТ АЖИЛТАН" ЦОЛ ХҮРТЭЭХ ДҮРЭМ

1."Монгол Улсын Байгаль орчны гавьяат ажилтан" цолыг байгаль орчны салбарт олон жил идэвх зүтгэл, үр бүтээлтэй ажиллаж, хөдөлмөрийн онцгой, тогтвортой амжилт гаргасан байгаль хамгаалагч, байгаль орчны хяналтын улсын байцаагч, ажилчин, инженер, техникч, эрдэмтэн, багш, сурган хүмүүжүүлэгч, байгаль орчны салбарын удирдах ажилтан болон цэвэр үйлдвэрлэл хөгжүүлэх чиглэлээр байгаль орчинд халгүй техник, технологи нэвтрүүлэн үр нөлөөтэй ажиллаж байгаа аж ахуйн нэгж, байгууллагын инженер техникч, удирдах ажилтанд олгоно.

2."Монгол Улсын Байгаль орчны гавьяат ажилтан" цол хүртэх нэр дэвшиг нь байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг нөхөн сэргээх, зүй зохистой ашиглах, орчны бохирдол, доройтлыг бууруулах, ус, цаг уурын мэдээллийг үнэн зөв шуурхай гаргах, иргэдэд экологийн боловсрол олгох, байгаль орчны судалгаа, эрдэм шинжилгээний ажлын үр өгөөжийг дээшлүүлэх үйлст онцгой амжилт гаргасан, байгаль орчныг хамгаалах ажлыг өргөн хүрээтэй сурталчилдаг, ажлын арга туршлагаа бусдад зааж дэлгэрүүлдэг, нэр хүнд сайтай иргэн байвал зохино.

3."Монгол Улсын Байгаль орчны гавьяат ажилтан" цолыг Монгол Улсын Ерөнхийлөгч зарлиг гаргаж хүртээнэ.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 3 дугаар сарын 22–ны өдөр **Дугаар 73** **Улаанбаатар хот**

Уильям Бикалесийг "Найрамдал" медалиар шагнах тухай

Монгол Улс, АНУ-ын харилцааг өргөжүүлэх, манай үндэсний мэргэжилтэн боловсон хүчнийг дадлагажуулан сургахад оруулсан хувь нэмрийг нь үнэлж Монгол Улсын Засгийн газраас АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагтай хамтран хэрэгжүүлж буй "Эдийн засгийн бодлогыг дэмжих төсөл"-ийн удирдагч, зөвлөх Уильям Бикалесийг "Найрамдал" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 3 дугаар сарын 27–ны өдөр **Дугаар 75** **Улаанбаатар хот**

Д.Алтангэрэлийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын "Шүүхийн тухай" хуулийн 51 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Тэтгэвэрт гарах насанд хүрсэнтэй холбогдуулан Даниагийн Алтангэрэлийг Монгол Улсын дээд шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 4 дүгээр сарын 03–ны өдөр **Дугаар 79** **Улаанбаатар хот**

Зарим шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийг томилж, чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн 51 дүгээр зүйл, "Шүүхийн тухай" хуулийн 6, 51 дүгээр зүйлийг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

1. Дулмаагийн Оюундарийг Сэлэнгэ аймгийн шүүхийн шүүгчийн, Бодьгэрэлийн Бямбасүрэнг Дорноговь аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Магсарын Нармандахыг Хөвсгөл аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

2. Адилбишийн Сайнтөгсийг Дундговь аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлж, мөн шүүхийн ерөнхий шүүгчээр томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 4 дүгээр сарын 04-ний өдөр **Дугаар 80** **Улаанбаатар хот**

Төрийн захиргааны зарим албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв олгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн, Монгол Улсын Засгийн газрын саналыг харгалзан ЗАРЛИГ болгох нь:

1. Хавсралтад дурдсан төрийн захиргааны албан хаагчдад төрийн захиргааны төрүүн түшмэлийн албан тушаалын зэрэг дэв олгосугай.

2. Энэ зарлигийг 2001 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2001 оны 80 дугаар зарлигийн хавсралт

ТЭРГҮҮН ТУШМЭЛИЙН АЛБАН ТУШААЛЫН ЗЭРЭГ ДЭВ ОЛГОСОН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧДЫН НЭРСИЙН ЖАГСААЛТ

№	Овог, нэр	Албан тушаал	Албан тушаалын зэрэглэл	Ажилласан хугацаа /жилээр/		Үйл ажиллагаа, мэргэшлийн түвшингийн үнэлгээ	Олгосон зэрэг дэв
				Төрийн албанд	Тухайн албан тушаалд		
1	Пандийн Бямбацэрэн	УИХ-ын Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн даргын орлогч	АА-1	24	5	А	Дэд зэрэг
2	Жамъянгийн Батсайхан	УИХ-ын Тамгын газрын албаны дарга	АА-2	20	4	Б	Гуттаар зэрэг
3	Банзрагчийн Одонжил	УИХ-ын Тамгын газрын хэлтсийн дарга	АА-2	17	7	Б	Дөтгөөр зэрэг
4	Дагдангийн Намсрай	Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга	АА-1	24	4	Б	Дөтгөөр зэрэг
5	Нанзадын Ганбаяр	Шүүхийн ерөнхий зөвлөлийн нарийн бичгийн дарга	ТӨ-Үl А	25	1	А	Гуттаар зураг

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 2 дугаар сарын 20-ны өдөр **Дугаар 35** **Улаанбаатар хот**

Хөтөлбөр батлах тухай

"Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль"-ийн 9 дүгээр зүйлийн 4 дэх заалт, 33 дугаар зүйл, Улсын Их Хурлын 2001 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл"-ийн 1.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Төрийн өмчийг 2001 онд хувьчлах хөтөлбөр"-ийг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэхүү хөтөлбөрийг холбогдох хууль тогтоомж, "Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл"-ийн дагуу холбогдох яамдтай хамтран зохион байгуулж, хэрэгжүүлэхийг Төрийн өмчийн хорооны дарга Л.Пүрэвдоржид даалгасугай.

3. Засгийн газрын 1999 оны 159 дүгээр тогтоолоор батлагдсан "Нийтийн аж ахуй, үйлчилгээний салбарыг хувьчлах хөтөлбөр"-ийн дагуу 2001 онд хувьчлах ажлыг хугацаа алдалгүй зохион байгуулахыг Дэд бүтцийн сайд Б.Жигжид, Төрийн өмчийн хорооны дарга Л.Пүрэвдорж, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

4. Дуудлагын худалдааны аргаар хувьчлах төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн худалдагдах үнийн дүнгийн 10 хүртэл хувьд хөрөнгө оруулагтын эрхийн бичгийн баталгаажуулсан ягаан тасалбарыг төлбөрт тооцон авахыг Төрийн өмчийн хорооны дарга Л.Пүрэвдоржид зөвшөөрсүгэй.

5. Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Засгийн газрын 1998 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн "Хөрөнгө оруулагтын эрхийн бичгийн баталгаажуулсан ягаан тасалбарыг төлбөрт тооцох тухай" 57 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

Засгийн газрын 2001 оны 35 дугаар тогтоолын хавсралт

ТӨРИЙН ӨМЧИЙГ 2001 ОНД ХУВЬЧЛАХ ХӨТӨЛБӨР

Нэг. Өмч хувьчлалын зорилго

2001 оны өмч хувьчлалын зорилго нь Улсын Их хурлын 2001 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл"-ийг хэрэгжүүлж, үнэ цэнэтэй аж ахуйн нэгж болон бусад аж ахуйн нэгж, эд хөрөнгийг хувьчлах дэд бүтэц, нийгмийн салбарт бүтцийн өөрчлөлт хийж хувьчлах бэлтгэлийг ханган замаар эдийн засаг дахь хувийн хэвшлийн үүрэг, оролцоог улам нэмэгдүүлж, зах зээлд шилжих шилжилтийг эрчимжүүлэн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэх, өсөлтийг ханган нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Хоёр. Өмч хувьчлалын зарчим

Улсын Их хурлын 2001 оны 10 дугаар тогтоолоор батлагдсан "Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл"-д тусгагдсан зарчмыг баримтална.

Гурав. Хувьчлах хуулийн этгээд, эд хөрөнгийн жагсаалт

Энэхүү хөтөлбөрт хамрагдах хувьчлах хуулийн этгээд, эд хөрөнгийн жагсаалт нь дараахь гурван чиглэлээс бүрдэнэ:

1. 2001 онд хувьчлах төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжийн жагсаалт (хавсралт №1);

2. 2001 онд хувьчлах дуусаагүй барилга байгууламжийн жагсаалт (хавсралт №2);

3. 2001 онд өөрчлөн байгуулалт хийх, хувьчлах бэлтгэлийг ханган аж ахуйн нэгж, байгууллагын жагсаалт (хавсралт №3).

Дөрөв. Хөтөлбөр, жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулах

Хөтөлбөр болон хувьчлах хуулийн этгээд, эд хөрөнгийн жагсаалтад дор дурдсан нөхцөлд нэмэлт, өөрчлөлт оруулна:

4.1. Монгол Улсын иргэн, эсвэл гадаадын иргэн, дотоод, гадаадын аж ахуйн нэгж тухайн аж ахуйн нэгжийг хувьчлуулах санал хүсэлт гаргасан;

4.2. Хувьчлах шийдвэр гарсан боловч холбогдох хууль тогтоомжийн дагуу татан буугдсан аж ахуйн нэгжийг жагсаалтаас хасч, хөрөнгийг зохих журмын дагуу хувьчлах;

4.3. Тодорхой салбар, үйлдвэрлэлийн үйл ажиллагааны хүрээнд олон улсын банк, санхүүгийн байгууллага болон хандивлагчдын зүгээс томоохон хэмжээний төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхтэй холбогдсон тусгай шаардлага гарсан;

4.4. Тухайн аж ахуйн нэгжийг энэхүү хөтөлбөр, жагсаалтад зааснаас өөр аргаар хувьчлах шийдвэрийг эрх бүхий байгууллагаас гаргасан;

4.5. Хувьчлах хөтөлбөрийн жагсаалтад орсон аж ахуйн нэгж хуваагдах бүюу тусгаарласны үндсэн дээр шинээр байгуулагдсан аж ахуйн нэгжүүдийн аль нь ч компанийнхаа анхны нэрийг өөлөн авааагүй тохиолдолд жагсаалтад орсон аж ахуйн нэгжийн нэрийг жагсаалтаас хасч шинээр бий болсон аж ахуйн нэгжүүдийн нэрийг холбогдох жагсаалтад оруулах, тухайн аж ахуйн нэгжийг салган хувьчлуулах санал гаргаж түүнийг холбогдох яам болон Төрийн өмчийн хороо албан ёсоор зөвшөөрсөн байх ба хэрэв тухайн аж ахуйн нэгж өр зээлтэй бол томоохон зээлдүүлэгчийн санал авсан тохиолдолд.

Тав. Хөтөлбөрийн хэрэгжилтийг тайлагнах

Энэхүү хөтөлбөрийн хэрэгжилтийн явцыг 2001 оны 7 дугаар сарын 15-ны дотор, биелэлтийг 2002 оны 1 дүгээр сарын 25-ны дотор Төрийн өмчийн хороо холбогдох яам, агентлагтай хамтран гаргаж Засгийн газарт тайлагнана.

2001 ОНД ХУВЬЧЛАХ ТӨРИЙН ӨМЧИТ БОЛОН ТӨРИЙН ӨМЧИЙН ОРОЛЦООТОЙ АЖ АХУЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ

д/д	Аж ахуйн нэгжийн нэр, хэлбэр	Байршил	Үндсэн үйл ажиллагаа	Хувьчлах төрийн өмчийн хувь	Хувьчлах хугацаа /улирал/	Хувьчлах арга	Хувьчлах хэлбэр, нөхцөл
1	"НИК" ХК	Улаан-баатар	Нефтийн бүтээгдэхүүн импортлох, борлуулах	80	I - IУ	Уралдаант шалгаруулалт	1.Нефть бүтээгдэхүүн үйлдвэрлэх,борлуулах бизнес эрхэлдэг, дотоод, гадаадын стратегийн хөрөнгө оруулагчдын дунд ; 2.Монгол Улсын эдлагдсан аймаг, сум дахь шатахуун түгээх станцыг нефть бүтээгдэхүүнээр хангах нөхцөлөөр. Засгийн газраас алтан хувьцаа гаргах.
2	"Говь" ХК	Улаан-баатар	Ноос, ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэх	70*	I - IУ	Уралдаант шалгаруулалт	Монгол ноолуураар үр ашигтай зүсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх урт хугацааны стратегийг хэрэжүүлэх чадвартай, олон улсын хэмжээнд нэр хүнд бүхий, санхүүгийн чадавхитай гадаад,дотоодын хөрөнгө оруулагчдын дунд
3	"Худалдаа, хөгжлийн банк" ХХК	Улаан-баатар	Банк	70	I - IУ	Уралдаант шалгаруулалт	Олон улсын хэмжээнд нэр хүнд бүхий,улс хоорондын банкны үйл ажиллагааны түршлага хуримтлуулсан дотоод, гадаадын стратегийн хөрөнгө оруулагчдын дунд
4	"МИАТ" ТӨҮГ	Улаан-баатар	Агаарын тээвэр	100	II-IУ	Уралдаант шалгаруулалт	Хөрөнгө оруулалт хийж, үйл ажиллагаа, үйлчилгээг нь сайжруулах, техник, технологийн шинэчлэл хийх санхүүгийн чадавхитай, олон улсын хэмжээнд нэр хүнд бүхий гадаадын авиакомпаниудын дунд

5	"Монгол шуудан банк" ХХК	Улаан-баатар	Банк	4,7	II	Дуудлагын худалдаа	Нийтийн
6	Улаанбаатарын II цахилгаан станц /ТӨҮГ/	Улаан-баатар	Эрчим хүч үйлдвэрлэл	100	III	Ураддаант шалгаруулалт	ТӨҮГ-ыг хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлснийг үндэсэн дээр эрчим хүчний салбарт олон улсын хэмжээнд нэр хүндтэй,эрчим хүчний техник, технологийн шинэчлэл хийх санхүүгийн чадавхитай дотоод, гадаадын стратегийн хөрөнгө оруулагчдын дунд
7	Эрчим хүчний нэгдсэн үйлдвэр /дизель цахилгаан станц//ТӨҮГ/	Баян-хонгор	Эрчим хүч үйлдвэрлэл	100	III	Менежментийн ур дүнг харгалзан хувьчлах	Тесел сонгон шалгаруулах үндсэн дээр
8	"Хотгор" ХК	Баян-Өлгий	Нүүрс	92,7	II	82,7%-ий дуудлагын худалдаагаар, 10% ийг хөрөнгө оруулалтын эрхийн бичгийн бататгаасан цэнхэр	Төрийн мэдлийн хувьцааны 82,7%-ийг бүтүүмжилсэн хэлбэрээр санал авах нөхцөлөөр. 10%- ий биржээр бичиит хийх нөхцөлөөр
9	Баянцагааны уурхай /ТӨҮГ/	Архангай	Нүүрс	100	III	Дуудлагын худалдаа	Нийтийн
10	"Монгол-Эрдэнэ холдинг" компани /ТӨҮГ/	Улаан-баатар	Геологи	100	II	Дуудлагын худалдаа	Нийтийн
11	"Улсын их дэлгүүр" ХК	Улаан-баатар	Худалдаа	15	I	Монголын хөрөнгийн биржээр	Төрийн мэдлийн хувьцаагаа арилжаалагдах хэмжээгээр багцалж худалдах
12	"Эрдэнэхайрхан" ХК	Орхон	Худалдаа	62,3	II	арилжаалах Дуудлагын худалдаа	Нийтийн
13	"АПУ" ХК	Улаан-баатар	Хүнс	51	II	Дуудлагын худалдаа	Нийтийн
14	"Түүл банк" ХК	Улаан-баатар	Ногооны зоорь	20	II	Монголын хөрөнгийн биржээр арилжаалах	
15	"Од банк" ХК	Улаан-баатар	Ногооны зоорь	51	II	Монголын хөрөнгийн биржээр арилжаалах	

16	"Журамт" ХХК	Завхан	Тэжээлийн аж ахуй	30	II	Дуудлагын худалдаа	Нийтийн
17	"Барилга байгууламж" ХК	Говь-Алтай	Барилга-угсралт	72,8	II	Дуудлагын худалдаа	Нийтийн
18	"Өгөөмөр" ХК	Төв	Барилга-угсралт	51	III	Дуудлагын худалдаа	Нийтийн
19	Карьерийн аж ахуй /ТӨҮГ/	Дорноговь	Барилгын материал	100	II	Дуудлагын худалдаа	Нийтийн
20	"Сэргэлт авто зам" компани /ТӨҮГ/	Улаан-баатар	Авто зам барих	100	II	Дуудлагын худалдаа	Нийтийн
21	"Дар зам" ХК	Дархан-Уул	Авто зам барих	51	III	Монголын хөрөнгийн биржээр арилжаалах	
22	"Мөнхжим" ХК	Увс	Авто зам барих	51	III	Монголын хөрөнгийн биржээр арилжаалах	
23	"Эрдэнэт авто зам" ХК	Орхон	Авто зам барих	55,2	II	Дуудлагын худалдаа	Нийтийн
24	Буга корпораци /ТӨҮГ/	Улаан-баатар	Буга үржүүлэг	100	II	Дуудлагын худалдаа	Нийтийн
25	"Цайз" компани /ТӨҮГ/	Улаан-баатар	Түүхий эдийн зах	100	II	Уралдаант шалгаруулалт	Нээлттэй төсөл сонгон шалгаруулах үндсэн дээр
26	"Чандгана" ХК	Хэнтий	Газар тариалан	51	III	Дуудлагын худалдаа	Нийтийн
27	Гал компани /ТӨҮГ/	Улаан-баатар	Галын машин, техникийн засвар	100	III	Менежментийн үр дүнг харгалзан хувьчлах	Төсөл сонгон шалгаруулах үндсэн дээр

Жич: * "Говь" ХК-ийн нийт хувьцааны 74,9 хувийг төр эзэмшдэг.

2001 ОНД ХУВЬЧЛАХ ДУУСААГҮЙ БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

д/д	Дуусаагүй барилга байгууламжийн байршил, нэр, хүчин чадал	Аймаг	Барьж эхэлсэн он	Зарцуулсан хөрөнгө оруулалтын хэмжээ /тухайн үеийн ханшаар, мян.төг./	Барилга угсралтын ажлын хэдэн хувь хийгдсэн	Хувьчлах хугацаа /улирлаар/	Хувьчлах арга хэлбэр
1	Хүнсний комбинатын өргөтгөл	Дархан-Уул	1990	8460.0	70	II	Нийтийн дуудлагын худалдаа
2	Өлгий сумын шүүх, прокурорын контор /40 хүн/	Баян-Өлгий	1995	9300.0	20	II	Нийтийн дуудлагын худалдаа
3	Бумбат сумын 200 үнээний механикжсан ферм	Баянхонгор	1989	16641.6	80	I	Нийтийн дуудлагын худалдаа
4	Баянхонгор сумын гоц халдвартын станцын барилгын гол корпус	Баянхонгор	1990	4766.6	80	I	Нийтийн дуудлагын худалдаа
5	Халхголын 500 тоннын хөргүүртэй зоорь, мал нядалгааны газар	Дорнод	1989	2385.1	34	II	Нийтийн дуудлагын худалдаа
6	Тамсагбулагийн "Ялалт" нэгдлийн төв \3О объект\	Дорнод	1987	31602.7	35	II	Нийтийн дуудлагын худалдаа
7	Хэрлэн сумын хөдөө аж ахуйн техникумын 44О сурагчтай сургууль	Дорнод	1989	8659.1	47	II	Уралдаант шалгаруулалт /хаалттай/

8	Хэрлэн сумын 800 машины засварын газар	Дорнод	1988	9086.0	24	II	Уралдаант шалгаруулалт /нээлттэй/
9	Сайхан дулаан сумын 160 хүүхдийн сургуулийн гуанз	Дорноговь	1990	488.8	60	I	Нийтийн дуудлагын худалдаа
10	Сайхан сумын соёлын төв	Булган	1989	560.0	40	I	Нийтийн дуудлагын худалдаа
11	Сэлэнгэ сумын ахуй үйлчилгээний төв	Булган	1991	825.8	50	I	Нийтийн дуудлагын худалдаа
12	Булган сумын 2 машины гараашт	Булган	1991	140.0	40	I	Нийтийн дуудлагын худалдаа
13	Ажилчдын 30 ортой сувилал	Орхон	1988	830.0	50	I	Уралдаант шалгаруулалт /хаалттай/
14	Баян-Өндөр сумын 500 суудалтай соёлын төв	Орхон	1989	3300.0	30	I	Уралдаант шалгаруулалт /нээлттэй/
15	Эсгий, эсгий гутлын үйлдвэр	Орхон	1988	54095.0	85	III	Уралдаант шалгаруулалт /нээлттэй/
16	Эрдэнэт дэх спорт заал	Орхон	1987	660.0	60	IV	Нийтийн дуудлагын худалдаа
17	30 автобусны засвар, үйлчилгээний станц	Орхон	1991	42700.0	65	III	Нийтийн дуудлагын худалдаа
18	Нэгдсэн эмнэлгийн төвийн 500 ортой эмнэлгийн А байр	Сүхбаатар	1990	3100.0	60	III	Уралдаант шалгаруулалт /хаалттай/
19	Баруун-Урт сумын 60 айлын орон сууц	Сүхбаатар	1990	5200.0	60	III	Нийтийн дуудлагын худалдаа
20	Баруун-Урт сумын театр	Сүхбаатар	1990	6400.0	40	III	Нийтийн дуудлагын худалдаа

21	Мандал сумын 5О амрачийн байр	Сэлэнгэ	1991	23000.0	70	IV	Нийтийн дуудлагын худалдаа
22	Улаангом сумын мах боловс руулах үйлдвэрийн А, Б, В, Г блок	Увс	1992	53400.0	80	II	Уралдаант шалгаруулалт /нээлттэй/
23	Улаангом сумын аммиакан агуулах	Увс	1990	1000.0	97	II	Уралдаант шалгаруулалт /нээлттэй/
24	Улаангом сумын хөргөх зоорь	Увс	1988	16810.0	90	II	Уралдаант шалгаруулалт /нээлттэй/
25	Улаангом сумын цэвэрлэх байгууламж	Увс	1989	1110.0	20	II	Уралдаант шалгаруулалт /нээлттэй/
26	Улаангом сумын шүгам сүлжээ	Увс	1989	5000.0	37	II	Уралдаант шалгаруулалт /нээлттэй/
27	Улаангом сумын түслэх бүтээгдэхүүний цех	Увс	1989	1870.0	8	II	Уралдаант шалгаруулалт /нээлттэй/
28	Улаангом сумын мах,тосны цех \7О тонн\	Увс	1990	2010.0	25	II	Уралдаант шалгаруулалт /нээлттэй/
29	Улаангом сумын автопүүний байр \3О тонн\	Увс	1990	380.0	42	II	Уралдаант шалгаруулалт /нээлттэй/
30	Түүл хорооны 3О ортой эмнэлэг	Улаанбаатар	1990	1920.0	20	III	Уралдаант шалгаруулалт /хаалттай/

31	Туул хорооны 29 айлын орон сууц \58х5\	Улаанбаатар	1991	8650,0	30	III	Нийтийн дуудлагын худалдаа
32	Баянхошуу дахь 24 айлын сууц	Улаанбаатар	1992	1800,0	6	III	Нийтийн дуудлагын худалдаа
33	Туул хороо 5-н 28 айлын орон сууц	Улаанбаатар	1991	8647,0	30	III	Нийтийн дуудлагын худалдаа
34	Баянзүрх дүүргийн ЗО машины гараашт	Улаанбаатар	1987	3800,0		III	Нийтийн дуудлагын худалдаа
35	Баянзүрх дүүргийн засвар үйлдвэрлэлийн байр	Улаанбаатар	1988	2500,0	40	III	Нийтийн дуудлагын худалдаа
36	Төрхурахын соёлын төв	Улаанбаатар	1989	1830,0	60	III	Нийтийн дуудлагын худалдаа
37	Төрхурахын бригадын барилга	Улаанбаатар	1989	750,0	58	III	Нийтийн дуудлагын худалдаа
38	Төрхурахын ЗО тн-ын тэжээлийн цех	Улаанбаатар	1988	2070,0	60	III	Нийтийн дуудлагын худалдаа
39	Төрхурахын үнэг,булганы дэвсгэр хадгалах байр	Улаанбаатар	1990	690,0	65	III	Нийтийн дуудлагын худалдаа
40	Төрхурахын ЗО тн-ын автопүүний байр	Улаанбаатар	1991	400,0	40	III	Нийтийн дуудлагын худалдаа
41	Төрхурахын өвчтэй мал нядлах байр	Улаанбаатар	1989	160,0	60	III	Нийтийн дуудлагын худалдаа
42	Үнэг, булганы саравч \10000 булга, 5000 үнэг\	Улаанбаатар	1989	1470,0	60	III	Нийтийн дуудлагын худалдаа
43	Сонгинохайрхан дүүрэг дэх 105 дугаар сургуулийн 720 хүүхдийн спорт заал	Улаанбаатар	1989	0,0		III	Урилдаант шалгарууллт /хаалттай/
44	Хөргүүлтэй агуулахын цогцолбор	Улаанбаатар	1990	100000,0	40	III	Нийтийн дуудлагын худалдаа

45	Жаргалант сумын цементийн үйлдвэр \15000 тонн\	Ховд	1991	73290.0	65	IV	Ураладсан шалгарупалт /хаалттай/
46	Зүүнмод сумын вааран эдлэлийн үйлдвэр	Төв	1987	14540.0	80	III	Нийтийн дуудлагын худалдаа
47	Зүүнмод сумын 29 айлын угсармал сууц	Төв	1989	1560.0	18	III	Нийтийн дуудлагын худалдаа
48	Эрдэнэ сумын 8 айлын сууц	Төв	1990	1350.0	80	III	Нийтийн дуудлагын худалдаа
49	Дадал сумын 75 трактор засварын газар	Хэнтий	1985	2300.0	100	III	Нийтийн дуудлагын худалдаа
50	Хэрлэн сумын төмөр бетон полигон цехийн тоног төхөөрөмж	Хэнтий	1988	6360.0	60	II	Нийтийн дуудлагын худалдаа
51	Дархан сумын тахианы байр	Дархан-Уул	1996	34373.0	70	II	Нийтийн дуудлагын худалдаа
52	Дархан сумын уурын зуух	Дархан-Уул	1991	7628.0		II	Нийтийн дуудлагын худалдаа
53	Дархан сумын цахилгаан, дулааны сантехникийн барилга	Дархан-Уул	1991	62024.0	60	II	Нийтийн дуудлагын худалдаа
54	Дархан сумын цахилгаан, дулааны сантехникийн барилга	Дархан-Уул	1991	57800.0	70	II	Нийтийн дуудлагын худалдаа
55	Өлзийт хорооны орон сууц	Улаанбаатар	1990	2340.0	50	III	Нийтийн дуудлагын худалдаа
56	Багануур дүүргийн 19О хүүхдийн ясли цэцэрлэг	Улаанбаатар	1989	2660.0	20	III	Ураладсан шалгарупалт /хаалттай/

57	Багануур дүүргийн дэд эртөө·	Улаанбаатар	1989	0,0	III	Нийтийн дуудлагын худалдаа
58	Батсүмбэр сумын минж үржүүлгийн өвлийн байр \1ОО толгой\	Төв	1984	0,0	50	III	Нийтийн дуудлагын худалдаа
59	Батсүмбэр сумын минж үржүүлгийн өвлийн байр - 2 \1ОО толгой\	Төв	1984	0,0	50	III	Нийтийн дуудлагын худалдаа
60	Зүүнмод сумын 35О хүний сөөлын төө	Төв	1990	1120.0.	65	III	Нийтийн дуудлагын худалдаа
61	Төв аймгийн Авдрантын 4О3 дугаар анхийн цэргийн байр	Төв	1993	1200.0	6	III	Нийтийн дуудлагын худалдаа
62	Хөдөө аж ахуйн машин засварын завод \45ОО трактор\	Дархан-Уул	1988	61119.0	60	III	Нийтийн дуудлагын худалдаа
63	Орхон сумын 48 айлын сууц	Дархан-Уул	1989	1498.0	45	III	Нийтийн дуудлагын худалдаа
64	Арвайхээр сумын цэвэр усны хангамж \2ООО\	Өвөрхангай	1989	3000.0	20	III	Нийтийн дуудлагын худалдаа
65	Улаангом сумын Чацарганы үйлдвэр	Увс				III	Үралдаант шалгарулалт /нээлттэй/
66	Улаангом сумын 50 ортой төрөхийн барилга	Увс	1991	3860.0	60	II	Үралдаант шалгарулалт /хаалттай/
					239024.0		

"Төрийн өмчийг 2001 онд хувьчлах хөтөлбөр"-ийн хавсралт №3

2001 ОНД ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАЛТ ХИЙХ, ХУВЬЧЛАХ БЭЛТГЭЛИЙГ ХАНГАХ АЖ АХУЙН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН ЖАГСААЛТ

№	Аж ахуйн нэгж, байгууллагын нэр	Өөрчлөн байгуулалт хийх ба хувьчлалын бэлтгэлийг хангахад баримтлах чиглэл
1	Хар төмөрлөгийн үйлдвэр	Өнөөгийн хүнд байдлыг арилгаж, цаашдын хэвийн ажиллагааг хангах нөхцөлөөр үйлдвэрийн удирдах үйл ажиллагааг удирдлагын гэрээгээр гүйцэтгүүлэх. Удирдлагын гэрээгээр ажиллах этгээдийг уралдаант шалгаруулалтаар сонгоно.
2	ТЭЦ-3	Бие даасан төрийн өмчит хувьцаат компани болгож бүтцийн өөрчлөлт хийх
3	ТЭЦ-4	
4	Дарханы цахилгаан станц	
5	Эрдэнэтийн цахилгаан станц	
6	Цахилгаан эрчим хүч дамжуулах, түгээх сүлжээний газрууд	
7	Эрчим хүчний их засвар хийдэг нэгж, хэсэг	Цахилгаан станц болон дамжуулах сүлжээний их засвар хийдэг нэгж, хэсгийг тусгаарлан компанийн хэлбэрт шилжүүлж хувьчлах ажлыг эхлэх
8	"АЗЗАН" ХК	Төвийн болон Баруун бүсийн авто замын засвар, арчлалтын нэгттэл болгон салгаж зохион байгуулах
9	"Дорнод Авто зам" ХК	Зүүн бүсийн авто замын засвар, арчлалтын толгой компани болгон өөрчлөн зохион байгуулах
10	"Архангай Авто зам" ХК	Авто замын засвар, арчлалтын хэсгийг тусгаарлан Зүүн, Төв, Баруун бүсийн толгойлох компанийн бүрэлдэхүүнд шилжүүлэн зохион байгуулах. Авто зам барилгын хэсгийг хуучин хэлбэрээр нь ажиллуулах
11	"Алтайн зам" ХК	
12	"Хөвсгөл-Автозам" ХХК	
13	"Завхан Улаа" ХК	
14	"Эрдэнэ зам" ТӨҮГ	Төрийн өмчит хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлж, хувьчлалын бэлтгэл ажлыг хангах
15	Замын цагдаагийн газар	Тээврийн хэрэгслийн жолооч бэлтгэх, сургалт зохион байгуулах, шалгалт авах, жолоочийн мэргэжил олгох үйл ажиллагааг Авто тээврийн газарт, авто замын ажуулгүй байдал, авто зам дээрх үйлчилгээтэй холбогдсон үүргийг Авто замын газарт тус тус шилжүүлэх

16	"МЦХ" ХК	Шуудан, цахилгаан холбооны газрын харилцаа холбооны суурь сүлжээний улс, хот хоорондын холболтын байгууламжаас бусад хөрөнгийг дахин үнэлэн, "Монголын цахилгаан холбоо" ХК-д шилжүүлж, төрийн эзэмшлийн хувьцааны хэмжээг нэмэгдүүлэхтэй холбогдсон тооцоо, судалгаа хийж, хувьчлах бэлтгэл ажлыг хангах
17	Нарны зайн үйлдвэр	Шуудан, цахилгаан холбооны газрын бүтцээс салган, бие даасан төрийн өмчит хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлэх
18	"Монгол Даатгал" ТӨҮГ "Түшиг даатгал" ТӨҮГ	Олон улсын хэмжээнд нэр хүнд бүхий, санхүүгийн чадавхитай, даатгалын үйл ажиллагааг амжилттай явуулж ирсэн туршлагатай хөрөнгө оруулагчид уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах чиглэл баримтлан хувьчлалын бэлтгэлийг хангах.
19	"Бэрх-Уул" ТӨҮГ	Чандаганы нүүрсний уурхайн хамт хувьцаат компанийн хэлбэрт оруулан өөрчлөн зохион байгуулж, Бэрх-Уул тосгоны нийгмийн асуудлыг цогцоор нь шийдвэрлэх асуудлыг тусган хувьчлалын бэлтгэлийг хангах
20	"Монголболгаргео" ХХК	Төрийн эзэмшлийн хувийг Монголын талын оруулсан хөрөнгийн хэмжээгээр шинэчлэн тогтоох, хувьцаат компанийн хэлбэрт оруулах зэрэг асуудлыг шийдвэрлэж, Болгарын талтай тохиролцон хувьчлалын бэлтгэлийг хангах
21	"Монгол-Амикаль" ХХК	Монголын талаас хөрөнгө оруулахтай холбогдон үүссэн өрийн асуудлыг шийдвэрлэж, Америкийн талтай тохиролцсоны үндсэн дээр төрийн эзэмшлийн хувийг хувьчлах бэлтгэл ажлыг хангах
22	Хөтөл дэх "Цемент шохойн үйлдвэр" ТӨҮГ	Төрийн өмчит хувьцаат компанийн хэлбэрт шилжүүлж, хувьчлалын бэлтгэлийг хангах
23	Эрүүл мэнд, боловсролын салбар	"Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл"-д заасны дагуу гадаад, дотоодын нэмэлт хөрөнгө оруулалт хийх болон гэрээний үндсэн дээр ажиллуулах эрүүл мэнд, боловсролын байгууллага, үйлчилгээний нэр төрлийг сонгох ажлыг төрийн захиргааны төв байгууллагууд хамтран зохион байгуулах
24	Биеийн тамир, спортын төв ордон	Зориулалтынх нь дагуу ашиглах нөхцөлөөр удирдлагын гэрээгээр ажиллуулах. Удирдлагын гэрээгээр ажиллах эгээдийг уралдаант шалгаруулалтаар тогтооно /Удирдлагын гэрээгээр эд хөрөнгө, хөрөнгийн эрх хувийн өмчид шилжихгүй/.
25	"Цав" ТӨҮГ	Өр авлагын асуудлыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагууд хамтран шийдвэрлэх

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 2 дугаар сарын 20-ны өдөр Дугаар 36 **Улаанбаатар хот**

Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх барилга байгууламж,төсөл,арга хэмжээний жагсаалт батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар 2001 онд санхүүжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалтыг 1 дүгээр хавсралт, улсын төвлөрсөн төсвийн болон замын сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх зам, гүүрийн барилга байгууламж, арга хэмжээний жагсаалтыг 2 дугаар хавсралт, хөрөнгийн эх үүсвэрийн хуралцээгүйгээс 2000 онд бүрэн санхүүжигдэлгүй шилжин ирсэн барилга байгууламж, төсөл, арга хэмжээний жагсаалтыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус батална.

2. Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгах нь:

а/хөрөнгийн эх үүсвэрийн хуралцээгүйгээс 2000 онд бүрэн санхүүжигдэлгүй шилжин ирсэн, 3 дугаар хавсралтад дурдсан барилга байгууламж, төсөл, арга хэмжээг 2001 онд бүрэн санхүүжүүлсүгэй;

б/өмнөх оноос шилжиж ирсэн санхүүжилтийн өрийг барагдуулах, энэ онд батлагдсан барилга байгууламж, төсөл, арга хэмжээг хугацаанд нь ашиглалтад оруулахын тулд емч хувьчлалын орлогыг төвлөрсөн төсөвт бүрэн төвлөрүүлж зөвхөн хөрөнгө оруулалтын санхүүжилтэд ашигласугай.

3. "Монгол Улсын 2001 оны төвлөрсөн төсвийн тэнцлийн тухай" Улсын Их Хурлын 2000 оны 49 дүгээр тогтоолыг үндэслэн өмч хувьчлалын орлого, гадаадын санхүүгийн зээлийн хэмжээ төлөвлөсөн хэмжээнээс давж биелсэн тохиолдолд санхүүжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээг 4 дүгээр хавсралт ёсоор батлуулсугай.

4. Улсын төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх барилга байгууламж, төсөл, арга хэмжээний гүйцэтгэлийн явц, төлийн ач холбогдол, ашиглалтад оруулах хугацаа, санхүүжилтийн байдалд хяналт тавьж, захиалагч байгууллагуудтай тохиролцон энэ тогтоолоор батлагдсан хөрөнгийн дүнд багтаан шаардлагатай зохицуулалт хийж ажиллахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

Засгийн газрын 2001 оны 36 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

УЛСЫН ТӨВЛӨРСӨН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР 2001 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

д/д	Барилга байгууламж, төсөл, арга хэмжээний нэр, байршил, хүчин чадал	Эхлэх, дуусах хугацаа	Нийт төсөвт өртөг	Үүнээс: 2001 онд санхүүжих	Ерөнхий захиалагч
	А	1	2	3	4
I	**ДУЛААНЫ СТАНЦ**				
1	Чойбалсан хотын ДЦС-ын шинэчлэлтийн Монголын талын хөрөнгө	1999-2001	1 600,0	200,0	ДБЯ
2	Даланзадгад сумын дулааны цахилгаан станцын инженерийн гадна шугам сүлжээ	1999-2001	1 839,0	400,0	ДБЯ
	Дүн		3 439,0	600,0	
II	**ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ШУГАМ, ДЭД ӨРТӨӨ**				
II.1	**110 кВт-ын шугам, дэд станц**				
1	Сайншанд-Замын -Үүдийн 110 кВт-ын шугам, дэд станц, 205 км	2001-2002	3 000,0	851,0	ДБЯ
	Дүн		3 000,0	851,0	
II.2	**35 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд өртөө**				
1	Даланзадгад-Хүрмэн сум, 45 км, Өмнөговь	2001-2001	480,0	480,0	ДБЯ
2	Баянгол-Төгрөг сум, 46.1 км, Өвөрхангай	2001-2001	704,0	654,0	ДБЯ
3	Ховд-Дуут сум, 85 км, Ховд	2001-2002	1 200,0	250,0	ДБЯ
4	Алтанбулаг-Баян-Өнжүүл сум, 80.4 км, Төв	2001-2002	1080,0	300,0	ДБЯ
6	Мянгад-Эрдэнэбүрэн сум, 58,2 км, Ховд	1999-2001	741	325,0	ДБЯ

	А	1	2	3	4
7	Баянгол-Сайхан-Овоо сум, 55 км, Дундговь	1999-2001	688,0	100,0	ДБЯ
8	Баруун-Урт-Халзан сум, 68 км, Сүхбаатар	2000-2001	659,6	325,0	ДБЯ
9	Бэрх-Батноров сум, 35 км, Хэнтий	2000-2001	459,3	300,0	ДБЯ
10	Өндөр-Улаан-Тариат сум, 52 км, Архангай	2000-2001	600,0	328,3	ДБЯ
11	Цахилгаан шугам сүлжээний алдагдлыг багасгах төсөл, /ДБ-ны зээлийн дотоод эх үүсвэр/ УБ	2001-2003	1 700,0	130,0	ДБЯ
	Дүн		8 311,9	3 192,3	
II.3	**10 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд өртөө**				
1	Сагсай-Буянт сум, 45 км, Баян-Өлгий	2001-2001	184,0	184,0	ДБЯ
2	Хутаг-Өндөр-Тэшиг сум, 60 км, Булган	2001-2001	280,0	280,0	ДБЯ
3	Баруун-Урт-Асгат сум, 45 км, Сүхбаатар	2001-2001	184,0	184,0	ДБЯ
	Дүн		648,0	648,0	
III	**СЭРГЭЭГДЭХ ЭРЧИМ ХҮЧ**				
1	Нар, салхины эрчим хүчийг ашиглах	2000-2004	1300,0	200,0	ДБЯ
	Дүн		1300,0	200,0	
IY	**УСАН ЦАХИЛГААН СТАНЦ**				
1	Улаанбоомын усан цахилгаан станц, 8 мВт, Монголын талын хөрөнгө	2001-2003	6 800,0	1000,0	ДБЯ
2	Усан цахилгаан станц, 150 кВ, Мөнххайрхан Ховд	2001-2002	300,0	100,0	ЗДТГ
	Дүн		7 100,0	1100,0	
Y	**ТҮЛШ**				
1	Олонбулагийн нүүрсний уурхай, Үенч, Ховд	2001-2002	110,0	50,0	ДБЯ
	Дүн		110,0	50,0	
YI	**ТЭЭВЭР**				
1	Нисэх буудлын барилга, Баян-өлгий	2000-2002	828,9	100,0	ДБЯ
	Дүн		828,9	100,0	
YII	**АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ**				
1	"Орон нутгийн НААУ-г сэргээн хөгжүүлэх төсөл"-ийн Монголын талын хөрөнгө, Баруун таван аймагт	1998-2001	1 789,0	1 533,1	ДБЯ
2	Хлоржуулах системийн шинэчлэлт, аймгуудад	1997-2004	474,6	50,0	ДБЯ
3	"Орон нутгийн НААУ-г сэргээн хөгжүүлэх төсөл"-ийн 2 дахь зээлжийн Монголын талын хөрөнгө, Төв болон зүүн аймгууд	2001-2003	4 000,0	100,0	ДБЯ
4	Цэвэр усны нөөцийн сан 1000 м3, Даланзадгад	2001-2001	300,0	300,0	ДБЯ
5	Аймаг, сумын төвийн нийтийн халуун ус	2001-2001	340,0	340,0	ДБЯ
6	Бохир усны шугам, 3.1 км, Улаанбаатар	2000-2001	867,2	667,2	ДБЯ
	Дүн		7 770,8	2 990,3	
YIII	**ОРОН СУУЦ**				
1	Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэж цагаатгагдсан иргэдийн болон ар гэрийнхэнд орон сууц худалдан авах	2001-2001	100,0	100,0	НЗДТГ
2	Парламентын гишүүдийн нэгдсэн байр барих болон АИХ-ын чуулганы танхимыг УИХ-ын танхим болгон өөрчлөх бэлтгэл ажил, зураг төсөв	2001-2001	100,0	100,0	УИХ
	Дүн		200,0	200,0	
IX	**ХӨДӨӨ АЖ АХУЙ**				
1	Усалгаатай тариалан эрхлэх, Ховдын Булган, Үенч сум, гурилын үйлдвэр Булган сум	2000-2001	190,0	100,0	ХХААЯ
	Дүн		190,0	100,0	
X	**ЭРҮҮЛ МЭНД**				
1	"Эрүүл мэндийн хөгжил хөтөлбөр" -ийн Монголын талын хөрөнгө	1998-2002	1 688,3	410,0	ЭМЯ
2	Сумын хүн эмнэлэг 15 ор, Увс Бөхмөрөн	2001-2001	100,0	100,0	ЭМЯ
3	Хавдар судлалын төв, зарим аймгийн эмнэлгүүдэд эмчилгээ, оношилгооны иж бүрэн тоног төхөөрөмж суурилуулах ажлын Монголын талын хөрөнгө	2001-2004	4 000,0	200,0	ЭМЯ
	Дүн		5 788,3	710,0	
XI	**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ**				
1	"SOS" хүүхдийн тосгоны Монголын талын хөрөнгө	2001-2001	27,7	27,7	НХХЯ

	А	1	2	3	4
2	Ахмад настан, ядуу хүмүүсийн асрамж, халамж, үйлчилгээний тевийн барилга, Төв аймаг, УБ Чингэлтэй дүүрэг	2001-2001	30,0	30,0	НХХЯ
	Дүн		57,7	57,7	
XII	**БОЛОВСРОЛ**				
1	Сургуулийн барилгын дуусгал, 320 суудал, Бор-Өндөр, Хэнтий	2000-2001	452,7	342,7	БСШУЯ
2	Сургуулийн барилгын дуусгал,928 суудал,Өндөрхаан, Хэнтий	2000-2001	704,6	570,6	БСШУЯ
3	Сургуулийн барилгын дуусгал,240 суудал, Сэлэнгэ	2000-2001	279,5	199,5	БСШУЯ
4	Өлгий сумын 8 жилийн сургуулийн барилгын дуусгал, Баян-Өлгий	2000-2001	196,6	96,6	БСШУЯ
5	Сургуулийн барилгын дуусгал, 160 суудал, Эрдэнэ, Дорноговь	2000-2001	223,0	123,0	БСШУЯ
6	8 жилийн сургуулийн барилгын дуусгал,Жаргалант, Архангай	1995-2001	205,0	60,0	ЗДТГ
7	Хичээлийн байрны өргөтгөл. Төв Цээл	2001-2002	148,0	100,0	ЗДТГ
8	Сургуулийн барилга, Баянхонгор Гурванбулаг	2001-2002	384,2	75,0	ЗДТГ
	Дүн		2 593,6	1 567,4	
XIII	**АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ**				
1	"Аялал жуулчлал хөгжүүлэх төсөл" -ийн дотоод эх үүсвэр	2001-2003	150,0	50,0	ДБЯ
	Дүн		150,0	50,0	
XIY	**БАТЛАН ХАМГААЛАЛ**				
1	Цэргийн байр, Эрдэнэт / 186-р анги /	2000-2001	195,0	145,0	БХЯ
2	Орон сууцны халаалтын зуух БЗУИ-100х4 , гадна инженерийн шугам сүлжээ, Өвөрхангай, Арвайхээр, 256-р анги /	2001-2001	140,0	140,0	БХЯ
3	Орон сууц, 48 айл, Өвөрхангай	2000-2001	256,0	193,0	БХЯ
	Дүн		591,0	478,0	
XY	**ХИЛ ХАМГААЛАЛ**				
1	Тамсагбулагийн хилийн хороо, Дорнод Матад	1999-2002	750,0	150,0	ХЦУГ
2	Хилийн хороонд байр худалдаж авах, засварлах.Увс Баруунтуруун	2001-2001	175,0	175,0	ХЦУГ
	Дүн		925,0	325,0	
XYI	**НИЙГМИЙН ХЭВ ЖУРАМ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ**				
1	Цагдаагийн хэлтэс, цагдан хорих, Увс	2000-2002	459,0	190,3	ЦЕГ
2	Цагдаагийн хэлтэс, урьдчилан хорих, эрүүлжүүлэх байр, гадна холболт Дундговь	2000-2001	210,0	110,0	ЦЕГ
	Дүн		669,0	300,3	
XYII	**ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭЛ**				
1	Дотоодын цэргийн байр	2000-2001	160,0	90,0	ШШБЕГ
2	Хөрс хуулалт	2000-2004	490,0	80,0	ШШБЕГ
	Дүн		650,0	170,0	
XYIII	**БАЙГАЛЬ ОРЧИН**				
1	Аэрологийн станцуудын өргөтгөл, Улаангом, Дорнод	2001-2001	40,0	40,0	БОЯ
2	Нисэх буудлуудад салхины ажиглалтын цамхаг байгуулах, 4 буудалд	2001-2003	60,0	40,0	БОЯ
	Дүн		100,0	80,0	
XIX	**ГААЛИЙН САН**	1996-2002	7 190,0	3 500,0	УГЕГ
	Дүн		7 190,0	3 500,0	
XX	**ЗАМЫН САН**	1994-2004	31 214,9	10 000,0	ДБЯ
	Үүнээс: -төвлөрсөн төсвийн хөрөнгө			5 400,1	
	-замын сангийн хөрөнгө			4599,9	
XXI	**БУСАД**				
1	Барилга байгууламж, төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах зардал	2001-2001	100,0	100,0	СЭЗЯ
	Дүн		100,0	100,0	
XXII	**ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ**	2001-2001	2 300,0	2 300,0	СЭЗЯ
	ТӨВЛӨРСӨН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН НИЙТ ДҮН		85 038,1	29 679,0	
XXIII	**ИХ ЗАСВАР**	2001-2001	2 730,0	**2 730,0**	СЭЗЯ
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН НИЙТ ДҮН		**87 768,1**	**32 400,0**	

УЛСЫН ТӨВЛӨРСӨН ТӨСВИЙН БОЛОН ЗАМЫН САНГИЙН ХӨРӨНГӨӨР САНХҮҮЖҮҮЛЭХ ЗАМ, ГҮҮРИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

/сая төг/

д/д	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Хүч чадал	Барих хугацаа	Төсөвт өртөг	2001 оны төсөл хянасан	Үүнээс		2001 онд ашиглалтад орох	
						Замын сан	Улсын төсөв	Хүч чадал	Улирал
	1	2	3	4	5	6	7	8	9
	Нэг.Хатуу хучилттай зам								
1	Багануур чиглэлийн зам	37.5 км	1999-2004	5250,0	560	560			
	Хоёр.Төмөр бетон гүүр								
1	Завханы Баянтэс,Тэсийн гол	144.9 м	1995-2001	440,1	149,1	149,1		144.9 м	II
2	Булганы Тэшиг, Эгийн гол	289.3 м	1994-2001	1137,2	564,9	564,9		289.3 м	III
3	Сэлэнгэ, Эүүнбүрэн	168 м	2001-2002	341,7	35,8	35,8			
4	Архангайн Өлзийт, Орхон гол	170 м	1996-2001	571,3	64,2	64,2		71 м	Ш
	Гурав. "Авто замын хууль"-ийн дагуу санхүүжүүлэх бусад арга хэмжээ, улсын чанартай зам, гүүрийн засварт		2001-2001	2045,8	2045,8	2045,8			
	Дөрөв.Гадаадын зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төслийн дотоод эх үүсвэр								
1	Кувейтийн сангийн зээлээр хэрэгжиж байгаа Дархан-Эрдэнэтийн хатуу хучилттай зам	184 км	1996-2001	6213,2	2900,0		2900,0	184 км	III
2	АХБанкны зээлээр хэрэгжих Налайх-Маанът-Чойрын чиглэлийн зам	200 км	2000-2004	9000,0	1482,0		1482,0		
3	Дэлхийн банкны зээлийн хөрөнгөөр хэрэгжих замын ажил Үүнд:								
	а/Эрдэнэсант-Арвайхээрийн хатуу хучилттай замын хэсэгчилсэн шинэчлэлт	211 км	2001-2003	1507,4	461,2	350,8	110,4		
	б/Цацэрлэг-Тосонцэнгэл чиглэлийн хэсэгчилсэн хайрган зам	129.5 км	2001-2002	1076,7	556,8		556,8		
	в/Зураг, хайгуул, төслийг удирдах нэгжийн зардал, тоног төхөөрөмжийн НӨТ		2001-2001	556,8	556,8	205,9	350,9		
4	Дэлхийн банкны зээлийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа Цацэрлэг-Тосонцэнгэл чиглэлийн хайрган замын хэсэгчилсэн шинэчлэлт, дуусгал	3 км	1997-2001	1140,7	231,9	231,9		3км	II
5	АХБанкны зээлээр хэрэгжих УБ-Дархан-Алтанбулагийн зам, Дэлхийн банкны зээлийн Хархорин-Тосонцэнгэл, Кувейтийн сангийн Дархан-Эрдэнэтийн замуудын гүйцэтгэгчдийн суутгалын бүцах мөнгө		2001-2001	391,5	391,5	391,5			
	Дүн				**10000**	**4599,9**	**5400,1**		

Засгийн газрын 2001 оны 36 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

ХӨРӨНГИЙН ЭХ ҮҮСВЭР ХУРЭЛЦЭЭГҮЙГЭЭС 2000 ОНД БҮРЭН САНХҮҮЖИГДЭЭГҮЙ ШИЛЖИН ИРСЭН БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

/сая төг/

д/д	Барилга байгууламж, төсөл, арга хэмжээний нэр, байршил, хүчин чадал	Хэрэгжүүлэх хугацаа	2000 онд санхүүжигдээгүй хөрөнгийн хэмжээ	Захиалагч
	А	1	2	3
	ДУЛААНЫ СТАНЦ		**640,2**	
1	Чойбалсан хотын ДЦС-ын шинэчлэлтийн Монголын талын хөрөнгө	1999-2000	350,0	ДБЯ
2	Даланзадгад сумын дулааны цахилгаан станцын инженерийн гадна шугам сүлжээ	1999-2000	249,9	ДБЯ
3	Дулааны төв шугамын шинэчлэлт, 583 м, Сайншанд	2000-2000	40,3	ДБЯ
	ТЭЭВЭР		**50,0**	
1	Нисэх буудлын барилга, Баян-өлгий	2000-2002	50,0	ДБЯ
	АХУЙН ҮЙЛЧИЛГЭЭ		**155,7**	
1	Цэвэр усны шугам, 2700 м3/хоног, Өвөрхангай	1999-2000	12,0	ДБЯ
2	Бохир усны шугам, 3.1 км, Улаанбаатар	2000-2000	50,0	ДБЯ
3	Цэвэр усны өндрийн сангийн дуусгал / 6000 м3/, Дархан	1990-2000	93,7	ДБЯ
	ЭРҮҮЛ МЭНД		**61,8**	
1	"Эрүүл мэндийн хөгжил хөтөлбөр" -ийн Монголын талын хөрөнгө	1998-2000	61,8	ЭМЯ
	БОЛОВСРОЛ		**169,2**	
1	Сургуулийн барилгын дуусгал, 320 суудал, Бор-Өндөр, Хэнтий	2000-2000	110,0	БСШУЯ
2	Сургуулийн барилга, 240 суудал, Цахир, Архангай	1999-2000	21,0	ЗДТГ
3	Сургуулийн барилгын дуусгал, 160 суудал, Эрдэнэ, Дорноговь	1998-2000	38,2	БСШУЯ
	СОЁЛ УРЛАГ, СПОРТ		**1,4**	
1	Соёлын төв, Хушаат сум, Сэлэнгэ		1,4	ЗДТГ
	НИЙГМИЙН ХЭВ ЖУРАМ, АЮУЛГҮЙ БАЙДАЛ		**197,0**	
1	"Ганц худаг"-ийн урьдчилан хорих төвийн барилга	1999-2000	97,0	ЦЕГ
2	Цагдаагийн хэлтэс, урьдчилан хорих, эрүүлжүүлэх байр, гадна холболт, Дундговь	2000-2000	100,0	ЦЕГ
	ГАДААД ХЭРЭГ		**400,0**	
1	Элчин сайдын яаманд байр худалдан авах, Берлин	2000-2000	400,0	ГХЯ
	БАРИЛГА-УГСРАЛТЫН АЖЛЫН ДҮН		**1675,3**	
	ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ	2000-2000	**246,0**	СЭЗЯ
	ЗАМЫН САН	2000-2000	**159,8**	ДБЯ
	ТӨВЛӨРСӨН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН НИЙТ ДҮН		**2081,1**	

Засгийн газрын 2001 оны 36 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт

ӨМЧ ХУВЬЧЛАЛЫН ОРЛОГО, ГАДААДЫН САНХҮҮГИЙН ЗЭЭЛ ТӨЛӨВЛӨГӨӨН ХЭМЖЭЭНЭЭС ДАВЖ БИЕЛСЭН ТОХИОЛДОЛД САНХҮҮЖҮҮЛЭХ БАРИЛГА БАЙГУУЛАМЖ, ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

/сая.төг/

д/д	Барилга байгууламж, төсөл, арга хэмжээний нэр, байршил, хүч чадал	Хэрэгжүүлэх хугацаа	Нийт төсөвт өртөг	Үүнээс: 2001 онд санхүүжих	Захиалагч
	А	1	2	3	4
	ЦАХИЛГААН ДАМЖУУЛАХ ШУГАМ, ДЭД ӨРТӨӨ				
	35 кВ-ын цахилгаан дамжуулах шугам, дэд өртөө				
1	Даланзадгад-Тавантолгой, 98 км, Өмнөговь	2001-2002	1 170,0	436,6	ДБЯ
	Дүн		**1 170,0**	**436,6**	
	БОЛОВСРОЛ				
1	Сургуулийн барилга, 628 суудал, Есөнбулаг сум, Говь-Алтай	2001-2002	750,0	470,3	БСШУЯ
2	Сургуулийн өргөтгөл, 920 суудал, Булган сум, Булган	2001-2001	320,0	320,0	БСШУЯ
	Дүн		**1 070,0**	**790,3**	
	БАТЛАН ХАМГААЛАХ				
1	Цэргийн байр, штаб, гал зуух, Хужирбулан	2001-2001	192,0	192,0	БХЯ
	Дүн		**192,0**	**192,0**	
	ГАЛ ТҮЙМЭРТЭЙ ТЭМЦЭХ				
1	Галын депо, 5 машины гараашт, Баруун-Урт	2001-2002	450,0	200,0	ГТГ
	Дүн		**450,0**	**200,0**	
	БУСАД				
1	Барилга байгууламж, төсөл, арга хэмжээний ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах зардал	2001-2001	100,0	100,0	СЭЗЯ
	Дүн		**100,0**	**100,0**	
	БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ДҮН		**2 790,0**	**1 718,9**	
	ИХ ЗАСВАР		**200,0**	**200,0**	СЭЗЯ
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН НИЙТ ДҮН		**2 990,0**	**1 918,9**	

2001 оны 2 дугаар сарын 20-ны өдөр | Дугаар 37 | Улаанбаатар хот

Тогтоол хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

"Байгаль орчны талаар авах зарим арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын 2000 оны 38 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Газар, газрын хэвлий, ой, ан амьтны талаархи хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдлыг шалгаж үнэлгээ, дүгнэлт өгөх улсын үзлэгийг 2001 оны 7 дугаар сарын 1-ний дотор багтаан явуулахаар тогтоосугай.

2. Байгаль орчны улсын үзлэгийг зохион байгуулж явуулах Засгийн газрын комиссын бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор батлуулсугай.

3. Улсын үзлэгийг зохион байгуулах Засгийн газрын комиссын дарга, Байгаль орчны сайд У.Барсболдод даалгах нь:

а/улсын үзлэг явуулах нэгдсэн удирдамж, нарийвчилсан төлөвлөгөөг батлуулж мөрдүүлэх, үүнтэй зориулсан семинарыг 2001 оны I улиралд багтаан зохион байгуулсугай;

б/нийслэл болон аймгуудад ажиллах салбар комиссыг арга зүй, зөвлөмж, мэргэжлийн удирдлагаар хангаж ажилласугай;

в/байгаль орчны улсын үзлэгийн нэгдсэн дүнг түүний мөрөөр зохиох арга хэмжээний саналын хамт 9 дүгээр сарын 1-ний дотор Засгийн газрын хуралдаанд танилцуулсугай.

4. Байгаль орчны улсын үзлэгт зохих мэргэжлийн хүмүүсийг оролцуулахыг холбогдох сайд, Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагийн дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

5. Байгаль орчны улсын үзлэгийг аймаг, нийслэлд зохион байгуулж явуулах салбар комиссыг томилон уг үзлэгт бэлтгэх ажлын төлөвлөгөөг гарган хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

6. Байгаль орчны улсын үзлэгийг явуулахад шаардагдах зардлыг Байгаль хамгаалах сангаас гаргах нь зүйтэй гэж үзсүгэй.

7. Байгаль орчны сайд У.Барсболд, Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг нарт даалгах нь:

а/байгаль орчны доройтлыг бууруулах, цөлжилттэй тэмцэх, орчны бохирдлыг багасгах, байгалийн нөөцийн ашиглалтыг сайжруулж дэвшилтэт технологи нэвтрүүлэх зэрэ зүйн болон урамшууллын хөшүүрэг бий болгох, хууль тогтоомж зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг чангатгах, энэ ажилд иргэдийн оролцоо, хяналтыг өргөжүүлэх чиглэлээр Байгаль орчны, Ашигт малтмалын, Газрын хэвлийн тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах талаар санал боловсруулж 2001 оны II улиралд багтаан Засгийн газарт оруулах арга хэмжээ авсугай;

б/байгалийн нөөц баялгийг хувиараа олборлох, ашиглахтай холбогдсон асуудлаархи эрх зүйн зохицуулалтын төслийг боловсруулж Засгийн газарт 2001 онд багтаан оруулсугай.

8. Байгаль орчны сайд У.Барсболд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгах нь:

а/орон нутагт ажиллаж байгаа байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчдыг бие хамгаалах болон бусад техник хэрэгсэл, уналгаар нормативын дагуу хангахын зэрэгцээ тэдний мэдлэг боловсролыг дээшлүүлэх, ажлын хариуцлага, сахилгыг өндөржүүлэх ажлыг хамтран зохион

байгуулсугай;

б/гадаад орон, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгөө хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд орон нутгийн байгаль орчны албадыг хамруулан, тэдгээрийн материаллаг бааз, чадавхийг бэхжүүлэх арга хэмжээг дэс дараатай авч хэрэгжүүлсүгэй.

9. Байгаль орчны сайд У.Барсболдод даалгах нь:

а/Агаар бохирдуулсны төлбөрийн тухай хуулийн төслийг боловсруулж 2001 онд Засгийн газарт оруулсугай.

б/билчээрийн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааг 2004 онд багтаан хийж дуусгах, эхний ээлжинд говь, цөл, хээрийн бус, төв суурин газрын болон тариалангийн талбай орчмын билчээрийн газарт энэ ажлыг хийхээр зохион байгуулж, бэлчээрийн даац, чадавхийг тодорхойлох арга хэмжээ авсугай;

в/байгаль орчныг хамгаалах асуудлаар төрийн болон төрийн бус байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөлөгчид, байгаль орчны хяналтын улсын байцаагчид, байгаль хамгаалагчдыг оролцуулсан чуулга уулзалтыг 2001 оны сүүлийн хагаст зохион явуулсугай;

г/ойн хөнөөлт шавьжны тархалт, хөнөөлийн байдлыг нарийвчлан судалсны үндсэн дээр 2001 оноос эхлэн тэдгээртэй тэмцэх ажлыг жил бүр 10 мянгаас доошгүй га талбайд явуулах зохион байгуулалтын холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлсүгэй;

д/аймаг, нийслэлийн Байгаль орчны албаны нийтлэг дүрмийг баталж мөрдүүлэн мэргэжлийн удирдлагаар хангаж байсугай.

10. "Экологийн боловсрол" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдуулан байгаль орчны чиглэлээр боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, бүх нийтэд экологийн боловсрол, хүмүүжил олгох зорилго бүхий мэдээлэл, сурталчилгааны төвүүдийг Улаанбаатар хот, Дархан-Уул, Дорнод, Ховд, Архангай, Өмнөговь аймгуудад 2001 онд багтаан байгуулан ажиллуулахыг Байгаль орчны сайд У.Барсболд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид нарт тус тус даалгасугай.

11. Байгаль орчны сургалт, сурталчилгааны талаар Байгаль орчны яамтай хамтран 7 хоног бүр тогтмол нэвтрүүлэг бэлтгэн нийтийн хүртээл болгож байхыг Радио, телевизийн Хэрэг эрхлэх газрын дарга Б.Ганболдод үүрэг болгосугай.

12. Заган ой, говийн бутлаг ургамлыг хамгаалах зорилгоор шахмал болон бусад төрлийн түлш орон нутагт үйлдвэрлэх, хий ашиглах асуудлыг судалж, манай улсад хэрэгжүүлж байгаа гадаад орон, олон улсын байгууллагын төслийн хөрөнгөөр говь, цөл, хээрийн бүсийн аймаг, сумдад эдгээр түлшний үйлдвэрлэлийг туршин нэвтрүүлэх арга хэмжээ авахыг Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг, Дэд бүтцийн сайд Б.Жигжид, Байгаль орчны сайд У.Барсболд, Дорноговь, Өмнөговь, Дундговь, Говь-Алтай, Ховд, Баянхонгор, Өвөрхангай, Сүхбаатар, Говьсүмбэр аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

13. Томоохон хот, суурин газрын бүх төрлийн авто тээврийн хэрэгслийг үзлэг шалгалтад тогтмол хамруулж, зөвшөөрөгдөх хэмжээнээс илүү утаа гаргаж, агаар бохирдуулахаас сэргийлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллахыг Байгаль орчны сайд У.Барсболд, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, нийслэл, Дархан-уул, Орхон, Дорнод аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

14. Томоохон хот, суурин газрын орчны бохирдлыг бууруулах зорилгоор бүрэн шаталттай сайжруулсан зуухны үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, байгаль орчны хяналтын болон замын цагдаагийн албадыг автомашины утаа хэмжигч бага оврын хөдөлгөөнт багажаар хангах, хатуу хог хаягдлыг ялгах, тээвэрлэх, зайлуулах, байгаль орчинд халгүйгээр

боловсруулах үйлдвэр байгуулах асуудлыг шийдвэрлэхэд зориулсан хөрөнгийн эх үүсвэрт гадаадын хандивлагч орон, олон улсын байгууллагын зээл, тусламжийн хөрөнгийг ашиглах боломжийг судалж хэрэгжүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун, Байгаль орчны сайд У.Барсболд нарт даалгасугай.

15. Бэлчээрийн хортон, мэрэгчид, царцаатай байгаль орчинд халгүй аргаар тэмцэх технологийг 2001 оноос эхлэн туршиж дэс дараатай нэвтрүүлэх, энэ ажлыг жил бүр 200 мянгаас доошгүй га талбайд явуулж, цаашид өргөжүүлэх арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид, Байгаль орчны сайд У.Барсболд нарт үүрэг болгосугай.

16. Гүний усны хайгуул судалгааны ажлыг улам эрчимжүүлж, шинээр нөөц тогтоох судалгааны ажлын зардлыг улсын төвлөрсөн төсвийн болон бусад бололцоотой хөрөнгийн эх үүсвэрээс санхүүжүүлэх арга хэмжээ авч байхыг Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг даалгасугай.

17. Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, Байгаль орчны сайд У.Барсболд нарт даалгах нь:

а/бэлчээр усжуулалтын зориулалттай уст цэг, услалтын системийн үзлэг тооллогыг 2001 онд багтаан явуулсугай;

б/тариалангийн талбайн бүртгэл тооллогыг 2001 онд зохион байгуулах, ажлын үр дүнг үндэслэн мэдээллийн нэгдсэн сан байгуулах арга хэмжээ авсугай;

в/тариалангийн талбайн ашиглалтын байдлыг зээмшигч, ашиглагч нэг бүрээр нарийвчлан гаргаж үнэлгээ, дүгнэлт өгөх үндсэн дээр хөрс сайжруулалтын болон агротехникийн дэвшилтэт арга технологи нэвтрүүлэн үр ашигтай ажиллаж буй аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийг урамшуулах, ашиглалтгүй байгаа болон үржил шимийг муутгасан, элэгдэл эвдрэлд оруулсан аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн эзэмшилд байгаа газрыг хууль тогтоомжийн дагуу терийн мэдэлд буцаан авах, улмаар дахин хуваарилалт хийх замаар өөр аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд шилжүүлэх арга хэмжээг холбогдох аймаг, нийслэлийн Засаг дарга нартай хамтран зохион байгуулсугай.

18. Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзоригт даалгах нь:

а/"Алт" хөтөлбөрийн хэрэгжилтийн явц байдалд үнэлэлт, дүгнэлт өгч, цаашид авах арга хэмжээний талаархи саналын хамтаар Засгийн газрын хуралдаанд 2001 оны эхний улиралд багтаан танилцуулсугай;

б/ашигт малтмалын талаар төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн төслийг 2001 оны эхний хагаст багтаан боловсруулах арга хэмжээ авсугай.

19. Ашиг хонжоо олох зорилгоор ан амьтныг хууль тогтоомж зөрчин олноор нь агнаж, түүний эдийг нуугаар хил давуулах аливаа үйлдлийг таслан зогсоох, ийм зөрчил гарахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авч ажиллахыг Байгаль орчны сайд У.Барсболд, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Улсын гаалийн ерөнхий газрын дарга Х.Баатар нарт даалгасугай.

20. Амьдралын түвшин доогуур, бага орлоготой иргэдийг байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, нөөцийг зохистой ашиглах ажилд өргөнөөр оролцуулах, тэдэнд ажлын байр бий болгох арга хэмжээ авч байхыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаяр, Байгаль орчны сайд У.Барсболд нарт үүрэг болгосугай.

21. "Байгалийн нөөц ашигласны

төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн хувь хэмжээний тухай" Монгол улсын хуулийн хэрэгжилтийн байдалд үнэлэлт, дүгнэлт өгч, дүнг 2001 оны IУ улиралд Засгийн газарт танилцуулахыг Байгаль орчны сайд У.Барсболд, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД У.БАРСБОЛД

Засгийн газрын 2001 оны 37 дугаар тогтоолын хавсралт

БАЙГАЛЬ ОРЧНЫ УЛСЫН ҮЗЛЭГИЙГ ЗОХИОН БАЙГУУЛЖ ЯВУУЛАХ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Төв комиссын дарга -Байгаль орчны сайд У.Барсболд

Гишүүд:

-Хүнс, хөдөө аж ахуйн дэд сайд Д.Тэрбишдагва;

-Үйлдвэр, худалдааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Ёндон;

-Хууль зүй,дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Баясгалан;

-Санхүү, эдийн засгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Түмэндэмбэрэл;

-Үндэсний татварын ерөнхий газрын дарга Л.Зориг;

-Улсын иргэний хамгаалалтын газрын дарга О.Үржин;

-Гал түймэртэй тэмцэх газрын дарга Д.Хишигбаатар;

-Радио, телевизийн Хэрэг эрхлэх газрын дарга Б.Ганболд;

-Авто замын газрын дарга Р.Буд;

-Улсын гаалийн ерөнхий газрын дэд дарга Ж.Батбаяр;

-Цагдаагийн ерөнхий газрын Эрүүгийн цагдаагийн албаны дарга Ш.Ганболд;

-Монголын байгаль орчны төрийн бус байгууллагуудын холбооны гүйцэтгэх захирал Ц.Даваасүрэн.

Нарийн бичгийн дарга -Байгаль орчныг хамгаалах албаны дарга Ц.Банзрагч.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 2 дугаар сарын 20-ны өдөр **Дугаар 38** **Улаанбаатар хот**

Эрүүл мэндийн улсын хяналтын дүрэм батлах тухай

Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Эрүүл мэндийн улсын хяналтын дүрэм"-ийг хавсралтын ёсоор батлуулсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Эрүүл ахуй, халдвар судлалын болон Эм, биобэлдмэл, эмчилгээний чанарын улсын хяналтын дүрэм шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 1999 оны 1 дүгээр сарын 13-ны өдрийн 5 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД П.НЯМДАВАА

Засгийн газрын 2001 оны 38 дугаар тогтоолын хавсралт

ЭРҮҮЛ МЭНДИЙН УЛСЫН ХЯНАЛТЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Эрүүл мэндийн улсын хяналтын зорилт нь "Эрүүл мэндийн тухай хууль", "Ариун цэврийн тухай хууль", "Эмийн тухай хууль" болон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтэд мэргэжлийн хяналт тавьж, байгаль, ахуйн орчноос хүний эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлж буй хүчин зүйлсийг илрүүлэх, түүний үр дагавраас шалтгаалан үүсэх өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, ариун цэврийн хэвийн нөхцөлийг хангуулах, иргэдэд чанарын баталгаатай эмийн болон эмнэлгийн тусламж үзүүлэх боломлоог бүрдүүлэх замаар хүн амын эрүүл мэндийг хамгаалахад оршино.

2. Эрүүл мэндийн улсын хяналтыг Эрүүл мэндийн улсын хяналтын алба, аймаг, нийслэл, дүүрэг, тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагын хяналтын албад, улсын байцаагч нь эрүүл ахуй, халдвар судлал, эмнэлгийн тусламж, үйлчилгээ болон эм, биобэлдмэлийн чиглэлээр хэрэгжүүлнэ.

3. Эрүүл мэндийн улсын хяналтын байцаагч нь эрүүл ахуй, халдвар судлал, эм, биобэлдмэл, эмчилгээ, оношилгооны чиглэлээр мэргэшсэн байна.

4. Эрүүл мэндийн улсын хяналтын албаны дарга нь эрүүл мэндийн улсын хяналтын ерөнхий байцаагч байна. Эрүүл мэндийн улсын хяналтын ерөнхий байцаагчийг эрүүл мэндийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүний санал болгосноор Засгийн газар томилж, чөлөөлнө.

5. Эрүүл мэндийн улсын хяналтын албанд ажиллах улсын ахлах байцаагч, улсын байцаагчийг эрүүл мэндийн улсын хяналтын ерөнхий байцаагчийн санал болгосноор эрүүл мэндийн асуудал хариуцсан Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлнө.

6. Аймаг, нийслэл, дүүрэг, тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагын хяналтын албанд ажиллах ахлах байцаагчийг эрүүл мэндийн улсын хяналтын ерөнхий байцаагчтай зөвшилцөж, улсын байцаагчийг тухайн байгууллагын ахлах байцаагчийн саналыг үндэслэн аймаг, нийслэл, дүүргийн Засаг дарга, тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагын дарга томилж, чөлөөлнө.

7.Эрүүл мэндийн улсын хяналтад хамрагдах объектын жагсаалтыг эрүүл мэндийн улсын хяналтын ерөнхий байцаагч батална.

8.Эрүүл мэндийн улсын хяналтын ерөнхий байцаагч, ахлах байцаагч, улсын байцаагч /цаашид "байцаагч" гэнэ/ нь Засгийн газраас загварыг нь батлсан, уг байцаагчийг томилсон эрх бүхий албан тушаалтнаас олгосон албаны болон хувийн дугаар бүхий үнэмлэх, тэмдэг, албан шаардлага, дүгнэлт, акт, торгууль, шийтгэврийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

9. Эрүүл мэндийн улсын хяналтын алба нь аймаг, нийслэл, дүүрэг, тусгайлан эрх олгогдсон захиргааны байгууллагын хяналтын албадын улсын байцаагчийг мэргэжил, арга

зүйн удирдлагаар хангаж, ажилд нь үнэлэлт дүгнэлт өгнө.

10. Байцаагч нь үйл ажиллагаандаа Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, эрүүл мэндийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр, энэхүү дүрмийг удирдлага болгоно.

Хоёр. Байцаагчийн хяналт шалгалт явуулах чиглэл

11. Эрүүл ахуй, халдвар судлалын хяналтын байцаагч нь Эрүүл мэндийн тухай, Ариун цэврийн тухай, Тамхины хор хөнөөлтэй тэмцэх тухай, Дархлаажуулалтын тухай, Дархлалын олдмол хомсдол өвчнөөс сэргийлэх тухай, Усны тухай, Архидан согтуурахтай тэмцэх тухай, Хүнсний тухай, Химийн хорт бодисоос хамгаалах тухай хууль болон хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, ажиллах, суралцах ариун цэврийн хэвийн нөхцөлийг хангуулахтай холбогдсон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг дараахь чиглэлийн дагуу хянан шалгана:

а/хот, суурин, барилга, байгууламжийн газрыг сонгох, зураг төсөл зохиох, түүнийг ашиглалтад оруулахад эрүүл ахуй, халдвар судлалын дүгнэлт гарган хяналт тавих;

б/хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүс тогтоолт, усны чанар, эрүүл ахуйн аюулгүй байдалд дүгнэлт гаргах;

в/химийн хорт бодисын үйлдвэрлэл, импорт, экспорт, хадгалалт, худалдаа, тээвэрлэлт, ашиглалт, устгалд хяналт тавих;

г/ус, хөрс, агаарт байгаа химийн бодисын зөвшөөрөгдөх хэмжээ, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөлд хяналт тавих;

д/цацраг идэвхт бодис, цахилгаан соронзон үүсгүүрийн хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөлд дүгнэлт гаргах;

е/үйлдвэрлэл, сургалт, ахуйн хэрэглээ, гоо сайхны бараа, бүтээгдэхүүний чанар, хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөлд дүгнэлт гаргах;

ж/хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээний байгууллагын эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмийн хэрэгжилтэд хяналт тавих;

з/хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл, тээвэрлэлт, хадгалалт, худалдаатай холбоотой хордлого, халдвар гарахаас урьдчилан сэргийлэх, эрүүл ахуй, халдвар хамгааллын дэглэмд хяналт тавих;

и/согтууруулах ундааны чанар, эрүүл ахуйн үзүүлэлтэд дүгнэлт гаргах;

к/хүүхдийн сургалт, амралтын байгууллагын эрүүл ахуйн байдалд дүгнэлт гаргах;

л/хүн амыг дархлаажуулах бэлдмэлийн аюулгүй байдал, чанар, хадгалалт, тээвэрлэлтэд дүгнэлт гаргах;

м/эрүүл мэндийн байгууллагын халдвар хамгааллын дэглэм, тусгай, халдвартай, хортой хог хаягдлын цуглуулалт, тээвэрлэлт, устгалд дүгнэлт гаргах;

н/хилийн эрүүл ахуй, халдвар судлалын хяналтыг хэрэгжүүлэх, олон улсын хөл хориот өвчнөөс урьдчилан сэргийлэх, танадалт хийх;

о/халдварт, халдварт бус өвчний талаархи дүрэм, зааврын хэрэгжилтэд хяналт тавих.

12. Эм, биобэлдмэлийн хяналтын байцаагч нь Эрүүл мэндийн тухай, Эмийн тухай хууль болон хүний эм, биобэлдмэлийн үйлдвэрлэл, хангалт, борлуулалт, хэрэглээтэй холбогдсон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг дараахь чиглэлээр хянан шалгана:

а/эм хангамжийн байгууллага дахь эмийн хадгалалт, тээвэрлэлтийн технологийн шаардлага, нөхцөлд хяналт тавих;

б/байгууллага, иргэдийн импортлож, экспортлож байгаа болон хүмүүнлэгийн тусламж, хандиваар авах эм, биобэлдмэл, эмнэлгийн хэрэгслийн чанарт дүгнэлт гаргах, хяналт тавих;

в/эм, эмнэлгийн хэрэгслийн үйлдвэрлэл эрхлэх талаархи заавар, журмын хэрэгжилтэд хяналт тавих;

г/эмийн сангийн үйл ажиллагаанд өмчийн хэлбэр харгалзахгүйгээр хяналт шалгалт хийх;

д/эмийн сурталчилгааны талаар хуулиар хориглосон заалтын хэрэгжилтэд хяналт тавих;

е/эм, биобэлдмэлийн чанарын баталгаажуулалт, үйлдвэрлэлийн стандарт, технологийн мөрдөлтөд хяналт тавих.

13. Эмчилгээний чанарын хяналтын байцаагч нь Эрүүл мэндийн тухай, Сэтгэцийн эрүүл мэндийн тухай, Донорын тухай хууль болон эмчлэх үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдсон бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийг дараахь чиглэлээр хянан шалгана:

а/эмчлэх, оношлох, нөхөн сэргээх тусламж, үйлчилгээний стандарт, технологийн хэрэгжилтэд хяналт тавих;

б/эмнэлгийн мэргэжилтний эмчлэх, сувилах үйл ажиллагаанд мөрдөгдөх журмын биелэлтэд хяналт тавих;

в/эмч, эмнэлгийн ажилтны мэргэжлийн ёс зүйн хэм хэмжээнд хяналт тавих;

г/эмч, эмнэлгийн ажилтны мэргэжлийн алдаа, түүнээс болж хүний амь нас, эрүүл мэнд хохирсонтой холбоотой гарсан гомдолд дүгнэлт гаргах;

д/сэтгэцийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ болон сэтгэцийн өвчтэй хүнийг албадан эмчлэх, аюулгүй байдлыг хангах талаархи эмнэлгийн мэргэжилтний үүргийн хэрэгжилтэд хяналт тавих;

е/донорын эд эрхтэнг эмчилгээний зориулалтаар авах, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, шилжүүлэн суулгах үйл ажиллагаанд хяналт тавих;

ж/эмнэлгийн чанарын алба, чанарын менежерийн талаархи тушаал шийдвэрийн мөрдөлтөд хяналт тавих.

Гурав. Байцаагчийн эрх

14. Байцаагч нь дор дурдсан нийтлэг эрхтэй байна:

а/эрүүл мэндийн талаархи хууль тогтоомж, түүнийг хэрэгжүүлэх зорилгоор гаргасан шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж, шаардлагатай бол албадан хэрэгжүүлэх;

б/хяналт шалгалтын ажилд шаардлагатай үед холбогдох байгууллагатай тохиролцсоны үндсэн дээр мэргэжилтнийг татан оролцуулах, магадлан шинжээчийн хэсэг томилох, магадлах шинжилгээг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх;

в/шинжилгээний зориулалтаар хүрэлцэхүйц хэмжээний дээжийг үнэ төлбөргүй авах;

г/хяналт, шалгалтын ажилд шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнаас гаргуулан авах;

д/хяналт, шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг газар дээр нь арилгуулах талаар холбогдох арга хэмжээг авахуулах, зөвлөмж, хугацаатай үүрэг, албан шаардлага өгөх;

е/шалгалтаар илэрсэн зөрчил нь нийтэд хор аюултай, нөхөн төлбөр шаардах, хүний амь нас, эрүүл мэндэд хор хохирол учруулсан гэж үзвэл шалгалтын акт, материалыг хуулийн байгууллагад шилжүүлэх;

ж/шалгалтын үед илэрсэн эд мөрийн баримтыг устгах боломжийг хаах, зөвшөөрөлгүй болон хориглосон үйл ажиллагаа явуулахаас сэргийлэх зорилгоор нэгж, объект, агуулах, өрөө тасалгаа, шүүгээ савыг хууль хяналтын байгууллагын төлөөлөгч буюу гэрчийг байлцуулан битүүмжлэх, түр хугацаагаар үйл ажиллагааг нь зогсоох;

з/хүний амь нас, эрүүл мэндэд хохирол учруулж байгаа болон учруулж болзошгүй нь зохих ёсоор нотлогдсон үйлдвэр, аж ахуйн нэгж, эмнэлэг үйлчилгээний болон эм хангамжийн байгууллагын үйл ажиллагааг бүхэлд нь буюу хэсэгчлэн уг зөрчлийг арилгах хүртэл түр зогсоох, энэ тухай иргэдэд зарлан мэдээлэх, энэхүү шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд хуульд өөрөөр заагаагүй бол үйлчилгээг бүрмөсөн зогсоох;

и/Монгол Улсын нутаг дэвсгэрт олон улсын хөл хориот болон байгалийн голомтот халдварт өвчин нэвтэрч, тархахаас сэргийлэх зорилгоор шаардлагатай үед срон нутгийн засаг захиргаа, холбогдох байгууллагатай хамтарч хилийн боомт болон аймаг, нийслэл, сум, дүүрэгт иргэдийн зорчих хөдөлгөөнийг түр хугацаагаар хориглох, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг саатуулах хүртэл арга хэмжээ авах;

к/эм биобэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл, нийлэг эдлэл, хувцас, тоглоом, хичээлийн хэрэгсэл, хүнс, хүнсний нэмэлт, гоо сайхны болон үйлдвэрлэлийн зориулалттай бодис, материалаас шинжилгээний дээж авч дүгнэлт гаргах, улсын хилээр нэвтрүүлэх, хэрэгцээнд нийлүүлэх зөвшөөрөл олгох;

л/эмч, мэргэжилтэн, эрүүл мэндийн байгууллагад мэргэжлийн үйл ажиллагаа явуулах тодорхойлолт гаргах;

м/хүний амь нас, эрүүл мэндэд хортой нөлөө үзүүлэх химийн, биологи, физикийн сөрөг хүчин зүйл, бодис, бэлдмэл, техник, технологийг зохих шинжилгээ, дүгнэлт, зөвшөөрөлгүйгээр хэрэглэж, нэвтрүүлсэн нь эрүүгийн хариуцлага

хүлээлгэхээргүй бол эд зүйлийг хэрэглэхийг хориглох, устгах;

н/хяналт, шалгалтаар гэм буруутай нь тогтоогдсон этгээдэд Захиргааны хариуцлагын тухай, Эрүүл мэндийн тухай, Ариун цэврийн тухай, Эмийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэх;

о/шалгалтын дүнг радио, телевиз, сонин хэвлэлээр сурталчлах, дутагдал доголдлыг дахин гаргуулахгүй байх талаар сэрэмжлүүлэг хийх.

Дөрөв. Байцаагчийн үүрэг

15. Байцаагч нь дор дурдсан нийтлэг үүрэг хүлээнэ:

а/төрийн захиргааны албан хаагчийн нийтлэг үүргийг сахин биелүүлж, зарчимч, шударга ажиллах, өргөсөн тангарагтаа үнэнч байх;

б/хяналт, шалгалтыг хуулинд заасан технологиор явуулах;

в/хяналт шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг газар дээр нь таслан зогсоох, түүний шалтгаан нөхцөлийг арилгах талаар үүрэг даалгавар өгч, биелэлтийг хангуулах;

г/захиргааны журмаар хураасан эд зүйл, эм, эмнэлгийн хэрэгслийг улсын орлого болгох, устгах, түүний биелэлтэд хяналт тавих;

д/хяналт шалгалтаар илэрсэн зөрчилд хүлээлгэсэн захиргааны арга хэмжээг аймаг, нийслэлийн хяналтын прокуророор хянуулах;

е/хяналтын үйл ажиллагааны тайланг холбогдох байгууллагад тогтоосон хугацаанд гарган өгөх;

ж/хяналт шалгалтаар тогтоосон нөхөн төлбөр, тавьсан торгууль, шийтгэврийн биелэлтийг хангуулах;

з/халдварт өвчин тарах аюул тохиолдсон үед халдварт өвчтэй хүн, халдварт өвчний нян тээгч, хавьтагсдыг тусгаарлах, эмчлүүлэх, хөл хорио тогтоох;

и/иргэдийн өргөдөл, гомдлыг цаг тухайд нь барагдуулах.

Тав. Бусад зүйл

16. Эрүүл мэндийн улсын хяналтын алба, байцаагчийн албан шаардлагыг байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэн хугацаанд нь биелүүлж, хариуг албан ёсоор өгч байх үүрэгтэй.

17. Шалгуулсан байгууллага, аж ахуйн нэгжийн эрх баригч, албан тушаалтан хяналт шалгалтын явцад хууль тогтоомж зөрчигдсөн, гаргасан шийдвэр үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо хяналт шалгалт хийсэн байгууллагын эрх баригчид буюу дээд шатны байцаагчид гаргана. Гомдлыг хүлээн авсан албан тушаалтан түүнийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хянаж шийдвэрлэнэ. Энэхүү шийдвэрийг эс зөвшөөрвөл гомдлоо зохих журмын дагуу шүүхэд гаргаж болно. Гомдол гаргах нь ноцтой зөрчлийг арилгахгүй байх үндэслэл болохгүй.

18. Үүрэгт ажлаа зохих ёсоор биелүүлээгүй, хууль тогтоомж зөрчсөн бол холбогдох хууль тогтоомжид заасны дагуу байцаагчид хариуцлага хүлээлгэнэ.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн эвлэл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 16 (203)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт ажлаас чөлөөлсөн, томилсон тухай*

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

- *Элчин сайдыг эгүүлэн татсан, томилсон тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Хөтөлбөр, төсөл баталсан, журам, заавар шинэчлэн баталсан тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2001 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2001 оны дөрөвдүгээр сарын 27 №16 (203)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

192. Б.Энэбишийг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт аажлаас чөлөөлөх тухай Дугаар 28 417
193. Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох тухай Дугаар 29 417

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

194. Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай Дугаар 81 418
195. Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай Дугаар 82 418
196. Б.А.Говориныг "Алтан гадас" одонгоор шагнах тухай Дугаар 83 418

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

197. Хөтөлбөр, төсөл батлах тухай Дугаар 39 418
198. Журам шинэчлэн батлах тухай Дугаар 40 432
199. Заавар шинэчлэн батлах тухай Дугаар 41 434
200. Гоц халдварт өвчний цагийн байдалтай уялдуулан авах зарим арга хэмжээний тухай Дугаар 42 438
201. Тогтоолд нэмэлт оруулах тухай Дугаар 44 440

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр **Дугаар 28** **Улаанбаатар хот**

Б.Энэбишийг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт аажлаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Б.Энэбишийг өөр ажилд шилжих болсонтой нь холбогдуулан Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын үүрэгт аажлаас чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2001 оны 4 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр **Дугаар 29** **Улаанбаатар хот**

Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргыг томилох тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Төрийн захиргааны албаны зөвлөлийн саналыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Дааданхүүгийн Батбаатарыг Улсын Их Хурлын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргаар томилсугай.

2.Энэ тогтоолыг 2001 оны 4 дүгээр сарын 13-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 4 дүгээр сарын 05-ны өдөр **Дугаар 81** **Улаанбаатар хот**

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

1. Монгол Улсаас Бүгд Найрамдах Казахстан Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Юмбуугийн Сандагийг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Бүгд Найрамдах Казахстан Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дамдинжавын Дашнямыг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 4 дүгээр сарын 05-ны өдөр **Дугаар 82** **Улаанбаатар хот**

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

1. Монгол Улсаас Швейцарийн Холбооны Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд, НҮБ-ын Женев, Вена дахь салбарууд болон Олон улсын бусад байгууллагын дэргэд суугаа Байнгын төлөөлөгчөөр Сүх-Очирын Болдыг өөр ажилд шилжсэнтэй нь холбогдуулан эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Швейцарийн Холбооны Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд, НҮБ-ын Женев, Вена дахь салбарууд болон Олон улсын бусад байгууллагын дэргэд суух Байнгын төлөөлөгчөөр Хасбазарын Бэхбатыг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 4 дүгээр сарын 05-ны өдөр **Дугаар 83** **Улаанбаатар хот**

Б.А.Говориныг "Алтан гадас" одонгоор шагнах тухай

Монгол Улс, Оросын Холбооны Улсын Найрсаг харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэн хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж ОХУ-ын Эрхүү мужийн захирагч Борис Александрович Говориныг "Алтан гадас" одонгоор шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 2 дугаар сарын 26-ны өдөр **Дугаар 39** **Улаанбаатар хот**

Хөтөлбөр, төсөл батлах тухай

Газар тариалангийн үйлдвэрлэлийн үнаатыг зогсоож, түүний тогтвортой хөгжих нөхцөлийг хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Үр" дэд хөтөлбөрийг 1 дүгээр хавсралт, "Уриншүүлэхэд шаардагдах хөрөнгийг Япон Улсын Засгийн газрын буцалтгүй тусламжийн хөрөнгөөс бүрдсэн сангаас гаргах асуудлыг холбогдох улс, байгууллагад тавьж шийдвэрлэхийг Гадаад хэргийн

сайд Л.Эрдэнэчулуун, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

3. Хөтөлбөр, төслийн хэрэгжилтийн явц, үр дүнд хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргалд үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД Д.НАСАНЖАРГАЛ

Засгийн газрын 2001 оны 39 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

"ҮР" ДЭД ХӨТӨЛБӨР

1. Өнөөгийн байдал

Манай улс хойноосоо Сибирийн их ой, Хэнтий, Хангай, Соёны их уулсаар, өмнөөсөө Зүүнгарын цөл, их говийн хуурай халуун элсэн манхнаар туслаарлагдсан учир эх газрын эрс тэс уур амьсгалтай, таримал ургамлын ургах хугацаа богино (85-103 хоног), чийг дутагдалтай (5-9 дүгээр сард дөнгөж 240-156 мм тундас унадаг, 5-6 дугаар сарын ган 3 жилд нэг удаа, 5-7 дугаар сарын ган 8 жилд нэг удаа, 8-9 дүгээр сарын ган 10 жилд нэг удаа тохиолддог) учир усалгаагүй үр тарианы үйлдвэрлэлэн эрхлэхэд нэн таалamжгүй нөхцөлийг бүрдүүлдэг. Иймэ нөхцөл тогтвортой ургац авахын тулд ихээхэн хөрөнгө, өндөр мэдлэг, дадлага, үр чадвар, техник хангамж, технологийн хатуу сахилга шаарддаг.

"Газар тариаланг сэргээх хөтөлбөр"-ийг 1998 онд боловсруулан хэрэгжүүлж байгаа боловч нэг талаас заагдсан арга хэмжээнүүдийг бүрэн хэрэгжүүлэх санхүүгийн эх үүсвэр хүрэлцээгүй, нөгөө талаас газар тариаланг сэргээх наад захын гол нөхцөл болсон сайн чанарын үрийн хэрэгцээг хангаж чадахгүй байгаагаас Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээнүүд олигтой үр дүнгээ өгч энэ салбарын бууралтыг сааруулж чадахгүй байна.

Мэргэжлийн байгууллага, эрдэмтэд, тариаланчдаас үр тарианы үйлдвэрлэлийг сэргээх үндсэн нөхцөл нь сайн чанарын үрээр хангах, уриншийн боловсруулалтыг сайжруулах, тариаланчдыг зээлжих боломж, нөхцөлөөр хангах, техник, технологийн шинэчлэл хийх явдал гэж санал нэгтэй дүгнэж байгааг үндэслэн манай орны хүнсний гол таримал болох буудай, төмсний үр үйлдвэрлэлийг зах зээлийн тогтолцоонд нийцүүлэн өөрчлөн зохион байгуулахаар энэхүү дэд хөтөлбөрийг боловсруулав.

2. Хөтөлбөрийн зорилго, зорилт

Энэ хөтөлбөрийн зорилго нь үр тариа, төмсний үрийн үйлдвэрлэлийг хувийн хэвшилд тулгуурлан, түүнийг ашиг орлого бүхий бизнесийн объект болгох замаар Засгийн газрын хамгийн бага оролцоо, дэмжлэгт үндэслэн дотоодын хэрэгцээгээ бүрэн хангадаг болох явдал юм.

Үрийн үйлдвэрлэлийг эрдэм шинжилгээний байгууллага төдийгүй нөхцөл боломж бүхий хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, иргэдийн бизнесийн сонирхолтой хослуулах нь хөтөлбөрийн гол зорилт мөн.

Дэд хөтөлбөрийн гол санаа нь эрдэм шинжилгээний байгууллагад дэмжлэг үзүүлэх замаар элит үрийн анхдагч материалыг гаргуулж, цаашид түүнийг супер элит, элит болон 1-2 дугаар репродукцийн үр болтол үржүүлэх ажлыг хувийн хэвшлийн оролцоотойгоор боломжтой бүх газар усалгаатай талбайг түшиглэн хийхэд чиглэгдэнэ.

3. Хөтөлбөр хэрэгжих боломж

Дэд хөтөлбөрийн хэрэгжих боломж нь манай улс зах зээлд шилжихийн өмнө 1.2 сая га эргэлтийн талбай ашиглаж, 800 гаруй мянган га талбайд тариалалт явуулж, 400 мянган га талбайг уриншилж, үр тариа 840 мянган тонн, төмс 145 мянган тонн, хүнсний ногоо 55 мянган тонн, ногоон тэжээл 226 мянган тонн, дарш 288 мянган тонныг хураан авч, 199.8 мянган тонн гурил үйлдвэрлэж, улсын нөөцөд 18 мянган тонн үр хадгалж, цаг уур тааламжтай жилүүдэд илүүдэл буудай, төмс, хүнсний ногоог экспортлож, жил бүр буудайн 1200-3000 тн элит, 18000-22000 тн сортын үр үйлдвэрлэж байсан бодит туршлага, үр үйлдвэрлэлийг ашиг орлоготой бизнес хэмээн тариаланчид ойлгож, түүнийг эрхлэх сонирхол бий болж байгаа явдал юм.

Мөн үед тариалангийн төв бүсэд үр тарианы элит үрийн эх материалыг Дарханы Үргамал, газар тариалангийн сургалт, эрдэм шинжилгээний хүрээлэн (цаашид "Дарханы УГТСЭШХ" гэх)-д үйлдвэрлэж, түүнийг нь Дарханы сангийн аж ахуйд элит үр болтол үржүүлэн улмаар үрийн сангийн аж ахуйнуудад 1-2 жил үржүүлж, таваарын тарианы сангийн аж ахуйнуудад олгож, бүх нэгдэл, аж ахуйнууд 5 жил тутамд үрээ шинэчилж байв.

Баруун болон зүүн бүсийн хэрэгцээт элит үрийн эх материал, элит, сортын үрийг Улаангом дахь Хөдөө аж ахуйн нэгдсэн туршлага станц, Дорнод талын бүсийн ХАА-н эрдэм шинжилгээний хүрээлэн үйлдвэрлэж байв. Энэ хоёр бүсэд шаардагдах элит, сортын үрийн хэрэгцээ бага (100-

200 тн элит, 400-700 тн сортын үр) учир тусгайлсан үрийн сангийн аж ахуй гэж үгүй, дээрх станц, хүрээлэнгүүд элит, сортын үрээр хэрэгцээг нь хангадаг байв.

Энэ бүгдийн дүнд улсын үр тарианы дундаж ургац 12.4-14.3 ц/га, зарим аж ахуйн дундаж нь 26.3 ц/га, зарим талбайгаас 73-92 ц/га ургац хураах боломжийг бүрдүүлж байсан нь манай улс газар тариаланг амжилттай эрхлэх, дотоодын хэрэгцээт үрээ үйлдвэрлэх хөрс, уур амьсгалын болон мэргэжлийн боловсон хүчний боломжтой гэдгийг нотлож байгаа юм.

4. Үр үйлдвэрлэл зогсонги байдалд орсон гол шалтгаан

Үр үйлдвэрлэл зогсонги байдалд орсон нь дараахь шалтгаантай байна:

а/элит, сортын үр үйлдвэрлэх үүрэг бүхий сангийн аж ахуйнууд хувьчлагдан тарсан;

б/элит үрийн анхдагч материал гаргах үүрэг бүхий бүсийн эрдэм шинжилгээний байгууллагуудыг шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын харьяанд шилжүүлж, техник, тоног төхөөрөмжөө шинэчлэх хөрөнгө оруулалт хийхээ больсон;

в/элит, сортын үр гартал 6-7 жил борлуулалт хийдэггүй зөвхөн үржүүлэг, шигшин сайжруулах ажиллагаа хийгддэг учир төрийн дэмжлэггүйгээр хувийн аж ахуйнууд эрхлэх боломжгүй байдаг. Сүүлийн 10-ад жилд нэг ч тн элит үр үйлдвэрлэгдээгүйгээр барахгүй 4 жил дараалан тарих үр дутагдаж гадаадаас импортлож байна. 2000 онд импортлосон үр нь хэдийгээр хөрш Буриадаас авсан боловч манайд нутагшаагүй буудайн сортын үрийг элит, супер элит үрийн үнээр буюу дотоодын үрнээсээ 50-100 хувь илүү үнээр авсан байна.

5. Дэд хөтөлбөрийн бүтэц

Энэ дэд хөтөлбөрийн бүтэц нь 1/стратегийн гол хүнсний бүтээгдэхүүн буудайн үрийн аж ахуй, 2/хүнсний хоёр дахь гол таримал төмсний үрийн аж ахуй гэсэн хоёр үндсэн хэсгээс бүрдэж байгаа болно.

6. Буудайн үрийн аж ахуй

6.1. Буудайн үрийн аж ахуйг зах зээлийн тогтолцоонд нийцүүлэн өөрчлөн зохион байгуулж тариалах талбай, хураан авах ургац, шаардагдах үрийн хэмжээг төлөвлөлөө. Ийнхүү төлөвлөхдөө 2000 онд бэлдсэн үриншийн хэмжээ, техник хэрэгслийн боломж зэргийг бодолцсон бөгөөд 1989 онд тариалангийн төв бүсэд 416 мянган га-д үр тариа тариалж, 537 мянган тонн ургац, зүүн бүсэд 72 мянган га тариалж 111 мянган тонн ургац, баруун бүсэд 42 мянган га-д тариалж 38 мянган тонн ургац авч байсан нөхцөлийг бас харгалзсан болно. 2001-2005 онд тариалах талбай, хураан авах ургацыг хүснэгтээр харуулбал:

Буудайн үйлдвэрлэл 2001-2005 онд

Бүс	2001 он		2002 он		2003 он		2004 он		2005 он	
	Тарих талбай мян. га	Хураах ургац мян.тн	Тарих талбай мян.га	Хураах ургац мян тн.	Тарих талбай мян. га	Хураах ургац мян. тн	Тарих талбай мян. га	Хураах ургац мян. тн	Тарих талбай мян. га	Хураах ургац мян. тн
Зүүн	13,2	10,7	21,0	17,0	26,2	21,2	37,5	30,6	47,0	42,5
Төв	180,0	128,0	250,0	212,5	300,0	270,0	330,0	313,5	350,0	350,0
Баруун	2,0	1,6	10,0	8,0	12,0	9,6	18,0	16,2	25,0	22,5
Бүгд	**195,2**	**140,3**	**281,0**	**237,5**	**338,2**	**300,8**	**385,5**	**360,3**	**422,0**	**415,0**

Тайлбар: Тариалангийн төв бүсэд: Хөвсгөл, Булган, Орхон, Сэлэнгэ, Дархан-Уул, Төв, Архангай, Өвөрхангай, зүүн бүсэд: Хэнтий, Сүхбаатар, Дорнод, баруун бүсэд: Завхан, Увс, Ховд, Баян-Өлгий, говийн бүсэд: Говь-Алтай, Өмнөговь, Дундговь, Дорноговь, Говьсүмбэр, Баянхонгор аймгуудыг оруулсан.

6.2. 2001-2005 онд шаардагдах үрийн хэмжээг тооцож бүс нутаг, оноор харуулбал:

2001-2005 онд шаардагдах үрийн хэрэгцээ,
түүнийг хангах боломж

Үзүүлэлт			2001 он	2002 он	2003 он	2004 он	2005 он
Зүүн бүс	Тарих талбай /мян.га/		**13,2**	**21,0**	**26,2**	**37,5**	**47,0**
	Хэрэгцээт үр /тн/		***2 244,0***	***3 570,0***	***4 454,0***	***6 375,0***	***7 990,0***
	Үүнээс	Элит үр /тн/	-	-	66,9	160,0	160,0
		1 дүгээр репрод.	-	504,0	504,0	248,0	593,0
		2 дугаар репрод.	-	-	1867	1867	2197*
		Бусад	2 244,0	3 066,0	2 016,1	4 100,0	5 040,0
Төв бүс	Тарих талбай /мян.га/		**180.0**	**250.0**	**300.0**	**330.0**	**350.0**
	Хэрэгцээт үр /тн/		*30 600,0*	*42 500,0*	*51 000,0*	*56 100,0*	*59 500,0*
	Үүнээс	Элит үр /тн/	-	-	197,0	218,0	632,0
		1 дүгээр репрод.	576,0	864,0	1 441,0	813,0	898,0
		2 дугаар репрод.	-	2 371,0	3 559,0	5 934,0	3 347,0

Баруун бүс	Үүнээс	бусад	30 024,0	39 265,0	45 803,0	49 135,0	54 623,0
		Тарих талбай /мян.га/	2,0	10,0	12,0	18,1	25,0
		Хэрэгцээт нийт үр /тн/	*200,0*	*1 000,0*	*1 200,0*	*1 810,0*	*2 500,0*
		Элит	-	-	-	119,0	119,0
		1 дүгээр.репрод.	-	353,0	353,0	353,0	666,0
		2 дугаар репрод	-	-	847,0	1 300,0	1 715,0
		бусад	200,0	647,0	0,0	38,0	0,0
Тарих талбай /мян.га/			195,2	281,0	338,2	385,6	422,0
Хэрэгцээт үрийн дүн /тн/			33 044,0	47 070,0	56 654,0	64 285,0	69 990,0

Тайлбар: - Тарих үрийн нормыг төв ба зүүн бүсэд 170 кг/га, баруун бүсэд 100 кг/га-гаар тооцов.

- Зүүн ба говийн бүсийн тариалалтыг хамтад нь оруулав.

- *зүүн бүсэд 2005 он гэхэд эрдэм шинжилгээний байгууллагаас гаргасан эх материалаар 919 тн 2 дугаар репродукцийн үр гарч 2006 онд 2197 тн болж хэрэгцээг хангах учир тоог 2006 оныхоор авав.

6.3. Тариалангийн дээрх 3 үндсэн бүсийн элит болон дээд үеийн үржүүлгийн (1 дүгээр репродукци) үрийн хэрэгцээг хангахын тулд 2003-2004 он хүртэл доорхи 2 аргыг хэрэглэнэ:

а/эрдэм шинжилгээний байгууллагуудыг бэхжүүлэн элит үрийн анхдагч материал үйлдвэрлэн түүнийг нь сонгож авсан үр үржүүлэх хувийн хэвшлийн аж ахуйнууд элит, сортын үр болгон үржүүлж таваарын аж ахуйнуудын хэрэгцээнд нийлүүлэх;

б/эрдэм шинжилгээний байгууллагуудыг анхдагч материал бий болготол сонгож авсан аж ахуйнуудад бөөний серег сонголтын аргаар, зөвхөн сортын үрийг хурдавчилсан аргаар үйлдвэрлэх гэсэн 2 үндсэн аргыг хослуулан хэрэглэж, цаашид эрдэм шинжилгээний байгууллагууд хүрэлцэх хэмжээний анхдагч материал гаргаж эхэлмэгц серег сонголтын аргыг орхиж, эрдэм шинжилгээний байгууллагаас гаргасан эх материалыг элит, 1 дүгээр репродукцийн үр болгол үржүүлэх болно. Харин 2 ба түүнээс цаашхи репродукцийн үр үржүүлэх ажлыг тариалангийн аж ахуйн нэгж, иргэд өөрсдөө хийнэ.

6.4. Хүнс, хөдөө аж ахуйн ямны захиалгаар үйлдвэрлэж борлоогүй үлдсэн буудайн элит, 1 дүгээр репродукцийн үрийг улсын үрийн нөөцөд худалдан авах бөгөөд нөөцөд үрийн хүрэлцээгүй бол аж ахуйн нэгж, иргэдээс 2 дугаар репродукцийн үр худалдан авах болно. Улсын нөөцөд 2 дугаар репродукциас доош үр худалдан авахгүй.

6.5. Тариалангийн төв, баруун болон зүүн бүсэд элит, сортын үр үйлдвэрлэж байсан хуучин схем, тогтолцоог бүрэн өөрчилж бүсүүдийн үр үржүүлгийг дараахь схем, төлөвийг тооцов.

Бүсүүдийн үр үржүүлгийн схем тариалангийн төв бүсэд буудайн элит, сортын үр үйлдвэрлэх төлөв

Он	Супер элит		Элит		1-р репродукци		2-р репродукци		3-р репродукци		4-р репродукци		Тухайн жилийн үрийн	
	Талбай /га/	Ургац /тн/	Талбай /га/	Ургац /тн/	Талбай /га/	Ургац /тн/	Талбай /га/	Ургац /тн/	Талбай /га/	Ургац /тн/	Талбай /га/	Ургац /тн/	Талбай /га/	Ургац /тн/
2001					823	576							823	576
2002	47	40			1235	804	3388	2371					4670	3275
2003	53	44	235	197	2059	1441	5085	3559	13947	9763			20929	15004
2004	153	128	259	218	1162	813	8478	5934	20935	14654	57429	40200	88416	61947
2005	153	128	753	632	1282	898	4782	3347	34907	24435	42943	30060	84820	59500
2006	153	128	753	632	3717	2602	5280	3696	19692	13784	55940	39158	85535	60000

Баруун бүсэд үйлдвэрлэх элит, сортын үр

Он	10 цн/га 100% Үржүүлгийн 1-р жил		Үржүүлгийн 2-р жил		9 цн/га 70% Супер элит		Элит		8 цн/га 70% 1-р репродукци		2-р репродукци		Тухайн жилийн үрийн	
	Талбай /га/	Ургац /тн/	Талбай /га/	Ургац /тн/	Талбай /га/	Ургац /тн/	Талбай /га/	Ургац /тн/	Талбай /га/	Ургац /тн/	Талбай /га/	Ургац /тн/	Талбай /га/	Ургац /тн/
2001	0.3	0.3											0.3	0.3
2002	0.3	0.3	3.0	3.0					630	353			633.3	356.3
2003	0.3	0.3	3.0	3.0	30	19			630	353	1520	847	2183.3	1222.3
2004	0.3	0.3	3.0	3.0	30	19	190	119	630	353	2330	1300	3183.3	1794.3
2005	0.3	0.3	3.0	3.0	30	19	190	119	1190	666	3050	1720	4463.3	2527.0

Зүүн бүсэд үйлдвэрлэх элит, сортын үр

Он	Супер элит		Элит		1-р репродукци		2-р репродукци		3-р репродукци		Тухайн жилийн үрийн	
	Талбай /га/	Ургац /тн/	Талбай /га/	Ургац /тн/	Талбай /га/	Ургац /тн/	Талбай /га/	Ургац /тн/	Талбай /га/	Ургац /тн/	Талбай /га/	Ургац /тн/
2001												
2002	23	16.1			800	504					800	504
2003	55	39	95	66.9	800	504	2964	1867			3913.7	24769
2004	55	39	229	160	393	248	2964	1867	9347	5889	14627	7600
2005	55	39	229	160	941	593	1458	919	9347	5889	13669	7600

Тайлбар: Зураасны доод талынх нь эрдэм шинжилгээний байгууллагаас гаргасан элит, сортын үрээр тариалах. Зураасны дээд талынх нь эрдэм шинжилгээний байгууллагын материалаар элит үр хүрэлцэх хэмжээгээр үйлдвэрлэх хүртэл 2001-2002 онуудад соногдсон 10 аж ахуйн нэгжид тус бүр нь 50 га талбайд бөөний серег сонголтоор гаргах үр. Үг үрийг 2005, 2006 оноос үржүүлэхийг нь багасгаж элит үрээр солих болно.

Баруун бүсийн хувьд Улаангом дахь газар тариалангийн эрдэм шинжилгээний салбарт бага зэрэг дэмжлэг үзүүлбэл хуучин схемээрээ өөрийн бүсийн хэрэгцээт (119 тн) элит үрийг бие даан үйлдвэрлэх боломжтой бөгөөд харин түүнийг нь 1-2 дугаар репродукцийн үр болтол үржүүлэх аж ахуйн нэгжүүд (усалгаатай, усалгаагүй сортын үр үржүүлэх)-ийг сонгон шалгаруулж ажиллуулах болно.

6.6. Шинээр боловсруулсан энэ тогтолцоо нь өмнөхөөс доорхи ялгаатай:

а/Дарханы УГТСЭШХ-д эх материал гаргах хугацааг ургацыг нэмэгдүүлэх замаар 1 жилээр цөөрүүлсэн;

б/хуучин үрийн аж ахуй нь хүрээлэнгээс авсан 3 дахь жилийн үржүүлгийн үрийг 2 жил тариалж супер элит, элит үр гаргах үүргийг дангаараа хариуцаж байсан бол одоо энэ үүргийн нэг хэсгийг хувийн хэвшилд шилжүүлсэн;

в/үр үржүүлгийн аж ахуйнуудад гаргаж байсан сортын үрийг хувийн хэвшлийн 27 компани, фермер (төрийн өмчийн хүрээлэн, станцууд, түүний харьяа салбарууд оролцож болно)-уудийг 3 бүсэд сонгон шалгаруулж сортын үр үйлдвэрлүүлэн дотоодын хэрэгцээг хангах болж байгаа;

г/захиалгаар үйлдвэрлэсэн элит, сортын үрийг хэрэв аж ахуйнууд худалдан авахгүй бол улсаас тогтоосон доод үнээр улсын нөөцөд худалдан авч байх нь үр үйлдвэрлэгчдийн борлуулалтыг баталгаажуулах замаар эдийн засгийн сонирхол бий болгоно гэж үзэв.

6.7. Энэ шинэчилсэн схемээр үр үйлдвэрлэх нь дор дурдсан давуу талтай байх болно:

а/элит үр үйлдвэрлэх үүргийг дангаараа хүлээж байсан Дарханы УГТСЭШХ-гийн "Найрамдал" салбар энэ үүргийг дангаараа биш хэд хэдэн аж ахуйтай зэрэгцэн хийх болсноор элит үрийн хувь заяа ганц аж ахуйгаас хамааралтай байхаа болих;

б/улсын захиалгаар үйлдвэрлэсэн элит, сортын үрийн борлолт баталгаатай болж үр үйлдвэрлэх аж ахуйнуудад эдийн засгийн сонирхол бий болох;

в/тариалан эрхлэгчид өөрийн санхүүгийн болон боловсон хүчний боломждоо нийцүүлэн элит, супер элит болон анхан шатны үржүүлгийн материал худалдан авч өөрөө элит, сортын үр үйлдвэрлэх боломж нээгдэх болно.

6.8. Супер элит, элит болон сортын үр үйлдвэрлэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулахдаа доорхи үндсэн зарчмыг баримтална:

а/аль болох усалгаатай талбайтай байх; Энэ нь үр үйлдвэрлэлийн эрсдэлийг бууруулах, бага талбайгаас ахиуургац авах замаар олон техник, хүн хүч шаардахгүй, богино хугацаанд их үр үйлдвэрлэх боломжтой болно;

б/аль болох бүрэн хувьчлагдаж хувьцаа нь төвлөрсөн аж ахуй байх; Энэ нь үр үйлдвэрлэлд хөрөнгө, хүч, анхаарлаа төвлөрүүлэх боломж олгоно;

в/тариалангийн тухайн бүсийнхээ хөрс, уур амьсгалыг төлөөлж чадах, байршлын хувьд тохиромжтой байх; Үржүүлсэн үр нь тухайн бүсдээ тохирох, аж ахуйнуудад ойр учир тээврийн зардал бага гарна;

г/уг аж ахуйн нэгж нь элит, сортын үр үйлдвэрлэх мэргэжлийн боловсон хүчинтэй, материаллаг бааз /техник, үтрэм, үтрэмийн техник г.м./- ын хувьд боломжтой байх;

д/уг аж ахуй нь гэрээнд заасан хэмжээний элит, сортын үр үйлдвэрлэхэд шаардагдах эх материал (2 дахь жилийн үржүүлгийн бүюу элит үр)-ыг жил бүр худалдан авч үржүүлэхээр Дарханы УГТСЭШХ, Хүнс, хөдөө аж ахуйн яамтай гурван талын гэрээ хийж хариуцлага хүлээхээ нотолсон байх.

6.9. Элит, сортын үр үйлдвэрлэл нь дараахь байдлаар явагдана:

а/тариалангийн төв ба зүүн бүс

Дарханы УГТСЭШХ нь тариалангийн төв болон зүүн бүсийн элит үр үйлдвэрлэлд хүрэлцэх хэмжээний анхдагч материалыг доорхи хүснэгтэд заасан хэмжээгээр үйлдвэрлэнэ:

Дарханы УГТСЭШХ-д үйлдвэрлэх буудайн элит үрийн анхдагч материал

/Цэвэр ургац 12 ц/га, үрийн гарц 100%/

Он	Үржүүлгийн 1 дүгээр жил		Үржүүлгийн 2 дугаар жил		Тухайн жил	
	Тарих талбай /га/	Хураах ургац /тн/	Тарих талбай /га/	Хураах ургац /тн/	Тарих талбай /га/	Хураах ургац /тн/
2001	2.1	2.6	-	-	2.1	2.6
2002	4.2	5.0	15	18	19.2	23.0
2003	4.2	5.0	29.4	35.3	33.6	40.3
2004	4.2	5.0	29.4	35.3	33.6	40.3
2005	4.2	5.0	29.4	35.3	33.6	40.3

Дарханы УГТСЭШХ, түүний харьяа "Найрамдал" салбар нь өөрийн талбай, техник, боловсон хүчний боломждоо тушиглэн тариалангийн төв бүсийн хэрэгцээнд зориулан доорхи хэмжээний элит, сортын үрийг үйлдвэрлэх үүргийг хүлээнэ.

Хүрээлэн болон түүний "Найрамдал" салбарт үйлдвэрлэх элит, сортын үрийн хэмжээ

он	Супер элит		Элит		1дүгээр репродукци	
	Тарих талбай /га/	Хураах ургац /тн/	Тарих талбай /га/	Хураах ургац /тн/	Тарих талбай /га/	Хураах ургац /тн/
2001	-	-	-	-	-	-
2002	47	40	-	-	-	-
2003	53	44	235	197	-	-
2004	53	44	259	218	300	210
2005	53	44	259	218	400	280

Үүнээс үлдэх үрийг сонгон шалгаруулсан үрийн аж ахуйнууд бөөний серег сонголтын аргаар тариалангийн төв, зүүн бүсэд буудайн элит, сортын үр үйлдвэрлэх төлөвт заасан хэмжээгээр үйлдвэрлэнэ.

б/тариалангийн баруун бүс

Тариалангийн баруун бүсэд үйлдвэрлэх элит үрийн хэмжээ нь 119 тн учир түүнийг талбай, боловсон хүчний хувьд боломжтой Улаангом дахь газар тариалангийн эрдэм шинжилгээний салбар хариуцан үйлдвэрлэх бөгөөд харин 1-2 дугаар репродукцийн 660-1976 тонн сортын үрийг үржүүлэх аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж ажиллана.

Баруун бүсэд усалгаагүй нөхцөлд богино болцтой сорт, усалгаатай нөхцөлд намхан иштэй эрчимжсэн хэлбэрийн сорт гэсэн 2 сорторт үрийн аж ахуй эрхлэх болно. Энэ бүсэд эрдэм шинжилгээний байгууллага нь хөтөлберт хамрагдсан ч гэсэн 2004 оноос наана элит үр гаргах боломжгүй учир 2001 оноос эхлэн 2 аж ахуйд бөөний, серег сонголтоор 1 дүгээр репродукцийн сортын үр үйлдвэрлэх замаар бүсийн хэрэгцээт үрийг шинэчлэх боломжийг бүрдүүлж, 2004 оноос элит үр гаргасан нөхцөлд тэдгээр аж ахуйнууд элит үрийг үржүүлнэ. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Баруун бүсэд үйлдвэрлэх буудайн элит үр

Он	Үржүүлгийн 1 дүгээр жил		Үржүүлгийн 2 дугаар жил		Супер элит үр		Элит үр		Тухайн жилийн үрийн тариалан	
	Тарих талбай /га/	Хураах ургац /тн/	Тарих талбай /га/	Хураах ургац /тн/	Тарих талбай /га/	Хураах ургац /тн/	Тарих талба й /га/	Хураах ургац /тн/	Тарих талбай /га/	Хураах ургац /тн/
2001	0.3	0.3	-	-	-	-	-	-	-	3.3
2002	0.3	0.3	3.0	3.0	-	-	-	-	3.3	3.3
2003	0.3	0.3	3.0	3.0	30	19	-	-	33.3	33.3
2004	0.3	0.3	3.0	3.0	30	19	190	119	223.3	141.3
2005	0.3	0.3	3.0	3.0	30	19	190	119	223.3	141.3
2006	0.3	0.3	3.0	3.0	30	19	190	119	223.3	141.3

6.10. Бүс бүрт үйлдвэрлэх элит, сортын үрийн хэмжээг аж ахуйн хэвшлээр нь хуваавал доорхи байдалтай болно:

Үр үйлдвэрлэх захиалгын ерөнхий хуваарь

Үр үйлдвэрлэгчид	Төв бүс		Зүүн бүс		Баруун бүс	
	Элит үр	I репро-дукци	Элит үр	I репро-дукци	Элит үр	I репро-дукци
Эрдэм шинжилгээний хүрээлэн	100	100	100	150	119	100
Түүний харьяа салбар *	118	180	-	-	-	-
Элит үр үйлдвэрлэх гэрээтэй аж ахуй	414	650	60	150	-	-
Сортын үр үйлдвэрлэх гэрээтэй аж ахуй	-	1672	-	293	-	560
Бүгд	**632**	**2602**	**160**	**593**	**119**	**660**

*Дарханы хүрээлэнгийн харьяа "Найрамдал" салбар.

6.11. Нэг аж ахуйн нэгж, байгууллагад 100 тн-оос ихгүй элит үр, 150 тн-оос ихгүй 1 дүгээр репродукцийн үр, 300 тн-оос ихгүй сортын үр үйлдвэрлэж байхаар зохицуулах нь үйлдвэрлэж байгаа үрийн чанарт тохиромжтой гэж үзнэ.

Энэ хэмжээгээр тооцоход:

Төв бүсэд:

а/ элит үрийг Дарханы УГТСЭШХ, түүний салбараас гадна сонгон шалгаруулсан 4 аж ахуйд;

б/1 дүгээр репродукцийн үрийг дээрх 6 аж ахуйн нэгж, байгууллагаас гадна сонгон шалгаруулсан 5 аж ахуй, бүгд 11 аж ахуйн нэгж, байгууллагад.

Зүүн бүсэд:

а/элит үрийг Дарханы УГТСЭШХ-гээс гадна сонгон шалгаруулсан 1 аж ахуйн нэгжид;

б/1 дүгээр репродукцийг дээрх 2-оос гадна сонгон шалгаруулсан 1 аж ахуйн нэгжид, бүгд 3 аж ахуйд.

Баруун бүсэд:

а/элит үрийг Улаангомын газар тариалангийн эрдэм шинжилгээний салбарт;

б/1 дүгээр репродукцийг дээрх салбараас гадна сонгон шалгаруулсан 2 аж ахуй, бүгд 3 аж ахуйн нэгжид эрхлэх шаардлагатай байна.

6.12. Дэд хөтөлбөр хэрэгжүүлэх явцад тариалангийн төв бүсэд үрийн аж ахуй эрхлэх 11 аж ахуйн нэгж, байгууллага, зүүн бүсэд 3 аж ахуйн нэгж, байгууллага, баруун бүсэд 3 аж ахуйн нэгж, байгууллага, бүгд 17 аж ахуйн нэгж, байгууллагыг сонгон шалгаруулж үрийн үйлдвэрлэл эрхлүүлэн төрөлжүүлэх болно.

6.13. Хүнс, хөдөө аж ахуйн яам нь бүсийн эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран тусгай шалгуур үзүүлэлтээр (дээр дурдсан болзол нөхцөл хангасан) элит, 1 дүгээр репродукцийн үр үйлдвэрлэх аж ахуйн нэгжүүдийг сонгон шалгаруулж гэрээ хийнэ.

6.14. Эрдэм шинжилгээний байгууллагууд нь Хүнс, хөдөө аж ахуйн яамнаас захиалсан сортын анхдагч үрийн материалыг гарган гэрээт элит үрийн аж ахуйнуудад худалдана. Үйлдвэрлэсэн анхдагч материалыг хуваарь, гэрээний дагуу аваагүй, эсвэл хүрээлэн нь чанарын шаардлага хангасан, гэрээт хэмжээний үрийг үйлдвэрлээгүй бол буруутай тал гэрээнд заасан хариуцлага хүлээхээс гадна зохих журмын дагуу сортын болон үрийн чанарын хяналтад хамруулж баталгаажуулна.

6.15. Үрийг худалдан борлуулах үйл ажиллагаат аж ахуйн нэгжүүд өөрсдөө хариуцах бөгөөд үнийг өөрсдөө тогтооно. Харин үйлдвэрлэсэн элит, 1 дүгээр репродукцийн үр чанарын шаардлага хангасан боловч борлоогүй тохиолдолд түүнийг улсын нөөцөд уг үйлдвэрлэгчийн ашгийн доод түвшин (5-20 %) -г хангах үнээр худалдан авна.

6.16. Манай улсад үржүүлэх буудайн үр нь төрөл (категори)-тэй байна. Үүнийг хүснэгтээр харуулбал:

Үйлдвэрлэх буудайн үрийн төрөл (категори)

Үрийн төрөл /категори/	Үр үйлдвэрлэгч	Үр үйлдвэрлэгчид тавих шаардлага	Санхүүжүүлэх байгууллага, эх үүсвэр	Тайлбар
Элит үрийн эх материал үржүүлгийн үр	Эрдэм шинжилгээний байгууллага	Шинэ сорт гаргаж, нутагшуулах ажил эрхэлдэг байх	ШУТ-ийн сан, хүнс, хөдөө аж ахуйн сан, гадаадын тусламж, төсөл	Дарханы УГТСЭШХ-д тариалан-гийн төв болон зүүн бүсийн хэрэгцээт эх материалыг гаргана. Дорнодын нүүрэлэн нь Дарханы хүрээлэнд гаргасан 2 дахь жилийн үржүүлгийн үрийг авах үчир эх материал үйлдвэрлэхгүй.
Супер элит, элит үр	Үрийн эх материал үйлдвэрлэсэн эрдэм шинжилгээний байгууллага, дээд сургууль, хувийн компани, хоршоо, иргэд	Тендерт шалгарч элит үр үйлдвэрлэх гэр-чилгээ авч эх материал авах эрдэм шинжилгээний байгууллагатай гэрээ байгуулсан байх	Төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллагад ШУТ-ийн сан, хүнс, хөдөө аж ахуйн сан, гадаадын төсөл, хөтөлбөр, хувийн хэвшилд урт хугацаатай хөнгөлөлттэй зээл, гадаадын төсөл, хөтөлбөр, зээл, тусламж	Эрдэм шинжилгээний байгуулла-гад техник шинэчлэхэд хөрөнгө оруулалт хийж, урсгал зардлын нэг удаагийн санхүүжилтэд зээл олгох, гадаадын төсөлд хамруулах хувийн хэвшилд техник шинэчлэх, урсгал зардлыг санхүүжүүлэхэд эргэн төлөгдөх нөхцөлөөр зээл олгох, гадаадын төсөлд хамруулах
1 дүгээр репордукцийн /сортын/ үр	Эрдэм шинжилгээний байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, иргэд	Тендерт шалгарч сортын үр үйлдвэрлэх гэр-чилгээ авсан, элит үрийн аж ахуйтай жил бүр элит үр авах гэрээ хийсэн байх	Өөрийн хөрөнгө, гадаад, дотоод-дын зээл, тус-ламж, төсөл, хөтөлбөрт хамрах	Гербицид цацагч, үр цэвэрлэх, дугаарлах техник авах, жилийн үрсгал зардалд зориулан зээл олгох

6.17. Буудайн үрийн аж ахуйг сэргээх, үр үржүүлэх хөрөнгийн эх үүсвэр, тооцоо

Буудайн үрийн аж ахуйг сэргээх хөтөлбөрийг хэрэгжүүлэх хөрөнгийн ойролцоо тооцоо

/сая төг/

	ҮЗҮҮЛЭЛТ		Нийт хэмжээ	Үүнээс: Үр үйлдвэрлэгч тус бүрээр						
				Хамрагдах аж ахуйн тоо	Дарханы УГТСЭШ-ний хүрээлэн	Дархан Найрамдал салбар	Дорнодын Хүрээлэн	Улаан-гом дахь ГТЭШС	Элит үр уржуулэх аж ахуй	1-р репрод. үр үйлдвэрлэх аж ахуй
Үйлдвэрлэх	Эх материал /тн/		40.3	2	35.3	-	-	3.0	-	-
	Элит үр /тн/		911	9	100	118	80	138	475	-
	1дүгээр репорд. /тн/		3861	8	100	180	93	200	1788	1500
Хэрэгцээтэй техник	Герби-цид цацагч	Тоо	17	17	-	1	1	1	6	8
		Бүгд үнэ /сая төг/	42.5	-	-	2.5	2.5	2.5	15.0	20.0
	Үр цэвэр-лэгч	Тоо	12	12	1	1	-	-	5	5
		Бүгд үнэ /сая төг/	96.0	-	8.0	8.0	-	-	40.0	40.0
	Үр дугаар-лагч	Тоо	18	18	1	2	-	-	5	10
		Бүгд үнэ /сая төг/	115.9	-	6.1	12.2	-	-	30.5	61.0
	Комбайн	Тоо	9	9	1	-	1	1	2	4
		Бүгд үнэ /сая төг/	216	-	24	-	24.0	24.0	48.0	96.0
	Трактор	Тоо	9	9	1	1	1	1	-	5
		Бүгд үнэ /сая төг/	198.0	-	22.0	22.0	22.0	22.0	-	110.0
Үндсэн хөрөнгө бүгд /сая төг/			662,3		60,1	44,7	48,5	48,5	133,5	327.0
Урсгал зардал /сая төг/			386.5	-	22.0	118.0	15.0	11.5	Зээл, 1 аж ахуйд 10.0 сая төг. 6х10=60	Зээл, 1 аж ахуйд 20.0 сая төг. 8х20=160
Нийт зардал /сая. төг/			**1048.8**	**-**	**82.1**	**162.7**	**63.5**	**60.0**	**193.5**	**487.0**
Үүнээс	Улсын төсөв		90.0	-	30.0	-	30.0	30.0	-	-
	КР-2 хуримт.сан		623.7	-	40.0	162.7	33.5	15.0	172.5	200.0
	Гадаадын төсөл		78.1	-	12.1	-	-	15.0	21.0	30.0
	Аж ахуйн өөрийн хөрөнгөөр		257.0	-	-	-	-	-	-	257.0

6.18. Энэ хөтөлбөрийг 2005 он гэхэд бүрэн хэрэгжүүлнэ. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 1048.8 сая төгрөг шаардагдана. Үүнээс зээл 623.7сая төгрөг буюу 59.5 хувь нь КР-2 сангийн хөрөнгө, 257.0 сая төгрөг буюу 24.5 хувь нь аж ахуйн нэгжүүдийн өөрийн хөрөнгө, эрдэм шинжилгээний байгууллагуудад "Шинжлэх ухаан, технологийн сан"-гаас олгох хөрөнгө оруулалт 90.0 сая төгрөг байна. Нийт зардлыг хөтөлбөр хэрэгжих 5 жилээр тооцоход 1 жилд 209 орчим сая төгрөг шаардагдана. Зээлийг Японы Засгийн газрын КР-1, КР-2 төслөөр нийлүүлсэн барааны борлуулалтын орлого болох "КР-1, КР-2 төслийн хуримтлалын сан"-гаас Японы талтай зөвшилцөн олгоно.

Азийн хөгжлийн банкны "ХАА-н хөтөлбөрт зээл"-ийн 1.0 орчим сая долларын зээлийн зохих хэсгийг үрийн аж ахуйнуудад олгуулах бодлого баримтална.

Гадаадын зээлийн хувьд зөвхөн хувийн хэвшлийн аж ахуйд ашиглах бодлого баримтална.

7. Төмсний үрийн аж ахуй

7.1. Төмсний хангамжийн байдал,

шаардлага

1989 онд манай улс 148 мянган тонн буюу 1 га-аас 128 ц төмс хураан авсан нь дотоодын хэрэгцээгээ бүрэн хангаад 40 гаруй мянган тонн төмсийг экспортод гаргаж байв. Төмс нь манай хүнсний хамгийн өргөн хэрэглээтэй бүтээгдэхүүн бөгөөд нийт хэрэглээнд мах, гурил, сүүний дараа ордог. Манай улсад тариалж байгаа таримлуудаас хөрс, цаг уурын нөхцөлд хамгийн тохиромжтой нь төмс.

Төмс нь хавар тарих үед өөрийн чийгээрээ үргадгаас 5-6 дугаар сарын ганд нэрвэгдэх нь бага, 8-9 дүгээр сар буюу төмсний бүлүүг ид томрох үед манай бороонд улирал эхлэх үчир үргүй нэмэгдэх гол нөхцөл болдог.

Гэвч сүүлийн жилүүдэд төмсний үйлдвэрлэл буурч 2000 оны байдлаар 8.7 мян.га-д тариалж 50.9 мян.тн үргац, 1 га-аас денгөж 58.5 центнер үргац авсан байна. Төмсний тариалалт буурсан шалтгаан нь төмсний төвлөрсөн томоохон аж ахуй болон түүний бүтээгдэхүүнийг бэлэн мөнгөөр бөөнөөр нь худалдан авч байсан зооринаж ахуй үгүй болсон, хүн амын худалдан авах чадвар буурсан зэрэгтэй холбоотой байна. Харин нэгж талбайгаас авах үргац буурсан нь зах зээлд шилжсэнээс хойш үрийн аж ахуйн тогтолцоо алдагдаж түүнийг эрхлэж байсан үрийн сангийн аж ахуйнууд хувьчлагдаж тарсан, эрдэм шинжилгээний байгууллагуудын техник хэрэгсэл хуучирч шаардагдах хэмжээний үр үйлдвэрлэх чадаргүй болсон явдал юм.

7.2. Төмсний хэрэгцээ, тариалах хэтийн төлөв

Монгол хүний физиологийн хэрэгцээгээр нэг хүн жилд 46 кг төмс хэрэглэх шаардлагатай бөгөөд үүнийг бүх жишмэл хүнээрээ тооцвол манай улс жилд 98 мянган тонн төмсийг хүнсэндээ хэрэглэх бөгөөд энэ хэмжээний үргац хураахын тулд 1га-аас 120 ц үргац авна гэхэд 8.2 мянган га-д тариалах ёстой болно. Хүнсний хэрэглээн дээр тарих үр 24.6 мянган тонн-ыг нэмж бодвол 122 мянган тонн төмс хэрэгтэй болох бөгөөд үүнийг 10.0 орчим мянган га-аас авах боломжтой.

Төмсний хэрэгцээ, тариалалтын төлөв

Бүс	2001		2002		2003		2004		2005	
	Тарих га	Үргац тн	Тарих га	Үргац тн	Тарих га	Үргац тн	Тарих га	Үргац тн	Тарих га	Үргац тн
Төв	6824	43577	7800	48360	7910	59325	8050	59570	8590	68720
Зүүн	600	1970	750	3000	785	3297	820	3526	952	4855
Баруун	1200	3932	1350	5400	1410	6063	1540	6930	1864	1025
Говь	352	2565	400	3000	420	3276	490	3871	526	4418
Бүгд	8994	52000	10300	59760	10525	71961	10900	73897	11932	79018

Төмсний үйлдвэрлэлийн өсөлтийг тооцохдоо 2000 онд тариалсан байдал, цаашид зах зээлд төмсний эрэлт хэрэгцээ ямар байх зэргийг харгалзан 2ОО5 онд тарих талбайг 2000 оны гүйцэтгэлээс 36.8 хувиар, хураан авах үргацыг 55.1 хувиар нэмэгдүүлнэ гэж үзэв.

7.3. Төмсний үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд шаардагдах үр, түүнээс элит үрийн хэрэгцээг тооцож үзэхэд доорхи байдалтай байна:

Төмсний үрийн хэрэгцээ, тн

Бүс	2001		2002		2003		2004		2005	
	Нийт үр	Элит үр	Нийт үр	Элит үр	Нийт үр	Элит үр	Нийт үр	Элит үр	Нийт үр	Элит үр
Төв	20535	287	23400	327	23730	332	24150	338	25770	360
Зүүн	1800	25.2	2250	31.5	2355	33	2460	34	2856	40
Баруун	3600	50	4050	56.7	4230	59	4620	64	5592	78
Говь	1056	14.8	1200	17	1260	18	1470	20	1578	22
Бүгд	56991	377	30900	432.2	31575	442	32700	456	30796	500

Тайлбар: Үрийн нормыг 3.0 тн/га-аар бодов. Элит үрийн хэрэгцээг нийт хэрэгцээт үрийн 1/70-ээр буюу 5 жилд үрээ шинэчлэх ёстой гэсэн үндэслэлээр хийв.

Хэрэгцээг хангахад нийт 500 тн элит үр шаардлагатай байгаагаас 72 хувь буюу 360 тн нь тариалангийн төв бүсэд хэрэгцээтэй байна. Бусад бүсүүдийн элит үрийн хэмжээ бага учир бүс бүрт нэг аж ахуй сонгон шалгаруулж, тэдгээр аж ахуйн нэгж Дарханы УГТСЭШХ-гээс бичил булцуу авч үржүүлэн элит үр гаргах, мөн түүнийг нь 1-2 дугаар репродукци болтол үржүүлэх аж ахуйн нэгж, иргэдтэй гэрээтэй ажиллана.

7.4. Төмсний үргамлын өвчний байдал

Манай улс өвөлдөө тэсгэм хүйтэн, зундаа хуурай халуун болж байгалийн байгныи ариутгалын нөхцөлд байдаг учир европын чийглэг уур

амьсгалтай орнуудын төмсний аж ахуйн гол гамшиг болсон вирусын өвчин харьцангуй бага бөгөөд харин мөөгөнцөр, бактерийн гаралтай өвчин давамгайлдаг. Шаардлагатай химийн бодисоор нь тогтмол ариутган төмсний үрийн аж ахуйг эрхлэж чадвал харьцангуй хямд аргаар богино хугацаанд үрээ эрүүлжүүлэх бүрэн боломжтой. Гэвч манай улс химийн бодис дотоoддоо үйлдвэрлэдэггүй, түүнийг аж ахуйн нэгжүүд импортоор авах санхүүгийн боломж муугаас сүүлийн жилүүдэд төмсний өвчин ихсэж ургац буурүүлж байгаа нэг шалтгаан болж байна. 1999 онд Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнгээс хийсэн түүвэр судалгаагаар төмс тариалдаг 40 гаруй аж ахуйн нэгж, байгууллагын төмсний үрийн 92 хувь нь өвчинтэй, нийт өвчний 78 хувь нь мөөгөнцөр, бактерийн өвчин ээлж байв.

7.5. Төмсний ургамлын өвчинтэй тэмцэх үндсэн арга:

а/төмсийг нэг талбайд давтан тариалахгүй үр тариа, тэжээлийн ургамал оролцсон 3-5 ээлжтэй сэлгээ хэрэглэх замаар зөвхөн төмсөнд гардаг өвчнийг байгалийн аргаар нь хязгаарлах;

б/ эрүүл үрээр тариалах замаар төмсний өвчнөөс бүрэн ангижрах;

в/ төмсний үрийг тариалах үедээ болон төмсийг ургаж байх үед нь өвчний тархалтыг хязгаарлах, халдварыг багасгах зорилгоор химийн бодис хэрэглэх явдал мөн.

Хөтөлбөр хэрэгжүүлэхэд шаардагдах төмсний өвчин, хортонтой тэмцэх бодисын хэрэгцээ, зардлын тооцоог дараахь хүснэгтээр харуулав:

Шаардлагатай химийн бодисуудын хэмжээ, үнэ

№	Бараа материалын нэр	Авах тоо, хэмжээ	Нэгжийн үнэ /мян.төг/	Бүгд үнэ /мян.төг/
1	**Анхдагч үрийн аж ахуй (УГТСЭШХ)**			
	А) Бордоо			
	-Аммиакийн шүү	6.0 тн	126.6	759.72
	-Супер фосфат	6.0 тн	207.5	1244.9
	-Калийн шүү	6.0 тн	91.6	549.7
	Б) Гербицид			
	-Зенкор	200 кг	18.2	3640.0
	-Раундап	180 литр	9.2	1656.7
	В) Фунгицид			
	-Брестан-60	100 кг	70.7	707.7
	-Цинеб	300 кг	3.22	967.0
	-Фенорам	50 кг	3.22	317.0
	-Децис	30 литр	10.56	317.0
	Дүн			**16373.64**
2	**Үр үржүүлэгчдийн хэрэгцээнд**			
	А) Фунгицид			
	-Брестан-60			
	-Цинеб	86 кг	70.8	6086.4
	-Фенорам	150 кг	3.2	483.6
	-Децис	40 кг	3.2	129.0
	Дүн	30 литр	10.6	317.0
				7016.0
	Бүгд			**23389.6**

7.6. Төмсний ургамлын үрийн аж ахуйн систем

Үрийн аж ахуйн системийн үндсэн зарчим нь Дарханы УГТСЭШХ, Ургамал хамгааллын хүрээлэнгийн биотехнологийн лабораторид ургуулсан эрүүл ургамаланцрыг зуны хүлэмжид ургуулан бичил булцуу гаргаж түүнийг тариалангийн төв, зүүн болон баруун бүсэд сонгон авсан усалгаатай талбай бүхий аж ахуйн нэгж, байгууллагууд (өмчийн хэвшил үл харгалзан) супер элит, элит болтол үржүүлж борлуулах замаар улсын хэрэгцээг хангах явдал мөн.

1997 оноос ХБНГУ-ын Засгийн газраас хэрэгжүүлсэн "Өрхийн аж ахуйд дэмжлэг үзүүлэх" төслийн хүрээнд Дарханы УГТСЭШХ-гийн эрүүл үрийн төмс ургуулах биотехнологийн лабораторийн хүчин чадлыг нэмэгдүүлэн, орчин үеийн тоног төхөөрөмжөөр иж бүрэн тоноглосон нь манайд хэрэгцээт төмсний эрүүл үр ургуулах үндсэн нөхцөлийг бүрдүүлсэн юм. Одоогийн байдлаар тус лаборатори нь 15-20 мянган ширхэг ургамаланцрыг хуруу шилэнд өсгөвөрлөж, 70-80 мянган бичил булцууг зуны хүлэмжид ургуулах хүчин чадалтай болсон нь манай улсын тариалангийн бүх бүс нутгийн хэрэгцээг хангах боломжтой байгаа юм.

Үүний зэрэгцээ Нийслэл дэх Ургамал

хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн нь өөрийн хүчээр жилд 4-6 мянган бичил үргамаланцар үржүүлэх хүчин чадалтай лабораторийг ажиллуулж байна.

Төмсний үрийг улсын нөөцөд хадгалдаггүй учир төмсний үр үйлдвэрлэл нь тухайн жилдээ борлуулж аших олохыг зорьсон аж ахуйн нэгж, иргэдийн сонирхолд үндэслэдэг.

7.7. Дарханы УГТСЭШХ-гийн төмсний анхдагч үрийн аж ахуйг доорхи хүснэгтэд заасан хэмжээнд хүргэнэ:

Дарханы УГТСЭШХ-гийн үйлдвэрлэх эрүүл үрийн хэмжээ

Он	Урга-малан-цар	Бичил бул-цуу	1 дэх жил		Талбайн ургац					
					Супер-супер-элит		Супер-элит		Элит	
			Талбай /га/	Ургац /тн/	Талбай /га/	Ургац /тн/	Талбай /га/	Ургац /тн/	Талбай /га/	Ургац /тн/
2000	10000	40000	1.0	10.0	2.0	26.0	8.0	82.0	21.0	221.0
2001	15000	55000	1.5	18.0	3.0	39.0	8.0	88.0	22.0	287.0
2002	15000	55000	1.5	18.0	5.0	65.0	9.0	117.0	24.0	327.0
2003	15000	55000	1.5	18.0	5.0	65.0	16.0	192.0	29.0	332.0
2004	20000	60000	2.0	2.4	7.0	91.0	20.0	240.0	36.0	338.0
2005	20000	60000	2.0	2.4	7.0	91.0	20.0	240.0	36.0	360.0

Иймхүү тус хүрээлэнгийн биотехнологийн лабораторийн нь 2005 онд 360 тн эрүүл элит үрийн эх материал гаргахаар төлөвлөж байна.

7.8. Төмсний үрийг дараахь схемээр үйлдвэрлэнэ:

Төмсний үрийн аж ахуйн схем

Хуучин схем

Бүсийн эрдэм шинжилгээний байгууллага	
Жил-1	Сонголтын талбар
Жил-2	Клон үнэлгээний I жил
Жил-3	Клон үнэлгээний II жил
Жил-4	Супер-супер элит
Жил-5	Супер элит
Жил-6	Элит

Үрийн сангийн аж ахуйнууд	
Жил-7	I Репродукци
Жил-8	II Репродукци

Таваарын аж ахуйнууд

Шинэ схем

Дархан-Уул аймгийн УГТСЭШХ	
Жил-1	Хуруу шилэнд эрүүл ургамаланцар ургуулах
Жил-2	Зуны хүлэмжид бичил булцуу ургуулах
Жил-3	Супер-супер элит
Жил-4	Супер элит
Жил-5	Элит

Үр үржүүлгийн аж ахуй, иргэд	
Жил-6	I Репродукци
Жил-7	II Репродукци

Таваарын аж ахуйнууд

7.9. Хэрэгжүүлэх арга зам

а/Дарханы УГТСЭШХ-гийн биотехнологийн лабораторийн хүлэмжийн талбайг 1000м^2-аар нэмэгдүүлж, жилд 100 мянгаас доошгүй бичил булцуу гаргах боломжийг бий болгоно;

б/тариалангийн төв бүсийн хэрэгцээнд зориулан 360 тн эрүүл төмсний элит үртэй болохын тулд хүлэмжид ургуулсан бичил булцуут ердийн талбайд үринш-төмс-буудайн 3 эвлэгтэй сэлгээнд үржүүлэн элит үр гаргана;

в/тариалангийн төв бүсэд энэ 360 тн элит үрийн төмсийг 1-2 дугаар репродукцийн үр болтол үржүүлэх 7 аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж үрийн төрөлжсөн аж ахуй болгоно;

г/бүсад бүс нутагт үйлдвэрлэх элит үрийн төмсний бичил булцуут Дарханы УГТСЭШХ-гээс авч бүс нутгийн аж ахуйнууд үржүүлнэ. Төмсний элит үрийг тухайн жилд гэрээт аж ахуйнуудад өгч үржүүлэх бөгөөд 2 дугаар репродукциас цааш үржүүлэх үүргийг төмс тариалагчид өөрсдөө хариуцна.

7.10. Хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилт

Аж ахуйн нэгжийг сонгон шалгаруулж төмсний үрийн аж ахуйг шинэчлэн зохион байгуулах, 2004 он гэхэд улсын хэрэгцээт бүх элит, 1 дүгээр репродукцийн үрээр хангах боломжийг бүрдүүлэхэд нийтдээ 448.2 сая төгрөгийн нэмэлт хөрөнгө оруулалт шаардагдах бөгөөд үүнээс 397.5 сая төгрөг буюу 88.7 хувь нь аймаг, 50.68 сая төгрөг буюу 11.3

хувь нь төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллагуудад олгох хөрөнгө оруулалт байна.

Төмсний үрийн аж ахуйг шинэчлэн сэргээх зардлыг хүснэгтээр харуулбал:

Төмсний үрийн аж ахуйг шинэчлэн сэргээх хөтөлбөрийн зардлын товчоо

/сая төг/

Зардлын төрөл		УГТСЭШХ			Үрийн аж ахуй, фермерууд		
		Тоо	Нэгж үнэ /сая.төг/	Бүгд /сая.төг/	Тоо	Нэгж үнэ /сая.төг/	Бүгд /сая.төг/
А. Хөрөнгө оруулалтаар		-	-	**50.68**	-	-	-
Үүнд	Үрийн агуулах засвар	1	26.0	26.0	-	-	-
	Хүлэмжийн усалгааны төхөөрөмж	1	7.0	7.0	-	-	-
	Оношилгооны бодис Eliza test	1	17.68	17.68	-	-	-
Б. Зөвл		-	-	**101.7**	-	-	**295.8**
Үүнд	Дугуйт трактор	2	17.0	34.0	7	17.0	119.0
	Төмс үрлэгч	2	4.0	8.0	7	4.0	28.0
	Төмсний комбайн	2	15.0	30.0	7	15.0	105.0
	Төмс дугаарлагч	2	4.2	8.4	4	4.2	16.8
	Хор шүршигч	1	5.0	5.0	4	5.0	20.0
	Үр ариутгах бодис*		16.3	16.3	-	-	7.0
Бүгд				**448.18**			

Тайлбар: * *Ариутгалын болон бусад химийн бодис 2 дугаар хавсралтад буй*

7.11. "Үр" дэд хөтөлбөрийн төмсний үрийн аж ахуйн зорилтыг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө оруулалтыг доорхи эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

Зардлын эх үүсвэр

/сая төг/

Зардлын төрөл	Бүгд зардал	үүнээс эх үүсвэр хариуцагчид		
		ХХААЯ /КР-2 зар-цуулалтын сан/	ШУТ-ийн сан	Японы туслалжийн сан
Хөрөнгө оруулалт	50.68	15.0	15.0	20.68
Хөнгөлөлттэй зөвл	397.5	-	-	397.5
Бүгд	**448.18**	**15.0**	**15.0**	**418.18**

Төмсний үрийн аж ахуй эрхлэхээр сонгон шалгаруулалтад шалгарсан аж ахуйн нэгж, байгууллагуудад хүчин чадлаа бүрэн ашиглах боломж олгохын тулд уг санхүүжилтийг эхний 2 жилд багтаан олгоно.

Засгийн газрын 2001 оны 39 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

"УРИНШ - 2001" ТӨСӨЛ

Нэг. Төслийн үндэслэл

1. Буудайн үйлдвэрлэл сүүлийн 10 жил дараалан буурч дотоодын хэрэгцээнийхээ дөнгөж 30 хувийг хангах болсон гол шалтгааныг доорхи байдлаар тодорхойлж байна:

а/улсын зөвлөлөр санхүүжүүлж байсан аж ахуйнуудыг эргэлтийн хөрөнгийн нөөцгүйгээр зах зөвлд шилжүүлж, улмаар зөвлийн эх үүсвэрээр хангаагүйгээс тариалангийн ажлын (уриншбэлтгэх, тарих, хураах г.м.) технологийн горим алдагдсан;

б/зах зөвлийн тогтолцоонд нийцсэн үрийн аж ахуйн тогтолцоог бий болгож хэрэгжүүлөхгүйгээс элит, сортын үр үйлдвэрлэл бүрмөсөн зогсч чанар муутай үрөөр тариалж байгаа;

в/бордох, гербицид цацах зөөрөг ургац нэмэгдүүлэх арга хэмжээг орхигдуулсан;

г/хоцрогдож хуучирсан техник хэрэглэж байгаа;

д/шинээр бий болсон аж ахуйн удирдлагууд нь зах зөвлийн нөхцөлд аж ахуй эрхлэх чадвар муутай байгаа зөөрөг болно.

2. 1984, 1986, 1989, 1990 онуудад ган гачиг тохиолдож байсан боловч үр тарианы үлсын дундаж ургац 750-880 мянган тонноос буураагүй гол нөхцөл нь нийт тариалсан үр тарианы талбайн 80-85 хувь (400-420 мян.га) нь чанар сайтай уриншид тариалж байсантай холбоотой. Энэ нь чанар сайтай уриншид тариалалт хийвэл цаг үеийн нөхцөл таагүй жилд ч тогтвортой ургац авах боломжтой гэдгийг харуулж байна.

Хоёр. Төслийн зорилго

3. Төслийн зорилго нь 2001 онд сайнаас онцсайн үнэлгээтэй 270.0 мянган га-д уриншбэлтгэхэд оршино.

Гурав. Төслийн зорилт

4. Төслийн зорилт нь:

а/2004 он гэхэд буудайн үйлдвэрлэлийг 2000 оны түвшингээс 2-2.5 дахин

нэмэгдүүлэх Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх эхний алхам хийх;

б/цаашид тариаланчдыг бие даан үйлдвэрлэлээ явуулах нөхцөлийг бүрдүүлэх;

в/газар тариаланд хувийн болон гадаадын хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Дөрөв. Төслийг хэрэгжүүлэх арга зам

5. Тариалангийн гол бүс нутгуудад байгаль цаг уур, удирдлагын болон материаллаг бааз, санхүүгүйн чадавхи сайтай аж ахуйн нэгжүүдийг сонгон шалгаруулах замаар уг төсөлд хамруулж эргэлтийн хөрөнгийн туслалцаа үзүүлнэ.

6. Төсөл хэрэгжүүлэх нийт зардлын 73 хувь буюу 5.0 тэрбум төгрөгийг төсөлд оролцогч аж ахуйн нэгжүүд өөрийн хөрөнгөөр (техник, хүн хүч, цалин, даатгал гэх мэт) санхүүжүүлнэ.

7. Төсөлд оролцогч аж ахуйн нэгжүүдийн уринш боловсруулалтад шаардагдах зөвхөн шатахуун, гербицидийн үнийн 60 хувь буюу 2.0 тэрбум төгрөгийг Япон Улсын Засгийн газрын "Хүнсний хангамжийг нэмэгдүүлэх-KP-1" буцалтгүй тусламжийн бараа, бүтээгдэхүүний борлуулалтын орлогоос бий болсон сангийн хөрөнгөөс эргэж төлөгдөх нөхцөлөөр зээл олгоно.

8. Уринш боловсруулахад дэмжлэг үзүүлэх зорилгоор олгосон эргэлтийн хөрөнгийг 6-18 сарын хугацаанд эргүүлэн төлөх нь дараа жилийн үйлдвэрлэлээ өргөжүүлэх үндэс болно.

Тав. Төслийн зардал

9. Төслийн зорилгыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны зардлыг шаардагдах хэрэгсэл бүрээр нь авч үзвэл дараахь байдалтай байна:

Уриншийн 1 га-гийн дундаж болон 2000 онд шаардагдах нийт зардал

№	Зардлын төрөл	Механик элдэшүүлэг-тэй 257300 га уринш		Химийн аргаар бэлдэх 12700 га уринш		Бүгд зардал /сая төг/
		1га-гийн зардал /төг/	Нийт зардал /сая төг/	1 га-гийн зардал /төг/	Нийт зардал /сая төг/	
1	Шатахуун	11,808.0	3,038.2	4,920.0	62.5	3,100.7
2	Дизель масло	804.0	206.9	335.0	4.2	211.2
3	Автобензин	114.0	29.3	38.0	0.5	29.8
4	Раундап гербицид	-	-	13,750.0	174.6	174.6
5	Урсгал засвар	3,500.0	900.6	2,013.0	25.5	926.1
6	Цалин + шимтгэл	1,450.0	373.0	689.0	8.8	381.8
7	Нийгмийн даатгал	435.0	111.9	207.6	2.6	114.5
8	Бусад шууд зардал*	460	118.3	460.0	5.8	124.1
9	**Бүх шууд зардал**	**18,571.0**	**4,778.2**	**22,412.0**	**284.6**	**5,062.8**
10	Үндсэн хөрөнгийн элэгдэл	7,117.0	1,831.2	3,840.0	48.7	1879.9
11	Газрын төлбөр	386.0	99.3	386.0	4.9	104.2
12	**Бүгд шууд бус зардал**	**7,503.0**	**1,930.5**	**4,226.0**	**53.6**	**1,984.1**
13	Нийт зардлын дүн	**26,074.0**	**6,708.7**	**26,638.0**	**338.2**	**7,046.9**

Тайлбар: **Ажилчдын хоол, хөдөлмөр хамгааллын хувцас*

10. 2001 онд боловсруулах уриншийн хэмжээ, шаардагдах зардлыг үр тарианы үйлдвэрлэл бүхий аймаг бүрээр тодорхойлбол дараахь байдалтай байна:

2001 онд аймгуудын бэлдэх уриншийн хэмжээ, түүнд шаардагдах зардлын дүн

№	Аймаг	Нийт уриншлах талбай /мян.га/	Үүнээс				Нийт уриншийн зардал /сая төг/
			Механик аргаар боловсруулах уринш		Химийн аргаар боловсруулах уринш		
			Талбай /мян.га/	Зардал /сая төг/	Талбай /мян.га/	Зардал /сая төг/	
1	Архангай	2.5	2.5	65.2	-	-	**65.20**
2	Булган	30.0	28.0	730.0	2.0	53.3	**783.20**
3	Дорнод	8.0	7.5	195.6	0.5	13.32	**208.92**
4	Өвөрхангай	2.0	1.8	46.9	0.2	5.33	**52.22**
5	Сүхбаатар	1.5	1.5	39.11	-	-	**39.11**
6	Сэлэнгэ	125.0	120.0	3,128.9	5.0	133.2	**3,262.10**
7	Төв	57.0	55.0	1,434.0	2.0	53.3	**1,487.27**
8	Увс	5.5	5.0	130.4	0.5	13.32	**143.72**
9	Хөвсгөл	8.0	7.5	195.6	0.5	13.32	**208.92**
10	Хэнтий	14.0	13.0	339.0	1.0	26.64	**365.64**
11	Дархан-Уул	15.0	14.0	365.0	1.0	26.64	**391.64**
12	Орхон	1.5	1.5	39.1	-	-	**39.10**
	Бүгд	**270.0**	**257.3**	**6,708.7**	**12.7**	**338.37**	**7,046.90**

11. Уринш бэлтгэх аж ахуйн нэгжүүд өөрийн хөрөнгийг бүрэн ашиглаж эвхэн шатахуун, гербицидийн зардлын зохих хувьд нь эргэлтийн хөрөнгийн туслалцаа үзүүлэхээр тооцоолбол доорхи байдалтай байна:

Аймгуудад бэлдэх уриншид шаардагдах шатахуун, гербицидийн хэмжээ, зардал

№	Аймаг	Нийт уринш /мян.га/	Үүнээс										Нийт зардал /сая төг/
			Механик боловсруулалт				Химийн уринш						
			Уринш /мян.га/	Шаардагдах			Уринш /мян.га/	Шаардагдах					
				Дизель түлш /тн/	Тулш-ний үнэ /сая төг/			Хэмжээ /тн/		Үнэ /сая төг/			
								Дизель түлш	Гербицид	Дизель түлш	Гербицид	Бүгд	
1	Архангай	2.5	2.5	60.0	29.52		-	-	-	-	-	-	**29.52**
2	Булган	30.0	28.0	672.0	330.6		2.0	20.0	5.0	9.8	27.5	37.3	**361.2**
3	Дорнод	8.0	7.5	180.0	88.56		0.5	5.0	1.25	2.5	6.9	9.4	**97.96**
4	Өвөрхангай	2.0	1.8	43.2	21.25		0.2	2.0	0.5	0.98	2.75	3.73	**25.25**
5	Сүхбаатар	1.5	1.5	36.0	17.71		-	-	-	-	-	-	**17.71**
6	Сэлэнгэ	125.0	120.0	2880.0	1417.0		5.0	50.0	12.5	25.0	69.0	94.0	**1511.0**
7	Төв	57.0	55.0	1320.0	649.4		2.0	20.0	5.0	9.8	27.5	37.3	**686.7**
8	Увс	55.0	5.0	120.0	59.0		0.5	5.0	1.25	2.5	6.9	9.4	**68.4**
9	Ховсгөл	8.0	7.5	180.0	88.56		0.5	5.0	1.25	2.5	6.9	9.4	**97.96**
10	Хэнтий	14.0	13.0	312.0	153.5		1.0	10.0	2.5	4.9	13.8	18.72	**160.42**
11	Дархан-Уул	15.0	14.0	336.0	165.3		1.0	10.0	2.5	4.9	13.8	18.72	**184.02**
12	Орхон	1.5	1.5	36.0	17.71		-	-	-	-	-	-	**17.71**
	Бүгд	**270.0**	**257.3**	**6175.2**	**3038.2**		**12.7**	**127.0**	**31.75**	**62.5**	**175.05**	**237.97**	**3257.8**

Тайлбар: 1. Механик элдэншүүлгээр бэлдэх уриншийг 4 удаа боловсруулахад 1 га-д дунджаар 24.0 кг дизель түлш, 1.2 кг дизель масло орохоор, химийн уриншийн 1 га-д 10.0 кг шатахуун зарахаар,

2. 1 кг дизель түлшийг 492 төгрөг, дизель масло-г 670 төгрөгөөр,

3. *Раундап гербицидийн 1 кг-ын үнийг 5 ам.доллар буюу 5500 төгрөгөөр, түүнийг нэг га-д 2.5 кг-ыг цацахаар

4. Аймаг бүрийн уриншлах талбайн хэмжээг 2000 онд бэлдсэн уриншийн хэмжээг баримжаалан тооцсон.

Зургаа. Төслийн гол үр дүн

12. Сайн чанартай уринш бэлдсэнээр цаг уурын хэвийн нөхцөлд 2002 онд улсын дундаажаар 8.5-10 центнер/га буюу 244-288 мянган тонн буудай хураах боломж бүрдэх бөгөөд энэ нь 2000 он (137.0 мянган тонн)-оос 1.78- 2.1 дахин илүү болж, Засгийн газрын хөтөлбөрт заасан зорилтын хэрэгжилт 84 хувь болно.

13. Иймхүү ургац авснаар тариаланчдын өр зээл ихээхэн багасч цаашид бие даан үйлдвэрлэлээ эрхлэх боломжтой болно.

14. 2001 онд 270.0 га уриншийг шаардлагын дагуу бэлтгэснээр хог ургамлын өсөлт тархалтыг хязгаарлаж дараа жилүүдэд хог ургамалтай тэмцэх арга хэмжээний зардал 2-3 дахин буурч тариаланчийн үйлдвэрлэлийг хэвийн явуулах нөхцөл бүрдэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 2 дугаар сарын 26-ны өдөр | **Дугаар 40** | **Улаанбаатар хот**

Журам шинэчлэн батлах тухай

Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Үйлчилгээний хөлс, түүнийг захиран зарцуулах журам"-ыг хавсралт ёсоор шинэчлэн батлагдсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Засгийн газрын 1998 оны 1 дүгээр сарын 7-ны өдрийн 2 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД **Ц.НЯМДОРЖ**

Засгийн газрын 2001 оны 40 дүгээр тогтоолын хавсралт

ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХӨЛС, ТҮҮНИЙГ ЗАХИРАН ЗАРЦУУЛАХ ЖУРАМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1. Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газар /товчоо/-аас үзүүлэх үйлчилгээний төрөл, үйлчилгээний хөлсний хувь хэмжээ, түүнийг захиран зарцуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

2. Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлтэй холбоотой үйлчилгээний хөлсний хураамж /цашид "хөлс" гэх/-ийг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас өмчийн хэлбэрийг үл харгалзан хураана.

ХОЁР. Хөлс төлөх үйлчилгээний төрөл

3. Хөлсийг дараахь үйлчилгээнд авна:

а/төрөөс хувьчилсан орон сууц өмчлөх эрхийн гэрчилгээнд баталгаажуулах бичилт хийх;

б/үл хөдлөх эд хөрөнгийг анхны удаа бүртгэж, өмчлөх эрхийг баталгаажуулах;

в/үл хөдлөх эд хөрөнгө арилжих гэрээг бүртгэх;

г/үл хөдлөх эд хөрөнгө эзэмших, ашиглахтай холбогдсон түрээслэх, хөлслөх болон барьцаалах гэрээг бүртгэх;

д/үл хөдлөх эд хөрөнгийг бэлэглэх, худалдах, худалдан авах гэрээгээр бусдын өмчлөлд шилжүүлэхтэй холбогдсон гэрээг бүртгэх;

е/албадан дуудлага худалдаагаар худалдагдсан үл хөдлөх эд хөрөнгийг бүртгэх;

ж/шүүхийн шийдвэрээр өмчлөгч өөрчлөгдсөнийг бүртгэх;

з/үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд залруулга хийх, нэмэлт, өөрчлөлт оруулах /үнэ, хэмжээ өөрчлөх, барьцаалах, түрээслэх, хөлслөх гэрээг сунгах, цуцлах, дуусгавар болгох, гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хувь хүний өмчлөлөөс тухайн хүний өөрийнх нь аж ахуйн нэгжийн өмчлөлд шилжих, эсвэл тухайн аж ахуйн нэгжийн өмчлөлөөс тухайн хувь хүний өмчлөлд шилжих гэх мэт/;

и/үл хөдлөх эд хөрөнгө хамтран өмчлөгч нэмэгдэж, хасагдах тухай бүртгэх;

к/үл хөдлөх эд хөрөнгөтэй холбогдолтой гэрээслэлийг бүртгэх;

л/өв залгамжлагчийн болон өмчлөгчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд урьдчилсан тэмдэглэл хийх;

м/гэрээслэл болон өв залгамжлалаар үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгчийг өөрчлөх;

н/үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн талаар эрх бүхий этгээдэд лавлагаа өгөх;

о/үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлээс хуулбар хийх.

ГУРАВ. Хөлсний хэмжээ

4. Төрөөс хувьчилсан орон сууц өмчлөх эрхийн гэрчилгээнд баталгаажуулах бичилт хийхэд тухайн орон сууцны хувьчлагдсан суурь үнээс үл хамааран 2500 төгрөг байна.

5. Үл хөдлөх эд хөрөнгийг анхны удаа бүртгэж, өмчлөх эрхийг баталгаажуулахад дараахь хөлс авна:

Бүртгүүлэх хөрөнгийн үнэлгээ /төг/	Хөлс /төг/
0– 10 000 000	3000
10 000 001 – 100 000 000	10 000
100 000 001–ээс дээш	20 000

6. Үл хөдлөх эд хөрөнгө арилжих гэрээг бүртгэхэд дараахь хөлс авна:

Хөрөнгийн үнэ /төг/	Хөлс /төг/
0– 10 000 000	4000
10 000 001 – 100 000 000	13 000
100 000 001–ээс дээш	25 000

7. Үл хөдлөх эд хөрөнгө эзэмших, ашиглахтай холбогдсон түрээслэх, хөлслөх, барьцааны гэрээг бүртгэхэд дараахь хөлс авна:

Хөрөнгийн үнэ /төг/	Хөлс /төг/
0– 10 000 000	5000
10 000 001 – 100 000 000	18 000
100 000 001-ээс дээш	35 000

8. Үл хөдлөх эд хөрөнгийг бэлэглэх, худалдах, худалдан авах гэрээгээр бусдын өмчлөлд шилжүүлэхтэй холбогдсон гэрээг бүртгэхэд дараахь хөлс авна:

Хөрөнгийн үнэ /төг/	Хөлс /төг/
0– 10 000 000	8000
10 000 001 – 100 000 000	25 000
100 000 001-ээс дээш	60 000

9. Үл хөдлөх эд хөрөнгийг албадан дуудлага худалдаагаар худалдахад үл хөдлөх эд хөрөнгийн худалдагдсан үнэнээс дараахь хөлс авна:

Хөрөнгийн үнэ / төг /	Хөлс /төг/
0– 10 000 000	5000
10 000 001 – 100 000 000	10 000
100 000 001-ээс дээш	20 000

10. Шүүхийн шийдвэрээр өмчлөгч өөрчлөгдсөн тухай бүртгэхэд 5000 төгрөг байна.

11. Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлд залруулга хийх, нэмэлт, өөрчлөлт оруулах /үнэ, хэмжээ, хувь хүний өмчлөлөөс тухайн хүний өөрийнх нь аж ахуйн нэгжийн өмчлөлд шилжих,

эсвэл тухайн аж ахуйн нэгжийн өмчлөлөөс тухайн хувь хүний өмчлөлд шилжих гэх мэт/-д 5000 төгрөг байна.

12. Үл хөдлөх эд хөрөнгө эзэмших, ашиглах болон бусдын өмчлөлд шилжүүлэхтэй холбогдон гэрээ, барьцааны гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах, гэрээг сунгах, цуцлах, дуусгавар болсныг буртгэхэд 3000 төгрөг байна.

13. Үл хөдлөх эд хөрөнгө хамтран өмчлөгч гишүүд нэмэгдэж, хасагдсаныг бүртгэхэд гишүүн тус бүр 3000 төгрөг байна.

14. Үл хөдлөх эд хөрөнгөтэй холбогдолтой гэрээслэл, өв залгамжлагчийн тухай болон өмчлөгчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор урьдчилсан тэмдэглэлийг бүртгэхэд 3000 төгрөг байна.

15. Гэрээслэл болон өв залгамжлалаар үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгчийг өөрчлөхөд 5000 төгрөг байна.

16. Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн талаар тухайн үл хөдлөх эд хөрөнгийн өмчлөгч / хамтран өмчлөгч/-ийн эвлэсөөрөлтэйгээр лавлагаа өгөхэд 5000 төгрөг байна.

17. Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлээс хуулбар хийхэд хуудас бүрээс 1000 төгрөг байна.

18. Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн мэдүүлгийн хуудасны үнэ 100 төгрөг, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн гэрчилгээний үнэ 5000 төгрөг, бүртгэлийн дэвтрийн үнэ 1000 төгрөг байна.

19. Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагад лавлагааг үнэ төлбөргүй гаргаж өгнө.

20. Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газар нь Монгол банкинд зээлийн барьцааны гэрээнийн бүртгэлийн талаархи мэдээллийг улирал бүрийн сүүлчийн сарын 25-30-ны хооронд, мөн иргэд, хуулийн этгээдийн үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлого /2%/ -оос улсад оруулсан албан татварын хэмжээ болон үл хөдлөх эд хөрөнгө өмчлөгч иргэд, хуулийн этгээдийн нэр, үл хөдлөх эд хөрөнгийн байршлын хаяг, гэрчилгээнд бичигдсэн үнэлгээний талаархи мэдээллийг тухайн жилээр гаргаж, дүнг дараа жилийн 1 дүгээр сарын 31-ний дотор Үндэсний татварын ерөнхий газарт тус тус үнэ төлбөргүй гаргаж өгнө.

ДӨРӨВ. Иргэдэд яаралтай үйлчилгээ үзүүлсний хөлсний хувь, хэмжээ

21. Баримт бичгийн бүрдэл нь бүртгэлийн шаардлага хангасан тохиолдолд үйлчлүүлэгчийн хүсэлтээр яаралтай үйлчилгээ үзүүлж болно.

22. Яаралтай үйлчилгээг ажлын 8 цагт багтаах бөгөөд энэ журмын 3 дугаар хэсэгт заасан хөлсний хувь, хэмжээг 2 дахин нэмэгдүүлж хураана.

ТАВ. Үйлчилгээний хөлсийг захиран зарцуулах

23. Үйлчилгээ үзүүлснээс орох орлогыг Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн газар /товчоо/-ын үйл ажиллагааны тухайн жилийн батлагдсан төсвийг санхүүжүүлэх болон улсын төсөв бүрдүүлэхэд зарцуулна.

24. Үйлчилгээ үзүүлснээс орох орлого, зарлагыг зохих журмын дагуу тайлагнана.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 2 дугаар сарын 26-ны өдөр Дугаар 41 **Улаанбаатар хот**

Заавар шинэчлэн батлах тухай

Архивын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх заавар"-ыг хавсралт ёсоор шинэчлэн батлуулсугай.

2. Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудасны хэв загварыг 2001 оны 7 дугаар сарын 1-нээс эхлэн энэхүү зааврын дагуу мөрдүүлэхийг Цагдаагийн ерөнхий газар, Үндэсний архивын газар болон аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хууль зүйн хэлтэст даалгасугай.

3.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан Засгийн газрын "Заавар батлах тухай" 1993 оны 1 дүгээр сарын 23-ны өдрийн 13 дугаар тогтоол, "Зааварт нэмэлт оруулах тухай" мөн оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 69 дүгээр тогтоол, "Зааврын зарим заалтыг өөрчлөн найруулах тухай" мөн оны 5 дугаар сарын 8-ны өдрийн 79 дүгээр тогтоол, "Зааварт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" мөн оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 113 дугаар тогтоол, "Зааварт өөрчлөлт оруулах тухай" 1994 оны 6 дугаар сарын 22-ны өдрийн 116 дугаар тогтоол, "Зааварт нэмэлт, өөрчлөлт оруулах тухай" мөн оны 8 дугаар сарын 12-ны өдрийн 141 дүгээр тогтоол, "Тогтоолын заалтад нэмэлт оруулах тухай" 1996 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн 309 дүгээр тогтоол, "Зааварт нэмэлт оруулах тухай" 1997 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн 157 дугаар тогтоол, "Зааварт нэмэлт оруулах тухай" мөн оны 8 дугаар сарын 13-ны өдрийн 172 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД Ц.НЯМДОРЖ

Засгийн газрын 2001 оны 41 дүгээр тогтоолын хавсралт

ТАМГА, ТЭМДЭГ, БАТАЛГААНЫ ТЭМДЭГ, ХЭВЛЭМЭЛ ХУУДАС ХИЙЛГЭХ, ХЭРЭГЛЭХ ЗААВАР

Нэг.Нийтлэг үндэслэл

1. Төрийн болон бусад байгууллага, хуулийн этгээд тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх, хэрэглэх журмыг энэ зааврааар зохицуулна.

2. Дор дурдсан төрийн байгууллага, албан тушаалтан тамга хэрэглэнэ:

а/Монгол Улсын Ерөнхийлөгч;

б/Монгол Улсын Их Хурал;

в/ Монгол Улсын Засгийн газар;

г/Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар;

д/Монгол Улсын яам, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, түүнчлэн үйл ажиллагаа нь Монгол Улсын хууль, Засгийн газрын шийдвэрээр тодорхойлогддог төрийн байгууллага;

е/аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон баг, хорооны Иргэдийн Нийтийн Хурал;

ж/бүх шатны Засаг дарга, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар;

з/шүүх, прокурор, цагдаагийн төв болон орон нутгийн байгууллага;

и/Монгол Улсын хилийн чанадад ажиллаж байгаа дипломат төлөөлөгчийн газар, өргөмжит консул;

к/Төрийн архив, нотариат, шүүхийн шийдвэр биелүүлэх болон үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн байгууллага.

3. Тамга нь төрийн тамга, төрийн байгууллагын тамга гэсэн хоёр төрөлтэй байна.

Төрийн тамга түүнтэй холбоотой асуудлыг "Төрийн бэлгэ тэмдгийн тухай хууль"-иар зохицуулна.

4. Төрийн байгууллагын тамга, тэмдэг нь дөрвөлжин хэлбэртэй, түүн дээрх бичээс нь дармал монгол үсгээр бичигдсэн байна. Тамганд сөөмбыг дүрслэхдээ Үндсэн хуульд хавсаргасан нэгж хэмжээсийг чанд баримтална.

5. Энэ зааврын 2-т заасан байгууллага нь албан хэрэгтээ тамганы зэрэгцээ тэмдэг хэрэглэж болно. Тэмдэг нь тухайн байгууллагын тамгатай ижил хэмжээтэй байна.

Төрийн бус бусад байгууллага, хуулийн этгээд тэмдэг хэрэглэнэ.

6. Тамга, тэмдэг, хэвлэмэл хуудсыг бусад байгууллага хуулбарлан хэрэглэхийг хориглоно.

7. Тамга, тэмдгийг албан тушаалын нэрийн эхний үсгүүдийг оруулан бүтэн, тэгш, тод дарна.

8. Санхүүгийн болон банкны баримт бичгийн тусгайлан заасан хэсэгт энэ зааврын 2-т заасан байгууллага нь тамга, бусад байгууллага тэмдэг дарна.

9. Тусгайлан заагаагүй бол албан бичгийн гадаадад явуулах хувь дээр тамга, тэмдэг дарахгүй.

10. Хэвлэмэл хуудас нь зориулалтын хувьд албан бичгийн, захирамжлалын гэсэн 2 төрөлтэй байна.

Албан бичгийн хэвлэмэл хуудас нь байгууллага, албан тушаалтны гэсэн 2 нэр төрөлтэй байна.

11. Байгууллага, албан тушаалтны албан бичгийн хэвлэмэл хуудсанд байгууллага / зохион байгуулалтын нэгж/ болон албан тушаалын нэр, хаяг, байгууллагын регистрийн дугаар, шуудангийн индекс, харилцах утас /факс, электрон шуудан/, огноо, дугаарыг бичсэн байна.

12. Захирамжлалын баримт бичгийн хэвлэмэл хуудсанд байгууллага, албан тушаалын нэр, баримт бичгийн нэр, огноо, дугаар, байгууллагын байрлаж буй газар, хотын нэрийг бичсэн байна.

Монгол Улсын хуулийн хэвлэмэл хуудас нь Төрийн сүлд, огноо, Төрийн ордон, Улаанбаатар хот гэсэн бүрдэлтэй байна.

13. Хэвлэмэл хуудсыг А4 /210х297мм/, А5 /148х210мм/ хэмжээтэй сайн чанарын цаасан /80 гр/ дээр стандартын дагуу хэвлэлийн аргаар бэлтгэнэ. Ажлын шаардлагын үүднээс А3 /297х420мм/ хэмжээтэй цаасыг хэвлэмэл хуудсанд хэрэглэж болно.

14. Хэвлэмэл хуудасны бүрдлүүд, түүнд дүрсэлсэн сүлд, соёмбыг хөх буюу хар өнгөөр стандартын дагуу үйлдэнэ.

Сүлд, соёмбыг дүрслэхдээ Үндсэн хуулийн хавсралтад заасан сүлдний тэг харьцаа, соёмбоны нэгж хэмжээсийг чанд баримтална.

15. Архивын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан төрийн архивын сан үүсгэгч төрийн байгууллагуудын хэвлэмэл хуудасны эх загварыг Үндэсний архивын газар гаргана.

Хоёр. Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудас хийлгэх

16. Төрийн байгууллага, Иргэдийн Төлөөлөгчдийн болон Иргэдийн Нийтийн Хурлын тамга, тэмдэгний дардасны хэсгийг резинээр хийсэн байх бөгөөд дор дурдсан хэмжээ, бичээстэй байна:

а/ Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газрын тамга нь 5,5х5,5х2,0 см-ийн хэмжээтэй, тэв хэсэгт нь соёмбо байрлуулсан, түүний баруун талд нь "Монгол Улсын", зүүн талд "Ерөнхийлөгч", "Их хурал", "Засгийн газар" гэсэн бичээс тус тус бичигдсэн байна;

б/ Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын Тамгын газар болон Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тамга нь 5,0х5,0х1,0 см-ийн хэмжээтэй, тэв хэсэгт нь соёмбо байрлуулсан, түүний баруун талд нь "Монгол Улсын Их Хурлын", "Монгол Улсын Ерөнхийлөгчийн", "Монгол Улсын Засгийн газрын" гэсэн бичээс, зүүн талд нь "Тамгын газар", "Хэрэг эрхлэх газар" гэсэн бичээс тус тус бичигдсэн байна;

в/ яам, түүнчлэн үйл ажиллагаа нь хуулиар буюу Засгийн газрын шийдвэрээр тодорхойлогдог төрийн байгууллага, Монгол Улсаас хилийн чанадад ажиллаж байгаа дипломат төлөөлөгчийн газар, өргөмжит консул болон шүүх, прокурор, цагдаагийн төв байгууллагуудын тамга нь 5,0х5,0х1,0 см хэмжээтэй, тэв хэсэгт нь соёмбо байрлуулсан, баруун талд нь "Монгол Улсын" гэсэн бичээс, зүүн талд нь тухайн байгууллагын нэр бичигдсэн байна;

г/ аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тамга нь 5,0х5,0х1,0 см хэмжээтэй, тэв хэсэгт нь соёмбо байрлуулсан ба түүний хоёр талаар "...аймаг /нийслэл/-ийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал" гэсэн бичээс тэгш байрлалтай бичигдсэн байна;

д/ аймаг, нийслэлийн Засаг даргын тамга нь 5,0х5,0х1,0 см хэмжээтэй, тэв хэсэгт нь соёмбо байрлуулсан, баруун талдаа "Монгол Улсын", зүүн талдаа "...аймаг /нийслэл/-ийн Засаг дарга" гэж бичигдсэн байна;

е/ Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагийн тамга нь 4,5х4,5х1,0 см хэмжээтэй, тэв хэсэгт нь соёмбо байрлуулсан, баруун талд нь "Монгол Улсын Засгийн газрын тохируулагч /хэрэгжүүлэгч/ агентлаг" гэсэн бичээс, зүүн талд нь тухайн агентлагийн нэр бичигдсэн байна;

ж/ шүүх, прокурор, цагдаагийн орон нутгийн байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын Тамгын газрын тамга нь 4,5х4,5х1,0 см хэмжээтэй, тэв хэсэгт нь соёмбо байрлуулсан, түүний баруун талд нутаг дэвсгэрт нь орших байгаа засаг захиргааны нэгжийн нэр, зүүн талд нь үг байгууллагын нэрийг бичсэн байна;

з/ сум, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тамга нь 4,5х4,5х1,0 см хэмжээтэй, тэв хэсэгт нь соёмбо байрлуулсан, түүний хоёр талаар "аймаг /нийслэл/-ийн ...сум / дүүрэг/-ын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал" гэсэн бичээс тэгш байрлалтай бичигдсэн байна;

и/ сум, дүүргийн Засаг дарга, хотын захирагчийн тамга нь 4,5 х 4,5 х 1,0 см хэмжээтэй, тэв хэсэгт нь соёмбо байрлуулсан, түүний хоёр талаар "аймаг /нийслэл/ -ийн ... сум /дүүрэг/ -ын Засаг дарга", хотын захирагчийн тамга нь " ... хотын захирагч" гэсэн бичээс тэгш байрлалтай бичигдсэн байна;

к/ баг, хорооны Засаг дарга, Иргэдийн Нийтийн Хурлын тамга, тосгоны захирагч, нотариатч, үл хөдлөх эд хөрөнгийн байгууллага, аймгийн архивын тасгийн тамга нь 4,0х4,0х1,0 см хэмжээтэй, түүний тэв хэсэгт соёмбо байрлуулсан байна.

Баг, хорооны Засаг даргын тамганд "... сум /дүүрэг/-ын ... дугаар баг /хороо/-ийн Засаг дарга", Иргэдийн Нийтийн Хурлын тамганд "... сум / дүүрэг/-ын ... дугаар баг /хороо/-ийн Иргэдийн Нийтийн Хурал" гэсэн бичээс соёмбоны хоёр талаар тэгш байрлалтай бичигдсэн байна.

Нотариатчийн тамга нь соёмбоны баруун талд "Нотариатч", зүүн талд "дугаар..." гэж, үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн байгууллагын тамга нь соёмбоны 2 талаар "Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн байгууллага" гэсэн бичээсийг тэгш байрлуулсан, аймгийн архивын тасгийн тамга нь соёмбоны баруун талд "...аймгийн" гэсэн, зүүн талд "архивын тасаг" гэсэн бичээс тус тус бичигдсэн байна.

17. Монгол Улсын хилийн чанадад ажиллаж байгаа дипломат төлөөлөгчийн газар нь төв хэсэгтээ соёмбо байрлуулсан, түүний баруун талд "Монгол Улсын", зүүн талд нь "Гадаад хэргийн яамны Консулын газар"; "Элчин сайдын яам"; "Байнгын төлөөлөгчийн газар"; "Ерөнхий Консулын газар" гэсэн нэр тус тус бичигдсэн 2,0х2,0 см-ийн хэмжээтэй дөрвөлжин дардас бүхий тамгатай байж болно.

Энэ тамгыг зөвхөн гадаадын иргэд тус улсад зорчих виз, зөвшөөрөл олгоход паспорт дээр дарахад хэрэглэнэ.

18. Тамга хийлгэх зөвшөөрлийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, тэмдэг, баталгааны тэмдэг хийлгэх зөвшөөрлийг цагдаагийн байгууллага олгоно.

19. Тэмдэг хийлгэхдээ тухайн байгууллагын шийдвэр, улсын бүртгэлийн гэрчилгээ, захиалга болон загварыг аймаг, хотын цагдаагийн байгууллагад өгч хянуулан, хийлгэх хугацааг тохиролцоно.

20. Иргэд баталгааны тэмдэг хэрэглэж болно.

Баталгааны тэмдэгт иргэний эцгийн болон өөрийн нэр, регистрийн дугаар, цагдаагийн байгууллагаас олгосон регистрийн дугаарыг бичсэн байна.

21. Иргэд баталгааны тэмдгийг хийлгэхдээ өргөдөл, иргэний үнэмлэхээ аймаг, хотын цагдаагийн байгууллагад өгч хянуулан, хийлгэх хугацааг тохиролцоно.

22. Тамга, тэмдэг, баталгааны тэмдгийг захиалгын дагуу цагдаагийн байгууллага хийж бүртгэн, дардсыг авч захиалагчид олгоно.

23. Төрийн байгууллагын тэмдэгт тухайн байгууллагын харьяалал, зохион байгуулалтын нэгжийн нэр бичигдсэн байна. Бусад байгууллага, аж ахуйн нэгжийн тэмдэгт түүний харьяалал, оноосон нэр, өмчийн хариуцлагын ялгаа, цагдаагийн байгууллагаас олгосон регистрийн болон улсын бүртгэлийн дугаарыг бичсэн байна.

24. Төрийн бэлгэ тэмдгийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 9-д заасан байгууллагуудын хэвлэмэл хуудас сулдтэй, бусад тамга хэрэглэх эрх бүхий төрийн байгууллагын хэвлэмэл хуудас соёмботой байна.

25. Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоолын хэвлэмэл хуудсанд Төрийн сүлдийг голлон байрлуулах ба "Төрийн бэлгэ тэмдгийн тухай хууль"-ийн 5 дугаар зүйлийн 2-т заасан өнгөөр хэвлэнэ. Сүлдний хэмжээ нь 30х35мм байна.

26. Аж ахуйн нэгж, бусад хуулийн этгээд хэвлэмэл хуудсанд өөрийн байгуллагын билэгдэл тэмдэг хэрэглэж болно.

27. Дор дурдсан байгууллагын хэвлэмэл хуудсыг Засгийн газрын хэвлэх үйлдвэрт хэвлэнэ:

а/Монгол Улсын Ерөнхийлөгч;

б/Монгол Улсын Их Хурал;

в/Монгол Улсын Засгийн газар;

г/Үндэсний аюулгүй байдлын зөвлөл;

д/Үндсэн хуулийн цэц;

е/Ерөнхийлөгчийн болон Улсын Их Хурлын Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар.

28. Яамд, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг болон үйл ажиллагаа нь Монгол Улсын хуулиар тодорхойлогдсон төрийн байгууллагын хэвлэмэл хуудсыг Үндэсний архивын газарт нэгдсэн журмаар хэвлэнэ.

29. Аймаг, нийслэлийн төрийн захиргааны байгууллагын хэрэглэх хэвлэмэл хуудсыг стандартын дагуу хэвлүүлэх зөвшөөрлийг орон нутгийн архив, албан хэрэг хөтлөлтийн улсын байцаагч олгоно.

30. Монгол Улсын хилийн чанадад ажиллаж байгаа дипломат төлөөлөгчийн газар, өргөмжит консул нь хэвлэмэл хуудсаа гадаадад хэвлүүлж болно.

Гадаадад хэвлүүлэх хэвлэмэл хуудасны эх загварыг Үндэсний архивын газарт хянуулж зөвшөөрөл авна.

Гурав. Тамга, тэмдэг, хэвлэмэл хуудас хэрэглэх

31. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газрын тамгыг Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга болон дэд дарга, Ерөнхий сайдын

гарын үсэг зурсан баримт бичигт дарна.

Монгол Улсын сайд нь Засгийн газрын гишүүний хувьд өөрийн эрхлэх асуудлын хүрээнд Ерөнхийлөгч болон Улсын Их Хуралд Засгийн газрын өмнөөс санал оруулах, албан бичиг явуулахад Засгийн газрын хэвлэмэл хуудас, тамгыг хэрэглэнэ.

32. Яам, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, түүнчлэн үйл ажиллагаа нь хуулиар буюу Засгийн газрын шийдвэрээр тодорхойлогдсон төрийн байгууллага, Монгол Улсын хилийн чанадад ажиллаж байгаа дипломат төлөөлөгчийн газрын тамгыг сайд, дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга, дарга, дэд дарга; тэмдгийг газар, хэлтэс, тасаг, албаны дарга, түүнтэй адилтгах албан тушаалтны гарын үсэг зурсан баримт бичиг дээр дарна.

33. Бүх шатны Засаг даргын тамга, тэмдгийг Засаг дарга, тэдгээрийн орлогч, хот, тосгоны захирагчийн тамга, тэмдгийг хот, тосгоны захирагч, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тамгыг Хурлын дарга, Хурлын Тэргүүлэгчдийн дарга, Нарийн бичгийн дарга, Иргэдийн Нийтийн Хурлын тамгыг Хурлын Тэргүүлэгчдийн даргын гарын үсэг зурсан баримт бичиг дээр дарна.

34. Зохион байгуулалт захирамжлалын баримт бичгийн хуулбарыг баталгаажуулж тэмдэг дарна.

35. Гадаад хэргийн яам, Монгол Улсын хилийн чанадад ажиллаж байгаа дипломат төлөөлөгчийн газар нь ноот, санамж бичиг, солилцсон захидлыг ноот бичгийн цаасан дээр бичиж бөгөөд тамга дарахгүй.

Төрийн тэргүүн, Гадаад хэргийн сайдаас гадаадад явуулах илгээлтэд тусгай хэвлэмэл хуудас хэрэглэх буюу түүн дээр тамга дарахгүй.

Дөрөв. Тамга, тэмдэг, баталгааны тэмдэг, хэвлэмэл хуудасны хадгалалт, хамгаалалт, бүртгэх тооцоо

36. Тамга, тэмдэг, хэвлэмэл хуудсыг ажлын байранд бөх бат саванд хадгална.

37. Тамга, тэмдгээ түшин болон хэвлэмэл хуудсыг хариуцах хүнийг байгууллагын удирдлага томилно.

38. Байгууллага нь бүх төрлийн хэвлэмэл хуудсыг нэр төрлөөр нь ангилж, хэвлэмэл хуудасны барүун доод өнцөг /дороосоо 10мм-ийн зайтай/-т тус бүрийн дугаарыг тусгай дугаарлагчаар дугаарлана.

39.Гэмтэлтэй буюу анхны загвараас дардас нь зөрүүтэй тамга, тэмдэг ашиглахыг хориглох бөгөөд ийм тамга, тэмдгийг цагдаагийн байгууллагад хураалгаж шинээр хийлгэнэ.

40.Тамга, тэмдэг алдагдвал цагдаагийн байгууллагад нэн даруй мэдэгдэж харьяа болон харьцдаг байгууллагадаа уг тамга, тэмдэг, баталгааны тэмдэг хүчингүй болсныг зарлана.

Алдагдсан тамга, тэмдэг, баталгааны тэмдэг олдвол түүнийг дахин хэрэглэхгүй.

41. Тамга, тэмдэг, баталгааны тэмдгийн ашиглалтад цагдаагийн байгууллага, хэвлэмэл хуудсыг хийлгэх, хэрэглэх асуудалд Үндэсний архивын газар тус тус хяналт тавина.

42. Энэ заавар нь Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа иргэд, байгууллага, гадаадын хөрөнгө оруулалттай байгууллага, гадаадын иргэд, харьяалалгүй хүмүүст нэгэн адил хамаарна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 3 дугаар сарын 1-ний өдөр **Дугаар 42** **Улаанбаатар хот**

Гоц халдварт өвчний цагийн байдалтай уялдуулан авах зарим арга хэмжээний тухай

Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Иргэний хамгаалалтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3,6 дахь хэсэг, Засгийн газрын 1994 оны 170 дугаар тогтоолоор батлагдсан "Иргэний хамгаалалтын бэлэн байдлын зэрэг, тэдгээрт шилжих журам"-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хэнтий аймгийн Норовлин сумын зарим нутаг дэвсгэрт малын гоц халдварт өвчний шинж тэмдэг илэрсэнтэй холбогдуулан тус аймгийн төрийн захиргааны бүх шатны байгууллага, иргэний хамгаалалтын албад, холбогдох аж ахуйн нэгжүүдийг 2001 оны 3 дугаар сарын 1-нээс эхлэн иргэний хамгаалалтын бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, Норовлин, Дадал, Баян-Овоо, Баян-Адрага, Батноров сумын нутаг дэвсгэрт хорио цээрийн онцгой дэглэм, бусад сумын нутаг дэвсгэрт

хорио цээрийн хязгаарлалтын дэглэм тогтоосугай.

Үүнтэй холбогдуулан төрийн захиргааны бүх шатны байгууллага, иргэний хамгаалалтын штаб, мэргэжлийн анги, холбогдох аж ахуйн нэгжүүдийг зохих журам, удирдамжийн дагуу бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, тэдгээрийн бэлэн байдлыг хангуулах арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг Хэнтий аймгийн Засаг дарга Ч.Эрдэнэбаатарт даалгасугай.

2. Хэнтий, Дорнод, Сүхбаатар аймгийн Засаг дарга Ч.Эрдэнэбаатар, Д.Одбаяр, Т.Дашсүрэн нарт даалгах нь:

а/иргэний хамгаалалтын бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт болон хорио цээрийн дэглэм тогтоосон хугацаанд сум, аймаг, багийн хилийн дотор аймгийн байнгын онцгой комиссоос зөвшөөрөгдсөнээс бусад тээврийн хэрэгсэл, хүн, малын шилжилт, хөдөлгөөнийг зогсоон журамлах арга хэмжээ авсугай;

б/аймаг хооронд болон аймаг, сумын нутаг дэвсгэрт зөвшөөрөгдсөнөөс бусад хөдөлгөөнд хязгаарлалт тавьж, зөрчил гаргасан гэм буруутай этгээдүүдэд хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэж байсугай;

в/малын гоц халдварт өвчний халдварын голомт, тархалтыг тогтоох, устгах, уг өвчин халдварлан тархахаас урьдчилан сэргийлэх завсрын тусгаарлах бүс бий болгох арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлсүгэй;

г/хууль, хяналтын байгууллагын оролцоотойгоор аймаг, сум бүрийн нутаг дэвсгэрт байгаа бүх төрлийн тээврийн хэрэгслийг бүртгэлтэй болгож, тэдний хөдөлгөөнд байнга хяналт тавьж ажилласугай;

д/халдварын голомт дахь үхсэн болон устасан малыг холбогдох дүрэм, журам, шаардлагын дагуу тухайн газарт нь дарж булах, ариутган халдваргүйжүүлэх арга хэмжээ авч байсугай.

3. Халдварын голомт, түүний орчны бүс нутагт хийгдэж байгаа ариутгал, халдваргүйжүүлэлтийг баталгаатай болгох нөхцөлийг бүрдүүлэхтэй холбогдсон арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх, зохих техник хэрэгслээр тоноглосон ариутгалын цэгийн тоог олшруулах арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргалд даалгасугай.

4. Хорио цээрийн онцгой дэглэм тогтоосон Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймагт харуул, хамгаалалтын хүч хэрэгслийг нэмэгдүүлэх, хорио цээрийн дэглэм зөрчсөн иргэд, ийм зөрчил гаргахад нөлөөлсөн, зөвшөөрөл олгосон, мөн хариуцлага алдсан албан тушаалтныг илрүүлэн зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцох, цаашид энэ дутагдал давтан гарахаас сэргийлэх арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтанд даалгасугай.

5. Орон нутагт ажиллаж байгаа хээрийн штабын ажилтан, мэргэжилтний хариуцлага, ажлын шаардлагыг дээшлүүлэх, дутагдал, зөрчил гаргасан хүмүүстэй хариуцлага тооцохыг Батлан хамгаалахын сайд, Улсын байнгын онцгой комиссын дарга Ж.Гүррагчаа, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, Сүхбаатар, Дорнод, Хэнтий аймгийн Засаг дарга Т.Дашсүрэн, Д.Одбаяр, Ч.Эрдэнэбаатар нарт үүрэг болгосугай.

6. Малын гоц халдварт өвчний халдвар тархахаас урьдчилан сэргийлэх зорилгоор ясли, цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуулийн хичээлийн хугацаа, түүнчлэн хурал цуглаан, уулзалт, үзвэр, үйлчилгээ зэрэг нийтийг хамарсан бусад арга хэмжээг хорио цээрийн дэглэмтэй уялдуулан, Улсын байнгын онцгой комисстой зөвшилцөн зохицуулж байхыг Сүхбаатар, Дорнод, Хэнтий аймгийн Засаг дарга Т.Дашсүрэн, Д.Одбаяр, Ч.Эрдэнэбаатар нарт зөвшөөрсүгэй.

7. Нийслэл болон бусад газарт суралцдаг бөгөөд Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгийн нутаг дэвсгэрт амарч буй оюутан, суралцагчдыг хорио цээрийн тухайн бүсээс гаргахгүй байлгахаар зохицуулах, тэдний тасарсан хичээлийг нөхүүлэх асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэх арга хэмжээ авахыг Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжидад даалгасугай.

8. Нийслэлд орж байгаа бүх төрлийн авто тээврийн хэрэгсэл, зорчигчдод тавих хяналтыг чангатгах, нийслэлээс мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн авто тээврийн хэрэгслээр гаргахыг таслан зогсоох бүх талын арга хэмжээ авахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын

захирагч М.Энхболдод даалгасугай.

9. Нийт мал сүрэгтээ 2001 оны 3 дугаар сарын 15-ны дотор малын гоц халдварт өвчнөөс сэргийлэх үзлэг явуулж дүнгээ Засгийн газарт ирүүлэх, шинж тэмдэг илэрсэн тухайд мэдээллийг зохих байгууллагад шуурхай хүргэхийг Сүхбаатар, Дорнод, Хэнтийгээс бусад бүх аймгийн Засаг дарга нар болон нийслэлийн Засаг даргад үүрэг болгосугай.

10. Малын гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийг зөвхөн ариутгал, халдваргүйжүүлэлт хийсний үндсэн дээр төмөр замын тээвэрээр тээвэрлэн улсын хил нэвтрүүлэн гаргаж байх журам тогтоон хэрэгжүүлэхийг Улаанбаатар төмөр замын хэрэг эрхлэх газрын дарга Р.Рааш, Улсын гаалийн ерөнхий газрын дарга Х.Баатар, Хилийн цэргийг удирдах газрын дарга П.Сүндэв болон мал эмнэлэг, ариун цэврийн хяналтын байгууллагын эрх баригчдад даалгасугай.

11. Мал аж ахуйн гаралтай бүтээгдэхүүн, түүхий эдийг аймаг дамжуулан тээвэрлэж хил нэвтрүүлэхээс сэргийлэх арга хэмжээ авч, хяналтыг чангатгахыг Төв, Өмнөговь, Говь-Алтай, Ховд аймгийн Засаг дарга нар болон Улсын гаалийн ерөнхий газрын дарга Х.Баатар, Хилийн цэргийг удирдах газрын дарга П.Сүндэв нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД Ж.ГҮРРАГЧАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 3 дугаар сарын 13-ны өдөр Дугаар 44 **Улаанбаатар хот**

Тогтоолд нэмэлт оруулах тухай

Төмөр боловсруулах үйлдвэрийн техникийн аюулгүй ажиллагаа, технологи, бүтээгдэхүүний чанарт тавих шаардлагыг чангатгах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1995 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 100 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын "Заавал мөрдөх улсын стандарт, улсын зохих стандартын заавал мөрдөх үзүүлэлт, шаардлагыг тогтоох объект (зүйл)-ын дэлгэрэнгүй жагсаалт"-д "102.Хаягдал хар болон өнгөт төмөрлөг, түүгээр хийсэн цутгамал;" гэх нэмсүгэй.

2. "Журам, жагсаалт батлах тухай" Засгийн газрын 1991 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн 260 дугаар тогтоолын хавсралтын "Аж ахуйн нэгжээс зөвшөөрөлтэйгээр эрхлэн гүйцэтгэж болох үйлдвэрлэл, үйлчилгээний жагсаалт"-д

"39	Хаягдал төмрийг үйлдвэрлэлийн зориулалтаар цуглуулах, боловсруулах, худалдаалах ажил, үйлчилгээ	Үйлдвэр, худалдааны яам"

гэж нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД Ч.ГАНЗОРИГ

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн эвлэл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 17 (204)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай*
- *Зарим барааны нөгдүүлэх экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *Монголбанкны худалдан авах алт болон Монголбанкнаас худалдах алт, мөнгөний хэмжээ тогтоох тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Чанарын баталгаажуулалтыг боловсронгуй болгох зарим арга хэмжээний тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2001 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2001 оны тавдугаар сарын 4 №17 (204)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

202. Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай (2001-4-19-ний хууль) 441

203. Зарим бараанд ногдуулах экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2001-4-19-ний хууль) 447

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

204. Монголбанкны худалдан авах алт болон Монголбанкнаас худалдах алт, мөнгөний хэмжээ тогтоох тухай Дугаар 30 447

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

205. Шүүгч томилох тухай Дугаар 84 448

206. Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай Дугаар 86 448

207. Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай Дугаар 87 448

208. Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай Дугаар 88 448

209. Элчин сайдыг томилох тухай Дугаар 89 449

210. Чиглэл өгөх тухай Дугаар 90 449

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

211. Чанарын баталгаажуулалтыг боловсронгуй болгох зарим арга хэмжээний тухай Дугаар 45 449

212. Арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай Дугаар 46 462

213. Хөтөлбөр батлах тухай Дугаар 47 465

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр **Улаанбаатар хот**

АЖИЛЛАХ ХҮЧ ГАДААДАД ГАРГАХ, ГАДААДААС АЖИЛЛАХ ХҮЧ, МЭРГЭЖИЛТЭН АВАХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын иргэнийг гадаадад, гадаадын иргэнийг Монгол Улсад хөдөлмөр эрхлүүлэх /цаашид "ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах" гэх/, тэдний эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль тогтоомж

2.1. Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай

хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль[1], Хөдөлмөрийн тухай хууль[2], Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль[3], Нийгмийн даатгалын тухай хууль[4], энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Гадаадад хөдөлмөр эрхлүүлэхийг хориглох

3.1. Дараахь тохиолдолд гадаадад хөдөлмөр эрхлүүлэхээр зуучлахыг хориглоно:

3.1.1.гадаадын иргэн, харьяалалгүй хүн, 18 насанд хүрээгүй хүнийг;

3.1.2. химийн хортой, тэсрэх болон цацраг, биологийн идэвхт бодистой харьцах, хар тамхи, мансуурууллах бодис үйлдвэрлэх, борлуулах зэрэг олон улсын хэмжээнд хориглосон ажилд.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах үйл ажиллагааны зохицуулалт

4 дүгээр зүйл. Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийнзахиргааны төв байгууллагын бүрэн эрх

4.1. Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах талаар хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.1.1. хүн амын хөдөлмөр эрхлэлт, хөрөнгө оруулалтын бүтцийн бодлоготой уялдуулан ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах асуудлаар бодлого, чиглэл тодорхойлох, хэрэгжилтийг хангуулах;

4.1.2. аж ахуйн нэгж, байгууллага, иргэнд ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах, хөдөлмөр эрхлүүлэх талаар зуучлах үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл, Монгол Улсад гадаадын иргэд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох, таттагдах, хугацаа нь сунгах болон хүчингүй болгох;

4.1.3. гадаадад хөдөлмөрийн гэрээгээр ажиллагч болон гадаадаас Монгол Улсад хөдөлмөрийн гэрээгээр ажиллагчийн нийгмийн хамгаалллын талаар гэрээнд заасан үүргийн биелэлтэд хяналт тавьж, тэдгээрийг хэрэгжүүлэх явцад илэрсэн зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;

4.1.4. эдийн засгийн үйл ажиллагааны салбар, байгууллагын нийт ажиллагчдын тоо, гадаадын хөрөнгө оруулалтын хэмжээнээс хамааруулан нийт ажиллагчдын тоонд гадаадаас авах ажиллах хүч, мэргэжилтний эзлэх хувийг жил бүр тогтоож, Засгийн газраар батлуулах;

4.1.5. ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах асуудлаар төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газрын агентлаг, төрийн бус байгууллагын үйл ажиллагаат уялдуулах, гадаадын холбогдох төрийн захиргааны болон төрийн бус байгууллагатай гэрээ байгуулах.

5 дугаар зүйл. Ажиллах хүч гадаадад гаргах тухай гэрээнд тусгах ерөнхий нөхцөлүүд

5.1. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн / цаашид "байгууллага" гэх/ нь үндэсний ажиллах хүчний мэдлэг, мэргэжил, мэргэшлийн ур чадварыг ахиулах, хөдөлмөр эрхлүүлэх зорилгоор гадаадын аж ахуйн нэгж, байгууллагад Монгол Улсын иргэнийг хөдөлмөрийн гэрээгээр ажиллуулах, үйлдвэрлэлийн дадлага хийлгэх, мэргэжил эзэмшүүлэх гэрээ байгуулж болно.

Энэхүү гэрээ нь энэ талаархи олон улсын эрх зүйн хэм хэмжээ, хоёр улсын хооронд байгуулсан гэрээ, тухайн орнуудын хууль тогтоомжид нийцсэн байвал зохино.

5.2. Ажиллах хүч гадаадад гаргах гэрээнд гадаадад ажиллах иргэний хөдөлмөрийн харилцаа, нийгмийн хамгаалллын асуудалтай холбогдсон гэрээний нөхцөлийг ажиллах хүч авч байгаа орны хууль тогтоомжид заасан хэм хэмжээнээс дордуулахгүйгээр тусгасан байна.

5.3. Ажиллах хүч гадаадад гаргах тухай

[1] Монгол Улсын Үндсэн хууль. "Төрийн мэдээлэл"-ийн 1992 оны № 1 дугаарт нийтлэгдсэн.
[2] Хөдөлмөрийн тухай хууль. --"Төрийн мэдээлэл"-ийн 1999 оны № 25 дугаарт нийтлэгдсэн.
[3] Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль. "Төрийн мэдээлэл"-ийн 1995 оны № 2 дугаарт нийтлэгдсэн.
[4] Нийгмийн даатгалын тухай хууль. "Төрийн мэдээлэл"-ийн 1994 оны № 8 дугаарт нийтлэгдсэн.

гэрээнд дараахь нөхцөлийг тодорхой тусгана:

5.3.1. хөдөлмөрийн гэрээгээр ажиллах улс, хот, байгууллагын нэр;

5.3.2. ажил, мэргэжлийн чиглэл, гүйцэтгэх ажил, албан тушаал, ажиллах хүчний тоо;

5.3.3. гэрээний хугацаа, гэрээ дуусгавар болох, түүнийг цуцлах нөхцөл;

5.3.4. ажиллагчдын хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ;

5.3.5. хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй, хөдөлмөрийн нөхцөл, ажил, амралтын цагийн горим;

5.3.6. орон сууц, нийгэм, ахуйн хангамжийн асуудал;

5.3.7. гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдон үүсэх маргаан болон хөдөлмөрийн маргааныг шийдвэрлэх арга, хэлбэр;

5.3.8. нийгмийн болон эрүүл мэндийн даатгал, тэтгэвэр, тэтгэмж, бусад көнгөлөлт;

5.3.9. очих, буцах замын зардал, тээврийн нөхцөл;

5.3.10. цалин хөлс, хууль ёсны бусад орлогыг тухайн орноос гуйвуулах боломж.

6 дугаар зүйл. Ажиллах хүч гадаадад гаргах

6.1. Ажиллах хүч гадаадад гаргах үйл ажиллагааг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон Монгол Улсын иргэдийг гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах тусгай зөвшөөрөл /цаашид "зуучлах зөвшөөрөл" гэх/ бүхий аж ахуйн нэгж, байгууллага, иргэн эрхэлнэ.

6.2. Зуучлах зөвшөөрлийг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно. Зуучлах зөвшөөрлийн гэрчилгээ нь ялгагдах онцлог тэмдэг, улсын нэгдсэн дугаар бүхий албан ёсны баримт байх бөгөөд хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр батлагаажигдсан байна. Гэрчилгээнд тухайн байгууллагын болон ажиллах хүч авах улсын нэр, зуучлах зөвшөөрөл олгосон шийдвэрийн дугаар, зөвшөөрлийн хүчинтэй байх хугацааг заана.

6.3.Байгууллага нь ажиллах хүч гадаадад гаргах талаар гадаадын байгууллагатай гэрээ байгуулсны дараа Монгол Улсын иргэнийг гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах зөвшөөрөл хүссэн өргөдлөө хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад гаргах бөгөөд өргөдөлд дараахь баримт бичгийг хавсаргана:

6.3.1. ажиллах хүч гадаадад гаргах талаар гадаадын байгууллагатай байгуулсан гэрээ;

6.3.2. аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатчаар батлагдсан хуулбар;

6.3.3. тухайн байгууллага нь Монгол Улсын холбогдох хууль тогтоомжоор тавигдах шаардлагыг хангаж, хэвийн ажиллах боломжтой эсэх тухай татварын албаны тодорхойлолт;

6.3.4. зуучлах үйлчилгээ явуулах зорилго, чиглэл, гадаадад ажиллах иргэний өмнө хүлээх үүрэг, хариуцлага тэдэнд тавих шаардлагыг тусгасан тухайн байгууллагын албан бичиг;

6.3.5. гадаадад ажиллах иргэнийг сонгон шалгаруулах журам, зуучлагч байгууллагаас тэдэнтэй байгуулах гэрээний төсөл, зуучлалын хураамжийн хэмжээг тогтоосон шийдвэр;

6.3.6. байгууллагын санхүүгийн чадварын тухай үйлчлэгч банкны тодорхойлолт;

6.3.7. шаардлагатай гэж үзвэл тухайн улсад суугаа Элчин сайдын яам, дипломат төлөөлөгчийн газар бусад холбогдох байгууллагын тодорхойлолт;

6.4. Ажиллах хүч гадаадад гаргах талаар хийсэн гэрээг үндэслэн зуучлах зөвшөөрлийг гурван жил хүртэл хугацаагаар олгох бөгөөд байгууллагын хүсэлт, үйл ажиллагааны тайлан, үр дүнг үндэслэн зуучлах зөвшөөрлийг сунгаж болно. Зуучлах зөвшөөрлийн хугацааг сунгах шийдвэрийг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гаргана.

6.5. Зуучлах зөвшөөрөлд нэр заагдсанаас өөр улсад ажиллах хүч гаргах бол тухайн орны аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулсан гэрээ, байгууллагын хүсэлтийг үндэслэн хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн зуучлах зөвшөөрөлд нэмэлт оруулах тухай шийдвэр гаргана.

6.6. Ажиллах хүч гадаадад гаргах талаар байгуулсан гэрээ нь Монгол Улсын хууль тогтоомжтой зөрчилдсөн, энэ хуулийн 5.3; 6.3-т заасан шаардлагыг хангаагүй тохиолдолд зуучлах зөвшөөрөл олгох, сунгах, түүнд нэмэлт оруулахаас татгалзсан хариуг тухайн байгууллагын хүсэлт, холбогдох баримт бичгийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 15 хоногт багтаан бичгээр мэдэгдэнэ.

6.7. Байгууллага нь хөдөлмөрийн гэрээгээр гадаадад ажиллах хүч гаргах бүрдээ хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэр гаргуулна.

6.8. Хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь гадаадад ажиллахаар явсан иргэдийн нэрсийн жагсаалт, гэрээ, холбогдох материалын нэг хувийг тухайн оронд суугаа Монгол Улсын Элчин сайдын яам, консул, төлөөлөгчийн газарт хүргүүлнэ.

6.9.Гадаадад хөдөлмөр эрхлэхэд зуучлах зөвшөөрөл авсан байгууллага нь иргэний хууран мэхэлсэн, тэдний хөдөлмөрийн ашуулгүй байдал, эрүүл ахуй, нийгмийн болон эрүүл мэндийн баталгаа алдагдахад хүргэсэн, зуучлах зөвшөөрөлд заагдаагүй оронд дур мэдэн ажиллах хүч гаргасан, зуучлах үйл ажиллагаанаас өндөр ашиг олох зорилгоор үндэслэлгүй үнэ тогтоосон зэргээр иргэний эрх ашгийг хохироосон нөхцөй зөрчил гаргасан тохиолдолд уг байгууллагын зуучлах зөвшөөрлийг хүчингүй болгох шийдвэрийг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гаргана.

6.10. Монгол Улсын иргэн гадаадад гэрээгээр ажиллаж байгаад үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас амь алдсан, тахир дутуу болсон нөхцөлд зуучлах зөвшөөрөл авсан байгууллага холбогдох хохирлыг барагдуулах бөгөөд ар гэрийнхэн нь хүсэлт гаргасан тохиолдолд амь алдсан иргэний цогцсыг Монгол Улсад авчрах зардлыг хариуцна.

6.11. Зуучлагч байгууллага нь ажиллах хүч гаргахдаа хөдөлмөрийн гэрээгээр ажиллах тухайн улсын нийгмийн болон эрүүл мэндийн даатгалд хамруулах талаар гэрээндээ тусгасан байхын зэрэгцүэ иргэн өөрөс хүсвэл Монгол Улсын Нийгмийн даатгалын тухай хуулийн дагуу даатгалд хамруулж, нийгмийн даатгалын байгуллагатай гэрээ байгуулна. Даатгалд шимтгэл, хураамж төлөх орлогын хэмжээ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс доошгүй байна.

6.12. Зуучлах зөвшөөрөл олгоод авах хураамжийг Монгол Улсын төмдэгтийн хураамжийн хуулийн[1] дагуу зохицуулна.

7 дугаар зүйл. Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай гэрээнд тусгах ерөнхий нөхцөлүүд

7.1. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн /цаашид "байгууллага" гэх/ нь шинжлэх ухаан, боловсрол, үйлдвэрлэлийн дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэх, шинэ үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах, тоног төхөөрөмж үгсрах, засварлах, төсөл хэрэгжүүлэх зорилгоор мэргэжлийн өндөр ур чадвар шаардах ажил, мэргэжлээр гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай гэрээг гадаадын хуулийн этгээдтэй байгуулж болно.

7.2. Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай гэрээнд дараахь ерөнхий нөхцөлийг тусгана:

7.2.1. гадаадын иргэний ажиллах байгууллага, гүйцэтгэх ажил үүрэг;

7.2.2. гадаадын иргэний ажиллах мэргэжлийн чиглэл, ажлын байрны нэр, хөдөлмөр эрхлэх гадаадын иргэний тоо;

7.2.3. гадаадын иргэний эрүүл мэндэд тавих шаардлага;

7.2.4. мэргэжил, боловсролын түвшинг баталсан баримт бичгийг харилцан зөвшөөрөх нөхцөл;

7.2.5. гэрээний хугацаа, гэрээ дуусгавар болох, түүнийг цуцлах нөхцөл;

7.2.6. цалин хөлсний хэмжээ;

7.2.7. хөдөлмөрийн ашуулгүй ажиллагаа, эрүүл ахуй, хөдөлмөрийн нөхцөл, ажил, амралтын цагийн горим;

7.2.8. орон сууц, ахуйн хангамжийн асуудал;

7.2.9. нийгмийн даатгалын асуудал;

7.2.10. гэрээг хэрэгжүүлэхтэй холбогдон үүсэх маргаан болон хөдөлмөрийн маргааныг шийдвэрлэх арга хэлбэрүүд.

7.3. Улсын хэмжээний томоохон төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, барилга, байгууламж барих, байгалийн гамшиг, сүйрлийн хор хөнөөлийг арилгахад шаардагдах ажиллах хүчийг дотоодоос хангах бололцоогүй нөхцөлд Засгийн газрын шийдвэрийг үндэслэн гадаадаас ажиллах хүч авч болно.

7.4. Гадаадын иргэн байгалийн гамшиг, түймэр, усны үерт өртөж амь алдсан нөхцөлд Засгийн газраас Монгол Улсын иргэний нэгэн адил туслажж, дэмжлэг үзүүлнэ.

7.5. Үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас амь алдсан, тахир дутуу болсон нөхцөлд гадаадын иргэнийг ажиллуулж байсан байгууллага нь гэрээнд энэ талаар заасан үүргээ бүрэн биелүүлнэ.

[1] Монгол Улсын төмдэгтийн хураамжийн хууль. "Төрийн мэдээлэл"-ийн 1993 оны № 4, 5 дугаарт нийтлэгдсэн.

8 дугаар зүйл. Гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах

8.1. Байгууллага нь гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авахын өмнө хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүний эрх олгосон байгууллага /цаашид "эрх бүхий байгууллага" гэх/-ын зөвшөөрлийг урьдчилан авсан байна.

8.2. Байгууллага нь энэ хуулийн 8.1-д заасан зөвшөөрөл авахдаа дараахь баримт бичгийг бүрдүүлнэ:

8.2.1. гадаадын ажиллах хүч, мэргэжилтэн зайлшгүй ажиллуулах шаардлага, гүйцэтгэх ажил, үйлчилгээний хэмжээ, хугацаа, үйлдвэрлэлийн онцлог, байршил, гадаадын иргэний мэргэжил, туршлага, ур чадварын талаар дэлгэрэнгүй тодорхойлсон албан бичиг;

8.2.2. аж ахуйн нэгж, байгууллагын улсын бүртгэлийн болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжийн гэрчилгээний нотариатчаар батлагдсан хуулбар;

8.2.3. гадаадын хуулийн этгээдтэй ажиллах хүч, мэргэжилтэн авах талаар байгуулсан гэрээ;

8.2.4. гадаадын иргэний гадаад паспортын хуулбар;

8.2.5. гадаадын иргэний мэргэжлийн үнэмлэх, дипломын хуулбар;

8.2.6.хөдөлмөр эрхлүүлэх салбарын яам, агентлагийн тодорхойлолт;

8.2.7. гадаадын иргэн, түүний гэр бүлийн гишүүдийн талаархи гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаны санал;

8.2.8. тухайн байгууллагад гадаадын ажиллах хүч, мэргэжилтэн ажиллуулах шаардлага, хэрэгцээний тухай орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн албаны санал.

8.3. Эрх бүхий байгууллага нь холбогдох баримт бичгийг хүлээн авч, хянан шалгасны үндэсэн дээр Засгийн газраас тогтоосон хувь, хэмжээнд багтаан Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгоно.

8.4. Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл нь 1 жил хүртэл хугацаатай байх бөгөөд зөвшөөрлийн хугацааг байгууллагын хүсэлт, гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний үр дүн, цаашид ажиллуулах болсон шалтгааныг судалж, шалгасны үндэсэн дээр энэ хуулийн 8.2; 8.3-т заасан шаардлагын дагуу сунгана.

8.5. Хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн дагуу гадаадын иргэнийг Монгол Улсад ирүүлсэн байгууллага нь Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албанд бүртгүүлнэ.

8.6. Хөдөлмөр эрхлэх зөвшөөрөлтэй гадаадын иргэн нь байгууллагатай байгуулсан хөдөлмөрийн гэрээгээ цуцалсан тохиолдолд ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт, гэрээ цуцлах болсон шалтгааныг үндэслэн эрх бүхий байгууллагаас зохих журмын дагуу зөвшөөрөл олгох асуудлыг шийдвэрлэнэ.

8.7. Монгол Улсад хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл бүхий гадаадын иргэн тухайн байгууллагатай байгуулсан хөдөлмөрийн гэрээнийүүргээ биелүүлээгүй, гэрээ зөрчсөн, өөр байгууллага, орон нутагт зөвшөөрөлгүй шилжин ажилласан тохиолдолд үг зөвшөөрлийг байгууллагын тодорхойлолтыг үндэслэн холбогдох эрх бүхий байгууллагаас хүчингүй болгож, Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албанд энэ тухай мэдэгдэнэ.

8.8. Гадаадын иргэнд олгох хөдөлмөр эрхлэх зөвшөөрлийн хугацааг холбогдох байгууллагад энэ хуулийн 8.2.1-д заасан албан бичгээр хүсэлт тавьсан өдрөөс эхлэн тооцно.

8.9. Гадаадын иргэнд хөдөлмөр эрхлэх зөвшөөрөл олгох үйлчилгээний журам, хураамжийн хэмжээг хөдөлмөрийн болон санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран тогтооно.

9 дүгээр зүйл. Ажлын байрны төлбөр, түүний хэмжээ

9.1. Аж ахуйн нэгж, байгууллага, иргэн нь гадаадын иргэнийг ажлын байраар хангаж, орлого бүхий ажил, үйлчилгээ эрхлүүлсний төлөө ажлын байрны төлбөрийг энэ хуулийн 9.2-т заасан хэмжээгээр төлнө.

9.2. Ажлын байрны төлбөрийн хэмжээ нь 1 сард гадаадын иргэн бүрт Монгол Улсын Засгийн газраас тогтоосон хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 2 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцүү байна.

9.3. Ажлын байрны төлбөрийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зориулалтын санд төвлөрүүлж, ажлын байр бий болгох, ажилгүйдлийг бууруулах арга хэмжээнд зарцуулна.

9.4. Гадаадын дипломат төлөөлөгчийн болон консулын газар, олон улсын байгууллагын суурин төлөөлөгчийн газар ажиллаж байгаа гадаадын иргэд, түүнчлэн боловсрол, шинжлэх ухааны салбарт гэрээгээр ажиллаж байгаа гадаадын

мэргэжилтэн, ажилтнууд Засгийн газар хоорондын гэрээнд заасан тохиолдолд уг гэрээгээр ажиллаж байгаа гадаадын мэргэжилтэн, ажилтнуудад энэ зүйлд заасан төлбөр хамаарахгүй.

9.5. Ажлын байрны төлбөр авах, хөнгөлөлт үзүүлэх, чөлөөлөх журмыг Засгийн газар тогтооно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

10 дугаар зүйл. Байгууллага болон гадаадад суугаа дипломат төлөөлөгчийн газрын үүрэг

10.1. Байгууллага нь гадаадад ажиллах хүч гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай гэрээний биелэлт, гадаадад хөдөлмөр эрхлүүлж байгаа иргэд, гадаадаас авч ажиллуулж байгаа ажиллах хүч, мэргэжилтний талаархи тайлан, мэдээг батлагдсан маягтын дагуу улирал тутам гаргана. Цуцлагдсан болон сунгасан гэрээний тухай мэдээллийг тухай бүр гаргаж, хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу түүний эрх олгосон байгууллагад албан ёсоор ирүүлж байна.

10.2. Байгууллага нь гадаадад хөдөлмөр эрхлүүлж байгаа монгол иргэд, гадаадаас авч ажиллуулж байгаа ажиллах хүч, мэргэжилтнийг хөдөлмөрийн гэрээ дуусмагц эх оронд нь буцаах арга хэмжээ авах үүрэгтэй.

10.3. Тухайн оронд суугаа Элчин сайдын яам, консул, төлөөлөгчийн газар нь хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж, үйлдвэрлэлийн дадлага хийж байгаа монгол иргэд, Монгол Улсад хөдөлмөр эрхлэх гадаадын иргэдийн талаар дараахь үүрэг хүлээнэ:

10.3.1. Монгол Улсын иргэдийг гадаадад хөдөлмөр эрхлүүлэх тухай байгуулсан гэрээний биелэлтэд хяналт тавих;

10.3.2. гэрээгээр хөдөлмөр эрхэлж байгаа Монгол Улсын иргэдийн талаар бүртгэл, мэдээлэл хөтлөх, улирал тутам хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх;

10.3.3. ажлын байрны нөхцөл, цалин хөлс, нийгмийн хамгааллын байдалтай газар дээр нь танилцаж судлах, шаардлагатай тохиолдолд энэ асуудлаар тухайн орны эрх бүхий байгууллагад хандаж, өөрийн орны иргэдэд дэмжлэг туслалцаа үзүүлэх;

10.3.4. Монгол Улсад орох визийг олгоход гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах гэрээ болон хөдөлмөр эрхлэх зөвшөөрөлтэй эсэхэд хяналт тавих, энэ талаар зөвлөгөө өгөх.

11 дүгээр зүйл. Хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналт

11.1. Энэ хуулийн хэрэгжилтэд хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага буюу түүний эрх олгосон байгууллага, аймаг, нийслэл, дүүргийн Засаг даргын тамгын газар, холбогдох хууль, хяналтын байгууллага хяналт тавина.

12 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

12.1. Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдэд дараахь захиргааны шийтгэлийг хөдөлмөрийн улсын байцаагч буюу шүүгч ногдуулна:

12.1.1. энэ хуулийн 6.1, 8.1-д заасныг зөрчиж зөвшөөрөлгүйгээр ажиллах хүч, мэргэжилтэн гадаадаас авч ажиллуулсан, ажиллах хүч гадаадад гаргасан бол учруулсан хохирлыг төлүүлж, гэм буруутай албан тушаалтныг 30000-60000, байгууллагыг 150000-250000 төгрөгөөр торгох;

12.1.2. энэ хуулийн 9.1-д заасан төлбөрийг төлөөгүй бол төлбөрийг нөхөн төлүүлж, байгууллагыг 150000-250000 төгрөгөөр торгох;

12.1.3. энэ хуулийн 10.1-д заасныг зөрчиж, тайлан, мэдээг удаа дараа хугацаанд нь гаргаж хүргүүлээгүй албан тушаалтныг 5000-25000 төгрөгөөр, байгууллагыг 50000-100000 төгрөгөөр торгох;

12.1.4. энэ хуулийн 10.2-т заасан иргэдийг эх оронд нь буцаахаас санаатайгаар зайлсхийсэн, тэдэнд зөвшөөрөлгүйгээр хөдөлмөр эрхлэх боломж олгосон албан тушаалтныг 50000-100000 төгрөгөөр, байгууллагыг 500000-1000000 төгрөгөөр тус тус торгох.

13 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

13.1. Энэ хуулийг 2001 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр **Улаанбаатар хот**

ЗАРИМ БАРААНД НОГДУУЛАХ ЭКСПОРТЫН ГААЛИЙН ТАТВАРЫН ХЭМЖЭЭ ТОГТООХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Зарим бараанд ногдуулах экспортын гаалийн татварын хэмжээ тогтоох тухай хуулийн 1 дүгээр зүйлийг дараахь байдлаар өөрчлөн найруулсугай:

"**1 дүгээр зүйл**. Хаягдал хар болон өнгөт төмөрлөгт дор дурдсан хэмжээгээр экспортын гаалийн татвар ногдуулсугай:

№	Үндэсний код	Барааны нэр	Хэмжих нэгж	Гаалийн татварын хэмжээ /төгрөг/
1	72.04	Хар төмөрлөгийн өдөөс, хаягдал, дахин хайлуулах төмөр буюу гангийн өдсийн цутгамал	кг	140
2	7204.10.00	Ширэмний өдөөс, хаягдал	кг	140
3	7204.21.00	Чанаржуулсан, зэвэрдэгтүй гангийн өдөөс, хаягдал	кг	140
4	7204.29.10	Хаягдал зам төмөр	кг	140
5	72.06	Цутгамал болон анхдагч бусад хэлбэртэй төмөр, чанаржуулаагүй ган	кг	140
6	72.24	Цутгамал, анхдагч хэлбэрт байгаа чанаржуулсан бусад ган, чанаржуулсан бусад гангаар хийсэн хагас боловсруулсан бүтээгдэхүүн	кг	140
7	73.01	Өрөмдөлт, цөмлөлт, боловсруулалт хийсэн болон хийгээгүй, эсхүл угсрагдах зд ангиас бүрдэх төмөр, ган хуудсан материалаар хийсэн шон, төмөр, гангаар хийсэн гагнамал булан хэлбэрт болон сортын төмөр	кг	140
8	7302.10.00	Зам төмөр	кг	140
9	7403.21.00	Зэс, цайрын хайлш /гууль/	кг	128
10	74.04	Зэсийн өдөөс, хаягдал	кг	1500
11	74.07	Зэс цулдан, туйван болон оготолбор	кг	1500
12	76.01	Боловсруулаагүй хөнгөн цагаан	кг	450
13	76.02	Хөнгөн цагааны өдөөс, хаягдал	Кг	450
14	76.04	Хөнгөн цагаан цулдан, туйван болон оготолбор	Кг	350

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2001 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА **Ж.БЯМБАДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр **Дугаар 30** **Улаанбаатар хот**

Монголбанкны худалдан авах алт болон Монголбанкнаас худалдах алт, мөнгөний хэмжээ тогтоох тухай

Эрдэнэсийн сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 3, 5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Алт олборлодог аж ахуйн нэгжүүдээс Монголбанкны худалдан авах алтны доод хэмжээг 2001 онд 12000.0 килограмм байхаар тогтоосугай.

2.Дотоодын үйлдвэрлэлийн хэрэгцээнд зориулж 2001 онд Монголбанкнаас худалдах алтны хэмжээг 50.0 килограмм, мөнгөний хэмжээг 1000.0 килограмм байхаар тус тус тогтоосугай.

3.Худалдан авсан алтыг тухай бүр олон улсын стандартад хүргэн зохих журмын дагуу цэвэршүүлж, үнийн тааламжтай нөхцөл бүрдсэн үед борлуулж, улсын валютын нөөцийг нэмэгдүүлэх арга хэмжээ авч байхыг Монголбанк /О.Чулуунбат/-нд зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр Дугаар 84 **Улаанбаатар хот**

Шүүгч томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, "Шүүхийн тухай" хуулийн 6, 51 дүгээр зүйлийг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Оросоогийн Зандраагийн Нийслэлийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлж, Улсын дээд шүүхийн шүүгчээр томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр Дугаар 86 **Улаанбаатар хот**

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

Равдангийн Хатанбаатарыг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Бүгд Найрамдах Унгар Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Таукейн Султааныг томилсугай.

1. Монгол Улсаас Бүгд Найрамдах Унгар Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр Дугаар 87 **Улаанбаатар хот**

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

Булгаагийн Алтангэрэлийг эгүүлэн татсугай.

2. Бүдрагчаагийн Даш-Ёндонг Монгол Улсаас Бүгд Найрамдах Болгар Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар томилсугай.

1. Монгол Улсаас Бүгд Найрамдах Болгар Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр Дугаар 88 **Улаанбаатар хот**

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Ватикан Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Чулууны Батжаргалыг томилсугай.

1. Монгол Улсаас Ватикан Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Сүх-Очирын Болдыг

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр Дугаар 89 **Улаанбаатар хот**

Элчин сайдыг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Ардчилсан Лаос Ард Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Нямсүрэнгийн Алиасүрэнг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр Дугаар 90 **Улаанбаатар хот**

Чиглэл өгөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалтыг баримтлан Монгол Улсын Засгийн газарт дор дурдсан чиглэл өгсүгэй.

1. Нийслэл Улаанбаатар хотын эдийн засаг, нийгмийн хөгжлийн өнөөгийн байдлыг судлан, тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэх талаар санал боловсруулах ажлын хэсгийг энэ оны 5 дугаар сард томилж ажилд нь оруулах.

2. Ажлын хэсгийн саналыг хэлэлцэн Засгийн газрын шийдвэр гаргаж, төрийн эрх барих дээд байгуулагын бүрэн эрхэд хамаарах асуудлуудаар нь хууль, УИХ-ын тогтоолын төсөл боловсруулан 2002 оны нэгдүгээр улиралд багтаан УИХ-д өргөн барих.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 3 дугаар сарын 13-ны өдөр Дугаар 45 **Улаанбаатар хот**

Чанарын баталгаажуулалтыг боловсронгуй болгох зарим арга хэмжээний тухай

Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 8 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 12 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Чанарын баталгаажуулалтад заавал хамрагдах экспорт, импортын барааны жагсаалтыг 1 дүгээр, чанарын баталгаажуулалтад хамрагдах экспорт, импортын бараг улсын хилээр нэвтрүүлэх, шалгах журмыг 2 дугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн батлуулсугай.

2. Энэ тогтоолын 1 дүгээр хавсралтад заасан бараат үйлдвэрлэж дотоодын зах зээлд нийлүүлэхэд чанарын баталгаажуулалтад заавал хамруулж байхаар тогтоосугай.

3. Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг даалгах нь:

а/хүн, амьтан, ургамлын эрүүл мэнд, байгаль орчныг хамгаалах, аюулгүй байдлыг хангах, дотоодын үйлдвэрлэлийг дэмжих шаардлагыг харгалзан худалдаан дахь техникийн зохицуулалтыг олон улсын нийтлэг зарчимд нийцүүлэн тогтоож байх;

б/экспорт, импортын барааны чанарын баталгаажуулалтын дүгнэлтийг харилцан хүлээн зөвшөөрөх талаар бүс нутгийн болон олон улсын байгуулагатай, худалдааны түнш орнуудтай шаардлагатай гэрээ, хэлэлцээр байгуулж, биелэлтэд нь хяналт тавьж байх;

в/бараа, үйлчилгээний чанарын баталгаажуулалтын үйл ажилгааны талаар үндэсний хэмжээнд нэгдсэн арга зүйгээр хангах, холбогдох журам, заавруг энэ тогтоолтой нийцүүлэн шинэчлэн батлаж мөрдүүлэх;

г/холбогдох яам, агентлагуудын оролцоотойгоор техникийн зохицуулалт болон стандартчиллын холбогдох бусад баримт бичгийн мэдээллийн сан, сүлжээ бий болгох арга хэмжээ авах;

д/хилийн болон гүний гааль дахь баталгаажуулалтын албаны ажилтнуудыг дүрэмт хувцастай болгох асуудлыг судалж, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.

4. Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгах нь:

а/хилийн болон гүний гааль дахь орон нутгийн чанарын баталгаажуулалтын албадыг барааны чанарын үзүүлэлтүүдийг шуурхай тодорхойлох сорилт, шинжилгээний зориулалтын багаж хэрэгслээр хангах арга хэмжээ авах;

б/орон нутгийн стандартчилал, хэмжил зүйн төвийн үйл ажиллагаат жигдрүүлж, мэргэжлийн боловсон хүчнээр бэхжүүлж, тэдгээрийг сургалтад хамруулж байх;

в/орон нутгийн чанарын баталгаажуулалтын байгууллага, сорилтын лабораториудыг зохих хууль тогтоомжийн дагуу итгэмжлүүлж, чанарын баталгаажуулалт явуулах эрх олгох арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

5. "Хилийн мэргэжлийн хяналтыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1994 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 78 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Хилийн хяналтын албадын ажлыг зохицуулах журам"-ын 4 дэх хэсгийн "а", "б" заалт бүрийн төгсгөлд "чанарын баталгаажуулалт" гэж, 5 дахь хэсгийн "...мал эмнэлэг, хорио цээрийн" гэсний дараа "...чанарын баталгаажуулалтын" гэж, мөн "...Эрүүл мэндийн яам" гэсний дараа "Үйлдвэр, худалдааны яам" гэж тус тус нэмсүгэй.

6.Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хуулийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1995 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 100 дугаар тогтоолын 2 дугаар заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

7. Энэ тогтоолыг 2001 оны 4 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД Ч.ГАНЗОРИГ

Засгийн газрын 2001 оны 45 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТАД ЗААВАЛ ХАМРАГДАХ ЭКСПОРТ, ИМПОРТЫН БАРААНЫ ЖАГСААЛТ

ЭКСПОРТЫН БАРАА

Бүлэг №	Зүйл №	Мөр №	Барааны бичиглэл
02	02.01		Үхрийн шинэ буюу хөргөсөн мах
	02.02		Үхрийн хөлдүү мах
	02.04		Хонь, ямааны шинэ, хөргөсөн буюу хөлдүү мах
	02.05	0205.00.10	Адууны мах
03	03.02		Зүйл № 03.04-т заасан загасны ясгүй гол мах ба бусад махнаас өөр шинэ буюу хөргөсөн хөлдүү загас
	03.03		Зүйл № 03.04-т заасан загасны ясгүй гол мах ба бусад махнаас өөр хөлдүү загас
	03.04		Загасны шинэ, хөргөсөн, хөлдүү ясгүй гол мах ба бусад мах /татсан ба татаагүй/
	03.05		Хатаасан, давсалсан буюу давсны уусмалд хадгалсан загас; халуун ба хүйтэн утлагат /утах явцад буюу утахаас өмнө болгосон байж болно/ загас
04			Сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөг, зөгийн бал

05	05.04		Мал амьтны /загаснаас бусад/ шинэ, хөргөсөн, хөлдөөсөн, давсалсан, давсны уусмалд хадгалсан, хатаасан, утсан бүтэн буюу хуваасан өлөн гэдэс
16	16.01 16.02		Мах, дайвар мах буюу цусан хиам, түүнтэй төстэй бүтээгдэхүүн; тэдгээрээр хийсэн хүнсний бэлдмэл Мах, дайвар мах болон цусаар хийсэн бусад бэлдмэл, тэдгээрийн лаазалсан бүтээгдэхүүн
22			Ус, ундаа, спирт, архи, дарс, цуу
23	23.02 23.09		Үр тариа, буурцагт ургамлын шигших, тээрэмдэх буюу бусад боловсруулалт хийх явцад гардаг хорголжилсон буюу хорголжлоогүй хивэг үртэс ба улдэгдэл Мал, амьтны бэлдмэл тэжээл
25	25.29	2529.10	Хайлуур жонш
26	26.03 26.11 26.12 26.13		Зэсийн хүдэр ба баяжмал Гянт болдын хүдэр ба баяжмал Ураны буюу торийн хүдэр ба баяжмал Молибдений хүдэр ба баяжмал
30	30.02 30.02 30.03 30.04	3002.20 3002.30	Хүн эмнэлгийн зориулалттай вакцин Мал эмнэлгийн зориулалттай вакцин Жижиглэн худалдаалах тун хэлбэрт савлагдаагүй, урьдчилан сэргийлэх буюу эмчилгээний зориулалттай хоёр буюу түүнээс дээш найрлагатай эмийн бэлдмэл / Зүйл 30.02, 30.05, 30.06-д зааснаас бусад/ Жижиглэн худалдаалах тун хэлбэрт савлагдаагүй, урьдчилан сэргийлэх буюу эмчилгээний зориулалттай холимог буюу холимог бус эм /Зүйл 30.02, 30.05, 30.06-д зааснаас бусад/
35	35.07		Фермент; бусад газар заагдаагүй ферментийн бэлдмэл
41			Арьс, ширэн түүхий эд (ангийн үсгээс бусад) ба боловсруулсан арьс шир
42	42.03		Савхи, хиймэл савхиар хийсэн хувцас ба хувцасны тоног хэрэглэл
43	43.01 43.02 43.03		Үслэг түүхий эд /толгой, сүүл, савар болон үслэг эдлэлийн үйлдвэрт хэрэглэж болох бусад хэсэг/ /Зүйл № 41.01, 41.02 буюу 41.03-т хамаарах арьс ширний түүхий эдээс бусад/ Зүйл № 43.03-т заагдсанаас бусад идээлсэн болон өнгө засал хийсэн үслэг арьс /толгой, сүүл, савар болон бусад хэсгүүд, оготолсон зүйлс/, эгнэсэн буюу эгнээгүй /бусад материалыг нэмэлгүйгээр/ Үслэг эдлэлээр хийсэн хувцасны тоноглол, хувцасны зүйлс
44	44.12 44.13 44.18		Фанер, хуулга наасан хавтан ба давхарлаж наасан адил төстэй модон материал Дөрвөлжин, хавтгай, тууз хэлбэрийн буюу хэлбэржүүлэн нягтруулсан мод Барилгын дархны модон эдлэл, хөндий, хавтан, зүймэл модон шал /нийлүүлсэн/, хавтан, дээврийн ба бусад савх мод
51			Ноос, мал, амьтны нарийн буюу бүдүүн үс, ноос, ноолуур, хялгас, адууны хялгасан эрмэл, тэдгээрийн нэхмэл даавуу
57			Хивс ба бусад нэхмэл дэвсгэр

61	61.01- 61.17	Үндэсний код: 10 20 30	Хонины ноосон сүлжмэл хувцас ба сүлжмэл тоног хэрэгсэл Ямааны ноолууран сүлжмэл хувцас ба сүлжмэл тоног хэрэгсэл Тэмээний ноосон сүлжмэл хувцас ба сүлжмэл тоног хэрэгсэл
63		6301.20	Хонины ноосон буюу мал, амьтны нарийн үс, ноосон хөнжил (цахилгаанаар халдгаас бусад), аяны хөнжил
72	72.04 72.04 72.04 72.04 72.06 72.24	 7204.10 7204.30 7204.29	Хар төмөрлөгийн өвдөс ба хаягдал, дахин хайлуулах төмөр буюу гангийн өвдсийн цутгамал Ширэмний хаягдал ба өвдөс Гангийн хаягдал ба өвдөс Хаягдал төмөр зам /рельс/ Цутгамал болон анхдагч бусад хэлбэртэй төмөр ба чанаржуулаагүй ган Цутгамал буюу анхдагч хэлбэрт байгаа чанаржуулсан бусад ган, чанаржуулсан бусад гангаар хийсэн хагас боловсруулсан бүтээгдэхүүн
73	73.08		Төмөр хийц, түүний эд анги, төмөр буюу гангаар хийсэн төмөр хийц үйлдвэрлэх зориулалттай хавтан, туйван, булан хэлбэрт болон сортын төмөр, хоолой ба тэдгээртэй төстэй зүйлс
74			Зэс ба түүгээр хийсэн эдлэл
90	90.18	9018.31	Зүүтэй ба зүүгүй тариур
			ИМПОРТЫН БАРАА
02			Мах, хүнсний дайвар бүтээгдэхүүн
03			Загас, хавч, нялцгай биетэн ба усны бусад сээр нуруугүй амьтан
04			Сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөг, зөгийн бал
07			Хүнсний ногоо, зарим ургамлын үндэс, булцуу
08			Хүнсэнд хэрэглэдэг жимс, самар, жүрж ба гуаны халс
09	09.01 09.02		Хуурсан буюу хуураагүй, кофеиноос цэвэрлэсэн буюу цэвэрлээгүй кофе; кофены халс, яс;тодорхой хэмжээний кофеины агуулгатай кофег орлодог бүтээгдэхүүн Амт, үнэр оруулсан буюу оруулаагүй /ферментжүүлсэн буюу ферментжүүлээгүй/ цай
10			Үр тариа
11	11.01 11.02		Улаан буудайн буюу улаан буудай-хөх тарианы гурил Улаан буудайн буюу улаан буудай-хөх тарианы гурилаас бусад үр тарианы гурил
15			Мал, амьтны болон ургамлын гаралтай тос, түүнийг задалж боловсруулсан бүтээгдэхүүн; идэшний өөх; тос; мал, амьтан, ургамлын гаралтай лав
16			Махан зүйлс ба загас, далайн хавч, нялцгай биетэн буюу усны бусад сээр нуруугүй амьтдаар хийсэн хүнсний зүйл
17			Сахар, сахран бүтээгдэхүүн
18			Какао болон какаоны бэлдмэл
20			Хүнсний ногоо, жимс, самар буюу ургамлын бусад эд хэсгийн бэлдмэл
22			Ус, ундаа, спирт, архи, дарс, цуу
24			Тамхи, түүнийг орлуулагч бүтээгдэхүүн

25		2501.00	Давс /хүнсний ба хүнсний биш/, тооснжилтыг дарах, бөөгнөрөлтөөс хамгаалах бодис нэмсэн буюу нэмээгүй цэвэр хлорт натри, цэвэр давсны усан уусмал; далайн шорвог ус
27	27.10		Нефть ба битумжсэн эрдсээс гаргасан газрын тос / түүхий биш/; жингийн 70% буюу түүнээс их нефть буюу битумжсан эрдсээс гаргасан газрын тос агуулсан, бусад газарт тусгайлан заагдаагүй буюу ороогүй бэлдмэл /эдгээр газрын тос нь бэлдмэлийн үндсэн бүрэлдүүлэгч хэсэг нь байна/
28	28.01		Фторид, хлорид, бромид, иодат
30	30.02	3002.20	Хүн эмнэлгийн зориулалттай вакцин
		3002.30	Мал эмнэлгийн зориулалттай вакцин
	30.03		Жижиглэн худалдаалах тун хэлбэрт савлагдаагүй, урьдчилан сэргийлэх буюу эмчилгээний зориулалттай хоёр буюу түүнээс дээш найрлагатай эмийн бэлдмэл / Зүйл № 30.02, 30.05, 30.06-д зааснаас бусад/
	30.04		Жижиглэн худалдаалах тун хэлбэрт савлагдаагүй, урьдчилан сэргийлэх буюу эмчилгээний зориулалттай холимог буюу холимог бус эм /Зүйл № 30.02, 30.05, 30.06-д зааснаас бусад/
31			Бордоо
32	32.08		Нийлэг буюу байгалийн хувиргасан полимерт суурилсан, усан биш орчинд уусгасан буюу булингаржуулсан найруулсан будаг, чий (лак) (пааландас будаг буюу маажин орно); энэ бүлгийн 4-р зүйлд заасан уусмал
	32.09		Нийлэг буюу байгалийн хувиргасан полимерт суурилсан, усан орчинд уусгасан буюу булингаржуулсан найруулсан будаг, чий лак) (пааландас будаг буюу маажиндах чий орно).
33	33.03		Үнэртэй ус, ариун цэврийн ус
	33.04		Гоо сайхны бэлдмэл, биеийн арьс арчилж, хамгаалах бэлдмэл (эмийн бэлдмэлээс бусад наранд шарах ба нарнаас хамгаалах бэлдмэл орно); хумс заслын бэлдмэл
	33.05		Үс арчлах бэлдмэл
	33.06		Амны хөндий, шүдний ариун цэврийн бэлдмэл, хиймэл шүд бэхжүүлэх нунтаг, шахмал оо; жижиглэн худалдаалах нэг бүрийн боодолтой шүдний мяндсан чиглүүр
34	34.01	3401.11	Гар нүүрийн саван (эмийн бэлдмэлтэй бүтээгдэхүүн орно)
		3401.19	Эдийн саван
	34.02	3402.20	Жижиглэн худалдах зориулалтаар савласан бэлдмэл; угаалгын нунтаг
35	35.07		Фермент; бусад газар заагдаагүй ферментийн бэлдмэл
36			Тэсрэмтгий бодис
48	48.03		Гэр ахуй, ариун цэврийн зориулалттай гар нүүр, жорлонгийн цаас, цаасан алчуур, амны цаасан алчуур буюу тэдгээртэй төстэй цаас, гадаргууд нь хэв, атираа, нугалаас үүсгэсэн, нүхэлсэн, будсан, хээлж чимэглэсэн буюу ийм боловсруулалт хийгээгүй, хуудаслан зүссэн буюу хуйлмал хэлбэрийн, целлюлёзон хөвөн ба целлюлёзон зулмал
61	61.07		Эрэгтэйчүүдийн буюу хөвгүүдийн сүлжмэл агтавч, дотуур өмд, унтлагын цамц, унтлагын өмд цамцны хослол, усны, гэрийн халат ба ижил тестэй сүлжмэл зүйлс
	61.08		Эмэгтэйчүүдийн буюу охидын сүлжмэл сарафан, дотуур банзал, дотуур өмд цамцны хослол, нимгэн халат, гэрийн ба усны халат
	61.09		Сүлжмэл футболк, майк ба дотуур цамц

62	62.07		Эрэгтэйчүүдийн буюу хөвгүүдийн майк, агтавч, дотуур өмд, унтлагын цамц, унтлагын өмд цамцны хослол, усны, гэрийн халат ба ижил төстэй зүйлс
	62.08		Эмэгтэйчүүдийн буюу охидын майк, сарафан, дотуур банзал, агтавч, дотуур өмд, унтлагын даашинз, унтлагын өмд цамцны хослол, гэрийн нимгэн халат, усны, гэрийн халат ба ижил төстэй зүйлс
	62.12		Оёмол буюу сүлжмэл, хөхний даруулга, бүс, гэдэсний даруулга, мөрөвч, өмдний татуурга, оймсны татуурга болон тэдгээртэй ижил төстэй эдлэл ба тэдгээрийн эд анги
63	63.02		Орны цагаан хэрэглэл, ширээ, ариун цэвэр ба гал тогооны даавуун хэрэглэл
68	6810		Цемент, бетон болон хиймэл чулуун, хүчитгэсэн буюу хүчитгээгүй бүтээгдэхүүн
73	73.08		Төмөр хийц, түүний эд анги, төмөр буюу гангаар хийсэн төмөр хийц үйлдвэрлэх зориулалттай хавтан, туйван, булан хэлбэрт болон сортын төмөр, хоолой ба тэдгээртэй төстэй зүйлс
74			Зэс ба түүгээр хийсэн эдлэл
85	85.09		Өртөө цахилгаан хөдөлгүүр бүхий гэр ахуйн зориулалтын цахилгаан–механик хэрэглэл
90	90.16		5сг (50мг) буюу түүнээс илүү нарийвчлалтай, туухайтай буюу туухайгүй жин
		9017.30	Микрометр, штангенциркуль, нарийн хэмжилтийн багаж
		9018.11	Зүрхний бичлэг хийх цахилгаан аппарат
		9018.31	Зүүтэй буюу зүүгүй тариур
		9026.20	Даралт хэмжих, хянах багаж хэрэгсэл
		9027.10	Хий буюу утаа шинжлэх багаж хэрэгсэл
		9028.10	Хийн тоолуур
		9028.20	Шингэний тоолуур
		9028.30	Цахилгааны тоолуур
		9030.10	Ионжуулагч цацрагийг хэмжих буюу илрүүлэх багаж, аппарат
		9030.20	Катодын туяаны осциллоскоп, катодын туяаны осциллограф
		9030.31	Цахилгаан хэмжлийн олон ажиллагаат багаж
		9030. 40	Харилцаа холбооны бусад салбарт ашиглагдах тусгай зориулалтын бусад багаж хэрэгсэл
95	95.01		Хүүхэд унаж тоглох дугуйт тоглоом /жишээ нь: унадаг гурван дугуйт, өөрөө явагч, гишгүүрт машин/; хүүхэлдэй тэрэг
	95.02		Зөвхөн хүн дурстэй хүүхэлдэй
	95.03		Бусад тоглоом; овор хэмжээ (масштаб)-г нь багасгасан загвар буюу түүнтэй төстэй, зугаа цэнгэлийн хөдөлгөөнт буюу хөдөлгөөнт биш загвар; бүх төрлийн оньсон тоглоом

Засгийн газрын 2001 оны 45 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ЧАНАРЫН БАТАЛГААЖУУЛАЛТАД ХАМРАГДАХ ЭКСПОРТ, ИМПОРТЫН БАРААГ ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХ, ШАЛГАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэхүү журам нь Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай болон Хэрэглэгчийн эрхийг хамгаалах, Эрүүл мэнд, Хүнсний тухай хуулиуд, Дэлхийн Худалдааны Байгууллагын "Худалдаан дахь техникийн саад тотгорын тухай хэлэлцээр"-т нийцүүлэн харилцан нийлүүлж байгаа барааг чанарын баталгаажуулалтад хамруулах, баталгаажуулалтын талаар гадаад орнуудтай байгуулсан гэрээ, хэлэлцээрийг хэрэгжүүлэх, чанарын баталгаажуулалтад хамрагдах экспорт, импортын бараг хилээр нэвтрүүлэх, шалгахтай холбогдсон харилцааг зохицуулна.

2. Чанарын баталгаажуулалтад хүн, амьтан, ургамлын эрүүл мэнд, байгаль орчны аюулгүй байдлыг хангах, стратегийн ач холбогдол бүхий экспорт, импортын бараат хамруулна. Худалдаа эрхлэн явуулж байгаа өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгуллага, иргэд чанарын баталгаажуулалтад заавал хамрагдах бараат экспортлох, импортлоход энэхүү журмыг мөрдөнө.

3. Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төв болон түүнээс эрх авсан мэргэжлийн байгуллага, орон нутагт нийслэл, аймгийн стандартчилал, хэмжилзүйн төв /цаашид баталгаажуулалтын алба гэнэ/ чанарын баталгаажуулалтад заавал хамрагдах барааны жагсаалтад орсон бараанд тохирлын үнэлгээ явуулж чанарын баталгаажуулалт хийнэ.

4. Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төв нь экспорт, импортын барааны чанарын баталгаажуулалтын талаар дараахь эрх, үүрэгтэй байна:

а/гадаад орны холбогдох байгууллагатай экспорт, импортын барааны чанарын баталгаажуулалтын асуудлаар хамтран ажиллах гэрээ хэлэлцээр байгуулах, гэрээ хэлэлцээрт барааны нэр, төрөл, тохирлын үнэлгээний журам, тохирлын гэрчилгээ, тэмдгийн загвар, чанарын баталгаажуулалт хийх эрх бүхий байгуллагын талаар тусгасан байвал зохино. Тохирлын үнэлгээ, гэрчилгээ, тэмдэг зэрэг нэр томьёог Дэлхийн Худалдааны байгуллагын /WTO/ Худалдаан дахь техникийн саад тотгорын тухай хэлэлцээрийн 1-р хавсралт, Олон улсын стандартчиллын байгуллага /ISO/ , Олон улсын цахилгаан техникийн комисс /IEC/ -ын арга зүйн удирдамжид заасны дагуу ойлгоно;

б/Засгийн газраас баталсан чанарын баталгаажуулалтад заавал хамрагдах барааны жагсаалт (цаашид "Жагсаалт" гэнэ)-д нэмэлт, өөрчлөлт оруулах саналыг "Бараат тодорхойлох, кодлох, уялдуулсан систем"-ийн дагуу холбогдох байгуллагуудтай хамтран боловсруулах;

в/сорилтын дүнг холбогдох стандартын дагуу үнэн зөв, зохих магадлалтайгаар тодорхойлох чадвартай нь тогтоогдсон лабораторид чанарын баталгаажуулалтын сорилт хийх эрх олгох /цаашид "итгэмжлэгдсэн лаборатори" гэнэ/;

г/барааны тохирлын үнэлгээг зохих стандарт, журмын дагуу гүйцэтгэх чадвартай нь тогтоогдсон байгуллагуудад барааны чанарын баталгаажуулалтын үйл ажиллагаа явуулах эрх олгох /цаашид "барааны баталгаажуулалтын байгуллага" гэнэ/;

д/гадаад орнуудтай тохирлын гэрчилгээтэйгээр харилцан нийлүүлэхээр тохиролцсон барааны жагсаалт, баталгаажуулалтын эрх бүхий байгуллага, итгэмжлэгдсэн лаборатори, тохирлын тэмдгийн

загвар, тэдгээрт гарсан өөрчлөлт, энэхүү журмын хэрэгжилтийн тухай мэдээллийг Улсын гаалийн ерөнхий газар болон хилийн мэргэжлийн хяналтын байгууллагуудад тухай бүр өгч байх;

е/шаардлагатай гэж үзсэн хилийн боомт, гүний гаальд энэхүү журмыг хэрэгжүүлэх зорилгоор чанарын баталгаажуулалтын албыг байгуулж, түүнд шаардагдах лабораторийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангахад дэмжлэг үзүүлэх.

5. Хилийн боомт болон гүний гааль дахь чанарын баталгаажуулалтын алба, уг алба байхгүй тохиолдолд чанарын баталгаажуулалтын ажилтан дараахь эрх, үүрэгтэй байна:

а/жагсаалтад орсон хилээр нэвтэрч буй бараанд чанар, хэрэглээний аюулгүй байдлын үзлэг хийж чанарын баталгаажуулалтын баримт бичгийн бүрдэлттэй танилцах;

б/чанар, хэрэглээний аюулгүй байдал, чанарын баталгаажуулалтын баримт бичгийн үзүүлэлт болон тохирлын гэрчилгээ, тэмдгийн зөрчилгүй импортын барааны тохирлын гэрчилгээ, экспортын барааны чанарын гэрчилгээг олгох;

в/чанарын баталгаажуулалтын баримт бичиг, тохирлын тэмдгийг хуурамчаар үйлдсэн, засварласан, чанар, хэрэглээний аюулгүй байдлын зөрчилтэй барааг гаалийн нутаг дэвсгэрт оруулах, гаргахаас татгалзах. Зөрчил нь баримтаар нотлогдсон тохиолдолд тухайн экспортлогч, импортлогчид хуулийн дагуу зохих хариуцлага хүлээлгэх;

г/чанарын баталгаажуулалтын зөрчилтэй бараанаас дээж авч итгэмжлэгдсэн сорилтын лабораторид шинжлүүлэх, тохирлын үнэлгээ хийх.

6. Чанарын баталгаажуулалтын ажилтан чанарын баталгаажуулалтын хэвлэмэл хуудас, тэмдэг, дүрэмт хувцас хэрэглэнэ.

7. Улсын гаалийн ерөнхий газар, хилийн болон гүний гаалийн байгууллага экспорт, импортын барааны чанарын баталгаажуулалтад дараахь эрх, үүрэгтэйгээр оролцоно:

а/жагсаалтад орсон экспортын бараг чанарын гэрчилгээгүйгээр улсын хилээр гаргахгүй байх;

б/жагсаалтад орсон импортын бараг "Бүтээгдэхүүнийг тохирлын үнэлгээнд хамруулах тухай мэдэгдэл" болон тохирлын гэрчилгээгүй бол хүлээн авагчид олгохгүй байх;

в/тохирлын үнэлгээ хийх, гаалийн үзлэг, шалгалт явуулах ажлыг зохих журмын дагуу уялдуулан зохицуулах.

8. Чанарын баталгаажуулалт хийхтэй холбогдон гарах зардлыг тухайн экспортлогч, импортлогч хариуцна.

9. Экспортын барааны олгосон чанарын гэрчилгээний нэг хувийг тээврийн дагалдах баримт бичигт хавсаргасан байна.

10. Экспорт, импортын барааны чанарын талаар чанарын баталгаажуулалтын ажилтны гаргасан дүгнэлт нь энэ хүрээнд үүссэн маргааныг шийдвэрлэх нотолгоо баримт болно.

Хоёр. Экспортын барааны чанарын баталгаажуулалт

1. Баталгаажуулалтын байгууллага нь тохирлын үнэлгээ явуулах талаар экспортлогчоос ирүүлсэн холбогдох материалыг хүлээн авч Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвийн Зөвлөлөөс батлагдсан "Бүтээгдэхүүн, үйлчилгээний чанарыг баталгаажуулах журам"-ын дагуу чанарын баталгаажуулалтыг хийнэ.

2. Экспортлогч нь жагсаалтад орсон

барааг экспортлохын өмнө дор дурдсан баримт бичгийг урьдчилан бүрдүүлж баталгаажуулалтын албанд ирүүлсэн байна:

а/чанарын гэрчилгээ хүссэн өргөдөл / энэ журмын 4 дүгээр хавсралтаар баталсан маягт/;

б/экспортын гэрээ, контрактын хуулбар;

в/хилийн боомт, хилээр гарах хугацаа, тээврийн хэрэгслийн тухай мэдүүлэг;

г/тохирлын гэрчилгээ, тэмдэг хэрэглэх эрх олгосон бол шийдвэрийн хуулбар;

д/итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүгнэлт (энэ журмын 2 дугаар бүлгийн 2-ын "г"-д дурдсан эрх олгогдоогүй тохиолдолд).

3. Баталгаажуулалтын алба экспортлогчоос ирүүлсэн дээрх материалыг үндэслэн энэхүү журмын 2 дугаар хавсралтад заасан чанарын гэрчилгээг экспортлогчид олгоно.

4. Чанарын гэрчилгээнд барааны кодыг "Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан систем" /БТКУС/-ийн зүйлийн түвшинд эхний 4 орноор бичнэ.

5. Чанарын удирдлага болон байгаль орчны удирдлагын тогтолцоо /ИСО 9000, 14000/-ны олон улсын стандартыг нэвтрүүлсэн аж ахуйн нэгж, экспортлогчдод энэ бүлгийн 1 ба 2 дугаар заалт хамаарахгүй бөгөөд тэдгээрт чанарын баталгаажуулалтын байгууллагаас чанарын гэрчилгээ хэрэглэх эрхийг тодорхой хугацаагаар олгоно.

Гурав. Импортын барааны чанарын баталгаажуулалт

1. Монголын импортлогч нь жагсаалтад орсон импортын барааны тухайн гадаадын экспортлогч орны баталгаажуулалтын эрх бүхий хөндлөнгийн байгууллагаас олгосон тохирлын гэрчилгээ, эсвэл итгэмжлэгдсэн лабораторийн сорилтын дүгнэлтийг заавал авсан байна. Монгол улсаас бүс нутгийн болон олон улсын байгууллага, худалдааны түнш орнуудтай байгуулсан гэрээ, хэлэлцээрийн дагуу хүлээн зөвшөөрөгдсөн тохирлын тэмдэгтэй барааны энэ заалт хамаарахгүй.

2. Баталгаажуулалтын байгууллага нь монголын импортлогчийн хүсэлтээр импортын бүтээгдэхүүнд үндэсний тохирлын тэмдэг хэрэглэх зөвшөөрлийг олгоно.

3. Баталгаажуулалтын алба жагсаалтад орсон импортын барааг хил, гүний гаальд ирмэгц зохих журмын дагуу тохирлын үнэлгээ хийж, тэнцсэн барааны энэ журмын 3 дугаар хавсралтад заасан тохирлын гэрчилгээг олгоно.

4. Баталгаажуулалтын алба нь чанар, хэрэглээний аюулгүй байдлын шаардлага хангаагүй, тохирлын гэрчилгээ нь зөрчилтэй импортын барааг гаалийн баталгаат агуулахад хадгалуулж тохирлын үнэлгээ хийх бөгөөд дүгнэлт гартал барааг борлуулахыг хориглоно.

5. Баталгаажуулалтын алба нь тохирлын үнэлгээнд тэнцээгүй импортын барааг хэрэх асуудлыг холбогдох байгууллагуудтай хамтран хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

6. Хилийн болон гүний гаальд баталгаажуулалтын алба, албан тушаалтан байхгүй бол тухайн аймгийн стандартчилал, хэмжил зүйн төв тохирлын үнэлгээ хийнэ.

7. Монгол Улсын үндэсний тохирлын тэмдэгтэй болон барааны чанарын баталгаажуулалтыг харилцан хүлээн зөвшөөрөх талаар Монгол Улс ба олон улс, бүс нутгийн байгууллага, худалдааны түнш орнуудтай байгуулсан гэрээ, хэлэлцээрээр тохирсон тохирлын гэрчилгээ, тохирлын тэмдэгтэй импортын барааны тохирлын үнэлгээ хийхгүй.

Чанарын баталгаажуулалтад заавал хамрагдах экспорт, импортын барааг хилээр нэвтрүүлэх, шалгах журмын 1 дүгээр хавсралт

СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ТӨВ

Барааг тохирлын үнэлгээнд хамруулах тухай мэдэгдэл

№

_____

(аж ахуйн нэгж, байгууллагын нэр)

-ийн ———————— улсаас———————————————-------

(чанарын баталгаа,холбогдох стандарт, баримт бичгийн нэр, дугаар)

-тайгаар 20... оны.....дугаар сарын....-нд оруулж ирсэн

_____

_____

_____

(барааны нэр, тоо хэмжээ, хэмжих нэгж)

нь холбогдох баримт бичигт заагдсан чанарын шаардлагыг хангаж байгаа тухай дүгнэлт гарч, "ТОХИРЛЫН ГЭРЧИЛГЭЭ" олгосны дараа худалдаанд нийлүүлэхийг зөвшөөрнө.

Тэмдэг Баталгаажуулалтын байгууллагын ажилтан

Гарын үсэг

Огноо

Чанарын баталгаажуулалтад заавал хавсаргах экспорт, импортын бараа хилээр нэвтрүүлэх, шилжүүлэх журмын 2 дугаар хавсралт

МОНГОЛ УЛС / MONGOLIA

Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төв

National center for standardization and metrology

ЧАНАРЫН ГЭРЧИЛГЭЭ / QUALITY CERTIFICATE

№

Худалдагч / Seller	Чанарын гэрчилгээ / Quality certificate № Хүчинтэй хугацаа / Valid Until
	Гэрээний дугаар / Contract №
Хүлээн авагч / Consignee	Худалдан авагч / Buyer
Гэрчилгээ олгосон байгууллага / Issued by	Гарал үүсэл, улсаар / Country of origin
Тээвэрлэлтийн мэдээлэл / Transport details	Стандартын дугаар / Standard №

Ачааны тэмдэглэгээ, Чингэлэг Shipping marks, Container №	Баглааны тоо, төрөл Number and kind of packing	Барааны нэр Denomination of goods	Барааны код Code of goods	Бохир жин Gross weight	Эзэлхүүн Cubage (m^3)
				Цэвэр жин Net weight	
				Тоо хэмжээ, хэмжих нэгж Quantity and unit	Үнийн дүн Value

Барааны чанарын тодорхойлолт

Quality description

Нийлүүлж байгаа барааны чанар нь стандарт болон гэрээний нөхцөлүүдтэй тохирч байна.

The quality of the delivered goods is in conformity with the standards and the condition of the contract.

Огноо/ Date

Баталгаажуулалтын байгууллагын удирдах албан тушаалтны нэр, гарын үсэг

тэмдэг
(stamp)

Name and signature of chief officer of the certification body

Чанарын баталгаажуулалтын экспертийн нэр, гарын үсэг

Name and signature of quality certification expert

Чанарын баталгаажуулалтад заавал хатгагдах экспорт, импортын барааг хилээр нэвтрүүлэх, шалгах журмын 3 дугаар хавсралт

СТАНДАРТЧИЛАЛ, ХЭМЖИЛ ЗҮЙН ҮНДЭСНИЙ ТӨВ
ТОХИРЛЫН ГЭРЧИЛГЭЭ

№

CERTIFICATE OF CONFORMITY

_____

(аж ахуйн нэгж, байгууллагын нэр)

-ийн улсаас

_____

(чанарын баталгаа, холбогдох стандарт, баримт бичгийн нэр, дугаар)

_____

-тайгаар 20... оны.....дугаар сарын....-нд оруулж ирсэн

_____

_____

(барааны нэр, тоо хэмжээ, хэмжих нэгж)

нь холбогдох стандарт, техникийн зохицуулалтын шаардлагыг хангаж байгаа тул тохирлын гэрчилгээ олгов.

Энэхүү гэрчилгээ нь тухайн бүтээгдэхүүний холбогдох стандарт, техникийн баримт бичиг болон түүний сав, баглаа боодол, хаяг, шошгон дээр заасан хэрэглээний баталгаат хугацааны дотор хүчинтэй бөгөөд хадгалах нөхцөлийг зөрчиж чанар байдлаа алдсан бүтээгдэхүүнд хамаарахгүй болно.

Баталгаажуулалтын байгууллагын удирдах албан
тушаалтны нэр, гарын үсэг

тэмдэг

Баталгаажуулалтын байгууллагын экспертийн нэр,гарын үсэг

Чанарын баталгаажуулалтад заавал хатгагдах экспорт, импортын барааг хилээр нэвтрүүлэх, шалгах журмын 4 дүгээр хавсралт

Экспортлогч (Exporter)	**Чанарын гэрчилгээ хүссэн өргөдөл** (Application for quality certificate)	
	Гэрээний дугаар (Contract №)	Он, сар, өдөр (Date)
Хүлээн авагч (Consignee)	Худалдан авагч (buyer)	
	Гарал үүсэл улсаар (Country of origin)	
Тээвэрлэлтийн мэдээлэл (Transport details)	Стандартын дугаар (Standard №)	

Барааны нэр (Denomination of goods)		
Барааны код (Code)	Тоо хэмжээ, хэмжих нэгж (Quantity and unit)	Үнийн дүн (Value)

Хэрэв бараа нь тохирлын тэмдэгтэй бол (If the goods have Mark of conformity:)

Түүнийг олгосон Баталгаажуулалтын байгуулагын нэр, код (Name of certification body and its code)	Тохирлын гэрчилгээний дугаар, олгосон огноо (№ and date of conformity certificate)

Хавсаргасан баримт (Attached documents)

1.

2.

3.

4.

5.

Хянасан: Чанарын баталгаажуулалтын

эксперт.....(.....)
(нэр, гарын үсэг)

Танилцсан:

Баталгаажуулалтын албаны
удирдах албан тушаалтан
.....(.....)
(нэр, гарын үсэг)

Өргөдөл гаргасан:
Байгуулагын нэр.....
Албан тушаалтны нэр.....
Гарын үсэг
Харилцах утас: .....
Огноо .....

Огноо .....

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 3 дугаар сарын 13-ны өдөр **Дугаар 46** **Улаанбаатар хот**

Арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай

2001 оныг Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих жил болгосонтой холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "2001 оныг Үндэсний үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх жил болгох тухай" Засгийн газрын 2000 оны 203 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 1 дүгээр, дээрх төлөвлөгөөнд заасан арга хэмжээг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, хяналт тавих Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус батлсугай.

2. Үйлдвэр, худалдааны сайд бөгөөд Үндэсний зөвлөлийн дарга Ч.Ганзориг даалгах нь:

а/үйлдвэрлэлийг дэмжих, экспортыг нэмэгдүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж ажиллах;

б/үйлдвэрлэлд гааль, татварын бодлогоор дэмжлэг үзүүлж, стратегийн ач холбогдолтой болон экспортын чиглэлийн үйлдвэрүүдийн жагсаалтыг 2001 оны 4 дүгээр сард багтаан гаргаж Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэх;

в/үндэсний үйлдвэрийн бүтээгдэхүүнийг дотооддоо борлуулах боломж, зах зээлийнн судалгаа гаргаж, холбогдох яам, газруудтай хамтран шийдвэрлэх арга хэмжээ авах;

г/үйл ажиллагаа нь харилцан уялдаатай үйлдвэрүүдийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, борлуулалтын уялдааг сайжруулах чиглэлээр үйлдвэр, аж ахуйн нэгжүүдтэй хамтран ажиллаж, үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Экспортын үйлдвэрлэлийг дэмжих хөтөлбөрийг батлах тухай" Засгийн газрын 1998 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн 158 дугаар тогтоолын 2 дугаар заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД **Ч.ГАНЗОРИГ**

Засгийн газрын 2001 оны 46 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН "2001 ОНЫГ ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ, ХӨГЖҮҮЛЭХ ЖИЛ БОЛГОХ ТУХАЙ" 203 ДУГААР ТОГТООЛЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хийж гүйцэтгэх ажлууд	Хугацаа	Хариуцах эзэн
1.	Дотоодын үйлдвэрлэгчдэд түүхий эд худалдан авах, бэлтгэхэд нь санхүү, зээлийн дэмжлэг үзүүлэх арга хэмжээний төслийг боловсруулж Засгийн газрын хуралдаанд оруулах.	3 –р сар	Ч.Ганзориг Д.Насанжаргал Б.Жигжид Ч.Улаан
2.	Түүхий эдийн нөөцийн сан байгуулах асуудлыг судалж, санал боловсруулан холбогдох байгууллагуудтай хамтран шийдвэрлэх арга хэмжээ авах	жилдээ	Ч.Улаан Ч.Ганзориг Д.Насанжаргал
3.	"Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль", "Гаалийн тарифын тухай хууль"-д орсон өөрчлөлттэй уялдуулан гадаадын хөрөнгө оруулалтын тэргүүлэх чиглэлийг тогтоож, стратегийн ач холбогдолтой болон экспортын үйлдвэрлэлийн салбар, түүнд хамаарах тоног төхөөрөмжийн жагсаалт гаргаж Засгийн газрын хуралдаанд оруулах	3 –р сар	Ч.Улаан Ч.Ганзориг Д.Насанжаргал Б.Жигжид

4.	Мал аж ахуйн гаралтай түүхий эдийг экспортлох журам боловсруулж, Засгийн газрын хуралдаанд оруулж батлуулан мөрдүүлэх арга хэмжээ авах	2-р сар	Ч.Ганзориг Ч.Улаан Д.Насанжаргал
5.	Хивсний үйлдвэрүүдээс Австри Улсад төлөх өрийн асуудлыг шийдвэрлэх	3 –р сар	Ч.Улаан Ч.Ганзориг
6.	Даатгалын үйлчилгээг олон улсын стандартад нийцүүлэх арга хэмжээ авах.	4 -р сар	Ч.Улаан
7.	Улсын үйлдвэрийн газрыг Компанийн хэлбэрт оруулах, түүний бие даан ажиллах нөхцөлийг бүрдүүлэх чиглэлээр Компанийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулж, Засгийн газар, УИХ-д өргөн барих.	10 –р сар	Ч.Улаан Б.Жигжид Ц.Нямдорж
8.	Геологи хайгуулын ажилд ихээхэн хэмжээний хөрөнгө гаргадаг хөрөнгө оруулагчдыг тогтвортой байдлын гэрээнд хамруулах, эрх зүйн орчныг бүрдүүлэх	5 –р сар	Ч.Улаан Ч.Ганзориг
9.	Үйлдвэрлэл, экспортыг нэмэгдүүлэх зорилгоор дор дурдсан хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулж холбогдох байгууллагуудад тавьж шийдвэрлэх арга хэмжээ авах:		
	а/ Хүн амын орлогын албан татварын тухай хууль	3 –р сар	Ч.Ганзориг Д.Насанжаргал Ч.Улаан Ц.Нямдорж
	б/ Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль	4-р сар	Ч.Ганзориг Д.Насанжаргал Ч.Улаан Ц.Нямдорж
	в/ Татварын ерөнхий хууль	10 –р сар	Ч.Улаан Ч.Ганзориг Д.Насанжаргал Б.Жигжид Ц.Нямдорж
	г/ Санхүүгийн түрээсийн тухай хууль	4 –р сар	Ч.Улаан Ц.Нямдорж
	д/ Үнэт цаасны тухай хууль	7-р сар	Ч.Улаан Ч.Ганзориг Д.Насанжаргал Ц.Нямдорж
	е/ Ашигт малтмалын тухай хууль	8-р сар	Ч.Ганзориг У.Барсболд Ц.Нямдорж
	ж/ Газрын хэвлийн тухай хууль	10-р сар	У.Барсболд Ч.Ганзориг Д.Насанжаргал Ц.Нямдорж
	з/ Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль	5-р сар	Ч.Ганзориг Д.Насанжаргал Б.Жигжид Ч.Улаан Ц.Нямдорж
	и/ Импортын гаалийн татварын тухай хууль	6-р сар	Ч.Ганзориг Д.Насанжаргал Б.Жигжид Ч.Улаан Ц.Нямдорж
10.	"Хөрөнгө оруулалтын тухай хууль"-ийн төслийг боловсруулан Засгийн газар, Улсын Их Хуралд өргөн барьж шийдвэрлүүлэх	4 –р сар	Ч.Ганзориг Ч.Улаан Д.Насанжаргал Б.Жигжид Ц.Нямдорж
11.	2001 оныг үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх жил болгон зарласантай холбогдуулан авах арга хэмжээний биелэлт, үр дүнг сурталчилах	жилдээ	Үндэсний зөвлөл

12.	Үйлдвэрлэлийг дэмжих, хөгжүүлэх жилийн арга хэмжээг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл болон бусад арга хэмжээтэй уялдуулан хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	жилдээ	Үндэсний зөвлөл
13.	2001 онд хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүнгийн зөвлөлдөх уулзалт зохион байгуулах	12-р сар	Үндэсний зөвлөл
14.	Ажлын багийн хурлыг зохион байгуулах арга хэмжээ авч, арга хэмжээний төлөвлөгөөний гүйцэтгэлд дүгнэлт өгч, цаашид авах арга хэмжээг нарийвчлан тодотгож ажиллах	Улиралд нэг удаа	Үндэсний зөвлөл
15.	2001 онд хийж гүйцэтгэсэн ажлын дүнг Засгийн газарт тайлагнах	2002 оны 1-р сар	Үндэсний зөвлөл

Засгийн газрын 2001 оны 46 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ҮЙЛДВЭРЛЭЛИЙГ ДЭМЖИХ, ХӨГЖҮҮЛЭХ БОДЛОГЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ, ЗОХИЦУУЛАХ, ХЯНАЛТ ТАВИХ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	-Үйлдвэр, худалдааны сайд
Орлогч дарга	-Хүнс, хөдөө аж ахуйн сайд
Гишүүд:	-Санхүү, эдийн засгийн дэд сайд; -Дэд бүтцийн дэд сайд; -Гадаад хэргийн дэд сайд; -Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд; -Байгаль орчны яамны Төрийн нарийн бичгийн дарга; -Шинжлэх ухаан, технологийн үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга; -Үйлдвэр, худалдааны яамны Геологи, эрдэс баялгийн бодлого, зохицуулалтын газрын дарга; -Үйлдвэр, худалдааны яамны Худалдааны бодлого, хамтын ажиллагааны газрын дарга; -Хүнс, хөдөө аж ахуйн яамны Стратегийн төлөвлөлт, нэгдсэн бодлогын газрын дарга; -Хүнс, хөдөө аж ахуйн яамны Бодлого, зохицуулалтын газрын дарга; -Санхүү, эдийн засгийн яамны Салбарын хөгжлийн удирдлага зохицуулалтын газрын дарга; -Монгол банкны тэргүүн дэд ерөнхийлөгч (тохиролцсоноор); -Монголын худалдаа, аж үйлдвэрийн танхимын захирал (тохиролцсоноор); -Үндэсний үйлдвэрлэгчдийн холбооны дарга (тохиролцсоноор); -Монголын ноос, ноолуурын холбооны тэргүүн (тохиролцсоноор).
Нарийн бичгийн дарга	-Үйлдвэр, худалдааны яамны Үйлдвэрийн бодлого зохицуулалтын газрын дарга.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 3 дугаар сарын 13-ны өдөр **Дугаар 47** **Улаанбаатар хот**

Хөтөлбөр батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн "Мал сүргийг ган, зудаас хамгаалах тогтолцоо, гамшгийн туслажийн сүлжээ бүрдүүлэх" зорилтыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Мал сүргийг ган, зудаас хамгаалахад туслах үндэсний хөтөлбөр"-ийг 1 дүгээр хавсралт, хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 2 дугаар хавсралт ёсоор тус тус батлсугай.

2. Хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон арга хэмжээ, зардлыг 2001 оноос эхлэн жил бүрийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвөт тусган хэрэгжүүлж байхыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Мал хамгаалах санг бүрдүүлэх, захиран зарцуулах, тайлагнах тухай журмыг Санхүү, эдийн засгийн яамтай, Ган, зудын үнэлгээ хийх журам, хэрэглээ аргачлалыг Байгаль орчны яам болон холбогдох эрдэм шинжилгээний байгууллагатай хамтран боловсруулж энэ оны Ш улиралд багтаан Засгийн газарт оруулж хэлэлцүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргалд даалгасугай.

4. Бэлчээр ашигласны төлбөр, хувийн мал бүхий иргэдээс авах орлогын албан татварын зохих хэсгийг мал хамгаалах санд төвлөрүүлэн ашиглахтай холбогдуулан холбогдох хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг боловсруулж 2001 оны 6 дугаар сард багтаан Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт үүрэг болгосугай.

5. Хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүрийн 10 дугаар сард багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргалд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД **Д.НАСАНЖАРГАЛ**

Засгийн газрын 2001 оны 47 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

МАЛ СҮРГИЙГ ГАН, ЗУДААС ХАМГААЛАХАД ТУСЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР

Нэг. Нийтлэг үндэслэл

Ган, зудын байдал, түүний давтамж

1. Бэлчээрийн мал аж ахуй нь олон зууны туршид монголчуудын нүүдлийн амьдралын гол хэв маяг, эдийн засгийн үндэсэн салбар байсаар ирсэн бөгөөд байгалийн гамшигт өртөх магадлал ихтэй байдаг онцлогтой. Монгол орны бэлчээрт одоогоор тогтоогдоод буй 2600 гаруй ургамлаас 600 гаруй нь малын тэжээлийн үндсэн хэрэгцээг хангадаг. Хангайн өндөр уулын бэлчээрийн ургац зуншлага сайтай жилүүдэд олон жилийн дундаж ургацаас 26-38 хувиар ихсэж, гантай жилүүдэд 12-48 хувиар багасч байхад цөлөрхөг хээрийн бэлчээрийн ургац зуншлага, ургац сайтай жил 23.1-58.3 хувиар нэмэгдэж, гантай жилүүдэд 28-60.3 хувиар багасдаг байна.

Бэлчээрийн ургамлын шимт чанар өвөл, хаврын улиралд зуныхаас 2-3 дахин, шингэх протеин 3-4 дахин буурдаг байна. Өвөл, хаварт мал хоногт шаардагдах тэжээлийнхээ дөнгөж 40-50 хувийг бэлчээрээс авдаг. Ган, зудтай жилүүдэд бэлчээрийн даац хэвийн жилийнхээс 23-39 хувиар буурч, мал аж ахуйн үйлдвэрлэлд багагүй хохирол үзүүлсэрэ ирсэн юм.

2. Байгалийн гамшиг дотроос хамгийн их хохирол учруулдаг нь ган, зуд юм. Сүүлийн 60 жилийн судалгаанаас үзэхэд манай оронд ган, зудын давтамж богиносох хандлагатай болж, үлэмж хэмжээний хохирол учруулж, түүнэн сургамж үлдээсэн байна:

Ган, зудаас мал аж ахуйд учирсан хохирол

Он	Жил	Гамшгийн төрөл	Хамарсан нутаг дэвсгэр (%)	Малын хорогдол /сая.тол/ Том мал		Төл	
				Тоо	Хувь	Тоо	Хувь
1944-1945	Бич, тахиа жил	Ган-зуд	9 аймгийн 65 хувь	8.1	33.2	1.1	17.0
1954-1955	Морь, хонь жил	Зуд	9 аймаг	1.9	8.2	0.3	4.0
1956-1957	Бич, тахиа жил	Зуд	11 аймаг	1.5	6.2	0.9	12.0
1967-1968	Хонь, бич жил	Ган-зуд	13 аймгийн 80 хувь	2.7	11.9	1.7	21.6
1976-1977	Луу, могой жил	Зуд	15 аймгийн 116 сумын 90 хувь	2.0	8.6	1.6	10.7
1986-1987	Туулай, луу жил	Зуд	11 аймгийн 198 сумын 80 хувь	0.8	3.6	0.9	9.0
1993	Тахиа жил	Зуд	Завхан, Баянхонгор, Говь-Алтай аймгийн 30 сум	1.6	6.4	1.2	13.0
1996-1997	Хулгана, үхэр жил	Зуд	11 аймгийн 39 сум зудтай, 12 аймгийн 30 сум зудархуу	0.6	2.1	0.5	5.4
1999-2000	Туулай, луу жил	Ган-зуд	12 аймгийн 157 сум	3.0	8.9	1.2	12.1

Хөтөлбөр боловсруулах шаардлага

3. Дэлхийн уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр сүүлийн жилүүдэд төв Азийн эрс тэс уур амьсгалтай манай оронд байгалийн гамшиг, түүний дотор ган, зудын давтамж ойртож, эдийн засаг, нийгэмд ихээхэн хохирол учруулж байна.

Иймд эдийн засгийн үндсэн салбар болох мал аж ахуйг ган, зудаас сэргийлэн хамгаалах, байгалийн гамшиг тохиолдсон үед хүн хүч, хөрөнгө санхүүгийн нөөцийг зөв зохистой ашиглах, учирсан хохирлыг нөхөн хангахад баримтлах бодлогыг тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээний тогтолцоог бүрдүүлэх үүднээс энэхүү хөтөлбөрийг боловсруулав.

Хөтөлбөрийг боловсруулахдаа 1944-2000 онуудад ган, зуд тохиолдсон үед Засгийн газар, аймаг, сумаас авч хэрэгжүүлж байсан зохион байгуулалт, үйл ажиллагааг хийсэн дүгнэлт, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн санаачилга, дэмжлэгээр зохион байгуулсан "1999-2000 оны зудын сургамж" судалгааны зөвлөмж, эрдэмтдийн дүгнэлт санал, малчдын гамшигийг гэтлэн давдаг туршлага зэргийг үндэслэл болгов.

Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт

4. Хөтөлбөрийн зорилго. Мал сүргийг ган, зудаас сэргийлэн хамгаалах, ган, зуд тохиолдсон үед аяз арга хэмжээ болон үчирсан хохирлыг нөхөх тогтолцоог боловсронгуй болгож, тусламжийн сүлжээг бүрдүүлж, малчид, мал бүхий иргэд болон бүх шатны төрийн захиргааны байгууллагуудын үүрэг хариуцлагыг тодорхойлж, мал аж ахуйн үйлдвэрлэлийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэсэн бодлого, зохицуулалт, дэмжлэг тусламжийг үзүүлэхэд хөтөлбөрийн зорилго оршино.

5. Хөтөлбөрийн зорилт. Хөтөлбөрийн зорилгыг дараахь зорилтуудаар хэрэгжүүлнэ:

Нэгдүгээр зорилт - Бэлчээрийн мал аж ахуйг байгалийн болзошгүй ган, зудаас урьдчилан сэргийлэх, аль болох хохирол багатай даван туулах бэлтгэл хангахад малчид, мал бүхий иргэд, аж ахуйн нэгж болон бүх шатны төрийн захиргааны байгууллагуудын гүйцэтгэх үүргийг тодорхойлж, хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Хоёрдугаар зорилт - Ган, зудын нөхцөл байдалд үнэлгээ өгч, түүнийг хохирол багатай даван туулах үйл ажиллагаа, зохион байгуулалтын оновчтой хэлбэрийг тогтоож, гамшигийн тусламжийн сүлжээ бий болгож хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлнэ.

Гуравдугаар зорилт - Ган, зудын улмаас эдийн засаг, малчид, мал бүхий иргэдэд үчирсан хохирлын хэмжээг тогтоон, түүнийг богино хугацаанд нөхөх удирдлага зохион байгуулалтын бүтцийг бүрдүүлж, ажиллах нөхцөлийг сайжруулна.

Гурав. Хөтөлбөрийн зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа, үндсэн чиглэл

6. Ган, зудаас мал сүргийг урьдчилан сэргийлэх, хамгаалах талаар малчид, мал бүхий иргэд, бүх шатны төрийн захиргааны байгууллагын түвшинд явуулах үйл ажиллагааны чиглэлийг доорхи байдлаар тодорхойлж, хүлээх үүрэг, хариуцлагын нарийн хуваарьтайгаар энэхүү хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.

7. Хөтөлбөрийн 1 дүгээр зорилтыг дараахь үйл ажиллагаагаар хэрэгжүүлнэ:

8. Малчдын зүгээс хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

8.1. Бэлчээрийг улирлаар хуваарьтай ашиглах, ялангуяа зун, намрын улиралд өвөлжөө, хаваржааны бэлчээрийг малын хөлөөс хамгаалах, түүний даацыг хэтрүүлж талхлахгүй байх, бэлчээрийг сайжруулах, нөхөн сэргээх, худаг, уст цэг, хашаа хороогоо засч сэлбэх, дулаалах, мал сүрэгтэх тарга хүч авахуулах зэргээр мал өвөлжүүлж, хаваржуулах бэлтгэлийг биеэ даан хангах;

8.2. Байгалийн болзошгүй ган, зудын аюулаас хамгаалах зорилгоор нэг хонин толгойд ойт хээрт 30 кг, өндөр уул, тал хээрийн бүсэд 10 кг, говийн бүсэд 3 кг-аас доошгүй нэмэгдэл тэжээлээр тэжээх өвс, түүнчлэн гар тэжээл, хужирын нөөцийг өөрсдийн хүч, хөрөнгөөр заавал бүрдүүлэх;

8.3. Мал сүргээ зохих хууль тогтоомжийн дагуу даатгалд хамруулах;

8.4. Цаг агаарын мэдээ, мэдээллийг мал аж ахуйн үйлдвэрлэлийн өдөр тутмын үйл ажиллагаанд бүтээлчээр ашиглаж хэвших;

8.5. Мал аж ахуйн үйлдвэрлэл, үйл ажиллагаат бусад малчидтай хорших, хамтын хөдөлмөр эрхлэх замаар хэрэгжүүлж хэвших;

8.6. Мал сүргийг ган, зудаас хамгаалах сумын санд жил бүр тодорхой хэмжээний хувь нэмэр оруулах.

9. Сум, багийн Засаг дарга, түүний Тамгын газар:

9.1. Сум бүр нэг хонин толгойд хоногт 1 кг-аас доошгүй өвсөөр тооцон нийт малыг 3-аас доошгүй хоног нэмэгдэл тэжээлээр тэжээх, сумын аюулаас хамгаалах өвс, тэжээлийн нөөцийг энэ жилээс эхлэн үе шаттайгаар хангаж, 2004 он гэхэд бүрэн бүрдүүлсэн байх;

9.2. Бэлчээр нутгийг малчдад эзэмшүүлэх, улирлаар хуваарьтай ашиглах ажлыг батлагаажуулан, өвөлжөө, хаваржааны бус нутаг нутаглах хугацаанд нарийвчлан тогтоож мөрдүүлэх;

9.3. Бэлчээрийн даац багтаамжийг жил бүрийн 8 дугаар сард багтаан баг бүрээр тогтоож, түүнд тулгуурлан мал өвөлжилт, хаваржилтын өрөнхий төлөвлөгөө боловсруулж, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар батлуулан хэрэгжүүлэх, бэлчээрийн хортон мэрэгчид устгах, хадлан тэжээл бэлтгэж сум, багийн нөөц бий болгох ажлыг цэргийн дүйцүүлэх албаны шугамаар хэрэгжүүлэх;

9.4. Дотоод нөөц бололцоог ашиглан гол, горхи, бороо, цасны усыг тогтоож бэлчээр, хадлангийн талбайг услах, хаших, чулуут цэвэрлэх, малын шивх, буудаар бордох замаар бэлчээр, хадлангийн үргацыг нэмэгдүүлэх ажлыг төлөвлөгөөтэйгээр хэрэгжүүлэх;

9.5. Малын тэжээл үйлдвэрлэлийн хувийн жижиг цех байгуулж, түүнийг түүхий эдээр хангах ажлыг иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санаачилгад тулгуурлан зохион байгуулж, дэмжлэг, тусламжаа үзүүлэх;

9.6. Малчдын хамтын хүчээр бэлчээрт худаг, уст цэгийг шинээр гаргах, засварлах, эзэмшилт, ашиглалтыг сайжруулах ажлыг зохион байгуулах, ашиглалтгүй зэлүүд бэлчээрийг ашиглахыг дэмжиж урамшуулах;

9.7. Хээлтэгч, хээлтүүлэгч малын зохистой тохироог бүрдүүлж 2003 оноос эхлэн эвэхэн батлагаажсан хээлтүүлэгчийг үржилд ашиглах замаар мал сүргийн чанарыг сайжруулах;

9.8. Мал эмнэлгийн урьдчилан сэргийлэх арга хэмжээ, ялангуяа паразиттаг өвчний эсрэг авах арга хэмжээний үр дүнг дээшлүүлж, малаа хамуу өвчнөөс, үхрийг гуртах өвчнөөс 2001 онд багтаан эрүүлжүүлэх;

9.9. Малчид, мал бүхий иргэд, аж ахуйн нэгж, байгууллага бүрээр өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг 10 дугаар сарын 1-ний дотор бүрэн хангуулан шалгаж, хүлээн авч хэвших;

9.10. Мал сүргийг даатгалд хамруулах зохион байгуулалтын арга хэмжээ авч, хэлэлцэл хийж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

9.11. Бусад сумдын удирдлагатай мал оторлолт, бэлчээр ашиглалтын гэрээ, хэлцэл хийж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;

9.12. Малчдыг нүүлгэн шилжүүлэх үед дамжин өнгөрүүлэх түр цэг байгуулж, оторт явааа малчдад эрүүл мэндийн үзлэг, шинжилгээ, эм хангамж, худалдаа, соёлын үйлчилгээ үзүүлэх нөхцлийг бүрдүүлж ажиллах;

9.13. Зудтай нөхцөлд цас арилгах, зам чөлөөлөх техник хэрэгслийг малчдаар бэлтгүүлэх, сум, багтаа шатах тослох материал, хөрөнгө санхүүгийн зохих нөөцтэй болсон байх;

9.14. Малчдын дунд хоршоо, нөхөрлөл, фермийн аж ахуй байгуулахын ач холбогдлыг сурталчлах, урамшуулан дэмжих.

10. Аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний Тамгын газар:

10.1. Бэлчээрийн эдэлбэр газрын зээмшилт, ашиглалтыг сайжруулан, хадлангийн хэмжээг нэмэгдүүлж, нэг хонин толгойд хоногт 1 кг өвсөөр тооцож нийт малыг 3-аас доошгүй хоног нэмэгдэл тэжээлээр тэжээх өвс, тэжээлийн аймгийн аюулгүйн нөөцийг 2001 оноос эхлэн жил бүр заавал бүрдүүлсэн байх;

10.2. Хадлангийн талбай багатай аймгууд гар тэжээл болон биологийн гаралтай тэжээл бэлтгэлийн хэмжээг нэмэгдүүлэх, хангайн бүсийн аймаг, сумдтай хоршин ажиллах асуудлыг судлан хэрэгжүүлэх;

10.3. Шинээр барих хашаа байрны зураг төсөл, түүнд тавигдах шаардлагыг орон нутгийн байгаль, цаг уурын онцлогт тохируулан боловсруулж, малчдад зөвлөмж болгон хэрэгжүүлэх;

10.4. Аймаг, сум дундын отрын нөөц нутгийн хил, даац багтаамжийг тогтоож, хамгаалалтад авч зохистой ашиглах, мал сүргийг өөр аймаг, сумын нутагт оторлох, өвөлжүүлэх гэрээ хэлцлийг тухайн аймгийн удирдлагатай зохицон хамтарч ажиллах;

10.5. Бэлчээр усжуулах өрөнхий төлөвлөгөө боловсруулж, аймгийнхаа төсөв, хамтын хүч, хандивын хөрөнгөөр худаг ус гаргах ажлыг хэрэгжүүлэх;

10.6. Мал сүргийг ган, зудаас хамгаалах арга ажиллагааны талаар хашир туршлагатай малчдын арга ажиллагаат залуу малчид, өсвөр үеийнхэнд зээмшүүлэх, зааж сургах ажлыг тусгай хөтөлбөрийн дагуу зохион байгуулж хэрэгжүүлэх;

10.7. Ган, зудын үед шаардагдах унаа,

бензин шатахуун, эм бэлдмэл, тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангах, малчдын дунд эрүүл мэнд, нийгмийн хамгааллын чиглэлээр авах арга хэмжээ, ажил, үйлчилгээний төлөвлөгөөг урьдчилан боловсруулж хэрэгжүүлэх бэлтгэлийг хангасан байх;

10.8. Цасанд хаагдсан зам, дабааны цас арилгах, зам гаргах хөдөлгөөнт түр отряд зохион байгуулан ажиллуулж байх.;

10.9. Төв, суурин газарт шилжин ирж буй иргэдийн хөдөлгөөнийг уян хатан зохицуулах, ажлын байраар хангах арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

11. Хүнс, хөдөө аж ахуйн яам:

11.1. Мал сүргийг ган, зудаас хамгаалахад туслах хууль эрх зүйн орчинг бүрдүүлэх арга хэмжээг хууль зүйн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран боловсруулж шийдвэрлэх;

11.2. Бүсүүдэд аймаг дундын отрын нутаг бий болгох асуудлыг судлан, хил хязгаарыг тогтоох, зохистой ашиглах болон ган, зудын нөхцөл байдалд үнэлгээ хийх журам, хэрэглэх аргачлалыг бэлтгэлийн орчны яамтай хамтран боловсруулж мөрдүүлэх;

11.3. Аймаг, сумын аюулаас хамгаалах сан бүрдүүлэх чиглэлээр бодлого, үйл ажиллагааны дэмжлэг туслалцаа үзүүлэх;

11.4. Шинээр гаргах, засварлах уст цэг, бэлчээрийн хортон мэрэгч, шавьжтай тэмцэх, улсын нөөцийн өвс, тэжээлийн хэмжээг нэмэгдүүлэх зэрэг асуудлыг судлан боловсруулж, шаардагдах хөрөнгийг улсын төсөрсөн төсөвт тусгуулах арга хэмжээ авах;

11.5. Ган, зудын давтамж ихтэй болон отрын бүс нутгийн бэлчээрийн даац тодорхойлох ажлыг хийх;

11.6. Бэлчээрийн үргац, даац багтаамжийг аймаг бүрээр жил бүрийн 9 дүгээр сард багтаан тодорхойлж, шаардлагатай нөхцөлд малчид нүүн отроор өвөлжих, хаваржих, бэлчээр нутгийн асуудлыг зохицуулах;

11.7. Улсын нөөцийн өвс, тэжээлийн цэг, салбаруудын тоог нэмэгдүүлэн зөв байршуулах, хүчин чадлыг сайжруулах асуудлыг боловсруулан шийдвэрлүүлж 1 хонин толгой 1 кг өвсөөр тооцон нийт малын 25 хувийг 3-аас доошгүй хоног тэжээх өвс, тэжээлийн нөөцийг 2001 оноос эхлэн бүрдүүлэх;

11.8. Улсын нөөцөд удаан хадгалах боломжтой, өвөр багатай, уураг, энергийн агуулламж ихтэй тэжээлийн үргамал (шар буурцаг, вандуй, эрдэнэ шиш, овъёос, цагаан гэх мэт)-ыг улсын захиалга даалгаврааар тариалах, түүнд шаардагдах хөрөнгийг зээл, төсөл, хөрөнгө оруулалтын бодлогоор дэмжих ажлыг 2002 оноос эхлэн хэрэгжүүлэх;

11.9. Тухайн жилийн байгаль, цаг уурын урьдчилсан тойм, бэлчээрийн даацыг харгалзан зах зээлийн эрэлт хэрэгцээтэй уялдуулан мал сүргийн зохих хэсгийг бэлтгэж бүтээгдэхүүн хэлбэрээр дотоод, гадаадын зах зээлд борлуулах асуудлыг зохицуулах;

11.10. Өвс, тэжээл бэлтгэх шинэ техник технологийг гадаадын төсөл хөтөлбөртэй уялдуулан хэрэгжүүлэх;

11.11. Аймгийн Засаг даргаас тавьсан санал хүсэлтийг үндэслэн мэргэжлийн хэсэг томилон ган, зуд болсон эсэх, түүний зэрэгтэлэн, хамрах хүрээг тогтоож, цагийн байдалтай холбогдуулан авах арга хэмжээг боловсруулж шийдвэрлүүлэх;

11.12. Цаг агаарын урьдчилан сэргийлэх мэдээнд тулгуурлан мал аж ахуйн үйлдвэрлэлд үзүүлэх сөрөг нөлөөллийг тооцож, болзошгүй хохирлыг гэтлэн давах асуудлыг холбогдох яамдтай хамтран жил бүрийн 9 дүгээр сард багтаан боловсруулж, төв, орон нутгийн төрийн захиргааны байгууллагуудад хүргэн хэрэгжүүлэх;

11.13. Ган, зудаас урьдчилан сэргийлэх, учирсан хохирлыг нөхөх чиглэлээр холбогдох төрийн бус байгууллагуудтай гэрээтэй ажиллах;

11.14. Эрсдэл багатай аж ахуйн оновчтой хэлбэр, малын төрөл, тоо хэмжээний загварыг боловсруулж суртачлах.

12. Байгаль, орчны яам:

12.1. Ус, цаг уурын хүрээлэнгээс жил бүрийн 4, 8 дугаар сард гаргадаг зун, өвлийн цаг агаарын урьдчилсан төлөв байдлын тухай мэдээллийг найдвартай болгож, ган, зуд болох эсэхийг 6 сараас багагүй хугацааны (урьдчилан хамгаалах бэлтгэл хангаж болохуйц) өмнө аймаг, сумын нутаг дэвсгэрийн нарийвчлалтай гарган мэдээлэх;

12.2. Цаг агаарын аюултай үзэгдэл болон гамшгийн сэрэмжлүүлэг, урьдчилан сэргийлэх мэдээг тусгай сэрэх дохиогоор холбоо, мэдээллийн бүх хэрэгслээр байнга шуурхай дамжуулан мэдээлэх;

12.3. Уур амьсгалын өөрчлөлт, түүнээс мал сүргийг хамгаалах чиглэлээр төв, орон нутгийн мэдээллийн хэрэгслийг ашиглан малчид, мал бүхий иргэдэд сургалт суртачилгаа явуулах.

13. Батлан хамгаалах яам:

13.1. Болзошгүй ган, зудын гамшгаас урьдчилан сэргийлэх, хохирлыг багасгах, ган, зудын үед ажиллах иргэний хамгаалалтын иж бүрэн болон команд штабын сургууль хийж дадлага олгох сургалт семинарыг төв, орон нутгийн төрийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгжийн удирдлагаар дамжуулж малчдад хүргэх ажлыг зохион байгуулах;

13.2. Ган, зудтай болох нь тогтоогдсон нөхцөлд холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн иргэний хамгаалалтын өндөржүүлсэн байдал зарлах, татан буулгах тухай журам боловсруулж мөрдүүлэх;

13.3. Ган, зудын үед ажиллах хүч хэрэгслийг иргэний хамгаалалтын тайван цагийн төлөвлөгөөний дагуу удирдан зохион байгуулах.

14. Санхүү, эдийн засгийн яам:

14.1. Ган, зудын болзошгүй эрсдэлээс хамгаалах зардлыг холбогдох яамны саналыг үндэслэн жил бүрийн улсын төсөвт тусгаж байх;

14.2. Усан хангамж хүрэлцээгүй отрын бүс нутагт уст цэг тогтоох эрэл хайгуул хийх, инженерийн хийцтэй худаг шинээр гаргах, засварлах, бэлчээрийн хортон мэрэгчидтэй тэмцэхэд шаардагдах нэмэлт хөрөнгийг холбогдох яам, аймгийн саналыг үндэслэн эхний эзлэнд жил бүрийн улсын төсөвт тусган хэрэгжүүлэх;

14.3. "Мал хамгаалах сан" байгуулах асуудлыг холбогдох яам, газруудтай хамтран боловсруулж, эрх зүйн орчин бүрдүүлэх үндэсэн дээр 2001 онд багтаан ажиллуулах;

14.4. Мал сүргийн даатгалын тогтолцоо бий болгож, олон улсын давхар даатгалд хамруулах асуудлыг зохицуулах.

15. Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам:

15.1. Залуу малчид, өсвөр үеийнхэнд мал аж ахуйн үйлдвэрлэлийг эрхлэн хөтлөх уламжлалт болон шинжлэх ухааны арга технологи, амьдрах ухааны сургах сургалтыг сумын сургуулийн баазад түшиглэн тусгай хөтөлберийн дагуу үе шаттайгаар зохион байгуулах;

15.2. Ган, зудыг прогнозлох, урьдчилан сэргийлэх, малын тэсвэрт чанарыг сайжруулах, бэлчээр ашиглалтыг дээшлүүлэх, малын тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх чиглэлийн Шинжлэх ухаан, техник, технологийн төслийг үе шаттай хэрэгжүүлэх.

16. Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам:

16.1. Ган, зудад нэрвэгдсэн хүн амын эдийн засаг, нийгмийн эмзэг байдлын үнэлгээг 2001 оноос эхлэн хийж, бодлого, стратегийг холбогдох яамдтай хамтран боловсруулж хэрэгжүүлэх.

17. Эрүүл мэндийн яам:

17.1. Ган, зудын давтамж өндөртэй бүс нутаг, сум, багийн эрүүл мэндийн байгууллагыг мэргэжлийн боловсон хүчин, шаардлагатай эм бэлдмэл, эмнэлгийн тоног төхөөрөмж, хэрэгсэл, дуудлагын машин, хөдөлгөөнт холбоогоор хангах арга хэмжээг энэ оноос эхлэн эхний ээлжинд зохицуулан хангах;

17.2. Ган, зудын үед үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, эм хангамжийн талаар орон нутгийн эрүүл мэндийн байгууллагуудад чиглэл, зөвлөмж өгч мөрдүүлэх.

18. Дэд бүтцийн яам:

18.1. Сум, багийн холбоог хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө боловсруулан эхний ээлжинд ган, зудын давтамж өндөртэй сум, багийг, цаашид бүх сум, багийг холбоожуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх;

18.2. Малчдыг жижиг радио хүлээн авагчаар хангах асуудлыг шийдвэрлэх.

19. Хөтөлберийн хоёрдугаар зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаа:

19.1. Ган, зуд тохиолдсон үед авч хэрэгжүүлэх арга хэмжээг "Иргэний хамгаалалтын тухай" хуулийн дагуу Улсын байнгын онцгой комисс эрхэлнэ. Улсын байнгын онцгой комиссын өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэх газар нь Улсын иргэний хамгаалалтын газар байна.

19.2. Улсын байнгын онцгой комисс нь ган, зудын хүрээнд үйл ажиллагаа явуулахдаа терийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагатай хамтран энэ хөтөлберийг хэрэгжүүлж ажиллана. Яам, агентлаг нь өөр өөрийн эрхэлсэн ажлын чиг үүргийн дагуу холбогдох мэдээллэн, судалгаагаар Улсын байнгын онцгой комиссыг ханган, холбогдох асуудлаар түүний өмнө үүрэг, хариуцлага хүлээнэ.

19.3. Ган, зуд тохиолдсон аймаг, нийслэлийн Байнгын онцгой комисс нь тухайн орон нутгийнхаа хэмжээнд ган, зудыг хамгийн хохирол багатай даван туулах зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Аймгийн Байнгын онцгой комисс нь Улсын онцгой комиссыг холбогдох мэдээллээр, сумын онцгой комиссыг удирдлагаар ханган ажиллана.

19.4. Ган, зуд тохиолдсон үед улс, аймаг, сумын нөөцөөс малчдад өвс, тэжээл, хүнсний болон ахуйн хэрэгслээний бараагаар туслах арга хэмжээ авч болно. Тэрхүү арга хэмжээ нь тухайн бараа, материалыг худалдах болон нөхөн бүрдүүлэх нөхцөлтэй байна.

19.5. Ган, зудын үед болон учирсан хохирлыг нөхөн барагдуулахад чиглэгдсэн дотоодын байгууллага, иргэдийн хандив, тусламж, гадаад орон, олон улсын байгууллага, иргэдийн хандив, тусламж, эд хөрөнгийг улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн онцгой комиссоор буюу тусламжийн сүлжээний шугамаар дамжуулан малчдад хүргэнэ. Тусламжийн бараа, материалын хүргэлт,

зарцуулалт, үр дүнгийн байдлыг аймаг, сумын Байнгын онцгой комисс нь Улсын байнгын онцгой комисст тайлагнах үүрэгтэй.

20. Хөтөлбөрийн гуравдугаар зорилтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаат Улсын байнгын онцгой комисс, бүх шатны төрийн захиргааны байгууллага хэрэгжүүлнэ:

20.1. Ган, зудад нэрвэгдсэн бүс нутаг, аймгийн нийгэм, эдийн засагт гарсан хохирлыг аймаг, нийслэлийн Байнгын онцгой комисс эрхлэн тооцож, түүнийг богино хугацаанд нөхөхтэй холбогдсон цогц арга хэмжээг төлөвлөн Улсын байнгын онцгой комисст ируулнэ;

20.2. Улсын байнгын онцгой комисс нь ган, зудын хохирлын нэгдсэн дүн, сургамж, цаашид авах арга хэмжээний санал (ган, зудын хохирлыг нөхөх, арилгахтай холбогдсон нэгдсэн төлөвлөгөө)-ыг холбогдох төрийн захиргааны төв байгууллагыг оролцуулан боловсруулж, Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэн шийдвэрлэнэ.

Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалт

21. Хөтөлбөр хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд удирдан зохицуулах, хяналт тавих үүргийг Хүнс, хөдөө аж ахуйн яам хариуцна:

21.1. Хүнс, хөдөө аж ахуйн яам нь:

а/ хөтөлбөрийг жил бүр нэгдсэн төлөвлөгөөтэйгээр удирдан зохион байгуулж, хяналт тавих, үр дүнг тооцох;

б/ хөтөлбөрт заасан арга хэмжээг хэрэгжүүлэх явцад яам, агентлагуудын ажлыг уялдуулан зохицуулах;

в/ хөтөлбөрт шаардагдах санхүүгийн эх үүсвэрийг тооцон Санхүү, эдийн засгийн яамаар батлуулах, хуваарилан зарцуулах, холбогдох байгууллагуудтай хамтран хянат тавих;

г/ хөтөлбөр хэрэгжүүлэх асуудлаар аймаг, нийслэлийн Засаг дарга, түүний Тамгын газрыг чиглэл, арга зүйгээр хангах.

21.2. Хүнс, хөдөө аж ахуйн яам нь хөтөлбөрийн хэрэжилтийг жил бүрийн 11 дүгээр сарын 1-ний дотор Засгийн газарт тайлагнаж байна.

Тав. Хөтөлбөрийн санхүүжилт

22. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор улс, аймаг, суманд "Мал хамгаалах сан" байгуулна. Сан нь дараахь санхүүгийн эх үүсвэрээс бүрдэнэ:

а/ улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвөөс жил бүр энэ хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд зориулж олгох хөрөнгө;

б/ гадаад орон, олон улсын байгууллагаас ган, зудаас хамгаалах, хохирлыг нөхөхтэй холбогдуулан олгож байгаа эзэн, тусламж;

в/ бэлчээр ашигласны болон мал аж ахуйн орлогын албан татварын тодорхой хэсэг;

г/ иргэд, аж ахуйн нэгж, төрийн бус байгууллагын хандив, тусламж.

Зургаа. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа, үе шат

23. Энэхүү хөтөлбөрийг 2001-2005 оныг дуустал хугацаанд хэрэгжүүлнэ.

24. Хүнс, хөдөө аж ахуйн яам Хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган, хэрэгжүүлэх үйл ажиллагаа нэг бүрийг хэрэгжих хугацаа, хариуцах байгууллага, эзэн, гарах хөрөнгийн эх үүсвэртэйгээр боловсруулж, Улсын байнгын онцгой комиссоор батлуулж мөрдүүлнэ.

Долоо. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр гарах үр дүн

25. Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараахь үр дүн гарна:

а/ мал сүргийг ган, зудаас хамгаалах эрх зүйн орчин боловсронгуй болно;

б/ мал сүргийг ган, зудаас хамгаалахад туслах тоготолоо, тусламжийн нэгдсэн сүлжээ бүрэлдэж, мал хамгаалах улсын нэгдсэн сан бий болно;

в/ ган, зудын үнэлгээний нэгдсэн журам тогтож, бүх шатанд зохион байгуулж, хэрэгжүүлэх ажлын чиглэл тогтсоноор гарах үр дүн, хүлээх хариуцлага сайжирна;

г/ мал бүхий иргэд, аж ахуйн нэгж, байгууллага болон бүх шатны төрийн захиргааны байгууллагын үүрэг, хариуцлагын тогтолцоог бүрдүүлснээр байгалийн бэрхшээл ган, зудыг хохирол багатай даван туулах орчин бүрэлдэж эхэлнэ;

д/ улсын хэмжээгээр 700.0 мянган тонн тэжээлийн нэгжээс доошгүй хэмжээний өвс, тэжээл бэлтгэдэг болно;

е/ малчид мал сүргээ ган, зудаас хамгаалах зорилгоор нэг хонин толгойд 10 кг-аас доошгүй тэжээлийн нэгжтэй тэнцэх хэмжээний өвс, тэжээлийг заавал бэлтгэдэг болж, малын хашаа, байр, усан хангамжийн түвшин дээшилнэ;

ж/ мал сүргийг Олон улсын давхар даатгалд хамруулж, улс орны эдийн засгийн аюулгүй байдлын баталгаа сайжирна;

з/ бэлчээрийг үнэлгээжүүлж, эдийн засгийн харилцаанд шилжүүлэх эрх зүйн орчин бүрдсэнээр даац, багтаамжид тохирсон мал сүргийг өсгөн үржүүлж, мал аж ахуйн үйлдвэрлэл тогвортой хөгжих боломжтой болно.

"МАЛ СҮРГИЙГ ГАН, ЗУДААС ХАМГААЛАХАД ТУСЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨР"-ӨӨР ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭ

Д/Д	Зорилт	Арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Санхүүжилт						Хариуцах, хяналт тавих байгууллага
				Сая төгрөг					Эх үүсвэр	
				2001	2002	2003	2004	2005		
1.	Мал хамгаалах сан бүрдүүлэх	Мал хамгаалах санг бүрдүүлэх зарцуулах журам боловсруулж Засгийн газарт оруулж шийдвэрлүүлэх	2001 оны эхний хагас жилд	Мал бүхий иргэдийн орлогын албан татвар, бэлчээр ашигласны төлбөрийн 50 хувьтай тэнцэх 1.3 тэрбум төгрөгийг сан д төвлөрүүлэх. Үүнээс улсын сан д 130.0 сая төгрөг, аймгийн сан д 195.0 сая төгрөг, сумын сан д 325 сая төгрөг хуримтлуулах асуудлыг судалж шийдвэрлэх.						Санхүү, эдийн засгийн яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам
2.	Отрын бүс нутгийг тэтгэж хамгаалалтад авах	Хэнтий аймгийн Хэрлэнбаян-улаан, Баянхонгор аймгийн Хар-Аргалант, Завхан аймгийн Сарт хайрхан, Төвийн бүсэд тус тус отрын бүс нутгийг судлан тэтгэж хамгаалалтад авах	2001-2004 он	103.8	90.8	111.8	148.8		Улсын төсөв	Санхүү, эдийн засгийн яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам

3.	Хадгалж бэлтгэл, тэжээл үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх	Улсын нөөцийн өвс, тэжээлийн хэмжээг нэмэгдүүлэх, аймаг, сумдад өвс, тэжээлийн бэлтгэлийн нөөцийг байгуулж арга хэмжээ авна	2001-2005 он	15498.0	22222.0	25640.0	29861.5	35118.5	Санхүү, эдийн засгийн яам, Газарзүй, уул уурхайн яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам
				(өссөн дүнгээр)					
4.	Улсын нөөцийн өвс, тэжээлийн цэг, салбарын тоог нэмэгдүүлэх	Завхан, Увс, Баянхонгор, Өвөрхангай, Архангай, Булган, Хөвсгөл, Ховд, Төв, Сэлэнгэ аймагт улсын нөөцийн өвс, тэжээлийн салбар шинээр байгуулах	2001-2005 он	200.0	250.0	200.0	100.0	100.0	Улсын төсөв Хүнс, хөдөө аж ахуйн яам
5.	Сум, багийг холбоожуулах	Эхний зэлмэнд гэр, зудын даватгаж өндөртэй 30 сум, 120 багт богино долгионы радио холбооны хэрэгсэлээр хангах	2001-2003 он	70.4	70.5	70.0	-	-	Газадзүйн зэвэл, туслалцаа Дэд бүтцийн яам

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 18 (205)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Засгийн газарт эрх олгох тухай*
- *Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*
- *Гаалийн тарифын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *Мөнгөн тэмдэгтийн хэв загвар батлах тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон болон лицензтэй нэвтрүүлэх барааны кодлосон жагсаалт, журам батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2001 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2001 оны тавдугаар сарын 11 №18 (205)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

214. Засгийн газарт эрх олгох тухай (2001-4-26-ны хууль) 473
215. Гаалийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2001-4-26-ны хууль) 474
216. Гаалийн тарифын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2001-4-26-ны хууль) 474

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

217. Тамхины хор хөнөөлтэй тэмцэх тухай хуулийн төсөл буцаах тухай Дугаар 36 475
218. Малын даатгалын тухай хуулийн төсөл буцаах тухай Дугаар 38 475
219. Мөнгөн тэмдэгтийн хэв загвар батлах тухай Дугаар 39 475
220. Хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай тогтоолын төсөл буцаах тухай Дугаар 40 475

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

221. Хөтөлбөр хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Дугаар 48 476
222. Гэрээ байгуулж ажиллахыг зөвшөөрөх тухай Дугаар 49 477
223. Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай Дугаар 50 477
224. Хууль зүй, дотоод хэргийн ямны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх тухай Дугаар 51 477
225. Журамд нэмэлт оруулах тухай Дугаар 52 483
226. Тогтоолд нэмэлт оруулах тухай Дугаар 53 483
227. Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон болон лицензтэй нэвтрүүлэх барааны кодлосон жагсаалт, журам батлах тухай Дугаар 54 484

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр **Улаанбаатар хот**

ЗАСГИЙН ГАЗАРТ ЭРХ ОЛГОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Малын гоц халдварт өвчнөөс сэргийлэх зориулалтаар 2001 оны 2 дугаар сарын 19-ний өдрөөс 2001 оны 8 дугаар сарын 19-ний өдөр хүртэлх хугацаанд импортолсон буюу импортлох вакцин, хаврын тариалалтад зориулж 2001 оны 8 дугаар сарын 19-ний өдөр хүртэл хугацаанд импортлох үрийн улаан буудай, бордоо, ургамал хамгаллын бодист ногдуулах импортын гаалийн татварын хувь, хэмжээг өөрчлөн зохицуулах эрхийг Засгийн газарт олгосугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг 2001 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр **Улаанбаатар хот**

ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гаалийн тухай хуульд дор дурдсан агуулгатай зүйл, хэсэг, заалт тус тус нэмсүгэй:

1/ 7[1] дүгээр зүйл:

"7[1] дүгээр зүйл. Гаалийн түр агуулах

1. Гаалийн нутаг дэвсгэрт гаалийн түр агуулах байна.

2. Гаалийн хяналтад байгаа бараа, тээврийн хэрэгслийг гаалийн түр агуулахад хадгалж болно.

3. Гаалийн түр агуулахад оруулсан бараа, түүний сав, баглаа боодол, лац, ломбонд гаалийн байгууллагын зөвшөөрөлгүйгээр өөрчлөлт оруулж болохгүй.

4. Гаалийн хяналтад байгаа бараа, тээврийн хэрэгслийг гаалийн байгууллагын зөвшөөрснөөр тээврийн байгууллага, эсхүл өмчлөгч мэдэлд хадгалуулж болно. Энэ тохиолдолд бараа, тээврийн хэрэгслийг гаалийн түр агуулахад байгаа гэж үзнэ.

5. Бараа, тээврийн хэрэгслийг гаалийн түр агуулахад 2 сар /амархан гэмтэх болон аюултай бараог 7 хоног/-аас илүү хугацаагаар хадгалахгүй. Шаардлагатай бол гаалийн байгууллага энэ хугацааг 1 сар /амархан гэмтэх болон аюултай бараог 7 хоног/ хүртэл хугацаагаар нэг удаа сунгаж болно."

2/ "34 [1] дүгээр зүйл:

34[1] дүгээр зүйл. Бараг гаалийн хяналтын дор хүргэх

1.Гаалийн хилээр нэвтрүүлэхийг хориглосон бараг нэвтрүүлсэн этгээдийг илрүүлэх зорилгоор гаалийн байгууллага уг бараг гаалийн хяналтын дор хүргэх аргыг хэрэглэж болно.

2. Бараг гаалийн хяналтын дор хүргэх аргыг хэрэглэх журмыг Засгийн газар тогтооно."

3/ 73 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:

"1. Бараг гаалийн хилээр хууль бусаар нэвтрүүлэх зорилгоор өөр бараг нуувч болгон ашигласан бол нуувч болгон ашигласан бараг хураан авах, хураан авах бололцоогүй бол үнийг гаргуулан авна."

4/ 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 20 дахь заалт:

"20/ "бараг гаалийн хяналтын дор хүргэх" гэж гаалийн байгууллагаас Монгол Улсын олон улсын гэрээний, эсхүл бусад улсын гаалийн болон эрх бүхий байгууллагатай харилцан тохиролцсоны үндсэн дээр Монгол Улсын гаалийн хилээр нэвтрүүлэхийг хориглосон барааны хууль бус эргэлтийг таслан зогсоох, оролцогч этгээдийг илрүүлэх зорилгоор гаалийн хилээр хяналтын дор оруулах, дамжин өнгөрүүлэх, гаргахыг хэлнэ."

2 дугаар зүйл. Гаалийн тухай хуулийн 73 дугаар зүйлийн гарчигт "Тээврийн" гэсний өмнө "Бараа,"; 84 дүгээр зүйлд "тээврийн хэрэгслийн үнийг" гэсний дараа "болон 82; 83 дугаар зүйлд заасан татвар, торгуулийг"; гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл. Гаалийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2, 42 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 88 дугаар зүйлийн гарчиг болон 1 дэх хэсгийн "зориулалтын" гэснийг "түр"; 73 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн дугаарыг "2" гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Гаалийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 19 дэх заалт, 31 дүгээр зүйлийн 12 дахь хэсгийн "гаалийн зориулалтын агуулах," гэснийг хассугай.

5 дугаар зүйл. Гаалийн тухай хуулийн 23 дугаар зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр **Улаанбаатар хот**

ГААЛИЙН ТАРИФЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гаалийн тарифын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "гаалийн байгууллагад мэдүүлсэн өдрийн" гэснийг "бараат_гаалийн хилээр оруулахад гаалийн эцсийн, гаргахад гаалийн анхны бүрдүүлэлт хийсэн өдрийн" гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр **Дугаар 36** **Улаанбаатар хот**

Тамхины хор хөнөөлтэй тэмцэх тухай хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 40 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлсэн Тамхины хор хөнөөлтэй тэмцэх тухай хуулийн шинэчлэн найруулсан төсөл нь Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн нийтлэг шаардлагыг хангаагүй байх тул хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр **Дугаар 38** **Улаанбаатар хот**

Малын даатгалын тухай хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 40 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Малын даатгалын тухай хуулийн төслийг малыг заавал даатгах тогтолцоо шаардлагатай эсэх, шаардлагатай тохиолдолд түүний хүрээ, хамрагдах малын төрөл, заавал даатгах эрсдэлийг тогтоох болон үүнд төр оролцох хэмжээ нь тодорхой бус байгаа зэрэг үндэслэлээр хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр **Дугаар 39** **Улаанбаатар хот**

Мөнгөн тэмдэгтийн хэв загвар батлах тухай

Төвбанк /Монголбанк/-ны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Ардын хувьсгалын 80 жилийн ойд зориулсан "500 төгрөг"-ийн зоосон мөнгөн тэмдэгтийн хэв загварыг хавсралт ёсоор батална.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

Монгол Улсын Их Хурлын 2001 оны 39 дүгээр тогтоолын хавсралт

ЗООСОН МӨНГӨН ТЭМДЭГТИЙН ХЭВ ЗАГВАР

1.Зоосны хэмжээ, мм-ээр:
-Голч нь 22
-Зузаан нь 1.7

2.Зоосны ар талын төв хэсэгт Соёмбо зурж, "Монгол Улс" гэсэн бичгийг худам монгол үсгээр, "Монголбанк, 500 төгрөг, 2001" гэсэн бичгийг кирилл үсэг, араб тоогоор бичнэ.

3.Зоосны өвөр талд жанжин Сүхбаатарын хөргийг зурж, "Монгол Ардын хувьсгалын 80 жилийн ой" гэсэн бичгийг кирилл үсгээр бичнэ.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр **Дугаар 40** **Улаанбаатар хот**

Хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай тогтоолын төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 40 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийн хавсралтын "Монгол Улсад нийгмийн дэг журам бэхжүүлэх хөтөлбөр", "Монгол Улсад нийгмийн дэг журам бэхжүүлэх талаар 2001-2002 онд авах арга

хэмжээний төлөвлөгөө”-нд тусгагдсан арга хэмжээнүүд нь Улсын Их Хурлын 1998 оны 18 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын эрх зүйн шинэтгэлийн хөтөлбөр”, Засгийн газраас нийгмийн дэг журам бэхжүүлэх талаар гаргасан бусад хөтөлбөрийн заалтуудтай давхардаж байгаа тул үүнийг дахин боловсруулахаар хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 3 дугаар сарын 13-ны өдөр **Дугаар 48** **Улаанбаатар хот**

Хөтөлбөр хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Мал сүргийг ган, зудаас хамгаалахад туслах үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Аймаг, нийслэл, сум, дүүрэг бүр өөрийн онцлог байдалд зохицуулан “Мал сүргийг ган, зудаас хамгаалахад туслах дэд хөтөлбөр”-ийг энэ оны Ш улиралд багтаан боловсруулж, 2005 он хүртэл үе шаттайгаар хэрэгжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

2. Энэ хөтөлбөртэй уялдуулан аймаг бүр өвс, тэжээлийн нөөц сантай болох асуудлыг бүх шатны Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Ган, зудад нэрвэгдэж малгүй болсон, амьжиргааны баталгаажих доод түвшингээс бага орлоготой, нэн ядуу иргэдийн судалгаат гаргаж тэдэнд үе шаттайгаар дэмжлэг туслалцаа үзүүлэх, ажлын байр буй болгох болон малжуулах төсөлд хамруулах арга хэмжээ авахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаяр, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

4. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээнд зарцуулах хөрөнгийн эх үүсвэрийг дотоод нөөц бололцоог дайчлах, менежментийг сайжруулах, гадаад орон, олон улсын байгууллагад тавьж шийдвэрлүүлэхийг Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал нарт даалгасугай.

5. Япон Улсын Засгийн газрын гамшгийн буцалтгүй тусламжийн хүрээнд хэрэгжүүлэх богино болон хэт богино долгионы радио, тоног төхөөрөмжөөр сум, багуудыг холбоожуулах ажлыг эрчимжүүлж, орон нутгийн зам, тээвэр, харилцаа холбоо, түлш, эрчим хүчний үйлдвэрүүдийн хэвийн найдвартай ажиллагаа хангахад онцгойлон анхаарч ажиллахыг Дэд бүтцийн сайд Б.Жигжид, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

6. Мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээг технологийн зохистой хугацаанд бүрэн хэрэгжүүлэх, мал сүргийг эрүүлжүүлэх, чанаржуулах ажлын үр дүнг дээшлүүлж, мал эмнэлэг, үржлийн хувьчлагдсан аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээ авч ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, Төрийн өмчийн хорооны дарга Л.Пүрэвдорж, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

7. Мал өвөлжүүлж, хаваржуулах болон төв суурин газрын өвөлжилтийн бэлтгэл хангах ажлыг жил бүрийн 8 дугаар сарын 1-нээс 10 дугаар сарын 1 хүртэл орон даяар нийтийг хамарсан хөдөлгөөн болгон өрнүүлж, энэ хугацаанд томоохон хэмжээний найр, наадам зохион байгуулахыг аль болох хязгаарлахыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

8. Сүүлийн жилүүдэд тохиолдсон ган, зудын хохирлын байдалд үнэлэлт, дүгнэлт хийж, улсын хэмжээнд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг энэ оны эхний хагаст багтаан боловсруулж мөрдөхийг Батлан хамгаалахын сайд, Улсын байнгын онцгой комиссын дарга Ж.Гуррагчаа, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД Д.НАСАНЖАРГАЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 3 дугаар сарын 14-ний өдөр | Дугаар 49 | Улаанбаатар хот

Гэрээ байгуулж ажиллахыг зөвшөөрөх тухай

Засгийн газрын тухай хуулийн 19 дүгээр зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах асуудлаар мэргэжлийн хяналтын байгууллагатай хамтран үзэлт, шалгалт явуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтийг шалгах, мэдээлэл сурталчилгаа хийх, энэ чиглэлээр мэргэжлийн сургалт зохион байгуулах талаархи төрийн гүйцэтгэх байгууллагын чиг үүргийг бүрэн эрхийнхээ хугацаанд гэрээ байгуулж Монголын хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэгээр гүйцэтгүүлэн ажиллахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаярт зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД Ш.БАТБАЯР

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 3 дугаар сарын 14-ний өдөр | Дугаар 50 | Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Ой тэмдэглэх тухай" Засгийн газрын 2001 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 20 дугаар тогтоолын хавсралтын "Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ө.Энхтүвшин" гэснийг "Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид" гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Ө.ЭНХТҮВШИН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 3 дугаар сарын 14-ний өдөр | Дугаар 51 | Улаанбаатар хот

Хууль зүй, дотоод хэргийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Хууль зүй, дотоод хэргийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-ийг хавсралт ёсоор зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Хууль зүйн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх, тус яамны бүтцийг батлах тухай" Засгийн газрын 1997 оны 6 дугаар сарын 25-ны өдрийн 151 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйл, "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын 1997 оны 9 дүгээр сарын 22-ны өдрийн 196 дугаар тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд Н.ЭНХБАЯР

Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.НЯМДОРЖ

Засгийн газрын 2001 оны 51 дүгээр тогтоолын хавсралт

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР

1.Нийтлэг үндэслэл

1.1.Оршил

Монгол Улсын Хууль зүй, дотоод хэргийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр /цаашид "Хөтөлбөр" гэх/-т Хууль зүй, дотоод хэргийн сайдын болон Засгийн газрын Танхимын шийдвэрийг боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд чиглэсэн эрх зүйн шинэтгэлийн стратегийн төлөвлөлт, бодлогын

удирдамж, төрийн захиргааны удирдлага, зохицуулалтаар хангах, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, эрх зүйн мэдээлэл, суурьчилгааг бүх иргэдэд хүргэх, хууль зүйн тусламжаа үзүүлэх, эрхийг нь баталгаажуулах үйлчилгээг нийт хүн амд үзүүлэх, улсын хил хамгаалалт, гэмт хэрэг, хэв журмын зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах, хүний эрхийг хамгаалахтай холбоотой асуудлыг хамарсан Хууль зүй, дотоод хэргийн яамны үйл ажиллагааны стратегийн болон бүтцийн загварыг тодорхойлов.

1.2.Үндэслэл

Хөтөлбөрийг Улсын Их Хурлын 1996 оны 38 дугаар тогтоолоор зөвшөөрсөн "Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого"-ын баримт бичиг, Улсын Их Хурлын "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай" 2000 оны 32 дугаар тогтоол, Засгийн газрын "Ямдын зохион байгуулалтын бүтцийг батлах тухай" 2000 оны 131 дүгээр тогтоол, Засгийн газрын Удирдлагын хөгжлийн хөтөлбөрийн "Төрийн захиргаа, төрийн албаны өөрчлөлт, шинэчлэл" бүрэлдэхүүн хэсгийн МОН/94/102 төслийн хүрээнд боловсруулсан "Хууль зүйн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн ерөнхий загвар" төслийн тайланг тус тус үндэслэн боловсруулав.

1.3.Хууль тогтоомжийн орчин

Хөтөлбөрийг дор дурдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ:

- Монгол Улсын Үндсэн хууль;
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;
- Монгол Улсын Төрийн албаны тухай хууль;
- Монгол Улсын Шүүхийн тухай хууль;
- Бусад хууль тогтоомж.

1.4.Арга зүй

Хөтөлбөрийг боловсруулахад олон улсын шилдэг туршлага, өөрчлөлтийн удирдлага, үйл ажиллагаа /бизнес/-ны төлөвлөлт болон дахин инженерчлэл, байгууллагын өөрчлөлт зэрэг арга зүйг хэрэглэв.

1.5.Удирдлагын ерөнхий чиг үүргийн байгууллагын үүрэг хариуцлагын ерөнхий хуваарь

Засгийн газрын удирдлагын ерөнхий чиг үүргийн байгууллагын нэг болох Хууль зүй, дотоод хэргийн яам нь Засгийн газрын үйл ажиллагааны стратегийг хэрэгжүүлэх талаар үүрэг, хариуцлага хүлээж, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Засгийн газрын Танхимд бүх талын зөвлөлгөө, дэмжлэг үзүүлнэ.

Хууль зүй, дотоод хэргийн яам нь эрх зүйн шинэтгэлийн бодлого, төлөвлөлтийн болон бодлого, төсвийн зарцуулалтын тэнцвэр, харилцан уялдаа холбоог хангах асуудалд Засгийн газрын өндөрлөгөөс өргөн хүрээтэй хандаж, зөв зохистой удирдахад анхаарлаа төвлөрүүлнэ.


Засгийн газрын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд оролцдог удирдлагын ерөнхий чиг үүргийн байгууллагын нэг болох Хууль зүй, дотоод хэргийн яам нь Засгийн газрын хуулийн зөвлөхийн үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

1.6.Стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр

Хууль зүй, дотоод хэргийн яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр, нэн ялангуяа үндсэн үйлчүүлэгч буюу хэрэглэгчийг зөв тодорхойлох нь яамны үйл ажиллагааны стратегийг үндэслэл сайтай тогтооход чухал ач холбогдолтой юм.

Энэ хэрэгцээний эх үүсвэрт дор дурдсан үйлчлүүлэгч буюу хэрэглэгч хамаарагдана:

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ СТРАТЕГИЙН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЦЭЭНИЙ ЭХ ҮҮСВЭР



Хууль зүй, дотоод хэргийн яамны үндэсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгч нь Хууль зүй, дотоод хэргийн сайд, Засгийн газрын Танхим болно.

Стратегийн удирдлага, зохицуулалт нь дээр дурдсан хэрэгцээний эх үүсвэр, үндэсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг хангахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулахад чиглэнэ.

Хууль зүй, дотоод хэргийн яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээг хангах үйлчилгээний хүрээ, төрөл, хэлбэрийг хэрэгцээний эх үүсвэр тус бүрээр тогтоон тус яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн зорилт, чиг үүрэг, төрийн албан хаагчдын ажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтод нарийвчлан тусгаж хэрэгжүүлнэ.

2.Хууль зүй, дотоод хэргийн яамны үйл ажиллагааны стратеги

2.1.Үйл ажиллагааны стратегийн мөн чанар

Хууль зүй, дотоод хэргийн яамны үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь Засгийн газрын тэргүүлэх чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнийг зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн Хууль зүй, дотоод хэргийн сайдын үйл ажиллагаанд өндөр мэргэшлийн, цаг үеэ олсон, шуурхай зөвлөлгөө, бүх талын дэмжлэг үзүүлэхэд оршино.

2.2.Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

Хууль зүй, дотоод хэргийн яам нь дор дурдсан үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлтэй ажилдана:

1. Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд яамны болон харьяа тохируулагч, хэрэгжүүлэгч агентлагийн үйл ажиллагааг чиглүүлэх, эрх зүйн зөвлөлгөө, үйлчилгээгээр цаг тухайд нь хангах замаар Хууль зүй, дотоод хэргийн сайд, Засгийн газар /Танхим/-ын үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх, сайн засаглал тогтооход дэмжлэг үзүүлэх;

2. Яамны хэмжээнд удирдлагын шилдэг арга барил, туршлагыг нэвтрүүлэх, тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог хөгжүүлэх замаар төрийн захиргааны удирдлагын мэдлэгийг хангах, иргэн байгууллагад үзүүлэх хууль зүйн үйлчилгээний чанарыг олон улсын жишигт хүргэх;

3. Хууль зүй, дотоод хэргийн яамны өөрчлөлт, хөгжлийн стратегитэй уялдсан хүний нөөцийн удирдлагын арга барилыг хэрэглэх, төрийн албан хаагчийн ажилхах нөхцөл, нийгмийн баталгаат хангах замаар яамны аппаратыг цомхон, чадварлаг болгон өөрчлөн хөгжүүлэх, өртөг, зардлыг бууруулахад чиглэсэн нийтлэг үйлчилгээг бий болгон хөгжүүлэх;

4. Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнийг Засгийн газрын агентлагаас үзүүлэх төрийн үйлчилгээний чанарыг дээшлүүлэх.

2.3.Үйл ажиллагааны эрхэм зорилго

Хууль зүй, дотоод хэргийн яамны эрхэм зорилго

Монгол Улсын иргэн хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгэмд Үндэсэн хуулиар тогтоосон эрх, эрх чөлөөгөө баталгаатай эдлэх, үүрэгээ биелүүлэх эрх зүйн таатай орчин бүрдүүлэх

2.4.Үйл ажиллагааны стратегийн зорилт

Хууль зүй, дотоод хэргийн яам нь эрхэм зорилгодоо хүрэхийн тулд дараахь стратегийн зорилтуудыг дэвшүүлж хэрэгжүүлнэ:

1. Эрх зүйн шинэтгэл, хууль зүйн бодлогын стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах;

2. Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах;

3. Эрх зүйн шинэтгэлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах;

4. Эрх зүйн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ /мониторинг/ хийх, үнэлгээ өгөх.

2.5.Үйл ажиллагааны гол зорилт

Хууль зүй, дотоод хэргийн яамны үйл ажиллагааны стратегийн зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн дор дурдсан үйл ажиллагааны гол зорилтыг дэвшүүлэн ажиллана:

1.0.Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд:

1.1. Эрх зүйн шинэтгэлийн стратегийг төлөвлөх;

1.2. Үндэсний эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох;

1.3. Эрх зүйн шинэтгэлийн бодлогын удирдамжаар хангах;

2.0.Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд:

2.1. Төрийн захиргаа, хүний нөөцийн удирдлагыг боловсронгуй болгох;

2.2. Сайдаас шийдвэр боловсруулан гаргахад эрх зүйн болон бусад дэмжлэг үзүүлэх;

2.3. Яамны үйл ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэх, тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог боловсронгуй болгох;

2.4. Эрх зүйн гадаад хамтын ажиллагаа хөгжүүлэх;

3.0.Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд:

3.1. Эрх зүйн бодлогын хэрэгжилтийг уялдуулах;

3.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах, хяналт тавих;

3.3. Агентлагийн үйл ажиллагаа зохицуулах, хяналт тавих;

3.4. Шүүх, прокурор, өмгөөлөх, нотариат, орон нутгийн хууль зүйн албадын харилцан ажиллагаа хангах;

3.5. Хуулинд тусгайлан заасан улсын нэгдсэн бүртгэлийг эрхлэх.

4.0.Үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд:

4.1. Эрх зүйн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ /мониторинг/ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх арга зүйг боловсруулах;

4.2. Хууль болон Засгийн газрын нийгмийн дэг журам хангах чиглэлээр баталсан хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ /мониторинг/ хийх, үнэлгээ өгөх;

4.3. Эрх зүйн үйлчилгээний үр нөлөөнд хяналт-шинжилгээ /мониторинг/ хийх, үнэлгээ өгөх;

4.4. Эрх зүйн албан ба албан бус сургалтын бодлого боловсруулах, хэрэгжилтийг хянах, эрх зүйн суурьчилгааг зохион байгуулан үр нөлөөг дээшлүүлэх.


2.6.Үйл ажиллагааны зорилт

Хууль зүй, дотоод хэргийн яамны үйл ажиллагааны гол зорилт нь бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны зорилтыг тус яам тодорхойлж хэрэгжүүлнэ.

2.7.Үйл ажиллагааны стратегийн загвар

Хууль зүй, дотоод хэргийн яамны үйл ажиллагаа /бизнес/-ны стратегийн загварыг дор дурдсанаар тодорхойлж байна:

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА /БИЗНЕС/-НЫ СТРАТЕГИЙН ЗАГВАР



3.Хууль зүй, дотоод хэргийн яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц, тэдгээрийн үүрэг, чиг үүрэг

3.1.Бүтцийн ерөнхий тогтолцоо боловсруулахад баримтлах зарчим


Хууль зүй, дотоод хэргийн яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтцийг боловсруулахад дараахь зарчмыг баримтлав:

1. Засгийн газрын үйл ажиллагааны стратегитай уялдсан тухайн яамны стратегийн зорилтыг тусгасан байх зарчим /тухайн яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцоо, зохион байгуулалтын бүтэц нь түүнтэй уялдсан байх/;
2. Эрх мэдлийн ялгаа зааг нь тодорхой, итгэл хүлээхүйц байх зарчим /бүтцийн нэгж, тэдгээрийн удирдах албан тушаалын түвшин, нэр нь аль нэгж, ямар асуудал эрхэлдэг, аль албан тушаал, ямар эрх мэдэлтэй болохыг тодорхой мэдэж болохуйц байх, тэдгээрийн ажлын уялдаа, ажиллах чадвар нь итгэл хүлээхүйц байх/;
3. Үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх зарчим /тухайн яамны нэр, бүтцээс үйл ажиллагааны дүр төрх харагдахуйц байх, тухайлбал, яамны зохион байгуулалтын бүтэц, бүтцийн нэгжийн нэр нь түүний үйл ажиллагааны стратегийг тусгасан байх/;
4. Бүтцийн хувьд энгийн байх зарчим /тухайн яамны Төрийн нарийн бичгийн даргаас доод нэгжээ хүртэл аль болох цөөн (3-аас илүүгүй) шат дамжлагатай байх/;
5. Тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтоох зарчим /тухайн яамны үйл ажиллагааны стратеги, бүтэц хоёрын зохистой тэнцвэрийг хангах замаар аль болох хялбар, шуурхай удирдах, хянах боломжтой байх, үйл ажиллагааны стратегийн зорилтыг аль болох оновчтой бүлэглэх замаар бүтцийн ерөнхий тогтолцоог тогтоосон байх, энэ нь удирдлагын чиг үүрэг, хүн хүчний болон бусад нөөцийг зөв хуваарилан хэрэглэгчийнхээ хэрэгцээнд нийцсэн үйлчилгээ үзүүлэх боломжийг бүрдүүлсэн байх/;
6. Улс төрийн хувьд төвийг сахисан байх зарчим /тухайн яамны төрийн захиргааны албан хаагчнь Сайд, Засгийн газар /Танхим/, бусад үйлчлүүлэгч буюу хэрэглэгчдэд улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй төвийг сахисан өндөр мэргэшлийн зөвлөлгөө, дэмжлэг, үйлчилгээ үзүүлдэг байх/;
7. Хангалттай чадавхи, бодитой үйл ажиллагааны зарчим /үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар, зохион байгуулалтын бүтэц нь чадавхиа бүрэн дүүрэн илрүүлэхэд чиглэсэн, хэрэгжихүйц бөгөөд ажиллах чадвартай байх/.

3.2. Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны загвар

Дээр дурдсан зарчим болон Хууль зүй, дотоод хэргийн яамны үйл ажиллагаа /бизнес/-ны стратегийн загварыг үндэслэн тус яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий тогтолцооны дор дурдсан загварыг санал болгож байна:

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЦИЙН ЕРӨНХИЙ ТОГТОЛЦООНЫ ЗАГВАР



3.3 Зохион байгуулалтын бүтэц

Хууль зүй, дотоод хэргийн яамны үйл ажиллагаа /бизнес/ -ны стратегийн болон бүтцийн ерөнхий тогтолцооны загвараас дор дурдсан зохион байгуулалтын бүтцийн нэгж урган гарч байна:

1. Эрх зүйн шинэтгэлийн стратегийн удирдлага, нэгдсэн төлөвлөлтийн асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндэсн

үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн нэгдүгээр зорилтын хүрээнд Хууль зүй, дотоод хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээний эрх зүйн шинэтгэлийн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах үндсэн үүргийг хүлээж, Монгол Улс дахь хууль зүйн бодлогын стратегийг төлөвлөх, үндэсний эрх зүйн тогтолцоог боловсронгуй болгох, эрх зүйн шинэтгэлийн бодлогын удирдамжаар хангахад мэргэшлийн зөвлөлгөө, үйлчилгээ үзүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь Хууль зүй, дотоод хэргийн сайд, Засгийн газрын Танхимын стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангахтай холбогдсон шийдвэр боловсруулан гаргахад дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын гишүүн, Хууль зүй, дотоод хэргийн сайдыг шаардлагатай мэдээллэл, өндөр мэргэшлийн, шуурхай зөвлөлгөө, үйлчилгээ, бүх талын дэмжлэгээр хангах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Хууль зүй, дотоод хэргийн сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газар /Танхим/ байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь Улсын Их Хурал, бусад яам, Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлаг, нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллага, ашгийн төлөө хуулийн этгээд, хэвлэл мэдээлэл, олон нийтийн байгууллага, ард иргэд байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцогч гол түнш нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Санхүү, эдийн засгийн яам, Гадаад хэргийн яам байна.

2.Төрийн захиргааны удирдлагын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн хоёрдугаар зорилтын хүрээнд төрийн захиргааны удирдлагын болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах үндсэн үүргийг хүлээж, яамны үйл ажиллагаанд удирдлагын шилдэг туршлагыг судлах, арга зүйг нэвтрүүлэх, хүний нөөцийн удирдлага, хөгжлийн асуудлыг шийдвэрлэх, ажлаа тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог бэхжүүлэх, эрх зүйн гадаад хамтын ажиллагаат хөгжүүлэх үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь цомхон, чадварлаг төрийн албан хаагч бүхий төрийн захиргааны мэргэшсэн албаны хүчээр яамны тасралтгүй, хэвийн жигд ажиллагаат хангахад чиглэнэ.

Энэ нь Хууль зүй, дотоод хэргийн сайдаас шийдвэр боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд эрх зүйн болон бусад үйлчилгээ үзүүлэх, шаардлагатай мэдээллэл, зөвлөлгөө, дэмжлэгээр хангах, удирдлагын соёл, чадавхийг дээшлүүлэх, тэргүүний арга барил, туршлагыг нэвтрүүлэх, төрийн захиргааны албан хаагчдыг сургах хөгжүүлэх, тэдний үйл ажиллагаа, мэргэшлийн түвшинг нь үнэлж дүгнэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгаат нь хангах замаар хэрэгжинэ. Энэ нэгжийн бүтцэд ямны аж ахуй, үйлчилгээ, санхүүгийн үйл ажиллагаа хамаарна.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Хууль зүй, дотоод хэргийн сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, төрийн захиргааны албан хаагчид байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, нутгийн захиргааны байгууллага, төсвийн байгууллага, аж ахуйн нэгж, бусад хэрэглэгч байна.

Үйлчилгээг үзүүлэхэд оролцогч гол түнш нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Санхүү, эдийн засгийн яам, боловсрол, сургалт, эрдэм шинжилгээний болон гадаад орон, олон улсын байгууллага байна.

3.Эрх зүйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн гуравдугаар зорилтын хүрээнд эрх зүйн шинэтгэлийн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийн хэрэгжилтийг зохицуулах, зохион байгуулах, хяналт тавих үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь Засгийн газар, Хууль зүй, дотоод хэргийн сайдын бодлогын хэрэгжилтийг зохицуулах, бодлого, төсвийн тэнцвэрт байдал, харилцан уялдаа холбоог хангахад чиглэнэ.

Энэ нь нөөцийг оновчтой хуваарилах замаар бодлого хэрэгжүүлэхэд оролцож байгаа бүх байгууллагатай түншийн харилцаа тогтоож, тэдний үйл ажиллагаат бодлого, төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглүүлэн зохион байгуулах, зохицуулах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Хууль зүй, дотоод хэргийн сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газар /Танхим/, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, шүүх, прокурор, өмгөөлөх, нотариат, нутгийн өөрөө удирдах болон захиргааны байгууллага байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь бусад яам, төсвийн байгууллага, аж ахуйн нэгж , төрийн бус болон шашны байгууллага, ард иргэд, бусад

хэрэглэгч байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түлхнь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Санхүү, эдийн засгийн яам, Гадаад хэргийн яам байна.

4.Мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн дөрөвдүгээр зорилтын хүрээнд бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ /мониторинг/ хийх, үнэлгээ өгөх үндсэн үүрэг хүлээж, хуулийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, эрх зүйн албан ба албан бус сургалтыг бодлогын удирдлагаар хангах, эрх зүйн сурталчилгааны ажлыг зохион байгуулах, эрх зүйн үйлчилгээ, мэдээллийн ажлын үр нөлөөнд хяналт-шинжилгээ /мониторинг/ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь яамны бодлого боловсруулах, түүний хэрэгжилтийг зохицуулах, төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чиглэнэ.

Энэ нь бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилт, үр дагаварт хяналт-шинжилгээ хийж, яамны бүтцийн нэгжүүдийн болон бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд оролцож байгаа бүх байгууллага, тэдгээрийн удирдах, гүйцэтгэх албан тушаалтны үйл ажиллагаар сайжруулахад чиглэсэн зөвлөлгөө, дэмжлэгээр цаг тухайд нь хангах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Хууль зүй, дотоод хэргийн сайд, дэд сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, нутгийн захиргааны байгууллага байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түлхнь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, сургалт, эрдэм шинжилгээний болон хэвлэл мэдээллийн байгууллага байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 3 дугаар сарын 14-ний өдөр Дугаар 52 **Улаанбаатар хот**

Журамд нэмэлт оруулах тухай

Татварын орлогыг нэмэгдүүлэх, татварын хяналт, шалгалтыг сайжруулах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Хилийн мэргэжлийн хяналтыг сайжруулах талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1994 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 78 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан журмын 4 дэх заалтын "а"-д "ургамлын хорио цээр" гэсний дараа, мөн заалтын "б"-д "гааль" гэсний дараа "татвар" гэж тус тус нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 3 дугаар сарын 14-ний өдөр Дугаар 53 **Улаанбаатар хот**

Тогтоолд нэмэлт оруулах тухай

"Монгол Улсын хүний эрхийн үндэсний комиссын тухай хууль"-ийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Төрийн зарим байгууллагын албан тушаалын ангилал, зэрэглэл, цалингийн сүлжээг батлах тухай" Засгийн газрын 1995 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн 132 дугаар тогтоолын 1 дүгээр зүйл болон мөн тогтоолын 1 дүгээр хавсралтын гарчиг ба 1 дэх баганын "Үндсэн хуулийн цэцийн" гэсний дараа "Хүний эрхийн үндэсний комиссын" гэж, мөн хавсралтад "Хүний эрхийн үндэсний комиссын ажлын алба" гэсэн хэсгийг хавсралт ёсоор тус тус нэмсүгэй.

2. "Төрийн албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай" Засгийн газрын 1999 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 224 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйл болон мөн тогтоолын 2 дугаар хавсралтын гарчгийн "Үндсэн хуулийн цэцийн" гэсний дараа "Хүний эрхийн үндэсний комиссын" гэж тус тус нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД Ц.НЯМДОРЖ

Засгийн газрын 2001 оны 53 дугаар тогтоолын хавсралт

ТОГТООЛЫН ХАВСРАЛТЫН НЭМЭЛТ

Ангилал	Зэрэглэл	Хүний эрхийн үндэсний комиссын ажлын алба
Ахлах түшмэл	АА-6	Референт
	АА-7	Ахлах шинжээч
	АА-8	Шинжээч
Дэс түшмэл	АА-9	
	АА-10	Зааварлагч
	АА-11	

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 3 дугаар сарын 14-ний өдөр **Дугаар 54** **Улаанбаатар хот**

Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон болон лицензтэй нэвтрүүлэх барааны кодлосон жагсаалт, журам батлах тухай

Монгол Улсын "Гаалийн тухай хууль"-ийн 5 дугаар зүйл, Монгол Улсын Их Хурлын 1998 оны 05 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын хилээр нэвтрүүлэхийг хориглосон барааны кодлосон жагсаалтыг 1 дүгээр, Монгол Улсын хилээр экспорт, импортын лицензтэй нэвтрүүлэх барааны кодлосон жагсаалтыг 2 дугаар, төрийн хяналтын дор улсын хилээр нэвтрүүлэх бараанд экспорт, импортын лиценз олгох журмыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус батлуулсугай.

2. Энэ тогтоолын 2 дугаар хавсралтад дурдсан барааг улсын хилээр нэвтрүүлэхэд экспорт, импортын лиценз олгох асуудлыг хянан шийдвэрлэж байхыг Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг даалгасугай.

3. Энэ тогтоолын 2 дугаар хавсралтад дурдсан барааг улсын хилээр нэвтрүүлэх экспорт, импортын лиценз олгоход шаардлагатай зөвшөөрөл, тодорхойлолт, дүгнэлт гаргаж байх албан тушаалтны нэр, гарын үсгийн баталгаагаа Үйлдвэр, худалдааны яаманд тухай бүр хүргүүлж байх, энэ үйл ажиллагаатай холбоотой журам, зааврыг олон шат дамжлагагүй, ил тод байдлыг хангах чиглэлээр шинэчлэн боловсруулж батлан мөрдүүлэхийг Батлан хамгаалахын сайд Ж.Гүррагчаа, Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид, Байгаль орчны сайд У.Барсболд, Эрүүл мэндийн сайд П.Нямдаваа, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

4. Энэ тогтоолын 1, 2 дугаар хавсралт, Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын болон Засгийн газрын тогтоолоор тусгайлан нэр зааснаас бусад барааны гаалийн хяналт, бүрдүүлэлтийг зохих журмын дагуу хийж улсын хилээр экспорт, импортын лицензгүй нэвтрүүлж байхыг Улсын Гаалийн ерөнхий газрын дарга Х.Баатарт зөвшөөрсүгэй.

5. Энэхүү тогтоолыг 2001 оны 4 сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД **Ч.ГАНЗОРИГ**

МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР НЭВТРҮҮЛЭХИЙГ ХОРИГЛОСОН БАРААНЫ КОДЛОСОН ЖАГСААЛТ

Бараат тодорхойлох, кодлох уялдуулсан системийн зүйл №	Бараат тодорхойлох, кодлох уялдуулсан системийн мөр №	Барааны бичиглэл	Үндэслэл бүхий эрх зүйн акт	Улсын хилээр нэвтрүүлэх ялгаа
		МАНСУУРУУЛАХ БОДИС, ТЭДГЭЭРИЙГ ҮЙЛДВЭРЛЭХ, ХЭРЭГЛЭХЭД ЗОРИУЛСАН БАГАЖ, ХЭРЭГСЭЛ, МАНСУУРУУЛАХ УРГАМАЛ А. Мансууруулах бодис, ургамал Энэхүү жагсаалтад орсон зарим төрлийн мансууруулах үйлчилгээтэй бодисууд нь /фентанил морфин, педитин кодейн гэх мэт/ эмчилгээний практикт өргөн хэрэглэгддэг тул эдгээрийг эм, эмчилгээний зориулалтаар хил нэвтрүүлж байгаа нөхцөлд Хүний эмийн салбар зөвлөлийн дүгнэлт, Эрүүл мэндийн яамны зөвшөөрлийг үндэслэн экспорт, импортын лиценз олгоно.	Монгол Улсын Их Хурлын 1998 оны 05 дугаар тогтоол	Гаргах, оруулах
12.11		Үнэртэн, гоо сайхан, эм бэлдмэлийн үйлдвэрлэлд эсвэл шавьж буюу мөөгөнцрийн эсрэг ашиглах, шинэ, хатаасан, бүтэн буюу хэсэгчилсэн, буталсан буюу нунтагласан ургамал, ургамлын хэсэг /үр жимс нь орно/. Үүнээс:		
	1211.90.00	Бусад: - Олсны ургамал - Кокагийн навч - Каннабис - Намууны сүрэл		

13.01		Лак, байгалийн нунжгай, давирхай, нунжгай давирхай, тослог давирхай /дальзам, түүгээр гэх мэт/. Үүнээс:		
	1301.90.00	Бусад: - Олсны ургамлын давирхай, жилли - Каннабисын давирхай		
29.22		Хүчилтөрөгчийн үүрэгт бүлэг бүхий амино-нэгдэл Үүнээс:		
	2922.19.00	Бусад: - Ацетилметадол (INN) 3-ацетокси-6-диметиламино-4,4- дифенилгептан - L-Альфацетилметадол - Альфацетилметадол - Альфаметадол (INN) 6- диметиламино-4,4-дифенил-3- гептон-3-ол - Напсилат - Метадол - Левопропоксифен (INN) - Бетацетилметадол (INN) а-3-ацетокси-6-диметиламино-4,4-дифенилгептан - Бетаметадол (INN) в-6-диметиламино-4,4-дифенил- 3-гептан-3-ол - Димефентанол (INN) 6-диметиламино 4,4-дифенил-3- гептан-3-ол - Норацетилметадол (INN) (+)- а-3-ацетокси-6- метиламино-4,4- дифенилгептан - Норацетилметадол клюконат - Норацетилметадол гидрохлорид - Декстропропоксифен (INN) - Декстропропоксифен гидрохлорид - Левацетилметадол (INN) - Левопропоксифен (INN) - Дименоксадол (INN) - Дименоксадол гидрохлорид - Димептанол (INN) - Димептанол гидрохлорид		

	2922.30.00	- Аминоальдегид, аминокетон ба аминохинон (нэгээс дээш төрлийн хүчтөрөгчийн үүрэг бүлэг агуулсан бусад); тэдгээрийн давс - Амино- хүчил, түүний нийлмэл эфир (нэгээс дээш төрлийн хүчилтөрөгчийн үүрэгт бүлэг агуулснаас бусад), тэдгээрийн давс. Үүнд: - Изаметадон (INN) 6-диметиламино-5-метил- 4,4 дифеннилгексан-3-он - d-Изометадон - l-Изометадон - Изометадон гидробром - Изометадон гидрохлорид - Метадон (INN) - d- Метадон - l- Метадон - Метадон гидробромид - Метадон гидрохлорид - Норметадон (INN) - Норметадон 2,6- ди-терт- бутилнафтален дисульфонат - Норметадон гидробромид - Норметадон гидрохлорид - Норметадон метилиодид - Норметадон ацетат - Норметадон пикрат			
	2922.39.00	- Ретар - Ретар гидрохлорид			
	2922.49.00	Бусад - Тилидин (INN) (+) -этил-транс-2-(диметиламино)-1-фенил-3-циклогексен-1-карбоксилат - Тилидин гидрохлорид			
	2922.50.00	- Амино-спирт-фенол, амино- хүчил-фенол, хүчилтөрөгчийн үүрэг бүлэг агуулсан бусад амино нэгдэл Үүнд - Дименоксадол (INN)			

29.24		Карбоксиамидийн үүрэгт бүлэг бүхий нэгдэл, нүүрсхүчлийн амидын үүрэгт бүлэг бүхий нэгдэл. Үүнээс:		
	2924.10.00	- Флуорацета-амид		
	2924.29.00	Бусад: - Диампромид (INN) - Диампромид сульфат		
29.26		Нитрилийн үүрэг бүхий бүлэгтэй нэгдэл. Үүнээс:		
	2926.90.00	Бусад: - Метадон (INN)- завсрын бодис - Норметадон (INN) завсрын бодис		
29.33		Зөвхөн азотын гетеро-атомтай гетероцагираг нэгдэл. Үүнээс:		
	2933.39.00	Бусад: - Ацетил-α-метилфентанил - Алфентанил (INN) - Алфентанил гидрохлорид - Аллилпродин (INN) 3-аллил-1-метил-4-пропионоксипипевридин - Аллилпродин гидрохлорид - Альфамепродин (INN) - Альфапродин (INN) А-1.3-диметал-4-фенил-4-Пропионоксипипевридин - Альфапродин гидрохлорид - Анилеридин (INN) - Анилеридин дигидрохлорид - Анилеридин фосфат - Алфентанил (INN) - Бензетидин (INN) - Бензетидин гидробромид - Бензетидин гидрохлорид - Бетамепродин (INN) - Бетапродин (INN) - Бетапродин гидрохлорид - Безитрамид (INN) - Безитрамид гидрохлорид - Дифеноксин (INN)		

- Дифеноксин гидрохлорид
- Дифеноксилат (INN)
- Дифеноксилат гидрохлорид
- Дипиванон (INN)
- Дипиванон гидрохлорид
- Дипиванон гидробромид
- Дифеноксин (INN)
- Этоксеридин (INN)
- Этоксеридин гидрохлорид
- Фентанил (INN)
- Фентанил цитрат
- Р- Фентанил
- Р- Фентанил гидрохлорид
- Р- Фторфентанил
- Р- Фторфентанил гидрохлорид
- Фенампромид (INN)
- Фенампромид гидрохлорид
- Фенотеридин (INN)
- Фенотеридин гидрохлорид
- Феназоцин (INN)
- Феназоцин гидробромид
- Феназоцин гидрохлорид
- Феназоцин мезилат
- Фуретидин (INN)
- β-Гидроксифентанил
- β-Гидроксифентанил гидрохлорид
- (+)-цис- β-Гидрокси-3-пп- метилфентанил
- β-Гидрокси-3-метилфентанил
- β-Гидрокси-3-метилфентанил гидрохлорид
- Гидроксипетидин (INN)
- Гидроксипетидин гидрохлорид
- Кетобэмидон (INN)
- Кетобэмидон (INN) гидрохлорид
- Норпипанон (INN)
- Норпипанон гидрохлорид
- Норпипанон гидробромид
- Метазоцин (INN)
- Метазоцин гидрохлорид
- Метазоцин гидробромид

		- 3-Метилфентанил - 3-Метилфентанил гидрохлорид - α-Метилфентанил - α-Метилфентанил гидрохлорид - MPPP - MPPP гидрохлорид - Петидин (INN) - Петидин (INN) гидрохлорид - Петидин (INN) завсрын бодисА - Петидин (INN) завсрын бодисБ - Петидин (INN) завсрын В гидрохлорид - Петидин (INN) завсрын В гидробромид - Петидин (INN) завсрын С - Пиминодин (INN) - Пиминодин дигидрохлорид - Пиминодин эсилат - Пиритрамид (INN) - Проперидин (INN) - Проперидин гидрохлорид - Пропарим (INN) - Пропарим фумарат - Триметперидин (INN) - Триметперидин гидрохлорид			
	2933.40.00	- Хинолин буюу изохинолиний цагираг систем (устөрөгчөн буюу устөрөгчөөгүй) агуулсан цашид шахагүй нэгдэл - Бүтцэндээ пиримидиний цагираг агуулсан (устөрөгчөөн буюу устөрөгчөөгүй) буюу пиперазиний цагираг агуулсан нэгдэл. Үүнд: - Дротебанол (INN) - Левометорфан (INN) - Левометорфан гидробромид - Левометорфан устөрөгчит тартрат (витартрат) - Левофенацетилморфан (INN) - Левофенацетилморфан гидрохлорид - Левофенацетилморфан метилсульфонат - Леворфанол (INN) - Леворфанол устөрөгчит тартрат (витартрат)			

		- Леворфанол гидрохлорид - Норлеворфанол (INN) - Норлеворфанол гидробромид - Норлеворфанол гидрохлорид - Феноморфан (INN) - Феноморфан гидробромид - Феноморфан устөрөгчит тартрат (витартрат) - Феноморфан метилбромид - Рацеметорфан (INN) - Рацеметорфан (INN) гидробромид - Рацеметорфан (INN) устөрөгчит тартрат (витартрат) - Рацеморфан (INN) - Рацеморфан (INN) гидробромид - Рацеморфан (INN) гидрохлорид - Рацеметорфан (INN) устөрөгчит тартрат (витартрат)			
29.33		Зөвхөн азотын гетеро-атомтай гетероцатриг нэгдэл. Үүнээс:			
	2933.90.00	Бусад: - Метазоцин (INN) - Этонитазен (INN) - Этонитазен гидрохлорид - Феназоцин (INN) - Прогентазин (INN) - Прогентазин цитрат - Прогентазин гидробромид - Прогентазин гидрохлорид - Клинотазен (INN) - Клинотазен гидрохлорид - Клинотазен месилат			
29.34		Нуклейн /бөөм/-ий хүчил ба түүний давс, гетероцагратт бусад нэгдэл. Үүнээс:			
	2934.90.00	Бусад: - Декстроморамид (INN) - Декстроморамид дигидрохлорид - Декстроморамид устөрөгчит тартрат (витартрат)			

		- Диэтилтиамбутен (INN) - Диэтилтиамбутен гидрохлорид - Диэтилтиамбутен - Диметилтиамбутен (INN) - Диметилтиамбутен гидрохлорид - Диоксафетил бутират (INN) - Диоксафетил бутират гидрохлорид - Левоморамид (INN) - Левоморамид дигидрохлорид - Морамид-завсрын бодис - Морфериден (INN) - Морфериден дигидрохлорид - Морфериден пикрат - α-Метилтиофентанил - α-Метилтиофентанил гидрохлорид - 3 -Метилтиофентанил - 3 -Метилтиофентанил гидрохлорид - (+) –цис- 3- Метилтиофентанил - (+) –цис- 3- Метилтиофентанил гидрохлорид - Фенадоксон (INN) - Фенадоксон гидрохлорид - Фуретидин (INN) - Фуретидин гидробромид - Фуретидин метилиодид - Фуретидин пикрат - Рацеморамид (INN) - Суфентанил (INN) - Суфентанил цитрат - Этилметилтиамбутен (INN) - Этилметилтиамбутен гидрохлорид - Тиофентанил		
29.39		- Тиофентанил гидрохлорид Ургамлын гаралтай байгалийн бүхүү нийлэг алкалиод, тэдгээрийн давс, энтийн ба нийлмэл эфир, бусад уламжлал. Үүнээс:		

	2939.10.00	- Хар тамхины алкалоид, түүний уламжлал, тэдгээрийн давс - Хинин модны алкалоид, түүний уламжлал, тэдгээрийн давс. Үүнд: - Ацеторфин (INN) - Ацеторфин гидрохлорид - Ацетилдигидрокодеин - Ацетилдигидрокодеин гидрохлорид - Ацетилморфин - 3- Ацетилморфин - 6- Ацетилморфин - Бензоилморфин - Бензилморфин - Бензилморфин гидрохлорид - Бензилморфин месилит - Бензилморфин - Кодеин - Кодеин ацетат - Кодеин фосфат -Кодеин аллобарбитурат - Кодеин барбитурат - Кодеин камфосульфонат - Кодеин цитрат - Кодеин циклобарбитурат - Кодеин циклопентобарбитурат - Кодеин 6-глюкуронид - Кодеин гидробромид - Кодеин гидрохлорид - Кодеин гидроиодид - Кодеин метилбромид - Кодеин фенобарбитурат - Кодеин резинат - Кодеин салицилат - Кодеин сульфат - Кодеин N-оксид - Кодеин N-оксид гидрохлорид - Кодеин сульфат - Дезоморфин (INN)		

- Дезоморфин гидрохлорид
- Дезоморфин гидробромид
- Дезоморфин сульфат
- Дигидрокодеин (INN)
- Дигидрокодеин гидрохлорид
- Дигидрокодеин устрвеч тартрат (битартрат)
- Дигидрокодеин фосфат
- Дигидрокодеин резинат
- Дигидрокодеин тюцианат
- Дигидроизоморфин гидриодид
- Дигидроизоморфин гидрохлорид
- Дигидроизоморфин пиктат
- Дигидроизоморфин
- Эторфин (INN)
- Эторфин гидрохлорид
- Эторфин 3- метилийн эфир
- Этилморфин
- Этилморфин гидрохлорид
- Этилморфин камфосульфонат
- Этилморфин гидробромид
- Этилморфин метилиодид
- Этилморфин фенобарбитурат
- Героин
- Героин гидрохлорид
- Героин метилиодид
- Гидрокодон (INN)
- Гидрокодон цитрат
- Гидрокодон гидриодид
- Гидрокодон гидрохлорид
- Гидрокодон устерчит тартрат (битартрат)
- Гидрокодон метилиодид
- Гидрокодон фосфат
- Гидрокодон резинат
- Гидрокодон терефталат
- Гидроморфинол (INN)
- Гидроморфол гидрохлорид

- Гидроморфол тартрат (битартрат)
- Гидроморфон (INN)
- Гидроморфон гидрохлорид
- Гидроморфон сульфат
- Гидроморфон терефталат
- Морфин
- Морфин ацетит
- Морфин цитрат
- Морфин 3,6-диглюкуронид
- Морфин диметилийн эфир
- Морфин глюконат
- Морфин 3-глюкуронид
- Морфин 6-глюкуронид
- Морфин 3-В D глюкуронид
- Морфин 6-В D глюкуронид
- Морфин гидриодид
- Морфин гидробромид
- Морфин гидрохлорид
- Морфин гипофосфит
- Морфин изобутират
- Морфин лактат
- Морфин меконат
- Морфин метилбромид
- Морфин метилхлорид
- Морфин метилиодид
- Морфин метилсульфонат
- Морфин мукат
- Морфин нитрат
- Морфин фенилпропионат
- Морфин фосфат
- Морфин фталат
- Морфин стеарат
- Морфин сульфат
- Морфин тартрат
- Морфин валерат
- Морфин – N- оксид
- Морфин – N- оксид куанит
- Мирофин (INN)
- Мирофин гидрохлорид
- Метилдезорфин (INN)
- Метилдезорфин гидрохлорид
- Метилдигидроморфин (INN)
- Метопон (INN)
- Метопон гидрохлорид
- Никокодин (INN)
- Никокодин гидрохлорид

	- Никодикодин (INN) - Никоморфин (INN) - Никоморфин гидрохлорид - Норкодеин (INN) - Норкодеин ацетат - Норкодеин гидриод - Норкодеин гидрохлорид - Норкодеин нитрат - Норкодеин платинихлорид - Норкодеин сульфат - Норморфин (INN) - Норморфин гидрохлорид - Оксикодон (INN) - Оксикодон камфосульфат - Оксикодон гидрохлорид - Оксикодон устөрөгч тартрат битартрат - Оксикодон пектанит - Оксикодон фенилпропионат - Оксикодон фосфат - Оксикодон тереталат - Оксиморфон (INN) - Оксиморфон гидрохлорид - Фолькодин (INN) - Фолькодин устөрөгчит тартрат битартрат - Фолькодин фитрат - Фолькодин гваяколсульфонат - Фолькодин гидрохлорид - Фолькодин фенилацетат - Фолькодин фосфат - Фолькодин сульфат - Фолькодин тартрат - Тебакон (INN) - Тебакон гидрохлорид - Тебайн устөрөгчит тартрат битартрат - Тебайн оксалат - Тебайн салицилат		
	2939.90.00	Бусад:		
		- Экгонин, түүний экгонин ба кокаин болж		

	хувирах нийлмэл эфир ба уламжлалууд - Экгонин бензоилэтилийн нийлмэл эфир - Экгонин бензоилпропилийн нийлмэл эфир - Экгонин циннамоилметилийн нийлмэл эфир - Экгонин 2,6-диметил- бензоилметилийн эфир - Экгонин гидрохлорид - Экгонин метилийн нийлмэл эфир - Экгонин метил эфирийн гидрохлорид - Экгонин фенилацетилметилийн нийлмэл эфир - Кокаин - d-Кокаин - Кокаин бензоат - Кокаин борат - Кокаин цитрат - Кокаин формат - Кокаин гидриодид - Кокаин гидробромид - Кокаин гидрохлорид - Кокаин лактат - Кокаин нитрат - Кокаин салицилат - Кокаин сульфат - Кокаин тартрат			
	Б. Мансуурууллах бодисыг үйлдвэрлэх буюу хэрэглээнд зориулсан багаж хэрэгсэл		Эдгээр багаж хэрэгслүүдэд эмийн үйлдвэр, эмчилгээ сувилгаа, эрдэм шинжилгээний ажил зэрэг анагаахын бүх салбарт түгээмэл хэрэглэгддэг зүйлс /лухайбал: зүү,тариур/ ордог түл тусгайлан нэр заах болюмгүй бөгөөд гаалийн хяналтын үед тухайн зүйлс зөвхөн мансуурулах бодис, ургамлыг үйлдвэрлэх, хэрэглэхэд ашигладаг тусгай зориулалтын багаж хэрэгсэл болох эсэхийг тогтооно.	
	БУХ ТӨРӨЛИЙН СПИРТ		Монгол Улсын Их Хурлын 1999 оны 11 дүгээр тогтоол	Оруулах

22.07				
	80% буюу түүнээс дээш хэмжээтэй этилийн хувиргагүй спирт, ямаар ч хэмжээтэй байж болох этилийн хувирсан спирт ба бусад спирт			
	ХИМИЙН ЗЭВСЭГ УЙЛДВЭРЛЭХ, ХЭРЭГЛЭХИЙГ ХОРИГЛОХ, ТЭДГЭЭРИЙГ УСТГАХ ТУХАЙ ОЛОН УЛСЫН КОНВЕНЦИЙ ОРСОН ХИМИЙН БОДИСУУД Байгаль орчны сайд, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 1998 оны 83/А160 дугаар хамтарсан тушаалын хоердугаар хавсралтад заасан 66 нэрийн химийн бодис	Химийн хорт бодисоос хамгаалах тухай Монгол Улсын хууль /1995/-ийн 2 дугаар бүлэг, 7.3	Гаргах, оруулах
	МОНГОЛ УЛСАД ХЭРЭГЛЭХИЙГ ХОРИГЛОСОН ХИМИЙН ХОРТ БОДИС Байгаль орчны сайдын 1997 оны 75 дугаар тушаалын хавсралтад заасан химийн бодис /16 нэр/	Химийн хорт бодисоос хамгаалах тухай хууль /1995/	Оруулах
	ХИМИЙН ЗЭВСГИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ХИМИЙН ХОРТ БОДИС, ТҮҮНИЙ ХАЯГДАЛ	Химийн хорт бодисоос хамгаалах тухай хууль /1995/-ийн 2 дугаар бүлгийн 15.3	Оруулах, гаргах
	ЦӨМИЙН ЗЭВСГИЙН ГАРАЛТАЙ ТУСГАЙ АНГИЛЛЫН ЦАГААР ИДЭВХТ БОДИС, ТҮҮНИЙ ХАЯГДАЛ	Цөмийн зэвсгээс ангид байх тухай хууль /2000 он/	Оруулах
	ЦӨМИЙН ЗЭВСГИЙН ЗОРИУЛАЛТААР БЭЛТГЭГДСЭН ЦӨМИЙН ЗЭВСГИЙН ЭД АНГИ, БҮРЭЛДЭХҮҮН	Цөмийн зэвсгээс ангид байх тухай хууль /2000 он/	Оруулах
	АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ	Аюултай хог хаягдлын импорт, хил дамжуулан тээвэрлэлтийг хориглох, экспортлох тухай хууль /2000/	Оруулах
	ДАРХЛАЛЫН ОЛДМОЛ ХОМСДОЛ ӨВЧНИЙ ХАЛДВАРТҮЙ НЬ БАТАГААЖААГҮЙ ЦУС, ЦУСНЫ БҮТЭЭГДЭХҮҮН, ЭД ЭРХТЭН	Дархлалын олдмол хомсдол өвчнөөс сэргийлэх тухай хууль /1993/	Оруулах
	ЗАЙЛШГҮЙ ХЭЛНАПТАНД БАЙХ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ЗОРИУЛАЛТТАЙ ЭД ЭРХТЭН, ДОНОРЫН ЦУС	Дархлалын олдмол хомсдол өвчнөөс сэргийлэх тухай хууль /1993/ Засгийн газрын 1994 оны 32 дугаар тогтоол	

30.01		Хүн эмнэлэгт хэрэглэх хатаасан, нунтагласан буюу нунтаглаагүй булчирхай, бусад эрхтэн; хүн эмнэлэгт хэрэглэх булчирхай болон бусад эрхтэний ханд, тэдгээрийн ялгарал, шүүрлийн ханд; гепарин, түүний давс; эмчилгээ, урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэглэх, бусад газар заагаагүй хүн, мал, амьтны гаралтай бусад бодис. Үүнээс		
	3001.10.00	Хатаасан, нунтагласан буюу нунтаглаагүй булчирхай, бусад эрхтэн		
	3001.20.00	Булчирхай болон бусад эрхтэний ханд, тэдгээрийн ялгарал, шүүрлийн ханд		
	3001.90.00	Бусад		
30.02		Донорын цус, оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх зориулалттай мал, амьтны цус; эсрэгийлдэс, цусны бусад фракц, биологийн ба бусад аргаар гарган авсан дархлалын хувирмал бэлдмэл; вакцин хор, бичил биетны өсгөвөр (хөрөнгөрцөөс бусад) ба эдгээртэй төстэй бүтээгдэхүүн. Үүнээс:		
	3002.10.00	Эсрэгийлдэс ба цусны бусад фракц, биотехнологийн болон бусад аргаар гарган авсан дархлалын хувирмал бэлдмэл		
	3002.20.00	Хүн эмнэлгийн зориулалттай вакцин		
	3002.90.00	Бусад		
		ГОЙД АШИГ ШИМТ МАЛ, ТҮҮНИЙ ҮР, ҮР ХӨВРӨЛ /Гойд ашиг шимт мал, түүний үр, үр хөврөлийг зохих журмын дагуу олон улсын генийн банкинд хадгалуулахаас бусад тохиолдолд/	Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль /1993/	
01.01		Адуу, илжиг, луус ба хөдий луус. Үүнээс		
		Адуу		

01.02		Үхэр			
01.04		Хонь,ямаа			
01.06		Бусад мал, амьтан. Үүнээс:			
		Тэмээ			
05.11		Бусад газар заагдаагүй, амьтны гаралтай бусад бүтээгдэхүүн. БНХС-ийн 1 бүлэг 3 дугаар бүлэгт заагдсан, хүнээнд тохирохгүй үхсэн амьтад. Үүнээс:			
	0511.10	Бухын үр			
	0511.99	Үржлийн мал, амьтны үр /бухын үр орохгүй/			
		САДАР САМУУНЫГ СУРГАЛЧИЛСАН ХЭВЛЭЛ, НОМ ЗОХИОЛ, КИНО, ДУРС БИЧЛЭГ, ЗУРАГ БОЛОН БУСАД ЗҮЙЛС Ном, сонин, зураг хуудас нь Барааг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн 49-р бүлэгт хамаарах бөгөөд түүн дотор садар самууныг сургалчилсан ном, сонин, зураг хуудас гэсэн тусгай код байхгүй түүл энэ бүлэг бараат бүлгээр, код заалтгүй орулав. Энэ бүлэг барааг зөвхөн садар самууныг сургалчилсан ном, зохиол, кино, дурс бичлэг гэж мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн хориглоно	Садар самуун явдлаатай тэмцэх тухай хууль /1998/	Оруулах, гаргах	

МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР ЛИЦЕНЗТЭЙ НЭВТРҮҮЛЭХ БАРААНЫ КОДЛОСОН ЖАГСААЛТ

Бараг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн зүйл №	Бараг тодорхойлох, кодлох уялдуулсан системийн мөр №	Барааны бичиглэл	Үндэслэл бүхий эрх зүйн акт	Улсын хилээр нэвтрүүлэх ялгаа	Зөвшөөрөл, тодорхойлолт, дүгнэлт гаргах байгууллага, албан тушаалтан
		ҮРЖЛИЙН МАЛ	Монгол Улсын малын үдмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль /1993/-ийн 4 дүгээр бүлэг 14.8, Монгол Улсын Их Хурлын 1998 оны 05 дугаар тогтоол	Гаргах	Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн улсын хяналтын албаны зөвшөөрөл
	0101.11.00	Цэвэр үүлдрийн үржлийн адуу			
	0101.19.00	Үржлийн бусад адуу			
	0102.10.00	Цэвэр үүлдрийн үржлийн үхэр			
	0102.90.00	Үржлийн бусад үхэр			
	0104.10.00	Хонь			
	0104.20.00	Ямаа			
	0106.00.11	Тэмээ			
		АН АМЬТАН, ТЭДГЭЭРИЙН ГАРАЛТАЙ ТҮҮХИЙ ЭД, АН АМЬТНЫ ХОЛБОГДОЛТОЙ СУДАЛГААНЫ АЖЛЫН СОРЬЦ, ДЭЭЖ, МАЛ, АМЬТНЫ ҮР ХӨВРӨЛ, БИЧИЛ БИЕТНИЙ ӨСГӨВӨР	Монгол Улсын Их Хурлын 1998 оны 05 дугаар тогтоол	Гаргах	
		Нэн хомор ан амьтан Амьтны аймгийн тухай хууль /2000/ -д заасан 26 нэрийн амьтан	Амьтны аймгийн тухай хууль /2000/	Гаргах Шууд лиценз	Засгийн газрын зөвшөөрөл
05.07		Боловсруулаагүй буюу энгийн аргаар бэлтгэсэн /хэлбэр оруулаагүй/ зааны яс, яст мэлхийн хуяг, халимны яс, халимны сахал, бүгын ба бусад эвэр, туурай, хумс, савар, шүвүүны хошуу, эдгээрийн нунтаг, хаягдал, Үүнээс:	Монгол Улсын Их Хурлын 1998 оны 05 дугаар тогтоол	Гаргах	БОЯ-ны зөвшөөрөл

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ
2001 он, №18 (205)

	0507.90	Бүгын цусан эвэр Бүгын ясан эвэр Аргалын эвэр Янгирын эвэр			
05.10		Цайвар бөөшил, минж, мануул болон хүдрийн заар, хатаасан цох, хатаасан буюу хатаагаагүй цөс, эмийн үйлдвэрлэлд хэрэглэх булчирхай зэрэг шинэ, хөргөсөн, хөлдөөсөн ба бусад аргаар хадгалсан амьтны гаралтай бүтээгдэхүүн. Үүнээс:			
	0510.00.00	Эмийн үйлдвэрлэлд хэрэглэдэг амьтны бие эрхтэн			
	0510.00.11	Хүдрийн заар			
	0510.00.12	Бүгын чив засаа			
05.11		Бусад газар заагдаагүй амьтны гаралтай бусад бүтээгдэхүүн, БТКУС-ийн 1 буюу 3 дугаар бүлэгт заагдсан, хүнсэнд тохирохгүй үхсэн амьтад. Үүнээс:	Монгол Улсын малын үдмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай хууль /1993/-ийн 4 дүгээр бүлэг 14.8, Монгол Улсын Их Хурлын 1998 оны 05 дугаар тогтоол	Гаргах	Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн улсын хяналтын албаны зөвшөөрөл
	0511.10.00	Бухын үр			
	0511.99.10	Үржлийн мал, амьтны үр (бухын үр орохгүй),ийлдэс			
	0511.99.90	Үржлийнхээс бусад мал, амьтны үр хөврөл			
		БАЙГАЛИЙН УРГАМАЛ	Байгалийн ургамлын тухай хууль /1995/	Гаргах	БОЯ-ны зөвшөөрөл
		А. Нэн ховор ургамал Байгалийн ургамлын тухай хууль /1995/ -ийн хавсралтад нэр заасан нэн ховор ургамал /133 нэр/1			
		Б. Ховор ургамал Засгийн газрын 1995 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан жагсаалтад нэр заасан ургамал /352 нэр/			
26.12		УРАНЫ БҮЮУ ТОРИЙН ХҮДЭР БА БАЯЖМАЛ. Үүнээс:	Монгол Улсын Их Хурлын 1998 оны 05 дугаар тогтоол, Засгийн газрын 2000 оны 56 дугаар тогтоол	Гаргах, оруулах	Цацрагийн хяналтын албаны дүгнэлт

	2612.10.00	Ураны хүдэр ба баяжмал				
		ЦАЦРАГ ИДЭВХТ БОДИС, ИОНАКУУЛАГЧ ЦАЦРАГИЙН БУСАД УУСГҮҮР	Заспийн газрын 2000 оны 56 дугаар тогтоол	Гаргах, оруулах		Цацрагийн хяналтын албаны дүгнэлт
28.44		Цацраг идэвхт химийн элемент ба цацраг идэвхт изотоп /хувиаргадгч бүсэу бэлэг химийн элемент болон изотоп орно/ ба тэдгээрийн нэгдэл. изотоп гэдгээрийг агуулсан хольц, уплдгэлэ. тэдгээрийг агуулсан хольц, уплдгэлэ.				
28.45		БТКУС-ийн Эүил № 28.44-т зааснаас бусад изотоп, тэдгээрийн химийн хувьд тодорхойлогдсон бүсэу тодорхойлогдоогүй органик бүсэу органик биш нэгдэл				
		ОНЦГОЙ ХОРТОЙ ХИМИЙН БОДИС /Байгаль орчны сайд, Эрүүл мэнд, нийтийн хамгааллын сайдын 1998 оны 83/А/160 дугаар хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралтын А-д заасан 96 нэрийн химийн бодис/	Химийн хорт бодисоос хамгаалах тухай Монгол улсын хууль/1995/-ийн 2 дугаар бүлэг, 7.3; Монгол Улсын Их Хурлын 1998 оны 05 дугаар тогтоол	Гаргах, оруулах		Химийн хорт бодис ашиглах хэмлгаагаг зохицуулах зевлөөрлйн дүгнэлт БОЭ-ны зевшөөрөл
		ХОРТОЙ ХИМИЙН БОДИС /Байгаль орчны сайд, Эрүүл мэнд, нийтийн хамгаалпын сайдын 1998 оны 83/А/160 дугаар хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралтын Б-д заасан 139 нэрийн химийн бодис/	Химийн хорт бодисоос хамгаалах тухай Монгол улсын хууль/1995/-ийн 2 дугаар бүлэг, 7.2	Оруулах		Аймаг,нийслэлийн Засаг даргын зевшөөрөл
		БАГА ХОРТОЙ ХИМИЙН БОДИС /Байгаль орчны сайд, Эрүүл мэнд, нийтийн хамгаалпын сайдын 1998 оны 83/А/160 дугаар хамтарсан тушаалын нэгдүгээр хавсралтын В-д заасан 171 нэрийн химийн бодис/	Химийн хорт бодисоос хамгаалах тухай Монгол улсын хууль/1995/-ийн 2 дугаар бүлэг, 7.3	Оруулах		Аймаг нийслэлийн Засаг даргын зевшөөрөл

	ОЗОНЫ ҮЕ ДАВХАРГЫГ ЗАДАЛДАГГҮЙ БОДИСЫН ТУХАЙ МОНРЕАЛЬН ПРОТОКОЛД ОРСОН ХИМИЙН БОДИСУУД /байгаль орчны сайд, Эрүүл мэнд, нийгмийн хамгааллын сайдын 1998 оны 83/А/160 дугаар хамтарсан тушаалын гуравдугаар хавсралтад заасан 95 нэрийн химийн бодис/	Химийн хорт бодисоос хамгаалах тухай Монгол улсын хууль /1995/ийн 2 дугаар бүлэг, 7 3.	Гаргах, оруулах	Химийн хорт бодис ашиглах үйл ажиллагаа зохицуулах эвлелтийн дүнэлт, БОЭ-ны зөвшөөрөл
	АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ Тэсрэмсий, шатамхай шингэн бүхэу хатуу, еерес шатдаг, цацраг идэвхт, хөрс, агаар устай харьцан үйлчилэнээс хортой, эсхуп галын аюултай хий ялгаруудаг, исэлдүүлэгч, идэмхий, органик ислийн хавгдал нь аюултай хог хаягдалд хамаарна.	Аюултай хог хаягдлын импорт, хил дамжуулан тээвэрлэлтийг хоригпох, экспортлох тухай хууль /2000/	Гаргах	Мэргэжлийн байгууллагын дүнэлт, БОЭ-ны тодорхойлолт
	ЗАЙЛШГҮЙ ХЭНАПТАНД БАЙХ, ЭМЧИЛГЭЭ, УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, ЗОРИУЛАЛТТАЙ ЭД ЭРХТЭН, ДОНОРЫН ЦУС, БИЧИЛ БИЕТНИЙ ӨСГӨӨР	Дархлалын олдмол хомсдол евчнеес сэргийлэх тухай хууль /1993/ Монгол Улсын Их Хурлын 1998 оны 05 дугаар тогтоол, Засгийн газрын 1994 оны 32 дугаар тогтоол Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль /2001/	Гаргах, оруулах	Эрүүл мэндийн яамны тодорхойлолт
30.01	Хүн эмнэлэг хэрэглэх хатаасан, нунтагласан буюу нунтаглаагүй бүлчирхай, бусад эрхтэн; хүн эмнэлэг хэрэглэх бүлчирхай болон бусад эрхтэний хэнд, тэдгээрийн ялгарал, шүүрлийн хэнд ; гепарин, түүний давс; эмчилгээ, урьдчилан сэргийлэх зорилгоор хэрэглэх, бусад газар зааагаүй хүн, мал, амьтны гаралтай бусад бодис. Үүнээс:			
	3001.10.00 Хатаасан, нунтагласан буюу нунтаглаагүй бүлчирхай, бусад эрхтэн			
	3001.20.00 Бүлчирхай болон бусад эрхтэний хэнд, тэдгээрийн ялгарал, шүүрлийн хэнд			

(Гаргасан нь дараагийн дугаарт)

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хянг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 19 (206)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай*
- *Галт зэвсгийн тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай*
- *Галт зэвсгийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2001 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2001 оны тавдугаар сарын 18 №19 (206)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

228. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай (2001-4-19-ний хууль) 506
229. Галт зэвсгийн тухай (2001-4-26-ны хууль) 512

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

230. Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн зарим зүйлийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл буцаах тухай Дугаар 31 516
231. Улсын Их Хурлын 2000 оны 32 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай Дугаар 32 516
232. Норматив тогтоох тухай тогтоолын төсөл буцаах тухай Дугаар 33 516
233. Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл буцаах тухай Дугаар 34 517
234. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай Дугаар 35 517
235. Галт зэвсгийн тухай хуульд батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай Дугаар 41 517

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

236. Засгийн газрын 2001 оны 54 дүгээр тогтоолын үргэлжлэл 518
237. Тогтоолд нэмэлт оруулах тухай Дугаар 56 525
238. Б.Ганболдыг Төрийн нарийн бичгийн даргаар томилох тухай Дугаар 57 525
239. Тогтоолын заалтад өөрчлөлт оруулах тухай Дугаар 58 525
240. Хариуцлага хүлээлгэх тухай Дугаар 59 525
241. Журамд өөрчлөлт оруулах тухай Дугаар 60 526
242. Тооны дээд хязгаар тогтоох тухай Дугаар 61 526
243. Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх тухай Дугаар 62 527
244. Импортын барааны гаалийн үнийг тодорхойлох аргачлал батлах тухай Дугаар 63 533

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр

Улаанбаатар хот

ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны төрөл, хэлбэр, хамрах хүрээ, санхүүжилт, хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын эрх зүйн үндсийг бүрдүүлж, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомж

2.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль[1], Хөдөлмөрийн тухай хууль[2], Нийгмийн даатгалын тухай хууль[3], энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

3.1. Энэ хуульд заасан дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "ажилгүй иргэн" гэж хөдөлмөрийн насны, хөдөлмөрийн чадвартай, хөдөлмөр эрхлэх боломжтой, ажил идэвхтэй хайж байгаа, хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн иргэнийг;

3.1.2. "ажил хайч" гэж хөдөлмөр эрхэлдэг боловч ажлаа өөрчлөх хүсэлтэй, эсхүл нэмэлт цагаар буюу ажил гүйцэтгэх гэрээгээр ажил хийх боломжтой, хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн иргэнийг;

3.1.3. "ажил идэвхтэй хайж байгаа иргэн" гэж хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн өдрөөс хойш сард нэгээс доошгүй удаа ажил хайж байгаагаа мэдэгдсэн иргэнийг;

3.1.4. "ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн" гэж хөдөлмөрийн гэрээ цуцлах мэдэгдэл авсан, байнгын бус орлоготой, хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгүүлсэн иргэнийг;

3.1.5. "ажилд зуучлах" гэж ажилд орохыг хүссэн иргэний хүсэл сонирхол, мэргэжлийн ур чадварт нь тохирсон ажил санал болгох, ажил олгогчийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн ажилтан олоход туслалцаа үзүүлэхийг.

4 дүгээр зүйл. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төрийн бодлого

4.1. Төрөөс хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар дараахь бодлого хэрэгжүүлнэ:

4.1.1. хүн амын хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэх;

4.1.2. хөрөнгө оруулалтыг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээтэй уялдуулах;

4.1.3. ажиллах хүчний эрэлт, нийлүүлэлтийг оновчтой зохицуулах;

4.1.4. ажиллах хүчийг зах зээлийн эрэлтэд нийцүүлэн хөгжүүлэх;

4.1.5. хүн амын хөдөлмөр эрхлэлтийн талаарх бүртгэл, мэдээллийг боловсронгуй болгох;

4.1.6. ажилгүйдлийн даатгалд хамрагчийн хүрээг өргөтгөж, иргэн бүрийг ажилгүйдлээс хамгаалах.

4.2. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бодлого хэрэгжүүлэхэд дараахь зарчим баримтална:

4.2.1. хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд иргэнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, хөрөнгө чинээ, боловсрол, нийгмийн гарал, байдал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь үл ялгаварлах;

4.2.2. хүн амын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа нь адил тэгш, хүртээмжтэй, ажлын байрны мэдээлэл нээлттэй, ил тод байх нөхцөл бүрдүүлэх;

4.2.3. хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд иргэн сайн дурын үндсэн дээр хамрагдах.

5 дугаар зүйл. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны төрөл, хэлбэр

5.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаа нь дор дурдсан төрөлтэй байна:

5.1.1. хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ;

---

[1] *Үндэсн хууль. "Төрийн мэдээлэл"-ийн 1992 оны № 1 дугаарт нийтлэгдсэн.*

[2] *Хөдөлмөрийн тухай хууль. "Төрийн мэдээлэл"-ийн 1999 оны № 25 дугаарт нийтлэгдсэн.*

[3] *Нийгмийн даатгалын тухай хууль. "Төрийн мэдээлэл"-ийн 1994 оны № 8 дугаарт нийтлэгдсэн.*

5.1.2. хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ;

5.1.3. ажилгүйдлийн тэтгэмж олгох.

5.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ дараахь хэлбэрээр хэрэгжинэ:

5.2.1. ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах;

5.2.2. ажилд зуучлах;

5.2.3. мэргэжил олгох, давтан сургалтад хамруулах;

5.2.4. хууль тогтоомжид заасан бусад үйлчилгээ.

5.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ нь дараахь хэлбэрээр хэрэгжинэ:

5.3.1. хувираа болон нөхөрлөл, хоршооны хэлбэрээр аж ахуй эрхлэх иргэнийг дэмжих;

5.3.2. ажил олгогчийг дэмжих;

5.3.3. нийтийг хамарсан ажил зохион байгуулах;

5.3.4. хууль тогтоомжид заасан бусад арга хэмжээ.

5.4. Ажилгүйдлийн тэтгэмж олгох нөхцөл, журмыг Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай[1] хуулиар тогтооно.

6 дугаар зүйл. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны хамрах хүрээ

6.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд хөдөлмөрийн зах зээлийн харилцаанд оролцогч ажилгүй иргэн, ажил хайгч болон ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн, ажил олгогч, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр, төсөл санаачлагч, хэрэгжүүлэгч хамрагдана.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ

7 дугаар зүйл. Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах

7.1. Хөдөлмөр эрхлэлтийн орон нутгийн алба нь хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцүүлэн иргэдэд ажил, мэргэжлээ сонгох, мэргэжлийн чиг баримжаа олгох, давтан сургалтад хамрагдах нөхцөл, боломжийн талаар зөвлөгөө өгч, хөдөлмөрийн зах зээлтэй холбогдох шаардлагатай мэдээллээр хангана.

7.2. Энэ хуулийн 7.1-д заасан үйлчилгээ нь үнэ төлбөргүй байна.

7.3. Ажил, мэргэжлийн чиг баримжаа олгох, мэргэжлийн зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээг ганцаар буюу хэсэг, бүлгээр зохион байгуулна.

8 дугаар зүйл. Ажилд зуучлах

8.1. Хөдөлмөр эрхлэхийг хүссэн ажилгүй иргэн, ажил хайгч, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэнийг хөдөлмөр эрхлэлтийн орон нутгийн алба бүртэж, ажил олгогчийн эрэлт, хэрэгцээг үндэслэн ажилд зуучилна.

8.2. Ажилд зуучлах үйлчилгээг хувийн болон төрийн бус байгууллагын хөдөлмөр зуучлалын алба гүйцэтгэж болно.Хөдөлмөр эрхлэлтийн албанаас тэднийг хөдөлмөрийн зах зээлтэй холбогдох шаардлагатай мэдээллээр хангана.

8.3. Ажилд зуучлах тохиолдолд ажлын байрны захиалга, түүнд тавих шаардлагын талаарх мэдээлэл ил тод байна.

8.4. Ажилд зуучлах төрийн үйлчилгээ үнэ төлбөргүй байна.

9 дүгээр зүйл. Мэргэжил олгох, давтан сургалтад хамруулах

9.1. Хөдөлмөр эрхлэлтийн алба нь эрх бүхий мэргэжлийн сургалтын байгууллага болон ажил олгогчтой хамтран мэргэжлийн сургалтад хамрагдах хүсэлтэй дараахь иргэнийг мэргэжил олгох, давтан сургалтад хамруулна:

9.1.1. мэргэжилгүй, эсхүл мэргэжлийн ур чадвар доогуур хүн амын эмзэг бүлэгт хамрагдах ажилгүй иргэн;

9.1.2. зээмшсэн мэргэжилд нь тохирох ажил олдохгүйгээс мэргэжлээ өөрчлөх шаардлагатай байгаа ажилгүйдэлд өртөж болзошгүй болон ажилгүй иргэн;

9.1.3. үйлдвэрлэлийн осол, хурц хордлого, мэргэжлээс шалтгаалсан өвчний улмаас мэргэжлээ өөрчлөхийг хүссэн ажил хайгч, ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэн;

9.1.4. мэргэжлийн онцлогоос шалтгаалан өндөр насны тэтгэвэр тогтоолгохоос өмнө ажилгүйдэлд өртөж болзошгүй болон ажилгүй болсон иргэн;

9.1.5. тухайн онд ерөнхий боловсролын сургуулийн 8,10 дугаар анги төгссөн, эсхүл хугацаат цэргийн албанаас халагдсан ажил, сургуульгүй иргэн.

9.2. Хувираа аж ахуй эрхлэх иргэнийг аж

[1] *Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль. "Төрийн мэдээлэл"-ийн 1994 оны № 8 дугаарт нийтлэгдсэн.*

ахуйн үйл ажиллагаа эрхлэх арга барил, ур чадвар эзэмшүүлэх сургалтад хамруулж болно.

9.3. Энэ хуулийн 9.1-д заасан иргэд мэргэжил олгох, давтан сургалтад хамрагдсанаас хойш 2 жилийн дараа дахин хамрагдаж болно.

9.4. Энэ хуулийн 9.1, 9.2-т заасан сургалтын зардлыг Хөдөлмөр эрхлэлтийн алба, сургалтын байгууллага болон ажил олгогчийн хооронд байгуулсан гэрээг үндэслэн Засгийн газраас тогтоосон нэг хүнд ногдох зардлын хэмжээгээр тооцож Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээ

10 дугаар зүйл. Хувираа болон нөхөрлөл, хоршооны хэлбэрээр аж ахуй эрхлэх иргэнийг дэмжих

10.1. Хувираа болон нөхөрлөл, хоршооны хэлбэрээр аж ахуй эрхлэх иргэнийг дэмжих арга хэмжээ нь жижиг үйлдвэр, үйлчилгээ, өрхийн аж ахуй эрхлэх буюу жижиг зээлийн төсөл хэрэгжүүлэх хүсэл сонирхолтой иргэнд хөдөлмөр эрхлэх боломжийг бүрдүүлэхэд чиглэнэ.

10.2. Хувираа болон нөхөрлөл, хоршооны хэлбэрээр аж ахуй эрхлэх иргэнд дараахь дэмжлэг үзүүлнэ:

10.2.1. материал, түүхий эд, багаж хэрэгсэл худалдан авах буюу бусад зайлшгүй шаардлагатай хөрөнгө оруулахад нь Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас эргэж төлөгдөх нөхцөлтэйгээр жижиг зээл олгох.

10.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас жижиг зээл олгох журмыг Засгийн газар тогтооно.

11 дүгээр зүйл. Ажил олгогчийг дэмжих

11.1. Хөдөлмөр эрхлэлтийн албанд бүртгэлтэй, 1 жилээс дээш хугацаагаар ажилгүй байсан иргэнийг ажилд авч, 6 сараас дээш хугацаагаар тогтвортой ажиллуулж байгаа ажил олгогчид тухайн ажилтанд олгосон эхний 6 сарын цалингийн нийлбэрийн 60 хувийг холбогдох татвар, нийгмийн даатгалын байгууллагын тодорхойлолтыг үндэслэн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас нөхөн олгоно.

11.2. Хөдөлмөр эрхлэлтийн албатай байгуулсан гэрээний үндэсэн дээр ажилгүй иргэнийг үйлдвэрлэл дээрээ сургалтад хамруулж, 3 сараас дээш хугацаагаар ажлын байраар хангасан ажил олгогчид энэ хуулийн 9.4-т заасан хэмжээгээр нэг хүнд ногдох зардлыг тооцон, сургалтад хамрагдсан болон мэргэжил эзэмшсэн тухай баримт бичгийг үндэслэн сургалтын зардлыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас нөхөн олгоно.

11.3. Ажилгүйдэлд өртөж болзошгүй иргэнийг сургалтад хамруулж үргэлжлүүлэн ажиллуулж байгаа ажил олгогчид энэ хуулийн 9.4-т заасан хэмжээгээр нэг хүнд ногдох зардал, тухайн ажилтны 3 сарын цалингийн нийлбэрийн 40 хувийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас нөхөн олгоно.

12 дугаар зүйл. Нийтийг хамарсан ажил зохион байгуулах

12.1. Нийтийг хамарсан ажил зохион байгуулах арга хэмжээ нь хөдөлмөр зарцуулалт ихтэй, мэргэжил болон мэргэжлийн урьдчилсан бэлтгэл шаардахгүй ажилд хөдөлмөр эрхлээгүй иргэдийг олноор нь зохион байгуулж оролцуулахад чиглэнэ.

12.2. Нийтийг хамарсан ажлыг Хөдөлмөр эрхлэлтийн албаны оролцоотойгоор орон нутгийн Засаг даргын тамгын газар зохион байгуулна.

12.3. Шаардлагатай тохиолдолд нийтийг хамарсан ажлыг тухайн нутаг дэвсгэрийн ажил олгогч санаачлан зохион байгуулж болно. Ажил олгогч нь нийтийг хамарсан ажил зохион байгуулах бол энэ талаар Хөдөлмөр эрхлэлтийн албатай гэрээ байгуулна.

12.4. Нийтийг хамарсан ажлыг зохион байгуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага нь уг ажилд оролцож байгаа иргэнтэй хөдөлмөрийн гэрээ байгуулна.

12.5. Нийтийг хамарсан ажил зохион байгуулах журмыг Засгийн газар тогтооно.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан

13 дугаар зүйл. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан

13.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд шаардагдах хөрөнгийг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас санхүүжүүлнэ.

13.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, түүнд хяналт тавих журмыг Засгийн газар тогтооно.

14 дүгээр зүйл. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлогын эх үүсвэр

14.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан нь

дор дурдсан эх үүсвэрээс бүрдэнэ:

14.1.1. улсын төвлөрсөн төсвөөс хуваарилсан хөрөнгө;

14.1.2. орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгө;

14.1.3. ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн орлогоос хуулийн дагуу зарцуулах хөрөнгө;

14.1.4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн чөлөөт үлдэгдлийг банкинд хадгалуулсны хүү;

14.1.5. гадаад улс, олон улсын байгууллагаас хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор олгосон зээл;

14.1.6. гадаад улс, олон улсын байгууллага, Монгол Улсын болон гадаад улсын аж ахуйн нэгж, байгууллага, төрийн бус байгууллага, иргэдээс Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд оруулсан хандив, тусламж;

14.1.7. бусад эх үүсвэр.

14.2. Ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн орлого бүрдүүлэх үйл ажиллагааг хуулиар зохицуулна.

15 дугаар зүйл. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн зарцуулалт

15.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг дор дурдсанаар хуваарилан зарцуулна:

15.1.1.Хөдөлмөр эрхлэлтийн санд улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвөөс хуваарилсан хөрөнгийг;

а/ мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах,

б/ ажилд зуучлах,

в/ ажилгүйдлийн даатгалд хамрагдаагүй иргэнийг мэргэжил олгох, давтан сургалтад хамруулах,

г/ хувираа аж ахуй эрхлэх иргэнийг аж ахуйн үйл ажиллагаа эрхлэх арга барил, үр чадвар эзэмшүүлэх сургалтад хамруулах,

д/ нийтийг хамарсан ажил зохион байгуулах,

е/ хувиараа болон нөхөрлөл, хоршооны хэлбэрээр аж ахуй эрхлэх иргэнийг дэмжихэд,

15.1.2.ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн орлогоос төвлөрүүлсэн хөрөнгийг Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуульд заасны дагуу;

15.1.3. хөдөлмөр эрхлэлтийг дэмжих бусад арга хэмжээний зардлыг энэ хуулийн 14.1.5, 14.1.6, 14.1.7-д заасан эх үүсвэрээс тус тус санхүүжүүлнэ.

15.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанаас өөр зориулалтаар зарцуулахыг хориглоно.

16 дугаар зүйл. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого, зарлагын төсөв

16.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд улсын төвлөрсөн төсвөөс жил бүр олгох хөрөнгийн хэмжээ нь төвлөрсөн төсвийн орлогын 0,3 хувиас доошгүй байна.

16.2. Ажилгүйдэл, мөнгөний хэлбэрээр олгогдох тэтгэмжийн хэмжээ, ажилгүй хүчний оролцооны түвшинг харгалзан тухайн жилд улсын төвлөрсөн төсвөөс Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд олгох хөрөнгийн хэмжээг Засгийн газрын саналыг үндэслэн Улсын Их Хурал тухайн жилийн төвлөрсөн төсөвт тусгаж батална.

16.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд орон нутгийн төсвөөс олгох хөрөнгийн хэмжээг аймаг, нийслэл, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал тухайн жилийн орон нутгийн төсөвт тусгаж батална.

16.4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн тухайн жилийн орлого, зарлагын төсвийг Хөдөлмөр эрхлэлтийн төв байгууллагын саналыг үндэслэн хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

17 дугаар зүйл. Сангийн тайлан тэнцэл гаргах

17.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого, зарлагын тайланг дор дурдсан хугацаанд гаргана:

17.1.1. улирлын тайланг дүүргийн хөдөлмөр эрхлэлтийн алба нийслэлийн, сумын хөдөлмөрийн асуудал эрхэлсэн ажилтан аймгийн хөдөлмөр эрхлэлтийн албанд дараа улирлын эхний сарын 5-ны дотор, аймаг, нийслэлийн хөдөлмөр эрхлэлтийн алба дараа улирлын эхний сарын 15-ны дотор хөдөлмөр эрхлэлтийн төв байгууллагад тус тус ирүүлнэ;

17.1.2. хөдөлмөр эрхлэлтийн төв байгууллага нь улирлын нэгдсэн тайланг дараа улирлын хоёр дахь сарын 5-ны дотор, жилийн эцсийн тайланг дараа оны 2 дугаар сарын 15-ны дотор тус тус гаргаж, санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл, Нийгмийн даатгалын тухай хуулийн дагуу нийгмийн даатгалын төв байгууллагад ирүүлнэ.

18 дугаар зүйл. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн бүртгэл тайлангийн маягт

18.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн

бүртгэл, тайлангийн маягтын загварыг санхүүгийн болон хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

ТАВДУГААР БҮЛЭГ

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт

19 дүгаар зүйл. Хөдөлмөр эрхлэлтийн байгуулагын зохион байгуулалт

19.1. Хөдөлмөр эрхлэлтийн байгуулагын зохион байгуулалт нь Хөдөлмөрийн тухай хуулийн 137 дугаар зүйлд заасны дагуу байна.

20 дугаар зүйл. Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл

20.1. Засгийн газар, ажил олгогч болон ажилтны эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалах улсын хэмжээний байгуулагын төлөөлөл бүхий Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл /орон тооны бус/-ийг байгуулж ажиллуулна.

20.2. Үндэсний зөвлөлийн гурван талын төлөөлөгчдийн тоо адил байна.

20.3. Үндэсний зөвлөлийн дүрмийг ажил олгогч, ажилтны төлөөлөгчдийн байгуулагатай зөвшилцөн Засгийн газар батална.

20.4. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг талуудын санал болгосноор Ерөнхий сайд 4 жилийн хугацаагаар батлах бөгөөд дарга нь хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн байна. Үндэсний зөвлөл дараахь бүрэлдэхүүнтэй байна:

20.4.1. Засгийн газрыг төлөөлж хөдөлмөрийн болон санхүү, боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тус бүр нэг гишүүн;

20.4.2. улсын хэмжээний ажилтны дийлэнх олонхийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалсан үйлдвэрчний эвлэлийн байгууллагаас гурван гишүүн;

20.4.3. улсын хэмжээний ажил олгогчийн дийлэнх олонхийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг төлөөлөн хамгаалсан байгууллагаас гурван гишүүн.

20.5. Үндэсний зөвлөлийн орлогч даргыг гурван тал зөвшилцөж, аль нэг талын төлөөлөгчөөс хуралдаанд оролцсон гишүүдийн дийлэнх олонхийн саналаар батална. Хөдөлмөр эрхлэлтийн албаны дарга, ажилтнуудыг үндэсний зөвлөлийн гишүүнээр батлахыг хориглоно.

20.6. Үндэсний зөвлөл дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

20.6.1. хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагааны талаар хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын тайлан, мэдээллийг сонсон хэлэлцэж санал, дүгнэлт гаргах, шаардлагатай асуудлыг холбогдох байгууллагад оруулж шийдвэрлүүлэх;

20.6.2. Хөдөлмөр эрхлэлтийн тухай хууль тогтоомжийн биелэлт, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн орлого, зарлагын байдалд хяналт тавих;

20.6.3. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хагас жилийн болон жилийн төсвийн тайланг хэлэлцэж санал, дүгнэлт гаргах;

20.6.4. хөдөлмөр эрхлэлтийн асуудлаар зөвлөмж гаргах;

20.7. Үндэсний зөвлөлийн гишүүдэд ажлын оролцоог харгалзан улирал тутам урамшуулал олгож болно. Урамшууллын хэмжээг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

21 дүгээр зүйл. Хөдөлмөр эрхлэлтийн байгууллага

21.1. Хөдөлмөр эрхлэлтийн төв байгууллага нь хөдөлмөр эрхлэлтийг дээшлүүлэх, хөдөлмөрийн зах зээлийн талаарх төрийн бодлогыг улсын хэмжээнд хэрэгжүүлэх үүрэг бүхий төрийн захиргааны байгууллага мөн.

21.2. Хөдөлмөр эрхлэлтийн төв байгууллагын даргыг хөдөлмөрийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний санал болгосноор Ерөнхий сайд, хөдөлмөр эрхлэлтийн орон нутгийн албаны даргыг Хөдөлмөр эрхлэлтийн төв байгууллагын даргатай зөвшилцөн тухайн шатны Засаг дарга томилно.

21.3. Хөдөлмөр эрхлэлтийн төв байгууллага нь улсын төвлөрсөн төсвөөс, орон нутгийн алба нь орон нутгийн төсвөөс санхүүжнэ.

21.4. Хөдөлмөр эрхлэлтийн төв байгууллага нь дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ:

21.4.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг улсын хэмжээнд зохион байгуулах, хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийг төлөвлөх, түүний чиг хандлагыг тодорхойлох;

21.4.2. хөдөлмөрийн зах зээлийн бодлогыг хэрэгжүүлж, ажиллах хүчийг хөгжүүлэх замаар ажилгүйдлийг бууруулах;

21.4.3. хөдөлмөр эрхлэлтийн байдалд судалгаа, дүгнэлт хийх, хөдөлмөрийн зах зээлийн

мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх;

21.4.4. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг баталсан төсвийн дагуу хуваарилах, зарцуулах, хяналт тавих, тайлагнах;

21.4.5. хөдөлмөр эрхлэлтийн орон нутгийн албадыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, үйл ажиллагааг нь уялдуулан зохицуулах.

21.5. Хөдөлмөр эрхлэлтийн төв байгууллага нь дараахь эрхтэй байна:

21.5.1. ажилгүйдлийн даатгал болон хөдөлмөр эрхлэлтийн асуудлаар хууль тогтоомжийг боловсронгуй болгох санал оруулж шийдвэрлүүлэх;

21.5.2. хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд зориулсан сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй аж ахуйн нэгж, байгууллага, иргэний асуудлыг холбогдох байгууллагад хандаж шийдвэр гаргуулах;

21.5.3. ажилгүйдлийн даатгалын сангаас олгох тэтгэмжтэй холбогдсон иргэний санал, гомдлыг судалж шийдвэрлэх;

21.5.4. хөдөлмөр эрхлэлтийн асуудлаар шаардлагатай мэдээ, тайлан, тооцоо, судалгааг төрийн болон төрийн бус байгууллага, өмчийн хэлбэр харгалзахгүйгээр аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтнаас үнэ төлбөргүй гаргуулан авах.

21.6. Хөдөлмөр эрхлэлтийн орон нутгийн алба нь энэ хуульд заасан чиг үүргийг хэрэгжүүлнэ.

21.7. Хөдөлмөр эрхлэлтийн орон нутгийн албаны дүрмийг Хөдөлмөр эрхлэлтийн төв байгууллагын дарга батална.

22 дугаар зүйл. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд иргэн, ажил олгогчийн оролцоо

22.1. Ажилгүй буюу ажил хайгч иргэн өөрийн мэргэжил, ур чадварын дагуу ажилд орох хүсэлтэх тухайн хөдөлмөр эрхлэлтийн орон нутгийн байгууллагад өөрийн биеэр мэдэгдэх бөгөөд уг байгууллагаас санал болгож байгаа үйлчилгээ, арга хэмжээний талаар сонголт хийх эрхтэй.

22.2. Хөдөлмөрийн тухай хуулийн 40.5-д заасан нөхцлөөр ажилтнуудыг бөөнөөр халах тохиолдолд ажил олгогч нь тухайн хөдөлмөр эрхлэлтийн орон нутгийн байгууллагад нэг сарын өмнө мэдэгдэнэ.

22.3. Ажил олгогч нь ажиллах хүчний хэрэгцээ, ажлын сул байрны талаарх захиалга, ажилд авсан, халсан иргэний тухай мэдээллийг сар бүр хөдөлмөр эрхлэлтийн албанд ирүүлж байна.

22.4. Ажил олгогч нь өөрийн захиалгын дагуу иргэнийг ажилд авсан бол энэ тухай шийдвэр гарснаас хойш ажлын 5 хоногийн дотор орон нутгийн хөдөлмөр эрхлэлтийн албанд мэдэгдэнэ.

23 дугаар зүйл. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналт

23.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомжид дараахь эрх бүхий байгууллага, албан тушаалтан хяналт тавина:

23.1.1. улсын хяналтыг Улсын Их Хурал, Засгийн газар, бүх шатны Засаг дарга, төрийн хяналтыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага, албан тушаалтан тус тусын эрх хэмжээний дагуу хэрэгжүүлнэ;

23.1.2. орон нутагт улсын хяналтыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, түүний хяналтын алба хэрэгжүүлнэ.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

24 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

24.1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол гэм буруутай этгээдэд дараахь захиргааны шийтгэлийг хөдөлмөрийн улсын байцаагч буюу шүүгч ногдуулна:

24.1.1. энэ хуулийн 4.2.1-ийг зөрчсөн албан тушаалтныг 5000-25000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-100000 төгрөгөөр торгох;

24.1.2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, эсхүл хууль бусаар ашигласан бол хохирлыг нөхөн төлүүлж, албан тушаалтныг 25000-50000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-250000 төгрөгөөр шүүгч торгох;

24.1.3. энэ хуулийн 22.2-т заасан үүргийг биелүүлээгүй албан тушаалтныг 5000-25000 төгрөгөөр, аж ахуйн нэгж, байгууллагыг 50000-150000 төгрөгөөр торгох.

25 дугаар зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

25.1. Энэ хуулийг 2001 оны 6 дугаар сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр

Улаанбаатар хот

ГАЛТ ЗЭВСГИЙН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь галт зэвсэг өмчлөх, зээмших, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Галт зэвсгийн тухай хууль тогтоомж

2.1. Галт зэвсгийн тухай хууль тогтоомж нь энэ хууль, түүнтэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

3.1. Энэ хуульд дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

3.1.1. "галт зэвсэг" гэж дарьны шаталтын хийн даралтаар сумны хошуу буюу үрлийг гол төрөөс их хурдтай гаргаснаар сумны хошуу нь хүний амь бие, эрүүл мэндэд хохирол учруулах, ан агнах, бусад зүйлийг хөнөөх чадвар бүхий хэрэгслийг;

3.1.2. "байлдааны зориулалттай галт зэвсэг" гэж зэвсэгт хүчин, бусад цэрэг, цагдаа, тагнуул, хорих байгууллага хуулиар олгогдсон чиг үүргээ хэрэгжүүлэх зорилгоор ашиглаж байгаа галт зэвсгийг;

3.1.3. "гар буу" гэж 100 метр хүртлэх зайд хөнөөх чадалтай, 20 сантиметр хүртлэх урт гол төмөртэй галт зэвсгийг.

4 дүгээр зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

4.1. Зэвсэгт хүчин, бусад цэрэг, цагдаа, тагнуул, хорих байгууллагын зээмшилд байгаа байлдааны зориулалттай галт зэвсгийг өмчлөх, зээмших, ашиглахтай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулахгүй.

4.2. Энэ хуулийн 4.1-д зааснаас бусад байгууллага, иргэн галт зэвсэг өмчлөх, зээмших, ашиглахтай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна.

4.3. Байлдааны зориулалттай галт зэвсгийн жагсаалтыг батлан хамгаалахын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Галт зэвсэг өмчлөх

5 дугаар зүйл. Галт зэвсэг өмчлөх

5.1. Энэ хуульд өөрөөр заагаагүй бол 18 нас хүрсэн, эрх зүйн бүрэн чадамжтай, Монгол Улсын иргэн цагдаагийн байгууллагаас олгосон зөвшөөрлийн үндсэн дээр галт зэвсэг өмчлөх эрхтэй.

5.2. Эрүүгийн хуульд заасан хүнд, онц хүнд гэмт хэрэгт, эсхүл галт зэвсэг ашиглаж үйлдсэн гэмт хэрэгт ял шийтгэгдэж, ял шийтгэлгүйд тооцогдоогүй байгаа болон архаг архичин, мансуурах донтой гэж тооцогдсон этгээд галт зэвсэг өмчлөх, зээмших, ашиглах эрхгүй.

5.3. Хуульд өөрөөр заагаагүй бол иргэн, хуулийн этгээд байлдааны зориулалттай галт зэвсэг өмчлөхийг хориглоно.

5.4. Хуульд өөрөөр заагаагүй бол дипломат болон олон улсын байгууллагад ажиллаж байгаагаас бусад гадаадын иргэн, харьяалалгүй хүн Монгол Улсын нутаг дэвсгэрт галт зэвсэг өмчлөхийг хориглоно.

5.5. Иргэн, хуулийн этгээдэд галт зэвсэг өмчлөх зөвшөөрөл олгох жүрмыг цагдаагийн төв байгууллагын саналыг үндэслэн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

6 дугаар зүйл. Галт зэвсэг өмчлөх зориулалт

6.1. Иргэн ан агнуур, спорт-сургалт, цуглуулгын зориулалтаар галт зэвсэг өмчилж болно.

6.2. Хуулийн этгээд харуул хамгаалалт, спорт-сургалт, цуглуулга, үзмэр, урлагийн тоглолтын зориулалтаар галт зэвсэг өмчилж болно.

6.3. Цуглуулга, үзмэр, урлагийн тоглолтын зориулалтаар өмчлөх галт зэвсгийг хөнөөх чадваргүй болгосон байна.

6.4. Энэ хуулийн 6.1, 6.2-т зааснаас бусад зориулалтаар галт зэвсэг өмчлөхийг хориглоно.

6.5. Галт зэвсгийн хэв загварыг өөрчлөх, үйлдвэрийн бус аргаар хийж бэлтгэх, ийм галт

зэвсэг өмчлөх, эзэмших, ашиглахыг хориглоно.

7 дугаар зүйл. Галт зэвсэг бүртгүүлэх

7.1. Шинээр галт зэвсэг худалдан авсан иргэн, хуулийн этгээд түүнийг 14 хоногийн дотор байнга оршин байгаа сум, дүүргийн цагдаагийн байгууллагад бүртгүүлэх ба дараахь баримт бичгийг бүрдүүлнэ:

7.1.1. иргэний үнэмлэхийн хуулбар, эсхүл хуулийн этгээдийн улсын бүртэлийн гэрчилгээний хуулбар;

7.1.2. галт зэвсгийн төрөл, марк, дугаарыг тодорхойлсон баримт бичиг;

7.1.3. цагдаагийн байгууллагаас олгосон зөвшөөрөл.

7.2. Спорт - сургалтын зориулалтаар галт зэвсэг өмчлөх хуулийн этгээд нь галт зэвсэг бүртүүлэх тухай хүсэлтдээ сургалт явуулах тоног төхөөрөмж, байр, байршлын тодорхойлолт, зураглалыг хавсаргасан байна.

7.3. Сум, дүүргийн цагдаагийн байгууллага галт зэвсгийг анх бүртгэхдээ уг галт зэвсгээр буудсан сумны хоёр хонгио, буудсан сумны хошуу авах ажлыг зохих журмын дагуу гүйцэтгэж, санд авна.

7.4. Галт зэвсэг өмчлөгч иргэн нь оршин суугаа газраа өөрчлөх бол галт зэвсгээ бүртэлээс хасуулж, шилжин очсон газрын цагдаагийн байгууллагад ажлын 5 хоногийн дотор бүртүүлнэ. Галт зэвсгийг бүртэлээс хассан цагдаагийн байгууллага шилжин очсон сум, дүүргийн цагдаагийн байгууллагад энэ тухай мэдэгдэнэ.

8 дугаар зүйл. Галт зэвсгийн гэрчилгээ

8.1. Иргэн, хуулийн этгээдийн галт зэвсэг өмчлөх эрх нь цагдаагийн байгууллагад бүртүүлж гэрчилгээ авснаар үүснэ.

8.2. Галт зэвсгийн гэрчилгээнд дараахь зүйлийг тусгасан байна:

8.2.1. галт зэвсэг өмчлөгч иргэний овог, нэр, иргэний үнэмлэхийн болон регистрийн дугаар, хаяг, эсхүл галт зэвсэг өмчлөгч хуулийн этгээдийн нэр, улсын бүртгэлийн дугаар, үйл ажиллагааны чиглэл, хаяг;

8.2.2. галт зэвсгийн төрөл, марк, дугаар, үйлдвэрлэсэн он;

8.2.3. галт зэвсэг өмчлөх зориулалт.

8.3. Иргэнд олгосон галт зэвсгийн гэрчилгээнд түүний зургийг нааж, тэмдэг дарсан байна. Галт зэвсгийн гэрчилгээнд тухайн галт зэвсгийг хамтран эзэмших этгээдийн нэрийг тусгаж болно.

8.4. Галт зэвсгийн гэрчилгээний загвар, гэрчилгээ олгох журмыг Цагдаагийн ерөнхий газрын дарга батална.

9 дүгээр зүйл. Галт зэвсэг эзэмших

9.1. Харуул хамгаалалтын үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээд нь энэ хуулийн 5.1-д заасан шаардлага хангасан харуул хамгаалалтын ажилтанд гэрээний үндсэн дээр зөвхөн албаны үүрэг гүйцэтгэх хугацаанд нь галт зэвсэг эзэмшүүлж болно.

9.2. Энэ хуулийн 9.1-д заасны дагуу байгуулсан галт зэвсэг эзэмшүүлэх гэрээг сум, дүүргийн цагдаагийн байгууллагад бүртүүлнэ.

10 дугаар зүйл. Галт зэвсэг ашиглах

10.1. Галт зэвсгийг ан агнуурын зориулалтаар хот, суурин газраас бусад газарт ашиглана.

10.2. Нутгийн захирагааны байгууллагын шийдвэрээр золбин нохой, муур зэрэг амьтныг хот, суурин газарт галт зэвсэг ашиглан устгаж болно.

10.3. Нутгийн захирагааны байгууллага энэ хуулийн 10.2-т заасны дагуу гаргасан шийдвэрээ цагдаагийн байгууллагад мэдэгдэж, ослоос сэргийлэх арга хэмжээ авна.

10.4. Галт зэвсэг өмчлөгч иргэн энэ хуулийн 5.2-т үл хамаарах, 5.1-д заасан шаардлага хангасан этгээдэд галт зэвсгийг итгэмжлэлийн үндсэн дээр ашиглуулж болно.

10.5. Эрүүл мэнд, бие эрхтнийх нь байдлыг харгалзан зарим иргэний галт зэвсэг ашиглах эрхэд хязгаарлалт тогтоож болно. Галт зэвсэг ашиглахад харшлах өвчин, бие эрхтний байдлын жагсаалтыг хууль зүйн болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

11 дүгээр зүйл. Галт зэвсэг хадгалах

11.1. Галт зэвсэг өмчлөгч иргэн галт зэвсгийг аюулгүй байдлыг хангасан нөхцөлд, өөрийн оршин суугаа гэр, суууцандаа сумнаас тусад нь хадгална.

11.2. Харуул хамгаалалт, спорт-сургалтын зориулалтаар галт зэвсэг өмчлөгч хуулийн этгээд галт зэвсгийг тусгай зориулалтын шүүгээнд, сумнаас тусад нь хадгална.

11.3. Арав ба түүнээс дээш тооны галт зэвсгийг аюулгүй байдлын хангалттай хангахуйц тусгайлан тоноглосон өрөөнд, зориулалтын шүүгээнд хадгална.

11.4. Галт зэвсгийг хаясан болон бусад байдлаар урэгдүүлсэн тохиолдолд 24 цагийн дотор түүнийг бүртүүлсэн цагдаагийн байгууллагад мэдэгдэнэ.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

12 дугаар зүйл. Галт зэвсэг нийтэд худалдах

12.1. Галт зэвсэг нийтэд худалдах эрхийг зөвхөн тусгайлан зөвшөөрөл авсан хуулийн этгээд

эдэлнэ.

12.2. Галт зэвсэг нийтэд худалдах зөвшөөрлийг энэ хуулийн 15.2-т заасан комиссын саналыг үндэслэн хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.

12.3. Галт зэвсэг нийтэд худалдах төв / цаашид "Төв" гэх/ нь Монгол Улсад нэг байх бөгөөд нийслэлд байрлана.

12.4. Төв нь орон нутагт салбар байгуулж болно. Салбар байгуулах, тэнд худалдаж болох галт зэвсгийн зөвшөөрлийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн олгоно.

12.5. Галт зэвсгийн сумыг нийтэд зориулан Төв, түүний салбарт худалдана.

12.6. Төв, түүний салбар нь цагдаагийн байгууллагын хяналтад байх бөгөөд буудлагын зориулалтын байртай, аюулгүй байдлыг хангасан, дохиолол, хамгаалалтын техөөрөмжөөр тоноглогдсон байна.

13 дугаар зүйл. Галт зэвсэг худалдаж авах

13.1. Иргэн, хуулийн этгээд галт зэвсэг худалдаж авах тухай хүсэлтээ Төв, түүний салбар оршин байгаа газрын цагдаагийн байгууллагад бичгээр гаргана.

13.2. Энэ хуулийн 13.1-д заасан хүсэлт хүлээж авсан цагдаагийн байгууллага 14 хоногийн дотор тухайн иргэний үнэмлэх, хуулийн этгээдийн гэрчилгээг хянан үзэж, энэ хуулийн 5.1-д заасан шаардлага хангасан, 5.2-т заасан харшлах шалтгаан байхгүй бол зөвшөөрөл олгоно.

13.3. Энэ хуулийн 13.1, 13.2-т заасны дагуу зөвшөөрөл авсан иргэн, хуулийн этгээд энэ хуулийн 12 дугаар зүйлд заасан Төв, түүний салбараас галт зэвсэг худалдаж авна.

13.4. Төв, түүний салбар худалдсан галт зэвсгийн тоо, төрөл, марк, дугаарын тэмдэглэл бүхий тодорхойлолтыг худалдан авагчид олгоно.

13.5. Энэ зүйлд заасны дагуу галт зэвсэг худалдаж авсан иргэн, хуулийн этгээд энэ хуулийн 7 дугаар зүйлд заасны дагуу бүртгүүлж, 8 дугаар зүйлд заасны дагуу гэрчилгээ авна.

14 дүгээр зүйл. Иргэн, хуулийн этгээдийн өмчлөлд байгаа галт зэвсэг худалдах, өвлөх, бэлэглэх

14.1. Иргэн, хуулийн этгээд өөрийн өмчлөлд байгаа галт зэвсэг худалдах бол энэ тухайгаа галт зэвсгийн гэрчилгээ олгосон цагдаагийн байгууллагад мэдэгдэж, гэрчилгээгээ хураалгаж, бүртгэлээс хасуулна. Галт зэвсгийг бүртгэлээс хассан цагдаагийн байгууллага худалдан авагчийн оршин суугаа сум, дүүргийн цагдаагийн байгууллагад энэ тухай мэдэгдэнэ.

14.2. Иргэн, хуулийн этгээдийн өмчлөлд байгаа галт зэвсэг худалдан авах иргэн оршин суугаа газрынхаа цагдаагийн байгууллагад хүсэлт гаргаж, энэ хуульд заасны дагуу зөвшөөрөл авч, бүртгүүлж гэрчилгээ авна.

14.3. Иргэн, хуулийн этгээдийн өмчлөлд байгаа галт зэвсэг өвлөх, бэлэглэхтэй холбогдсон харилцааг Иргэний хуулиар[1] зохицуулна.

14.4. Галт зэвсэг өвлөх, бэлэглэх тохиолдолд энэ хуулийн 14.1, 14.2-т заасан журмыг баримтална.

15 дугаар зүйл. Галт зэвсэг болон сумыг улсын хилээр оруулах зөвшөөрөл олгох

15.1. Хуулийн этгээд нь нийтэд худалдах зорилгоор галт зэвсэг болон сумыг улсын хилээр оруулахдаа үйлдвэр, худалдааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээс тусгайлан зөвшөөрөл авсан байх бөгөөд түүнийг сонгон шалгаруулалтын үндэсэн дээр олгоно. Сонгон шалгаруулалтын журмыг хууль зүйн болон үйлдвэр, худалдааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүд хамтран батална.

15.2.Төсөл сонгон шалгаруулах комисс нь хууль зүйн, батлан хамгаалахын, байгаль орчны, үйлдвэр, худалдааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон цагдаа, татнуулын байгууллагын төлөөлөгчдөөс бүрдэнэ. Дарга нь Цагдаагийн ерөнхий газрын хэв журмын албаны дарга байна.

15.3. Сонгон шалгаруулалтад оролцох хуулийн этгээд нь улсын хилээр оруулах галт зэвсэг болон сумны төрөл, марк, үнэ, тоо, техникийн болон бусад үзүүлэлтийг тусгасан танилцуулга бүхий материалыг цагдаагийн байгууллагад ирүүлнэ.

15.4.Монгол Улсын иргэн өөрөө өмчлөх зорилгоор энэ хуулиар хориглоогүй нэг галт зэвсэг улсын хилээр оруулах эрхтэй.

16 дугаар зүйл. Ан агнуур, уралдаан тэмцээний зориулалттай галт зэвсэг улсын хилээр оруулах, гаргах

16.1. Ан агнах, уралдаан тэмцээнд оролцох зорилготой гадаадын иргэнийг урьсан иргэн, хуулийн этгээд нь түүний галт зэвсгийг улсын хилээр нэвтрүүлэх хүсэлтийг Цагдаагийн ерөнхий газарт гаргах бөгөөд түүнд галт зэвсгийн төрөл, марк, тоо, дугаар болон оруулах, буцаан гаргах хугацаа, нэвтрүүлэх хилийн боомтыг дурдана.

16.2. Цагдаагийн ерөнхий газар уг хүсэлтийг

[1] *Иргэний хууль "Төрийн мэдээлэл"-ийн 1995 оны № 1 дугаарт нийтлэгдсэн.*

7 хоногийн дотор хянан үзэж, галт зэвсэг улсын хилээр нэвтрүүлэх эвшээрлийн хуудсыг олгоно.

16.3. Энэ хуулийн 16.2-т зааснаар эвшээрегдсэн галт зэвсгийг улсын хилээр оруулахад гаалийн байгууллага эвшээрлийн хуудас дээр тэмдэглэл хийж, улсын хилээр буцааж гаргахад эвшээрлийн хуудсыг хураан авч, Цагдаагийн ерөнхий газарт хүргүүлнэ.

16.4. Монгол Улсын иргэн, хуулийн этгээд гадаадад ан агнах, уралдаан тэмцээнд оролцох зорилгоор галт зэвсэг улсын хилээр гаргах бол түүний төрөл, марк, тоо, дугаар болон улсын хилээр гаргах, буцаан оруулах хугацаа, нэвтрүүлэх хилийн боомтыг дурдсан хүсэлтийг Цагдаагийн ерөнхий газарт гаргана. Цагдаагийн ерөнхий газар хүсэлтийг хянан үзэж, 7 хоногийн дотор эвшээрлийн хуудас олгоно.

16.5. Энэ хуулийн 16.4-т заасны дагуу галт зэвсэг улсын хилээр гаргахад гаалийн байгууллага эвшээрлийн хуудас дээр тэмдэглэл хийж, буцаан оруулсан даруй эвшээрлийн хуудсыг хураан авч, Цагдаагийн ерөнхий газарт хүргүүлнэ.

16.6. Энэ хуулийн 16.1, 16.2–т заасан журмаар улсын хилээр оруулсан галт зэвсэг өмчлөгч нь худалдах, бэлэглэх зэргээр бусдад шилжүүлж болно. Энэ тохиолдолд цагдаагийн байгууллагад бүртгүүлж, эвшээрлийн хуудас дээр тэмдэглэл хийлгэсэн байна.

16.7. Энэ хуулийн 16.2, 16.4-т заасан эвшээрлийн хуудасны загварыг Цагдаагийн ерөнхий газрын дарга батална.

17 дугаар зүйл. Галт зэвсэг авч явахад тавих шаардлага

17.1. Галт зэвсгийг агаарын хөлөг, усан онгоц, галт тэрэг, хот хоорондын нийтийн тээврийн хэрэгслээр авч явахад хөлгийн болон галт тэрэгний дарга, эсхүл жолооч хадгалуулна.

17.2. Хот, суурин газарт нийтийн тээврийн хэрэгслээр галт зэвсэг авч явахыг хориглоно.

17.3. Галт зэвсгийг гэрчилгээний хамт авч явах ба ашуулгүй байдлыг ханагж, сумнаас тусад нь зориулалтын гэрэнд хийсэн байна.

18 дугаар зүйл. Галт зэвсгийн тооллого

18.1. Иргэн, хуулийн этгээдийн өмчлөлд байгаа галт зэвсгийн тооллогыг жил бүрийн дөрөвдүгээр улиралд багтаан цагдаагийн байгууллага явуулна.

18.2. Галт зэвсгийн тооллого явуулах журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

19 дүгээр зүйл. Галт зэвсэг хураах

19.1. Дор дурдсан тохиолдолд цагдаагийн байгууллагын эрх бүхий ажилтан, байгаль орчны хяналтын байцаагч, байгаль хамгаалагч, гаалийн байцаагч галт зэвсгийг хурааж, 30 хоногийн дотор цагдаагийн байгууллагад хүргүүлнэ:

19.1.1. энэ хуулийн 5.2, 5.4-т заасан этгээд галт зэвсэг өмчлөх байсан нь тогтоогдсон;

19.1.2. энэ хуулиар хориглосон галт зэвсгийг иргэн, хуулийн этгээд өмчлөх байгаа нь тогтоогдсон;

19.1.3. эрэн сурвалжлагдаж байгаа галт зэвсэг бол;

19.1.4. гэмт хэрэг, захиргааны зөрчил үйлдэхэд ашигласан.

19.2. Галт зэвсэг өмчлөгч иргэн нас барсан, эсхүл хуулийн этгээд татан буугдсан тохиолдолд галт зэвсгийг бусдын өмчлөлд шилжүүлэх, хураах асуудлыг хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.

19.3. Байлдааны зориулалттай галт зэвсэг хураагдсан бол түүнийг энэ хуулийн 4.1-д заасан байгууллагын эзэмшилд шилжүүлнэ.

19.4. Хураагдсан галт зэвсгийг устгах, худалдах, шилжүүлэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

19.5. Энэ хуулийн 19.1-д заасан шийдвэрийг эвшээрэхгүй бол тухайн этгээд шүүхэд гомдол гаргах эрхтэй.

20 дугаар зүйл. Галт зэвсгийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд тавих хяналт

20.1. Галт зэвсгийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтэд цагдаагийн байгууллага хяналт тавина.

20.2. Галт зэвсгийг ан агнуурын зориулалтаар эзэмших, ашиглахад байгаль орчны хяналтын байгууллага хуульд заасан эрх хэмжээнийхээ хүрээнд хяналт тавина.

21 дүгээр зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

21.1. Галт зэвсгийн тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол цагдаагийн байгууллагын эрх бүхий ажилтан, байгаль орчны хяналтын улсын байцаагч гэм буруутай этгээдэд дараахь шийтгэл ногдуулна:

21.1.1. иргэн, хуулийн этгээд энэ хуулийн 4.1-д заасан галт зэвсэг хууль бусаар олж авсан, хэмжсэн, ашигласан бол иргэнийг 30000-50000, хуулийн этгээдийг 50000-150000 төгрөгөөр торгох;

21.1.2. энэ хуулийн 5.1-д заасан шаардлага хангаагүй, түүнчлэн 5.2, 5.4-т заасан галт

зэвсэг өмчлөх эрхтэй этгээд галт зэвсэг олж авсан, эзэмшсэн, ашигласан бол 30000-50000 төгрөгөөр торгох;

21.1.3. энэ хуулийн 6.4-ийг зөрчсөн иргэнийг 25000-50000, албан тушаалтныг 45000-60000, хуулийн этгээдийг 50000-150000 төгрөгөөр торгох;

21.1.4. энэ хуульд заасан журмын дагуу галт зэвсгийг бүртгүүлж гэрчилгээ аваагүй иргэнийг 10000 - 30000, албан тушаалтныг 30000 - 60000, хуулийн этгээдийг 50000-150000 төгрөгөөр торгох;

21.1.5. энэ хуулийн 5.1-д заасан шаардлага хангагаүй этгээдэд галт зэвсэг зэвэмшүүлсэн харуул хамгаалалтын үйл ажилгагаа эрхэлдэг хуулийн этгээдийг 200000 - 250000 төгрөгөөр торгох;

21.1.6. энэ хуулийн 10.2-т зааснаас бусад тохиолдолд хот суурингийн газарт галт зэвсэг ашиглаган бол 30000-50000 төгрөгөөр торгох;

21.1.7. энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасан галт зэвсэг хадгалах журам зөрчсөн иргэнийг 10000 - 25000, хуулийн этгээдийг 20000 - 40000 төгрөгөөр торгох;

21.1.8. галт зэвсэг худалдах, худалдан авах журам зөрчсөн иргэнийг 10000-30000, албан тушаалтныг 30000 - 60000, хуулийн этгээдийг 100000 - 250000 төгрөгөөр торгох;

21.1.9. галт зэвсэг авч явах журам зөрчсөн иргэнийг 5000 - 10000 төгрөгөөр торгох;

21.1.10. галт зэвсэг болон сумыг улсын хилээр оруулах, гаргах журам зөрчсөн иргэнийг 10000-20000, албан тушаалтныг 30000-60000, хуулийн этгээдийг 100000 - 250000 төгрөгөөр торгох.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр **Дугаар 31** **Улаанбаатар хот**

Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн зарим зүйлийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл бүцаах тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 40 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Засгийн газрын өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хуулийн зарим зүйлийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн орлогыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлэх асуудал Нийгмийн даатгалын багц хуулийн хүрээнд цогцоор нь шийдвэрлэх шаардлагатай гэсэн үндэслэлээр хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр **Дугаар 32** **Улаанбаатар хот**

Улсын Их Хурлын 2000 оны 32 дугаар тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ НЬ:

Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн өөрчлөлт бүдүүвчийг шинэчлэн батлах тухай Монгол Улсын Их Хурлын 2000 оны 32 дугаар тогтоолын хавсралтын 24-т заасан "Хөдөлмөр зохицуулалтын газар" гэснийг "Хөдөлмөр эрхлэлтийн газар" гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр **Дугаар 33** **Улаанбаатар хот**

Норматив тогтоох тухай тогтоолын төсөл бүцаах тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 40 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Засгийн газрын өргөн мэдүүлсэн Норматив тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн орлогыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих санд төвлөрүүлэх асуудал Нийгмийн даатгалын багц хуулийн хүрээнд цогцоор нь шийдвэрлэх шаардлагатай гэсэн үндэслэлээр хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 4 дүгээр сарын 19-ний өдөр Дугаар 34 **Улаанбаатар хот**

Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 40 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Засгийн газрын өргөн мэдүүлсэн Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг ажилгүйдлийн даатгалын шимтгэлийн орлогыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас төвлөрүүлэх асуудал Нийгмийн даатгалын багц хуулийн хүрээнд цогцоор нь шийдвэрлэх шаардлагатай гэсэн үндэслэлээр хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр Дугаар 35 **Улаанбаатар хот**

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 40 дүгээр зүйлийн 12 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хууль батлагдсантай холбогдуулан дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай.

1/ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуульд заасан дүрэм, журам, зааврыг батлан гаргах;

2/ Хөдөлмөр эрхлэлтийн төв байгууллага, орон нутгийн албадыг зохион байгуулж ажиллуулах;

3/ Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай хуультай уялдуулан Техник мэргэжлийн боловсролын тухай хуулийн төслийг 2001 оны гуравдугаар улиралд багтаан Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх;

4/ хувийн болон төрийн бус байгууллагын хөдөлмөр зуучлалын албадад энэ хуульд заасны дагуу дэмжлэг үзүүлэх.

2.Энэ тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороо /Т.Ганди/-нд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр Дугаар 41 **Улаанбаатар хот**

Галт зэвсгийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 40 дүгээр зүйлийн 12 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Галт зэвсгийн тухай хууль батлагдсантай холбогдуулан дор дурдсан арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Засгийн газар /Н.Энхбаяр/-т даалгасугай:

1/ Галт зэвсгийн тухай хуулийн 18.1-д заасан тооллогыг 2001 оны хувьд гуравдугаар улиралд багтаан явуулах;

2/ иргэн, хуулийн этгээдийн цуглуулга, музейн үзмэрт хадгалагдаж байгаа байлдааны зориулалттай галт зэвсгийг хөнөөх чадваргүй болгох, эсхүл нөхөн төлбөртэйгээр хураан авах;

3/ галт зэвсгийг нөхөн төлбөртэйгээр хураан авахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг улсын төвлөрсөн төсөвт тусгаж батлуулах;

4/ иргэдийн өмчлөлд байгаа бэлэг дурсгалын гар бууг өмчлөгч нь хураалгахүүгээр үзсэн тохиолдолд цуглуулгын зориулалттай гэж үзсэн хөнөөх чадваргүй болгох.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

Засгийн газрын 2001 оны 54 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын төгсгөл

Төгсгөл. Түрүүч нь № 18-д бий.

МОНГОЛ УЛСЫН ХИЛЭЭР ЛИЦЕНЗТЭЙ НЭВТРҮҮЛЭХ БАРААНЫ КОДЛОСОН ЖАГСААЛТ

Бараат тодорхойлох, кодлох үялдуулсан системийн зүйл №	Бараат тодорхойлох, кодлох үялдуулсан системийн мөр №	Барааны бичиглэл	Үндэслэл бүхий эрх зүйн акт	Улсын хилээр нэвтрүүлэх ялгаа	Зөвшөөрөл, тодорхойлолт, дүгнэлт гаргах байгууллага, албан тушаалтан
30.02		Донорын цус, оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх зориулалттай мал, амьтны цус, эсрэгийлдэс, цусны бусад фракц, биологийн ба бусад аргаар гарган авсан дархлалын хувирмал бэлдмэл, вакцин хор, бичил биетний өсгөвөр (хөрөнгөрцөөс бусад) ба эдгээртэй тестэй бүтээгдэхүүн. Үүнээс:			
	3002.10.00	Эсрэгийлдэс ба цусны бусад фракц, биотехнологийн болон бусад аргаар гарган авсан дархлалын хувирмал бэлдмэл			
	3002.90.00	Бусад: Үүн дотор бичил биетний өсгөвөр			
	3002.20.00	Хүн эмнэлгийн зориулалттай вакцин			
	3002.30.00	Мал эмнэлгийн зориулалттай вакцин			Хүнсний ахуулгүй байдал, хөдөө аж ахуйн улсын хяналтын албаны зөвшөөрөл
		ЭМИЙН БҮТЭЭГДЭХҮҮН	Эмийн тухай хууль /1998/ Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль /2001/	Гаргах, оруулах /хүний эм/ оруулах /малын эм/	Хүний эмийн салбар зөвлөлийн дүгнэлт, Эрүүл мэндийн улсын хяналтын албаны зөвшөөрөл Хүнсний ахуулгүй байдал, хөдөө аж ахуйн улсын хяналтын албаны зөвшөөрөл
30.03		Жижиглэн худалдаалах түн хэлбэрт савлагдаагүй, урьдчилан сэргийлэх буюу эмчилгээний зориулалттай, хоёр буюу түүнээс дээш найрлагатай эмийн бэлдмэл /БТКУС-ийн Зүйл № 30.02, 30.05, 30.06-д зааснаас бусад/			
30.04		Жижиглэн худалдаалах түн хэлбэрт савлагдсан, урьдчилан сэргийлэх буюу эмчилгээний зориулалттай, холимог буюу холимог бус эм /БТКУС-ийн Зүйл № 30.02, 30.05, 30.06-д зааснаас бусад/			

		НҮБ-ын "Мансууруулах эмийн тухай" 1961 оны КОНВЕНЦ, "Сэтгэцэд нөлөөлөх бодисуудын тухай" 1971 оны КОНВЕНЦИЙН ТУХАЙ 1971 ОНЫ НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХЭЛЭЛЦЭЭР ТОХИРОЛЦСОН УЛСУУДЫГ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ" 1988 ОНЫ КОНВЕНЦИЙН ЖАГСААЛТАД ОРСОН БОДИСУУД	НҮБ-ын "Мансууруулах эмийн тухай" 1961 оны Конвенц, "Сэтгэцэд нөлөөлөх бодисуудын тухай" 1971 оны Конвенц, "Мансууруулах эм, сэтгэц нөлөөт бодисуудыг хууль бусаар наймаалахын эсрэг" 1988 оны Конвенц	Гаргах, оруулах	Хүний эмийн сайбар зөвлөлийн дүгнэлт, Эрүүл мэндийн улсын хэмжээний албаны зөвшөөрөл
		ТЭСРЭХ БОДИС	Монтол Улсын Их Хурлын 1998 оны 05 дугаар тогтоол	Гаргах, оруулах	Цагдаагийн ерөнхий газар, Татварын төв газар, Зэвсэгт хүчний ерөнхий штабын тодорхойлолт
36.01	3601.00	Дарь, тийрэлтэт тулш			
36.02	3602.00	Дарь, тийрэлтэт тулшнээс бусад тэсрэгч бэлдмэл			
36.03	3603.00	Гал дамжуулах утас; тэсэлгээний утас, цохиулын бүрхүүл, цахилгаан тэслүүр			
36.04		Гэрэл, гарган шатаач бодис, дохионы гэрэлтүүлэгч пүүжин, аадар эсэргүүцэх, пиротехникийн бусад хэрэгсэл			
		УРГАМАЛ ХАМГААЛАХАД АШИГЛАХ БОДИС	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль /2001/	Оруулах	Хүнсний ахуулгүй байдал, хөдөө аж ахуйн улсын хэмжээний албаны зөвшөөрөл
38.08		Инсектицид, родентицид, фунгицид, гербицид, тариалангийн хортон, өвчний эсрэг бэлдмэл, ургамлын өсөлтийг зохицуулагч, халдварлуулжчлэгч бэлдмэл			
		Инсектицид, родентицид, фунгицид, гербицид, тариалангийн хортон, өвчний эсрэг бэлдмэл, ургамлын өсөлтийг зохицуулагч ариутгач, халдварлуулжчлэгч бэлдмэл			
		МАЛ ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЭЛ	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль /2001/	Оруулах	Хүнсний ахуулгүй байдал, хөдөө аж ахуйн улсын хэмжээний албаны зөвшөөрөл

90.18		Эмнэлэг, мэс засал, шүдний эмнэлэг ба мал эмнэлгийн зориулалттай багаж хэрэгсэл; цацраг хэмжих, буртэх багаж ба эмнэлгийн бусад эрдэм шинжилгээ, туршилтын цахилгаан төхөөрөмж ба хэрэгсэл, үүнээс:					
		Мал эмнэлгийн зориулалттай багаж хэрэгсэл, цацраг хэмжих, буртэх багаж					
90.22		Хүн эмнэлэг, мэс засал, шүдний эмнэлэг буюу мал эмнэлгийн зориулалттай буюу зориулалтгүй, рентген туяа, альфа, бета, гамма цацрагийн аппарат, радиографын буюу цацраг эмчилгээний аппарат, рентген хоолой, рентген үүсгүүр, хянах, тохируулах самбар, үүлэг, эмчилгээний ширээ, сандал, дэлгэц зэрэг хэрэгсэл. Үүнээс:					
		Мал эмнэлгийн зориулалттай рентген туяа, альфа, бета, гамма цацрагийн аппарат, радиографын буюу цацраг эмчилгээний аппарат, рентген хоолой, рентген үүсгүүр, хянах, тохируулах самбар зэрэг хэрэгсэл					
		БҮҮ, ЗЭР ЗЭВСЭГ, БАЙЛДААНЫ ХЭРЭГСЭЛ, ТЕХНИК, ТЭДГЭЭРИЙН ЭД АНГИ, ТОНОГ ХЭРЭГЛЭЛ	Монгол Улсын Их Хурлын 1998 оны 05 дугаар тогтоол Байлдааны хэрэгсэл, техникийг хилээр нэвтрүүлэхэд тусгай журмаар зохицуулна.	Гаргах, орулпах			Цагдаагийн ерөнхий газар, Татвурлын тэв газар, Зэвсэг хүчний ерөнхий штабын тодорхойлолт
93.01	9301.00	Револвер, гар буу болон Зүйл № 93.07-д заасан бусад зэвсгээс өөр цэргийн зориулалтай зэвсэг					
93.02	9302.00	Зүйл № 93.03 буюу 93.04-т зааснаас бусад револвер болон гар буу					
93.03		Гэмдэг цэнэгээс гал ачих пад буусад гал зэвсэг болон тэдгээрэй адил тестэй хэрэгсэл /жишээ нь спортын үрлэн сумтай буу болон винтов, хар дарнар гэж тооцогдохгүй нь цохиулах буу, дохионы гар буу болон зөвхэн цохиулах буу, хөдөлгүүрийн хүчээр ажилладаг буусад хэрэгсэл, хүлсон цэнэгтэй сумтай пневматик буу, гар буу, толгойгой бит хэлбэрийн ангийн буу, жийг буу/ Үүнээс:					

	9303.10	Гол төмрийг нь цэнэглэдэг галт зэвсэг			
	9303.20	Спортын, ангийн буюу бай бууддаг бусад зэвсэг /үрлэн сумтай буу, винтовын хослол орно/			
	9303.30	Спортын, ангийн буюу бай бууддаг бусад винтов			
93.04	9304.00	БТКҮС-ийн зүйл № 93.07-д зааснаас бусад зэвсэг /жишээ нь: пүрш, агаар, хийгээр ажилладаг буу, гар буу, цагдаагийн бороохой/			
93.05		БТКҮС-ийн Зүйл № 93.01-93.04-т заагдсан бүтээгдэхүүний эд анги, тоног хэрэгсэл			
93.06		Бөмбөг, гранат, торпед, мина, тийрэлтэт сум болон тэдгээртэй адил төстэй байлдааны зэвсэг,тэдгээрийн эд анги: хонгиотой сум болон бусад зэвсгийн хэрэгсэл, сум, тэдгээрийн эд анги (сумны бөглөөс, жийрэг орно)			
		ТҮҮХ, СОЁЛЫН ДУРСГАЛТ ЗҮЙЛ, ЭРДЭС СУДЛАЛ, АНАТОМИ, АРХЕОЛОГИ, ПАЛЕОНТОЛОГИ, УГСААТНЫ ЗҮЙ БОЛОН ЗООС СУДЛАЛЫН ЧИГЛЭЛИЙН ОЛДВОР БОЛОН ЦУГЛУУЛГА	Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хууль /1994/, Монгол Улсын Их Хурлын 1998 оны 05 дугаар тогтоол		
		А.Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйл /Засгийн газрын 241 /1995/, 126 /1998/, 110 /1999/, …/2000/ тогтоолоор батлагдсан түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлс, олдвор орох бөгөөд цаашид шинээр оруулах зүйлс энэ бүлэгт хамаарна/	Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хууль /1994/, Монгол Улсын Их Хурлын 1998 оны 05 дугаар тогтоол	Түр гаргах	БСШУЯ-ны зөвшөөрөл
		Б.Түүх, соёлын үнэт дурсгалт зүйл /БСШУЯ-ны дэргэдэх Зөрэглэл үнэлгээ тодорхойлох мэргэжлийн зөвлөлөөс тодорхойлж, БСШУ-ны сайдын тушаалаар батлагдсан түүх, соёлын үнэт дурсгалт зүйлс, олдвор энэ бүлэгт хамаарна/	Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хууль /1994/	Түр гаргах	БСШУЯ-ны зөвшөөрөл
XI хэсэг		СУЛЖМЭЛ, НЭХМЭЛ БҮТЭЭГДЭХҮҮН БОЛОН БЭЛЭН ХУВЦАС	Сулжмэл, нэхмэл бүтээгдэхүүн болон хувцас худалдаалах тухай Монгол улсын олон улсын гэрээ	Гаргах Шууд лиценз	Гарал үүслийн гэрчилгээ

Засгийн газрын 2001 оны 54 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

УЛСЫН ХИЛЭЭР ТӨРИЙН ХЯНАЛТЫН ДОР НЭВТРҮҮЛЭХ БАРААНД ЭКСПОРТ, ИМПОРТЫН ЛИЦЕНЗ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын хууль, Улсын Их Хурал, Засгийн газрын тогтоол, Монгол Улсын олон улсын гэрээгээр улсын хилээр төрийн хяналтын дор нэвтрүүлэхээр нэр төрлийг нь заасан бараанд экспорт, импортын лиценз олгоход энэхүү журмыг мөрдлөг болгоно.

1.2. Экспорт, импортын лиценз олгох үйл ажиллагаанд Үйлдвэр, худалдааны яам эрхлэн гүйцэтгэнэ. Лицензид гарын үсэг зурах албан тушаалтныг Үйлдвэр, худалдааны сайдын тушаалаар томилно.

1.3. Үйлдвэрлэл, худалдаа эрхлэгчдийн бизнесийн үйл ажиллагаанд хөнгөвчлөх, төрийн хяналтын зөвшөөрлийн үйлчилгээг аль болох нэг цэгээс хэрэгжүүлэх зорилгоор экспорт, импортын лиценз олгох үйл ажиллагаанд Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагийн дэргэдэх "Нэг цэгийн үйлчилгээ"-нд Үйлдвэр, худалдааны яамны төлөөллийг тусгай хуваарийн дагуу тогтмол ажиллуулах замаар зохион байгуулна.

1.4. Экспорт, импортын лиценз нь шууд бус болон шууд гэсэн хоёр төрөлтэй байна.

1.5. Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах, үндэсний түүх, соёлын үнэт зүйлийг хамгаалах, хүн, ургамал, мал, амьтны амь нас, эрүүл мэндийг хамгаалах, экспорт, импортын барааны урсгал, дотоод зах зээлийн эрэлт, нийлүүлэлтийн зохистой харьцааг бүрдүүлэх, Монгол Улсын олон улсын гэрээний заалтыг биелүүлэх зэрэг үндэслэлээр төрийн хяналт хэрэгжүүлэх зорилгоор олгох экспорт, импортын лицензийг шууд бус лицензи гэнэ.

1.6. Монгол Улсын хууль тогтоомж болон Монгол улсын олон улсын гэрээгээр тоо хэмжээний хязгаарлалт тогтоогоогүй монголын барааны гарал үүслийн гэрчлэлтийг баталгаажуулах, эдгээр барааны экспортод статистик, бүртгэлийн хяналт тавих, Монгол Улсын хилээр гаргах зөвшөөрлийг Монгол Улсын Засгийн газраас тусгайлан олгож байхаар заасан барааны экспортын бүртгэл, хяналтыг хэрэгжүүлэх зорилгоор олгох экспортын лицензийг шууд лиценз гэнэ.

Хоёр. Лиценз олгох өргөдөл гаргах, хянан шийдвэрлэх журам

2.1. Төрийн хяналтын дор улсын хилээр нэвтрүүлэх бараат экспортлох, импортлох өргөдлийг лиценз хүсэгч иргэн, аж ахуйн нэгж, хуулийн этгээд Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвөөс батлсан тусгай маягтын дагуу Үйлдвэр, худалдааны яаманд гаргана. Өргөдөлд дор дурдсан зүйлийг заасан байвал зохино:

- өргөдөл гаргагчийн нэр, хаяг;
- барааны нэр, тодорхойлолт, код /БТКУС/;
- барааны тоо, хэмжээ, өлөөт валютаар илэрхийлсэн үнэ;
- нийлүүлэх хугацаа, төээрийн төрөл;
- импортын лицензийн хувьд гадаад орны экспортлогчийн нэр,хаяг;
- барааны гарал үүслийн орон;
- бараа нэвтрүүлэх Монгол Улсын хилийн боомтын нэр;
- өргөдөл гаргагчийн харьяалагдах татварын албаны нэр, хаяг.

Өргөдөлд дурдсан мэдээллийн үнэн зөвийн хариуцлагыг өргөдөл гаргагч хүлээнэ.

2.2. Экспорт, импортын лиценз олгох өргөдөлд дор дурдсан баримт бичгийг хавсаргасан байна:

- аж ахуйн нэгж, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээ, иргэний хувьд иргэний үнэмлэхийн нотриатчаар гэрчлүүлсэн хуулбар;
- гэрээ, контрактын хуулбар;
- адил нэрийн бараагаар өмнө авсан лицензийн гүйцэтгэл;
- улсын төмдэгтийн хураамж төлсөн баримт.

2.3. Дор дурдсан бараагаар холбогдох байгууллагын зөвшөөрөл, тодорхойлолт, дүгнэлтийг гаргуулж өргөдөлд хавсаргана:

Барааны нэр	Зөвшөөрөл олгох байгууллага	Тодорхойлолт олгох байгууллага	Дүгнэлт гаргах байгууллага
Үржлийн мал	Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн улсын хяналтын алба	-	-
Нэн ховор ан амьтан	Засгийн газар	-	-
Бүгын цусан, ясан эвэр, аргаль янгирын эвэр	Байгаль орчны яам	-	-
Мал, амьтны үр, үр хөврөл	Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн улсын хяналтын алба	-	-
Байгалийн ургамал	Байгаль орчны яам	-	-
Цацраг идэвхт бодис,ионжуулагч цацрагийн бусад үүсгүүр,химийн бодис	-	-	Цацрагийн хяналтын алба
Хортой,бага хортой химийн бодис	Аймаг, нийслэлийн Засаг дарга	-	-
Озоны үе давхар-гыг задалдаг химийн бодисууд	Байгаль орчны яам	-	-
Аюултай хог хаягдал	-	Байгаль орчны яам	-
Ургамал хамгаалахад ашиглах бодис	Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн улсын хяналтын алба	-	-
Мал эмнэлгийн хэрэгсэл	Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн улсын хяналтын алба	-	-
Эмийн бүтээгдэхүүн	Хүний эм -Эрүүл мэндийн улсын хяналтын алба Малын эм -Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн улсын хяналтын алба	-	-
Тэсрэх бодис	Цагдаагийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Зэвсэгт хүчний ерөнхий штаб	-	-
Буу, зэр зэвсэг	Цагдаагийн ерөнхий газар, Тагнуулын ерөнхий газар, Зэвсэгт хүчний ерөнхий штаб	-	-
Түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйл	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	-	-
Сүлжмэл, нэхмэл бүтээгдэхүүн болон бэлэн хувцас	-	-	Гарал үүслийн гэрчилгээ

2.4. Үйлдвэр, худалдааны яам энэ журмын 2.3-т дурдсанаас бусад шаардлагатай зөвшөөрөл, тодорхойлолт, дүгнэлтийг холбогдох яам, байгууллагуудаас гаргуулна.

Эдгээр зөвшөөрөл, тодорхойлолт, дүгнэлтийг гаргахад шаардлагатай дараахь баримт бичгийг Үйлдвэр, худалдааны яам холбогдох байгууллагуудад хүргүүлнэ:

- лиценз олгох өргөдлийн хуулбар;
- аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн гэрчилгээ, иргэний хувьд иргэний үнэмлэхийн нотриатчаар гэрчлүүлсэн хуулбар;
- гэрээ, контрактын хуулбар;
- бусад.

2.5. Холбогдох яам, байгууллагууд зөвшөөрөл, тодорхойлолт, дүгнэлтийг ажлын 21 өдөрт багтаан гаргана. Монгол Улсын хууль тогтоомжоор тусгайлан заагаагүй бол зөвшөөрөл, тодорхойлолт, дүгнэлт гаргахад төлбөр, хураамж авахыг хориглоно.

2.6 Яам, газрууд зөвшөөрөл, тодорхойлолт, дүгнэлт гаргахдаа барааны кодыг БТКУС-ийн ангиллаар заасан байна.

2.7. Үйлдвэр, худалдааны яам экспорт, импортын лиценз олгох тухай өргөдөл, зохих журмын дагуу бүрдүүлсэн баримт бичгийг хүлээн авснаас хойш ажлын 21 өдөрт багтаан хянан шийдвэрлэнэ. Шууд лицензийг ажлын 5 хоногт багтаан шийдвэрлэнэ.

2.8 Үйлдвэр, худалдааны яам шаардлагатай бол өргөдөл гаргагчийн баримт бичгийг холбогдох байгууллагаар нягтлан шалгуулах, магадлан шинжилгээ хийлгүүлэх эрхтэй бөгөөд энэ тохиолдолд өргөдлийг шийдвэрлэх хугацааг 14 хоногоор сунгаж болно.

2.9. Монгол Улсын нэгдсэн олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол лицензийг Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвийн баталсан маягтын дагуу олгоно. Лицензийг 3 хувь үйлдэнэ. Лиценз олгоход Монгол Улсын хууль тогтоомжид заасны дагуу улсын тэмдэгтийн хураамж ногдуулна.

Гурав. Лицензийн хугацаа, түүнийг сунгах, тайлан, мэдээ гаргах журам

3.1. Лиценз зээмшигчийн экспортлогч, импортлогчидтой байгуулсан гэрээний үүргийг биелүүлэх хугацаа, шаардлагатай уялдуулан лицензийг 1 жил хүртэл хугацаагаар сунгаж болно. Лиценз сунгах өргөдлийг Үйлдвэр, худалдааны яам ажлын 3 хоногийн дотор хянан шийдвэрлэнэ.

3.2. Лицензийг бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах зэргээр шилжүүлж үл болно.

3.3. Лицензэд нэр заасан барааны хадгалах, борлуулах хугацааны шаардлага, тээвэрлэлт, хамгаалалт, чанар, стандартын нөхцөлийг хангасан байх үүргийг лиценз хүсэгч өөрөө хариуцна.

3.4. Лицензтэй бараанд олгосон зөвшөөрөл, тодорхойлолт, дүгнэлт, гэрчилгээний тайлан, мэдээг холбогдох яам, газрууд хагас жил тутам гаргаж Үйлдвэр, худалдааны яаманд хүргүүлнэ.

3.5. Үйлдвэр, худалдааны яам олгосон лицензийн тайлан, мэдээг холбогдох яам, газрууд, Улсын гаалийн өрөнхий газарт хагас жил тутам хүргүүлнэ.

3.6. Лиценз олгох журам, түүнд орсон өөрчлөлт, олгосон лицензийн тухай мэдээллийг Үйлдвэр, худалдааны яам зохих журмын дагуу Дэлхийн худалдааны байгууллагад мэдээлж байна.

Дөрөв. Бусад

4.1. Лиценз хүсэгч лиценз олгохтой холбогдсон гомдлыг Үйлдвэр, худалдааны сайдад гаргана. Үйлдвэр, худалдааны сайдын шийдвэрийг эс зөвшөөрвөл шүүхэд гомдол гаргаж болно.

4.2. Лиценз олгох тухай хууль тогтоомжийг зөрчсөн буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол "Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хууль" /2001 он/-д заасан захиргааны шийтгэл ногдуулна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 3 дугаар сарын 21-ний өдөр **Дугаар 56** **Улаанбаатар хот**

Тогтоолд нэмэлт оруулах тухай

Иргэний бүртгэлийн тухай хууль, Засгийн газрын 2000 оны 198 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Захирагчийн ажлын албаны бүтцийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 2000 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 185 дугаар тогтоолын 6 дугаар зүйлд "ц/Иргэний бүртгэл, мэдээллийн алба" гэж нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Ө.ЭНХТҮВШИН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 3 дугаар сарын 21-ний өдөр **Дугаар 57** **Улаанбаатар хот**

Б.Ганболдыг Төрийн нарийн бичгийн даргаар томилох тухай

Засгийн газрын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 8 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Баасанжавын Ганболдыг Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн даргаар томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ГАДААД ХЭРГИЙН САЙД Л.ЭРДЭНЭЧУЛУУН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 3 дугаар сарын 21-ний өдөр **Дугаар 58** **Улаанбаатар хот**

Тогтоолын заалтад өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Үүрэн телефон хэрэглээ эрх бүхий албан тушаалтны жагсаалт, зардлын норматив батлах тухай" Засгийн газрын 1999 оны 5 дугаар сарын 26-ны өдрийн 84 дүгээр тогтоолын 2 дугаар зүйлийн "...захирагчаас..." гэснийг "...захирагчид улс хоорондын ярианы эрхтэйгээр, нэг сард 150,0 мянган төгрөгөөс хэтрэхгүй байхаар," гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Ө.ЭНХТҮВШИН

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 3 дугаар сарын 21-ний өдөр **Дугаар 59** **Улаанбаатар хот**

Хариуцлага хүлээлгэх тухай

"МИАТ" компанийн "МИ-8" нисдэг тэрэгний сүйрлийн шалтгааныг шинжлэн шалгах комиссын дүгнэлтийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Дэд бүтцийн сайд Б.Жигжид, Төрийн өмчийн хорооны дарга Л.Пүрэвдорж нарт даалгах нь:

а/"МИ-8" нисдэг тэрэгний сүйрэлтэй холбогдуулан ажлын хариуцлага алдсан, техник, технологийн зөрчил гаргасан хүмүүст хариуцлага хүлээлгэсүгэй;

б/иргэний нисэхийн аюулгүй ажиллагаа хангах,бүтэц, зохион байгуулалтыг боловсронгуй болгох, үйл ажиллагаа нь сайжруулахад чиглэгдсэн арга хэмжээний талаар санал боловсруулж, энэ оны 4 дүгээр сард багтаан Засгийн газрын хуралдаанд оруулсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ДЭД БҮТЦИЙН САЙД Б.ЖИГЖИД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 3 дугаар сарын 28-ны өдөр **Дугаар 60** **Улаанбаатар хот**

Журамд өөрчлөлт оруулах тухай

Иргэний бүртгэлийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Засгийн газрын 1997 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 109 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын үндэсний гадаад паспорт олгох, зээмших, хадгалах журам"-ын 13 дугаар заалтын "... орон нутагт аймгийн цагдаагийн газар, хэлтсийн дарга..." гэснийг "аймагт Засаг даргын Тамгын газрын дарга, Хууль зүйн хэлтсийн дарга, Сэлэнгэ аймгийн Мандал сум, нийслэлийн Багахангай, Налайх, Багануур дүүрэгт сум, дүүргийн Засаг дарга, Засаг даргын Тамгын газрын дарга" гэж өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД **Ц.НЯМДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 3 дугаар сарын 28-ны өдөр **Дугаар 61** **Улаанбаатар хот**

Тооны дээд хязгаар тогтоох тухай

Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Цэргийн албыг 2001 онд биеэр дүйцүүлэн хаах иргэний тооны дээд хязгаарыг хавсралт ёсоор тогтоосугай.

2. Цэргийн дүйцүүлэх албыг зохих журмын дагуу хаалгах арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД **Ж.ГҮРРАГЧАА**

Засгийн газрын 2001 оны 61 дүгээр тогтоолын хавсралт

ЦЭРГИЙН АЛБЫГ 2001 ОНД БИЕЭР ДҮЙЦҮҮЛЭН ХААХ ИРГЭНИЙ ТООНЫ ДЭЭД ХЯЗГААР

№	Аймаг, нийслэлийн нэр	Тооны дээд хязгаар
1.	Архангай	120
2.	Баян-Өлгий	35
3.	Баянхонгор	120
4.	Булган	30
5.	Говь-Алтай	15
6.	Говьсүмбэр	20
7.	Дархан-Уул	35
8.	Дорноговь	30
9.	Дорнод	30
10.	Дундговь	16
11.	Завхан	30
12.	Орхон	15
13.	Өвөрхангай	80
14.	Өмнөговь	34
15.	Сүхбаатар	20
16.	Сэлэнгэ	30
17.	Төв	100
18.	Увс	60
19.	Ховд	60
20.	Хөвсгөл	35
21.	Хэнтий	30
22.	Улаанбаатар	55
Дүн		1000

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 3 дугаар сарын 28-ны өдөр Дугаар 62 **Улаанбаатар хот**

Боловсрол,соёл,шинжлэх ухааны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-ийг хавсралт ёсоор зөвшөөрсүгэй.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Гэгээрлийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх, тус яамны бүтцийг батлах тухай" Засгийн газрын 1997 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн 142 дугаар тогтоол, "Гэгээрлийн яамны бүтцийг батлах тухай" Засгийн газрын 1999 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 178 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД А.ЦАНЖИД

Засгийн газрын 2001 оны 62 дугаар тогтоолын хавсралт

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХӨТӨЛБӨР

Нэг.Нийтлэг үндэслэл

1.1.Оршил

Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам /цаашид "Яам" гэнэ/-ны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр /цаашид "Хөтөлбөр" гэнэ/-т Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын болон Засгийн газрын шийдвэрийн төсөл боловсруулах, тус салбарын талаар бодлого, хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, төрийн захиргааны удирдлага, зохицуулалт болон бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ /мониторинг/ хийх, үр дүнд үнэлгээ өгөх асуудлыг хамарсан үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн загварыг тодорхойлов.

1.2.Үндэслэл

Хөтөлбөрийг боловсруулахдаа Улсын Их Хурлын 1996 оны 38 дугаар тогтоолоор зөвшөөрсөн "Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлтийн талаар баримтлах бодлого", Засгийн газрын бүтцийн тухай хууль болон "Яамдын зохион байгуулалтын бүтцийг батлах тухай" Засгийн газрын 2000 оны 131 дүгээр тогтоолыг тус тус үндэс болгов.

1.3.Хууль тогтоомжийн орчин

Хөтөлбөрийг дор дурдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ:

- Монгол Улсын Үндсэн хууль
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
- Монгол Улсын Төрийн албаны тухай хууль
- Боловсролын тухай хууль
- Бага, дунд боловсролын тухай хууль
- Дээд боловсролын тухай хууль
- Соёлын тухай хууль
- Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хууль
- Шинжлэх ухаан, технологийн тухай хууль
- Технологи дамжуулах тухай хууль
- Төрөөс боловсролын талаар баримтлах бодлого
- Шинжлэх ухаан, технологийн талаар төрөөс баримтлах бодлого
- Монгол Улсын төрөөс баримтлах соёлын бодлого.

1.4.Яамны чиг үүрэг

Яам нь боловсрол, соёл, шинжлэх ухааны талаархи төрийн бодлого, Засгийн газрын үйл ажиллагааны стратегийг хэрэгжүүлэхэд Засгийн газар, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдад бүх талын зөвлөлгөө, дэмжлэг үзүүлнэ.

1.5.Стратегийн бодлого, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр

БСШУЯ-ны стратегийн бодлого, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр нь үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгч байхаар тодорхойлов. Энэхүү хэрэгцээний эх үүсвэрт дор дурдсан үйлчлүүлэгч буюу хэрэглэгч хамрагдана /Бүдүүвч 1/:

Яамны үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчнь Засгийн газар, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд байна.

Яамны стратегийн бодлого, зохицуулалт нь дээр дурдсан үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийн эрэлт, хэрэгцээг хангахад чиглэнэ.

Яамны стратегийн бодлого, зохицуулалтын хэрэгцээг хангах үйлчилгээний хүрээ, төрөл, хэлбэрийг хэрэгцээний эх үүсвэр тус бүрээр тогтоож, яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн зорилт, чиг үүргийг тодорхойлов.

БСШУЯ-НЫ СТРАТЕГИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЦЭЭНИЙ ЭХ ҮҮСВЭР



Бүдүүвч 1

2.0.Яамны үйл ажиллагааны стратеги

2.1.Яамны үйл ажиллагааны стратегийн мөн чанар

Яамны үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд чиглэсэн өндөр мэргэшлийн, цаг үеэ олсон, шуурхай зөвлөлгөө, бүх талын дэмжлэг үзүүлэхэд оршино.

2.2.Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл

- Боловсролын удирдлага, тогтолцоог боловсронгуй болгох, сургалтын агуулга, чанарыг сайжруулах
- Соёл, урлагийн үйлчилгээний хүртээмж, үр нөлөөг дээшлүүлэх, түүх, соёлын өвийг хадгалж, хамгаалах
- Шинжлэх ухаан, технологийн үндэсний чадавхийг нэмэгдүүлж, үр дүнг үйлдвэрлэл, үйлчилгээнд өргөн нэвтрүүлэх
- Боловсрол, соёл, шинжлэх ухааны салбарын үйл ажиллагаат стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар хангах, зохицуулах, хяналт-шинжилгээ /мониторинг/ хийх, үнэлгээ өгөх

- Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, үйл ажиллагааны чадавхи, үр нөлөөг дээшлүүлэх.

2.3.Үйл ажиллагааны эрхэм зорилго

Монгол Улсын иргэд ардчилсан нийгэмд амьдрах, ажиллахад шаардагдах мэдлэг, чадвар, технологи болон соёлын үнэт зүйлсийг эзэмших, сонгох таатай орчин, нөхцөлийг бүрдүүлэх.

2.4.Үйл ажиллагааны стратегийн зорилт

Яам нь стратегийн дор дурдсан зорилтыг хэрэгжүүлнэ:

1.Бага, дунд боловсролыг хөгжүүлэх стратегийн бодлого, зохицуулалтын удирдамжаар хангах

2. Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролыг хөгжүүлэх стратегийн бодлого, зохицуулалтын удирдамжаар хангах

3.Соёл, урлагийг хөгжүүлэх стратегийн бодлого, зохицуулалтын удирдамжаар хангах

4.Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын манлайллыг хангах, салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх

5.Салбарыг хөгжүүлэх эдийн засгийн бодлого, зохицуулалтын удирдамжаар хангах, стратегийн бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ /мониторинг/ хийх, үр дүнд үнэлгээ өгөх.

2.5.Үйл ажиллагааны гол зорилт

Стратегийн зорилтын хүрээнд дор дурдсан үйл ажиллагааны гол зорилтыг хэрэгжүүлнэ:

Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд:

- Бага, дунд боловсролыг хөгжүүлэх бодлогын удирдамжаар хангахад зөвлөлгөө, дэмжлэг үзүүлэх;
- Бага, дунд боловсролыг хөгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний боловсруулалт, хэрэгжилтийн зохицуулалтыг сайжруулах;
- Бага, дунд боловсролын талаархи төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх.

Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд:

- Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролыг хөгжүүлэх бодлогын удирдамжаар хангахад зөвлөлгөө, дэмжлэг үзүүлэх;
- Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролыг хөгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний боловсруулалт, хэрэгжилтийн зохицуулалтыг сайжруулах;
- Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын талаархи төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх.

Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд:

- Соёл, урлагийг хөгжүүлэх бодлогын удирдамжаар хангахад зөвлөлгөө, дэмжлэг үзүүлэх;
- Соёл, урлагийг хөгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээний боловсруулалт, хэрэгжилтийн зохицуулалтыг сайжруулах;
- Соёл, урлагийн талаархи төрийн бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх.

Үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд:

- Төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын чадавхийг дээшлүүлэхэд дэмжлэг, үйлчилгээ үзүүлэх;
- Салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааны үр нөлөөг дээшлүүлэх;
- Аппаратын санхүү, аж ахуйг бэхжүүлэх, байгууллагын соёлыг төлөвшүүлэхэд дэмжлэг үзүүлэх.

Үйл ажиллагааны стратегийн 5 дугаар зорилтын хүрээнд:


- Салбарын эдийн засгийн нөөцийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлж, нэгдсэн зохицуулалтаар хангах;
- Салбарын бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх;
- Салбарын статистик мэдээллийн боловсруулалтыг сайжруулж, мэдээллийн нэгдсэн сан, сүлжээг бий болгож, мэдээллээр үйлчлэх.

2.6.Үйл ажиллагааны зорилт

Гол зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны зорилтуудыг яамны газруудын чиг үүрэг, төрийн захиргааны албан хаагчдын аажлын байр /албан тушаал/-ны тодорхойлолтод тусган хэрэгжүүлнэ.

Яамны үйл ажиллагааны бүтцийн стратегийн загварыг дор дурдсанаар тодорхойлж байна /Бүдүүвч 2/:

БСШУЯ-НЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЦИЙН СТРАТЕГИЙН ЗАГВАР




Бүдүүвч 2

2.7.Үйл ажиллагааны бүтцийн загвар

Яам нь үйл ажиллагааны бүтцийн дор дурдсан загвартай байна /Бүдүүвч 3/.

БСШУЯ-НЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЦИЙН ЕРӨНХИЙ ТӨГТОЛЦООНЫ ЗАГВАР



3.0.Зохион байгуулалтын бүтэц

Яамны үйл ажиллагааны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, тэдгээрийн чиг үүргийг дор дурдсанаар тодорхойлж байна:

3.1. Бага, дунд боловсролын бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлаар бага, дунд боловсролыг хөгжүүлэх бодлогын үндэслэл, урт, дунд, богино хугацааны төлөвлөлт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг боловсруулах, тэдгээрийг нэгдсэн зохицуулалтаар хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ чиг үүргийг цаг үеэ олсон, шуурхай мэдээлэл, зөвлөгөө, үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх замаар хэрэгжүүлнэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн үйлчлүүлэгч нь Засгийн газар, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд байх бөгөөд хэрэглэгч нь бусад яам, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, нутгийн захиргааны байгууллага, бүх шатны сургууль, цэцэрлэг, эрдэм шинжилгээний байгууллага, аж ахуйн нэгж, бусад байгуулллага болон иргэд байна.

3.2.Шинжлэх ухаан, технологи, дээд боловсролын асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлаар шинжлэх ухаан, технологи, дээд боловсролыг хөгжүүлэх бодлогын үндэслэл, урт, дунд, богино хугацааны төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг боловсруулах, хэрэгжилтийг зохицуулах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ чиг үүргийг цаг үеэ олсон шуурхай мэдээлэл, мэргэшлийн зөвлөгөө, үйлчилгээ, бүх талын дэмжлэг үзүүлэх замаар хэрэгжүүлнэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн үйлчлүүлэгч нь Засгийн газар, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд байх бөгөөд хэрэглэгч нь бусад яам, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, нутгийн захиргааны байгууллага, их сургууль, коллеж, эрдэм шинжилгээний байгууллага, аж ахуйн нэгж, төрийн ба төрийн бус байгуулллага, иргэд байна.

3.3.Соёл, урлагийн асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын эрхлэх асуудлаар соёл, урлагийг хөгжүүлэх бодлогын үндэслэл, урт, дунд, богино хугацааны төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг боловсруулах, тэдгээрийг нэгдсэн зохицуулалтаар хангах чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ чиг үүргийг цаг үеэ олсон шуурхай мэдээлэл, мэргэшлийн зөвлөгөө, үйлчилгээ, бүх талын дэмжлэг үзүүлэх замаар хэрэгжүүлнэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн үйлчлүүлэгч нь Засгийн газар, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь бусад яам, Засгийн газрын тохируулагч, хэрэгжүүлэгч агентлаг, нутгийн захиргааны байгууллага, соёл, урлагийн болон эрдэм шинжилгээ, олон улсын байгууллага, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгуулллага, иргэд байна.

3.4.Төрийн захиргааны удирдлага, хамтын ажиллагааны асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд төрийн

захиргааны болон хүний нөөцийн удирдлагын чадавхийг бий болгох, салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг өргөжүүлэх, үр ашгийг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх, яамны үйл ажиллагаанд удирдлагын шилдэг арга барил, соёлыг нэвтрүүлэх, ажиллагдын ниймийн баталгааг нэмэгдүүлэх, ажлаа тайлагнах, хариуцлага тооцдог тогтолцоог төлөвшүүлэх зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь цомхон, чадварлаг төрийн захиргааны мэргэшсэн албан хаагчдаар яамны тасралтгүй, хэвийн жигд ажиллагааг хангахад чиглэнэ.

Энэ чиг үүргийг цаг үеэ олсон шуурхай мэдээлэл, мэргэшлийн зөвлөлгөө, үйлчилгээ, бүх талын дэмжлэг үзүүлэх замаар хэрэгжүүлнэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Төрийн нарийн бичгийн дарга, яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, яамны шууд харьяа байгууллага байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь бүх шатны сургууль, цэцэрлэг, соёл, урлаг, эрдэм шинжилгээний болон нутгийн захиргааны байгууллага, тэдгээрийн удирдлага, иргэд байна.

5.Эдийн засаг, хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, чиг үүрэг:

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 5 дугаар зорилтын хүрээнд салбарын эдийн засгийг хөгжүүлэх бодлогын үндэслэл, урт, дунд, богино хугацааны төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ боловсруулах, тэдгээрийг нэгдсэн зохицуулалтаар хангах, бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх, мэдээллийн сүлжээ, сан бүрдүүлэх, мэдээллээр үйлчлэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь Засгийн газар, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдаас тус салбар дахь материаллаг нөөцийг нэмэгдүүлэх, төсвийн тэнцвэрт байдал, харилцан уялдаа холбоог хангахад чиглэнэ.

Энэ чиг үүргийг цаг үеэ олсон шуурхай мэдээлэл, мэргэшлийн зөвлөлгөө, үйлчилгээ, бүх талын дэмжлэг үзүүлэх замаар хэрэгжүүлнэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн үйлчлүүлэгч нь Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Төрийн нарийн бичгийн дарга, яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, Үндэсний статистикийн газар байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь бусад яам, агентлаг, олон улсын байгууллага, сургууль, цэцэрлэг, соёл, урлагийн болон эрдэм шинжилгээний байгууллага, иргэд байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 3 дугаар сарын 28-ны өдөр **Дугаар 63** **Улаанбаатар хот**

Импортын барааны гаалийн үнийг тодорхойлох аргачлал батлах тухай

Гаалийн тарифын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Импортын барааны гаалийн үнийг тодорхойлох аргачлалыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Аргачлал батлах тухай" Засгийн газрын 1993 оны 4 дүгээр сарын 9-ний өдрийн 55 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

Засгийн газрын 2001 оны 63 дугаар тогтоолын хавсралт

ИМПОРТЫН БАРААНЫ ГААЛИЙН ҮНИЙГ ТОДОРХОЙЛОХ АРГАЧЛАЛ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Импортын барааны гаалийн үнийг тогтоохдоо энэхүү аргачлалыг мөрдөнө.

2. Импортын барааны гаалийн үнийг Дэлхийн Худалдааны Байгууллагын үнэлгээний Хэлэлцээр (цаашид "Хэлэлцээр" гэх), Гаалийн тарифын тухай хууль зэрэгцүүлэн 6 дугаар хэсэгт заасны дагуу үнэлгээний 6 аргыг хэрэглэн тогтооно.

3. Гаалийн үнийг мэдүүлэгч үнэн зөв, бодит үндэслэлтэй тодорхойлсон эсэхийг гаалийн байгууллага шалгаж шийдвэрлэнэ. Энэхүү шийдвэрийн талаар импортлогч бичгээр хүсэлт гаргаж гаалийн байгууллагаас импортын барааны гаалийн үнийг хэрхэн тодорхойлсон талаар тайлбар гаргуулан авах эрхтэй.

Хоёр. Гаалийн үнийг тодорхойлох арга

4. Импортын барааны гаалийн үнийг тодорхойлходоо дор дурдсан 6 аргыг хэрэглэнэ:

1. Хэлцлийн үнийн арга
2. Нэг төрлийн барааны хэлцлийн үнийн арга
3. Ижил төрлийн барааны хэлцлийн үнийн арга
4. Ялгавартай үнийн арга
5. Нийлбэр үнийн арга
6. Уялдуулан хэрэглэх арга.

НЭГДҮГЭЭР АРГА. ХЭЛЦЛИЙН ҮНИЙН АРГА

5. Энэ арга нь гаалийн үнэлгээний үндсэн арга болно. Хэлцлийн үнийн аргаар гаалийн үнэ тогтоохдоо Монгол Улсын нутаг дэвсгэрт бараог хүргэхтэй холбогдон гарсан хэлцлийн үнэд тусгагдаагүй, эсвэл хэлцлийн үнээс тусдаа ялгарч харагдаж байгаа тоон үзүүлэлтээр илэрхийлэгдсэн бөгөөд гадаад худалдааны болон санхүү, нягтлан бодох бүртгэлийн үндэслэлтэй мэдээ баримтад тулгуурласан дор дурдсан зардлуудыг нэмж тооцно:

5.1. Бараог Монгол Улсын хилийн өртөө хүртэл тээвэрлэх, ачих, буулгах зардал, даатгалын хураамж (цаашид "Т" гэж тэмдэглэх).

5.1.1. Тээврийн зардал.

5.1.1.1. Тээврийн бичиг баримт бүрдүүлэхтэй холбогдон гарсан аливаа хураамж, үнэ хөлс

5.1.1.2. EXW (үйлдвэрлэгчийн болон экспортлогчийн агуулахаас нийлүүлэх) ба FAS (экспортлогчийн боомтоос нийлүүлэгдэх) зэрэг бараа нийлүүлэх нөхцөлөөр гэрээ хэлцэл хийгдсэн бол экспортлогч орноос бараог гаргах үед экспортын бичиг баримт бүрдүүлэхтэй холбогдон гарсан зардал (тухайлбал, экспортын эвшээрлийн болон бусад адилтгах бичиг баримт, гаалийн бүрдүүлэлтийн хураамж гэх мэт)

5.1.1.3. Тээврийн хэрэгслийн болон чингэлгийн ашиглалтын үнэ хөлс, эсвэл түүний түрээсийн төлбөр

Тайлбар: Бараог тээвэрлэх чингэлэг гэдэгт бараанаас тусдаа ангилагдах зөөврийн контейнерээс гадна мөн тээврийн хэрэгсэлтэй цуг байдлаар ашиглагдах (ёмкость, цистерн зэрэг) торх савыг хамруулан авч үзнэ.

Хэрэв бараг үнэгүй тээвэрлэсэн, эсвэл худалдан авагч өөрийн тээврийн хэрэгслээр тээвэрлэсэн бол адил төстэй тээврийн хэрэгслийн тухайн үед мөрдөгдөж байгаа баталгаат тарифаар тооцож гаалийн үнэд нэмж тусгана.

Авто тээврийн хэрэгслээр бараг тээвэрлэх үед дээрх баримт мэдээлэл байхгүй тохиолдолд тухайн тээвэрлэлтийг зохион байгуулж байгаа аж ахуйн нэгжийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн баримтад тулгуурлан тооцох, эсвэл тухайн тээврийн хэрэгслийн зарцуулсан шатахууны үнэ болон жолоочийн хөлс, тээврийн хэрэгслийн элэгдлийг тооцсон зардлыг хамруулан тогтооно.

5.1.2. Бараг тээвэрлэх үед гарсан ачилт, буулгалт, хадгалалт, шилжүүлэн ачилт болон арчлан хамгаалах зардал.

5.1.2.1. Бараг хэд хэдэн төрлийн тээврийн хэрэгслээр тээвэрлэн улсын хил хүргэсэн бол түүнийг нэг тээврийн хэрэгслээс нөгөөд шилжүүлэн ачих, замд буулгах, хадгалах зэрэг үйл ажиллагааны явцад гарах бүх зардал, хөлс

5.1.2.2. Тээвэрлэлтийн явцад барааnd боловсруулалт хийх, тухайлбал, шаардлагатай дулаан бүхий орчинд тээвэрлэх ёстой бараа бол түүнд гарах зардал, мөн үүнтэй төстэй чийг, агааржуулалт, хөргөлтөд гарах зардал, түүнчлэн хэрвээ амьд амьтан бол түүнийг хооллох, эмчлэх зэрэг тухайн барааны бүрэн бүтэн байдал, чанарыг хадгалахтай холбогдон гарах зардлыг хамруулан тогтооно.

5.1.3. Даатгалын хураамж

Энэ заалтын 1.1, 1.2-т заасан тээвэрлэх, ачих, буулгах болон хадгалах зэрэг үйл ажиллагаатай холбогдон гарч болзошгүй эрсдэлээс хамгаалах зорилгоор хийгдсэн даатгалуудыг энд хамруулна. Даатгалыг түүний үндэсн бичиг баримт болох гэрээ (insurance contract), эсвэл гэрчилгээ (insurance polisy or certificate)-ээр баталгаажуулж тодорхойлно.

Тайлбар: Гэрээ хэлцэлд бараа нийлүүлэх нөхцөл нь EXW болон "F" бүлэг (FCA, FOB гэх мэт)-ийн нөхцөлөөр хийгдэн бол дээрх зардлуудыг хэлцлийн үнэ дээр нэмж тооцно.

5.2. Тухайн бараг худалдан авахтай холбогдуулан худалдан авагчийн төлсөн буюу төлбөл зохих комиссын болон зуучлагчийн хөлс, уг бараатай хамт ангилагдах эргэлтийн сав, баглаа боодлын үнийг (цаашид "К" үсгээр тэмдэглэх) хэлцлийн үнэд оруулж тооцоогүй тохиолдолд холбогдох төлбөр тооцооны баримтыг үндэслэн импортын барааны төлсөн болон төлбөл зохих үнэ дээр нэмж гаалийн үнэд тусгана.

5.2.1. Зуучлагчийн хураамж болон бараг худалдахад оролцсон комиссын шимтгэл

5.2.2. Гаалийн зорилгоор импортолж буй бараатай нэгдмэл байдлаар авч үзвэл зохих сав, баглаа боодол, чингэлэгийн (контейнерээс бусад) үнэ

Олон дахин ашиглах эргэлтийн сав, баглаа боодол, чингэлэгийн зардлыг ачилт болгон дахь барааны тоо хэмжээнд тохируулан хуваарилна. Тээврийн болон бусад гэрээ хэлцэлд тусгасан, эсхүл ямар нэгэн баримтаар баталгаажсан тохиолдолд ийнхүү хуваарилж хэрэгжүүлнэ.

Сав, баглаа боодлын зардал гэдэгт дараахь өртөг буюу үнэ, зардал, хөлсийг хамруулна. Үүнд:

- Дотор савлагааны хайрцаг, уут, сав, боодол (өөрөөр хэлбэл, "жижиглэн"-гийн хэмээгдэх уут, хайрцаг, картон сав, пластик боодол гэх мэт зүйлс)-ын өртөг буюу үнэ;

- Гадуур савлагааны хайрцаг, уут, сав, боодол ("экспорт"-ын хэмээгдэх картон хайрцаг, модон болон фанеран сав, төмөр торх зэрэг)-ын өртөг буюу үнэ;

- Савлалтын бусад туслах материал (картон давхрага, хөөсөн шахмал, сүрэл, цаас, үртэс гэх мэт)-ын зардал;

- Савлах ажилбар (тухайлбал хайрцаг саванд бараог хийх, савлах, битүүмжлэх наах, хаяг марклалт болон бусад бичилтийг бичих г.м)-ын хөлс зэрэг орно.

Тайлбар: Бараатай хамт нэгдмэл байдлаар нийлүүлэгдэх сав, баглаа боодол (тухайлбал, лонхтой архи, эсвэл шилэн савтай жимсний чанамал) бол "Бараг тодорхойлох, кодлох уялдуулсан систем"-ийн ангилалтын дагуу нэг кодод хамаарна. Энэ тохиолдолд сав, баглаа боодол (лонх, шилэн сав)-ын зардал ихэвчлэн бараа (архи болон жимсний чанамал)-ны үнэд шингэсэн байдаг.

Хэрэв бараа нь импортлогчийн худалдан авсан контейнер, цистерн зэрэгт савлагдан нийлүүлэгдэх тохиолдолд бараа болон контейнер, цистерн нь тус тусдаа ангилагдана.

5.3. Тухайн бараг үйлдвэрлэх, Монгол Улсад экспортлохтой холбогдуулан ашиглуулахаар худалдан авагчаас худалдагчид буюу үйлдвэрлэгчид шууд болон шууд бус хэлбэрээр үнэ төлбөргүй, эсхүл хямдруулсан үнээр нийлүүлсэн бараа, ажил, үйлчилгээний өртгийн зохих хэсэг (цаашид "Д" үсгээр тэмдэглэх).

Өртгийн зохих хэсэг гэдэгт тухайн бараанд бодитой зарцуулагдсан буюу үйлдвэрлэлийн явцад технологийн ажиллагаанаас хамааран зайлшгүй гарах материалын хаягдал, хэвийн хорогдлыг хасч тооцсон өртгийг ойлгоно.

Энэ бүлэг зардалд дараахь бараа материал, ажил, үйлчилгээний өртөг, зардлыг багтаан авч үзнэ. Үүнд:

5.3.1.Үнэлж байгаа импортын бараанд бүрэлдэхүүн хэсэг болгон нэттэгсэн материал, бүрдэл хэсэг, эд анги болон тэдгээртэй төстэй зүйлс;

5.3.2.Тухайн импортын бараг үйлдвэрлэх үед ашигласан багаж хэрэгсэл, хэв, загвар болон тэдгээртэй төстэй зүйлс;

5.3.3.Тухайн импортын бараг үйлдвэрлэх явцад зарцуулсан материал (тосолгооны материал, шатахуун, түлш гэх мэт зүйлс);

5.3.4.Тухайн импортын бараг үйлдвэрлэхэд шаардлагатай бөгөөд Монгол Улсаас өөр улс оронд хийж гүйцэтгэсэн инженерийн болон өөрчлөн шинэчлэх шийдэл, урлал чимэглэлийн болон дизайны ажил, өрөнхий бүдүүвч болон техникийн зураг төсөл.

5.4.Тухайн бараг худалдан борлуулах нөхцөл болгон худалдан авагчаас шууд болон шууд бус хэлбэрээр төлсөн, эсхүл төлөх

патентын төлбөр (цаашид "П" үсгээр тэмдэглэх).

Энэ зардалд зөвхөн патентын, оюуны өмчийн эрхийн бүх төрлийн шимтгэл, төлбөрийг хамруулна. Үүнд:

5.4.1.Патент буюу шинэ бүтээл, шинэ санаачилгыг хууль ёсоор эзэмших эзэндээ төлөх шимтгэл;

5.4.2.Худалдааны тэмдэг буюу үйлдвэрлэлийн болон худалдааны зорилгоор бараг ялгахад зориулагдсан тусгай таних тэмдгийг хэрэглэсний төлөө тухайн худалдааны тэмдэг эзэмшигчид төлөх төлбөр, шимтгэл;

5.4.3.Зохиогчийн эрх буюу оюуны бүтээлийг нь ашигласны төлөө зохиогчид төлөх төлбөр, шимтгэл.

Тайлбар: Зохиогчийн эрх нь оюуны бүтээлийг зохиогчийн зөвшөөрөлгүйгээр хуулбарлах, үйлдвэрлэх, орчуулах, тараахаас хамгаалсан эрх тул дараахь бүтээлүүдэд ихэнх тохиолдолд хэрэглэнэ. Тухайлбал:

-уран зохиол (роман, нийтлэл гэх мэт);

-хөгжмийн бүтээл (хөгжим, симфони, дуу гэх мэт);

-урлагийн бүтээл (уран зураг, баримал гэх мэт);

-карт болон техникийн зураг, фото зураг;

-киноны бүтээл (баримтат болон уран сайхны кино зэрэг) болно.

Оюуны өмчийн эрхийн төлбөр, шимтгэл нь импортын барааны төлсөн буюу төлбөл зохих үнэ дээр дор дурдсан нөхцөлд нэмэгдэж тооцогдоно. Үүнд:

- Үнэлж буй бараа нь зөвхөн оюуны өмчийн эрхийн төлбөр, шимтгэлд хамааралтай;

- Оюуны өмчийн эрхийн шимтгэл, төлбөрийг төлөх талаар худалдагч, худалдан авагч хоёрын хооронд байгуулсан худалдааны гэрээ хэлцэлд тусгайлан нөхцөл болон тусгагдсан.

5.5. Худалдан авагч тухайн бараг худалдан борлуулсан, захиран зарцуулсан, ашигласнаас олох орлогоосоо шууд болон шууд бус хэлбэрээр худалдагчид төлөх хэсэг (цаашид "О" үсгээр тэмдэглэх).

Худалдан авагч тухайн импортын бараг цаашь нь худалдан борлуулсан, захиран зарцуулсан, ашигласнаас олсон орлогын тодорхой хэсгийг худалдагчид өгнө гэж тохирч гэрээ хэлцэлд тусгасан бол түүнийг гаалийн үнэд оруулна.

Хэрвээ гаалийн бүрдүүлэлтийн хугацаанд худалдагчид төлөх орлогын хэмжээ тодорхой бус бол гаалийн байгууллагаас зөвшөөрсөн хөндлөнгийн магадлан шинжээч(аудит)-ээр тооцооны орлогыг тогтоолгон мэдүүлж болно.

Хэрвээ худалдагчид өгөх орлогын хэмжээг бүрдүүлэлтийн үед тодорхойлох боломжгүй бол гаалийн үнэлгээний дараагийн аргад шилжинэ.

5.6. Импортын барааны төлсөн буюу төлбөл зохих бодит үнээс хасах төлбөр, зардал (цаашид "Х" үсгээр тэмдэглэх).

Үнэлж буй импортын барааны төлсөн буюу төлбөл зохих бодит үнэд тусдаа өртөг болон шингэсэн дараахь зардал, төлбөрийг гаалийн үнээс хасч тооцно.

5.6.1.Үйлдвэрлэлийн хэрэгсэл, машин, тоног төхөөрөмж зэрэг бараг импортолсны дараа суурилуулсан, угсарсан, босгосон, засварласан болон техникийн туслалцаа үзүүлсэн, сургалт явуулсан төлбөр

5.6.2. Импортолсны дараахь тээврийн зардал

DDU (импортлогч орны заагдсан газар хүртэл гаалийн татвар төлөхгүйгээр хүргэх) буюу түүнтэй тестэй бараа нийлүүлэх нөхцөлөөр гэрээ хэлцэл тохирсон тохиолдолд импортолсны дараахь тээврийн зардлыг хэлцлийн үнээс хасч тооцно.

5.6.3. Импортлогч орны гаалийн болон бусад татвар

DDP (импортлогч орны заагдсан газар хүртэл бүх татвар, хураамж төлж хүргэх) буюу түүнтэй тестэй бараа нийлүүлэх нөхцөлөөр гэрээ хэлцэл тохирсон тохиолдолд импортолсны дараахь тээврийн зардал болон татвар хураамжийг хэлцлийн үнээс хасч тооцно.

Иймхүү 1 дүгээр аргын дагуу гаалийн үнийг дараахь томьёогоор тооцно:

ГҮ =ХҮ + (Т + К + Д + П + О) - Х

- ГҮ - гаалийн үнэ,

- ХҮ - хэлцлийн үнэ буюу импортын барааны төлсөн буюу төлбөл зохих үнэ,

- Т+К+Д+П+О - тээврийн зардал, комиссын шимтгэл гэх мэт энэхүү нэгдүгээр аргын 1-5-д дурдсан нэмэгдэх бүлэг зардал,

-Х – энэхүү аргын 6-д заасан хасагдах зардлын төмдэглэгээ.

Нэг ачилтанд багтаж хэд хэдэн нэр төрлийн бараа импортоор орж ирж байгаа тохиолдолд хэлцлийн үнэ дээр нэмэгдэх, хасагдах зардлыг бараа болгонд хуваарилахдаа нийт ачилтын цэвэр жин /өөрөөр хэлбэл нийт жингээс тээврийн хэрэгслийн жинг хассан дүн/-д тухайн нэрийн барааны ногдох жинг харьцуулан хуваарилна. Гэхдээ эвэхэн жингийн хуваарилалтаас гадна ээлхүүн, эсхүл үнийн дүнгийн хуваарилалтыг хэрэглэж болно.

5.7.Хэлцлийн үнийн аргыг дараахь нөхцөл, шаардлага бүрдсэн тохиолдолд хэрэглэхгүй. Үүнд:

5.7.1.Бараг ашиглах, захиран зарцуулах, худалдан борлуулахтай холбогдуулан худалдан авагчийн эрхийг дор дурдсанаас өөр ямар нэг байдлаар хязгаарласан тохиолдолд:

5.7.1.1.Монгол Улсын хууль тогтоомжоор болон төр засгийн эрх бүхий байгууллагаас хязгаарласан, эсхүл тийнхүү хязгаарлахыг шаардсан,

5.7.1.2.Импортын бараг цааш нь худалдан борлуулах газар зүйн бүсийг заасан,

5.7.1.3.Үнэлэх гэж буй импортын барааны үнэд мэдэгдэхүйц нөлөөлөхөөргүй хязгаарлалт тогтоосон.

Бараг ашиглах, захиран зарцуулах, худалдан борлуулах болон устгахтай холбоотой эрхийг хязгаарласан гэрээ хэлцэл (тухайлбал, консегнацийн гэрээ гэх мэт)-ийн тохиолдолд гаалийн үнэлгээний нэгдүгээр арга буюу хэлцлийн үнийн аргыг хэрэглэхгүй.

5.7.2. Үнэлж буй барааны арилжаа болон үнэ нь тухайн барааны үнийг тодорхойлох боломжгүй болгосон зарим нөхцөл болзол, шаардлагад захиргадсан тохиолдолд.

Үнэлж буй импортын бараатай холбогдуулан, түүний арилжаа болон үнэ нь зарим нөхцөл болзол, эсхүл саналд захиргадах бөгөөд үүний улмаас гаалийн үнийг тодорхойлох боломжгүй бол тухайн хэлцлийн үнийг хүлээн зөвшөөрөхгүй. Тухайлбал,

5.7.2.1. Худалдан авагчид тодорхой тоо хэмжээний өөр бараг нэмж худалдах болзол нөхцөлтэйгээр импортын барааны үнийг худалдагчийн талаас тогтоосон бол,

5.7.2.2. Үнэлэх гэж буй импортын барааны хэлцлийн үнэ нь худалдан авагчийн худалдагчид зөрүүлж зарсан барааны үнээс хамааралтай бол,

5.7.2.3. Бүрэн боловсруулалт хийсэн бүтээгдэхүүнээс тодорхой тоо хэмжээгээр худалдан авах нөхцөл болзолтойгоор хагас боловсруулсан бүтээгдэхүүн худалдахтай адил байдлаар, үнэлж буй импортын барааны хамааралгүй тусдаа төлбөр хийгдэхээр хэлцлийн үнийг тогтоосон бол.

ТАЙЛБАР: Гадаад худалдаанд, нэн ялангуяа хил орчмын худалдаанд дээрх арилжааны хэлбэрүүд элбэг тохиолдоно. Ялангуяа бараа солилцооны гэрээ хэлцэл болон түр боомтоор хил залгаа улс, орноос оруулж байгаа импортын барааны үнэ нь дээр дурдсан нөхцөл, болзол, шаардлагын нөлөөлөлд ихээхэн захиргдсан байдаг тул хэлцлийн үнийн аргыг хэрэглэхгүй.

5.7.3.Импортын бараг цааш нь худалдан борлуулсан, захиран зарцуулсан, ашигласнаас орох орлогоос худалдагчид ногдох хэсгийг тодорхойлох боломжгүй тохиолдолд;

5.7.4. Худалдагч, худалдан авагч хоёр хоорондоо хэлцлийн үнэд нөлөөлөхүйц харилцан хамааралтай тохиолдолд

Харилцан хамааралтай этгээдүүд гэдгийг Хэлэлцүүэрийн дагуу дараахь байдлаар тодорхойлно:

5.7.4.1. Бие биенийхээ аж ахуйн нэгжийн ажилтан буюу захирал байх;

5.7.4.2.Аж ахуйн үйл ажиллагаанд хамтран зүтгэгчид болох нь хуулиар хүлээн зөвшөөрөгдсөн;

5.7.4.3.Нэг нь ажил олгогч, нөгөө нь ажил гүйцэтгэгч байх;

5.7.4.4.Бие биенийхээ саналын эрхтэй хувьцаааны 5 буюу түүнээс дээш хувийг шууд буюу шууд бус хэлбэрээр өмчилдөг, хянадаг, эсхүл ээзэмшдэг;

5.7.4.5.Нэг нь нөгөөдөө шууд буюу шууд бус хэлбэрээр хяналт тавьдаг;

5.7.4.6.Хоёулаа гуравдагч этгээдийн шууд буюу шууд бус хяналтад байдаг;

5.7.4.7.Хамтдаа гуравдагч этгээдийг шууд буюу шууд бус байдлаар хянадаг;

5.7.4.8.Нэг гэр бүлийн гишүүд байх зэрэг багтана.

Хэрэв харилцан хамааралтай тохиолдолд хэлцлийн үнэ нь дор дурдсан шалгуур (тест) үнэтэй "тун ойролцоо" байвал хэлцлийн үнийн аргыг хэрэглэж болно. Үүнд:

-Монгол Улсад импортолсон нэг төрлийн буюу ижил төрлийн барааны харилцан хамааралгүй хэлцлийн үнэ;

-Гаалийн үнэлгээний хоёр, гуравдугаар аргуудаар тодорхойлсон нэг төрлийн буюу ижил төрлийн барааны гаалийн байгууллагаас урьд нь хүлээн зөвшөөрсөн гаалийн үнэ.

Харин дээр дурдсан шалгуур (тест) үнэтэй харьцуулалт хийхдээ арилжааны шат дамжлага буюу түвшин, барааны тоо хэмжээ, Хэлэлцээрийн 8 дугаар зүйлд заасан залруулан тодотгох элементүүд, мөн түүнчлэн харилцан хамааралгүй худалдагч, худалдан авагчтай хийсэн худалдаанд байвал зохих худалдагч хариуцах ёстой төлөөгүй зардлуудыг тооцон үзнэ.

"Тун ойролцоо" гэдэгт импортын барааны төрх байдал, үйлдвэрлэлийн онцлог, тухайн бараг импортоор оруулж байгаа улирал, үнийн зөрүү зэрэг үзүүлэлтийг багтаан авч үзнэ.

5.7.5. Мэдүүлэгч гаалийн үнийг тодорхойлходоо ашиглаасан мэдээлэл, тооцоогоо лавтай үнэн зөв болохыг гадаад худалдааны болон санхүү, нягтлан бодох бүртгэлийн холбогдох баримт бичгээр баталгаажуулж нотлоогүй зэрэг тохиолдолд хэлцлийн үнийн аргыг хэрэглэхгүй.

ХОЁР БОЛОН ГУРАВДУГААР АРГА. НЭГ ТӨРЛИЙН БОЛОН ИЖИЛ ТӨРЛИЙН БАРААНЫ ХЭЛЦЛИЙН ҮНИЙН АРГА

6. Импортын барааны гаалийн үнийг нэгдүгээр аргаар тодорхойлох боломжгүй бол гаалийн үнийг нь тодорхойлж буй бараатай нэгэн зэрэг буюу ойролцоо хугацаанд худалдан авч импортоор оруулсан нэг төрлийн болон ижил төрлийн барааны хэлцлийн үнээр тодорхойлно. Ойролцоо хугацаа гэдэгт үнэлгэдэж буй импортын барааны гаалийн бүртгүүлэлт хийгдсэн өдрөөс өмнөх 90 хоногийн хугацааг хамруулна.

7. Гаалийн үнэлгээний хоёр болон гуравдугаар аргын дагуу хэлцлийн үнийг тодорхойлходоо худалдааны эдийн түвшин (шүүд үйлдвэрээс, бөөний болон жижиглэнгийн худалдаа гэх мэт)-д байгаа, ойролцоо тоо хэмжээнд импортлогдсон нэг болон ижил төрлийн барааны хэлцлийн үнийг үндэслэнэ.

8. Нэг төрлийн болон ижил төрлийн импортын барааны хэлцлийн үнэ гэдэг нь гаалийн байгууллагад хүлээн зөвшөөрөгдсон Хэлэлцээрийн 1 дүгээр зүйл болон 8 дугаар зүйлийн дагуу тодотгол хийгдсэн гаалийн үнэ байна. Гэхдээ Хэлэлцээрийн 8 дугаар зүйлийн 2-т заасан тээвэрлэхтэй холбогдон гарах зардлыг тээвэрлэх зай, тээвэрийн хэрэгслийн төрлөөс хамаарч даран залруулга тодотгол хийнэ.

Тухайлбал, хэрэв үнэлэх гэж буй бараа төмөр замаар импортлогдсон, харин харьцуулж буй нэг төрлийн болон ижил төрлийн барааны хэлцлийн үнийг агаарын тээвэрээр урьд нь тодорхойлсон бол энэ үнээс агаарын тээвэрийн зардлыг хасч, төмөр замын тээвэрийн зардлыг нэмж гаалийн үнэ тогтоно. Энэ байдлаар тээвэрийн зайнаас хамаарсан залруулга тодотгол хийнэ.

9. Эдгээр залруулга тодотгол нь үндэслэлтэй, үнэн зөв болохыг зохих нотлох бичиг баримтаар баталгаажуулна. Хэрэв ийм нотлох, баталгаажуулах бичиг баримт байхгүй, эсхүл залруулга тодотгол хийгдэх боломжгүй бол гаалийн үнэлгээний хоёр болон гуравдугаар аргаар гаалийн үнэ тодорхойлохгүй.

10. "Нэг төрлийн бараа" гэж физик шинж чанар, нэр хүнд зэрэг бүх үзүүлэлтээр адил бараг ойлгоно. Энэхүү тодорхойлолтод тохирч байгаа бараа гадаад байдлаараа ялимгүй ялгаатай байх нь түүнийг нэг төрлийн гэж үзэхэд саад болохгүй.

11. "Ижил төрлийн бараа" гэж бүх үзүүлэлтээр ижил биш боловч ижил зориулалтаар ашиглаж болох, арилжааны хувьд харилцан бие биенээ орлож чадах, үндсэн шинж байдал, бүрдэл хэсэг нь ижил бараг ойлгоно. Тухайн барааны чанар, нэр хүнд, худалдааны тэмдэг нь бараг ижил төрлийн болохыг тогтоохын тулд харгалзаж үзэх хүчин зүйлсийн тоонд орно.

12. Нэг төрлийн болон ижил төрлийн бараа гэдэг ойлголтод "физик шинж" гэдгийг тухайн барааны бодит шинж байдал гэж үзнэ. Бодит шинж байдалд:

- хэмжээ, хэлбэр
- техникийн болон бусад шинж чанар
- бэлтгэсэн болон үйлдвэрлэсэн арга зэрэг үзүүлэлтийг хамруулна.

ДӨРӨВДҮГЭЭР АРГА. ЯЛГАВАР ҮНИЙН АРГА

13. Нэг, хоёр болон гуравдугаар аргуудаар гаалийн үнэ тогтоох боломжгүй бол энэ арга руу шилжинэ. Үнэлэх гэж буй импортын бараа, эсхүл түүнтэй нэг болон ижил төрлийн бараг Монгол Улсад худалдан борлуулсан байвал энэ аргыг

хэрэглэнэ.

14. Импортын барааны гаалийн үнийг энэ аргаар тодорхойлохдоо импортын бараа, эсхүл түүнтэй нэг болон ижил төрлийн бараанд импортлох үед буюу ойролцоо хугацаанд (90 хоногоос хэтрэхгүй) харилцан хамааралгүй этгээдэд хамгийн их тоо хэмжээгээр худалдан борлуулсан нэгжийн үнийг суурь болгон авч дараахь зардлуудыг хасна:

14.1. Төлсөн буюу төлбөл зохих комиссын ердийн шимтгэл болон адил ангилал бүлгийн бараг Монгол Улсад худалдан борлуулахтай холбогдон гарсан ерөнхий зардал болон ашиг;

Суурь үнийг сонгох жишээ:

Д/Д	Худалдсан хэмжээ	Нэгж үнэ (валютын нэгж)	Худалдааны түвшин	Тухайн үнээр зарсан тоо
1.	1-10 нэгж	100	3 нэгжээр 5 удаа 10 нэгжээр 5 удаа	65
2.	11-25 нэгж	95	11 нэгжээр 5 удаа	55
3.	25-аас их	90	80 нэгжээр 1 удаа	80

Энэ жишээнд хамгийн их тоо хэмжээгээр худалдагдсан бараа нь 80 бөгөөд үнэ нь 90 валютын нэгж байна. Иймд 90 валютын нэгж нь ялгавар үнийн аргын үнэлгээний суурь болно.

Хэрвээ өөр өөр үнээр ижил тоо хэмжээгээр борлогдсон бол хамгийн бага үнийг суурь болгон сонгоно.

15. Импортын барааны үнэ тогтоох үед түүнтэй нэг болон ижил төрлийн бараг өөрчлөлт оруулалгүйгээр дотоодод борлуулсан тохиолдол байхгүй бол мэдүүлэгчийн хүсэлтээр боловсруулалт хийсний дараахь үнийг ашиглана. Гэхдээ боловсруулалт хийсний дараахь үнийг дараахь тохиолдолд хэрэглэхгүй:

15.1. Импортоор оруулсан нэг төрлийн болон ижил төрлийн бараа нь өөрийн урьдах шинж чанараа боловсруулалтын явцад алдсан.

15.2. Урьдах шинж чанараа алдаагүй боловч боловсруулалтын дараахь эцсийн бүтээгдэхүүнд үнийн нөлөөлөл бага бол. Жишээ нь: дээлийн товч нь дээлний үнэд бага нөлөөлөлтэй тул товчны үнээр дээлийн үнийг тодорхойлох боломжгүй болно.

16. Мэдүүлэгчийн хүсэлтээр дөрөв болон тавдугаар аргын аль нэгийг сонгож болно.

Хэлэлцээрт зааснаар адил ангилал бүлгийн бараа гэдэгт тодорхой нэг үйлдвэрийн газар, үйлдвэрлэлийн салбарын хүрээнд багтан үйлдвэрлэгдсэн бүлэг бараг хамруулан авч үзнэ.

14.2. Монгол Улсын нутаг дэвсгэрт гарсан тээврийн, даатгалын болон бусад ердийн нэмэгдсэн зардлууд;

14.3. Тухайн бараг импортлох, худалдан борлуулахтай холбогдуулан Монгол Улсад төлөгдсөн гаалийн татвар болон бусад албан татварууд.

ТАВДУГААР АРГА. НИЙЛБЭР ҮНИЙН АРГА

17. Үнэлгээний дараагийн арга нь нийлбэр үнийн арга болно. Нийлбэр үнэ нь дараахь үнэ, ертөг, зардлын нийлбэрээс бүрдэнэ:

17.1. Үнэлэх гэж байгаа тухайн импортын бараг үйлдвэрлэхэд зарцуулсан материал, үйлдвэрлэлийн болон бусад боловсруулалтын үйл ажиллагааны зардал буюу ертөг;

17.2. Үнийг нь тодорхойлж буй бараатай адил төрөл бүлгийн барааны арилжаанд тусгагдаг бөгөөд тухайн бараг Монгол Улсад экспортлоход үйлдвэрлэгчээс гаргасан ерөнхий зардал болон ашгийн хэмжээ;

17.3. Монгол Улсын гадна буй болсон тээвэрлэлтийн үйл ажиллагааны зардал болон даатгалын шимтгэл.

ЗУРГААДУГААР АРГА. УЯЛДУУЛАН ХЭРЭГЛЭХ АРГА

18. Энэ арга нь гаалийн үнэлгээний сүүлчийн арга бөгөөд тогтоох гэж буй гаалийн үнэ нь аль болох урьд нь тогтоосон гаалийн үнэ дээр үндэслэх ёстой. Уялдуулан хэрэглэх аргыг хоёр

үндсэн арга замаар хэрэгжүүлнэ. Үүнд:

19. Нэгдүгээр арга замаар гаалийн үнэлгээний эхний 5 аргад заасан шаардлага, нөхцөлүүдийг багасгах, бууруулах, зөөлрүүлэх байдлаар хэрэглэнэ.

Нэгдүгээр арга: Мэдүүлэгчийн гаргасан зарим үнэ, зардлын бүрэлдэхүүн хэсгүүдынь баримт бичгээр нотлогдоогүй тохиолдолд гаалийн байгууллага болон бусад импортлогч нарт байгаа адил төстэй баталгаатай мэдээллийг ашиглах, мөн түүнчлэн бусад зардлуудтай харьцуулах байдлаар гаалийн үнийг тооцоолон гаргаж болно.

Хоёр болон гуравдугаар арга: Харьцуулах хугацаа 90 бус түүнээс дээш 6 сар, нэг болон хоёр жилийн хугацаагаар хамруулна. Бараанд тавих шаардлагыг зөөлрүүлэх буюу үйлдвэрлэгч, гарал үүсэлд тавих нөхцөлийг багасгаж болно.

Дөрөвдүгээр арга: Дотоодод борлуулсан хугацааны хязгаарыг ихэсгэж болно. Суурь үнийн сонголтыг зөөлрүүлнэ. Мөн боловсруулалт хийсний дараахь бага зэргийн өөрчлөлтийг хэрэгсэхгүй, эсхүл тооцоолж гаргаж болно. Хэрэв дотоод зах зээлд борлогдсон нэг болон ижил төрлийн бараа байхгүй бол адил төрөл бүлгийн барааг хамруулан авч үзнэ.

Тавдугаар арга: Материалын үнэ болон өртгийг өөр ижил төстэй барааны үнэ, өртөг дээр тулгуурлан авч үзэж болно. Хил хүртэл тээвэрлэсэн зардлыг бусад барааны зардалтай харьцуулах байдлаар тогтоож болно.

20. Хоёрдугаар арга замаар олон улсын худалдааны практик болон тухайн үеийн арилжааны бусад мэдээллэл дээр тулгуурлан тогтооно.

Энэ арга замаар гаалийн үнэ тогтоохдоо дараахь худалдааны мэдээлэл баримтыг ашиглана. Үүнд:

20.1. Худалдагчийн үнийн жагсаалт (price list), үнийн лавлагаа болон прейскурант, каталог;

20.2. Статистикийн мэдээлэл, нийтээр хэрэглэж буй зардлын тариф, комиссын шимтгэл;

20.3. Экспортлогчийн үнийн санал, дэлхийн томоохон барааны төрөлжсөн биржийн мэдээлэл, төрөлжсөн сонин хэвлэлийн мэдээлэл, томоохон импортлогчдын гэрээ, түүний үнэ;

20.4. Интернетээр нийтэд зориулан тараасан экспортын үнэ, худалдааны талаархи мэдээлэл;

20.5. Хил залгаа улс орны Монгол Улсад экспортоор гаргаж байгаа барааны үнийн судалгаа;

20.6. Гаальд мэдүүлж байгаа барааны тухайн цаг үед бий болсон үнийн дундаж үзүүлэлт зэрэг болно.

21. Энэхүү уялдуулан хэрэглэх аргаар гаалийн үнийг тодорхойлохдоо дараахь үнийг үндэслэж болохгүй. Үүнд:

21.1. Монгол Улсад үйлдвэрлэсэн бараг дотоодын зах зээлд худалдан борлуулсан үнэ;

21.2. Хоёр альтернатив үнээс өндөр үнийг нь гаалийн зорилгоор сонгох систем;

21.3. Экспортлогч орны дотоодын зах зээлийн үнэ (хил орчмын импортын барааны үнээс бусад);

21.4.Нэг болон ижил төрлийн барааны нийлбэр үнийг тодорхойлохоос бусад тохиолдолд гарсан үйлдвэрлэлийн зардал;

21.5.Монгол Улсаас өөр оронд экспортолсон барааны үнэ. Гэхдээ нийтэд зориулсан экспортын үнийн мэдээллэл хамаарахгүй;

21.6. Гаалийн доод үнэ;

21.7. Хийсвэр буюу зохиомол үнэ.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 20 (207)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *Хувийн хамгаалалтын тухай хуулийн төсөл буцаах тухай*
- *Нийслэлийн өмчлөлд эд хөрөнгө шилжүүлэх тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Дархлаажуулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай*
- *Санхүү, эдийн засгийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх, тус яамны бүтцийг шинэчлэн батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2001 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2001 оны тавдугаар сарын 25 №20 (207)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

245. Хувийн хамгаалалтын тухай хуулийн төсөл буцаах тухай Дугаар 37 542
246. Нийслэлийн өмчлөлд эд хөрөнгө шилжүүлэх тухай Дугаар 42 542

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

247. Зөвлөлийн бүрэлдэхүүнд нэмэлт оруулах тухай Дугаар 91 542
248. Зарим шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийг чөлөөлөх тухай Дугаар 92 542
249. Зарим шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийг томилох тухай Дугаар 93 543
250. Ц.Рашээвэгийг шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай Дугаар 94 543
251. Шүүгчийн албан тушаалаас огцруулах тухай Дугаар 95 543
252. Шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай Дугаар 96 543
253. Элчин сайдыг томилох тухай Дугаар 100 544
254. Элчин сайдыг томилох тухай Дугаар 101 544
255. Элчин сайдыг томилох тухай Дугаар 102 544
256. Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай Дугаар 117 544
257. Ой тэмдэглэх тухай Дугаар 118 545

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

258. Дүрэм батлах тухай Дугаар 64 545
259. Тогтоолд нэмэлт оруулах тухай Дугаар 65 549
260. Мөнгөн төлбөрийн хэмжээг тогтоох тухай Дугаар 66 549
261. Дархлаажуулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай Дугаар 67 549
262. Комисс байгуулах тухай Дугаар 68 553
263. Утаа багатай, түлшний хэмнэлттэй зуухны үйлдвэрлэлийг дэмжих тухай Дугаар 70 554
264. Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаны дүрэм, зохион байгуулалтын бүтцийг батлах тухай Дугаар 71 555
265. Журам батлах тухай Дугаар 72 559
266. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай Дугаар 73 562
267. Зөвлөл байгуулах тухай Дугаар 74 563
268. Санхүү, эдийн засгийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх, тус яамны бүтцийг шинэчлэн батлах тухай Дугаар 75 563
269. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүний тухай Дугаар 76 571

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр | **Дугаар 37** | **Улаанбаатар хот**

Хувийн хамгаалалын тухай хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 40 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Засгийн газраас өргөн мэдүүлсэн Хувийн хамгаалалтын тухай хуулийн төсөлд бие хамгаалагч галт зэвсэг хэрэглэхээр заасан хуулийн үзэл баримтлалыг Улсын Их Хурал зөвшөөрөөгүй тул төслийг хууль санаачлагчид нь буцаасугай.

ДЭД ДАРГА **Ж.БЯМБАДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 4 дүгээр сарын 26-ны өдөр | **Дугаар 42** | **Улаанбаатар хот**

Нийслэлийн өмчлөлд эд хөрөнгө шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Төрийн өмчлөлд байгаа, Нийслэлийн Баянзүрх дүүргийн 19 дүгээр хорооны нутаг дэвсгэр /Шархад/-т байрлалтай эмнэлгийн байр, штабын байр, цэргийн казарм /хуучин орос цэргийн хотхоны барилгууд/-ыг Төрийн өмчийн хороо, Хөдөө аж ахуйн их сургууль, Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг даргын саналыг үндэслэн Нийслэлийн өмчлөлд шилжүүлсүгэй.

ДЭД ДАРГА **Ж.БЯМБАДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 5 дугаар сарын 04-ний өдөр | **Дугаар 91** | **Улаанбаатар хот**

Зөвлөлийн бүрэлдэхүүнд нэмэлт оруулах тухай

"Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай" Монгол Улсын хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг бариmтлан, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн даргын саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

дүгээр хавсралтаар батлсан "Монгол Улсад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн бүрэлдэхүүн"-д "Эрүүл мэндийн дэд сайд" гэж нэмсүгэй.

Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2001 оны 2 дугаар сарын 13-ны өдрийн 25 дугаар зарлигийн 1

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 5 дугаар сарын 04-ний өдөр | **Дугаар 92** | **Улаанбаатар хот**

Зарим шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийг чөлөөлөх тухай

Монгол Улсын "Шүүхийн тухай" хуулийн 51 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1, 2 дахь заалтуудыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн, Дамдинсүрэнгийн Гансүхийг Сүхбаатар аймгийн шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

Төрийн өөр ажил, албан тушаалд томилогдох болсонтой холбогдуулан Дэлгэрэхийн Цэвээнцэрэнг Нийслэлийн Баянзүрх дүүргийн

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 5 дугаар сарын 04-ний өдөр **Дугаар 93** **Улаанбаатар хот**

Зарим шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэг, "Шүүхийн тухай" хуулийн 6 дугаар зүйлийн 2, 4 дэх хэсгийг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Дэлгэрэхийн Цэвээнцэрэнг Нийслэлийн шүүхийн шүүгчийн, Дамдинсүрэнгийн Гансүхийг Төв аймгийн шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 5 дугаар сарын 04-ний өдөр **Дугаар 94** **Улаанбаатар хот**

Ц. Рашзэвэгийг шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын "Шүүхийн тухай" хуулийн 51 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалтыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Цэрэндоржийн Рашзэвэгийг Төв аймгийн шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 5 дугаар сарын 04-ний өдөр **Дугаар 95** **Улаанбаатар хот**

Шүүгчийн албан тушаалаас огцруулах тухай

Монгол Улсын "Шүүхийн тухай" хуулийн 52 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1,2 дахь заалтуудыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Монгол Улсын Эрүүгийн байцаан шийтгэх хууль болон шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг ноцтой зөрчсөн Цэцэгтийн Төмөрцэцэгийг Дархан-Уул аймгийн сум дундын шүүхийн шүүгчийн, Цэрэндоржийн Үнэнбатыг Булган аймгийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус огцруулсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 5 дугаар сарын 04-ний өдөр **Дугаар 96** **Улаанбаатар хот**

Шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай

Монгол Улсын "Шүүхийн тухай" хуулийн 63 дугаар зүйлийн 5 дахь заалтыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Дорноговь аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгч, ерөнхий шүүгч Т. Баясгаланг эрүүгийн хэрэгт сэжигтнээр татаж шалгах зөвшөөрөл олгож, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагаас зохих шийдвэр гарах хүртэл шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 5 дугаар сарын 10-ны өдөр **Дугаар 100** **Улаанбаатар хот**

Элчин сайдыг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Латви Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дашдаваагийн Чулуундоржийг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 5 дугаар сарын 10-ны өдөр **Дугаар 101** **Улаанбаатар хот**

Элчин сайдыг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Эстони Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дашдаваагийн Чулуундоржийг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 5 дугаар сарын 10-ны өдөр **Дугаар 102** **Улаанбаатар хот**

Элчин сайдыг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

Монгол Улсаас Бүгд Найрамдах Литва Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Дашдаваагийн Чулуундоржийг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 5 дугаар сарын 11-ний өдөр **Дугаар 117** **Улаанбаатар хот**

Элчин сайдыг эгүүлэн татах, томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, Ерөнхийлөгчийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Дипломат албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг баримтлан ЗАРЛИГ болгох нь:

1. Монгол Улсаас Канад Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Жалбуугийн Чойнхорыг эгүүлэн татсугай.

2. Монгол Улсаас Канад Улсад суух Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайдаар Галсангийн Батсүхийг томилсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 5 дугаар сарын 11-ний өдөр Дугаар 118 **Улаанбаатар хот**

Ой тэмдэглэх тухай

Монголын төр ёсны олон мянган жилийн түүхнээ тохиосон онцгой учир холбогдолтой үйл хэргийн нэг бол 1206 онд монгол туургатны Их Хуралдай чуулж, Есүхэйн Тэмүүжинг Чингис Далай хаанаар ёслол төгөлдөр ергэмжлөн, нэгдсэн улсын эзнээр залж, Их Монгол Улсыг байгуулсан явдал билээ.

Их Монгол Улсыг байгуулан төрийн бэлгэдэл ёслол, бичиг соёл, хууль цаазыг шинээр үүсгэн баринтаглаж, монгол угсаатныг нэгдмэл хүчирхэг үндэстэн болгон төлөвшүүлэх улмаар ертөнц дахинаа Монгол улсыг мандуулсан түүхэн дэвшилтэт үйл хэргийг бүтээсэнд дэлхийн түүхийн хөөрдахь мянганы Их хүнээр тодорсон Чингис хааны гавьяа оршино.

Эдүгээ шинэ мянганы эхэнд дэлхий дахинаа даяаршлын их давалгаа өрнөн буй үед Монгол үндэстний бахархалт хүн-Их Эзэн Чингисийн нэр алдар, төр улсын түүхэн төр үйлсийг тэмдэглэлт ойгоор дурсах нь хүн ардынхаа үндэсний ухамсар сэтгэлгээг дээшлүүлэх, олон түмнийхээ эв эеийг бататгаж, идэвх чармайлтыг өрнүүлэх, улс орноо өөдлөн дэвжээх, тусгаар тогтолоо баталгаажуулах, монгол төрийг бэхжүүлэхэд чухал ач холбогдолтой тул энэхүү нийгмийн захиалга, нийт олныхоо хүсэл зоригийг илэрхийлэн ЗАРЛИГ буулгах нь:

1. Чингис Хаан-Тэмүүжиний мэндэлсний 840 жилийн ойг 2002 онд, Их Монгол Улс байгуулагдсаны 800 жилийн ойг 2006 онд Монгол Улс даяар төр ёсны их баяр болгон тус тус ёслон тэмдэглэсүгэй.
2. Эдгээр түүхт ойг үгтаж тусгай хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэх, ойг тэмдэглэх ажлыг удирдан зохион байгуулах Үндэсний хороог байгуулан ажиллахыг Засгийн газар /Ерөнхий сайд Н. Энхбаяр/-т чиглэл болгосугай.
3. Их ойг үгтаж хэрэгжүүлэх Тусгай хөтөлберийн агуулгад:

а.Чингис хааны дурсгалын болон онгон шүтээний ёслол хүндэтгэлийн цогцолбор барьж байгуулах;

б.Их Монгол Улсын түүх болон Чингис судлалыг идэвхжүүлэх, олон улсын эрдэм шинжилгээний хурал, семинар, судалгаа шинжилгээний аялал, экспедици зохион байгуулах;

в. Музейн үзвэр, фондыг сэргээн баяжуулж, өргөтгөх, дотоод гадаадад үзэсгэлэн гаргах;

г. Их Монгол Улс, Чингис хааны тухай кино бүтээх, урлаг, уран сайхны бусад олон төрлийн бүтээл туурвих санаачилгыг дэмжих;

д. Дэлхийн монголчуудын түүх, соёл, урлаг спорт, бизнес ажил хэргийн холбоо харилцааг өргөжүүлэх;

е. Чингис хааны одон буй болгох, нэрэмжит болгох зэрэг арга хэмжээг багтаан оруулах нь зүйтэй гэж үзсүгэй.

4. Шинэ зуун, шинэ мянганы эхэнд тохиож буй үндэсний түүхийн нэгэн бахархалт үеийн тэмдэглэлт Их ойнуудыг үгтаж санаачлан сэдэх, бүтээн туурвих, ахих дэвжихийн идэвхи гаргаж эдийн засаг, соёлын их бүтээн байгуулалтын бүх нийтийн ариун үйлс өрнүүлэн ажиллахыг Монголын ард иргэд, аймаг сум, албан байгууллага, хамт олон бүрт уриалсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 3 дугаар сарын 28-ны өдөр Дугаар 64 **Улаанбаатар хот**

Дүрэм батлах тухай

Иргэний нисэхийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Иргэний нисэхийн ерөнхий газрын дүрэм"-ийг хавсралт ёсоор батална.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Дүрэм батлах тухай" Засгийн газрын 1999 оны 4 дүгээр сарын 14-ний өдрийн 56 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ДЭД БҮТЦИЙН САЙД **Б.ЖИГЖИД**

Засгийн газрын 2001 оны 64 дүгээр тогтоолын хавсралт

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Иргэний нисэхийн ерөнхий газар (цаашид Ерөнхий газар гэх) нь иргэний нисэх, түүний дэд бүтцийг хөгжүүлэх талаархи Засгийн газрын бодлого, үйл ажиллагааны хөтөлбөр, олон улсын иргэний нисэхийн байгууллагын стандарт, зөвлөмжийг хэрэгжүүлэх үүрэг бүхий Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг мөн.

2. Ерөнхий газрын үйл ажиллагааны үндсэн зорилго нь иргэний нисэхийн болон нислэгийн аюулгүй байдлын хяналтыг хэрэгжүүлэх, нислэгийн хөдөлгөөн, нисэх буудлын үйлчилгээг удирдлага, зохион байгуулалтаар хангахад оршино.

3. Ерөнхий газар нь үйл ажиллагаандаа Иргэний нисэхийн тухай хууль, бусад хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээ болон энэ дүрмийг удирдлага болгоно.

4. Ерөнхий газар нь иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний эрхлэх ажлын хүрээнд үйл ажиллагаа явуулж, түүний өмнө ажлаа хариуцна.

5. Ерөнхий газар нь тогтоосон журмын дагуу үйлдсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

6. Ерөнхий газар нь билэгдэлтэй байх бөгөөд түүний загвар, хэрэглэх журмыг иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

Хоёр. Ерөнхий газрын бүрэн эрх

7. Ерөнхий газар нь Иргэний нисэхийн тухай хуулиар олгогдсон болон дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

а/Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг хангах;

б/иргэний нисэхийн талаархи Монгол Улсын олон улсын гэрээ, хэлэлцээрийн хэрэгжилтийг зохион байгуулах, олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах;

в/агаарын харилцааны тухай болон иргэний нисэхийн салбарт хамаарах олон улсын гэрээнийт төслийг Засгийн газраас өгсөн чиг үүргийн дагуу боловсруулах;

г/Монгол Улсад бүртгэлтэй агаарын хөлөгт тус улсын нутаг дэвсгэрт болон хилийн гадна нислэг-техникийн хэрэг тохиолдсон нөхцөлд түүнийг шалгахад оролцох;

д/нислэг-техникийн хэрэг гарахаас урьдчилан сэргийлэх, нисэхийн болон нислэгийн аюулгүй байдлыг хангуулах зорилгоор хяналт, шалгалт зохион байгуулах;

е/иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох;

ж/Монгол Улсын нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа дотоодын болон гадаадын агаарын хөлөгт нислэгийн аюулгүй байдлын шалгалт хийх;

з/Монгол Улсын агаарын зайд агаарын хөлгийн нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ, холбоо, навигацийн хангалт, нисэх буудлын үйлчилгээг нислэгийн аюулгүй байдлыг хангах түвшинд явуулах;

и/өмчийн бүх хэлбэрийн агаарын тээврийн байгууллагын бүтцэд мэргэжлийн хяналт тавих, шаардлагатай гэж үзвэл бүтцийг өөрчлөх, төрийн өмчийн болон төрийн өмчийн оролцоотой байгууллагын удирдах албан тушаалтны талаар санал, дүгнэлт гаргах;

к/улсын агаарын хөлгийн нислэгийн хөдөлгөөний үйлчилгээг гүйцэтгэх, агаарын зайн хяналтыг боловсронгуй болгох талаар Зэвсэгт хүчний ерөнхий штаб болон бусад байгууллагуудтай хамтран ажиллах;

л/нисэх буудлын болон агаарын навигацийн үйлчилгээний үнэлгээг олон улсад дагаж мөрдөж байгаа жишигт нийцүүлэх, шаардлагатай бусад үйлчилгээний үнэлгээг тогтоох, батлах;

м/иргэний нисэхийн салбарт хөрөнгө

оруулах нөхцөл боломжийг бүрдүүлж, хөрөнгө оруулагчийг дэмжих, иргэний нисэхийн салбарын нисэхийн бүс нийтлэг үйлчилгээг гэрээт үйлчилгээнд шилжүүлэх зохицуулалтыг хийх;

н/иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхлэх өмчийн бүх хэлбэрийн байгууллагуудад мэргэжлийн туслалцаа үзүүлэх, тэдгээрийг мэргэжлийн сургалтад хамрагдах боломж олгох.

Гурав. Ерөнхий газрын бүтэц, үйл ажиллагааны зохион байгуулалт

8. Ерөнхий газар нь бүрэн эрхээ хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ нийцсэн, нисэхийн болон нислэгийн аюулгүй байдлыг хангуулах, хяналт тавихад чиглэсэн тогтолцоо бүхий бүтэцтэй байна.

9.Ерөнхий газрын зохион байгуулалтын бүтцийг иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

10. Ерөнхий газрын дарга нь дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

а/Ерөнхий газрын зорилт, чиг үүргийг ханган биелүүлэх ажлыг хариуцах;

б/Засгийн газар, иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, олон улсын иргэний нисэхийн байгууллагыг тухайн салбарын талаарх мэдээллээр хангах, иргэний нисэхийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагаас статистикийн болон шаардлагатай бусад мэдээллийг гаргуулж авах;

в/Иргэний нисэхийн тухай хуульд заасны дагуу иргэний нисэхийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас шилжүүлсэн эрхийг хэрэгжүүлэх, нислэгийн аюулгүй байдалд хамаарах бүрэн эрхийнхээ тодорхой хэсгийг ажилтан, томилогдсон байцаагч нарт шилжүүлэн гүйцэтгүүлэх;

г/нислэгийн аюулгүй байдал хариуцсан байцаагчийн баталгаажуулах тусгай тэмдгийн загварыг батлах;

д/Ерөнхий газрыг гадаад, дотоодод төлөөлөх, бусад байгууллагуудтай харьцах;

е/Ерөнхий газрын харьяа байгууллага, албаны бүтэц, зохион байгуулалт, орон тоо, цалингийн санг батлах, удирдлагыг мэргэжлийн чиглэлийн дагуу томилж, чөлөөлөх;

ж/хууль тогтоомжид нийцүүлэн бүрэн эрхийнхээ хүрээнд тушаал гаргаж, биелэлтийг хангуулах, иргэд, хуулийн этгээдийн өргөдөл, гомдлыг шийдвэрлэх;

з/батлагдсан төсвийг захиран зарцуулах;

и/шаардлагатай бол дүгнэлт гаргах, магадлан шинжилгээ хийлгэх зэрэг тодорхой асуудлыг шийдвэрлэх зорилгоор гадаад, дотоодын шинжээч, мэргэжилтэн болон бусад ажилтныг гэрээний үндсэн дээр татан оролцуулах, тэдгээрт цалин, урамшуулал олгох асуудлыг шийдвэрлэх;

к/Монгол Улсын агаарын зайд хууль бусаар нэвтэрсэн агаарын хөлөгтэй холбоотой асуудлыг шийдвэрлэхэд оролцох;

л/хууль тогтоомжоор олгогдсон бусад бүрэн эрх.

11. Ерөнхий газрын бодлогын хэрэгжилт, хамтын ажиллагаа, санхүү хариуцсан бүтцийн нэгж нь дараахь асуудлыг хэрэгжүүлнэ:

а/Ерөнхий газрын төсөв, хөрөнгө, санхүүгийн бүртгэл хөтлөх, тайлан гаргах;

б/Ерөнхий газрын гадаад харилцаа, олон улсын хамтын ажиллагааны асуудлыг зохицуулан зохион байгуулах;

в/иргэний нисэхийн салбарын хөгжлийн стратегийн төлөвлөлтийн талаар санал боловсруулах, бодлогыг хэрэгжүүлэх;

г/иргэний нисэхийн салбарын мэдээллийн сан бий болгож ашиглах;

д/хүний нөөц, ажилтнуудын нийгмийн асуудлыг шийдвэрлэх;

е/нисэхийн мэргэжлийн давтан сургалт зохион байгуулах.

12. Ерөнхий газрын аюулгүй байдлын хяналт, зохицуулалт хариуцсан бүтцийн нэгж нь дараахь асуудлыг хэрэгжүүлнэ:

а/иргэний агаарын хөлгийг улсын бүртгэлд бүртгэх, бүртгэлийн гэрчилгээ олгох;

б/агаарын хөлгийг Монгол Улсад бүтээх, түүнд өөрчлөлт, сайжруулалт хийх зөвшөөрөл олгох;

в/нисэхийн мэргэжлийн

ажилтнуудаас шалгалт авах, мэргэжлийн үнэмлэх олгох;

г/агаарын тээврийн байгууллагад гэрчилгээ олгож, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

д/агаарын навигацид холбогдолтой үйлчилгээ эрхлэх эвшээрэл олгох, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

е/нисэх буудалд гэрчилгээ олгож, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

ж/нисэхийн аюулгүй байдлыг хангах байгууллагад гэрчилгээ олгож, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

з/сургалт, засвар үйлчилгээ, ханган нийлүүлэлт эрхлэх байгууллагад гэрчилгээ олгож, үйл ажиллагаанд нь хяналт тавих;

и/иргэний нисэхэд дагаж мөрдөх стандарт, заавар, эвлөмж боловсруулах;

к/нислэгийн аюулгүй байдлын холбогдолтой эрх зүйн актыг сурталчлах, сургалт явуулах.

13. Ерөнхий газрын нислэгийн хөдөлгөөний үйлчилгээ хариуцсан бүтцийн нэгж нь дараахь асуудлыг хэрэгжүүлнэ:

а/нислэгийн хөдөлгөөний төлөвлөлт, удирдлагын үйлчилгээ;

б/холбоо, агаарын навигацийн үйлчилгээ;

в/аэронавигацийн мэдээллийн үйлчилгээ;

г/эрэн хайх, авран туслах үйлчилгээ;

д/иргэний нисэхийг цаг уурын мэдээгээр хангах үйлчилгээ.

14. Ерөнхий газрын нисэх буудлын үйлчилгээ хариуцсан бүтцийн нэгж нь дараахь асуудлыг хэрэгжүүлнэ:

а/нисэх буудлын ерөнхий төлөвлөлт, үйл ажиллагааны технологийг тодорхойлж боловсронгуй болгох;

б/нисэх буудлын үйл ажиллагаатай холбоотой барилга байгууламж, инженерийн шугам сүлжээ барих, байгуулах, засварлах, ашиглах;

в/олон улсын нисэх буудлын үйлчилгээ;

г/орон нутгийн нисэх буудлын үйлчилгээ;

д/аэродромын болон агаарын хөлгийн газрын үйлчилгээний тоног төхөөрөмж, машин механизмын үйлчилгээ.

15. Ерөнхий газрын даргын дэргэд түүнд зөвлөх үүрэгтэй даргын зөвлөл ажиллана.

16. Ерөнхий газрын үйл ажиллагааны онцлогоос хамаарч нислэгийн аюулгүй байдал, салбарын болон техникийн бодлогын асуудал, үйл ажиллагааны чиглэлээр зөвлөмж, санал, дүгнэлт гаргах үүрэгтэй мэргэжлийн зөвлөлүүдийг байгуулан ажиллуулж болно. Зөвлөлүүдийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг Ерөнхий газрын дарга батална.

17. Ерөнхий газрын даргын түр эзгүйд түүнийг аюулгүй байдлын хяналт, зохицуулалт хариуцсан дэд дарга орлоно.

Дөрөв. Ерөнхий газрын үйл ажиллагааны төлөвлөлт, санхүүжилт

18. Ерөнхий газар нь салбарын хөгжлийн дор дурдсан төлөвлөгөөг үндэслэн үйл ажиллагаагаа явуулна:

а/урт хугацааны стратеги төлөвлөгөө (5-10 жил);

б/дунд хугацааны төлөвлөгөө (3-5 жил);

в/үйл ажиллагааны жилийн төлөвлөгөө.

19. Урт, дунд хугацааны төлөвлөгөөг Ерөнхий газрын хэмжээнд, жилийн төлөвлөгөөг албаа, харьяа байгууллагын хэмжээнд боловсруулан хэрэгжүүлнэ.

20. Ерөнхий газрын жил бүрийн төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг санхүүгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар хянуулсны үндсэн дээр иргэний нисэхийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

21. Ерөнхий газар нь жилийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг даргын зөвлөлөөр хэлэлцүүлж нийтэд танилцуулна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 3 дугаар сарын 28-ны өдөр **Дугаар 65** **Улаанбаатар хот**

Тогтоолд нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Олон улсын байгууллагуудын татвар хандивын тухай" Засгийн газрын 1998 оны 9 дүгээр сарын 16-ны өдрийн 173 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад "Үнэт цаасны комиссын олон улсын байгууллага" гэсэн 48 дахь заалтыг нэмсүгэй.

2. Үнэт цаасны хороо Үнэт цаасны комиссын олон улсын байгууллагын гишүүнээр элссэнтэй холбогдуулан гишүүний жилийн хураамж болох 6750 ам.долларыг 2002 оноос эхлэн улсын төсөвт тусган санхүүжүүлж байхыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 3 дугаар сарын 28-ны өдөр **Дугаар 66** **Улаанбаатар хот**

Мөнгөн төлбөрийн хэмжээг тогтоох тухай

Иргэний цэргийн үүргийн болон цэргийн албан хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Болзлын дагуу 2001 онд цэргийн дүйцүүлэх албыг мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах иргэний төлөх төлбөрийн хэмжээг 728142 (долоон зуун хорин найман мянга нэг зуун дөчин хоёр) төгрөг байхаар тогтоосугай.

2. Улсын Их Хурлын 1998 оны 94 дүгээр тогтоолоор батлагдсан "Цэргийн дүйцүүлэх албыг иргэн мөнгөн төлбөрийн хэлбэрээр орлуулан хаах болзол"-д заасны дагуу мөнгөн төлбөрийг төвлөрүүлэх, төлберийн орлогыг зарцуулахад хяналт тавьж ажиллахыг Батлан хамгаалахын сайд Ж.Гүррагчаа, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт, мөнгөн төлбөрийн хэлбэрээр алба хааж байгаа иргэдээр төлберийг бүрэн төлүүлэх арга хэмжээ авахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт тус тус даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД **Ж.ГҮРРАГЧАА**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 3 дугаар сарын 28-ны өдөр **Дугаар 67** **Улаанбаатар хот**

Дархлаажуулалтын талаар авах зарим арга хэмжээний тухай

Дархлаажуулалтын тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 1 дэх болон 12 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Дархлаажуулалтын сан байгуулж, уг сангийн ажиллах журмыг 1 дүгээр, "Сангийн зөвлөл (орон тооны бус)-ийн дүрэм"-ийг 2 дугаар, "Сэргийлэх тарилгад хамрагдах шаардлагатай ажил, үйлчилгээний жагсаалт, тарилгын товлол"-ыг 3 дугаар хавсралт ёсоор тус тус батлуулсугай.

2. Дархлаажуулалтын санд зохих хөрөнгийг төвлөрүүлэх, сэргийлэх тарилгыг зохион байгуулахтай холбогдсон арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Эрүүл мэндийн сайд П.Нямдаваа, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД **П.НЯМДАВАА**

Засгийн газрын 2001 оны 67 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ДАРХЛААЖУУЛАЛТЫН САНГИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Дархлаажуулалтын тусгай сан /цаашид "сан" гэнэ/ байгуулах, түүний хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах зэрэг үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмыг мөрдөнө.

2. Дархлаажуулалтыг зохион байгуулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг төвлөрүүлэх, хөрөнгийн хуримтлал бий болгох зорилго бүхий уг сангийн хөрөнгийг халдварт өвчнөөс сэргийлэх тарилга, дархлаажуулах бэлдмэл, тархвар судлалын заалтаар хийж байгаа сэргийлэх тарилга, зүү, тариур, эм, урвалж бодис худалдан авах, тээвэрлэх зардлыг санхүүжүүлэхэд зарцуулна.

3. Сан нь бие даасан хуулийн этгээд байх бөгөөд тогтоосон журмын дагуу хийгдсэн хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэж болно.

4. Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн дагуу сангийн төвлөрүүлэн захирагчийн үүргийг Эрүүл мэндийн яам, шууд захирагчийн үүргийг сангийн зөвлөлийн зохицуулалтын дор Халдварт өвчин судлалын үндэсний төв гүйцэтгэнэ.

5. Сан байгуулах, үйл ажиллагаанд нь өөрчлөлт оруулах, санг татан буулгах асуудлыг Засгийн газар шийдвэрлэнэ.

Хоёр. Сангийн хөрөнгийн бүрдүүлэлт

6.Сангийн хөрөнгө нь дараахь эх үүсвэрээс бүрдэнэ:

а/улсын төвлөрсөн болон орон нутгийн төсвийн хөрөнгө;

б/өмчийн бүх хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэдийн хандив, тусламж;

в/гадаад орон, олон улсын болон сайн дурын байгууллагын хандив, тусламж;

г/сайн дурын дархлаажуулалтын болон сэргийлэх тарилгын төлбөр;

д/бусад эх үүсвэр.

7. Дархлаажуулалтын арга хэмжээнд тухайн санхүүгийн жилд шаардагдах хөрөнгийг Эрүүл мэндийн яамны саналыг үндэслэн Санхүү, эдийн засгийн яам улсын төвлөрсөн төсөвт тусгана.

8. Санхүү, эдийн засгийн яам нь улсын төвлөрсөн төсвөөс энэ дүрмийн 7-д заасан арга хэмжээнд зориулан олгох хөрөнгийг тус сангийн дансанд саадгүй шилжүүлэх, сангийн эрх захирагчийн төлбөрийн даалгаврыг үндэслэн төлбөр тооцоог шуурхай гүйцэтгэх, холбогдох хууль тогтоомжийн дагуу сангийн зарцуулалтын байдалд хяналт тавьж ажиллах үүрэг хүлээнэ.

9. Сангийн хөрөнгийн зарцуулагдаагүй үлдэгдлийн тайланг Санхүү, эдийн засгийн яаманд гарган өгч, үлдэгдлийг баталгаажуулан дараа жилийн үйл ажиллагаанд шилжүүлэн зарцуулна.

Гурав. Сангийн хөрөнгийн зарцуулалт

10. Сангийн хөрөнгийг урьдчилан сэргийлэх тарилга, дархлаажуулах бэлдмэл, зүү, тариур, сэргийлэх бусад эм, урвалж худалдан авах, тэдгээрийг тээвэрлэх, түгээх зориулалтаар сангийн зөвлөлийн зөвшөөрсөн хэмжээгээр Халдварт өвчин судлалын үндэсний төв захиран зарцуулна.

11. Энэ дүрмийн 10-т заасныг үндэслэн Халдварт өвчин судлалын үндэсний төв нь дараахь үйл ажиллагааг хэрэгжүүлнэ:

а/улсын хэмжээнд хэрэглэгдэх вакцин, биобэлдмэл, зүү, тариурын нэгдсэн захиалга болон шаардагдах хөрөнгийн тооцоог гаргаж, жилд 2–оос доошгүй удаа сангийн зөвлөлд танилцуулна;

б/сангийн хөрөнгөөр худалдан авах вакцин, зүү, тариур, биобэлдмэл, эм, урвалжийн үнийн болон тэдгээрийг нийлүүлэх, тээвэрлэх гэрээний нөхцөлийн талаар сангийн зөвлөл болон Эрүүл мэндийн яамтай урьдчилан зөвшилцөнө;

в/вакцин, биобэлдмэлийг захиалах, ханган нийлүүлэх, хадгалах, тээвэрлэх, нөөцлөх, хуваарилах асуудлаар аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газартай гэрээ байгуулан ажиллана;

г/стандартын шаардлагад бүрэн нийцсэн, чанарын баталгаатай вакцин, биобэлдмэлээр хангах арга хэмжээ авч, тэдгээрийн тээвэрлэлт, хадгалалт, орон нутагт хүргэх үеийн хадгалалтын горимыг чанд мөрдөнө;

д/вакцин, биобэлдмэл, зүү, тариурын болон хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжийн үнэ, тээвэрийн зардлыг нийлүүлэгч болон тухайн ажлыг гүйцэтгэгч байгуулагын нэхэмжлэл, гүйцэтгэлийн тухай албан ёсны бичиг баримтыг үндэслэн зөвхөн дансаар шилжүүлнэ;

е/сангийн хөрөнгийн зарцуулалтын тайлан тэнцлийг улсын хэмжээнд мөрдөгдөж байгаа тайлан тэнцлийн маягтын дагуу улирал, жилээр гарган сангийн зөвлөлд танилцуулна.

Дөрөв. Сайн дурын дархлаажуулалтын болон сэргийлэх тарилгын төлбөрийн зохицуулалт

12. Энэ дүрмийн 6-гийн "г"-д заасны дагуу сайн дурын дархлаажуулалтын болон сэргийлэх тарилга /цаашид "сэргийлэх тарилга" гэнэ/-ын төлбөрийг сангийн дансанд оруулна.

13.Сэргийлэх тарилгад хамрагдах шаардлагатай ажил, үйлчилгээ эрхэлж буй аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн ажиллагчдыг сэргийлэх тарилгад бүрэн хамруулах үүрэг хүлээж, тухайн жилд уг тарилгад хамрагдвал зохих хүмүүсийн судалгааг сэргийлэх тарилга тус бүрээр гаргаж хамрах хүрээний эмнэлэг, эрүүл мэндийн газарт жил бүрийн 1 дүгээр сарын 25-ны дотор ирүүлнэ.

14. Тарваган тахал өвчний голомт бүхий нутгийн малчдын сэргийлэх тарилгын төлбөрийг дархлаажуулалтын сангаас хариуцна.

15. Сэргийлэх тарилгад хамрагдах шаардлагатай ажил, үйлчилгээ эрхэлж буй ажилтны "В" гепатит, балнад, боом, шар чичрэг, урвах тахлын дархлаажуулалтын зардлыг тухайн ажилтныг ажиллуулж байгаа аж ахуйн нэгж, байгууллага нь, ийм төрлийн ажил, үйлчилгээ хувираа эрхлэгч төлбөрөө өөрөө хариуцна.

ТАВ. Хяналт, хариуцлага

16. Сангийн хөрөнгөөр худалдан авсан вакцин, биобэлдмэл, зүү, тариурын чанар, хуваарилалт, хадгалалтад Эрүүл мэндийн улсын хяналтын алба болон холбогдох бусад байгууллага хяналт тавина.

17. Сангийн хөрөнгийг энэ дүрэмд зааснаас бусад арга хэмжээнд зарцуулахыг хориглоно.

18. Сангийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулсан буюу энэ журмыг зөрчсөн этгээдэд Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Засгийн газрын 2001 оны 67 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ДАРХЛААЖУУЛАЛТЫН САНГИЙН ЗӨВЛӨЛИЙН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Дархлаажуулалтын сангийн орон тооны бус зөвлөл /цаашид "зөвлөл" гэнэ/-ийн үйл ажиллагаат энэ дүрмээр зохицуулна.

2. Зөвлөл нь Монгол Улсын дархлаажуулалтын тухай хууль болон дархлаажуулалтын үндэсний хөтөлбөрийн хүрээнд улсын хэмжээнд дархлаажуулалтыг төлөвлөх, зохион байгуулах, хэрэгжүүлэхтэй холбогдсон удирдамж, зөвлөмж гаргах, халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх, зарим халдварт өвчнийг туушгай бууруулах, устгах зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг бүрдүүлэх, сангийн хөрөнгийг зориулалтын дагуу зөвхөөрөлд, түүний зарцуулалтад хяналт тавих үүргэтэйгээр ажиллана.

3. Зөвлөлийн бүрэлдэхүүнийг Эрүүл мэндийн дэд сайдаар ахлуулан Эрүүл мэндийн болон Санхүү, эдийн засгийн сайдын хамтарсан тушаалаар батална.

4. Зөвлөлийн хурлыг улирал тутам зохион байгуулна. Хурлаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн гаргана. Зөвлөлийн ээлжит бус хурлыг шаардлагатай үед зарлан хуралдуулж болно.

5. Зөвлөлийн ажлын албаны үүргийг Халдварт өвчин судлалын үндэсний төв гүйцэтгэнэ.

6. Зөвлөл нь асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэх ба зөвлөлийн хурлаас тогтоол, удирдамж, зөвлөмж гаргана.

7. Зөвлөл нь хурлаараа сангийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг улирал, хагас, бүтэн жилээр хэлэлцэж, дүгнэлт өгөх ба сангийн хөрөнгийг хуваарилах болон дархлаажуулалтын бодлого, төлөвлөлт, хэрэгжилт, зохион байгуулалтын асуудлаар холбогдох шийдвэр гаргана.

Хоёр. Зөвлөлийн эрх, үүрэг

8. Зөвлөл нь дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ:

а/сан бүрдүүлэх, сангийн хөрөнгийг зарцуулахтай холбогдсон асуудлаар шийдвэр гаргах;

б/жил бүрийн улсын төвлөрсөн төсвөөс Дархлаажуулалтын санд олгох хөрөнгийн талаар эрүүл мэндийн болон санхүү, эдийн засгийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад санал, зөвлөмж гаргах;

в/сангийн хөрөнгийн орлого, зарлагын байдалд хяналт тавих, шаардлагатай бол энэ асуудлаар холбогдох төрийн захиргааны төв байгууллагад санал гаргах;

г/сан бүрдүүлэхэд иргэд, аж ахуйн нэгж, төрийн болон төрийн бус байгууллагын идэвхтэй оролцоог хангах;

д/сангийн үйл ажиллагааг идэвхжүүлэхэд чиглэсэн мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

е/сангийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалтад аудитын байгууллагаар шалгалт хийлгэх, дутагдал илэрсэн нөхцөлд зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;

ж/сангаас санхүүжүүлэн нийлүүлэх вакцин, биобэлдмэлийн үнэ тарифын талаар эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад санал оруулах.

9. Зөвлөл нь дор дурдсан эрх эдэлнэ:

а/сангийн үйл ажиллагааны тайлан, дархлаажуулалтын үр дүнгийн талаархи мэдээллэл, судалгаат холбогдох мэргэжлийн байгууллагаар тогтоосон

хугацаанд гаргуулан авах;

б/сонгон шалгаруулалтаар нийлүүлэхээр төлөвлөгдөж байгаа вакцин, биобэлдмэлийн чанар, үнийн санал, ерөнхий нөхцөлийн талаар холбогдох байгууллагуудад хандсан зөвлөмж гаргах, чиглэл өгөх;

в/сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавих, шаардлагатай тохиолдолд ажлын хэсэг томилон ажиллуулах, хөрөнгийн ашиглалтыг сайжруулах талаар чиглэл, үүрэг даалгавар өгөх;

г/сангийн хөрөнгийг зориулалтын бусаар ашиглаган байгуллага, иргэдэд зохих хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэх асуудлаар холбогдох байгууллагад санал гаргах.

Засгийн газрын 2001 оны 67 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

СЭРГИЙЛЭХ ТАРИЛГАД ХАМРАГДАХ ШААРДЛАГАТАЙ АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЖАГСААЛТ, ТАРИЛГЫН ТОВЛОЛ

1.Тарваган тахлын вакцинд:

-Байгалийн голомтот халдварт өвчнийг эсэргүүцэн судлах байгууллагын бүх ажиллагчид;

-Тарваган тахлын байгалийн идэвхтэй голомтот нутгийн эрүүл мэндийн байгууллагын ажиллагчид;

-Тарваган тахлын байгалийн идэвхтэй голомтот нутгийн анчин, туувархчин, жолооч.

Уг сэргийлэх тарилгыг жил бүрийн 5-6 дугаар сард 1 удаа хийлгэнэ.

2. "В" гепатитын вакцинд:

-Мэс засал, эх барих, эмэгтэйчүүдийн эмч, сувилагч;

-Шүдний их эмч, сувилагч, техникч;

-Лабораторийн эмч, лаборант;

Уг сэргийлэх тарилгыг нэг удаа, 2 тунг нэг сарын зайтай хийлгэнэ.

3. Балнадын вакцинд:

-Халдвартын эмнэлэг, тасгийн гэдэсний халдвартай өвчтөнтэй ажиллах хэсгийн эмч, сувилагч;

-Бохир ус цэвэрлэх байгууламжийн слесарь, механик;

-Орон сууц болон албан байгууллага, аж ахуйн нэгжийн цэвэр, бохир усны слесарь, үйлчлэгч.

Уг сэргийлэх тарилгыг хоёр жилд 1 удаа, 4-5 дугаар сард 10 хоногийн зайтай 2 удаа хийлгэнэ

4. Боомын вакцинд:

-Малын их, бага эмч, амьтан маллагч;

-Мал, амьтны гаралтай түүхий эд /арьс, шир, ноос, ноолуур/ хүлээн авагч, бэлтгэгч, иймгиглэлийн боловсруулах үйлдвэрийн хүлээн авах, анхан шатны боловсруулалт хийх дамжлагын ажилчин.

Уг сэргийлэх тарилгыг жил бүрийн 4 дүгээр сард 1 удаа хийлгэнэ.

5. Шар чичрэгийн вакцинд:

-Шар чичрэг өвчний голомт бүхий улсад ажиллах дипломат ажилтан, түүнтэй хамт амьдрах гэр бүлийн гишүүд.

Уг сэргийлэх тарилгыг тухайн улсад нэвтрэхээс 10 хоногийн өмнө 10 жилд 1 удаа хийлгэнэ.

6. Урвах тахлын вакцинд:

-Урвах тахал өвчний голомт бүхий улсад ажиллах дипломат ажилтан, түүнтэй хамт амьдрах гэр бүлийн гишүүд.

Анхны сэргийлэх тарилгыг тухайн улсад нэвтрэхээс 1 сарын өмнө, цаашид жил тутам 1 удаа хийлгэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 3 дугаар сарын 28-ны өдөр **Дугаар 68** **Улаанбаатар хот**

Комисс байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Ардын хувьсгалын 80 жилийн ойд бэлтгэх, ойн баярыг тэмдэглэх ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий Улсын баяр-наадмын төв комиссыг хавсралтад дурдсан бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

2. Баяр-наадмын салбар комиссыг

байгуулж, ойн арга хэмжээг бэлтгэх, тэмдэглэх ажлын төлөвлөгөө болон тэдгээрт шаардагдах зардлын төсвийг гарган энэ оны 4 дүгээр сарын 20-ны дотор Засгийн газарт танилцуулахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Улсын баяр-наадмын төв комиссын дарга М.Энхболд нарт үүрэг болгосугай.

3. Аймаг, сум болон зарим салбарын ойн баяр, наадмыг Ардын хувьсгалын 80 жилийн ойн баяр-наадамтай хамтруулан тэмдэглэх арга хэмжээ авахыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ө.Энхтүвшин, Улсын баяр-наадмын төв комиссын дарга М.Энхболд нарт даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА Ө.ЭНХТҮВШИН

Засгийн газрын 2001 оны 68 дугаар тогтоолын хавсралт

АРДЫН ХУВЬСГАЛЫН 80 ЖИЛИЙН ОЙД БЭЛТГЭХ, ОЙН БАЯРЫГ ТЭМДЭГЛЭХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ УЛСЫН БАЯР-НААДМЫН ТӨВ КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	-Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч М.Энхболд
Орлогч дарга	-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын төргүүн дэд дарга Л.Хангай
Гишүүд:	-Санхүү,эдийн засгийн дэд сайд Л.Энхтайван; -Гадаад хэргийн дэд сайд,ёслол,үйлчилгээний комиссын дарга С.Батболд; -Хүнс, хөдөө аж ахуйн дэд сайд, үндэсний бэхийн комиссын дарга Д.Төрбишдагва; -Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн дэд сайд, шагайн харвааны комиссын дарга С.Чинзориг; -Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга, хурдан морины комиссын дарга С.Баасанхүү; -Дэд бүтцийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, үндэсний сурын комиссын дарга Ц.Цэнгэл; -Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга, урлаг, соёлын арга хэмжээний комиссын дарга Б.Мишигжав; -Цагдаагийн ерөнхий газрын дарга,хэв журмын комиссын дарга Ч.Амарболд; -Радио, телевизийн хэрэг эрхлэх газрын дарга, хэвлэл мэдээлэл, сурталчилгааны комиссын дарга Б.Ганболд; -Төрийн ёслолын албаны дарга Ч.Батжаргал; -Төрийн тусгай хамгаалалтын газрын дарга Г.Жаргалсайхан; -Улаанбаатар хотын ерөнхий менежер,тохижилт, засвар, худалдаа, үйлчилгээний комиссын дарга Т.Бадамжунай.
Нарийн бичгийн дарга	-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын дарга Ц.Болдсайхан.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 3 дугаар сарын 30-ны өдөр **Дугаар 70** **Улаанбаатар хот**

Утаа багатай, түлшний хэмнэлттэй зуухны үйлдвэрлэлийг дэмжих тухай

"Хүний аюулгүй байдлыг хангах сайн засаглал хөтөлбөр"-ийн бодлогын баримт бичигт тодорхойлсон "Ажилгүйдэл, ядуурлыг бууруулж, ард иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх", "Томоохон хот, суурин газруудын агаар, ус, хөрсний бохирдлыг бууруулж хог хаягдлыг дахин боловсруулах замаар иргэдийн амьдрах орчинг сайжруулах" тухай Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлүүдийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг, Байгаль орчны сайд У.Барсболд нарт даалгах нь:

а/хот, төв, суурин газрын бохирдлыг

багасгах зорилгоор Байгаль орчны яамнаас тендер зарлаж сонгон авсан утаа багатай, түлшний хэмнэлттэй загварын 15000 ширхэг зуухыг 2001 оны Ш улиралд багтаан үйлдвэрлэх ажлыг зохион байгуулсугай;

б/Нийслэлийн гэр хорооллын айл өрхийг утаа багатай, түлшний хэмнэлттэй зуухаар бүрэн хангах арга хэмжээг 2004 онд багтаан авч хэрэгжүүлсүгэй.

2. Утаа багатай, түлшний хэмнэлттэй зуух үйлдвэрлэхэд шаардагдах 190,0 (нэг зуун ерэн) сая төгрөгийн эх үүсвэрийг зохих хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэж өгөхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

3. Зуух үйлдвэрлэхэд зарцуулах 1000 тн төмрийн үнийг Японы төслийн бус санд төвлөрүүлэх хөрөнгөөс санхүүжүүлэх арга хэлбэрийг судалж Монгол Улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх 2002 оны үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлэхийг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаяр, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

4. Нийслэл гэр хорооллын агаарын бохирдлын түвшин, утааны нягтрал, газар зүйн байршил, ноёлох салхины чиглэл зэрэг хүчин зүйлүүдийг харгалзан гэр хорооллын айл өрхийг шинэ загварын зуухаар дэс дараатайгаар хангах, түгээх, борлуулах арга хэмжээ авахыг Байгаль орчны сайд У.Барсболд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаяр, Нийслэлийн Засаг дарга М.Энхболд нарт үүрэг болгосугай.

5. Түргэн дулаацуулах, түлш хэмнэх, утаа тортогийг бүрэн шүүх чадвар бүхий загварын зуух зохион бүтээх, хүн амын эрүүл мэндэд агаарын бохирдол хэрхэн нөлөөлж байгааг судалгаа хийх, утааны найрлагыг шинжлэх зэрэг ажлыг байнга зохион байгуулж байхыг Байгаль орчны сайд У.Барсболд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд А.Цанжид, Эрүүл мэндийн сайд П.Нямдаваа нарт даалгасугай.

6. Шинэ зуухыг хэрэглэж буй нутаг дэвсгэрт агаарын бохирдлын хяналт-шинжилгээг тогтмол хийх, тухайн нутаг дэвсгэрийн агаарын бохирдлын одоогийн түвшинг тогтоох зорилгоор агаарын бохирдлыг хянах суурин харуул байгуулж ажиллуулахын зэрэгцээ агаар бохирдуулсны харицуцлагын талаар хуулийн төсөл боловсруулж 2001 онд багтаан Засгийн газарт оруулахыг Байгаль орчны сайд У.Барсболдод даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД **У.БАРСБОЛД**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр **Дугаар 71** **Улаанбаатар хот**

Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаны дүрэм, зохион байгуулалтын бүтцийг батлах тухай

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албыг байгуулж, түүний дүрмийг хавсралт ёсоор батална сугай.

2. Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаны бүтцийг зөвшөөрөл, бүртгэлийн болон захиргааны удирдлагын хэлтэстэй байхаар тогтоож, орон тоог нь эрхлэх асуудлынхаа хүрээний агентлагуудын орон тооны хязгаарт багтаан зохицуулахыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид зөвшөөрсүгэй.

3. Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албыг ажлын байр, албаны унаагаар хангах асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Төрийн өмчийн хорооны дарга Л.Пүрэвдорж нарт даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Засгийн газрын комисс, үндэсний зөвлөл, хороо, ажлын хэсгийн тухай" Засгийн газрын 1996 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 238 дугаар тогтоолын 1 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД **Ц.НЯМДОРЖ**

Засгийн газрын 2001 оны 71 дүгээр тогтоолын хавсралт

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН АСУУДАЛ ЭРХЛЭХ АЛБАНЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэхүү дүрмийн зорилго нь Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаны эрх, үүрэг, үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох, тэдгээртэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2. Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх алба /цаашид "Алба" гэх/ нь гадаадын иргэний эрх зүйн байдлын болон харьяатын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, хяналт тавих, төрийн захиргааны байгууллагуудын гадаадын иргэний эрх зүйн байдалтай холбогдсон үйл ажиллагаат уялдуулан зохицуулах үндсэн чиг үүргийг гүйцэтгэнэ.

3. Албаны үйл ажиллагаатай холбогдож гарах вардлыг улсын төвлөрсөн төсвөөс санхүүжүүлнэ.

4. Алба нь тогтоосон журмаар хийлгэсэн тамга, тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

Хоёр. Албаны бүтэц, зохион байгуулалт

5. Алба нь хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний дэргэд ажиллана.

6. Алба нь дор дурдсан хэлтсийн зохион байгуулалтаар үйл ажиллагаагаа явуулна:

-Зөвшөөрөл, бүртгэлийн хэлтэс;

-Захиргааны удирдлагын хэлтэс.

7. Албаны даргыг хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлнө. Дэд даргыг Албаны даргын санал болгосноор хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн томилж, чөлөөлнө.

8. Албаны хэлтсийн дарга, ажилтнуудыг Албаны дарга томилж, чөлөөлнө.

9. Албаны ажилтан тусгай загвараар хийсэн үнэмлэх, тэмдэгтэй байна. Үнэмлэх, тэмдэгний загварыг хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

10. Албаны дарга ажлаа хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний өмнө тайлагнана.

Гурав. Албаны эрх, үүрэг

11. Алба нь энэхүү дүрмийн 2 дугаар заалтад заасан үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэхийн тулд дараахь эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

Үдирдлага, зохион байгуулалтын асуудлаар:

1/Гадаадын иргэн, харьяат, цагаачлалын асуудлаар төрийн бодлого боловсруулахад санал өгөх, хүн амын тоо, нягтрал, газар зүйн байршил, хөгжлийн түвшин зэрэг хүчин зүйлтэй уялдуулан тус улсад цагаачлах иргэдийн тоо, бүтэц, хөдөлгөөний талаар санал боловсруулах;

2/Гадаадын иргэний эрх зүйн байдал, цагаачлал, харьяатын асуудлаар төрийн захиргааны болон нутгийн захиргааны байгууллагуудын үйл ажиллагаат уялдуулан зохицуулах, энэ талаархи төрийн бодлогын хэрэгжилтэд хяналт тавих, тодорхой асуудлаар үүрэг даалгавар өгч биелэлтийг хангуулах;

3/Гадаадын иргэний эрх зүйн байдал, цагаачлал, харьяатын асуудлаар Монгол Улсаас гадаад улсад суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газрыг гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар дамжуулан мэдээлэл болон мэргэжил арга зүйн удирдлагаар хангах;

Бүртгэх болон зөвшөөрөл олгохтой холбоотой асуудлаар:

4/ Монгол Улсын энгийн зэргийн виз авах тухай байгууллага, иргэнээс гаргасан хүсэлтийг хүлээн авч виз олгох буюу визийн зөвшөөрөл өгөх;

5/Монгол Улсад байнга оршин суугч, цагаач гадаадын иргэн, харьяалалгүй хүнд гарах, гарах-орох виз олгох, олгохоос татгалзах, хүчингүй болгох, визийн хугацааг сунгах, богиносгох, ангиллыг нь өөрчлөх;

6/Монгол Улсад хувийн хэргээр удаан хугацаагаар оршин суугч, цагаач гадаадын иргэн ажил эрхлэх, гэрээ, хэлэлцээрийн дагуу төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, аж ахуйн нэгжийн төлөөлөгчийн газарт ажиллах, аж ахуйн нэгж байгуулан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгоход санал өгөх;

7/ Засгийн газар хоорондын болон эрх бүхий байгууллагын гэрээний үндсэн дээр туслах ажиллаж, суралцаж байгаа, түүнчлэн олон улсын болон төрийн бус байгууллагын төлөөлөгчийн газар ажилладаг гадаадын иргэний гэрээний хугацаа дуусан буюу хугацаанаас өмнө гэрээгээ цуцалсан тохиолдолд тухайн байгууллага нь дэмжиж өөр аж ахуйн нэгж, байгууллага, иргэнтэй гэрээ байгуулсан үндэслэлээр цаашид ажиллах, суралцах зөвшөөрлийг хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас олгоход санал өгөх;

8/хөдөлмөр эрхлэлтийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах зөвшөөрөл олгоход санал өгөх;

9/Монгол Улсад зорчигч, түр буюу удаан хугацаагаар оршин суугч гадаадын иргэн, харьяалалгүй хүнийг бүртгэх;

10/Монгол Улсын нутаг дэвсгэрт байнга оршин суугч, цагаач гадаадын иргэн, харьяалалгүй хүнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн тодорхой нэгжид оршин суугч мөн болохыг тодорхойлсон оршин суух үнэмлэх олгох;

11/харьяалалгүй хүнд гадаадад зорчих үнэмлэх олгох, Монгол Улсад хуурамч баримт бичгээр орж ирсэн, эсхүл паспорт болон түүнийг орлох хууль ёсны баримт бичгээ үрэгдүүлсэн, эсвэл хүчингүй болсон гадаадын иргэнд дипломат төлөөлөгчийн болон консулын байгуулага нь тус улсад байхгүй тохиолдолд гарах үнэмлэх олгох;

12/Монгол Улсад албан болон хувийн хэргээр зорчигч, түр болон удаан хугацаагаар оршин суугч, байнга оршин суугч, цагаач гадаадын иргэний оршин суух хугацааг сунгах;

13/Монгол Улсад байнга оршин суугч, цагаач гадаадын иргэн, харьяалалгүй хүн гадаадад зорчиход оршин суух үнэмлэхийг нь хадгалах, бүрмөсөн явах тохиолдолд хураах авах;

14/дор дурдсан асуудлаар нэгдсэн бүртгэл хөтлөх:

-Монгол Улсын визийн;

-визийн зөвшөөрлийн;

-Монгол Улсын харьяат болсон, харьяатаас гарсан, иргэний харьяаллаа алдсан, сэргээн тогтоолгосон иргэний;

-Монгол Улсад байнга оршин суугч, цагаач, харьяалалгүй хүний;

-Монгол Улсад зорчигч гадаадын иргэний;

-Монгол Улсын харьяат хүүхэд үрчилж авсан гадаадын иргэн, харьяалалгүй хүний болон тэдгээрт үрчлэгдсэн Монгол Улсын харьяат хүүхдийн;

-виз, бүртгэлийн журам зөрчиж захиргааны шийтгэл хүлээсэн, гэмт хэрэгт холбогдсон болон албадан гаргасан гадаадын иргэн, харьяалалгүй хүний.

15/гадаадын иргэний эрх зүйн байдал, цагаачлал, харьяатын тухай хууль тогтоомжид заасан мэдээ, баримтыг холбогдох байгууллагаас хүлээн авч нэгтгэх, мэдээллийн сан байгуулах;

16/гадаадын иргэнийг урьж ирүүлэх хүсэлт гаргасан байгууллага, аж ахуйн нэгж, иргэнд урилга олгох асуудлыг шийдвэрлэх;

17/гадаадын иргэн, харьяалалгүй хүнд Монгол Улсын харьяат хүүхэд үрчлүүлэх асуудлыг хүн ам зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн шийдвэрлэх;

18/гадаадын төрийн бус болон олон улсын байгууллагын төлөөлөгчийн газрыг нээн ажиллуулах зөвшөөрөл олгож улсын бүртгэлд бүртгэх.

Харьяатын асуудлаар:

19/Монгол Улсын харьяат болох хүсэлт гаргасан гадаадын иргэн, харьяалалгүй хүний хүсэлтийг хүлээн авч, шийдвэрүүлэхээр холбогдох бусад баримт бичиг, саналын хамт Монгол Улсын Ерөнхий сайдад танилцуулснаар Ерөнхийлөгчид өргөн барих;

20/тодорхой иргэний харьяаллын асуудлаар гарсан шийдвэрийн биелэлтэд хяналт тавих;

21/Монгол Улсын харьяат болох, харьяатаас гарах, иргэний харьяаллыг нь сэргээн тогтоох хүний талаар тагнуулын болон цагдаагийн төв байгууллагаас санал, дүгнэлт гаргуулах, шаардлагатай баримт бичгийг аж ахуйн нэгж, байгууллага, албан тушаалтнаас үнэ төлбөргүйгээр гаргуулж авах;

22/Монгол Улсын иргэний харьяаллын асуудлыг шийдвэрлэхэд шаардагдах бичиг баримтын жагсаалт гаргах;

Цагаачлалын асуудлаар:

23/гадаадын иргэн, харьяалалгүй хүнд Монгол Улсад цагаачлах зөвшөөрөл олгох;

24/гадаадад цагаачлах, байнга оршин суух Монгол Улсын иргэний асуудлыг хянан шийдвэрлэх, бүртгэл судалгаа хөтлөх;

25/оршин суух үнэмлэхээ гэмтээсэн, үрэгдүүлсэн, хуульд заасан хугацаа хэтрүүлэн гадаадад зорчсон цагаач гадаадын иргэний оршин суух зөвшөөрлийг сэргээх, дахин үнэмлэх олгох асуудлыг хянан шийдвэрлэх.

Хяналт тавих асуудлаар:

26/хуульд заасан үндэслэлд нийцүүлэн гадаадын иргэнийг албадан гаргах тухай шийдвэр гаргуулахаар хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд санал тавих, шийдвэрийг үндэслэн албадан гаргах ажлыг зохион байгуулах;

27/Монгол Улсад оршин суух, зорчих хугацаа хэтрүүлсэн, хууль бусаар хөдөлмөр эрхэлсэн болон гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай, харьяатын тухай, иргэний бүртгэлийн тухай хууль тогтоомж зөрчсөн гадаадын иргэнд холбогдох хууль тогтоомжид заасан шийтгэл ногдуулах, хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор баримт бичгийн шалгалт хийх, шаардлагатай тохиолдолд цагдаагийн байгууллагад мэдэгдэх;

28/хүчин төгөлдөр бус буюу бусдын баримт бичгээр тус улсад орж ирсэн хүний асуудлыг эрх бүхий байгууллага шийдвэрлэх хүртэл түр саатуулах.

12. Албан нь дараахь зөрчил гаргасан гадаадын иргэнийг Монгол Улсын нутаг дэвсгэрээс албадан гаргах шийдвэр гаргуулахаар хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнд санал тавина:

1/ хүчин төгөлдөр бус болон хуурамч баримт бичгээр Монгол Улсад орж ирсэн буюу оршин суух хугацаа нь дуусан боловч тус улсаас гарч явахаас зайлсхийсэн;

2/Монгол Улсад оршин суух зөвшөөрлийг нь хүчингүй болгосон буюу буцаан авсан боловч тухайн

гадаадын иргэн тус улсаас гарч явахаас зайлсхийсэн;

3/эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүй хөдөлмөр эрхэлсэн буюу ирсэн зорилгоосоо өөр үйл ажиллагаа явуулсан.

13.Алба нь энэ дүрмийн 12 дахь заалтад заасан албадан гаргах шийдвэр гарсан даруй энэ тухай гадаадын иргэнд мэдэгдэх, оршин байгаа хаяг нь тодорхойгүй бол цагдаагийн болон хилийн цэргийн байгууллагатай хамтран эрэн сурвалжлах, шийдвэрт заасан хугацаанд улсын хилээр албадан гаргах арга хэмжээ авна.

Дөрөв. Албаны ажилтны эрх, үүрэг

14. Албаны ажилтан нь энэ дүрмийн 2; 3; 4; 5 дахь заалтад заасан Албаны эрх, үүргийг хэрэгжүүлж ажиллана.

15. Албаны ажилтан нь гадаадын иргэний эрх зүйн байдал, харьяатын болон цагаачлалын асуудлыг зохицуулсан хууль тогтоомжийг гадаадын иргэн, харьяалалгүй хүн зөрчихөөс урьдчилан сэргийлэх зорилгоор баримт бичиг шалгах, зөрчил илэрсэн тохиолдолд түүнийг арилгах арга хэмжээ авахыг гадаадын иргэн, харьяалалгүй хүнээс шаардах, хаяг тодруулах, гадаадын иргэнийг албадан гаргах шийдвэрийг хэрэгжүүлэх, зөрчлийг таслан зогсоох зорилгоор цагдаагийн байгууллагын дэмжлэг авах эрхтэй.

16. Хяналт шалгалт хариуцсан байцаагч нь улсын байцаагчийн эрхтэй байх бөгөөд гадаадын иргэний бүртгэлийн тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавьж, зөрчил илэрсэн тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасан шийтгэл ногдуулна.

17. Албаны ажилтан нь энэ дүрэмд заасан эрх, үүргийг хэрэгжүүлэхдээ хууль тогтоомж зөрчсөн бол холбогдох хуульд заасан хариуцлага хүлээнэ.

Тав. Бусад зүйл.

18. Алба нь гадаадын иргэний эрх зүйн байдал, цагаачлал, иргэний харьяалалтай холбогдсон асуудлаар гадаад улсаас тус улсад суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын байгууллага, түүнчлэн гадаад улсын холбогдох бусад байгууллагатай өөрийн орны хууль тогтоомж, олон улсын эрх зүйн хэм хэмжээ, зан заншлаар тогтоосон ёс журамд нийцүүлэн харилцан ажиллана.

19. Алба нь Монгол Улсын нутаг дэвсгэрээс гадаадын иргэнийг албадан гаргах тухай шийдвэрийг хэрэгжүүлэхэд болон хууль тогтоомжийн биелэлтийг шалгах явцад гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, цагдаагийн болон хилийн цэргийн байгууллагын дэмжлэг туслалцаа авч хамтран ажиллана.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр **Дугаар 72** **Улаанбаатар хот**

Журам батлах тухай

Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын виз олгох журмыг хавсралт ёсоор батлагдсугай.

2. Монгол Улсад гадаадын иргэдийн зорчих визийн хуудасны загварыг 2001 оны П улиралд багтаан шинэчлэн батлахыг Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуунд, визийн хуудсыг хэвлүүлэх болон бусад арга хэмжээнд шаардагдах зардлын тооцоог хийж 2002 оны төсөвт тусгахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд тус тус даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Журам батлах тухай" Засгийн газрын 1997 оны 4 дүгээр сарын 30-ны өдрийн 110 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД **Ц.НЯМДОРЖ**

Засгийн газрын 2001 оны 72 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ВИЗ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Гадаадын иргэн, харьяалалгүй хүнд Монгол Улсын виз (цаашид "виз" гэнэ) олгоход Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль болон энэхүү журмыг мөрдөнө.

2. Энэ журам иргэд харилцан зорчих нөхцөлийн талаар байгуулсан Монгол Улсын олон улсын гэрээний заалтыг хөндөхгүй.

Хоёр. Виз, түүний зэрэг, ангилал

3. Виз нь дипломат, албан, энгийн гэсэн зэрэгтэй байна. Гадаадын иргэн, харьяалалгүй хүнд олгох визийн зэрэг нь тэдгээрийн паспорт буюу түүнийг орлох хууль ёсны баримт бичгийн төрөлд тохирсон байна.

4. Виз нь дор дурдсан ангилалтай байх бөгөөд виз олгохдоо холбогдох ангиллыг заасан латин үсгийг түүнд дараахь байдлаар тэмдэглэнэ:

1/Дипломат төлөөлөгчийн газар болон Консулын газарт ажиллах дипломат ажилтны визэд "D";

2/олон улсын байгуулагын ажилтны визэд "OУ";

3/гадаадын байгуулагын төлөөлөгчийн газар, гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгжид ажиллах хүний визэд "Т";

4/албан хэргээр зорчих визэд "А";

5/хувийн хэргээр зорчих визэд "Н";

6/жуулчлах визэд "J";

7/суралцах визэд "S";

8/хөдөлмөрийн гэрээгээр ажиллах визэд "HG";

9/цагаачлах визэд "TS";

10/ажил хэргийн шугамаар ирэх визэд "В";

11/Засгийн газрын бус байгуулагад болон олон улсын хүмүүнлэгийн байгуулагын шугамаар зорчих визэд "О".

Гурав. Виз олгох байгуулага, тэдгээрийн эрх, үүрэг

5. Гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулага виз олгох талаар дараахь эрх, үүрэгтэй:

1/Дипломат, албан зэргийн виз олгох, сунгах, хүчингүй болгох ;

2/Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаны эвшөөрлийг үндэслэн дипломат, албан зэргээс бусад зэрэг, ангиллын виз олгох, сунгах, ангиллыг өөрчлөх, хүчингүй болгох;

3/Монгол Улсын нутаг дэвсгэрт паспорт буюу түүнийг орлох хууль ёсны баримт бичгээ үрэгдүүлэн шинээр дипломат, албан паспорт, буцах үнэмлэх авсан гадаадын иргэнд гарах виз олгох;

4/Дипломат төлөөлөгчийн болон Консулын газар, Монгол Улсын Өргөмжит консулаас олгосон визийн улирлын мэдээг дараа улирлын эхний сарын 16-ны дотор гаргуулан авч нэгдсэн бүртгэл хөтлөх, виз олгох үйл ажиллагаанд хяналт тавих, шалган зааварлах;

5/Энэ журмын 5 дахь заалтын "4"-т заасан мэдээг Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх албаа /цаашид "Албаа" гэх/-нд мэдээлэх;

6/өөрийн харьяа виз олгох эрх бүхий бусад байгуулагад визийн хуудас олгож, зарцуулалтад нь хяналт тавих.

6. Гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулагаас олгох визэд консулын асуудал хариуцсан хэлтсийн дарга, түүний эзгүйд эрх зүй, консулын асуудал хариуцсан газрын захирал, дэд захирал нар гарын үсэг зурж, визийн тэмдэг дарж баталгаажуулсан байна.

7. Гадаад улсад суугаа Монгол Улсын Дипломат төлөөлөгчийн болон Консулын газар виз олгох талаар дараахь эрх, үүрэгтэй:

1/гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуулагын зөвшөөрлийг үндэслэн гарах зориулалттайгаас бусад бүх зэрэг, ангиллын виз олгох;

2/Монгол Улсын нутаг дэвсгэрээр дамжин өнгөрөх гадаадын иргэн, харьяалалгүй хүн виз авах хүсэлт гаргасан тохиолдолд дамжин өнгөрөх визийг галт тэрэг, нисэх онгоцоор зорчигчдод 48 цаг,

автомашинаар зорчигчдод тав хүртэл хоногийн хугацаагаар олгох;

3/албаны болон хувийн урилгаар Монгол Улсад ирэх гадаадын иргэн, харьяалалгүй хүн, жуулчдын зохих ангиллын визийг 30 хүртэл хоногийн хугацаагаар олгох;

4/суугаа болон хавсран суугаа орон, тойргийн нутаг дэвсгэрт ажиллаж байгаа Өргөмжит консулд виз олгох талаар заавар, чиглэл өгөх;

5/виз олгох үед Монгол Улсын виз, бүртгэлийн журмыг тайлбарлах, зөвлөлгөө өгөх.

8.Дипломат төлөөлөгчийн болон Консулын газрын тэргүүн, эсхүл түүнийг орлож байгаа консулын албан тушаалтан визэд гарын үсэг зурж, визийн тэмдэг дарж баталгаажуулсан байна.

9. Алба виз олгох талаар дараахь эрх, үүрэгтэй:

1/гадаадын иргэнд дипломат, албан зэргийнхээс бусад визийг 30 хоногоос дээш хугацаагаар олгох асуудлыг виз хүсэгчийн материалыг хүлээн авснаас хойш 48 цагийн дотор хянан шийдвэрлэж, гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын консулын асуудал хариуцсан нэгжид зөвшөөрөл өгөх, татгалзсан тохиолдолд хүсэлт гаргагч байгууллага, аж ахуйн нэгж, иргэнд энэ тухай мэдэгдэх;

2/хууль тогтоомжид заасан үндэслэл байвал виз олгохоос татгалзах, визийн хугацаг богиносгох, сунгах, ангиллыг нь өөрчлөх, олгосон визийг хүчингүй болгох зэрэг асуудлыг хянан шийдвэрлэх буюу холбогдох төрийн захиргааны байгууллагад мэдэгдэх;

3/Монгол Улсад байнга оршин суугч, цагаач гадаадын иргэн, харьяалалгүй хүнд гарах, гарах-орох визийг 120 хүртэл хоногийн хугацаагаар олгох;

4/Монгол Улсад байнга оршин суугч, цагаач гадаадын иргэн, харьяалалгүй хүн гадаадад 120 хүртэл хоногийн хугацаагаар зорчих тохиолдолд Монгол Улсад оршин суух үнэмлэхийг нь авч хадгалах;

5/Монгол Улсад байнга оршин суугч, цагаач гадаадын иргэн, харьяалалгүй хүн тус улсаас бүрмөсөн гарч явах, эсхүл 120-иос дээш хоногийн хугацаагаар гадаадад зорчих бол түүний Монгол Улсад оршин суух үнэмлэхийг нь хураан авах;

6/Монгол Улсын хилийн олон улсын нээлттэй боомт дээр гадаадын зорчигчдод орох-гарах визийг 30 хүртэл хоногийн хугацаагаар, дамжин өнгөрөх визийг галт тэрэг, нисэх онгоцоор зорчигчдод 48 цаг, автомашинаар зорчигчдод тав хүртэл хоногийн хугацаагаар олгох. Зайлшгүй шаардлагатай тохиолдолд Албаны даргын зөвшөөрснөөр гарах виз олгох;

7/Монгол Улсад хуурамч бичиг баримтаар орж ирсэн, эсхүл паспортоо үрэгдүүлсэн, паспорт нь хүчингүй болж гарах үнэмлэх авсан гадаадын иргэнд гарах виз олгох.

10. Визэд Албаны дарга, түүний эзгүйд Зөвшөөрөл, бүртгэлийн хэлтсийн дарга гарын үсэг зурж, визийн тэмдэг дарж баталгаажуулна. Хилийн олон улсын нээлттэй боомт дээр олгосон визэд Албаны дарын эрх олгосноор албаны ажилтан гарын үсэг зурж, визийн тэмдэг дарж баталгаажуулна.

11. Удаа дараа виз, бүртгэлийн журам зөрчиж захиргааны шийтгэл хүлээсэн, түс улсын нутаг дэвсгэрээс албадан гаргах арга хэмжээ авагдсан буюу алан хядах байгууллагын гишүүн, нийгмийн онц аюултай халдварт өвчтэй, мансууруулах бодис хэрэглэгч, худалдан борлуулагч гэж үзэх үндэслэл бүхий этгээдэд болон хуульд заасан бусад үндэслэл байвал Монгол Улсад орох визийн зөвшөөрөл, виз олгохгүй байх, олгосон зөвшөөрөл, визийг хүчингүй болгож болно.

12. Монгол Улсын Өргөмжит консул гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас олгосон зөвшөөрлийг үндэслэн орох, орох-гарах, дамжин өнгөрөх виз олгох бөгөөд түүнд Өргөмжит консул гарын үсэг зурж, тамга дарж баталгаажуулсан байна.

Дөрөв. Бусад зүйл

13. Монгол Улсын виз авсан гадаадын иргэн паспортоо үрэгдүүлсэн, сольсон бөгөөд энэ журмын 18 дахь заалтад заасан хугацаа хэтрээгүй тохиолдолд уг визийг шинэ паспортад нөхөн олгож болно.

14. 30 хоногт багтан тус улсын нутаг дэвсгэрээс гарч чадахгүй болсон гадаадын иргэн, харьяалалгүй хүн визийн хугацаа дуусахаас гурав хоногийн өмнө үндэслэл бүхий хүсэлтээ гаргасан тохиолдолд Алба визийн хугацааг 30 хүртэл хоногийн хугацаагаар нэг удаа сунгаж болно.

15. Визийн хугацааг хэтрүүлсэн бол сунгахдаа хэтэрсэн хугацаат хасаж тооцно.

16. Визийг хүчингүй болгохдоо түүн дээр "хүчингүй" гэсэн дардас тавина.

17. Визийн хугацаат богиносгох тохиолдолд

уг визийг хүчингүй болгож зохих хугацааны визийг шинээр олгоно.

18. Монгол Улсад орох, орох-гарах виз нь олгосон өдрөөс хойш гурван сарын хугацаанд, гарах виз нь олгосон өдрөөс хойш арав хоногийн хугацаанд хүчин төгөлдөр байна.

19. Визийн үйлчлэх хугацааг Монгол Улсын хилийг нэвтэрсэн өдрөөс эхлэн тооцно.

20. Визийн хураамжийг Монгол Улсын Тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн дагуу ногдуулна.

21. Визэд гарын үсэг зурах албан тушаалтны гарын үсэг, дардасны загвар өөрчлөгдөх тохиолдолд гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон Алба хилийн цэргийн байгууллагад шинэ загварыг урьдчилан хүргүүлж хуучин загвар хүчингүй болмогц тэр даруй мэдэгдэх арга хэмжээ авна.

22. Гадаадын иргэнийг тус улсад урих урилын загварыг Албаны дарга батална. Ургилын болон түүнд гарын үсэг зурах албан тушаалтны гарын үсгийн загвар, тамга, тэмдэгний дардас, тэдгээрт орсон өөрчлөлтийн талаархи мэдээллийг Дипломат төлөөлөгчийн болон Консулын газарт хүргүүлэх үүргийг Алба, аймгийн Засаг даргын Тамгын газрын хууль зүйн хэлтэс хариуцна.

23. Виз олгох эрх бүхий байгууллага нь визтэй холбогдох материалыг архивын зааврын дагуу эмхлэн жил бүрийн 12 дугаар сарын 25-ны дотор Албанд ирүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр **Дугаар 73** **Улаанбаатар хот**

Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Ардын уламжлалт урлагийг дэмжих Үндэсний хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг дор дурдсанаар шинэчлэн батлагдсугай:

Дарга Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд

Нарийн бичгийн дарга-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны утга соёлын өвийн бодлого, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн

Гишүүд: -Санхүү, эдийн засгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Гадаад хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;

-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Соёл, урлагийн бодлого, зохицуулалтын газрын дарга;

-Нийслэлийн Засаг даргын дэргэдэх Соёлын газрын дарга;

-Соёл, урлагийн сангийн гүйцэтгэх захирал;

-Улсын ардын дуу, бүжгийн чуулгын уран сайхны удирдагч;

-Шинжлэх ухааны академийн Хэл зохиолын хүрээлэнгийн захирал;

-Соёл,урлаг судлалын хүрээлэнгийн захирал;

-Утга соёлын өвийн үндэсний төвийн тэргүүн /тохиролцсоноор/;

-Монголын урчуудын эвлэлийн хорооны дарга /тохиролцсоноор/;

-Монголын морин хуурын төвийн тэргүүн / тохиролцсоноор/;

-Монголын уртын дууны нийгэмлэгийн тэргүүн /тохиролцсоноор/;

-Ерөөлч, магтаалч нарын төвийн тэргүүн / тохиролцсоноор/;

-"Монгол хөөмий" төвийн тэргүүн / тохиролцсоноор/.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Үндэсний хөтөлберийг батлах тухай" Засгийн газрын 1999 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 68 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД **А.ЦАНЖИД**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр **Дугаар 74** **Улаанбаатар хот**

Зөвлөл байгуулах тухай

Монголын залуучуудын үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

ёсоор батлагдсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

Залуучуудын асуудлаархи Үндэсний зөвлөлийг байгуулж, бүрэлдэхүүнийг хавсралт

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД Ш.БАТБАЯР

Засгийн газрын 2001 оны 74 дүгээр тогтоолын хавсралт

ЗАЛУУЧУУДЫН АСУУДЛААРХИ ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга -Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.БАТБАЯР

Гишүүд:
-Улсын Их Хурлын гишүүн Б.ЭРДЭНЭБИЛЭГТ /өөртэй нь зөвшилцсөнөөр/;
-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Б.МИШИГЖАВ;
-Санхүү, эдийн засгийн яамны Эдийн засгийн хамтын ажиллагааны удирдлага, зохицуулалтын газрын дарга Х.АМАРСАЙХАН;
-Гадаад хэргийн яамны Олон талт хамтын ажиллагааны газрын захирал О.ЭНХЦЭЦЭГ;
-Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Д.ОДСҮРЭН;
-Эрүүл мэндийн яамны Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга Д.ОЮУНЧИМЭГ;
-Нийслэлийн Засаг даргын орлогч Ч.СУМААХҮҮ;
-Монголын залуучуудын холбооны ерөнхий нарийн бичгийн дарга Ч.ЗОРИГТБААТАР /өөртэй нь тохиролцсоноор/;
-Монголын ардчилсан социалист залуучуудын холбооны ерөнхийлөгч У.УЛАМБАЯР /өөртэй нь тохиролцсоноор/;
-Ардчилсан залуучуудын холбооны ерөнхийлөгч Г.БАТХҮҮ /өөртэй нь тохиролцсоноор/;
-"Оюутан төсөл" үндэсний төвийн тэргүүн Д.АРВИН /өөртэй нь тохиролцсоноор/
-"Скайтель" ХХК-ий ерөнхий захирал Д.ЭРДЭНЭБАТ /өөртэй нь тохиролцсоноор/.

Нарийн бичгийн дарга -Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Стратегийн төлөвлөлтийн газрын залуучуудын асуудал эрхэлсэн мэргэжилтэн Д.БИНДЭРЬЯА.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр **Дугаар 75** **Улаанбаатар хот**

Санхүү, эдийн засгийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрийг зөвшөөрөх,тус яамны бүтцийг шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

байгуулалтын бүтцийг дор дурдсанаар шинэчлэн баталсугай:

1. "Санхүү, эдийн засгийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр"-ийг хавсралт ёсоор зөвшөөрсүгэй.

а/эдийн засгийн нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газар;

б/төсвийн бодлого, зохицуулалтын газар:

2. Санхүү, эдийн засгийн яамны зохион

-орлого, татварын хэлтэс;
-зарлага, санхүүжилтийн хэлтэс.

в/төрийн захиргааны удирдлагын газар;

г/төрийн сангийн удирдлага, зохицуулалтын газар:

-төрийн сангийн зарлага, бүртгэл, арга зүйн хэлтэс;
-өрийн удирдлагын хэлтэс.

д/эдийн засгийн хамтын ажиллагааны удирдлага, зохицуулалтын газар;

е/салбарын хөгжлийн удирдлага, зохицуулалтын газар:

-бодит салбарын хэлтэс;

-санхүүгийн салбарын хэлтэс;
-нягтлан бодох бүртгэл, магадалгааны хэлтэс;

ж/мэдээлэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний газар:

з/худалдан авах ажиллагааны бодлого, зохицуулалтын хэлтэс.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Сангийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хэтөлбөрийг зөвшөөрөх, түр яамны бүтцийг батлах тухай" Засгийн газрын 1999 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 171 дүгээр тогтоол, "Яамдын зохион байгуулалтын бүтцийг батлах тухай" Засгийн газрын 2000 оны 8 дугаар сарын 23-ны өдрийн 131 дүгээр тогтоолын 1 дүгээр зүйлийн "б" заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН
ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

Засгийн газрын 2001 оны 75 дугаар тогтоолын хавсралт

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЦИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ХЭТӨЛБӨР

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Оршил

Санхүү, эдийн засгийн яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хэтөлбөр /цаашид "Хэтөлбөр" гэх/-т Санхүү, эдийн засгийн сайд, Засгийн газрын Танхимын шийдвэрийг боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд чиглэсэн үндэсний хөгжил, эдийн засгийн аюулгүй байдал, төсөв, санхүүгийн стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамж, төрийн захиргааны удирдлага, зохицуулалтаар хангах, хэтөлбөр, үндсэн чиглэл боловсруулах, тэдгээрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ (мониторинг) хийх, үнэлгээ өгөх, холбогдох арга хэмжээг зохицуулах, төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын асуудлыг хамарсан Санхүү, эдийн засгийн яамны үйл ажиллагааны стратегийн болон бүтцийн загварыг тодорхойлов.

1.2. Үндэслэл

Хэтөлбөрийг Улсын Их Хурлын 1996 оны 38 дугаар тогтоолоор зөвшөөрсөн "Монгол Улсын төрөөс Засгийн газрын үйл ажиллагааны чиглэл, бүтцийн ерөнхий тогтолцооны өөрчлөлт, шинэчлэлийн талаар баримтлах бодлого"-ын баримт бичиг, Улсын Их Хурлын "Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай" 2000 оны 32 дугаар тогтоол, Засгийн газрын Удирдлагын хөгжлийн хэтөлбөрийн "Төрийн захиргаа, төрийн албаны өөрчлөлт, шинэчлэл" бүрэлдэхүүн хэсгийн МОН/94/102 төслийн хүрээнд боловсруулсан "Сангийн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн ерөнхий загвар" төслийн тайлан, "Санхүү, эдийн засгийн яамны бүтцийг батлах тухай" Засгийн газрын 2000 оны 131 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн боловсруулав.

1.3. Хууль тогтоомжийн орчин

Санхүү, эдийн засгийн яамны үйл ажиллагааны үндэсн зарчим нь Үндсэн хуульд заасны дагуу ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, хууль дээдлэх явдал мөн. Санхүү, эдийн засгийн яам нь үйл ажиллагаанаасаа үндэсн зарчимд тулгуурлан, төрийн захиргааны төв байгууллагын зорилт, чиг үүргийг нарийвчлан тодорхойлсон энэхүү хэтөлбөрийг дор дурдсан хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлнэ:

- Монгол Улсын Үндсэн хууль,
- Монгол Улсын Засгийн газрын тухай хууль,
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль,
- Монгол Улсын Төрийн албаны тухай

хууль,
- Монгол Улсын Төсвийн тухай хууль,
- Монгол Улсын Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Бусад хууль тогтоомж.

1.4. Арга зүй

Хөтөлбөрийг боловсруулахад олон улсын шилдэг туршлага, өөрчлөлтийн удирдлага, үйл ажиллагаа (бизнес)-ны төлөвлөлт болон дахин инженерчлэл, байгууллагын өөрчлөлтийн зэрэг арга зүйг хэрэглэв.

1.5. Удирдлагын ерөнхий чиг үүргийн байгууллагын үүрэг хариуцлагын ерөнхий хуваарь

Засгийн газрын удирдлагын ерөнхий чиг үүргийн байгууллагын нэг болох Санхүү, эдийн засгийн яам нь Засгийн газрын үйл ажиллагааны стратегийг хэрэгжүүлэх талаар үүрэг хариуцлага хүлээж, Ерөнхий сайд, Санхүү, эдийн засгийн сайд, Засгийн газрын Танхимд санхүү, эдийн засгийн талын зөвлөлгөө өгч, дэмжлэг үзүүлнэ.


Санхүү, эдийн засгийн яам нь Засгийн газрын стратегийн бодлого, нэгдсэн төлөвлөлт болон бодлого, төсвийн зарцуулалтын тэнцвэр, харилцан уялдаа холбоог хангах асуудалд Засгийн газрын өндөрлөгөөс өргөн хүрээтэй хандаж, зөв зохистой удирдахад анхаарлаа төвлөрүүлнэ.

Засгийн газрын зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэх үүрэг бүхий Санхүү, эдийн засгийн яам нь Засгийн газрын санхүү, эдийн засгийн зөвлөхийн үүрэг хариуцлагыг хүлээнэ.

1.6. Стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр

Санхүү, эдийн засгийн яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэрт дор дурдсан үйлчлүүлэгч буюу хэрэглэгч хамрагдана:

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ЯАМНЫ СТРАТЕГИЙН УДИРДЛАГА, ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭРЭГЦЭЭНИЙ ЭХ ҮҮСВЭР



Санхүү, эдийн засгийн яамны үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгч нь Санхүү, эдийн засгийн сайд, Засгийн газрын Танхим байна.

Стратегийн удирдлага, зохицуулалт нь дээр дурдсан хэрэгцээний эх үүсвэр, үндсэн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийн эрэлт хэрэгцээг хангахтай холбогдон үүсэх олон төрлийн харилцааг зохицуулахад чиглэнэ.

Санхүү, эдийн засгийн яамны стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээг хангах үйлчилгээний хүрээ, төрөл, хэлбэрийг хэрэгцээний эх үүсвэр тус бүрээр тогтоон, тус яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүдийн зорилт, чиг үүрэг, төрийн албан хаагчдын ажлын байр (албан тушаал)-ны тодорхойлолтод нарийвчлан тусгаж хэрэгжүүлнэ.

ХОЁР. САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИ

2.1. Үйл ажиллагааны стратегийн мөн чанар

Санхүү, эдийн засгийн яамны үйл ажиллагааны стратегийн мөн чанар нь Монгол Улсын хөгжлийн үзэл баримтлал, Засгийн газрын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, хөтөлбөр, Санхүү, эдийн засгийн сайдын эрхлэх асуудлын хүрээний зорилт, чиг үүргийг хэрэгжүүлэхэд

чиглэсэн Санхүү, эдийн засгийн сайдын үйл ажиллагаанд өндөр мэргэшлийн, цаг үеэ олсон, шуурхай зөвлөлгөө өгч, бүх талын дэмжлэг үзүүлэхэд оршино.

2.2. Үйл ажиллагааны төрүүлэх чиглэл

Санхүү, эдийн засгийн яам нь дор дурдсан үйл ажиллагааны төрүүлэх чиглэлтэй ажилана:

1. Улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратеги, үндсэн чиглэл, эдийн засгийн аюулгүй байдлыг ханган бодлого боловсруулах, хэрэгжүүлэхэд шаардлагатай зөвлөлгөө, үйлчилгээгээр цаг тухайд нь ханган, Санхүү, эдийн засгийн сайд, Засгийн газрын Танхимд үйл ажиллагаагаа үр нөлөөтэй, үр ашигтай явуулахад нь бүх талын дэмжлэг үзүүлэх,

2. Засгийн газрын үйл ажиллагааны төрүүлэх чиглэл, хөтөлберт тусгагдсан эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэхэд бусад яам, газруудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, эдийн засаг, төсөв, санхүүгийн удирдлага, төлөвлөлт, зохицуулалтад шаардлагатай зөвлөлгөө, үйлчилгээгээр цаг тухайд нь ханган,

3. Эдийн засаг, төсөв, санхүүгийн удирдлагын чадавхийг нэмэгдүүлж, бүтэц, үйл ажиллагааг өөрчлөн, боловсронгуй болгох,

4. Эдийн засгийн шинэчлэл, зохицуулалт, бүтцийн өөрчлөлтийн нэгдсэн бодлого явуулах, бодит салбар, салбар хоорондын болон бүс нутгийн хөгжлийн бодлого боловсруулах,

5. Улс орны хөгжлийн ерөнхий чиг хандлага, бодлоготой уялдуулсан төсөв, санхүү, татвар, хөрөнгө оруулалт, даатгалын удирдлага, зохицуулалтыг ханган бодлого боловсруулж хэрэгжүүлэх,

6. Ямны хэмжээнд удирдлагын үр ашигтай арга барил, туршлага нэвтрүүлэх, тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог хөгжүүлэх замаар төрийн захиргааны удирдлагын мэнлайллыг ханган,

7. Гадаадын зээл, тусламжийн талаархи нэгдсэн бодлого, зохицуулалтыг боловсронгуй болгох, гадаад, дотоод ерийн менежментийг жинхэнэ ёсоор бий болгож, чанд мөрдүүлэх.

8. Нягтлан бодох бүртгэл, магадалгаа, санхүүгийн хяналт шалгалтын нэгдсэн бодлого, удирдлагаар ханган.

2.3. Үйл ажиллагааны эрхэм зорилго

Улсын Их Хурлын 1996 оны 38 дугаар тогтоолоор зөвшөөрөгдсөн бодлогын бичиг бичгийн 2.4, Засгийн газрын 1996 оны 205 дугаар тогтоолоор зөвшөөрөгдсөн хөтөлберт тусгагдсан арга зүйг үндэс болгож Санхүү, эдийн засгийн яамны эрхэм зорилгыг дараахь байдлаар томьёолж байна:

Санхүү, эдийн засгийн яамны үйл ажиллагааны эрхэм зорилго нь:

Үндэсний хөгжил, эдийн засгийн аюулгүй байдлыг ханган шаардлагад нийцсэн макро эдийн засгийн тактай орчин бүрдүүлэх, Засгийн газрын санхүүгийн оновчтой удирдлагаар ханган оршино

2.4. Үйл ажиллагааны стратегийн зорилт

Санхүү, эдийн засгийн яам нь эрхэм зорилгодоо хүрэхийн тулд стратегийн дор дурдсан зорилтуудыг хэрэгжүүлнэ:

1.Стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар ханган,

2.Төрийн захиргааны удирдлагын мэнлайллыг ханган,

3.Бодлогын хэрэгжилтийг зохицуулах,

4.Бодлогын хэрэгжилтийн явц, байдалд хяналт-шинжилгээ /мониторинг/, үнэлгээ хийх.

2.5. Үйл ажиллагааны гол зорилт

Санхүү, эдийн засгийн яамны үйл ажиллагааны стратегийн зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн дор дурдсан үйл ажиллагааны гол зорилтыг дэвшүүлэн ажиллана:

1.0. Үйл ажиллагааны стратегийн 1 дүгээр зорилтын хүрээнд:

1.1.Улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, үндсэн чиглэл боловсруулахад зөвлөлгөө өгч, дэмжлэг үзүүлэх;

1.2.Макро эдийн засгийн үндсэн тэнцвэрт харьцааг ханган зөвлөлгөө өгөх,

1.3.Төсөв, санхүү, татварын бодлого боловсруулахад зөвлөлгөө өгч, дэмжлэг үзүүлэх,

1.4.Эдийн засгийн бүтцийн өөрчлөлт, хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлого болон өмчийн бодлого боловсруулахад зөвлөлгөө өгч, дэмжлэг үзүүлэх,

1.5.Зах зээлийн харилцааны зарчимд нийцсэн нягтлан бодох бүртгэл, магадалгааны тогтолцоо бүрдүүлэх,

1.6.Засгийн газрын худалдан авах ажиллагааны бодлогыг боловсруулахад зөвлөлгөө өгөх.

2.0. Үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд:

2.1.Төрийн захиргааны удирдлагын мэнлайллыг ханган,

2.2.Хүний нөөцийг зохистой ашиглахад зөвлөлгөө өгч, нийтлэг үйлчилгээ үзүүлэх,

2.3.Сайдаас шийдвэр боловсруулан гаргахад эрх зүйн болон бусад дэмжлэг үзүүлэх,

2.4.Ямны үйл ажиллагааны үр ашиг,

нөлөөг дээшлүүлэх, тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог боловсронгуй болгох.

3.0. Үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд:

3.1.Улсын төсвийн хэрэгжилтийг зохицуулах,

3.2.Эдийн засгийн гадаад хамтын ажиллагааг хэрэгжүүлэх,

3.3.Засгийн газрын бэлэн мөнгө, өрийн удирдлага, зохицуулалтаар хангаж, санхүү бүртэлийн тогтолцоог бүрдүүлэх,

3.4.Бодит салбарын үйл ажиллагааг удирдлага зохицуулалтаар хангах,

3.5.Засгийн газрын санхүүгийн бүртгэлийн тогтолцоог бүрдүүлэх.

4.0. Үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд:

4.1.Эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлогын боловсруулалт, хэрэгжилтийн явц, байдалд хяналт-шинжилгээ (мониторинг) хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх,

4.2.Мэдээллийн тогтолцоог боловсронгуй болгох, мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээллийн үйлчилгээ үзүүлэх.


2.6. Үйл ажиллагааны зорилт

Санхүү, эдийн засгийн яамны үйл ажиллагааны гол зорилт тус бүрийн хүрээнд тэдгээрийг хэрэгжүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааны зорилтыг тус яамны газар, хэлтсийн ажил үүргийн хуваариар тодорхойлж хэрэгжүүлнэ.

2.7. Үйл ажиллагааны стратегийн загвар

Санхүү, эдийн засгийн яамны үйл ажиллагаа (бизнес)-ны стратегийн загварыг дор дурдсанаар тодорхойлж байна:

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ СТРАТЕГИЙН ЗАГВАР(БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨ)



ГУРАВ. САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЦИЙН ЕРӨНХИЙ ТӨГТОЛЦОО, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ, ТЭДГЭЭРИЙН ЧИГ ҮҮРЭГ

3.1. Бүтцийн ерөнхий төгтолцоо боловсруулахад баримтлах зарчим

Санхүү, эдийн засгийн яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий төгтолцоо, зохион байгуулалтын бүтцийг боловсруулахад дор дурдсан зарчмыг баримтална:

1. Засгийн газрын үйл ажиллагааны стратегитай уялдсан тухайн яамны стратегийн зорилтыг тусгасан байх зарчим (тухайн яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий төгтолцоо, зохион байгуулалтын бүтэц нь тус яамны үйл ажиллагааны стратегийн зорилттой уялдсан байх),

2. Эрх мэдлийн ялгаа заагг нь тодорхой, итгэл хүлээхүйц байх зарчим (бүтцийн нэгжүүдийн нэр нь аль нэгж ямар асуудал эрхэлдэг болохыг тодорхой мэдэж болохүйц байх, тэдгээрийн ажлын уялдаа, ажиллах чадвар нь итгэл хүлээхүйц байх),

3. Үзэгдэхүйц үйлчилгээний болон стратегийн удирдлагын баримжаатай байх зарчим (байгууллагын нэр, бүтцээс тухайн байгууллагын үйл ажиллагааны дүр төрх харагдахүйц байх, тухайлбал, яамны зохион байгуулалтын бүтэц, бүтцийн нэгжийн нэр нь тус яамны үйл ажиллагааны стратегийг тусгасан байх),

4. Бүтцийн хувьд энгийн байх зарчим (тухайн яамны Төрийн нарийн бичгийн даргаас хамгийн доод нэгжээ хүртэл аль болох цөөн шат дамжлагатай байх),

5. Тэнцвэрийг хангах, хяналтын хүрээг тогтоох зарчим (тухайн яамны үйл ажиллагааны стратеги, бүтэц хоёрын зөв зохистой тэнцвэрийг хангах замаар аль болох хялбар, шуурхай удирдах, хянах боломжтой байх, үйл ажиллагааны стратегийн зорилтыг аль болохоор оновчтой бүлэглэх замаар бүтцийн ерөнхий төгтолцоог тогтоосон байх),

6. Улс төрийн хувьд төвийг сахисан байх зарчим (тухайн яамны төрийн захиргааны албан хаагч нь сайд, Засгийн газар /Танхим/, бусад үйлчлүүлэгч буюу хэрэглэгчдэд улс төрийн аливаа нөлөөлөлд автахгүй, төвийг сахисан өндөр мэргэшлийн зөвлөлгөө, дэмжлэг, үйлчилгээ үзүүлдэг байх),

7. Хангалттай чадавхи, бодитой үйл ажиллагааны зарчим (үйл ажиллагааны бүтцийн ерөнхий төгтолцооны загвар, зохион байгуулалтын бүтэц нь чадавхиа бүрэн дүүрэн илрүүлэхэд чиглэсэн хэрэгжихүйц бөгөөд ажиллах чадвартай байх).

3.2. Үйл ажиллагааны бүтцийн ерөнхий төгтолцооны загвар

Дээр дурдсан зарчим болон Санхүү, эдийн засгийн яамны үйл ажиллагаа (бизнес)-ны стратегийн загварыг үндэслэн тус яамны үйл ажиллагааны бүтцийн ерөнхий төгтолцоо доорхи загвартай байна:

САНХҮҮ ЭДИЙН ЗАСГИЙН ЯАМНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БҮТЦИЙН ЕРӨНХИЙ ТОГТОЛЦООНЫ ЗАГВАР



3.3. Зохион байгуулалтын бүтэц

Санхүү, эдийн засгийн яамны үйл ажиллагаа (бизнес)-ны стратегийн болон бүтцийн ерөнхий тогтолцооны загвараас тус яамны зохион байгуулалтын бүтцийн дор дурдсан чиг үүрэг бүхий нэгж урган гарч байна:

1. Стратегийн удирдлага, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны нэгдүгээр зорилтын хүрээнд Санхүү, эдийн засгийн сайдын эрхлэх асуудлын хүрээнийд улс орны хөгжлийн бодлогыг тодорхойлоход чиглэгдсэн дараахь үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Монгол улсын хөгжлийн үзэл баримтлал, хэтийн бодлого боловсруулах, эдийн засгийн аюулгүй байдлыг ханган бодлогыг тодорхойлох,

- Макро эдийн засгийн бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр боловсруулах, биелэлтийг нэгтгэн дүгнэх, эдийн засаг, нийгмийн хөгжлийн бүсчилсэн болон салбарын хөгжлийн бодлого боловсруулах, макро эдийн засгийн үндэсэн тэнцвэрт харьцаат хангахад зөвлөлгөө өгөх, эдийн засаг, нийгмийн бодлогын хүрээнд хийгдэх салбарын өөрчлөлтийн бодлогыг тодорхойлох,

- Эдийн засгийн макро түвшинд уялдуулсан төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэл, мөнгө зээл, улсын өрийн нэгдсэн бодлогыг тодорхойлох, улсын төсвийн жилийн болон хэтийн төлөвлөгөө боловсруулах,

- Эдийн засгийн гадаад харилцаа, хамтын ажиллагааны бодлого болон олон улсын банк, санхүүгийн байгууллагуудтай харьцахад баримтлах зарчмыг тодорхойлох,

-Зах зээлийн харилцааны зарчимд нийцсэн санхүүгийн бүртгэл, магадалгааны тогтолцоог бүрдүүлэх,

- Аж ахуйн нэгж, байгууллагуудын санхүүгийн тайлан балансыг хүлээн авч нэгтгээд статистикийн үзүүлэлтийг гаргах,

- Засгийн газрын худалдан авах ажиллагааны бодлогыг олон улсын хөгжлийн хандлага, өөрийн орны нөхцөл байдалтай уялдуулах,

- "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэгч сонгох журмын тухай" хуулийн хэрэгжилтийг ханган зэрэг болно.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь Санхүү, эдийн засгийн сайд, Засгийн газрын Танхимын эдийн засаг, нийгмийн бодлогыг хэрэгжүүлэх ажиллагааны үр нөлөө, үр ашгийг дээшлүүлэхэд чиглэнэ.

Энэ нь Санхүү, эдийн засгийн сайд, Засгийн газрын Танхимаас улс орны эдийн засаг, нийгмийн хөгжлийн стратегийн төлөвлөлт, бодлогын удирдамжаар ханган хэрэгжүүлэх, сайдын шийдвэр боловсруулан гаргах механизмд дэмжлэг үзүүлэх, Засгийн газрын гишүүн, Санхүү, эдийн засгийн сайдыг шаардлагатай мэдээлэл, өндөр мэргэшлийн, цаг үеэ олсон шуурхай зөвлөлгөө, үйлчилгээ, бүх талын дэмжлэгээр ханган хамааг зэрэгцүүлэх.

Тус нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Санхүү, эдийн засгийн сайд, Засгийн газрын Танхим байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь чиглэлийн яамд, тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагууд, нутгийн захирганы байгууллагууд байх болно.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Гадаад хэргийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Монгол банк, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар байна.

2. Төрийн захиргааны удирдлагад эрх зүйн дэмжлэг үзүүлэх асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 2 дугаар зорилтын хүрээнд төрийн захиргааны болон хүний нөөцийн удирдлагын мanлайллыг ханган үндсэн үүргийг хүлээж, яамны үйл ажиллагаанд удирдлагын шилдэг тэрүүний туршлага, арга зүйг нэвтрүүлэх, хүний нөөцийн удирдлага, хөгжлийн асуудлыг шийдвэрлэх, ажлаа тайлагнах, хариуцлага тооцох тогтолцоог хөгжүүлэх, Санхүү, эдийн засгийн сайд, захиргааны удирдлагад эрх зүйн дэмжлэг үзүүлэх үндсэн үүргийг хүлээж, эдийн засаг, санхүүгийн холбогдолтой хууль эрхийн баримт бичгийг боловсруулах, тэдгээрт нэмэлт, өөрчлөлт оруулах, санал боловсруулах, Санхүү, эдийн засгийн сайдын эрхлэх үүрэзнийг асуудлыг зохицуулж буй хууль тогтоомжийг боловсронгуй болгох чиглэлээр тус яамнаас дангаар болон бусад яам, газруудтай хамтран боловсруулах хууль тогтоомжийн төсөл дээр хамтран ажиллах, Санхүү, эдийн засгийн сайдын эрхлэх асуудал, бүрэн эрхийн хүрээнд нийтээр дагаж мөрдүүлэх дүрэм, журам, заавар боловсруулах, УИХ, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилтийн явц, биелэлтэд нь хяналт тавих, гүйцэтгэлийг гаргах, шинээр гарсан хууль тогтоомжид эрх зүйн баримт бичиг нийцэж байгаа эсэхийг хянаж, зөрчлийг арилгах арга хэмжээ авах,

Санхүү, эдийн засгийн сайдын эрхлэх асуудлаар гадаад, дотоодын төр, засгийн байгууллага, хуулийн этгээдтэй хийх гэрээ, хэлэлцээрийн төсөлд эрх зүйн талаар зөвлөлгөө өгөх, хууль, эрх зүйн баримт бичгийн бүртгэл, лавламжийн санг хөтлөж, өөрчлөлт хөдөлгөөнийг тогтмол тусгах зэрэг үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь эдийн засаг, санхүүгийн холбогдолтой хууль, эрх зүйн баримт бичгийг боловсруулан гаргахад хууль, эрх зүйн дэмжлэг үзүүлэх цомхон, чадварлаг төрийн захиргааны мэргэшсэн албаны хүчээр ямны тасралтгүй, хэвийн, жигд ажиллагаат хангахад чиглэнэ.

Энэ нь Санхүү, эдийн засгийн сайдад болон ямны аппаратад шийдвэр боловсруулан гаргах, хэрэгжүүлэхэд дотоод үйлчилгээ үзүүлэх, ямны газар, хэлтэс хоорондын ажлын уялдаат хангах, дотоод дэг журам, ажил хэрэгч шуурхай байдлыг хангах, эдийн засаг, санхүүгийн салбарын бүх шатанд ажиллах мэргэжилтэнг бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, тэдний нийгмийн баталгаат бий болгоход дэмжлэг үзүүлэх, удирдлагын соёл, чадавхийг дээшлүүлэх, аппаратыг албан хэргийн техник хэрэгсэл, бусад шаардлагатай зүйлээр хангаж үйлчлэх замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Санхүү, эдийн засгийн сайд, дэд сайд, Төрийн нарийн бичгийн дарга, ямны зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, төрийн захиргааны албан хаагчид, холбогдох тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагууд байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь бүх шатны санхүү, татвар, гааль, санхүүгийн хяналт шалгалтын байгууллага, нутгийн захиргааны байгууллага, тэдгээрийн удирдлага байна.

Үйлчилгээ үзүүлэхэд оролцох гол түлш нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Гадаад хэргийн яам, салбарын яамд, агентлагууд, аймаг, нийслэлийн Засаг дарга нар, гадаадын зарим улс, олон улсын байгууллагууд байна.

3. Бодлогын хэрэгжилтийг зохицуулах асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 3 дугаар зорилтын хүрээнд Санхүү, эдийн засгийн сайдын эрхлэх асуудлын хүрээний бодлогын хэрэгжилтийг зохицуулахтай холбогдсон дараахь үндсэн чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Улс орны эдийн засгийн болон төсөв, санхүү, татвар, мөнгө зээл, хөрөнгө оруулалт, бүтцийн өөрчлөлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулахтай холбогдсон арга хэмжээг авч хэрэгжүүлэх, хөгжлийн төлөв байдлыг үнэлэх,

- Төвлөрсөн төсвийн гүйцэтгэлийг зохион байгуулах, төсвийн урсгал тэнцлийг хангах, төсвийн алдагдал нөхөх эх үүсвэрийг тогтоох, улс орны санхүүгийн нөөцийг гадаад, дотоод эх үүсвэрээс арвижуулах, түүнийг оновчтой зөв хуваарилж зохицуулах,

- Засгийн газрын дансуудыг хөтлөх, тэдгээрийн урсгал зарцуулалтад хяналт тавих, төсвийн гүйцэтгэлийн тайланг хүлээн авах, нэгдсэн тайланг гаргах, төсөвт байгууллагуудын санхүү бүртгэлийг хөтлөх, Засгийн газрын нягтлан бодох бүртгэлийн асуудлаар арга зүйн зөвлөгөө өгөх, тайлан тэнцлийн маягт, аргачлалыг боловсруулах, улсын ерийн хэрэгжилтийг зохицуулах, бэлэн мөнгөний төлөвлөлт хийх, Засгийн газрын зээл, бонд, үнэт цаас гаргах, хэрэгцээт төгөөс, хөвлөх үйл ажиллагааг гүйцэтгэх, Засгийн газрын зээлийн баталгаа гаргах,

- Салбарын өөрчлөлтийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах, төрийн өмч, өмч хувьчлалын бодлогыг хэрэгжүүлэх, эдийн засаг, нийгмийн бүсчилсэн болон салбарын хөгжлийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах, төвлөрсөн төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавих, банк, санхүүгийн салбарын нийтлэг асуудлыг зохицуулах,

- Эдийн засгийн гадаад харилцаа, хамтын ажиллагаа, түүний хэрэгжилт, гадаад орон, олон улсын банк санхүүгийн байгууллагатай хамтран ажиллах хөтөлбөр болон зээл, тусламжийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах эдгээр болно.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь Монгол Улсын төсвийн орлогын бүрдүүлэлтийг хангах, төсвийн зарлагын оновчтой бүтцийг бий болгох, төсвийн тэнцэл, Засгийн газрын дансны хөрөнгийн урсгал зарцуулалтыг хангах болон хөрөнгийн ашиглалтын тайлан, мэдээллийг цаг тухайд нь гаргуулах замаар төсвийн хөрөнгийг үр ашигтай ашиглах, гадаад орон, олон улсын санхүүгийн байгууллагатай хамтран ажиллах болон зээл, тусламжийн асуудлаар бодлого боловсруулах, түүний хэрэгжилтийг зохицуулахтай холбогдсон шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэх, Санхүү, эдийн засгийн сайдыг шаардлагатай мэдээлэл, өндөр

мэргэшлийн, цаг үеэ олсон шуурхай зөвлөлгөө, үйлчилгээ, бүх талын дэмжлэгээр хангах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Санхүү, эдийн засгийн сайд, Засгийн газрын Танхим байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь бусад яамд, Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагууд, нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, улсын төсөөс санхүүжилт авдаг газрууд, иргэд, бусад хэрэглэгчид байна.

Үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Гадаад хэргийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Монгол банк, Төрийн өмчийн хороо, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар байна.

4. Мэдээллэл, хяналт-шинжилгээ, үнэлгээний асуудал эрхэлсэн зохион байгуулалтын бүтцийн нэгж, түүний үндсэн үүрэг, чиг үүрэг

Энэ нэгж нь үйл ажиллагааны стратегийн 4 дүгээр зорилтын хүрээнд бодлогын хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийх, үнэлгээ өгөх үндсэн үүргийг хүлээж, бодлого, төлөвлөгөө, хөтөлбөр, төслийн боловсруулалт, хэрэгжилтийн явц байдал, Санхүү, эдийн засгийн сайдаас харьяа агентлагийн дарга нартай байгуулах үйл ажиллагааны үр дүнгийн гэрээний биелэлтэд хяналт-шинжилгээ /мониторинг/ хийх, үр дүнд нь үнэлгээ өгөх, шаардлагатай мэдээлэл, зөвлөлгөө, дэмжлэгээр хангах, мэдээллийн сүлжээ, сан бүрдүүлэх, мэдээллээр үйлчлэх зэрэг чиг үүргийг хэрэгжүүлнэ.

Энэ нэгжийн үйл ажиллагаа нь яамны бодлого боловсруулах, түүний хэрэгжилтийг зохицуулах, төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэхэд чиглэнэ.

Энэ нь Санхүү, эдийн засгийн сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгж, тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагт бодлого боловсруулах, түүнийг хэрэгжүүлэх ажлыг сайжруулахтай холбогдсон зөвлөлгөө, үйлчилгээ, дэмжлэг үзүүлэх, шаардлагатай мэдээллээр хангах замаар хэрэгжинэ.

Энэ нэгжээс үзүүлэх үйлчилгээний үндсэн хэрэглэгч нь Санхүү, эдийн засгийн сайд, яамны Төрийн нарийн бичгийн дарга, зохион байгуулалтын бүтцийн нэгжүүд, Засгийн газрын холбогдох тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагууд байх бөгөөд шууд бус хэлбэрээр энэ үйлчилгээг хэрэглэгч нь бусад яамд, аж ахуйн нэгж, байгууллагууд байна.

Энэ үйлчилгээг үзүүлэхэд оролцох гол түнш нь Засгийн газрын Хэрэг эрхлэх газар байна.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 4 дүгээр сарын 4-ний өдөр **Дугаар 76** **Улаанбаатар хот**

Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах холбогдуулан "Ногоон хувьсгал" хөтөлбөрийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр хавсралт ёсоор, "Цагаан хувьсгал" хөтөлбөрийн зөвлөлийн бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралт ёсоор тус тус шинэчлэн батлуулсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Засгийн газрын комисс, Үндэсний зөвлөл, хороо, ажлын хэсгийн тухай" Засгийн газрын 1996 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 238 дугаар тогтоолын 5 дугаар зүйл, "Ногоон хувьсгал" үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Засгийн газрын 1997 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн 199 дүгээр тогтоолын 4 дүгээр зүйл, "Хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 1999 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн 105 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт, "Хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 1999 оны 4 дүгээр сарын 21-ний өдрийн 64 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт, "Хөтөлбөр батлах тухай" 1998 оны 7 дугаар сарын 22-ны өдрийн 128 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД **Д.НАСАНЖАРГАЛ**

Засгийн газрын 2001 оны 76 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

"НОГООН ХУВЬСГАЛ" ХӨТӨЛБӨРИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	-Хүнс, хөдөө аж ахуйн сайд
Орлогч дарга Гишүүд:	-Хүнс, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн дарга -Засгийн газрын тохируулагч агентлаг- Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн улсын хяналтын албаны дарга; -Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг- Улсын нөөцийн газрын дарга; -Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Газрын хэрэг эрхлэх газрын дарга; -Санхүү, эдийн засгийн яамны Төсвийн бодлого, зохицуулалтын газрын дарга; -Гадаад хэргийн яамны Олон талт хамтын ажиллагааны газрын захирал; -Хүнс, хөдөө аж ахуйн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга; -Хүнс, хөдөө аж ахуйн яамны Стратегийн төлөвлөлт, бодлогын газрын дарга; -Байгаль орчны яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга; -Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Бага, дунд боловсролын бодлого, зохицуулалтын газрын дарга; -Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга; -Эрүүл мэндийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга; -Улаанбаатар хотын ерөнхий менежер бөгөөд Захирагчийн албаны дарга; -Ядуурлыг бууруулах хөтөлбөрийн газрын дарга; -Хөдөө аж ахуйн их сургуулийн захирал; -Хөдөө аж ахуйн их сургуулийн Ургамал, газар тариалангийн сургалт, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал; -Монголын радио, телевизийн хэрэг эрхлэх газрын дарга.
Нарийн бичгийн дарга	-Хүнс, хөдөө аж ахуйн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Газар тариалан, техник, технологийн хэлтсийн мэргэжилтэн.

Засгийн газрын 2001 оны 76 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

"ЦАГААН ХУВЬСГАЛ" ХӨТӨЛБӨРИЙН ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	-Хүнс, хөдөө аж ахуйн сайд
Орлогч дарга	-Хүнс, хөдөө аж ахуйн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга
Гишүүд:	-Засгийн газрын тохируулагч агентлаг- Хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн улсын хяналтын албаны дарга; -Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Гадаад хүдалдаа, гадаадын хөрөнгө оруулалтын газрын дарга; -Санхүү, эдийн засгийн яамны Төсвийн бодлого, зохицуулалтын газрын дарга; -Гадаад хэргийн яамны Олон талт хамтын ажиллагааны газрын захирал; -Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга; -Байгаль орчны яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга; -Хүнс, хөдөө аж ахуйн яамны Стратегийн төлөвлөлт, бодлогын газрын Гадаад харилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн дарга; -Засгийн газрын тохируулагч агентлаг-Үндэсний татварын ерөнхий газрын Бодлого зохицуулалтын хэлтсийн дарга; -Улаанбаатар хотын ерөнхий менежер бөгөөд Захирагчийн албаны дарга; -Монголын радио, телевизийн хэрэг эрхлэх газрын дарга; -Эрүүл мэндийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн мэргэжилтэн; -Ядуурлыг бууруулах хөтөлбөрийн газрын дарга; -"Хүнс тех" корпорацийн эрдэмтэн нарийн бичгийн дарга; -Нийгмийн эрүүл мэндийн хүрээлэнгийн Хоол судлалын төвийн захирал; -Сүү үйлдвэрлэгч, боловсруулагчдын холбооны нарийн бичгийн дарга (тохиролцсоноор); -Монгол цагаан идээ үйлдвэрлэгчдийн холбооны төрөлтүүлэгч гишүүн (тохиролцсоноор).
Нарийн бичгийн дарга	-Хүнс, хөдөө аж ахуйн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын Мал аж ахуй, үсжүүлэлтын хэлтсийн мэргэжилтэн.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 21 (208)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Нэмэлт зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай*
- *Гэрээ соёрхон батлах тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *Үндсэн чиглэл батлах тухай*

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

- *Шүүгчийг чөлөөлөх тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Улсын нөөцөөс тариалт үргэлжлүүлэн үр гаргаж, нөхөн бүрдүүлэх тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2001 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2001 оны зургадугаар сарын 1 №21 (208)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

270. Нэмэлт зээлийн хэлэлцээр соёрхон батлах тухай (2001-5-10-ны хууль) 573

271. Гэрээ соёрхон батлах тухай (2001-5-17-ны хууль) 574

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

272. Прокурорын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, цалингийн санг тогтоох тухай тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Дугаар 43 574

273. Үндсэн чиглэл батлах тухай Дугаар 44 574

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

274. Шүүгчийг чөлөөлөх тухай Дугаар 119 603

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

275. Журам батлах тухай Дугаар 78 603

276. Монгол хэлтэн үндэстний театрын олон улсын наадам зохион байгуулах тухай Дугаар 79 604

277. Улсын нөөцөөс таримал ургамлын үр гаргаж, нөхөн бүрдүүлэх тухай Дугаар 80 604

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 5 дугаар сарын 10-ны өдөр **Улаанбаатар хот**

НЭМЭЛТ ЗЭЭЛИЙН ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газрын Сэргээн босголтын зээлийн банк хооронд 2001 оны 2 дугаар сарын 12-ны өдөр байгуулсан Чойбалсан дахь Дулааны цахилгаан станцыг шинэчлэх төслийн Нэмэлт зээлийн Хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батлагдсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА **Ж.БЯМБАДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 5 дугаар сарын 17-ны өдөр — Улаанбаатар хот

ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Монгол Улс, Азийн хөгжлийн банкны хооронд 2001 оны 2 дугаар сарын 16-ны өдөр байгуулсан Хөдөө аж ахуйн салбарын хөгжлийн хөтөлбөрийн зээлийн Гэрээ болон Хөдөө аж ахуйн хөгжлийн төслийн зээлийн Гэрээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр тус тус соёрхон батлагдсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 5 дугаар сарын 17-ны өдөр — Дугаар 43 — Улаанбаатар хот

Прокурорын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, цалингийн санг тогтоох тухай тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн тавин зургадугаар зүйлийн 3 дахь хэсэг, Прокурорын байгууллагын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1."Прокурорын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, цалингийн санг тогтоох тухай" Улсын Их Хурлын 1993 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын "Хөөр. Сум дундын прокурорын газар" гэсэн хэсэгт дор дурдсан агуулгатай 8 дахь заалт нэмсүгэй:

"8.Хэнтий аймаг дахь сум дундын прокурорын газар	Бор-Өндөр хот	Галшар, Дэлгэрхаан, Баянмөнх, Дархан сум, Бор-Өндөр хот"

2. ."Прокурорын байгууллагын бүтэц, зохион байгуулалт, цалингийн санг тогтоох тухай" Улсын Их Хурлын 1993 оны 7 дугаар сарын 9-ний өдрийн 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтын "Нэг. Сумын прокурорын газар" гэсэн хэсгийн 5 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 5 дугаар сарын 18-ны өдөр — Дугаар 44 — Улаанбаатар хот

Үндсэн чиглэл батлах тухай

Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын хууль тогтоомжийг 2004 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэлийг хавсралт ёсоор батлагдсугай.

2.Монгол Улсын хууль тогтоомжийг 2004 он хүртэл боловсронгуй болгох Үндсэн чиглэлийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Байнгын хороодын дарга нар, Тамгын газар /Д.Батбаатар/-т даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА Ж.БЯМБАДОРЖ

№	Хуулийн төслийн нэр	Хариуцан боловсруулах байгууллага	Хугацаа	Тайлбар
	НЭГ. НИЙГМИЙН БОДЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР:			
1	Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	2001	Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлыг хангах, цацраг үүсгүүр, цацраг идэвхт ашигт малтмалыг ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулах
2	Эх хэлний тухай	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	2001-2002	Энэ хууль нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр Монгол Улсын иргэд эх хэлээрээ харилцах, мэдээлэл солилцох, суралцах, соёл, урлаг, шинжлэх ухааны үйл ажиллагаа явуулах болон монгол үндэстний утга зохиолын хэлний нийгмийн үүргийг нэмэгдүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлэх, хэм хэмжээг боловсронгуй болгох харилцааг зохицуулах юм.
3	Соёлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	2001-2002	Соёлын зарим дэд салбар, урлагийн үйл ажиллагааг зохицуулах эрх зүйн асуудлуудыг тусгах
4	Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	2002	Урлагийн зарим нарийн мэргэжлийн хүмүүсийн 60, 55 наснаас өмнө тэтгэвэр тогтоолгох тодорхой нөхцөл, болзлыг хуульчлан баталгаажуулах
5	Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	2001	Түүх, соёлын дурсгалт зүйлээс гадна утга соёлын өв буюу бодит, бодит бус соёлын өвийг хамгаалахтай холбогдсон бүхий л харилцааг зохицуулах

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

2001 он, №21 (208)

6	Боловсролын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	2001	Сургуулийн өмнөх болон бага, дунд боловсрол, мэргэжлийн сургуулиудын бүтэц, уялдаа холбоог сайжруулах, боловсролын байгууллагын удирдах зөвлөлийн үйл ажиллагаа, боловсролын санхүүжилт зэргийг боловсронгуй болгох
7	Эмийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Эрүүл мэндийн яам	2001	Эмийн нэгдсэн бодлогын хүрээнд эм, тарилгын хангамжийг сайжруулж, чанарын хяналтыг хүчтэй болгох
8	Мансууруулах эм, сэтгэц нөлөөт бодисын хууль бус эргэлтийн эсрэг НҮБ-ын 1988 оны нэгдсэн Конвенцид нэгдэх тухай	Эрүүл мэндийн яам	2001	Мансууруулах бодисын эсрэг, тэр тусмаа мансууруулах үйлчилгээ үзүүлдэг эм, хүний сэтгэцэд нөлөө үзүүлдэг бодисыг хууль бусаар хэрэглэх, ашиглах, худалдан борлуулах зэрэг үйлдлүүдийг хязгаарлах, таслан зогсоох чиглэлээр тодорхой арга хэмжээ авах шаардлагын үүднээс энэхүү Конвенцид нэгдэх
9	Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Эрүүл мэндийн яам	2001-2004	Эрүүл мэндийн даатгалын бие даасан тогтолцоо бий болгох, хүн амд үзүүлэх эрүүл мэндийн тусламжийг чанартай, баталгаатай болгох
10	Биеийн тамир, спортын тухай	Эрүүл мэндийн яам	2001	Биеийн тамир, спортыг хөгжүүлэх төрийн бодлогын үндсийг тодорхойлох, биеийн тамир, спортын байгууллагуудын эрх хэмжээ, удирдлага, зохион байгуулалт, үйл ажиллагааны үндсийг тодорхойлох, биеийн тамир, спорттой холбогдсон нийгмийн харилцааг зохицуулсан хууль тогтоомжийг шинэчлэх үндсийг бүрдүүлэх
11	Тамхины хор хөнөөлтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Эрүүл мэндийн яам	2001	Хуулийн нэр томъёонд тайлбар өгөх, тамхины хор хөнөөлтэй тэмцэх талаар баримтлах бодлогыг тодруулах, “Олон улсын тамхины хяналтын ерөнхий Конвенц”-ийн дагуу дэлхий нийтээрээ баримтлах зарим асуудлуудыг нэмж тусгах

12	Эрүүл мэндийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Эрүүл мэндийн яам	2001	Эрүүл мэндийн тухай хуулийн 13 дугаар зүйлд нэмэлт, өөрчлөлт оруулах
13	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих тухай	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам	2001	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төрийн бодлого, үйл ажиллагааны төрөл, хэлбэр, хамрах хүрээ, санхүүжилт, хөдөлмөр эрхлэлтийн байгууллагын эрх зүйн үндсийг тодорхойлох, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулах
14	Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам	2002	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин, хурц хордлогын улмаас тахир дутуу болсон иргэдийн тэтгэвэр авч байх хугацааны тэтгэврийн даатгалын шимтгэл болон тэднийг асрах, сувилах, эмчлэх зардлыг үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас олгож байх асуудлыг тусгах
15	Ажиллах хүч гадаадад гаргах, гадаадаас авах	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам	2001	Монгол Улсын иргэнийг гадаадад болон гадаадын иргэнийг Монгол Улсад хөдөлмөр эрхлүүлэх, тэдний эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулах
16	Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам	2002	Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах тухай хуулийг боловсронгуй болгох, хэрэглэгчдийн эрх ашиглах холбоотой шинээр бий болж буй харилцааг хуульчлах
17	Нийгмийн халамжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам	2001	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт туссан зорилтуудыг хэрэгжүүлэх эрх зүйн орчин бүрдүүлэх

18	Нийгмийн даатгалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам	2002	Малчин, хувираа хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн даатгалын заавал даатгуулах хэлбэрт хамруулах эрх зүйн орчин бүрдүүлэх
19	Техникийн болон мэргэжлийн анхан ба дунд шатны боловсролын тухай	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам	2001	Хөдөлмөр эрхэлтийг дэмжих тухай хууль батлагдсантай холбогдуулан хөдөлмөр эрхлэлтийн албанд бууртэгдсэн болон тухайн жилд 8, 10 дугаар анги төгсөгчид, цэргийн албанаас халагдсан ажил, мэргэжилтэй хүмүүст техникийн болон анхан, дунд шатны боловсрол олгох эрх зүйн үндэс тавигдах орчин бүрдүүлэх
20	Ахмад настан, түүнд үзүүлэх хөнгөлөлт, үйлчилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Эрүүл мэндийн яам	2002	Одоо үйлчилж байгаа хуулиар ахмадуудад хөнгөлөлт үзүүлж байгаа түлээ, нүүрсний болон талбайн хөлсний үнийг, биет мөнгөөр нь олгож байхаар өөрчлөх
21	Хөдөлмөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Эрүүл мэндийн яам	2001-2002	Хөдөлмөрийн тухай хуулийн 111 дүгээр зүйлийн холбогдох заалтууд амьдралд хэрэгжихгүй байгаа учир тахир дутуу иргэдийг ажиллуулаагүй аж ахуйн нэгж, байгууллагын төлбөрийг хөдөлмөр эрхэлтийг дэмжих сан шилжүүлэх, хөдөлмөрийн хэвийн бус нөхцөлд ажиллагдын эрх ашгийг хамгаалах асуудлаар зохих өөрчлөлт оруулах
22	Хүүхдийн хамгаалах хуульд өөрчлөлт тухай	эрхийг тухай нэмэлт, оруулах	УИХ-ын гишүүн Н.Болормаа	2002	Хүүхдийн эрхийг хамгаалах эрх зүйн орчныг боловсронгуй болгох, төрөөс хүүхэд, гэр бүлийн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны бүтэц, тогтолцоог шинэчлэх зорилгоор хуульд зохих нэмэлт, өөрчлөлт оруулах

23	Нийгмийн хувьчлал тухай	салбарт явуулах	УИХ-ын гишүүн Д.Оюунхорол	2001-2002	Нийгмийн салбарын үйл ажиллагааны чанар, үр егөөжийг дээшлүүлэх, төсөв, санхүүгийн талаар төрийн ачаалыг багасгах, салбарын онцлогыг тусгасан өмч хувьчлалын эрх зүйн орчин бүрдүүлэх
			ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР:		
1	Иргэний хууль		Хууль зүй, дотоод хэргийн яам	2001	Дэлхийн нийтийн эдийн засаг, эрх зүйн харилцааны түгээмэл тогтлыг өөрийн орны хөгжлийн чиг хандлагатай нийцүүлэн загварчлан хуульчлах, иргэний эрх зүйн харилцаанд оролцогчдын эрх тэгш байдлыг хангах, өмчийн бүх төрөл, хэлбэрийг чөлөөтэй, тэгш хөгжүүлэх эрх зүйн механизмыг нарийвчлан тодорхойлох, гэрээний харилцаанд гэрээний эрх чөлөөний зарчим, төрийн зохицуулалтыг илүү оновчтой болгох
2	Үнэт цаасны хөрөнгө оруулалтын сангийн тухай		Санхүү, эдийн засгийн яам	2003	Хөрөнгийн зах зээл дээр хөрөнгө оруулалтын сангууд үйл ажиллагаа явуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах, тэдгээр эрсдэлд орохоос сэргийлэх, бий болоод байгаа хөрөнгө оруулалтын сангуудын үйл ажиллагаг идэвхжүүлэх
3	Гадаадын	зээл тусламжийг зохицуулах тухай	Санхүү, эдийн засгийн яам	2001	Гадаадын зээл, тусламжийг үр дүнтэй ашиглах, захиран зарцуулах механизмыг бүрдүүлэх, гадаадын зээл, тусламжийн талаарх төрийн байгууллагуудын эрх хэмжээг тодорхой болгох, эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгох

4	Зээлийн болон бусад өрийг барагдуулах тухай	Санхүү, эдийн засгийн яам	2001	Зээлийн өр төлбөрийг барагдуулах, банкны өр барагдуулах албаны үйл ажиллагаат зохицуулах
5	Санхүүгийн хяналт шалгалтын тухай	Санхүү, эдийн засгийн яам	2001	Санхүүгийн улсын хяналт шалгалтыг явуулах чиглэл, зарчим, журам болон уг хяналтыг хэрэгжүүлэх байгууллагын тогтолцоог хуульчлан батлагаажуулах
6	Санхүүгийн түрээсийн тухай	Санхүү, эдийн засгийн яам	2002	Санхүүгийн түрээс, түүнийг эрхлэх аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа, зөвшөөрөл, өөрийн хөрөнгө, түүнд тавигдах шаардлага, түрээсийн гэрээ, гэрээний талуудын эрх, үүргийг зохицуулах
7	Үнэт цаасны тухай	Санхүү, эдийн засгийн яам	2002	Үнэт цаас гаргах, арилжих талаархи маргаан, түүнийг шийдвэрлэх үйл ажиллагааны журмыг тодорхой болгох, үнэт цаасны нэр төрлийг нэмэгдүүлэх, Үнэт цаасны хороо болон Хөрөнгийн биржийн харъяалалыг оновчтой болгох, үнэт цаасны холбогдолтой дотоод мэдээллийн ангилалыг тогтоох, хөрөнгийн зах зээлийн харилцааг боловсронгуй болгох
8	Үнэлгээний тухай	Хууль зүй, дотоод хэргийн яам	2002	Үнэлгээний эрх зүйн зохицуулалтыг бий болгох, үнэлгээг нэг мөр, үндэслэл бүхий тогтоодог байх нөхцөлийг бүрдүүлэх, үнэлгээний байгууллагуудын үйл ажиллагаат зохицуулах
9	Арбитрын тухай	Хууль зүй, дотоод хэргийн яам	2001	Арбитрын үйл ажиллагаат зохицуулах эрх зүйн орчныг боловсронгуй болгох, дэлхийн нийтийн жишиг хэмжээнд дагуу арбитрыг төлөвшүүлэх, хөгжүүлэх.

10	Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай	Хууль зүй, дотоод хэргийн яам	2001	Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагад бизнес эрхлэх таатай орчин бүрдүүлэх, хүнд суртал, авилгалыг багасгах, аж ахуйн үйл ажиллагаа эрхлэхэд шаардагдах тусгай зөвшөөрлийн тоог цөөлөх, эрх зүйн зохицуулалтыг нь боловсронгуй болгох
11	Зар сурталчилгааны тухай	Хууль зүй, дотоод хэргийн яам	2002	Шинээр үүсэн хөгжиж байгаа реклам, зар сурталчилгааны эрх зүйн зохицуулалтыг бий болгох, цаашдын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох ажилд эрх зүйн зохицуулалтаар дамжуулан нөлөөлөх, зар сурталчилгаа хийж байгаа этгээдийн үйл ажиллагааг зохицуулах
12	Төсвийн тухай	Санхүү, эдийн засгийн яам	2002	Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хуультай уялдуулах
13	Татварын багц хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Санхүү, эдийн засгийн яам, Үйлдвэр, худалдааны яам	2001-2004	Татварын ачааллыг бууруулах татварын тогтолцоог төгөлдөржүүлэн, татвар ногдуулалт, хураалт, түүнд тавих хяналт шалгалт, татвар төлөгчийн бүртгэлийн асуудлыг нарийвчлан тусгах
14	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Санхүү, эдийн засгийн яам	2001-2004	Өмч хувьчлал, төрийн өмчийн байрын түрээсийн орлогыг төсөвт төвлөрүүлэх, төрийн өмчийн хорооны удирдлага, үйл ажиллагааны талаар тусгах
15	Мөнгөн хадгаламж, төлбөр, тооцоо, банкны зээлийн үйл ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Санхүү, эдийн засгийн яам	2001	Банкны зээл олгохтой холбогдсон зүйл заалтуудыг шинэчлэх, банк болон банкны эрх бүхий албан тушаалтанд ногдуулах хариуцлагыг чангатгах

16	Аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Санхүү, эдийн засгийн яам	2001	Нягтлан бодох бүртгэлийн мэргэжлийн зөвлөлийн үйл ажиллагаатай холбогдсон зүйл, заалтуудыг тодорхой болгох, мэргэшсэн нягтлан бодогч нарын үйл ажиллагааг нарийвчлан зааж өгөх, тэдгээрийн хариуцлагын асуудлыг тодорхой болгох, дотоод аудитын асуудлыг шинээр тусгах	
17	Хэмжлийн нэгдмэл байдлыг хангах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Үйлдвэр, худалдааны яам	2003	Хэмжлийн нэгжийн эталоны бий болгож, хэмжилзүйн үзүүлэлт, нарийвчлалыг шаардлагын түвшинд хадгалахад төрийн хүлээх үүргийг тодотгох, хэмжилзүйн шалгалт,тохируулга, баталгаажуулалтын алба, лабораторийг итгэмжлэх, хэмжилзүйн төрийн хяналт, шалгалтын хамрах хүрээг өөрчлөх, хэмжих хэрэгслийн загварын түршилт, баталгаажуулалтын үр дүнг харилцан хүлээн зөвшөөрөх	
18	Стандартчилал, чанарын баталгаажуулалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Үйлдвэр, худалдааны яам	2001	Стандартчилал, чанарын баталгаажуулалт, итгэмжлэлийн тогтолцоог олон улсын нийтлэг жишиг нийцүүлэх замаар үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээг дэмжих, чанар, аюулгүй байдал, эрүүл мэнд, байгаль орчин, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахад чиглэсэн үйл ажиллагаг боловсронгуй болгох	
19	Нягтлан бодох бүртгэлийн хуульд өөрчлөлт оруулах тухай	Санхүү, эдийн засгийн яам	2002	Төсвийн нягтлан бодох бүртгэлийн систем, нягтлан бодогчдын үйл ажиллагаатай холбогдсон зүйл, заалт нэмэх, нягтлан бодогчдын хариуцлагын асуудлыг тодорхой тусгах, бусад хуультай нийцүүлэх	

20	Харилцаа, холбооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Санхүү, эдийн засгийн яам	2002	Өнөөгийн нөхцөлд нийцүүлэн харилцаа, холбооны салбарын удирдлага, зохион байгуулалт, хувьчлал, либеральчлалын асуудлыг шинэчлэн тусгах, харилцаа, холбооны Зохицуулах эвлөлийг орон тооны байгууллага болгох
21	Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Санхүү, эдийн засгийн яам, Байгаль орчны яам, Үйлдвэр, худалдааны яам, Дэд бүтцийн яам	2001	Лиценз, лицензийн төлбөрийн асуудлыг зохицуулах, эвдэрсэн газрыг нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх, ашигт малтмал хайх, олборлох, лиценз олгох ажлыг байгаль хамгаалах, газар олголт, эзэмшлийн асуудалтай уялдуулах механизм тогтоох, ердийн ашигт малтмал ашиглах үеийн лицензийн төлбөр, талбайн хэмжээг багасгах, лиценз олгох, шилжүүлэх, цуцлахад тавих хяналтын механизмыг боловсронгуй болгох, төсвийн хөрөнгөөр хийгдэж байгаа геологийн судалгаанд олгогдох талбайн эвшээрлийг олгох, цуцлах тухай заалтыг тодруулах, геологи, уул уурхайн хөгжлийн агентлагийн бүтэц, эрх үүргийн талаархи заалтуудад өөрчлөлт оруулах, ашигт малтмалын нөөцийг баталгаажуулах, хөдөлгөөнийх нь бүртгэл тооцоог хөтлөх тухай хайгуулын лиценз эзэмшигчдтэй хийх “тогтвортой байдлын гэрээ”-ний нөхцөлийг тусгах, гар аргаар ашигт малтмал олборлохыг эвшээрэх
22	Хоршооны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Хүнс, хөдөө аж ахуйн яам	2001	Хадгаламж, зээл, даатгалын болон мал эмнэлэгийн хоршооны талаар нэмэлт, өөрчлөлт оруулах

23	Аялал, жуулчлалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Дэд бүтцийн яам	2001	Аялал жуулчлалын үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд гүйцэтгэхтэй холбоотой болзол, шаардлагыг тодорхой болгох, туүний үйл ажиллагаа мэргэжил, тусгалагатай боловсон хүчнээр дагнан эрхлүүлэх, зочид буудал, жуулчны баазуудын хангах үзүүлэлтүүдийг тогтоох	
24	Лизингийн тухай	Санхүү, эдийн засгийн яам	2002	Үүл, уурхай, ХАА-н салбарт лизингийн хэлбэрээр техникийн шинэчлэл хийх, үйлдвэр худалдааны шинэ техник, технологи нэвтрүүлэхэд санхүү зээлийн аятай нөхцөл бүрдүүлэх, үндсэн болон эргэлтийн хөрөнгийн ашиглалтыг дэмжлүүлэх эрх зүйн орчин бүрдүүлэх	
25	Экспортыг дэмжих тухай	Үйлдвэр худалдааны яам	2001 оны IV улирал	Экспортыг дэмжих үйл ажиллагааны зохион байгуулалт, эрх үүргийн тогтолцоо болон экспортыг төрөөс дэмжих хэлбэр, зарчмуудын эрх зүйн зохицуулалт бий болгох	
26	Гадаадын оруулалтын хуульд өөрчлөлт тухай	хөрөнгө тухай нэмэлт, оруулах	Үйлдвэр, худалдааны яам	2001 оны 6 дугаар сар	Гадаадын хөрөнгө оруулалтыг төрүүлэх ач холбогдол бүхий салбар, экспортын үйлдвэрлэлд түлхүү чиглүүлэх, татварын хэт хавтайрсан чөлөөлөлтийг багасгах, гадаадын хөрөнгө оруулалтыг чанаржуулах, их хэмжээний хөрөнгө оруулалтыг дэмжих, гадаадын хөрөнгө оруулагчдад үзүүлэх хөнгөлөлт, урамшууллын тогтвортой байдлыг хангах
27	Банк бус санхүүгийн байгууллагын тухай		УИХ-ын гишүүн Н.Гэрэлсүрэн, Д.Түмэндэмбэрэл, Б.Шаравсамбуу, Н. Энхболд	2001	Хуулийн этгээд буюу иргэдээс санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа болон хууль тогтоомжоор хориглоогүй бусад ажил, үйлчилгээ эрхлэх эрхтэй Банк бус санхүүгийн байгууллага байгууллж болох эрх зүйн үндсийг бий болгох
28	Авто тээврийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай		Дэд бүтцийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам	2002	Автотээврийн хэрэгслийн жолоч бэлтгэх, мэргэшил дээшлүүлэх үйл ажиллагаа болон автотээврийн үйлчилгээ, ашиглалтад төрөөс тавих хяналт шалгалттай холбогдсон асуудлаар зохих өөрчлөлт оруулах	

ГУРАВ. БҮС НУТАГ, ХӨДӨӨГИЙН БОДЛОГО:				
1	Бүс нутгийн хөгжлийн тухай	Санхүү, эдийн засгийн яам	2001	Бүс нутаг, эдийн засгийн бүсчлэлийн талаархи нэр томъёог олон нийтэд ойлгомжтой, зохистой, цэгцтэй ойлголт болгон жигдлэх, аймаг, хот тосгод хоорондын, салбар хоорондын шинжтэй эдийн засаг, нийгмийн иж бүрэн харилцааны эрх зүйн зохицуулалтын зарчмыг тогтоох, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, хот тосгоны удирдлага хийгээд бүс нутгийн хөгжлийг дэмжих үйл ажиллагааны зохион байгуулалт, түүний эрх зүйн ойлголтын харьцаа хамаарлыг зөв тогтоох
2	Эдийн засаг, худалдааны чөлөөт бүсийн эрх зүйн байдлын тухай	Санхүү, эдийн засгийн яам	2001	Эдийн засаг, худалдааны чөлөөт бүс байгуулахтай холбогдуулан харьцангуй бие даасан байдлаар энэхүү бүсийг төлөвшүүлэх, бүсийн засаг захиргааны байгууллагын эрх зүйн байдал, тэнд дагаж мөрдөх хууль тогтоомжийн үндсийг бүрдүүлэх
3	Малын даатгалын тухай	Санхүү, эдийн засгийн яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам	2001	Малчид малаа даатгуулснаар аливаа эрсдэлээс мал сүргээ хамгаалах, ган, зуд, байгалийн бусад гамшиг тохиолдох, өвчин эмгэг гарах үед хохирол багатай давах нөхцөлийг бүрдүүлэх, даатгалын хураамжийг мал, амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнээр орлуулах, даатгалын хураамж, нөхөн олговрын хувь, хэмжээг бүс нутгийн онцлог, мал, амьтны төрлийн бүтэц зэрэг хүчин зүйлээс хамааруулан ялгавартай тогтоох

4	Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай, Мал, амьтныг хамгаалах тухай, Мал, амьтны өвчинтэй тэмцэх тухай	Хүнс, хөдөө аж ахуйн яам	2001-2004	Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалахад төрийн байгууллага, мал эмнэлгийн үйлчилгээний байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо, малчдын үүрэг хариуцлагыг тодорхой заах, энэ чиглэлээр Засгийн газраас хариуцан санхүүжүүлэх арга хэмжээг тоймтой болгож, олон улсын жишигт нийцсэн зайлшгүй шаардлагатай цөөхөн арга хэмжээг хуульчлан санхүүжүүлэх, малчид өмчлөх эрхээ эдлэхийн зэрэгцүэ өмчөө хамгаалах хариуцлага хүлээх ёстой гэсэн бодлого баримтлах, мал, амьтны өвчний хорио цээр, мэдээлэлтэй холбогдох харилцааг тусгах, мал, амьтны арчилгаа, маллагаа, тэжээл, тээвэрлэлтэд хэрхэн хяналт тавих, түүнийг зөрчсөн , өмчлөгч иргэн, хуулийн этгээдээс мал, амьтантай зүй бусаар харьцсан тохиолдолд ямар хариуцлага хүлээлгэх асуудлыг зохицуулах, Засгийн газрын бүртгэлтэй, заавал мэдээлэх өвчний жагсаалт, олон улсын “А” жагсаалтын болон нийгэм, эдийн засагт ноцтой хохирол учруулдаг халдварт өвчин гарсан үед хэрхэн оношлох, мэдээлэх, түүнтэй тэмцэх үйл ажиллагаа, энэ талаархи иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, хүлээх хариуцлагыг тодорхойлох
5	Малчин өрхийн болон фермерийн аж ахуйн эрх зүйн байдлын тухай	Хүнс, хөдөө аж ахуйн яам	2001-2004	Монгол орны нөхцөлд бэлчээрийн болон эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчид, малчид, мал аж ахуй, газар тариалангийн фермерийн аж ахуйн эрх зүйн байдлыг энэ хуулиар тодорхойлж, үйл ажиллагааных нь эрх зүйн орчныг бүрдүүлэх

6	Урийн тариаланг даатгах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Хүнс, хөдөө аж ахуйн яам	2001-2002	Урийн тариалангийн даатгалын нөхөн олговрын хэмжээ нь урийн тариалангийн даатгалын үнэлгээний 80.0 хувьтай тэнцүү байхаар хатуу заасныг өөрчлөх, хуульд заасан эрсдэл тухайн даатгалын компанид даатгагдсан нийт талбайн 70-аас дээш хувьд тохиолдсоны улмаас даатгагч нь нөхөн олговрыг бүрэн нөхөн төлж чадахгүй болсон нь тогтоогдсон нөхцөлд нөхөн олговрын эрүүг Засгийн газар хариуцахаар заасныг зах зээлийн зарчимд нийцүүлэх
7	Газар тариалангийн тухай	Хүнс, хөдөө аж ахуйн яам	2002	Тариалангийн газрын зээмшил, ашиглал, тариалангийн талбайн бүртгэл, мониторингийг зохион байгуулах, газар тариалан эрхлэгчдийн эрх ашгийг хамгаалах зэрэг асуудлаар иргэд, хуулийн этгээдийн хооронд үүсэх харилцааг зохицуулах
8	Ургамал хамгааллын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Хүнс, хөдөө аж ахуйн яам	2001-2002	Хуулийн зарим зүйл, заалт Захиргааны харилцлагын тухай болон Төрийн хяналт шалгалтын тухай хуультай зөрчилдөж байгааг өөрчлөх
9	Амьтан, ургамал, амьтан, ургамлын гаралтай зүйлсийг улсын хилээр оруулах, гаргах хорио цээрийн хяналтын тухай	Хүнс, хөдөө аж ахуйн яам	2002	Ургамлын өвчин, хөнөөлт шавьж, мэрэгч амьтад зэргийг өөрийн оронд нэвтэрч хөнөөл учруулахаас урьдчилан сэргийлэх эрх зүйн орчин бүрдүүлэх, экспортлогч орны мал эмнэлэг, ургамлын хорио цээрийн хяналтад байдаг батлагаатай үйлдвэр, аж ахуйн нэгжээс түүхий эд бүтээгдэхүүн импортлодог болгох

10	Улсын нөөцийн тухай	Хүнс, хөдөө аж ахуйн яам	2001-2002	Улсын нөөц бүрдүүлэх, хадгалах, шинэчлэх, захиран зарцуулахтай холбогдсон харилцааг зохицуулах, улсын нөөцийн бэлэн байдлыг дээшлүүлэх, эдийн засгийн тогтвортой байдлыг хангах, үндэсний аюулгүй байдалд дэмжлэг үзүүлэх боломж бүрдүүлэх
11	Эрчим хүчний тухай	Дэд бүтцийн яам	2001	Эрчим хүчний нөөцийг ашиглан эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, диспетчерийн зохицуулалт хийх, ханган үйл ажиллагаа эрхэх, эрчим хүчний барилга байгуулламж болон эрчим хүчийг хэрэглэгчэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах
12	Монгол орны газар орны нэрийн тухай	Дэд бүтцийн яам	2002	Газар усны нэрийг бүх төрлийн албан ёсны бичиг, газрын зураг, түүх, ном зохиолд үнэн зөв хэрэглүүлэх, дотоодод хэрэглэгдэх албан ёсны альфавит бичиг болон НҮБ-ын албан ёсны хэлүүдээр нэгдмэл стандартын дагуу галиглах, эдгээр асуудлыг зохион байгуулах
13	Усны хангамж, цэвэрлэх байгуулламжийн тухай	Дэд бүтцийн яам	2001-2002	Хүн амын эрүүл ахуйн нөхцөлийг сайжруулах, байгаль орчинд нөлөөлж буй сөрөг нөлөөллийг багасгах үүднээс усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах үйл ажиллагаг зохицуулах, ажил, үйлчилгээний төлбөр тооцоог үйлчилгээний чанар, түвшинтэй холбож бодитой хэрэглэсэн хэмжээгээр хийх тогтолцоог бий болгох
14	Шуудан холбооны тухай	Дэд бүтцийн яам	2001-2002	Харилцаа холбооны бие даасан салбарын нэг болох шуудан холбооны эрх зүйн зохицуулалттыг боловсронгуй болгох

15	Авто замын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Дэд бүтцийн яам	2001	Замын сантай холбоотой зарим нэмэлт, өөрчлөлт оруулах
16	Дундын өмчлөлийн орон сууцны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Дэд бүтцийн яам	2001-2002	Сууц өмчлөгчдийн холбоо, конторын зохицуулалтыг өөрчлөх
17	Иргэний нисэхийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Дэд бүтцийн яам	2001-2002	Иргэний нисэхийн багц дүрэмтэй холбоотой нэмэлт, өөрчлөлт оруулах
	ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ БОДЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР:			
1	Хаягдал усанд төлбөр ногдуулах тухай	Байгаль орчны яам	2001-2002	Хаягдал усанд төлбөр ногдуулахтай холбоотой үйл ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг бий болгох, хаягдал усанд төлбөр ногдуулснаар түүнийг цэвэршүүлэх үйл ажиллагааг санхүүжүүлэх эх үсвэрийг бий болгох
2	Агаар бохирдуулсны төлбөрийн тухай	Байгаль орчны яам	2001-2002	Агаар бохирдуулсны төлбөр төлөхтэй холбогдсон харилцааг зохицуулах
3	Газрын тухай	Байгаль орчны яам	2001	Газар олголт, эзэмшилтийг журамлах, газрын ашиглалтыг сайжруулах, менежментийг оновчтой болгох
4	Газрын төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Байгаль орчны яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам	2001-2002	Газрын ашиглалт, хамгаалалтыг сайжруулах
5	Газрын хэвлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Байгаль орчны яам	2001	Эвдэрсэн газрыг нөхөн сэргээх, засч тохижуулахад тавих хяналтыг чангатгах

6	Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Байгаль орчны яам	2001-2002	Байгаль орчны төв, орон нутгийн байгуулагуудын удирдлага, зохион байгуулалтын бүтэц, тогтолцоог оновчтой болгох
7	Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Байгаль орчны яам	2001-2004	Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын дэглэмийг боловсронгуй болгох, тусгай хамгаалалттай газар нутагт газар ашиглах, судалгаа шинжилгээ явуулах, байгалийн нөөц болон дурсгалт газрын хамгаалалтыг сайжруулах
8	Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Байгаль орчны яам	2002	Орчны бүсийн сан бүрдүүлэх, орчны бүсийн статусын талаар тодруулах
9	Усны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Байгаль орчны яам Хүнс, хөдөө аж ахуйн яам	2001	Усны барилга байгууламж, ашиглалтын талаар заалт нэмэх, худаг, уст цэгийн өмчлөл, эзэмшил, ашиглалттай холбогдох харилцааг хуульчлах
10	Ус, рашаан ашигласны төлбөрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Байгаль орчны яам	2002	Төлбөрийн дээд, доод хязгаарыг зах зээлийн нөхцөлд зохицуулан шинэчлэх
11	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Байгаль орчны яам	2001	Байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий болон нарийвчилсан үнэлгээ хийх ажлыг чанаржуулах, энэ ажилд оролцох субьектуудын харилцан уялдааг боловсронгуй болгох, нөхөн сэргээлтийн ажлыг эрчимжүүлэх, хуулийн биелэлтэд тавих хяналтын механизмыг сайжруулах

ТАВ. БАТЛАН ХАМГААЛАХ, ГАДААД БОДЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР:

1	Батлан хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Батлан хамгаалах яам	2001	Батлан хамгаалах бодлогод өөрчлөлт оруулах холбогдуулан Батлан хамгаалахын сайд энгийн хүн байх, Батлан хамгаалах асуудлаар төрийн захиргааны тев, орон нутгийн байгууллагын хүлээх чиг үүргийг хуульчлан тогтоох
2	Иргэний хамгаалалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Батлан хамгаалах яам	2002	Иргэний хамгаалалтын тогтолцоо, зарим албан тушаалтны чиг үүргийг тодотгох
3	Зэвсэгт хүчний тухай	Батлан хамгаалах яам	2001	Зэвсэгт хүчний үүрэг, түүний удирдагын тогтолцоо, захиргааны болон удирдлагын заагаа ялгаа, эрх хэмжээ, бэлэн байдлын шаардлага зэрэг багц асуудлыг хуулиар зохицуулах
4	Дайны байдлын үед санхүүгийн дайчлах тухай	Батлан хамгаалах яам	2002	Улс орны нийгэм, эдийн засгийн шаардлагатай үед дайны байдалд шилжүүлэх урьдчилсан нөхцөлийг хангах үйл ажиллагаог эрх зүйн хувьд зохицуулах
5	Дайны байдлын үед хөдөө, аж ахуйн бүтээгдэхүүн, түүхий эд бэлтгэх тухай	Батлан хамгаалах яам	2002	Улс орны нийгэм, эдийн засгийн шаардлагатай үед дайны байдалд шилжүүлэх урьдчилсан нөхцөлийг хангах үүднээс хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн, түүхий эд бэлтгэхтэй холбогдсон харилцааг зохицуулах
6	Улсын дайчилгааны нөөцийн тухай	Батлан хамгаалах яам	2001	Дайны байдалд шилжүүлэх урьдчилсан нөхцөлийг хангах үүднээс улсын дайчилгааны нөөцтэй холбогдсон асуудлыг зохицуулах
7	Цэргийн албан хаагчид гадаад орон болон улсын байгууллагад түүрэг	Батлан хамгаалах яам	2001	Зэвсэгт хүчний чиг үүрэгт НҮБ-ын энхийг сахиулах үйл ажиллагаанд гадаад орондбайлдааны зэвсэг, техникгэйгээ явж үүрэг гүйцэтгэхээр өөрчлөлт оруулах холбогдуулан бусад орны жишээр өөрийн хуулиар зохицуулах

8	Зэвсэгт хүчинд ажиллаж буй энгийн хүмүүсийн эрх зүйн байдлын тухай	Батлан хамгаалах яам	2003	Зэвсэгт хүчинд ажиллаж буй энгийн хүмүүс нь цэргийн нууцтай харьцдаг, цэргийн анги байгууллагын үйл ажиллагааны онцлог, дүрэм, журамд захирагдан эрх нь тодорхой хэмжээгээр хязгаарлагдаг учраас тэдний эрх зүйн байдлыг хуулиар зохицуулах
9	Цэргийн албан хаагчид эд хөрөнгийн хариуцлага хүлээлгэх тухай	Батлан хамгаалах яам	2001	Зах зээлийн харилцааны үед урьд мөрдөж байсан хууль тогтоомжийн актууд зохицохоо больсон, цэргийн өмч, эд хөрөнгө үрэгдэх явдал гарсаар байгаатай холбогдуулан энэ харилцааг хуулиар зохицуулах
10	Агаарын орон зайн тухай	Батлан хамгаалах яам	2002	Улсын агаарын хилийн хамгаалалт, агаарын орон зайд хэвлэл тавих, үүнтэй холбогдон үүсэх бусад л харилцааг зохицуулах
11	Улсын байнгын онцгой комиссын тухай	Батлан хамгаалах яам	2001	Улсын байнгын онцгой комиссын эрх, чиг үүрэг, үйл ажиллагааны зарчмыг хуульчлан тодорхойлох
12	Аврагчийн эрх зүйн байдлын тухай	Батлан хамгаалах яам	2001-2002	Байгалийн гамшиг, үйлдвэрлэлийн ослын үед хүний амь, эд хөрөнгийг авран хамгаалах онцгой хүнд, эрсдэл ихтэй үүрэг гүйцэтгэдэг аврагчдын нийгмийн баталгааг хангах харилцааг зохицуулах
13	Монгол Улсын олон улсын гэрээ буртгэх, паспортжуулах тухай	Гадаад хэргийн яам	2002	Монгол Улсын олон улсын гэрээг буртгэх, түүнийг паспортжуулахтай холбогдсон харилцааг зохицуулах
14	Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	УИХ-ын гишүүн Д.Базарсад, П.Жасрай, С.Оюун	2001	Хууль бусаар гүйцэтгэх ажил явуулахыг хориглох
15	Татнуулын байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	УИХ-ын гишүүн С.Базарсад, Х.Жекей, Ц.Шаравдорж	2001	Хууль бусаар гүйцэтгэх ажил явуулахыг хориглох, хилийн цэргийг татнуултай болгох
16	Батлан хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	УИХ-ын гишүүн С.Базарсад, Х.Жекей, Ц.Шаравдорж	2001	Засгийн газрын мөрийн хөтөлбөрт тусгаснаар хилийн цэргийн бие даасан тоотолцоог бий болгох

ЗУРГАА. ЗАСАГЛАЛЫН ХЭМРАЛЫГ АРИЛГАХ, ДЭГ ЖУРМЫГ БЭХЖҮҮЛЭХ БОДЛОГЫН ЧИГЛЭЛЭЭР:

1	Эрүүгийн хууль	Хууль зүй, дотоод хэргийн яам	2001	Үндсэн хуульд нийцүүлэн эрүүгийн эрх зүйн бодлогыг үндсээр нь шинэчлэх, гэмт хэргийн улмаас учирсан хохирлыг нөхөн төлүүлэх, эрх зүйн шийдэлд хүрэх, ялын бодлогын гэмт хэргийн нийгмийн хор аюул, гэмт хэрэг үйлдсэн этгээдийн хувийн байдлыг харгалзан шинэчлэх, тодорхойлох
2	Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай	Хууль зүй, дотоод хэргийн яам	2001	Иргэний хэрэг шийдвэрлэх ажиллагааны бүх шатанд мэтгэлзэх зарчмыг хэрэгжүүлэх, үүнтэй нийцүүлэн иргэний хэрэг шийдвэрлэх ажиллагаанаас прокурорын ажиллагаат хасах, хэрэг шийдвэрлэх ажиллагаанд хөндлөнгөөс оролцох оролцогч этгээд тэгш эрхийн зарчмыг алдагдуулдаг байсныг хязгаарлах зэрэг зарчмын зарим өөрчлөлт оруулах
3	Эрүүгийн байцаан шийтгэх хууль	Хууль зүй, дотоод хэргийн яам	2001	Шүүх эрх мэдлийн байгууллагуудын үйл ажиллагааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгох, хууль хамгаалах байгууллагуудын чиг үүрэг, зохион байгуулалтад зарчмын өөрчлөлт оруулах, эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаат нийгмийн амьдралд гарч буй өөрчлөлтүүдтэй уялдуулан боловсронгуй болгох
4	Шүүхийн тухай	Хууль зүй, дотоод хэргийн яам	2001	Шүүхийн шинэчлэлийг иж бүрнээр шүүхийн тогтолцоо, зохион байгуулалт, шүүгчдийн хараат бус байх баталгаа зэргийг бүхэлд нь хамруулан хэрэгжүүлэх эрх зүйн үндсийг бүрдүүлэх
5	Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай	Хууль зүй, дотоод хэргийн яам	2001	Иргэн, хуулийн этгээдийг захиргааны байгууллага, албан тушаалтны гаргасан хууль бус актаас хамгаалах, тэдний гаргасан гомдлын дагуу захиргааны актыг үзэж шийдвэрлэх механизмыг бий болгох, шүүн таслах ажлын төрлөөр шүүхийг дагнан явуулж болно гэсэн Үндсэн хуулийн үзэл баримтлалыг хэрэгжүүлэх

6	Шүүхийн шийдвэр биелүүлэх тухай	Хууль зүй, дотоод хэргийн яам	2001	Шүүхийн шийдвэр биелүүлэх байгуулагын үйл ажиллагааг боловсронгуй болгох, шийдвэр биелэлтийг дэмжлэх, шийдвэр гүйцэтгэлийн гүйцэтгэхээр чадварлаг хуульчид ажиллах нөхцөлийг бүрдүүлэх, шүүхийн шийдвэр биелүүлэх байгуулагын өөрийн санхүүжүүлэх үндсийг тавих
7	Төр, сум харилцааны хуульд өөрчлөлт оруулах тухай	Хууль зүй, дотоод хэргийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	2002	Төр, сум хийдийн хоорондын харилцааны эрх зүйн үндсийг боловсронгуй болгох, хүн шашин шүтэх, эс шүтэх чөлөөтэй эдлэх эрх зүйн баталгаат Үндсэн хуульд нийцүүлэн төгөлдөржүүлэх, хуулийг хэрэгжүүлэх субъектүүдийн үйл ажиллагааны уялдаа, холбоог сайжруулах, шашны байгууллагын өмчийн өмчлөгчийн эрхийг хамгаалах, хуульд музей болон бусад түүх соёлын дурсгалууд хадгалагдаж буй байгууллагуудаас соёлын дурсгалт зүйлүүдийг нь сүм хийдүүдэд шүүд хэрэглүүлж болохоор заалт байдгаас шинээр байгуулагдсан уламжлалт шашны сүм хийдүүд нь уг дурсгалуудыг ямар ангилалтайг нь үл харгалзан ашиглах, зэзмишихээр санал тавьж, үүнтэй холбоотой зарим зөрчил гарч байгаг арилгах
8	Галт зэвсгийн тухай	Хууль зүй, дотоод хэргийн яам	2001	Зэвсэгт хүчин, бусад цэрэг, цагдаа, тагнуул, хорих байгууллагаас бусад байгуулллага, иргэн галт зэвсэг өмчлөх, зэзмших, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулах.
9	Торгуулийн тухай	Хууль зүй, дотоод хэргийн яам	2001	Захиргааны хариуцлага ногдуулахтай холбогдсон харилцааг боловсронгуй болгох

10	Хувийн хамгаалалтын тухай	Хууль зүй, дотоод хэргийн яам	2001	Төрийн тусгай хамгаалалт, зэвсэгт хүчин, бусад цэрэг, цагдаа, тагнуулын болон тэрээт харуул хамгаалалттай холбогдсон харилцаанаас бусад хувийн хамгаалалттай холбогдсон харилцааг зохицуулах
11	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Хууль зүй, дотоод хэргийн яам	2002	Бүх шатны зохицуулах зөвлөлийн эрх хэмжээг өргөтгөх, яам, агентлаг, нутгийн захиргааны байгууллагын үүргийг тодруулах
12	Архидан согтуурахтай тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Хууль зүй, дотоод хэргийн яам	2001	Архидан согтуурахтэй тэмцэх сан байгуулах
13	Үндсэн хуулийн цэцэд харгаан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Ерөнхийлөгчийн Тамгын газар	2001	Үндсэн хууль зөрчсөн тухай Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээмар тогтоосон хугацаанд Улсын Их Хурал хэлэлцэхгүй бол Цэц өөрөө уг асуудлыг дахин хэлэлцэн шийдвэрлэх байх
14	Авилгалын эсрэг хууль	Хууль зүй, дотоод хэргийн яам	2001	Нийгмийн гаж бүрүү үзэгдэл болох авилгалтай тэмцэх эрх зүйн зохицуулалтыг бий болгох, олон нийтийн авилгалын эсрэг тэмцэх үзэл санааг дэмжих, төрийн байгууллагуудын эрх хэмжээг тодорхойлох
15	Яамны эрх зүйн байдлын тухай	Хууль зүй, дотоод хэргийн яам Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	2001	Монгол Улсын төрийн тогтоцоонд яамдын эзлэх байр суурь, тэдний бүтэц, чиг үүргийг тодорхой болгох ба сайдад бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэх мэргэжлийн, цомхон, чадварлаг аппарат бий болгох эрх зүйн үндэс бүрдүүлэх.

16	Агентлагийн эрх зүйн байдлын тухай	Хууль зүй, дотоод хэргийн яам, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар	2001	Засгийн газрын тохируулагч болон хэрэгжүүлэгч агентлагуудын онөчтой тогтолцоог бүрдүүлэх, тэдгээр нь зорилгоо мэргэжлийн өндөр ур чадвартайгаар хэрэгжүүлэх нөхцлийг бүрдүүлэх, агентлагийн үйл ажиллагааны бие даасан байдлыг хангах, төдний ажлын үр дүнг дээшлүүлэх
17	Олон нийтийн радио, телевизийн тухай	Хууль зүй, дотоод хэргийн яам	2001	Монгол Улсад үндэсний хэмжээнд нэвтрүүлэг явуулдаг бие даасан, харааг бус олон нийтийн радио, телевизийг үүсгэн байгуулах, түүний удирдах болон өдөр тутмын үйл ажиллагаанд нь зохицуулах, гүйцэтгэх байгууллагын зохион байгуулалт, эрх хэмжээ, санхүүжилт, өмч хөрөнгөтэй холбоотой харилцааг зохицуулах
18	Мэдээллийн МОНЦАМЭ агентлагийн тухай	Хууль зүй, дотоод хэргийн яам	2001	Мэдээллийн МОНЦАМЭ агентлагийн үйл ажиллагааны зарчим, эрх хэмжээ, санхүүжилттэй холбогдсон харилцааг зохицуулах
19	Үндэсний аюулгүй байдлын тухай	Ерөнхийлөгчийн Тамгын газар, Батлан хамгаалах яам	2002	Үндэсний аюулгүй байдлыг хангах тогтолцоог боловсронгуй болгох
20	Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хууль зүй, дотоод хэргийн яам	2001	Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасныг үндэслэн зарим шаардлагатай өөрчлөлт оруулах

21	Прокурорын байгууллагын хуульд өөрчлөлт тухай	тухай нэмэлт, орууллах	Хууль зүй, дотоод хэргийн яам Улсын Ерөнхий прокурорын газар	2001	Прокурорын байгууллагын албан хаагчийн ажлаас нэхцэлийг бүрдүүлэх, хүний эрх , эрх чөлөөг хязгаарласан үйл ажиллагаа явуулахад чиглэсэн заавар, журам тогтоохдоо Улсын Ерөнхий прокурортой зөвшилцөж байх, прокурор төрийн албанд анх ороход тангараг өргөж байх, прокурорын байгууллага гэмт хэргийн болон зөрүүгийн ял шийтгүүлэгчдийн тоо бүртгэлийг хөтөлж байх
22	Өмгөөллийн хуульд өөрчлөлт тухай	тухай нэмэлт, орууллах	Хууль зүй, дотоод хэргийн яам Монголын өмгөөлөгчдийн холбоо	2001	Өмгөөлөгчдийн хариуцлагын даатгалын санд өмгөөллийн байгууллагын гишүүний татварын 20 хувийг төвлөрүүлж байх, төлбөрийн чадваргүй иргэдийн өмгөөллийн зардлыг хохицулах, өмгөөллийн байгууллагын удирдлага, зохион байгуулалтын бүтцийг тодорхой болгох
23	Нотариатын хуульд өөрчлөлт тухай	тухай нэмэлт, орууллах	Хууль зүй, дотоод хэргийн яам	2001	Нотариатын байгууллагын удирдлага, зохион байгуулалтын бүтцийг тодорхой болгох, нотариатч, нотариатын үүрэг гүйцэтгэгч нотариатын үйлдэл хийх эрхээ гацхүү өөрөө хэрэгжүүлэх, нотариатчийн сонгон шалгаруулалт явуулах мэргэжлийн орон тооны бус комиссыг хууль зүйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын дэргэд байхаар зохион байгуулах
24	Цагдаагийн байгууллагын хуульд өөрчлөлт тухай	тухай нэмэлт, орууллах	Хууль зүй, дотоод хэргийн яам	2001	Цагдаагийн байгууллагын бүтэц, тогтолцоог шинэчлэх, хэрэг бүртгэх, мөрдөн байцаах байгууллагыг өөрчлөн зохион байгуулах

25	Хилийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Хууль зүй, дотоод хэргийн яам	2001	Төрөөс хилийн талаар баримтлах бодлогод хууль тогтоомжийг нийцүүлэх, хилчдийн эрх зүйн байдлыг дээшлүүлэх, хилийн зурвасын хэмжээг өргөтгөх
26	Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Хууль зүй, дотоод хэргийн яам	2001	Үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн үйлчилгээний чанар, шуурхай байдлыг хангах, шинээр бий болсон харилцааг зохицуулах
27	Барааны тэмдэг, аж ахуйн нэгжийн нэрийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Хууль зүй, дотоод хэргийн яам	2002	Дэлхийн худалдааны байгууллагын оюуны өмчийн эрхийн худалдааны хэлэлцээрийн дагуу хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах
28	Төрийн албаны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хууль зүй, дотоод хэргийн яам	2001	Төрийн жинхэнэ албан хаагчийн эрх, үүрэг, заагийг нарийн тодорхойлох, төрийн албаны төв байгууллагын эрх хэмжээг өргөтгөх, төрийн улс төрийн болон захиргааны албан тушаалын ангилалд өөрчлөлт оруулах
29	Төрийн хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Төрийн хянан шалгах хороо	2001	Төрийн хяналт шалгалтын байгууллагын үйл ажиллагаатай холбоотой шинээр бий болж буй харилцааг хуульчлах
30	Хуульчдыг сонгон шалгаруулах журмын тухай	Хууль зүй, дотоод хэргийн яам	2001	Хуульч мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх, сонгон шалгаруулахтай холбогдсон харилцааг зохицуулах, хуульчдыг сонгон шалгаруулах үндэсний нэгдмэл механизмыг бүрдүүлэх эрх зүйн үндсийг тавих

31	Иргэдээс байгууллага, тушаалтанд өргөдөл, шийдвэрлэх хуульд өөрчлөлт тухай	Төрийн албан гаргасан томдлыг тухай нэмэлт, оруулах	Хууль зүй, дотоод хэргийн яам	2001	Иргэдийн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэх, хяналт тавих нийтийн гэрээний журамтай болгох
32	Засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хууль зүй, дотоод хэргийн яам		2001	Нутгийн өөрөө удирдах ёс, нутгийн өөрөө удирдах байгуулагын эрх зүйн байдал, төрийн захиргааны төв байгууллагатай харилцах статусыг нь тодорхой болгох, аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн ажлын албаны талаар тодорхой зүйл, заалт оруулах, аймаг, нийслэлийн Засаг даргын захирамжийг ХЗДХЯ хянадаг тогтолцоог хуульчлах, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар, түүний дэргэдэх хэлтэс, албаны орон тоо, цалин, ажлыг журмыг ИТХ тогтоож байх
33	Төрийн мэдээллийн харилцааны эрх зүйн байдлын тухай	Хууль зүй, дотоод хэргийн яам		2001	Төрийн удирдлагын мэдээллийн нэгдмэл сүлжээг бий болгож ашиглах удирдлага, зохион байгуулалтын бүтэц болон төрийн удирдлагын бүх шатанд шаардлагатай мэдээлэл цуглуулах, хадгалах, ашиглах, харилцан солилцох орон зайн зохион байгуулалттай мэдээллийн найдвартай эх үүсвэрүүдийн тогтолцоог хөгжүүлэх харилцаг зохицуулах эрх зүйн үндсийг тодорхойлох, төрийн удирдлагын мэдээллийн сангаас бүс байгууллага олон нийт ашиглах эрх зүйн үндсийг бүрдүүлэх, төрийн байгууллага, албан хаагчид мэдээллийг бага зардлаар бөгөөд хугацаанд боловсруулж дамжуулах нэгдмэл орчин бүрдүүлэх

34	Хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл боловсруулах, өргөн мэдүүлэх журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Хууль зүй, дотоод хэргийн яам	2001	Хууль боловсруулах үйл ажиллагааг боловсронгуй болгох, Засгийн газраас боловсруулж байгаа хуулийн төслийг Засгийн газраар хэлэлцүүлэхийн өмнө Хууль зүй, дотоод хэргийн сайдын зөвшөөрөл авдаг байх
35	Монгол Улсын Их Хурлын тухай, Улсын Их Хурлын хуралдааны дэгийн, Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай, Засгийн газрын тухай, Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	УИХ-ын гишүүн С.Төмөр, Б.Долгор, Н.Болормаа, Ж.Наранцацралт, О.Сүрэн	2001	Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан өөрчлөлт оруулах
36	Төрийн албан хаагчийн ёс зүйн байдлын тухай	УИХ-ын гишүүн Ц.Шаравдорж, Д.Цэвээнжав, Д.Базарсад, С.Төмөр	2001	Төрийн өндөр албан тушаалтны нийтлэг дагаж мөрдөх ёс зүйн хэм хэмжээний эрх зүйн орчин бүрдүүлэх
37	Монгол Улсын Их Хурлын гишүүний ёс зүйн байдлын тухай	УИХ-ын гишүүн Ц.Шаравдорж С.Төмөр, Т.Ганди, Д.Базарсад	2001	Хуралдааны үед болон гэр бүл, ахуйн хүрээнд бариментлах ёс зүйн хэм хэмжээ, санхүү, бизнесийн үйл ажиллагаанд тавих хяналт гэх мэт УИХ-ын гишүүний дагаж мөрдөх нийтлэг хэм хэмжээг тогтоож, түүний өндөр албан тушаалын нэр хүндийг хамгаалах
38	Төрийн дээд шагналын тухай	Ерөнхийлөгчийн Тамгын газар	2001	Төрийн дээд шагнал олгох, төрийн ёслол үйлдэх журмыг хуульчлах, төрийн дээд шагналыг шинэчлэх, боловсронгуй болгох

39	Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Засгийн газар	2001	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд оруулах өөрчлөлттэй холбогдуулан шаардлагатай зарим өөрчлөлтийг тусгах
40	Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Засгийн газар	2001	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд оруулах өөрчлөлттэй холбогдуулан шаардлагатай зарим өөрчлөлтийг тусгах
41	Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай хууль	Засгийн газар	2001	Төрийн санхүүжилтийг боловсронгуй болгох

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

№	Төслийн нэр	Хариуцан боловсруулах байгууллага	Хугацаа	Тайлбар
1	Гавьяат малчин цол бий болгох тухай	Хууль зүй, дотоод хэргийн яам	2001	Мал аж ахуйн үйлдвэрлэлд олон жил үр бүтээлтэй ажиллаж, онцгой, тогтвортой амжилт гаргасан малчдыг төрөөс урамшуулах зорилгоор "Гавьяат малчин" цолыг бий болгох
2	Авилгалтай тэмцэх Үндэсний хөтөлбөр	Хууль зүй, дотоод хэргийн яам	2001	Авилгалын эсрэг хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, авилгалтай тэмцэх төрийн бодлогыг тодорхойлох, авилгалтай тэмцэх ажлыг эрчимжүүлэх, энэ ажлыг шинэ шатанд гаргах, төрөөс хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох
3	Нийгмийн дэг журам бэхжүүлэх арга хэмжээний хөтөлбөр	Хууль зүй, дотоод хэргийн яам	2001	Нийгмийн дэг журмыг бэхжүүлэх, гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар төрөөс баримтлах бодлого

					чиглэлийг тодорхойлох
4	Төрөөс хилийн талаар баримтлах бодлого	Хууль зүй, дотоод хэргийн яам	2001		Улсын хилийг баталгаажуулах замаар үндэсний аюулгүй байдлыг хангах, хилийн тухай хууль тогтоомж, нэгдэн орсон олон улсын гэрээ хэлэлцээрийн хэрэгжилтэд үнэлгээ өгч, энэ талаар баримтлах төрийн цэцтэй тодорхойлох
5	Хүний эрхийн үндэсний хөтөлбөр	Хууль зүй, дотоод хэргийн яам	2002		Хүний эрхийн талаархи арга хэмжээг төрөөс уе шаттайгаар, тодорхой хугацааны туршид хэрэгжүүлэх, хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулах, эрх, эрх чөлөөгөө эдлэх таатай нөхцөлийг бүрдүүлэх, хүний эрхийн талаар төрөөс баримтлах бодлого, чиглэлийг оновчтой тодорхойлох
6	Соёл урлагийн гадаад суртачилгааны үндэсн чиглэл	Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам	2002		Монгол Улсыг гадаадад суртачлах ажлын нэг хэлбэр болох соёл, урлагийг гадаадад суртачилахад баримтлах төрийн бодлогыг тодорхойлох, энэ чиглэлээр хэрэгжүүлж буй ажлуудыг цэгцлэх, төрийн байгууллагуудын үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлох
7	Эдийн засгийн бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал	Санхүү, эдийн засгийн яам	2001		Монгол Улсын эдийн засгийг бүсчилэн хөгжүүлэх үндэслэлиг тодорхойлох, энэхүү бүсчлэлээр дамжуулан нутаг дэвсгэрийн хөгжлийн тэнцвэрийг хангах төрийн байгууллалт, эдийн засаг, нийгэм соёл, хүн амын нутагшилт, хот байгуулалт, гадаад хамтын ажиллагааны таатай орчныг бүрдүүлэх, эдийн засгийн мэкро бүсүүдийн хүрээнд бүс нутаг-хот байгуулалтын уялдаа хангах замаар аймаг, орон нутгийн хөгжлийг дэмжих төрийн бодлого, зохицуулалтын тогтолцоог бий болгох

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 5 дугаар сарын 15-ны өдөр | Дугаар 119 | Улаанбаатар хот

Шүүгчийг чөлөөлөх тухай

Монгол Улсын "Шүүхийн тухай" хуулийн 51 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Шүүгчийн мэргэшлийн хорооны дүгнэлт гарсантай холбогдуулан Балдандоржийн Нарандолгорыг Нийслэлийн Баянгол дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

Мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадварын хувьд шүүгчээр ажиллах боломжгүй тухай

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр | Дугаар 78 | Улаанбаатар хот

Журам батлах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 117 дугаар зүйлийг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Хөдөлмөрийн хамтын маргааныг зуучлагчийн оролцоотойгоор шийдвэрлэх журам"-ыг хавсралт ёсоор батлалсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД Ш.БАТБАЯР

Монгол Улсын Засгийн газрын 2001 оны 78 дугаар тогтоолын хавсралт

ХӨДӨЛМӨРИЙН ХАМТЫН МАРГААНЫГ ЗУУЧЛАГЧИЙН ОРОЛЦООТОЙГООР ШИЙДВЭРЛЭХ ЖУРАМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1. Энэ журмын зорилго нь хамтын гэрээ, хэлэлцээр байгуулах явцад үүссэн санал зөрүүтэй асуудлаар болон хамтын гэрээ, хэлэлцээрийн заалтыг биелүүлэх талаар ажилтны төлөөлөгчидийн тавьсан шаардлагыг ажил олгогч хүлээж авааг үй, хугацаанд нь хариу өгөөгүй, эсхүл ажил олгогчоос өгсөн хариуг ажилтны төлөөлөгчид хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн тохиолдолд хөдөлмөрийн хамтын маргааныг зуучлагчийн оролцоотойгоор шийдвэрлэхтэй холбоотой харилцааг зохицуулахад оршино.

2. Зуучлагч нь үйл ажиллагаандаа Хөдөлмөрийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон энэ журмыг дагаж мөрдөнө.

3. Зуучлагчийг маргалдагч талууд харилцан тохиролцож сонгох буюу тохиролцоонд хүрээгүй бол сум, дүүргийн Засаг дарга томилно.

4. Зуучлагч нь үйл ажиллагаандаа хууль ёсыг дээдлэх, хөндлөнгийн нөлөөнд үл автах, шударга ёсыг хангах, ил тод, бодитой байх зарчмыг баримтална.

5. Зуучлагчийг хөдөлмөрийн хамтын маргааныг шийдвэрлэхэд оролцсон хугацаанд үндсэн ажлаас нь чөлөөлж, дундаж цалин хөлстэй нь тэнцэх хэмжээний олговрыг ажлын газраас нь олгоно.

Зуучлагч нь хөдөлмөр эрхэлдэггүй бол олговрын хэмжээг талууд түүнтэй тохиролцон тогтоож болно.

Хоёр.Хамтын маргааныг шийдвэрлэх үйл ажиллагаа

6. Зуучлагч хамтын маргааныг шийдвэрлэх явцад уг маргаантай холбогдсон асуудалтай газар дээр нь очиж танилцан, маргалдагч талуудтай нэг бүрчлэн, шаардлагатай бол холбогдох мэргэжилтэн, хамт олонтой урьдчилан уулзаж, санал дүгнэлтийг нь сонсоно.

7. Маргалдагч талууд нь өөрт байгаа мэдээллийг зуучлагчид өгөх үүрэг хүлээх бөгөөд ажил олгогч нь зуучлагчийг бичиг хэргийн техник хэрэгсэл, маргааныг хянан хэлэлцэх байр болон ажиллах нөхцөлөөр хангана.

8. Маргалдагч талууд зуучлагч урьж ажиллуулснаас хойш маргааныг ажлын тав хүртэл өдрийн хугацаанд хэлэлцэнэ.

9. Маргааныг хянан хэлэлцэх хуралд зуучлагч нь маргалдагч талууд, тэдгээрийн маргааны агуулгыг танилцуулна. Талууд санал зөрүүтэй асуудлаар өөр өөрсдийн байр суурь, үндэслэлийг зуучлагчид танилцуулна. Зуучлагч маргалдагч талуудын тайлбарыг сонссоны дараа асуулт тавих, талуудыг эвлэрүүлэх зорилгоор маргалдагч талуудад бие биедээ асуулт тавьж

хариулт авах, тайлбар хийх, санал солилцох боломж олгоно.

10. Зуучлагч нь маргаантай асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаархи зөвлөмжөө маргалдагч талуудад танилцуулна.

11. Талууд маргаантай асуудлаар харилцан тохиролцсон бол энэ тухай шийдвэрийг бичгээр гаргана. Харин санал зөрүүтэй байдал хэвээр байгаа тохиолдолд энэ тухай зуучлагчийн дэлгэрэнгүй тэмдэглэлийг талуудад танилцуулснаар хөдөлмөрийн хамтын маргааныг зуучлагчийн оролцоотойгоор шийдвэрлэх үйл ажиллагаа дуусгавар болно.

Гурав.Зуучлагчийн эрх, үүрэг

12. Зуучлагч дор дурдсан эрх эдэлнэ:

а/хамтын маргааныг шийдвэрлэхэд шаардлагатай бичиг баримт, холбогдох мэдээ, судалгааг талуудаас шаардаж авах;

б/маргалдагч талуудаас хамтын маргаантай холбогдсон тайлбар, тодорхойлолт гаргуулж авах, хамт олонтой уулзаж санал хүсэлтийг сонсох;

в/шаардлагатай гэж үзвэл холбогдох байгууллага, хүмүүсээс мэргэжлийн зөвлөлгөө авах.

13. Зуучлагч дор дурдсан үүрэг хүлээнэ:

а/маргалдагч талуудын санал хүсэлтийг сонсож судлах, хуулиар тогтоосон нууцад хамаарах бичиг баримт, мэдээ, судалгааны нууцыг хадгалах;

б/тухайн маргааныг хянан хэлэлцээд харилцан тохиролцоонд хүрсэн тухай шийдвэр, эсхүл санал зөрүүтэй байдал хэвээр байгаа тухай зуучлагчийн дэлгэрэнгүй тэмдэглэлийг тухайн сум, дүүргийн Засаг даргад танилцуулах;

в/зуучлагчийн дэлгэрэнгүй тэмдэглэлд маргааны агуулга, хууль тогтоомжийн зохицуулалт, талуудын баримталсан байр суурь, зарчмын зөрүүтэй асуудал, зуучлагчийн гаргасан зөвлөмж зэргийг бүрэн тусгах.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 4 дүгээр сарын 11-ний өдөр **Дугаар 79** **Улаанбаатар хот**

Монгол хэлтэн үндэстний театрын олон улсын наадам зохион байгуулах тухай

Соёлын өв, оюуны олоттыг харилцан дэлгэрүүлэх, соёлын үнэт зүйлсийг хамтран бүтээх чиглэлээр гадаад орон, олон улсын байгууллагатай хамтын ажиллагаагаа өргөтгөх талаар Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлберт тусгагдсан зорилтыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Монголын Урлагийн ажилтны нийгэмлэгийн холбооны хорооноос гаргасан саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол хэлтэн үндэстний театрын олон улсын Ш наадмыг 2001 оны 6 дугаар сард Улаанбаатар хотноо зохион байгуулах нь зүйтэй гэж үзсүгэй.

2. Монгол хэлтэн үндэстний театрын олон улсын Ш наадмын арга хэмжээнд зориулан 28895,0 /хорин найман сая найман зуун ерэн таван/ мянган төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД **А.ЦАНЖИД**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр **Дугаар 80** **Улаанбаатар хот**

Улсын нөөцөөс таримал ургамлын үр гаргаж,нөхөн бүрдүүлэх тухай

2001 оны хаврын тариалалтад дутагдах таримал ургамлын үрийн хэрэгцүэг хангах зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Улсын нөөцөөс улаанбуудайн үр 11000 тонн, бусад үр тарианы ургамлын үр 360 тонн, ОХУ-аас импортолж байгаа буудайн "Саратов-29" сортын 1 дүгээр үеийн үр 2000 тонн, бүгд 13360 тонн үрийг тариалангийн аж ахуйн нэгжүүдэд зохих урьдчилгаа, эргэн төлөгдөх нөхцөл бүхий гэрээгээр олгож 2001 оны 12 дугаар сарын 1-ний дотор нөхөн бүрдүүлэхийг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргалд зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ХҮНС ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД **Д.НАСАНЖАРГАЛ**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 22 (209)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Хэлэлцээр соёрхон батлах тухай*
- *Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт оруулах тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Гаалийн татварын хувь хэмжээг өөрчлөх тухай*
- *Зарим ахмад дайчдад нэг удаагийн буцалтгүй туслалж олгох тухай*
- *Монгол Улс, БНХАУ-ын хоорондын улсын хилийн шугамыг шалгах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2001 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2001 оны зургадугаар сарын 7 №22 (209)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

278. Хэлэлцээр соёрхон батлах тухай (2001-5-25-ны хууль) 606
279. Гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай (2001-5-25-ны хууль) 606

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

280. Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий будүүвчийг шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт оруулах тухай Дугаар 45 606

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

281. Төрийн захиргааны зарим албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв олгох тухай Дугаар 129 606
282. Зарим шүүгчийг чөлөөлөх тухай Дугаар 130 608

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

283. Төр, засгийн үйлчилгээний автобаазын талаар авах зарим арга хэмжээний тухай Дугаар 81 608
284. Үндэсний хорооны дүрэм, бүрэлдэхүүн батлах тухай Дугаар 82 609
285. Зарим байгууллагыг байгуулах, дүрэм батлах тухай Дугаар 83 611
286. Жүрам батлах тухай Дугаар 84 615
287. "Мянганы зам" төслийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай Дугаар 85 617
288. Дүрэм батлах тухай Дугаар 86 620
289. Гаалийн татварын хувь хэмжээг өөрчлөх тухай Дугаар 87 621
290. Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай Дугаар 88 622
291. Төрийн үйлчилгээний зарим албан хаагчийн цалингийн хэмжээг нэмэгдүүлэх тухай Дугаар 89 622
292. Төрийн үйлчилгээний зарим албан хаагчдын цалингийн нэмэгдлийн тухай Дугаар 90 623
293. Зарим ахмад дайчдад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох тухай Дугаар 91 624
294. Ахмадын талаар авах зарим арга хэмжээний тухай Дугаар 92 624
295. Зуны цагийн тоололд шилжүүлэх тухай Дугаар 93 625
296. Монгол Улс, БНХАУ-ын хоорондын улсын хилийн шугамыг шалгах тухай Дугаар 94 626

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 5 дугаар сарын 25-ны өдөр — **Улаанбаатар хот**

ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, Цөмийн туршилтыг бүрэн хориглох Гэрээний Байгууллагын Бэлтгэл Комиссын хорооны 2000 оны 6 дугаар сарын 5-ны өдөр байгуулсан Цөмийн туршилтыг бүрэн хориглох Гэрээний олон улсын хяналтын байгууламж болон түүнийг гэрчилгээжүүлсний дараахь үйл ажиллагааны тухай Хэлэлцээрийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА — **Ж.БЯМБАДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 5 дугаар сарын 25-ны өдөр — **Улаанбаатар хот**

ГААЛИЙН БОЛОН НЭМЭГДСЭН ӨРТГИЙН АЛБАН ТАТВАРААС ЧӨЛӨӨЛӨХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын Засгийн газрын Сэргээн босголтын зээлийн банк хооронд 2001 оны 2 дугаар сарын 12-ны өдөр байгуулсан Чойбалсан дахь Дулааны цахилгаан станцыг шинэчлэх төслийн нэмэлт зээлийн Хэлэлцээрийн дагуу Монгол Улсын хилээр орж ирэх тоног төхөөрөмж, сэлбэг хэрэгслийг гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА — **Ж.БЯМБАДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 5 дугаар сарын ~~25~~-ны өдөр — **Дугаар 45** — **Улаанбаатар хот**

Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

"Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай" Улсын Их Хурлын 2000 оны 9 дүгээр сарын 1-ний өдрийн 32 дугаар тогтоолын хавсралтын "Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг" гэсэн хэсэгт Дэд бүтцийн сайдын эрхлэх ажлын хүрээнд "22[1].Улсын геодези, зураг зүйн газар" гэж нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДЭД ДАРГА — **Ж.БЯМБАДОРЖ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 5 дугаар сарын 23-ны өдөр — **Дугаар 129** — **Улаанбаатар хот**

Төрийн захиргааны зарим албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв олгох тухай

Төрийн албаны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн, Монгол Улсын Засгийн газрын саналыг харгалзан ЗАРЛИГ болгох нь:

1. Хавсралтад дурдсан төрийн захиргааны албан хаагчдад төрийн захиргааны тэргүүн түшмэлийн албан тушаалын зэрэг дэв олгосугай.

2. Энэ зарлигийг 2001 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ — **Н.БАГАБАНДИ**

ТЭРГҮҮН ТҮШМЭЛИЙН АЛБАН ТУШААЛЫН ЗЭРЭГ ДЭВ ОЛГОСОН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ АЛБАН ХААГЧДЫН НЭРСИЙН ЖАГСААЛТ

№	Овог нэр	Албан тушаал	Албан тушаалын зэрэглэл	Ажилласан хугацаа /жилээр/		Үйл ажиллагаа, мэргэшлийн түвшингийн үнэлгээ	Олгосон зэрэг дэв
				Төрийн албанд	Тухайн албан тушаалд		
1.	Жамбын Норовсамбуу	Төрийн захиргааны албаны зөвлөлийн дарга	ТӨ-Ү	34	1	Б	Тэргүүн зэрэг
2.	Нямдолгорын Сампилноров	Улсын цагаатгалын комиссын нарийн бичгийн дарга	АА-2	28	9	Б	Тэргүүн зэрэг
3.	Халтарын Шаандар	ТЗАЗ-ийн орон тооны гишүүн	ТЗ-13	23	6	Б	Тэргүүн зэрэг
4.	Жамбалсүрэнгийн Нарантуяа	УИХ-ын Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргын I орлогч дарга	АА-1	18	1.6	Б	Дэд зэрэг
5.	Сандуйжавын Одхүү	Ерөнхийлөгчийн Тамгын газрын Мэдээллэл, харилцааны албаны дарга	АА-3	19	1	Б	Дэд зэрэг

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 5 дугаар сарын 23-ны өдөр | Дугаар 130 | Улаанбаатар хот

Зарим шүүгчийг чөлөөлөх тухай

Монгол Улсын "Шүүхийн тухай" хуулийн 51 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалтыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадварын хувьд шүүгчээр ажиллах боломжгүй тухай Шүүгчийн мэргэшлийн хорооны дүгнэлт гарсантай холбогдуулан Доржийн Цэцгээг Нийслэлийн Баянгол дүүргийн шүүхийн шүүгчийн, Цэрэнхүүгийн Батчимэг, Мижидийн Баярсүрэн нарыг Нийслэлийн Баянзүрх дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр | Дугаар 81 | Улаанбаатар хот

Төр, засгийн үйлчилгээний авто баазын талаар авах зарим арга хэмжээний тухай

Төр, засгийн үйлчилгээний авто баазын үйл ажиллагаг зах зээлийн харилцаанд шилжүүлэх, үйлчилгээний чанарыг сайжруулах, төсвийн хөрөнгийг хэмнэж, үр ашигтай зарцуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Авто баазын гүйцэтгэж байгаа чиг, үүргийг харгалзан тухайн байгууллагын үйлчилгээний чанар, санхүүгийн удирдлагыг сайжруулах, үр ашгаа дээшлүүлэх сонирхлыг нэмэгдүүлэх зорилгоор 2003 оны 12 дугаар сарын 31-ний хүртэлх хугацаанд төр, засгийн үйлчилгээний авто баазыг орлогоороо зарлагаа нөхөх зарчмаар туршилтын журмаар ажиллуулсугай.

2. Орлогоороо зарлагаа нөхөх зарчмаар ажиллах нөхцөл бүрдүүлэх зорилгоор парк шинэчлэлтийн асуудалд төрөөс тодорхой дэмжлэг үзүүлж байгааг харгалзан нормативын дагуу байгуулбал зохих автомашины элэгдлийн 40 хувийг тусгасан зардлаар төр, засгийн байгууллагуудад үйлчлэх тээврийн үйлчилгээний нэг километрийн тарифыг үнэ, хэмжээг нь тогтоох эрхийг Сангийн яам, Үйлдвэр, худалдаа, аялал жуулчлалын яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Төрийн ордон, Үндэсний аудитын газар, Шүүхийн ерөнхий зөвлөлд тус тус олгосугай.

3. Авто баазын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор 2000 онд нурсан 50 автомашины гараашийг сэргээн засварлах зардалд шаардагдах 88,2 сая /наян найман сая хоёр зуун мянган/ төгрөгийг улсын төсвийн тодотголд тусган шийдвэрлэх, улсын нийгмийн даатгалд төлөх ёстой 36,0 /гучин зургаан/ сая төгрөгийг Засгийн газрын нөөц хөрөнгөөс гаргахыг Сангийн яам, Үйлдвэр, худалдаа, аялал жуулчлалын яам, Нийслэлийн Засаг даргын Тамгын газар, Төрийн ордон, Үндэсний аудитын газар, Шүүхийн ерөнхий зөвлөлд тус тус олгосугай.

4. Туршилтын хугацаанд өөрийн үйл ажиллагааны үр ашгийг нэмэгдүүлэх, бусад байгууллага, иргэдээс авах авлагыг барагдуулах зорилгоор татвар болон сэлбэг, материал, шатахууны өрийг /73,9 сая төгрөг/ барагдуулахыг төр, засгийн Үйлчилгээ, аж ахуйг эрхлэх газрын дарга Ж.Бадраад үүрэг болгосугай.

5. Албан тушаалын болон албан ажлын суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтны тоог багасгах чиглэлээр уг асуудлыг дахин хянан боловсруулж шинэчлэн батлуулахыг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ө.Энхтүвшинд даалгасугай.

6. Албан тушаалын болон албан ажлын суудлын автомашин хэрэглэх эрх бүхий албан тушаалтнууд автомашин хэрэглэхдээ дараахь

зарчмыг баримтлах нь зүйтэй гэж үзсүгэй:

а/хот дотор ажиллахдаа цилиндрийн багтаамж нь 1,3-2,2 литр бүхий суудлын автомашин хэрэглэх;

б/"Суудлын автомашин хэрэглэх эрхийн тухай" Засгийн газрын 1996 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 266 дугаар тогтоолоор батлагдсан лимитийг мөрдөх, хэтрүүлсэн нөхцөлд шатахууны зардлыг тухайн албан тушаалтан өөрөө нөхөн төлөх.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ,ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА **Ө.ЭНХТҮВШИН**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр **Дугаар 82** **Улаанбаатар хот**

Үндэсний хорооны дүрэм, бүрэлдэхүүн батлах тухай

Монгол Улсын Их Хурлаас батлагдсан "Монгол Улсын мэдээлэл, холбооны технологийн хөгжлийн 2010 он хүртэлх үзэл баримтлал"-ыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Монгол Улсын мэдээлэл, холбооны технологийн үндэсний хорооны дүрэм"-ийг 1 дүгээр хавсралт ёсоор батлуулсугай.

2. Мэдээлэл, холбооны технологийн үндэсний хорооны бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралт ёсоор батлуулсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ДЭД БҮТЦИЙН САЙД **Б.ЖИГЖИД**

Засгийн газрын 2001 оны 82 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

МОНГОЛ УЛСЫН МЭДЭЭЛЭЛ, ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Энэ дүрмээр Мэдээлэл, холбооны технологийн үндэсний хороо /цаашид "үндэсний хороо" гэх/-ны бүтэц, зохион байгуулалт, ажиллах журмыг зохицуулна.

2. Үндэсний хороо нь Улсын Их Хурлын 2000 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан "Монгол Улсын мэдээлэл, холбооны технологийн хөгжлийн 2010 он хүртэлх үзэл баримтлал"-аар тодорхойлсон стратегийн болон үйл ажиллагааны зорилтыг хэрэгжүүлэх талаар Засгийн газарт зөвлөлгөө өгөх үүрэг бүхий орон тооны бус байгууллага байна.

3. Мэдээлэл, холбооны талаархи төрийн бодлогыг хэрэгжүүлэхэд нийгмийн эрх тэгш оролцоог бүрдүүлэх, олон нийтийн хяналтыг сайжруулах зорилгоор Үндэсний хорооны бүрэлдэхүүнд төр, ашгийн төлөө хуулийн этгээд, боловсрол, шинжлэх ухааны болон төрийн бус байгууллагын төлөөллийг тэнцүү тоогоор оруулна.

Хоёр. Үндэсний хорооны бүтэц, зохион байгуулалт

4. Үндэсний хороог Монгол Улсын Ерөнхий сайд тэргүүлнэ.

5. Үндэсний хороо нь дэд тэргүүнтэй байна.

6. Үндэсний хорооны өдөр тутмын үйл ажиллагаог Үндэсний хорооны ажлын алба гүйцэтгэнэ.

7. Үндэсний хорооны бүрэлдэхүүнийг Засгийн газар батлах бөгөөд төлөөлөл тус бүрээс нэг гишүүн нь жил тутам солигдох зарчмаар бүрэлдэхүүнийг шинэчилнэ. Орны гишүүнийг түүний төлөөлөл санал болгосноор Засгийн газар баталгаажуулна.

8. Үндэсний хорооны ажлын албаны бүтэц,

зохион байгуулалт, ажиллах журмыг Үндэсний хорооны дарга батална.

Гурав. Үндэсний хорооны чиг үүрэг

9. Үндэсний хороо дараахь асуудлаар Засгийн газарт зөвлөлгөө өгнө:

1/мэдээлэл, холбооны технологийн хөгжлийн эрх зүйн таатай орчин бүрдүүлж, төлөвшүүлэх;

2/мэдээллийн бодлого, зохицуулалтын тогтолцоог бий болгох, төрийн мэдээллийн тогтолцоог мэдээлэл, холбооны технологиор дэмжин хөгжүүлэх;

3/мэдээлэл, холбооны технологийн бизнесийг өргөжүүлэх, өндөр үр ашигтай эдийн засгийн салбар болгох;

4/эдийн засаг-бизнесийн үр ашигтай, шуурхай мэдээллийн тогтолцоо бий болгох;

5/дотоодын үйлдвэрлэл, үйлчилгээ, боловсролын салбарт мэдээлэл, холбооны технологийг эрчимтэй нэвтрүүлэх;

6/мэдээллийн үйлчилгээгээр дамжуулан иргэд нийгмийн харилцаанд эрх тэгш оролцох боломжийг бүрдүүлэх;

7/нийгмийн үйлчилгээнд мэдээлэл, холбооны технологийг өргөн нэвтрүүлэх;

8/мэдээлэл, холбооны технологийн өнөөгийн байдал болон энэ талаар хэрэгжүүлж байгаа арга хэмжээний үр дүнд байнга дүгнэлт хийж, тухай бүр үнэлгээ өгч байх.

10. Үндэсний хороо мэдээлэл, холбооны технологийн хөгжлийн бодлогыг хэрэгжүүлэх талаар Засгийн газраас боловсруулсан бодлого, шийдвэрийн талаар санал, дүгнэлт, зөвлөмж гаргах эрхтэй.

Дөрөв. Үндэсний хорооны ажиллах журам

11.Үндэсний хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь Үндэсний хорооны хурал байна. Үндэсний хороо улиралд нэгээс доошгүй удаа хуралдана.

12.Үндэсний хорооны хурлыг Үндэсний хорооны тэргүүн, түүний эзгүйд дэд тэргүүн удирдана.

13. Үндэсний хорооны хурлын бэлтгэл ажлыг Үндэсний хорооны ажлын алба хариуцна.

14. Шаардлагатай гэж үзвэл хуралд холбогдох мэргэжлийн хүмүүсийг оролцуулан, тэдний санал, дүгнэлтийг сонсож болно.

15. Үндэсний хорооны хурлыг гишүүдийн олонхи оролцсон тохиолдолд хүчинтэйд тооцох бөгөөд хэлэлцэж буй асуудлыг хуралд оролцон гишүүдийн олонхийн саналаар шийдвэрлэнэ.

16. Үндэсний хорооны хурлын шийдвэр нь зөвлөмж бөгөөд хурлын тэмдэглэлийг хөтөлнө.

17. Үндэсний хороо тодорхой зарим асуудлаар ярилцлага, семинар, зөвлөгөөн, сургалт зохион байгуулж болно.

18. Үндэсний хороо ажлаа Засгийн газрын өмнө хариуцах бөгөөд жилд нэг удаа тайлагнана.

Засгийн газрын 2001 оны 82 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

МОНГОЛ УЛСЫН МЭДЭЭЛЭЛ, ХОЛБООНЫ ТЕХНОЛОГИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ БҮРЭЛДЭХҮҮН

Тэргүүн: Н. Энхбаяр — Монгол Улсын Ерөнхий сайд
Дэд тэргүүн: Т. Очирхүү — Улсын Их Хурлын Эдийн засгийн байнгын хорооны дарга /зөвшилцсөнөөр/
Гишүүд: Төрийн төлөөлөл
У.Уламбаяр — Дэд бүтцийн дэд сайд;
С.Батболд — Гадаад хэргийн дэд сайд;
Б.Эрдэнэсүрэн — Боловсрол , соёл, шинжлэх ухааны дэд сайд;
Г.Гэрэлт-Од — Монгол Улсын Ерөнхий сайдын зөвлөх.
Бизнесийн салбарын төлөөлөл
Д.Энхбат — Датаком ХХК-ийн захирал;
С.Нацагдорж — Бодькомпьютер ХХК-ийн захирал;
Р.Ганболд — Интерактив ХХК-ийн захирал;
Д.Болор — МЦХК-ийн Техникийн захирал.
Боловсрол, шинжлэх ухааны болон олон нийтийн байгууллагын төлөөлөл
Д.Бадарч — МУТИС-ийн ректор;
Т.Галбаатар — ШУА-ийн эрдэмтэн нарийн бичгийн дарга;
Ё.Буянжаргал — Мэдээлэл, Холбоо, Технологийн Нийгэмлэгийн Гүйцэтгэх Захирал;
О. Оюунцэцэг — Зохистой хөгжлийн жэндэр төвийн Удирдлагын зөвлөлийн дарга.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 4 дүгээр сарын 16-ны өдөр Дугаар 83 **Улаанбаатар хот**

Зарим байгууллагыг байгуулах, дүрэм батлах тухай

Эрчим хүчний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Эрчим хүчний зохицуулах газрыг байгуулж, дүрмийг хавсралт ёсоор батална.

2. Эрчим хүчний зохицуулах газрын орон тоо, цалингийн санг батална, эрчим хүчний байгууллагуудын бүтцийг Эрчим хүчний тухай хуулийн дагуу шинэчлэн зохион байгуулахыг Дэд бүтцийн сайд Б.Жигжидэд даалгасугай.

3. Дараахь арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Дэд бүтцийн сайд Б.Жигжид нарт даалгасугай:

а/эрчим хүчний салбарын төрийн өмчит үйлдвэрийн газруудыг төрийн өмчит компани болгон өөрчлөн байгуулах, алдагдалтай ажилладаг зарим үйлдвэрүүдэд олгож байгаа татаас болон эрчим хүчний салбарт үүссэн өр, авлагыг шийдвэрлэх талаар холбогдох байгууллагуудтай хамтран санал боловсруулж Засгийн газарт оруулж шийдвэрлүүлэх;

б/Эрчим хүчний зохицуулах газрын 2001 оны төсвийг хянаж, санхүүжүүлэх эх үүсвэрийг шийдвэрлэх.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ДЭД БҮТЦИЙН САЙД **Б.ЖИГЖИД**

Засгийн газрын 2001 оны 83 дугаар тогтоолын хавсралт

ЭРЧИМ ХҮЧНИЙ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Эрчим хүчний зохицуулах газар нь /цаашид "Газар" гэх/ холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, эрчим хүчээр хангах, диспетчерийн зохицуулалт хийх зэрэг үйл ажиллагааг зохицуулах үүрэг бүхий байгууллага мөн.

2. Газрын үндсэн зорилго нь Эрчим хүчний тухай хуульд заасны дагуу эрчим хүчний үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрөл зээмшигчидийн тарифыг хянаж батлах, тусгай зөвшөөрөл зээмшигчид, хэрэглэгчдийн эрх ашгийг тэнцвэртэй хамгаалах, үйлдвэрлэгч, хангагчийн хүрээнд шударга өрсөлдөөнийг бий болгох нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

3. Газар нь үйл ажиллагаандаа Эрчим хүчний тухай болон холбогдох бусад хууль тогтоомж, энэхүү дүрмийг удирдлага болгох бөгөөд Монгол Улсын нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэл, үндэсний аюулгүй байдал, төрөөс байгаль орчин болон эрчим хүчний үйлдвэрлэл, хангамжийн талаар баримталж буй бодлогод нийцсэн үйл ажиллагаа явуулна.

4. Газар нь Засгийн газарт үйл ажиллагаа, төсвийн гүйцэтгэлээ жил бүр тайлагнана.

5. Газар нь аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлүүдэд өөрийн эрх, үүргэт хамаарах асуудлаар мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлнэ.

6. Газар нь билгэдэл, тогтоосон журмаар хийлгэсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудастай байна.

Хоёр. Газрын удирдлага, зохион байгуулалт

7. Газрын удирдлага нь гурван зохицуулагчаас бүрдсэн Зохицуулагчдын зөвлөл байх бөгөөд тэдгээрийн нэг нь зөвлөлийн дарга байна. Зөвлөлийн дарга, зохицуулагчдыг Дэд бүтцийн сайдын саналыг үндэслэн Ерөнхий сайд томилж, чөлөөлнө.

8. Газар нь Тусгай зөвшөөрлийн алба, Үнэ тарифын алба, Эрх зүй, мэдээлэл, захиргааны алба гэсэн албатай байна.

9. Газрын өдөр тутмын үйл ажиллагаог Зохицуулагчдын зөвлөлийн дарга удирдах бөгөөд

дараахь эрх, үүрэгтэй байна:

1/ газрыг итгэмжлэлгүйгээр төлөөлөх;

2/ зохицуулагчдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг тодорхойлох, хуралдааныг товлох, удирдах;

3/ газрын ажилтнуудын ажил, үүргийн хуваарийг тогтоох, тэдгээрийг томилох, чөлөөлөх, тэдэнд хариуцлага хүлээлгэх, ажилтнуудын цалин хөлсийг холбогдох хууль тогтоомжийн дагуу тогтоох;

4/ батлагдсан цалингийн санд багтаан газрын орон тоог тогтоох, эрх хэмжээнийхээ асуудлаар тушаал гаргаж, биелэлтийг хангуулах;

5/ шаардлагатай бол тодорхой асуудал боловсруулах, дүгнэлт гаргах, магадлан шинжилгээ хийлгэхэд шинжээч, мэргэжилтнийг татан оролцуулах, гэрээгээр ажиллуулах, тэдгээрт цалин хөлс олгох асуудлыг шийдвэрлэх;

6/ зохицуулагчдын зөвлөлийн шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж, биелэлтийг хангуулах арга хэмжээ авах, бусад байгууллага, аж ахуйн нэгжтэй байгуулах гэрээ, хэлэлцээрийг батлах.

10. Зохицуулагчдын зөвлөлийн даргын эзгүйд түүнийг зохицуулагчаар хамгийн олон жил ажилласан, хэрэв зохицуулагчдын ажилласан жил адил бол насаар ахмад зохицуулагч нь орлоно.

11. Газар нь шаардлагатай гэж үзвэл Зохицуулагчдын зөвлөлд зөвлөх үүрэг бүхий хэрэглэгч, түсгай зөвшөөрөл эзэмшигчийн тэнцүү тооны төлөөллөөс бүрдсэн орон тооны бус зөвлөл (цаашид "Зөвлөх зөвлөл" гэх)-ийг байгуулан ажиллуулж болох бөгөөд түүний үйл ажиллагааг зөвлөлийн дарга удирдана.

Гурав. Газрын үйл ажиллагаа

А. Зохицуулагчдын зөвлөл

12. Зохицуулагчдын зөвлөл нь дараахь эрх, үүрэгтэй байна:

1/ газрын чиг үүрэг, бүрэн эрхэд хамаарах асуудлуудыг хэлэлцэж шийдвэрлэх;

2/ батлагдсан тесвийг захиран зарцуулах;

3/ газрын дотоод үйл ажиллагаанд мөрдөх болон өөрийн эрх хэмжээнд хамаарах асуудлаар дүрэм, журам, заавар баталж, биелэлтэд нь хяналт тавих;

4/ газрын албаны даргыг томилох, чөлөөлөх, албадын үйл ажиллагаанд үнэлэлт, дүгнэлт өгөх;

5/ Зохицуулагчдын зөвлөлийн шийдвэрийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгсэл, олон нийтэд мэдээлэх.

13. Газрын шийдвэрлэх асуудлыг Зохицуулагчдын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэнэ.

14. Зохицуулагчдын зөвлөлийн хуралдаан сард нэгээс доошгүй удаа хуралдах бөгөөд шаардлагатай тохиолдолд зөвлөлийн дарга ээлжит бус хуралдааныг зарлан хуралдуулж болно.

15. Зохицуулагчдын зөвлөлийн хуралдааныг 3 зохицуулагчийн бүрэлдэхүүнтэйгээр хийх бөгөөд саналаа илээр гаргаж, асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэнэ. Хэрэв аль нэг зохицуулагч хуралдаанд оролцох боломжгүй бол хэлэлцэх асуудлын талаархи саналаа бичгээр гарган битүүмжилж зөвлөлийн нарийн бичгийн даргад урьдчилан ирүүлнэ.

16. Хурлын шийдвэр тогтоол хэлбэртэй байх бөгөөд хурлын явцад дэлгэрэнгүй тэмдэглэл хөтлөнө. Тэмдэглэлийг зөвлөлийн нарийн бичгийн дарга хөтлөнө.

17. Зохицуулагчдын зөвлөлийн тогтоолд зөвлөлийн дарга, зохицуулагчид, хуралдааны тэмдэглэлд зөвлөлийн дарга, нарийн бичгийн дарга тус тус гарын үсэг зурж баталгажуулсан байна.

18. Зохицуулагчдын зөвлөл шийдвэр гаргахдаа аль нэг талын болон хувийн ашиг сонирхлын үүднээс хандахгүй байх зарчмыг баримтална.

19. Зохицуулагчид нь өөрийн хариуцсан чиглэлээр санал боловсруулж, зөвлөлийн хуралдаанд оруулж шийдвэрлүүлэх эрхтэй байна.

20. Зохицуулагчдын зөвлөлийн дарга, зохицуулагч нь эрчим хүчний салбарт болон энэ чиглэлээр ажилласан, дадлага туршлагатай, дээд боловсролтой, Монгол Улсын иргэн байна.

21. Зохицуулагчдыг дараахь тохиолдолд

үүрэгт ажлаас нь чөлөөлнө:

1/ томилогдсон хугацаа дууссан;

2/ өөрөө хүсэлт гаргасан;

3/ эрүүл мэндийн хувьд цаашид ажиллах бсломжгүй болсон нь эрүүл мэндийн байгууллагаар тогтоогдсон;

4/ иргэний харьяалал өөрчлөгдсөн;

5/ хууль тогтоомж зөрчсөн нь эрх бүхий байгууллагаар тогтоогдсон.

22. Хугацаа дуусахаас өмнө үүрэгт ажлаасаа чөлөөлөгдсөн зохицуулагчийн оронд шинээр зохицуулагч томилохдоо өмнөх зохицуулагчийн үлдсэн хугацаагаар томилно.

23. Газрын үйл ажиллагаатай холбоотой мэдээ материал, баримт бичиг /төрийн болон байгууллагын нууцад хамаарахаас бусад/ нийтэд ил тод байна.

Б. Тусгай зөвшөөрлийн алба

24. Тусгай зөвшөөрлийн алба нь дараахь эрх, үүрэгтэй байна:

1/ тусгай зөвшөөрөл эзэмшихэд тавигдах шаардлагуудыг тогтоох;

2/ тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үйл ажиллагааны болон тусгай зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг тогтоох, хэрэгжилтийг хянах;

3/ тусгай зөвшөөрөл авах тухай өргөдлийг хүлээн авч, хянах, өргөдөл, түүнд хавсаргасан баримтуудыг шаардлага хангаагүй гэж үзвэл өргөдөл гаргагчид буцаах, энэ талаар баримтлах журам тогтоох;

4/ эрчим хүчээр зохицуулалтгүй хангах тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хэрэглэгчтэй байгуулсан гэрээг бүртгэх;

5/ тусгай зөвшөөрөл эзэмшигчийн үг зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа болон Зохицуулагчдын зөвлөлийн тогтоол, холбогдох дүрэм, журмын биелэлтэд хяналт тавих;

6/ хангагчийн "Аж ахуйн харилцааны дүрэм"-д тусгах шаардлагуудыг тогтоож, батлах, түүнд өөрчлөлт оруулах;

7/ эрчим хүчний үйлдвэрлэл, хангамжид зүй ёсны монополийг хууль бусаар ашиглах явдлаас урьдчилан сэргийлэх, энэ талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах;

8/ эрчим хүчний хангамжийн чанарт тавигдах шаардлагуудыг тогтоох, хэрэгжилтийг хянах;

9/ тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагааны тайлан, техник, эдийн засгийн үзүүлэлтүүд болон диспетчерийн зохицуулалт хийх тусгай зөвшөөрөл эзэмшигчийн боловруулсан ойрын болон урт хугацааны эрчим хүчний үйлдвэрлэл, хэрэглээний урьдчилсан таамаглалд дүн шинжилгээ хийх;

10/ эрчим хүчээр зохицуулалтгүй хангалтаар үйлчлүүлэх шалгуур үзүүлэлтүүдийг тогтоох;

11/ тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн тоног төхөөрөмж, техник, технологийн ашиглалтын стандартыг дотоодын болон олон улсын шалгуурт нийцүүлэн боловсруулах.

25. Тусгай зөвшөөрлийн алба нь дараахь асуудлаар санал боловсруулж,Зохицуулагчдын зөвлөлийн хурлаар шийдвэрлүүлнэ:

1/ тусгай зөвшөөрөл олгох, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

2/ тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон тохиолдолд эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх найдвартай ажиллагаат хангах, хэрэглэгчдийн эрчим хүчний хангамжийг тасалдуулахгүй байх үүднээс бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчээр энэхүү үйл ажиллагаат тусгай зөвшөөрлийн асуудлыг шийдвэрлэх хүртэл хугацаанд түр гүйцэтгүүлэх;

3/ тусгай зөвшөөрөл эзэмшигч нь өөрчлөгдөн зохион байгуулагдах, тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагааг хэвийн явуулахад шаардагдах барилга байгууламж, шугам сүлжээ, тоног төхөөрөмж, бусад эд хөрөнгийг шинэчлэх, өөрчлөх, тэдгээрийг өмчлөх эрхээ шилжүүлэх, барьцаалах нь тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаанд нөлөөлөхөөр бол тухайн өөрчлөлтийг зөвшөөрөх эсэхийг шийдвэрлэх талаар санал боловсруулах.

В. Үнэ тарифын алба

26. Үнэ тарифын алба нь дараахь эрх, үүрэгтэй байна:

1/ тариф тогтоох аргачлал боловсруулах, тусгай зөвшөөрлийн төрөл тус бүрээр тарифын бүтцийг тодорхойлох, тарифыг Зохицуулагчдын зөвлөлөөр батлуулах, түүнийг хянаж, энэ талаар баримтлах журам тогтоох;

2/ тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн санхүү, эдийн засгийн байдал, үйл ажиллагааны зардалд дүн шинжилгээ хийх, зардлын бүтцийг тодорхойлох аргачлалыг тогтоох;

3/ тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн санхүүгийн нөөц, чадавхийн өөрчлөлт болон уг өөрчлөлт нь тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаанд үзүүлэх нөлөөллийг хянах;

4/ тариф тогтоох аргачлалд ашиглах зорилгоор тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн санхүү, эдийн засгийн болон үйл ажиллагааны зардлын үзүүлэлтийн талаар мэдээллийн системийг бүрдүүлэх, уг мэдээллийг байнга шинэчлэх;

5/ эрчим хүч үйлдвэрлэх, дамжуулах, түгээх, хангах, диспетчерийн зохицуулалт хийх үйл ажиллагаанд техник, технологийн найдвартай ажиллагааны шаардлагад нийцүүлэн хамгийн бага өртгийн зарчмыг мөрдүүлэх;

6/ тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс авах зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээний талаар санал боловсруулах;

7/ тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэхэд чиглэсэн дэмжлэг туслалцаа үзүүлэх;

8/ аймаг, нийслэлийн зохицуулах зөвлөлүүдэд өөрийн эрх, үүрэгт хамаарах асуудлаар мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

9/ тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс хэрэглэгчид үзүүлэх үйлчилгээ, эрчим хүчний зохицуулалттай тариф, төлбөр тооцооны болон хангамжийн бусад нөхцөлүүдээр нэг зэрэглэлийн хэрэглэгчдийг үндэслэлгүйгээр ялгаварлахгүй байх нөхцөлийг бүрдүүлэх болон бусад.

Г. Эрх зүй, мэдээлэл, захиргааны алба

27. Эрх зүй, мэдээлэл, захиргааны алба нь дараахь эрх, үүрэгтэй байна:

1/ газрын эрх хэмжээнд хамаарах асуудлаар холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, зааврын төсөл боловсруулж, газрын дотоод дүрэм, журмын мөрдөлтөд хяналт тавих;

2/ зөвлөлийн шийдвэрийн хууль зүйн үндэслэлийг хангуулах, төр, засаг, холбогдох дээд байгууллагын тогтоол шийдвэрийн биелэлтэд хяналт тавих

3/ хэрэглэгчдийн эрх ашгийг хөндсөн асуудал болон хэрэглэгчээс гарсан санал, гомдлыг судалж, зохих журмын дагуу шийдвэрлэх ;

4/ бусад байгууллага, аж ахуйн нэгжтэй байгуулах гэрээ, хэлэлцээрийг боловсруулах, биелэлтэд хяналт тавих, зөвлөлийн шийдвэрийг хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд сурталчлан тайлбарлах;

5/ олон улсын байгууллага болон гадаад улсын эрчим хүчний зохицуулах байгууллагуудтай хамтран ажиллаж, туршлага судлах, газрын үйл ажиллагаанд нэвтрүүлэх;

6/ тусгай зөвшөөрөлд заасан үйл ажиллагаа, техник, эдийн засгийн талаар дотоод мэдээллийн нэгдсэн сан бий болгох, тусгай зөвшөөрөл эзэмшигчид, албадуудаас холбогдох мэдээллийг гаргуулах, төр захиргааны байгууллагуудыг мэдээллээр хангах;

7/ тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хооронд болон тусгай зөвшөөрөл эзэмшигч, хэрэглэгчийн хооронд газрын эрх хэмжээний асуудлаар үүссэн маргааныг шийдвэрлэх арга хэмжээ авах;

8/ газрын хэмжээнд архив, бичиг хэргийг зохих дүрэм, журмын дагуу хөтлөх;

9/ газрын жилийн төсвийн болон хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний төслийг боловсруулах, төсвийн бүрдэлтэд хяналт тавих;

10/ нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан тэнцэл гарган аудитаар баталгаажуулж нийтлэх;

11/ газрын ажилтнуудыг сургалтад хамруулан мэргэшүүлэх, тэдний нийгмийн асуудлын талаар санал боловсруулж шийдвэрлүүлэх.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 4 дүгээр сарын 17-ны өдөр Дугаар 84 **Улаанбаатар хот**

Журам батлах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 37 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Худалдах доод үнэ тогтоох журам"-ыг хавсралт ёсоор батлсугай.

2. Өмч хувьчлалыг явуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд заасан арguудыг хэрэгжүүлэх журмыг хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулж мөрдөхийг Төрийн өмчийн хорооны дарга Л.Пүрэвдоржид зөвшөөрсүгэй.

3. Орон нутгийн өмчийг хувьчлахдаа энэ тогтоолын 1 дүгээр зүйлээр батлсан Худалдах доод үнэ тогтоох журмыг удирдлага болгон ажиллахыг аймаг, нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, түүний Тэргүүлэгчдэд зөвлөмж болгосугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 1997 оны 7 дугаар сарын 2-ны өдрийн 160 дугаар тогтоолын 1 дүгээр зүйл, "Журам батлах тухай" Засгийн газрын 1997 оны 11 дүгээр сарын 3-ны өдрийн 221 дүгээр тогтоолыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД Ч.УЛААН

Засгийн газрын 2001 оны 84 дүгээр тогтоолын хавсралт

ХУДАЛДАХ ДООД ҮНЭ ТОГТООХ ЖУРАМ

1. Хувьчлагдах төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувьцаа, ногдол хувь болон дуусаагүй барилга байгууламж, ашиглалтгүй буюу илүүдэлтэй үл хөдлөх хөрөнгө, үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн худалдах доод үнийг тогтоохдоо энэхүү журмыг мөрдөнө.

2. Хувьчлагдах төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төрийн эзэмшлийн хувьцаа, ногдол хувийн худалдах доод үнийг Төрийн өмчийн хороо тогтоох бөгөөд тухайн хувьчлагдах хуулийн этгээдийн онцлогоос хамааран дараахь аргачлалын аль оновчтойг сонгон хэрэглэнэ:

а/бизнесийн үнэлгээний /үнийн стандарт, ирээдүйн орлогын өнөөгийн үнэ цэнийг тодорхойлох, цэвэр хөрөнгийн үндсэн дээр тооцох, зах зээлийн харьцуулалт хийх болон бусад/ аргуудын аль тохирохыг хэрэглэх;

б/төрийн өмчийн оролцоотой хувьцаат компанийн төрийн эзэмшлийн хувьцааг хувьчлахад Төрийн өмчийн хорооноос хувьчлах шийдвэр гаргахаас өмнөх 52 долоо хоногт Монголын хөрөнгийн биржээр арилжаалагдсан тухайн хувьцаат компанийн нэгж хувьцааны үнийн дундаж ханшийг хувьчлах төрийн эзэмшлийн хувьцааны тоогоор үржүүлэн тогтоох;

в/ төрийн өмчит үйлдвэрийн газрын болон төрийн өмчийн оролцоотой хязгаарлагдмал хариуцлагатай компанийн төрийн эзэмшлийн ногдол хувийн худалдах доод үнийг тухайн хуулийн этгээдийн дахин үнэлгээ хийсэн хувьчлагдах хөрөнгийн үнэлгээнээс тооцон тодорхойлох. Хувьчлагдах хөрөнгө нь тухайн хуулийн этгээдийн нийт хөрөнгөөс бусдад өгөх нийт өр төлбөрийг хасч, төрд ногдох хувь

хэмжээгээр үржүүлсэнтэй тэнцэх бөгөөд энэ нь хувьчлагдах хөрөнгийн 40 хувиас доошгүй байх;

г/төрийн өмчит үйлдвэрийн газрын сүүлийн 3 жилийн татварын дараахь цэвэр ашгийн дундаж хэмжээгээр тогтоох;

д/төрийн өмчит үйлдвэрийн газар олон жил дараалан алдагдалтай, үр ашигүй ажилласан бол худалдах доод үнэ нэг төгрөг байна;

е/тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааны цар хүрээ, үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ, ашигт ажиллагааны түвшин зэргээс хамааруулан Төрийн өмчийн хороо дээр дурдсанаас өөр аргачлал хэрэглэж болно.

3. Энэ журмын 2 дугаар заалтын "а"-г хэрэгжүүлэх болон 6 дугаар заалтад дурдсан хуулийн этгээдийн худалдах доод үнийг тогтоохын тулд эрх бүхий хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний компаниудын дунд Төрийн өмчийн хорооноос тендер зарлан, хувьчлах хуулийн этгээдийг худалдах доод үнийн талаар санал авч болно.

4. Хувьчлагдах хуулийн этгээдийн худалдах доод үнийг энэ журмын 2 дугаар заалтад заасан аргачлалын аль нэгээр тодорхойлох боломжгүй, эсхүл тусгай нөхцөлөөр хувьчлах хуулийн этгээдийн хувьд Доод үнэ тогтоох шинжээчдийн хэсгийг Засгийн газар томилно.

5. Энэ журмын 4 дүгээр заалтад дурдсан „Худалдах доод үнийг тодорхойлох боломжгүй хуулийн этгээд" гэдэгт дор дурдсан төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд орно:

а/үндсэн үйл ажиллагааны бус хэлбэрээр сүүлийн 3 жил ашиг олсон;

б/жил дараалан алдагдалтай ажилласан болон балансдаа өртэй боловч харилцах дансандаа аль нэг хэлбэрээр их хэмжээний бэлэн мөнгөтэй, мөн бэлэн мөнгөнд хувирах боломжтой бараа бүхий.

6. „Тусгай нөхцөлөөр хувьчлах хуулийн этгээд" гэдэгт дор дурдсан төрийн өмчит үйлдвэрийн газар, төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд орно:

а/Засгийн газар хоорондын хэлэлцээрээр байгуулагдсан хамтарсан үйлдвэр;

б/Монгол улсын стратегийн ач холбогдол бүхий үнэ цэнэтэй хуулийн этгээд;

в/хандивлагч орнуудын болон олон улсын байгуулагын шугамаар төсөл хэрэгжиж байгаа, гадаадын зээлийн өртэй, буцалтгүй тусламжийн бараа хадгалдаг, борлуулдаг хуулийн этгээд.

7. Доод үнэ тогтоох шинжээчдийн хэсэг нь 9 хүний бүрэлдэхүүнтэй байна. Шинжээчдийн хэсгийн нарийн бичгийн дарга нь Төрийн өмчийн хорооны Өмч хувьчлалын газрын дарга байх бөгөөд бусад 8 хүнийг Төрийн өмчийн хорооны саналыг үндэслэн Засгийн газар тухай бүр томилно.

8. Шинжээчдийн хэсэг нь дийлэнх олонхийн бүрэлдэхүүнтэй хуралдаж, аливаа асуудлыг дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэх зарчмыг баримтална.

9. Дуусаагүй барилга байгууламж, ашиглалтгүй буюу илүүдэлтэй үл хөдлөх хөрөнгө, үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгийн худалдах доод үнийг Төрийн өмчийн хороо тогтооно.

10. Худалдах доод үнэ тогтоохтой холбогдон гарах зардлыг өмч хувьчлалын зардлаас санхүүжүүлнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр Дугаар 85 Улаанбаатар хот

"Мянганы зам" төслийг хэрэгжүүлэх талаар авах зарим арга хэмжээний тухай

"Мянганы зам болон дэд бүтцийн босоо тэнхлэгийн чиглэл батлах тухай" Улсын Их Хурлын 2001 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 9 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Засгийн газрын бүрэн эрхийн хугацаанд "Мянганы зам"-ын чигийн дагуухь давааа, намаг, шавартай газрыг засч 800 хүртэл км зам, 600 хүртэл метр төмөр бетон гүүр барьж байгуулах нь зүйтэй гэж үзсүгэй.

2. "Мянганы зам" төслийн хүрээнд 2001 онд хийх зам, гүүрийн хайгуул, зураг төсөв, барилга угсралтын ажлын жагсаалтыг 1 дүгээр хавсралт ёсоор батална.

3. Дараахь арга хэмжээ авахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгасугай:

а/ "Мянганы зам"-ын ажилд 2001 онд шаардагдах 2,5 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг улсын төсвийн тодотголд тусган шийдвэрлүүлж 2 дугаар хавсралтад заасан арга хэмжээг санхүүжүүлэх;

б/"Мянганы зам"-ын зүүн чиглэлээр баригдах зам, барилгын ажлын санхүүжилтэд зориулж 600 сая төгрөгийг энэ оны 4 дүгээр сараас эхлэн Авто замын сангаас санхүүжүүлэх;

в/2002 оноос эхлэн автобензин, дизелийн түлшний онцгой албан татвартай дүйцхүйц хэмжээний хөрөнгийг "Мянганы зам"-ын ажлын санхүүжилтийн эх үүсвэрийг нэмэгдүүлэхэд зориулан зарцуулах.

4. Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тодотгол хийх үед батлагдсан хөрөнгө оруулалтын хэмжээг зохицуулах, оновчтой хуваарилах замаар "Мянганы зам"-д шаардагдах нэмэгдэл эх үүсвэр гаргах санал боловсруулж, Засгийн газарт оруулж шийдвэрлүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Дэд бүтцийн сайд Б.Жигжид нарт даалгасугай:

5. Ядуурлыг бууруулах, хөдөлмөр эрхлэлтийг дэмжихэд чиглэсэн гадаад, дотоодын санхүүгийн эх үүсвэрийн зохих хувийг "Мянганы зам"-ын ажилд оролцох ажилгүй иргэдийг ажлын байраар хангах, тэдгээрийн нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зарцуулж байхыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаяр нарт даалгасугай.

6. "Мянганы зам" төслийг хэрэгжүүлэхэд хандивлагч орнууд, олон улсын банк, санхүүгийн байгууллагын дэмжлэг туслалцаа авах, хөрөнгийн эх үүсвэрийг олох ажлыг тус улсаас гадаад орнуудад суугаа Элчин сайдын яамдаар дамжуулан зохион байгуулахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун, Дэд бүтцийн сайд Б.Жигжид нарт даалгасугай.

7. Зам, барилгын ажлын тодорхой хэсгүүдэд сум, суурин болон хөдөө орон нутгийн ажилгүй иргэд, хоригдлуудыг нэгдсэн зохион байгуулалттайгаар ажиллуулах арга хэмжээ авахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаяр, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Дэд бүтцийн сайд Б.Жигжид, холбогдох аймгийн Засаг дарга нарт даалгасугай.

8. "Мянганы зам" төслийг хэрэгжүүлэхэд бүх нийтийн идэвхтэй оролцоог нэмэгдүүлэх, дотоод нөөц бололцоогоо бүх талаар дайчлан ашиглах, ажиллах хүчийг оновчтой зохион байгуулж ажиллахыг бүх шатны Засаг дарга нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ДЭД БҮТЦИЙН САЙД Б.ЖИГЖИД

Засгийн газрын 2001 оны 85 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

"МЯНГАНЫ ЗАМ" ТӨСЛИЙН ХҮРЭЭНД 2001 ОНД ХИЙГДЭХ ЗАМ ,ГҮҮРИЙН ХАЙГУУЛ, ЗУРАГ ТӨСӨВ, БАРИЛГА УГСРАЛТЫН АЖЛЫН ЖАГСААЛТ

/Сая төгрөгөөр/

№	Объектын нэр	Зардал			
		Хайгуул, зураг төсөв		Барилга угсралтын ажил	Дүн
		Улсын төсвөөс	Хандивын хөрөнгөөс		
1	Хашаат /Ховд/, Бураат /Баян-өлгий/, Загастай, Булжих, Бохөн шар /Завхан/, Ухаачулуут /Архангай/, Хангай, Дөтлүүр /Төв/ зэрэг даваануудын зам	65.0		732.8	797.8
2	Завхан голын төмөр бетон гүүр, Орхон голын төмөр бетон гүүр, Халх голын төмөр бетон гүүр, Хонгио, Шурагын гол, Тогосын хоолойн гүүр	54.0		890.0	944.0
3	Улаанбайшинтаас Завханы Завхан-Тээлийн бэлчир, Төв аймгийн Лүн сумаас Архангай аймгийн Батцэнгэл сум хүртэл замын хайгуул, зураг төсвийн ажил хийх	740.0	141.0		881.0
	Нийт дүн	**859.0**	**141.0**	**1622.8**	**2622.8**
	Үүнээс улсын төсвөөс	859.0		1622.8	2481.8

Засгийн газрын 2001 оны 85 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

"МЯНГАНЫ ЗАМ" ТӨСЛИЙН ХҮРЭЭНД УЛСЫН ТӨВЛӨРСӨН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР САНХҮҮЖҮҮЛЭХ ХАЙГУУЛ, ЗУРАГ ТӨСӨВ, ЗАМ, ГҮҮРИЙН БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙН ЖАГСААЛТ

/сая.төгрөгөөр/

№	Төсөл, арга хэмжээний нэр, байршил	Хүчин чадал	Барих хугацаа	Төсөвт өртөг	2001 оны төсөл	Сараар								
						IУ	У	УI	УII	УIII	IX	X	XI	XII
	Нэг. Өндөр даваануудыг налгааж бартаагүй арилгах													
1	Баян-өлгий аймаг, Бураатын даваа	12 км	2001-2004	720.0	54.2	10.0	10.0	8.0	7.0	8.0	8.0	3.2		
2	Ховд аймаг, Хашаатын даваа	8 км	2001-2004	480.0	85.2	10.0	10.0	15.0	15.0	14.0	12.0	9.2		

3	Завхан аймаг, Бөхөн шарын давааа	10 км	2001-2004	600.0	103.5		10.0	20.0	20.0	30.0	15.0	8.5		
4	Завхан аймаг, Булжихын давааа	8 км	2001-2004	480.0	123.2		15.0	18.0	25.0	22.0	25.0	18.2		
5	Завхан аймаг, Загастайн давааа	12 км	2001-2004	720.0	203.9		25.0	30.0	35.0	44.0	42.0	27.9		
6	Архангай аймаг, Ухаачулуутын давааа	10 км	2001-2004	600.0	104.4	15.0	15.0	20.0	20.0	20.0	7.4	7.0		
7	Төв аймаг, Хангайн давааа	14 км	2001-2004	840.0	57.3	10.0	8.0	8.0	8.0	10.0	10.0	3.3		
8	Төв аймаг, Дөтлүүрийн давааа	6 км	2001-2004	360.0	66.1	10.0	8.0	10.0	10.0	10.0	10.0	8.1		
	Хөөр. Төмөр бетон гүүрийн барилга													
1	Завхан аймаг, Завхан гол	200 м	2001-2004	1000.0	160.0			20.0	20.0	30.0	40.0	30.0	10.0	10.0
2	Архангай аймаг, Орхон гол	210 м	2001-2004	1050.0	160.0			20.0	20.0	20.0	30.0	40.0	20.0	10.0
3	Дорнод аймаг, Халх гол	40 м	2001-2002	300.0	70.0					10.0	20.0	20.0	10.0	10.0
4	Ховд аймаг, Шурагын гол	120 м	2001-2003	600.0	80.0				10.0	10.0	20.0	20.0	10.0	10.0
5	Ховд аймаг, Хонгиогийн гол	40 м	2001-2002	200.0	44.0						10.0	10.0	20.0	4.0
6	Төв аймаг,Тогосын хоолой	72 м	2001	430.0	430.0	50.0	80.0	50.0	50.0	50.0	50.0	50.0	30.0	20.0
	Гурав. Хайгуул, зураг													
1	Улаанбайшинтаас Завханы Завхан-Тээлийн бэлчир	500 км	2001	470.0	470.0		40.0	40.0	60.0	50.0	80.0	80.0	80.0	40.0
2	Төв аймгийн Лүн сумаас Архангай аймгийн Батцэнгэл сум	300 км	2001	270.0	270.0	40.0	30.0	30.0	30.0	30.0	30.0	30.0	30.0	20.0
	ДҮН				2481.8	145.0	251.0	289.0	330.0	358.0	409.4	365.4	210.0	124.0

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 4 дүгээр сарын 18-ны өдөр **Дугаар 86** **Улаанбаатар хот**

Дүрэм батлах тухай

Улсын Их Хурлын 2001 оны 9 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Мянганы зам" төслийг хэрэгжүүлэх Үндэсний хорооны дүрмийг хавсралт ёсоор батлалсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ДЭД БҮТЦИЙН САЙД Б.ЖИГЖИД

Засгийн газрын 2001 оны 86 дугаар тогтоолын хавсралт

"МЯНГАНЫ ЗАМ" ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1."Мянганы зам" төсөл /цаашид "төсөл" гэх/ -ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах Үндэсний хороо /цаашид "Үндэсний хороо" гэх/ нь төслийн хүрээнд хэрэгжүүлэх ажлыг төлөвлөх, төсөлд оролцож буй байгууллагуудын үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, хяналт тавих үүрэг бүхий орон тооны бус байгууллага мөн.

2. Үндэсний хороо нь 17 хүний бүрэлдэхүүнтэй байх бөгөөд хорооны дарга, гишүүдийг Засгийн газраас батална.

3. Үндэсний хороо нь хорооны өдөр тутмын ажлыг эрхлэн гүйцэтгэх үүрэг бүхий зохицуулагчтай байна. Төслийн зохицуулагчийг Үндэсний хорооны дарга томилно.

4. Үндэсний хорооны үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь гишүүдийн хурал байна. Хурлыг Үндэсний хорооны гишүүдийн ердийн олонхи оролцсоноор хүчинтэйд тооцно.

5. Үндэсний хорооноос тогтоол гаргах бөгөөд асуудлыг олонхийн саналаар шийдвэрлэнэ. Тогтоолд Үндэсний хорооны дарга гарын үсэг зурна.

6. Үндэсний хорооны ажлын алба нь Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Авто замын газрын бүтцэд байна.

7. Аймаг, нийслэлд уг төслийг хэрэгжүүлэх ажлыг төслийн салбар хороо, суманд товчоо эрхлэн ажиллана. Салбар хороог аймаг, нийслэлийн Засаг дарга 7 хүний бүрэлдэхүүнтэйгээр, товчоог сумын Засаг дарга 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр тус тус байгуулна. Шаардлагатай бол нийслэлийн зарим дүүрэгт товчоо байгуулан ажиллуулж болно.

Хоёр.Үндэсний хорооны эрх, үүрэг

8.Үндэсний хороо дараахь эрхийг эдэлнэ:

1/"Мянганы зам"-ын зориулалтаар төвлөрсөн хөрөнгийг зарцуулах хуваарийг батлах;

2/төслийн хөрөнгийн ашиглалт, зарцуулалтын байдалтай танилцах, төслийг хэрэгжүүлэх ажлын явц, үр дүнд хянан магадалгаа хийлгэх, үнэлгээ, дүгнэлт гаргуулах, шаардлагатай бол Засгийн газрын шийдвэр гартал санхүүжилтийг түр зогсоох арга хэмжээ авах;

3/төслийн санд хандив өргөсөн, төслийг хэрэгжүүлэхэд тодорхой хувь нэмэр оруулсан байгууллага, аж ахуйн нэгж, хувь хүнийг шагнаж урамшуулах;

4/төслийг хэрэгжүүлэх явцад гарсан маргаантай асуудалд мэргэжлийн байгууллага, шинжээчээр дүгнэлт гаргуулах, холбогдох арга хэмжээ авах;

5/төслийн хүрээнд тодорхой асуудлыг хариуцан гүйцэтгэх ажлын хэсэг байгуулах.

9. Үндэсний хороо нь дараахь үүргийг хэрэгжүүлнэ:

1/төслийг хэрэгжүүлэхтэй холбогдсон санал боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтнаар шийдвэрлүүлэх арга хэмжээ авах;

2/төслийн хүрээнд барьж байгуулах зам, замын байгууламж, тэдгээрийн техник, эдийн засгийн үндэслэл, хайгуул, зураг төсөл, барилга угсралт, засвар арчлалтын ажлын дарааллыг тогтоох;

3/аймаг, нийслэл, сум, дүүрэг дэх салбар зөвлөл, товчооны ажлыг уялдуулан зохицуулах;

4/замын барилга угсралтын ажлын явц, хэрэгжилтэд хяналт тавих;

5/шинэ техник, технологи нэвтрүүлэх, шинэ материал ашиглахад дэмжлэг туслалцаа үзүүлэх;

6/"Мянганы зам"-ын хөрөнгийг үр ашигтай зарцуулах, түүнд хяналт тавих;

7/төслийг хэрэгжүүлэх ажлыг дэмжих хөдөлгөөн өрнүүлэх, олон нийтийг хамарсан ажил зохион байгуулах;

8/төслийг дэд бүтцийн салбарт хэрэгжиж буй төсөл, арга хэмжээнүүдтэй уялдуулан зохицуулах;

9/төслийг хэрэгжүүлэхэд шаардлагатай ажиллах хүчний тооцоо, судалгаа гарган бэлтгэх /сургах/, шаардлагатай мэргэжилтнээр хангах ажлыг зохион байгуулах, зохицуулах арга хэмжээ авах;

10/төслийн ач холбогдол, хэрэгжилт, үр дүнгийн талаар олон нийтэд хэвлэл, мэдээллийн хэрэгслээр сурталчлах ажлыг зохион байгуулах;

11/төслийн хүрээнд гадаадын байгууллага, хамт олон, хүмүүсийг Монгол Улсын холбогдох байгууллагатай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх ажлыг зохион байгуулах;

12/төслийг хэрэгжүүлэхэд хөрөнгө хуримтлуулах зорилгоор үнэт цаас гаргах саналыг холбогдох эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлэх.

Гурав.Бусад

10. Үндэсний хороо ажлаа Засгийн газрын өмнө хариуцах бөгөөд төслийн үйл ажиллагааны явцын талаар хагас жил тутам Засгийн газарт танилцуулна.

11. Үндэсний хорооны гишүүд нь өөрийн хариуцсан ажлын талаар улирал бүр Үндэсний хорооны хуралд тайлагнана. Үндэсний хорооны дарга гишүүдийнхээ ажлыг дүгнэнэ.

12. Үндэсний хорооны үйл ажиллагааны болон ажлын хэсгийн зардлыг Үндэсний хорооны дарга Сангийн сайдтай зөвшилцөн батлуулж, санхүүжүүлнэ.

13. Үндэсний хороо нь тогтоосон журмаар хийлгэсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр **Дугаар 87** **Улаанбаатар хот**

Гаалийн татварын хувь хэмжээг өөрчлөх тухай

Гаалийн тарифын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4, Улсын Их Хурлын 2000 оны 28 дугаар тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Хилийн Цагааннуур, Даян, Асгатын гол, Бургастай, Арц суурь, Тэс, Давст, Боршоо, Байтаг, Ярант, Бичигт, Гашуунсухайт, Шивээхүрэн, Баянтэс, Ханх боомтоор 2001 оны 6 дугаар сарын 1 хүртэл хугацаанд орж ирэх гурилын импортын гаалийн татварын хувь хэмжээг "О" байхаар өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД **Д.НАСАНЖАРГАЛ**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр Дугаар 88 **Улаанбаатар хот**

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай

Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хуулийн 30 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нийгмийн даатгалын сангаас олгох бүрэн тэтгэврийн доод хэмжээг 10,6 хувиар, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээг 15,0 хувиар нэмэгдүүлэн тогтоож, 16001-20000 хүртэлх тэтгэврийг 1500 төгрөгөөр, 20001-30000 төгрөг хүртэлх тэтгэврийг 1000 төгрөгөөр, 10001-ээс дээшхи хувь тэнцүүлсэн тэтгэврийг 1000 төгрөгөөр тус тус нэмэгдүүлж 2001 оны 4 дүгээр сарын 15-наас тооцон олгох арга хэмжээ авахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаяр нарт даалгасугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Тэтгэвэр бодох хөдөлмөрийн хөлс, түүнтэй адилтгах орлогыг тооцоход хэрэглэх итгэлцүүрийг шинэчлэн тогтоох тухай" Засгийн газрын 1999 оны 10 дугаар сарын 1-ний өдрийн 157 дугаар тогтоолын 2 дугаар зүйлийн "в" заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД **Ш.БАТБАЯР**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр Дугаар 89 **Улаанбаатар хот**

Төрийн үйлчилгээний зарим албан хаагчийн цалингийн хэмжээг нэмэгдүүлэх тухай

Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төрийн үйлчилгээний албаны албан тушаалын ТУ-1, ТУ-2, ТУ-3 зэрэглэлийн цалингийн доод жишгийг хавсралт ёсоор шинэчлэн батална.

2. Төсвийн удирдлага, санхүүжилтийн шинэ журам нэвтрүүлэхтэй уялдуулан төрийн улс төрийн, захиргааны болон тусгай албан хаагчид, түүнчлэн энэ тогтоолд хамрагдаагүй төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх асуудлыг боловсруулж, энэ онд багтаан Засгийн газарт оруулахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаяр, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт даалгасугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Төрийн албан хаагчийн цалингийн талаар авах арга хэмжээний тухай" Засгийн газрын 1999 оны 12 дугаар сарын 29-ний өдрийн 224 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтын ТУ-1, ТУ-2, ТУ-3 зэрэглэлийн цалингийн доод жишгийг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД **Ш.БАТБАЯР**

Засгийн газрын 2001 оны 89 дүгээр тогтоолын хавсралт

ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ АЛБАНЫ АЛБАН ТУШААЛЫН ТҮ-1, ТҮ-2, ТҮ-3 ЗЭРЭГЛЭЛИЙН ЦАЛИНГИЙН ДООД ЖИШИГ

Цалингийн жишгийн шатлал /ажилласан жилээр/	Албан тушаалын зэрэглэл		
	ТҮ-1	ТҮ-2	ТҮ-3
1-4	27225	28878	29886
5-8	28738	30358	31309
9-12	30250	31839	32732
13-16	31763	33320	34155
17-20	33275	34801	35578
21-24	34788	36282	37001
25 ба түүнээс дээш	36300	37763	38424

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр **Дугаар 90** **Улаанбаатар хот**

Төрийн үйлчилгээний зарим албан хаагчдын цалингийн нэмэгдлийн тухай

Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4 болон 8 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:,

1. Аймаг, сумын эмнэлэг, аймаг, нийслэлийн өрхийн эмнэлгийн ажилтнуудад олгох цалингийн нэмэгдлийг 1 дүгээр, аймаг, сумын ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, соёлын төвийн ажилтнуудад олгох цалингийн нэмэгдлийг 2 дугаар хавсралт ёсоор батлан 2001 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн мөрдүүлсүгэй.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Төрийн албан хаагчийн цалингийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1998 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 52 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын хоёрын 2 дахь хэсгээс "...хөдөөгийн сум, өрхийн их эмч, багийн бага эмч" гэснийг тус тус хассугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙД **Ч.УЛААН**

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД **Ш.БАТБАЯР**

Засгийн газрын 2001 оны 90 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

АЙМАГ, СУМЫН ЭМНЭЛЭГ, АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ӨРХИЙН ЭМНЭЛГИЙН АЖИЛТНУУДАД ОЛГОХ ЦАЛИНГИЙН НЭМЭГДЭЛ

№	Албан тушаал	Сарын нэмэгдлийн хэмжээ (хувиар)
1	Аймгийн төвийн эмнэлгийн ерөнхий эмч, эмчилгээ эрхэлсэн орлогч дарга, эмчилгээ, чанарын хяналтын менежер, их эмч, бага эмч, лаборант, эх бариач-бага эмч, рентген техникч, шүдний техникч, ерөнхий сувилагч, сувилагч, дүн бүртгэгч их эмч, ариутгагч, түргэн тусламжийн жолооч	10
2	Өрхийн сувилагч; сумын эмнэлгийн сувилагч, лаборант, жолооч	15
3	Өрхийн эмч; сумын эмнэлгийн эрхлэгч эмч, их эмч, бага эмч, багийн бага эмч	20

Засгийн газрын 2001 оны 90 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

АЙМАГ, СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬ, ЦЭЦЭРЛЭГ, СОЁЛЫН ТӨВИЙН АЖИЛТНУУДАД ОЛГОХ ЦАЛИНГИЙН НЭМЭГДЭЛ

№	Албан тушаал	Сарын нэмэгдлийн хэмжээ (хувиар)	
		Аймгийн төвийн суманд	Хөдөөгийн суманд
1	Боловсрол, соёлын төвийн захирал, ерөнхий боловсролын сургуулийн захирал, хичээлийн эрхлэгч, нийгмийн ажилтан, хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч, соёлын төвийн эрхлэгч, музейн эрхлэгч, номын сангийн эрхлэгч	10	15
2	Ерөнхий боловсролын сургуулийн багш, хичээлийн туслах ажилтан (лаборант), номын санч, дотуур байрын хүмүүжүүлэгч багш; хүүхдийн цэцэрлэгийн багш, туслах багш, дуу хөгжмийн багш; соёлын төвийн дуу, хөгжим, бүжгийн багш, кино механикч, номын санч; музейн тайлбарлагч, арга зүйч, сан-хөмрөгийн эрхлэгч; боловсрол, соёлын төвийн арга зүйч	8	10

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр **Дугаар 91** **Улаанбаатар хот**

Зарим ахмад дайчдад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох тухай

Монголын ахмадын холбоо, Дайнд оролцогсдын Монголын хороо, зарим ахмад дайчдаас удаа дараа тавьж байгаа санал, хүсэлтийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Дайнд оролцсон ахмад настны талаар авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 1998 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн 134 дүгээр тогтоол гарснаас хойш "Байлдаанд оролцсон ахмад дайчин" үнэмлэх шинээр авсан Баруун хилийн тулгаралт, 1939 оны Халхын голын байлдаан, 1945 оны чөлөөлөх дайн /1 дайн/-д оролцсон ахмад дайчин бүрт 200,0 мянган төгрөг, 1939 оны Халхын голын байлдаан, 1945 оны чөлөөлөх дайн /2 дайн/-д оролцсон ахмад дайчин бүрт 500,0 мянган төгрөгийн нэг удаагийн буцалтгүй тусламжийг 2002 онд багтаан олгож дуусгахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаярт даалгасугай.

2. Нэг удаагийн буцалтгүй тусламж олгоход шаардагдах 61,5 /жаран нэгэн сая таван зуун мянга/ сая төгрөгийг 2002 оны улсын төсөвт тусган санхүүжүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД **Ш.БАТБАЯР**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр **Дугаар 92** **Улаанбаатар хот**

Ахмадын талаар авах зарим арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монголын ахмадын байгууллага үүсч хөгжсөний 70 жилийн ойг 2001 оны 6 дугаар сарын 25-ны өдөр тэмдэглэн өнгөрүүлсүгэй.

2. Монголын ахмадын байгууллагын 70 жилийн ойн арга хэмжээнд зориулан 8350,0 /найман сая гурван зуун тавин/ мянган төгрөгийг Засгийн

газрын нөөц хөрөнгөөс гаргахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй.

3. Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгах нь:

а/Монголын ахмадын байгууллагын 70 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд ахмадын байгууллагын үйл ажиллагааг дэмжиж, ойг тэмдэглэн өнгөрүүлэхэд зохион байгуулалтын болон санхүүгийн зохих туслалцаа үзүүлэх арга хэмжээ авах;

б/ажиллаж байсан байгууллага нь татан буугдсан, дампуурсан, хувьчлагдсан, эсхүл өөр орон нутгаас шилжин суурьшсан ахмадуудын бүртгэл, судалгааг нарийвчлан гаргаж тэдэнд дэмжлэг туслалцаа үзүүлэх, шаардлагатай зарим зардлыг орон нутгийнхаа төсөвт тусгаж санхүүжүүлэх арга хэмжээ авах;

в/"Олон улсын ахмадын жил"-ийн хүрээнд шинээр байгуулагдсан ахмадын эмнэлэг, кабинет, тасаг, сувиллын газар зэрэг сувилгаа, үйлчилгээний төвүүдийг цаашид үргэлжлүүлэн хэвийн ажиллуулж, зохион байгуулалтын хувьд бэхжүүлж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах;

г/орон гэрээ ахмадуудын судалгааг нарийвчлан гаргаж ахмад дайчид, нэн ядуу ахмадыг гэр, орон байраар хангах талаар дэс дараатай арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

4. Ахмад настанд үзүүлэх эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах, алангуяа ядуу, хөвтрийн өвчтэй, ганц бие ахмадуудад гэрээр нь үйлчлэх үйлчилгээг өргөжүүлэх, тэдэнд олгох эм, тарианы үнийг хөнгөлөх асуудлыг судалж шийдвэрлүүлэх талаар санал боловсруулж Засгийн газарт оруулахыг Эрүүл мэндийн сайд П.Нямдавааг, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ш.Батбаяр нарт даалгасугай.

5. Архангай аймаг дахь Шивэртийн амралтын дэргэдэх цэцэрлэг-яслийн барилгыг тус аймгийн Нийгмийн халамж, үйлчилгээний төвийн харьяанд шилжүүлэн ахмад настны аймаг дундын амралт-рашаан сувилал болгон зохион байгуулан ажиллуулахыг Төрийн өмчийн хорооны дарга Л.Пүрэвдоржид даалгасугай.

6. Ахмад настны талаархи төр, засгийн бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, энэ чиглэлээр ахмадын байгууллагатай хамтран ажиллаж, тэдэнд дэмжлэг туслалцаа үзүүлэхийг өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж болон төрийн бус байгууллагуудад зөвлөмж болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХӨДӨЛМӨРИЙН САЙД **Ш.БАТБАЯР**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 4 дүгээр сарын 20-ны өдөр **Дугаар 93** **Улаанбаатар хот**

Зуны цагийн тоололд шилжүүлэх тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Жил бүрийн 3 дугаар сарын сүүлчийн долоо хоногийн баасан гаригаас бямба гаригт шилжих шөнийн 02 цаг /2001 оны хувьд 4 дүгээр сарын сүүлчийн долоо хоногийн баасан гаригаас бямба гаригт шилжих шөнийн 02 цаг/-аас эхлэн 9 дүгээр сарын сүүлчийн долоо хоногийн баасан гаригаас бямба гаригт шилжих шөнийн 02 цаг хүртэлх хугацаанд Монгол Улсын нутаг дэвсгэрт цагийн тооллыг нэг цагаар урагшлуулан ажил, үйлчилгээний эхлэх цагийн хуваарийг хэвээр мөрдөж байхаар тогтоосугай.

2. Энэ тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан хэмжил зүйн талаар гарах асуудлыг зохицуулан шийдвэрлэж байхыг Үйлдвэр, худалдааны сайд Ч.Ганзориг даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХӨДӨЛМӨРИЙН САЙД **Ш.БАТБАЯР**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр **Дугаар 94** **Улаанбаатар хот**

Монгол Улс, БНХАУ-ын хоорондын улсын хилийн шугамыг шалгах тухай

Монгол Улсын хилийн тухай хуулийн 9 дүгээр зүйл, Монгол, Хятадын хилийн дэглэм, хилийн асуудлыг зохицуулж байх тухай Монгол Улсын Засгийн газар, БНХАУ-ын Засгийн газар хоорондын гэрээний 6 дугаар зүйлийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол, Хятадын улсын хилийн шугамыг шалгах хамтарсан комиссын Монголын хэсгийн бүрэлдэхүүнийг 1 дүгээр, баримтлах удирдамжийг 2 дугаар, орон тоо, цалинг 3 дугаар хавсралт ёсоор тус тус батална.

2. Монгол, Хятадын улсын хилийн шугамыг шалгах хамтарсан комиссын Монголын хэсэг, түүний салбар комисс, техник ажлын группийг Хятадын талтай тохиролцсон тогоогор байгуулж, шаардагдах мэргэжлийн болон ажиллах хүчнээр ханган ажиллуулахыг Гадаад хэргийн сайд Л.Эрдэнэчулуун, Дэд бүтцийн сайд Б.Жигжид, Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж нарт тус тус үүрэг болгосугай.

3. Монгол, Хятадын улсын хилийн шугамыг шалгах ажилд шаардагдах хүн хүч, тээврийн хэрэгсэл, техник, тоног төхөөрөмж, байр сууц, түлш, шатахуун, хүнс, эд материалын туслалцаа үзүүлж, мэдээлэл судалгааны материалаар хангаж байхыг Гадаад хэргийн яам, Санхүү, эдийн засгийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Батлан хамгаалах яам, Дэд бүтцийн яам, Хүнс, хөдөө аж ахуйн яам, Шинжлэх ухааны академи болон БНХАУ-тай хил залгаа аймгуудын Засаг дарга нарт тус тус даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ХУУЛЬ ЗҮЙ,ДОТООД ХЭРГИЙН САЙД **Ц.НЯМДОРЖ**

Засгийн газрын 2001 оны 94 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

МОНГОЛ, ХЯТАДЫН УЛСЫН ХИЛИЙН ШУГАМЫГ ШАЛГАХ ХАМТАРСАН КОМИССЫН МОНГОЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга: -Тусгай үүрэг гүйцэтгэгч Элчин сайд /орон тооны/

Дэд дарга: -Гадаад хэргийн яамны Эрх зүй, консулын газрын Хилийн тасгийн дарга /хавсран/
-Хилийн цэргийг удирдах газрын дарга/хавсран/;
-Улсын геодези, зураг зүйн газрын дарга /хавсран/;
-Санхүү, аж ахуй, захиргааны ажил эрхэлсэн дэд дарга /орон тооны/.

Хариуцлагатай нарийн бичгийн дарга /орон тооны/

Гишүүд: -Гадаад хэргийн яамны Эрх зүй, консулын газрын ажилтан /хавсран/;
-Хилийн цэргийг удирдах газрын Хилийн хэлтсийн дарга /хавсран/;
-Зэвсэгт хүчний ерөнхий штабын цэргийн байр зүйн зургийн хангалтын асуудал эрхэлсэн ажилтан /хавсран/;
-Шинжлэх ухааны академийн Информатикийн хүрээлэнгийн геодези, геомэдээллийн асуудал эрхэлсэн эрдэм шинжилгээний ажилтан /хавсран/;
-Байр зүйн мэргэжилтэн /орон тооны/;
-Геодезийн мэргэжилтэн /орон тооны/;
-Хилийн албаны мэргэжилтэн /орон тооны/;
-Дорнод,Сүхбаатар,Дорноговь,Өмнөговь, Баянхонгор, Говь-Алтай,Ховд, Баян-Өлгий аймгийн Засаг дарга нар /хавсран/.

Засгийн газрын 2001 оны 94 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт

МОНГОЛ, ХЯТАДЫН УЛСЫН ХИЛИЙН ШУГАМЫГ ШАЛГАХ ХАМТАРСАН КОМИССЫН МОНГОЛЫН ХЭСГИЙН БАРИМТЛАХ УДИРДАМЖ

Нэг. Үндсэн чиглэл

1. Монгол, Хятадын улсын хилийн шугам, тэмдгийн байршлыг 2001-2003 онд Хятадын талтай хамтран шалгана.

2. Улсын хилийн шугамыг шалгахдаа Монгол Улсын үндэсний эрх ашиг, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдал, хил хязгаарын халдашгүй байдлыг хамгаалах, харилцан ашигтай байх зарчим, түүнчлэн олон улсын харилцааны болон эрх зүйн нийтлэг хэм хэмжээг удирдлага болгоно.

Мөн Монгол Улсын Хилийн тухай хууль, хоёр улсын хооронд 1962, 1964 онд байгуулсан хилийн гэрээ, протокол, улсын хилийн шугамыг 1962-1963 онд газар дээр нь тогтоон тэмдэглэж, 1982-1984 онд анх удаа хамтран шалгасан баримт бичгүүдийг тус тус үндэслэл болгоно.

3. Улсын хилийн бүх тэмдэг, тэдгээрийн холбоосыг шалгаж сэргээн засварлах, эвдэрч хэмхэрсэн болон байгалийн нөлөөллийн улмаас алга болсон хилийн тэмдгүүдийн байршлыг тогтоох, өөрчлөх, шаардлагатай хэсэгт туслах чанарын тэмдэг босгох зэргээр хилийн шугамын зүг чиг, байршлыг нарийн тодорхой болгож, үр дүнг нь улсын хилийн шугамыг хамтран шалгасан тухай баримт бичигт тусгана.

4. Монгол, Хятадын улсын хилийн шугамыг шалгах хамтарсан комисс байгуулах бөгөөд улсын хилийн шугамыг 1982-1984 онд хамтран шалгасан жишгийн дагуу хамтарсан салбар комисс 7, хамтарсан техник ажлын групп 17-г байгуулж ажиллуулна.

5. 1962-1963 онд газар дээр нь тогтоон тэмдэглэж, 1982-1984 онд хамтран шалгасан хилийн шугамаас зөрсөн аливаа тохиолдлыг нягтлан үзэж Хамтарсан комиссын хуралдаанаар хэлэлцүүлнэ.

6. Хамтарсан комиссын хуралдаанаар хэлэлцэх үндэсэн асуудлууд болон шалгалтын явцад гарч болох зарчмын асуудлуудыг Гадаад хэргийн сайдад урьдчилан танилцуулж чиглэл авах, зайлшгүй шаардлага гарвал Засгийн газарт оруулан хэлэлцүүлнэ.

7. Улсын хилийг хамтран шалгах явцад улсын хилийн шугамыг өөрчилбөл энэ талаар Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн, холбогдох хуулиар баталгаажуулна.

Хоёр. Тодорхой асуудлаар баримтлах чиглэл

1. Хилийн зурвасын 1:100000-ны масштабын зургийг 6 км хүртэл өргөнтэй зурваст 1:50000-ны масштабын зураг болгон шинэчилнэ. Харин Монгол, Хятад, Оросын хилийн баруун уулзвараас хилийн 38 дугаар тэмдэг хүртэлх Алтайн нурууны өндөр уулсын хэсэгт өөрчлөхгүй үлдээж болно, тэгэхдээ хилийн шугамын байршлыг зурагтай нь сайтар тулган шалгаж тодотгоно.

2. Хилийн тэмдэг бүрийг хамтран шалгаж, засан сэргээх ажлыг Хамтарсан комиссоос тогтоосон зааврын дагуу гүйцэтгэнэ. Хоёр талын аж ахуйн үйл ажиллагаа идэвхжсэн хилийн хэсгүүд болон бусад шаардлагатай газарт хилийн шугамын байршлыг тодорхой болгох зорилгоор зохих тооны туслах чанарын тэмдгүүдийг шинээр нэмж босгоно.

3. Булган, Нөмрөг, Шарилж, Халхын голын хил болдог хэсэгт хилийн шугамын байршлыг тодотгоно. Буйр нуураар дайрч байгаа хилийн шугамыг солбицол тодорхойлохгүйгээр хөвүүр тэмдгээр тэмдэглэж тодорхой болгох чиглэл баримтална.

Голын голдрил өөрчлөгдсөн хэсэгт хилийн усыг хадгалах чиглэл баримталж, голдрилыг сэргээх. Хуурай голдрилоор /салаа, сайраар/ хил тогтоох саналыг зөвшөөрөхгүй байх, шаардлагатай тохиолдолд ус зүйн ажил явуулж шийдвэрлэнэ.

4. Хилийн шугамын дагуухь оготолсон хуучин ойн зурвасыг сэргээх, шинэчлэх ажлыг гүйцэтгэнэ.

5. Урьдчилсан тооцоогоор хилийн нийт

тэмдгийн 20 хүртэл хувийн солбицлыг түүвэрлэн тодорхойлж шалгахын дээр хилийн 1-38 дугаар тэмдгүүдийн солбицлыг шинээр тодорхойлно.

6. Хилийн 12-12/1, 40-44/3, 45/1-47, 71-72, 379-383, 538/2-539, 542-544/2, 545-545/1 дүгээр тэмдгүүдийн хэсэгт хилийн шугамын байршлыг тусгайлан үзэж шалгана.

7. Хилийн шугамын байршлыг зааж баримжаа болж байсан зам харгуй арилж мэдэгдэхгүй болсон зэрэг шалтгаанаар цаашид хос багана тай байх шаардлагагүй хэсэгт дан багана бүхий тэмдэг босгон өөрчилнө.

8. Хилийн тэмдэг, туслах чанарын тэмдгүүдэд 1:10000-ны масштабтай байршлын тойм зураг хийж эсэх талаар Хятадын талтай тохиролцож хэрэгжүүлнэ.

9. Хилийг хамтран шалгахтай холбогдсон ажлын зардлыг Хятадын талтай тохиролцоно. Буйр нуурт хөвүүр тэмдгүүд тавьж хилийн шугамын байршлыг тэмдэглэх, хилийн дагуу агаараас зураг авах, хилийн зурвасын газрын зураг хэвлэх ажлыг Хятадын талаар хийлгэх бүюу зардлыг нь даалгахыг эрмэлзэнэ.

Засгийн газрын 2001 оны 94 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралт

МОНГОЛ, ХЯТАДЫН УЛСЫН ХИЛИЙН ШУГАМЫГ ШАЛГАХ ХАМТАРСАН КОМИССЫН МОНГОЛЫН ХЭСГИЙН ОРОН ТОО, ЦАЛИН

	Албан тушаал	Зэрэглэл	Орон тоо			Сарын цалин
			Бүгд	Хавсран	Орон тооны	
	а) Монголын хэсгийн төв аппарат					
1	Дарга	ТЗ-13	1		1	79525
2	Дэд дарга	ТЗ-12	4	3	1	78273
3	Хариуцлагатай нарийн бичгийн дарга	ТЗ-11	1		1	75350
4	Гишүүд	ТЗ-9	16	13	3	71385
5	Орчуулагч	ТУ-6	2		2	46063
6	Санхүү, аж ахуйн тасгийн дарга	ТЗ-7	1		1	64600
7	Хэрэг хөтлөгч-бичээч	ТУ-2	1		1	35063
8	Жолооч, нярав зэрэг техник ажилтан	ТУ-3	5		5	37125
	Бүгд		31	16	15	
	б) Салбар комисс - 7					
1	Дарга	ТЗ-9	1		1	71385
2	Дэд дарга		1	1		
3	Гишүүд	ТЗ-7	2		2	64600
4	Орчуулагч-нарийн бичгийн дарга	ТУ-5	1		1	42625
5	Жолооч, техник ажилтан	ТУ-3	4		4	37125
	Бүгд		9(63)	1(7)	8(56)	
	в) Техник ажлын групп - 17					
1	Дарга	ТЗ-7	1		1	64600
2	Гишүүд	ТЗ-5	2		2	58339
3	Орчуулагч-нарийн бичгийн дарга	ТУ-4	1		1	39188
4	Жолооч, техник ажилтан	ТУ-3	4		4	37125
	Бүгд		8(136)		8(136)	
	Нийт		**230**	**23**	**207**	

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 23 (210)

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилох тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Монгол Улсын зэрэглэлийг олон улсын санхүүгийн зах зээлд ахиулан бататгах арга хэмжээний тухай*
- *Гаалийн татварын хувь, хэмжээг өөрчлөх тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2001 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2001 оны зургадугаар сарын 14 №23 (210)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

297. Цацрагийн хамгаалалт, аюулгүй байдлын тухай хуулийн төсөл буцаах тухай — Дугаар 46 — 630

298. Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилох тухай — Дугаар 47 — 630

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

299. А.С.Ладыго, А.А.Кирьянов нарыг одон, медалиар шагнах тухай — Дугаар 132 — 630

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

300. Хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулахыг дэмжих тухай — Дугаар 95 — 630

301. Хамгаалалтын бүс тогтоох тухай — Дугаар 96 — 631

302. Дүрэм шинэчлэн батлах тухай — Дугаар 97 — 631

303. Ой, хээрийг түймрээс хамгаалах хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай — Дугаар 98 — 636

304. Монгол Улсын зэрэглэлийг олон улсын санхүүгийн зах зээлд ахиулан батлатгах арга хэмжээний тухай — Дугаар 99 — 637

305. Орон сууц хувьчлах тухай — Дугаар 100 — 638

306. Малын гоц халдварт өвчний цагийн байдалтай холбогдуулан авах арга хэмжээний тухай — Дугаар 101 — 640

307. Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай — Дугаар 102 — 642

308. Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай — Дугаар 103 — 642

309. Иргэний нисэхийн талаар авах зарим арга хэмжээний тухай — Дугаар 104 — 643

310. Төлөвлөгөө батлах тухай — Дугаар 105 — 644

311. Гадаадын хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтыг зохион байгуулах тухай — Дугаар 106 — 652

312. Гаалийн татварын хувь, хэмжээг өөрчлөх тухай — Дугаар 107 — 652

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 5 дугаар сарын 25-ны өдөр | Дугаар 46 | Улаанбаатар хот

Цацрагийн хамгаалалт, ашуулгүй байдлын тухай хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын Хуралдааны дэгийн хуулийн 40 дүгээр зүйлийн 11 дэх хэсгийн 5 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлсэн Цацрагийн хамгаалалт, ашуулгүй байдлын тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцээд бүхэлд нь батлаагүй тул хууль санаачлагчид буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 5 дугаар сарын 31-ний өдөр | Дугаар 47 | Улаанбаатар хот

Үндсэн хуулийн цэцийн гишүүнийг томилох тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн жаран тав дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дахь хэсгийн 1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 23 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, нууц санал хураалтын дүнг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Улсын дээд шүүхийн санал болгосноор Цэрэнбалтавын Сарантуяа, Чоймжуурын Дашням нарыг Үндсэн хуулийн цэцийн гишүүнээр томилсугай.

2. Энэ тогтоолыг 2001 оны 5 дугаар сарын 31-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 5 дугаар сарын 25-ны өдөр | Дугаар 132 | Улаанбаатар хот

А.С.Ладыгө, А.А.Кирьянов нарыг одон, медалиар шагнах тухай

Монгол Улс, ОХУ-ын эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжүүлэх, Монгол - Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн үр ашгийг дээшлүүлэх, ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж тус үйлдвэрийн оросын талын "Зарубежцветмет" нэгдлийн ерөнхий захирал Алексей Сергеевич Ладыго-г "Алтан гадас" одонгоор, мөн нэгдлийн ажилтан Артем Аввакумович Кирьяновыг "Найрамдал" медалиар тус тус шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр | Дугаар 95 | Улаанбаатар хот

Хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулахыг дэмжих тухай

Төрийн өмчийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 6 дугаар заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Монгол Улсын "Дархан мах экспо" хувьцаат компаниас Япон Улсын "Эйко корпораци"-тай хамтран 51 хувийн хөрөнгө оруулж гэрийн тэжээвэр амьтны хоол үйлдвэрлэх хувь нийлүүлсэн "Дархан фуудс" хязгаарлагдмал хариуцлагатай компани байгуулан ажиллуулах тухай "Дархан мах экспо" хувьцаат компанийн саналыг дэмжих нь зүйтэй гэж үзсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ХҮНС, ХӨДӨӨ АЖ
АХУЙН САЙД Д.НАСАНЖАРГАЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр Дугаар 96 **Улаанбаатар хот**

Хамгаалалтын бүс тогтоох тухай

Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 6 дахь хэсэгт заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нийслэлийн нутаг дэвсгэрт оршдог түүх, соёлын үл хөдлөх дурсгалууд болох Гандантэгчинлэн хийд, Гэсэр сүмийн хамгаалалтын бүсийг 58,0 га, Богд хааны Могоон ордны хамгаалалтын бүсийг 5,7 га, Чойжин ламын сүмийн хамгаалалтын бүсийг 2,0 га, Дамбадаржаа хийдийн хамгаалалтын бүсийг 10,5 га, Гэр хэлбэрт модон дугануудын буюу Дашчойлин хийдийн хамгаалалтын бүсийг 1,7 га, Чин ван Ханддоржийн байшингийн хамгаалалтын бүсийг 0,5 га газар байхаар тус тус тогтоосугай.

2. Хамгаалалтын бүсэд түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн хадгалалт хамгаалалт, бүрэн бүтэн байдалд хохирол учруулахуйц үйл ажиллагаа явуулах, барилга барихгүй байхыг Нийслэлийн Засаг дарга М.Энхболдод даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД А.ЦАНЖИД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр Дугаар 97 **Улаанбаатар хот**

Дүрэм шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Байгаль орчны улсын хяналтын дүрэм"-ийг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Байгаль орчны улсын хяналтын дүрэм батлах тухай" Засгийн газрын 1995 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 209 дүгээр тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД У.БАРСБОЛД

Засгийн газрын 2001 оны 97 дугаар тогтоолын хавсралт

БАЙГАЛЬ ОРЧНЫ УЛСЫН ХЯНАЛТЫН ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1. Байгаль орчны улсын хяналтын зорилт нь байгууллага, аж ахуйн нэгж, иргэдээс байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, экологийн аюулгүй байдал, хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангахтай холбогдсон Монгол Улсын хууль тогтоомж, эрх бүхий байгууллагаас тэдгээртэй нийцүүлэн тогтоосон журам, хэм хэмжээ, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, стандартын биелэлтийг хангуулахад оршино.

2. Улсын хяналтыг Засгийн газрын тохируулагч агентлаг-Байгаль орчны хамгаалах алба, аймаг, нийслэлийн Байгаль орчны алба, газар, Улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргаа, сум, дүүргийн улсын байцаагч, байгаль хамгаалагч хэрэгжүүлнэ.

3. Байгаль орчныг хамгаалах албаны дарга нь байгаль орчны хяналтын улсын ерөнхий байцаагч байна. Улсын ерөнхий байцаагчийг Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 1-д заасны дагуу томилж, чөлөөлнө.

4. Байгаль орчныг хамгаалах алба Улсын тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын

захиргааны болон аймаг, нийслэл, сум, дүүргийн улсын ахлах байцаагч, улсын байцаагч, байгаль хамгаалагчдыг Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 26 дугаар зүйлийн 4-т заасны дагуу томилж, чөлөөлнө.

Байгаль орчны хяналтын улсын ахлах байцаагч нь байгаль орчны чиглэлээр мэргэжил эзэмшсэн, магистрын зэрэгтэй, мэргэжлээрээ 5-аас доошгүй жил ажилласан байна.

5. Аймаг, нийслэл, сум, дүүрэгт ажиллах байгаль хамгаалагчийн тоог Засгийн газраас батална нормативыг баримтлан тогтооно.

6. Хил, гааль, цагдаа, мал эмнэлэг, эрүүл мэнд, уул уурхайн зэрэг хяналтын улсын байцаагч буюу хуульд зааснаар энэхүү хяналтыг хэрэгжүүлэх үүрэг бүхий ажилтанд Байгаль орчны хяналтын улсын ерөнхий байцаагчийн санал болгосноор Байгаль орчны асуудал эрхэлсэн сайд байгаль орчны улсын байцаагчийн эрх олгож болно.

7. Байгаль орчны улсын байцаагч, байгаль хамгаалагч нь байгаль орчны асуудлаар мэргэшсэн төрийн захиргааны албан хаагч мөн.

8. Байгаль орчныг хамгаалах алба, аймаг, нийслэлийн Байгаль орчны алба, газар, бүх шатны улсын байцаагч, байгаль хамгаалагч нь үйл ажиллагаандаа Монгол Улсын холбогдох хууль тогтоомж, Засгийн газар, Байгаль орчны асуудал эрхэлсэн сайд, нутгийн захиргааны болон өөрөө удирдах ёсны байгууллагын шийдвэр, энэхүү дүрмийг удирдлага болгоно.

9. Байгаль орчны улсын ерөнхий болон ахлах байцаагч, улсын байцаагч /цашид "байцаагч" гэх/, байгаль хамгаалагч нь үнэмлэх, хувийн дугаар бүхий тэмдэг болон шийдвэр, зөрчлийн тэмдэглэл, албан шаардлага, дүгнэлт, акт, торгууль, нөхөн төлбөр, шийтгэврийн хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

10. Аймаг, нийслэлд ажиллаж байгаа улсын байцаагч, байгаль хамгаалагчийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, ажлыг нь шалгах, шалгалтын дүнг нэгтгэн дүгнэлт гаргах, шаардлагатай асуудлаар авах арга хэмжээний санал боловсруулж шийдвэрлүүлэхийг Байгаль орчныг хамгаалах алба хариуцан гүйцэтгэнэ.

Хоёр. Байгаль орчны улсын хяналтын чиглэл

11. Байгаль орчны улсын хяналтыг дор дурдсан чиглэлээр хэрэгжүүлнэ:

а/газар, газрын хэвлий, түүний баялаг, ус, ой, ургамал, амьтан, агаарыг хамгаалах, тэдгээрийг зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбоотой хууль тогтоомж, стандарт, хэм хэмжээ, дүрэм, журам, шийдвэрийн биелэлт;

б/Монгол Улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулж буй байгууллага, аж ахуйн нэгж болон иргэдээс байгаль орчныг хамгаалах, сэргээн сайжруулах, засаж тохижуулах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх чиглэлээр байгуулсан гэрээ, төсөл, төлөвлөгөөний биелэлт, бусад үйл ажиллагаа;

в/байгалийн нөөц баялгийг ашигласны төлбөр, хураамж, хог хаягдал, бохирдуулах бодис гаргасны төлбөрийн барагдуулалт;

г/байгаль орчинд нөлөөлөх үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа байгууллага, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа болон шинээр байгуулах, өргөтгөх байгууллага, аж ахуйн нэгжийн төсөл, хөтөлбөр, гэрээний байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнд хамрагдсан байдал, үнэлгээгээр заасан байгаль орчныг нөхөн сэргээх, засаж тохижуулах арга хэмжээний биелэлт;

д/хайгуул, судалгаа шинжилгээний ажил, байгалийн аялал жуулчлалын явцад байгаль орчны талаархи хууль тогтоомжийг хэрэгжүүлж байгаа байдал;

е/байгаль орчны талаархи хуулиуд болон Монгол Улсын улаан номонд орсон нэн ховор, ховор амьтан, ургамлын хамгаалалт, нөхөн сэргээлт;

ж/тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалт;

з/цацраг идэвхт болон химийн хорт бодисыг үйлдвэрлэх, экспортлох, импортлох, хадгалах, тээвэрлэх, устгах, хог хаягдлыг цуглуулах, зөөвөрлөх, боловсруулж ашиглах, булах, устгах журам, горимын мөрдөлт;

и/байгаль орчны талаархи хууль тогтоомж, түүнтэй нийцүүлэн эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэр, журамд заасан бусад үйл ажиллагаа.

Гурав.Байгаль орчны улсын байцаагчийн эрх, үүрэг

12. Байцаагч дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ:

а/энэ дүрмийн 11 дүгээр зүйлд заасан чиглэлийн дагуу байгаль орчны хяналтыг зохион байгуулж явуулах;

б/байгаль орчны талаархи хууль тогтоомжийн зөрчил /зөрчил гаргачийн нэр, хаяг, үйлдлийн шинж байдал, учруулсан хохирол, нөгдуулах хариуцлагын тухай/-ийн тухай зөрчлийн тэмдэглэл хөтлөн зөрчил гаргачаар гарын үсэг зуруулах буюу зурахаас татгалзсан бол энэ тухай тайлбар, тэмдэглэл хийх;

в/байгууллага, аж ахуйн нэгж, иргэнд захиргааны шийтгэл ногдуулах, тэдгээрийн хууль бус үйл ажиллагаат тудгэлзүүлэн зогсоох, зөрчил гаргагдаас эд зүйлийг хураахдаа үндэслэл, шалтгааныг хууль тогтоомжийн зүйл, заалтын дагуу тодорхойлж, акт, бусад баримт, торгууль, нөхөн төлбөр, шийтгэврийн хуудсанд тэмдэглэх;

г/илрүүлсэн зөрчлийг таслан зогсоох, арилгах арга хэмжээ авахдаа байгууллага, аж ахуйн нэгж, иргэний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хүндэтгэх, үйлдвэрлэлийн нууцыг хадгалах;

д/зөрчил гаргачаас хуульд заасан үндэслэлээр хураан авсан эд зүйл, зөвсөг, хэрэгсэл, түр хураасан бичиг баримтын бүртгэлийг үйлдэж, хувийг эзэнд нь үлдээж, зөвсөг хэрэгслийг эрх бүхий байгууллагад 14 хоногийн хугацаанд шилжүүлэх;

е/хууль тогтоомжийг чанд сахих, хөндлөнгийн нөлөөнд үл автах, албан үүргээ үнэнчээр гүйцэтгэх;

ж/гүйцэтгэсэн үзлэг шалгалт, үйлдсэн дүгнэлт, акт, танилцуулга, албан шаардлага, тоо баримтын үндэслэл, нотолгооны үнэн зөвийг бүрэн хариуцах;

з/сум, дүүрэгт байгаль хамгаалагч ажиллахгүй тохиолдолд түүний үүргийг гүйцэтгэх;

и/хууль тогтоомж, шийдвэрт заасан бусад үүрэг.

13. Байцаагч дор дурдсан эрх эдэлнэ:

а/байгууллага, аж ахуйн нэгж, иргэний байгаль орчны тухай хууль тогтоомжийг хэрхэн биелүүлж байгааг нутаг дэвсгэр, засаг захиргааны харьяалал харгалзахгүйгээр хянан шалгах;

б/хяналт шалгалтын ажилд шаардлагатай мэдээ, судалгаа, тайлбар, тодорхойлолт, бусад баримт бичгийг холбогдох байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтнаас гаргуулан авах;

в/холбогдох байгууллага, албан тушаалтантай тохиролцсоны үндсэн дээр зохих мэргэжлийн хүмүүсийг хяналт шалгалтын ажилд татан оролцуулах, шаардлагатай асуудлыг магадлах зорилгоор лабораторийн буюу магадлан шинжилгээг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх;

г/хүний амь нас, эрүүл мэнд, байгаль орчинд шууд буюу шууд бус хохирол учруулж болзошгүй нь нотлогдсон, түүнчлэн аюул осол гарч болох тохиолдолд холбогдох үйлдвэрлэл, үйлчилгээг уг зөрчлийг арилгах хүртэл хугацаагаар

бүхэлд нь буюу хэсэгчлэн түр зогсоох, шаардлагатай зүйлийг ариутгах, хоргүйжүүлж цэвэршүүлэх, энэ тухай олон нийтэд зарлан мэдээлж энэ шийдвэрийг биелүүлээгүй тохиолдолд хуульд өөрөөр заагаагүй бол тухайн үйлдвэрлэл, үйлчилгээг бүрмөсөн зогсоох талаар холбогдох байгууллагад санал оруулах;

д/хяналт шалгалт хийхээр байгууллага, аж ахуйн нэгж, тэдгээрийн үйлдвэр, цех, агуулах, талбай зэрэг объектод нэвтрэн орох, сорьц дээж авах, тэдгээрийг өөрийн хяналтын дор шинжлүүлэх;

е/байгалийн гамшиг, гэнэтийн осол аюулын үед шаардлагатай бол нийтийн тээврийн хэрэгслээр дараалал харгалзахгүйгээр зорчих, бусад тээврийн хэрэгслийг дайчилж хөлсийг нь төлөх;

ж/байгаль орчны талаархи хууль тогтоомж зөрчсөн иргэний бичиг баримтыг шалгах, хууль бусаар агнасан, түүсэн, бэлтгэсэн зүйл, зэвсэг, хэрэгслийг акт үйлдэн хураан авч тогтоосон журмын дагуу улсын орлогод оруулах, холбогдох байгууллагад шилжүүлэх, шаардлагатай бол тээврийн хэрэгсэлд нь үзлэг хийх, бичиг баримтыг түр хураах;

з/улсын байцаагч байгаль орчин, байгалийн баялагт учирсан шууд хохирлыг тодорхойлж холбогдох хууль тогтоомжид заасны дагуу буруутай этгээдэд нөхөн төлбөр ногдуулах;

и/байгаль орчны талаархи хууль тогтоомжийн зөрчлийг арилгах зорилгоор үйл ажиллагааг нь түр буюу тодорхой хугацаагаар зогсоох шийдвэр гаргасан, эсвэл акт, тэмдэглэл үйлдэж лац ломбо тавьсны дараа үйлдвэрлэл, үйл ажиллагаа явуулсан, байгалийн гаралтай түүхий эд ашигласан, бэлтгэсэн бол олборлосон ашигт малтмал, бүтээгдэхүүн, түүхий эдийн зүйл, зүй бус орлогыг хураж улсын орлого болгох. Ийнхүү улсын орлого болгоход гарсан ачиж, буулгах, тээвэрлэх, хадгалах, борлуулах зэрэг зардлыг хураагдсан зүйлийг борлуулсны орлогоос нөхөн төлөх;

к/байгаль орчны талаархи хууль тогтоомжийн зөрчил гаргасан байгууллага, аж ахуйн нэгж, иргэний үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх лиценз, тусгай зөвшөөрөл, байгаль орчны мэргэжлийн байгууллагын гэрчилгээг хураан авч уг лиценз, тусгай зөвшөөрөл, гэрчилгээг олгосон холбогдох байгууллагатай хамтран асуудлыг шийдвэрлэх;

л/ноцтой осол аюул гарсан, хүний амь нас, эрүүл мэнд хохирсон, их хэмжээний хохирол учирсан тохиолдолд болон илэрсэн зөрчил нь гэмт хэргийн шинжтэй бол шалгалтын акт, холбогдох баримт бичгийг эрх бүхий байгууллагад шилжүүлэх;

м/байгаль орчны улсын ерөнхий байцаагч, ахлах байцаагч нь байгаль орчны хяналтын ажлын хүрээнд шийдвэр гаргаж түүний биелэлтийг хангуулах арга хэмжээ авах;

н/байгаль орчны бүх шатны улсын байцаагч нь байгаль орчны зөрчлийг таслан зогсоох, дахин гаргуулахгүй байх зорилгоор байгууллага, аж ахуйн нэгж, иргэнд албан шаардлага өгч, биелэлтийг нь гаргуулан авах;

о/байцаагч, байгаль хамгаалагчдын гаргасан шийдвэр, акт, албан шаардлага, үүргийг биелүүлээгүй болон торгууль, нөхөн төлбөрийг хугацаанд нь төлж барагдуулаагүй бол байцаагч, байгаль хамгаалагчид нь хууль хяналтын зохих байгууллагад хандаж асуудлыг шийдвэрлүүлэх;

п/хууль тогтоомж, шийдвэрт заасан бусад эрх.

Дөрөв. Байгаль хамгаалагчийн үүрэг, эрх

14. Байгаль хамгаалагч дор дурдсан үүрэг гүйцэтгэнэ:

а/энэ дүрмийн 12-ын "б", "г", "д", "е", "ж", "и"-д заасан үүргийг хэрэгжүүлэх;

б/байгууллага, аж ахуйн нэгж, иргэнд захиргааны шийтгэл ногдуулахдаа түүний үндэслэлийг хууль тогтоомжийн зүйл, заалтын дагуу тодорхойлж акт буюу зөрчлийн тэмдэглэл үйлдэх, торгууль, нөхөн төлбөр, шийтгэвэр

ногдуулах, улмаар тэдгээрийн хууль бус үйл ажиллагааг тудгэлзүүлэн зогсоох саналаа байцаагчид тавьж шийдвэрлүүлэх;

в/байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөлөл, аюулаас сэргийлэх, байгалийн баялгийг хамгаалах арга хэмжээ авах;

г/байгалийн нөөц баялгийг ашиглах эрхийн бичгийг зохих хууль тогтоомжийн дагуу олгох;

д/байгууллага, аж ахуйн нэгж, иргэнд гэрээ, тусгай зөвшөөрөл, эрхийн бичгийн дагуу тухайн баялгийг ашиглах газрыг зааж өгөх, хэрэгжилтэд байнгын хяналт тавих;

е/байгаль орчны төлөв байдал, байгалийн баялгийн өөрчлөлтөд ажиглалт, судалгаа хийж, мэдээг мэдээллийн санд тусгуулах;

ж/байгалийн гамшиг, гэнэтийн аюул, ноцтой хэрэг,зөрчил гарсан даруйд тухайн шатны Засаг дарга, Байгаль_орчны албаны даргад мэдээлж хор уршгийг арилгах арга хэмжээ авах;

з/нутаг дэвсгэртээ байгалийн баялгийг нөхөн сэргээх ажлыг зохион байгуулах;

и/хууль тогтоомж, шийдвэрт заасан бусад үүрэг.

15. Байгаль хамгаалагч дор дурдсан эрх эдэлнэ:

а/байгаль хамгаалагч нутаг дэвсгэртээ энэ дүрмийн 13-ын "а", "д", "е"-д заасан эрхийг хэрэгжүүлэх;

б/хуульд тусгайлан заасан тохиолдолд нутаг дэвсгэртээ энэ дүрмийн 13-ын "ж", "з"-д заасан эрхийг хэрэгжүүлэх;

в/хууль тогтоомж, шийдвэрт заасан бусад эрх.

16. Байгаль орчны тухай хууль тогтоомж, дүрэм, журам зөрчсөн, илэрсэн зөрчлийг арилгуулах талаар тавьсан шаардлагыг биелүүлэгүй гэм буруутай этгээдэд байцаагч, байгаль хамгаалагч зөрчлийн шинж байдал, хохирлын хэмжээг харгалзан байгаль орчны тухай хуулиудын холбогдох зүйл, заалтыг үндэслэн захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

Тав. Бусад зүйл

17. Байгаль орчныг хамгаалах алба, аймаг, нийслэлийн Байгаль орчны алба, газар, Улсын тусгай хамгаалалттай газруудын хамгаалалтын захиргаа, байцаагч, байгаль хамгаалагчийн албан шаардлагыг байгууллага, аж ахуйн нэгж, албан тушаалтан, иргэд хүлээлгээнд нь биелүүлж, хариуг албан ёсоор өгч байх үүрэгтэй.

18. Байцаагч, байгаль хамгаалагч ялгах тэмдэг, дүрэмт хувцас, бие хамгаалах тусгай болон бусад техник хэрэгсэл, унаглаар хангагдах бөгөөд тэдгээрийн эдэлгээний хугацаог байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

19. Шалгуулсан байгууллага, аж ахуйн нэгжийн эрх баригч, албан тушаалтан хяналт шалгалтын явцад хууль тогтоомж зөрчигдсөн, байцаагчийн гаргасан шийдвэр үндэслэлгүй гэж үзвэл гомдлоо хяналт шалгалт хийсэн байгууллагын эрх баригчид, эсвэл улсын ерөнхий байцаагчид уг шийдвэрийг хүлээн авснаас хойш 10 хоногийн дотор гаргана.

Гомдол гаргах нь зөрчлийн тэмдэглэл, торгууль, нөхөн төлбөр, шийтгэврийн хуудсаар ногдуулсан хариуцлагаас чөлөөлөгдөх үндэслэл болохгүй бөгөөд гомдлыг хяналт шалгалт хийсэн байгууллагын эрх баригч буюу улсын ерөнхий байцаагч түүнийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор хянан шийдвэрлэх арга хэмжээ авна.

20. Байцаагч, байгаль хамгаалагч үүрэгт ажлаа зохих ёсоор биелүүлээгүй, хууль тогтоомж зөрчсөн нь тогтоогдвол холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр | Дугаар 98 | Улаанбаатар хот

Ой, хээрийг түймрээс хамгаалах хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зарим арга хэмжээний тухай

Дэлхийн уур амьсгалын дулаарлын нөлөөгөөр сүүлийн жилүүдэд манай орны хур тундасны улирлын тэнцвэр алдагдаж гангийн давтамж ихсэн цөлжих үйл явц эрчимжих хандлагатай болж байгаа харгалзан Ой, хээрийг түймрээс хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдоржид даалгах нь:

а/Гал түймэртэй тэмцэх газар, түүний салбар нэгжийн чадавхийг бэхжүүлж, нутгийн захиргааны холбогдох байгууллагыг ой, хээрийн түймэртэй тэмцэх талаар арга зүй, мэргэжлийн удирдлагаар байнга хангаж ажилласугай;

б/зохих бэлтгэлийг хангасны үндсэн дээр түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх, түймэртэй тэмцэх, амь нас, эд хөрөнгөө хамгаалах аргыг ард иргэдэд зэрэмшүүлэхэд чиглэгдсэн үзүүлэх сургууль, сургалтыг 2001 оны 5 дугаар сард багтаан сум, дүүрэг бүрт зохион байгуулж, шаардлагатай гарын авлага, материалаар хангах арга хэмжээ авсугай;

в/орон нутгийн хүчээр унтраах боломжгүй болж голомт нь өргөжсөн ой, хээрийн түймрийг унтраахад цагдаагийн болон дотоодын цэргийн анги, салбарыг дайчлан ажиллуулах арга хэмжээг шуурхай авч байсугай.

2. Батлан хамгаалахын сайд, Улсын байнгын онцгой комиссын дарга Ж.Гүррагчаад даалгах нь:

а/ой, хээрийн түймэртэй тэмцэхэд шаардагдах техник хэрэгсэл, шатахуун, хүн хүч, гарах зардлыг урьдчилан тооцоолж аймаг бүрийн төсөвт тусгуулж байх, байвал зохих нөөцийг бүрдүүлэх, түймэр унтраах бүс нутгийн сүлжээг бий болгох асуудлыг төлөвлөгөөний үндсэн дээр хэрэгжүүлсүгэй;

б/шаардлагатай үед ой, хээрийн түймрийг унтраах, урьдчилан сэргийлэх ажилд зэвсэгт хүчний анги, салбарын тэсвэрийн хэрэгсэл, бие бүрэлдэхүүнийг дайчлан ажиллуулах арга хэмжээ авч байсугай;

в/түймэр унтраах, хөрсний чийгийг нэмэгдүүлэх, таримал ургамлыг мөндөөс хамгаалах ажилд хэрэглэгдэж байгаа зенитийн их бууны засвар, үйлчилгээг хариуцан байнгын бэлэн байдалд байлгах, шаардлагатай тохиолдолд борооны пуужин зөөвөрлөх нисдэг тэрэг, техник хэрэгслийг гаргаж байсугай.

3. Ой, хээрийн түймрийн голомт өргөжиж гамшгийн цагийн байдал бий болсон үед Гал түймэртэй тэмцэх газрыг Иргэний хамгаалалтын газартай хамтран ажиллуулах талаар журам боловсруулж мөрдүүлэхийг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Батлан хамгаалахын сайд Ж.Гүррагчаа нарт даалгасугай.

4. Байгаль орчны сайд У.Барсболдод даалгах нь:

а/цаг агаарын хуурайшилтын мэдээг нийтэд тогтмол хүргэж байхын хамт хиймэл дагуулын мэдээ ашиглан илрүүлсэн түймрийн талаар холбогдох байгууллага, аймаг, орон нутагт шуурхай мэдээлж байсугай;

б/байгалийн нөөц ашиглах, нөхөн сэргээх, хамгаалах үүрэг бүхий мэргэжлийн байгууллагад түймэр гарах магадлал ихтэй тодорхой газар нутгийг хариуцуулан өгч, түймрээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авахуулан хийсэн ажлын үр дүнтэй нь уялдуулан урамшуулж, хариуцлага тооцож байсугай.

5. Хавар, намрын хуурайшилт ихтэй үед түймрийн аюулаас сэрэмжлүүлэх, түймрийн цагийн байдлын талаархи шуурхай мэдээг радио, телевизээр цаг алдалгүй дамжуулах арга хэмжээ авч байхыг Радио, телевизийн хэрэг эрхлэх газрын дарга Б.Ганболдод даалгасугай.

6. Үүлэнд зориудаар нөлөөлж хур тундас оруулж түймэр унтраах, ган тайлах, хөрсний чийгийг нэмэгдүүлэх, таримал ургамлыг мөндөөс

хамгаалах арга хэмжээнд шаардагдах урсгал болон тусгай зориулалтын материалын зардлыг 2002 оноос эхлэн улсын төвлөрсөн төсөвт тусган санхүүжүүлж байхыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Байгаль орчны сайд У.Барсболд нарт даалгасугай.

7. Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгах нь:

а/хуурайшилт бүхий газар нутгийн түүмрийн эрдэлийн үнэлгээг мэргэжлийн байгууллагын оролцоотойгоор жил бүр гаргаж, түүмэртэй тэмцэхэд шаардагдах зардлыг бодитойгоор тогтоон санхүүжүүлэх эх үүсвэрийг шийдвэрлэж байсугай;

б/орон нутгийн байгууллага, цэргийн дүйцүүлэх алба хаагчид, иргэдийн бэлтгэл, бэлэн байдлыг хангуулсны үндэсэн дээр тэдгээрийг ой, хээрийг түүмрээс хамгаалах, гарсан түүмрийг унтраах ажилд зохион байгуулалттайгаар дайчлан оролцуулж байсугай;

в/ой, хээрийн түүмрийг унтраах техник хэрэгсэл бүхий "мэргэжсэн баг"-ийг цэргийн дүйцүүлэх алба хаагчдыг түшиглүүлэн байгуулж сургаж бэлтгэх, хуурайшилтын үед тэдгээрийг түүмэр гарах магадлал ихтэй нутаг дэвсгэрт байнга ажиллуулах арга хэмжээ авч байсугай;

г/"мэргэжсэн баг"-ийн хүчээр ойд цэвэрлэгээ хийж түүмрээс хамгаалах зурвас байгуулах, малчдын өвөлжөө, хаваржаагаа түүмрийн хамгаалалтын зурвастай болгох, үнс нурмаа галын аюулгүйгээр хадгалах, хаях, түүмрийн аюулын үед амь нас, эд хөрөнгөө хамгаалах арга ажиллагаанд иргэдийг сургах арга хэмжээ авч байсугай;

д/түүмрийн аюултай үед хуурайшилт бүхий газар нутагт аялал зугаалга хийх, ан агнах, бүгын эвэр түүх, мод бэлтгэх, байгалийн дагалт баялаг ашиглах зэрэгт оролцох иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бүрийн үйл ажиллагаанд сум, баг, дүүргийн Засаг дарга нарын зүгээс тахь хяналт, урьдчилан сэрэмжлүүлэх ажлыг хэвшүүлэн биелэлтэд нь хяналт тавьж ажилласугай.

8. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Эрдэм шинжилгээ, туршилт үйлдвэрлэлийн ажлын дүнгийн тухай" Засгийн газрын 1994 оны 6 дугаар сарын 28-ны өдрийн 120 дугаар тогтоолын 3 дугаар зүйлийн "а" заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БАЙГАЛЬ ОРЧНЫ
САЙД У.БАРСБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 4 дүгээр сарын 25-ны өдөр **Дугаар 99** **Улаанбаатар хот**

Монгол Улсын зэрэглэлийг олон улсын санхүүгийн зах зээлд ахиулан бататтах арга хэмжээний тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын зэрэглэлийг олон улсын санхүүгийн зах зээлд ахиулан бататтах асуудлыг зарчмын хувьд зөвшөөрч, энэ чиглэлээр холбогдох олон улсын байгууллагатай хамтарч ажиллахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгасугай.

2. Зэрэглэлийн ажлыг үргэлжлүүлэхэд шаардагдах мэдээ, баримтыг гаргаж өгч байхыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгаж, Монгол банк /О.Чулуунбат/, Үндэсний статистикийн газар /Ч.Даваасүрэн/-т зөвлөсүгэй.

3. Монгол Улсын зэрэглэлийг олон улсын санхүүгийн зах зээлд ахиулан бататтахтай холбогдон гарах зардлыг Монгол банктай хамтран тэнцүү хубааж төлөхөөр жил бүрийн улсын төвлөрсөн төсөвт тусган батлуулж, тухай бүр санхүүжүүлж байхыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгасугай.

4. Монгол Улсын зэрэглэлийг олон улсын санхүүгийн зах зээлд ахиулан тогоолгосон дүн, түүний өөрчлөлтийн явцыг 2001 оны IУ улиралд багтаан Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

ХУУЛЬ ЗҮЙ,ДОТООД ХЭРГИЙН САЙД
БӨГӨӨД САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Ц.НЯМДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 4 дүгээр сарын 27-ны өдөр **Дугаар 100** **Улаанбаатар хот**

Орон сууц хувьчлах тухай

Орон сууц хувьчлах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 3 дахь хэсэг болон Тагнуулын ерөнхий газрын саналыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Тагнуулын ерөнхий газрын эзэмшилд байгаа 1 дүгээр хавсралтад дурдсан орон сууцыг тэдгээрт одоо оршин суугаа тагнуулын ажилтан, офицер, ахлагч, тухайн салбарын албан хаагч, цэргийн тэтгэвэрт гарсан ахмадууд болон тэдний гэр бүлийнхэнд хувьчлахыг Төрийн өмчийн хорооны дарга Л.Пүрэвдоржид зөвшөөрсүгэй.

2. Тагнуулын ерөнхий газрын эзэмшилд байгаа хувьчлалд үл хамаарах орон сууцны жагсаалтыг 2 дугаар хавсралт ёсоор шинэчлэн батлуулсугай.

3. Энэ тогтоолын 1 дүгээр хавсралтад дурдсан орон сууцыг хувьчлах ажлыг хуульд заасан журмын дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн хороонд даалгасугай.

4. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хувьчлалд үл хамаарах орон сууцны жагсаалт батлах тухай" Засгийн газрын 1998 оны 8 дугаар сарын 18-ны өдрийн 148 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтад "17.Аймгийн тагнуулын газар, хэлтсийн дарга" гэсэн заалт нэмж, мөн тогтоолын 1 дүгээр хавсралтын 241-250 дугаар заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД БӨГӨӨД САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ **Ц.НЯМДОРЖ**

Засгийн газрын 2001 оны 100 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ХУВЬЧЛАХ ОРОН СУУЦНЫ ЖАГСААЛТ

Д/д	Эзэмшигч байгууллагын нэр	Орон сууцны барилгын нэр	Орон сууцны барилгын байршил	Ашиглалтад орсон он	Сууцны тоо
1	Тагнуулын ерөнхий газар	32 айлын сууц	Сүхбаатар дүүрэг	1992	9
2	Тагнуулын ерөнхий газар	38 айлын сууц	Сүхбаатар дүүрэг	1995	12
3	Тагнуулын ерөнхий газар	60 айлын сууц	Баянзүрх дүүрэг 16 дугаар хороо	1978	7
4	Тагнуулын ерөнхий газар	60 айлын сууц	Баянзүрх дүүрэг 16 дугаар хороо	1979	17
5	Тагнуулын ерөнхий газар	58 айлын сууц	Баянзүрх дүүрэг 16 дугаар хороо	1983	17
6	Тагнуулын ерөнхий газар	20 айлын сууц	Чингэлтэй дүүрэг 1 дүгээр хороо	1930	20

Засгийн газрын 2001 оны 100 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

ТАГНУУЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ЭЗЭМШИЛД БАЙГАА ХУВЬЧЛАЛД ҮЛ ХАМААРАХ ОРОН СУУЦНЫ ЖАГСААЛТ

Д/д	Эзэмшигч байгууллагын нэр	Орон сууцны барилгын нэр	Орон сууцны барилгын байршил	Ашиглалтад орсон он	Сууцны тоо
1	Дорнод аймаг дахь тагнуулын газар	60 айлын сууц	Чойбалсан сум 13-р байр	1989	1
2	Дорнод аймаг дахь тагнуулын газар	60 айлын сууц	Чойбалсан сум 25-р байр	1989	1
3	Замын-үүд дэх тагнуулын газар	5 айлын сууц	Замын-үүд ШНБ	1995	5
4	Завхан аймаг дахь тагнуулын хэлтэс	3 дугаар 60 айлын сууц	Улиастай сум Жинст баг	1994	1
5	Дархан-уул аймаг дахь тагнуулын хэлтэс	60 айлын сууц	Шинэ дархан 21-р байр	1982	1
6	Хөвсгөл аймаг дахь тагнуулын хэлтэс	48 айлын сууц	Мөрөн сум, 6-р баг, Гурилын үйлдвэрийн байр	1994	1
7	Баян-өлгий аймаг дахь тагнуулын газар	60 айлын сууц	Өлгий сум 5-р баг, 3 дугаар 60 айл	1994	5
8	Ховд аймаг дахь тагнуулын газар	52 айлын сууц	Жаргалант сум 4-р баг	1984	1
9	Увс аймаг дахь тагнуулын газар	58 айлын сууц	Улаангом хот	1996	2
10	Говь-алтай аймаг дахь тагнуулын хэлтэс	60 айлын сууц	Алтай хот	1992	1
11	Өвөрхангай аймаг дахь тагнуулын хэлтэс	24 айлын сууц	Арвайхээр хот	1996	1

2001 оны 5 дугаар сарын 2-ны өдөр | Дугаар 101 | Улаанбаатар хот

Малын гоц халдварт өвчний цагийн байдалтай холбогдуулан авах арга хэмжээний тухай

Улсын мал эмнэлгийн болон хүнсний аюулгүй байдал, хөдөө аж ахуйн улсын хэналтын байгууллагын мэргэжилтнүүдийн гаргасан дүгнэлтийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Дорнод аймгийн бүх сумын болон Сүхбаатар аймгийн Эрдэнэцагаан, Сүхбаатар, Хэнтий аймгийн Норовлин сумын хийгээд Нийслэлийн Чингэлтэй, Сүхбаатар, Баянзүрх дүүргийн зарим хорооны нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, иргэний хамгаалалтын албадыг иргэний хамгаалалтын өндержүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж, хорио цээрийн хязгаарлалтын дэглэмээр ажиллуулж байгаа 2001 оны 5 дугаар сарын 3-ны өдрөөс эхлэн цуцалсугай.

2. Малын гоц халдварт өвчний голомттой байсан газруудаас бусад малд халдвар тархаахгүй байх урьдчилан сэргийлэх арга хэмжээг мэргэжлийн байгууллагын хяналтын дор зохион байгуулан хэрэгжүүлэхийг Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгийн Засаг дарга Д.Одбаяр, Т.Дашсүрэн, Ч.Эрдэнэбаатар, нийслэлийн Засаг дарга М.Энхболд нарт үүрэг болгосугай.

3. "Гоц халдварт А010 өвчний голомтод устгасан малын нөхөх олговрын жишиг үнэ"-ийг хавсралт ёсоор тогтоосугай.

4. Малын гоц халдварт өвчинтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймагт зарцуулсан нийт зардлын 20 хувийг тухайн аймгийн, нийслэлд зарцуулсан нийт зардлын 25 хувийг нийслэлийн төсвөөс тус тус гаргасугай.

5. Малын гоц халдварт өвчинтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулсан зардлын зөрүү болон малын нөхөх олговорт зориулан Засгийн газрын нөөц хөрөнгөөс 426,0 (дөрвөн зуун хорин зургаа) сая хүртэл төгрөгийг дор дурдсан байдлаар гаргахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд зөвшөөрсүгэй:

а/малын гоц халдварт өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд орон нутгаас гарсан зардлыг нөхөхөд зориулан Дорнод аймагт 3,0 сая хүртэл, Сүхбаатар аймагт 57,0 сая хүртэл, Хэнтий аймагт 17,2 сая хүртэл, нийслэлд 199,1 сая хүртэл төгрөг;

б/улсын нөөцөөс гаргасан бараа, материалыг нөхөн бүрдүүлэхэд зориулан 26,7 сая төгрөг;

в/төсвөөс нь гарсан зардлыг буцаан төлөхөд зориулан Улсын иргэний хамгаалалтын газарт 38,5 сая төгрөг, Улсын мал эмнэлгийн газарт 8,1 сая төгрөг;

г/малын гоц халдварт өвчний голомтод устгасан малын нөхөх олговорт зориулан Дорнод аймагт 27652,0 мянга, Сүхбаатар аймагт 50008,0 мянга, Хэнтий аймагт 10469,0 мянга, нийслэлд 8151,0 мянган төгрөг.

6. Батлан хамгаалахын сайд, Улсын байнгын онцгой комиссын дарга Ж.Гүррагчаа, Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан нарт даалгах нь:

а/малын гоц халдварт өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулан Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймаг болон нийслэлд зарцуулсан зардлыг нарийвчлан шалгасны үндсэн дээр зөрүүг гүйцэтгэлээр нь тооцон санхүүжүүлсүгэй;

б/малын гоц халдварт өвчинтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэхэд зориулан Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймаг болон нийслэлд төсвөөс гарсан хөрөнгийн зарцуулсан байдалд Терийн хянан шалгах хороогоор хяналт шинжилгээ хийлгэж дүгнэлт гаргуулах арга хэмжээ авсугай.

7. Устгасан малын нөхөх олговрыг олгох арга, хэлбэрийг тухайн малчинтай зохицуулан шийдвэрлэх талаар холбогдох арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймгийн Засаг дарга Д.Одбаяр, Т.Дашсүрэн, Ч.Эрдэнэбаатар, Нийслэлийн Засаг дарга М.Энхболд нарт тус тус даалгасугай.

8. Энэ тогтоол гарсантай холбогдуулан Засгийн газрын дор дурдсан тогтоол, тогтоолын

заалтыг хүчингүй болсонд тооцсугай:

а/"Иргэний хамгаалалтын бэлэн байдлын зэргүүдэд шилжүүлэх тухай" Засгийн газрын 2001 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 31 дүгээр тогтоолын 13 дугаар зүйл;

б/"Гоц халдварт өвчний цагийн байдалтай уялдуулан авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2001 оны 3 дугаар сарын 1-ний өдрийн 42 дугаар тогтоол;

в/"Иргэний хамгаалалтын бэлэн байдлын зэргүүдэд шилжүүлэх тухай" Засгийн газрын 2001 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн 55 дугаар тогтоолын 2-5 дугаар зүйл;

г/"Малын гоц халдварт өвчний цагийн байдал, түүнтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2001 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 77 дугаар тогтоолын 1-3 дугаар зүйл, 5 дугаар зүйлийн "а" заалт.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БАТЛАН ХАМГААЛАХЫН
САЙД Ж.ГҮРРАГЧАА

Засгийн газрын 2001 оны 101 дүгээр тогтоолын хавсралт

ГОЦ ХАЛДВАРТ А010 ӨВЧНИЙ ГОЛОМТОД УСТГАСАН МАЛ, АМЬТНЫ НӨХӨХ ОЛГОВРЫН ЖИШИГ ҮНЭ

Мал, амьтны төрөл	Ялгаа	Хүйс	Жишиг үнэ /мянган төгрөг/	
			Дорнод, Сүхбаатар, Хэнтий аймагт	Нийслэлд
Үхэр	Бух	-	130,0	-
	4 ба түүнээс дээш насны	эр	110,0	-
		эм	95,0	190,0
	3 наст	эр	85,0	-
		эм	85,0	170,0
	2 наст	эр	70,0	-
		эм	72,0	-
	1 наст	эр	32,0	60,0
		эм	35,0	60,0
	Тугал	-	20,0	30,0
Тэмээ	4 ба түүнээс дээш насны	эр	150,0	-
		эм	110,0	-
Хонь	2 ба түүнээс дээш настай	эр	22,0	22,0
		эм	20,0	22,0
	1 настай	эр	14,0	-
		эм	12,0	-
	Хурга	-	-	6,0
	Хуц	-	35,0	-
Ямаа	2 ба түүнээс дээш настай	эр	17,0	17,0
		эм	15,0	15,0
Гахай	-	-	60,0	200,0
Тахиа	-	-	-	25,0

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 5 дугаар сарын 2-ны өдөр | Дугаар 102 | Улаанбаатар хот

Тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албаны албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай" Засгийн газрын 1995 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 94 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан "Яам, төрийн бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл"-ийн "Т3-2" гэсэн хэсгийн 5 дахь багананд "4.Байгаль хамгаалагч" гэж нэмсүгэй.

2. Төрийн захиргааны албан хаагчийн ангилал, зэрэглэлд байгаль хамгаалагчийг хамааруулсантай холбогдуулан гарах цалингийн нэмэгдэл зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхийг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Төрийн захиргааны болон төрийн үйлчилгээний албаны албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай" Засгийн газрын 1995 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 94 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан "Төрийн үйлчилгээний албан тушаалын ангилал, зэрэглэлд хамаарах албан тушаалын жагсаалт"-ын "ТУ-4" гэсэн хэсгийн 9 дэх баганаас "Байгаль хамгаалагч" гэснийг хассугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД У.БАРСБОЛД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 5 дугаар сарын 2-ны өдөр | Дугаар 103 | Улаанбаатар хот

Үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн батлах тухай

Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүн өөрчлөгдсөнтэй холбогдуулан Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Техникийн боловсрол, мэргэжлийн сургалтын бодлого, зохицуулалтын үндэсний зөвлөлийн бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор шинэчлэн батлагдсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Хөтөлбөр, төлөвлөгөө батлах тухай" Засгийн газрын 1998 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 41 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Н.ЭНХБАЯР

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД А.ЦАНЖИД

Засгийн газрын 2001 оны 103 дугаар тогтоолын хавсралт

ТЕХНИКИЙН БОЛОВСРОЛ, МЭРГЭЖЛИЙН СУРГАЛТЫН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ҮНДЭСНИЙ ЗӨВЛӨЛИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга	-Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд
Орлогч	-Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн дэд сайд
Гишүүд:	-Санхүү, эдийн засгийн дэд сайд;
	-Үйлдвэр, худалдааны дэд сайд;
	-Дэд бүтцийн дэд сайд;
	-Хүнс, хөдөө аж ахуйн дэд сайд;
	-Хөдөлмөр зохицуулалтын газрын дарга;
	-Санхүү, эдийн засгийн яамны Эдийн засгийн нэгдсэн бодлого,төлөвлөлтийн газрын дарга;
	-Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Эдийн засаг, хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын дарга;
	-Нийгмийн хамгаалал,хөдөлмөрийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга;
	-Монголын үйлдвэрчний эвлэлүүдийн холбооны дэд ерөнхийлөгч (тохиролцсоноор);
	-Монголын залуучуудын холбооны ерөнхийлөгч (тохиролцсоноор);
	-Монголын эмэгтэйчүүдийн холбооны дэд дарга (тохиролцсоноор);
	-Ажил олгогч эздийн нэгдсэн холбооны гүйцэтгэх захирал (тохиролцсоноор);
	-Үйлдвэрлэл,үйлчилгээний хоршоодын холбооны тэргүүн (тохиролцсоноор);
Нарийн бичгийн дарга	-Боловсролын хөгжлийн сургуулийн захирал. -Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны Бага, дунд боловсролын бодлого,зохицуулалтын газрын орлогч дарга.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 5 дугаар сарын 2-ны өдөр **Дугаар 104** **Улаанбаатар хот**

Иргэний нисэхийн талаар авах зарим арга хэмжээний тухай

Иргэний нисэхийн нислэгийн аюулгүй байдлыг ханган, төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэлд иргэний нисэхийн талаар тусгасан арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Иргэний нисэхийн салбарт явуулах бодлогыг боловсруулж хэрэгжүүлэхдээ ажлын зохион байгуулалт, дэг журмыг бэхжүүлж ажилтнуудын мэргэжлийн чадварыг дээшлүүлэхэд анхааран дотоодын хяналтыг эрс чангатгахыг Дэд бүтцийн сайд Б.Жигжидэд үүрэг болгосугай.

2. Дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг Дэд бүтцийн сайд Б.Жигжид, Төрийн өмчийн хорооны дарга Л.Пүрэвдорж нарт даалгасугай:

а/хөрөнгө оруулалт хийж, үйл ажиллагаа, үйлчилгээг нь сайжруулах нөхцөлтэйгээр олон улсын уралдаант шалгаруулалтын аргаар "МИАТ" компанийг хувьчлах, Монгол Улсад хөрөнгө оруулалт хийж, өөрийн нислэгийн баазыг бий болгож түүнийгээ ашиглан олон улсын дамжин өнгөрөх тээвэрлэлт зохион байгуулах сонирхолтой нэр хүнд бүхий гадаадын нисэх компанийг татан оролцуулах чиглэлээр идэвхтэй үйл ажиллагаа явуулах;

б/үйл ажиллагааны чиглэлийн онцлогийг харгалзан одоогоор ашиглаж байгаа Ан-2, Ан-24, Ан-26 онгоц, Ми-8 нисдэг тэргийг эхний ээлжинд түрээслүүлж, ашиглагдахгүй байгаа нь хууль тогтоомжийн дагуу худалдаж борлуулах;

в/"МИАТ" компанийн үйл ажиллагааг нислэгийн аюулгүй байдлыг хангах, тээвэрлэлтийн аюлын технологийг боловсронгуй болгох, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлэхэд чиглүүлж, иргэний нисэхийн салбарт өмчийн олон хэвшлийн байгууллагууд үйл ажиллагаа явуулах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор газрын үйлчилгээ, шатахуун болон зорчигчдын хоол хүнсний хангалт зэрэг нийтлэг үйлчилгээг зах зээлийн харилцаанд нийцүүлэн зохион байгуулах.

3. Агаарын хөлгийн паркийг шинэчлэх болон орон нутгийн нисэх буудлуудын хүчилттай зурвас, Улаанбаатарт олон улсын нөөц аэродром барихад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийн талаархи санал боловсруулж 2001 оны Ш улиралд багтаан Засгийн газарт танилцуулахыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Дэд бүтцийн сайд Б.Жигжид нарт үүрэг болгосугай.

4. Улсын агаарын хөлөг /тусгай зориулалттай/-ийг иргэний нисэхийн зориулалтаар ашиглахдаа холбогдох хууль тогтоомжийн дагуу зохих зөвшөөрөл авч байх нь зүйтэй гэж үзсүгэй.

5. Төв, орон нутгийн нисэх буудлуудын аэродромын аюулгүйн бүсэд тавигдах шаардлагыг хангаж ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газрын дарга М.Дагва, аймаг, нийслэл болон холбогдох сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ДЭД БҮТЦИЙН САЙД **Б.ЖИГЖИД**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 5 дугаар сарын 2-ны өдөр **Дугаар 105** **Улаанбаатар хот**

Төлөвлөгөө батлах тухай

Улсын Их Хурлын 2001 оны 10 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хавсралт ёсоор батлуулсугай.

2. Энэ төлөвлөгөөний биелэлтэд байнгын хяналт тавьж, гүйцэтгэлийг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон жил бүрийн эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх Үндсэн чиглэлийн биелэлттэй хамтатган Засгийн газарт танилцуулж байхыг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаан, Төрийн өмчийн хороо (Л.ПҮРЭВДОРЖ)-нд тус тус үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА **Ө.ЭНХТҮВШИН**

"ТӨРИЙН ӨМЧИЙГ 2001-2004 ОНД ХУВЬЧЛАХ ҮНДСЭН ЧИГЛЭЛ"-ИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Үндсэн чиглэлийн зааЛт	Хийх ажлын товч утга	Хугацаа /он, улирал/	Хэрэгжүүлэх байгууллага, албан тушаалтан
1	**Нэг. Төрийн өмчийг хувьчлахад баримтлах нийтлэг зарчим** Хувьчлах аж ахуйн нэгж, үл хөдлөх эд хөрөнгийн жагсаалт, энэхүү жагсаалтад орсон хөрөнгө /объект/-ийг хувьчлах арга хэлбэрийг Засгийн газар жил бүр батлан гаргаж, Үндсэн чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах	Хувьчлах аж ахуйн нэгж, эд хөрөнгийн жагсаалтыг тухайн жилийн улсын төсвийн төсөлтэй хамт боловсруулан Засгийн газарт оруулж батлуулах	Жил бүрийн Х сард	ТӨХ, холбогдох яам, газрууд
2	Өр, зээлийг баталгаажуулах, шаардлагатай бол зарим өрийг түсгаарлах, өр төлбөрийг төлөх хуваарийг шинэчлэн баталгаа гаргаж, хэрэгжүүлэх	Хувьчлах аж ахуйн нэгжийн өр, зээлийн судалгааг гаргаж хувьчлах үед томоохон өр зээлийг хэрхэх талаар нарийвчилсан санал боловсруулах, ялангуяа төрийн байгууллагуудад төлөх өр, зээлийг түсгайлан авч үзэж холбогдох байгууллагуудын саналыг авч Засгийн газарт оруулж шийдвэрлүүлэх	Тухай бүр	ТӨХ, холбогдох яам, газрууд
		Шаардлагатай гэж үзсэн хувьчлагдсан аж ахуйн нэгжүүдээс төрийн байгууллагад төлөх томоохон хэмжээний өр, зээлийг төрийн эзэмшлийн хувьцаанд шилжүүлэх замаар тухайн компанийн удирдлагын үйл ажилллагааг сайжруулах санал боловсруулж Засгийн газарт танилцуулах	2001-2002 онд	ТӨХ, ҮХЯ, СЭЗЯ
3	Гадаадын хөрөнгө оруулагчдыг татах, Монгол Улсын олон тулгуурт гадаад бодлогыг эдийн засгийн талаар хангах	Монгол Улсын олон тулгуурт гадаад бодлогыг эдийн засгийн талаар хангахтай уялдуулан үнэ цэнэтэй аж ахуйн нэгжийг гадаадын хөрөнгө оруулагчид уралдаант шалгаруулалтын аргаар хувьчлахад баримтлах чиглэлийг гаргаж Засгийн газарт танилцуулах	2001 оны 5 дугаар сард	ГХЯ
4	Гадаад орнуудаас Монгол Улсын Засгийн газарт үзүүлсэн тусламж, хөнгөлөлттэй зээлээр үйлдвэр, аж ахуйн газарт оруулсан хөрөнгө оруулалтын өмчлөлийн асуудлыг шийдвэрлэхийн дараа хувьчлалын асуудлыг шийдвэрлэх.	Төрийн өмчийн ороцоотой аж ахуйн нэгжүүдэд Япон болон бусад хандивлагч орноос Монгол Улсын Засгийн газрын нэрээр олгосон хөнгөлөлттэй зээл, тусламжийн хөрөнгө оруулалтын өмчлөлийн асуудлыг аж ахуйн нэгж бүрээр боловсруулж Засгийн газарт оруулж шийдвэрлүүлэх	2001-2002 онд	СЭЗЯ, ТӨХ, ДБЯ, ҮХЯ, ХХААЯ

5	Аж ахуйн нэгж, байгууллагын бүтцийн өөрчлөлтийн асуудлыг Төрийн өмчийн хороо тухайн чиглэлийн /салбарын/ төрийн захиргааны төв байгууллагатай хамтран шийдвэрлэж, энэ тухайгаа Засгийн газарт мэдээлэх	Үндсэн чиглэлд заасан бүтцийн өөрчлөлт хийх байгууллага, нэгжийн жагсаалт, хэрэгжүүлэх хугацааны саналыг боловсруулж Засгийн газарт оруулж шийдвэрлүүлэх	Жил бүр	ТӨХ, холбогдох яам, газрууд
6	Алдагдалтай, цаашид ашиггүй ажиллах боломжгүй аж ахуйн нэгжийг татан буулгаж, эд хөрөнгийг нь худалдах	Алдагдалтай ажиллаж буй аж ахуйн нэгжийн жагсаалтыг гаргаж цаашид авах арга хэмжээний талаар санал боловсруулах, үйл ажиллагаагаа явуулах болощгоогүй аж ахуйн нэгжийг татан буулгаж, эд хөрөнгийг нь салган худалдах арга хэмжээ авахаар санал боловсруулж Засгийн газарт танилцуулах	2001 оны сүүлийн хагас жилд	ТӨХ, холбогдох яам, газрууд
7	Өмч хувьчлалын талаар мөрдөж байгаа эрх зүйн актыг хувьчлалын талаар бариментлах төрийн бодлоготой уялдуулан боловсронгуй болгох	Төрийн болон орон нуттийн өмчийн тухай хуулинд нэмэлт, өөрчлөлт оруулах талаар холбогдох газруудтай хамтран санал боловсруулах	2001 оны II хагас жилд	ХЗДХЯ,ТӨХ
		Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэлтэй уялдуулан төрийн өмчийг хувьчлах ажлыг хэрэгжүүлэхээр Төрийн өмчийн хорооноос урьд гаргасан дүрэм, журмуудыг шинэчлэх, хувьчлах эд хөрөнгө, аж ахуйн нэгжийн худалдах доод үнэ тогтоох журмыг боловсруулж Засгийн газраар батлуулах	2001 онд	ТӨХ
8	**Хоёр. Үнэ цэнэтэй аж ахуйн нэгжийн хувьчлал**	Тухайн жилд хувьчлах үнэ цэнэтэй аж ахуйн нэгж бүрээр "Үндсэн чиглэл"-д заасан хувьчлалын боддого, зарчмыг бүрэн тусгасан тендерийн баримт бичгийг боловсруулан Засгийн газарт оруулан шийдвэрлүүлж хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	Тухай бүр	ТӨХ
		Үнэ цэнэтэй аж ахуйн нэгжийн хувьцааг худалдан авсан этгээдтэй байгуулах гэрээний загварыг Засгийн газраар батлуулан хэрэгжүүлэх	2001 оны эхний хагаст	ТӨХ, холбогдох яам, газрууд
		Хувьчлалын өмнө хийгдэх бүтэц зохион байгуулалтын өөрчлөлтийг "Үндсэн чиглэл"-д заасны дагуу аж ахуйн нэгж бүрээр авч үзэн шийдвэрлэх	Тухай бүр	ТӨХ, холбогдох яам, газрууд
		Тухайн жилийн хувьчлах жагсаалтад орсон үнэ цэнэтэй аж ахуйн нэгж бүрээр Төрийн өмчийн хорооны итгэмжлэгдсэн төлөөлөгч томилон, хувьчлах ажлыг "Төрийн болон орон нуттийн өмчийн тухай" хуулийн дагуу хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	Тухай бүр	ТӨХ
		Үнэ цэнэтэй аж ахуйн нэгжийг хувьчлах олон улсын тендерийн дүрмийн теслийг боловсруулж Засгийн газраар хэлэлцүүлэн батлуулах	2001 оны 5 дугаар сард	ТӨХ

Тендерийн удирдах хорооны бүрэлдэхүүн, түүний ажлыг журмыг боловсруулан Засгийн газраар батлуулах	2001 оны 5 дугаар сард	ГХЯ, ТЕҮ,	
"НИК" ХК-ийн төрийн мэдлийн хувьцаат хувьчлахын өмнө нефть бүтээлэхүүний чанарын лабораторийн сүлжээг тусгаарлан ийгэд үйлчлэх чиглэлээр зохион байгуулах, уялан нөөцийн нефтийн бүтээлэхүүнийг хадгалах зорилгатай савны талаарх асуудлыг хойшлох хуулийн хүрээнд авч үзэж шийдвэрлэх	2001 оны эхний хагаст	ТЕҮ, УХЯ	
Хувьчлалын өмнө "Төв" ХК, "ХХ Банк" ХХК, "НИК" ХК-нуудын зарим плацлагатай гэж үзсэн нийтийн болон гуслах чанарын нэгж, салбар, эд хөрөнгийн талаар хуулах, төрийн мэдэд шилжүүлэх асуудлыг Телекомын удирдах зөвлөлийн хуралд оруулан шийдвэрлүүлэх	2001 онд	ТЕҮ	
Хар төмөртөгийн үйлдвэрийн үлдэрлэх үйл ажиллагаат удирдлагын гэрээгээр түйлэгүүлэх ажлыг "Үлдсэн чиглэл"-д заасны дагуу зохион байгуулах	2002 онд 1 улиралд	ТЕҮ, УХЯ	
"Төв" ХК, "НИК" ХК, "ХХБанк" ХХК-ийн төрийн мэдлийн хувьцаа болон "МИАТ" ТӨҮТ-ыг үралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах ажлыг хойшлох заамны саналыг авсны үлдсэн дээр зохион байгуулах	2001 оны III, IV улиралд	ТЕҮ	
"АПУ" ХК-ийн төрийн мэдлийн хувьцаат бигүүмжилсэн дүүлага худалдаагаар ажлыг зохион байгуулах	2001 оны III улиралд	ТЕҮ	
"Монгол даатгал" ТӨҮТ, "Хөтөл-Цемент похойн үйлдвэр" ТӨҮТ-ыг үралдаант шалгаруулалтын аргаар хувьчлах ажлыг "Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үлдсэн чиглэл"-д заасны дагуу зохион байгуулах	2002 онд	ТЕҮ	
"Монголбогатсе" ХХК, "Монгол-Амикаль" ХХК-ийн "Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үлдсэн чиглэл"-д заасны дагуу зохих өөрчлөх хангасны үлдсэн дээр хойшлох талуудтай тохиролцон төрийн мэдлийн хувьцаат нь худалдах ажлыг зохион байгуулах	2002-2003 онд	ТЕҮ, УХЯ	

9	Гүрэл. Дэд бүтцийн салбарын хуьцаа, өөрчлөх байгууллага	-Эрчим хүчний гүехий хууль болон "Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл"-ийн дагуу эрчим хүчний салбарт өөрчлөн байгуулалт хийж дуусгах -Авто замын салбарыг төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэжэгдэл хийгдэх бүтцийн өөрчлөлтийг Компанийн гүехий хуулийн дүрэмд нийцүүлэн чадвар хэлбэлзүүлэн шийдэгдэх -Цахилгаан шугамын холбоосны салбарт хийгдэх өөрчлөн байгуулалт холбогдох талбүүдтэй тохиролцон зохион байгуулах -Төмөр замын салбарт хийгдэх бүтцийн өөрчлөлтийн талаар эхний шатны судалгааг хийж, дүгнэлтийг Засгийн газарт танилцуулах -"МИАТ" ТӨҮГ-ыг хувьчлахтай холбогдуулан түүний мөдлөг байгаа нийтийн үйлчилгээний зарим нэгжийг тусгаарлаж, хувьчлах эвслыг зохион байгуулах -Төрийн өмчийн эрсдэлтэй нүүрс олборлох хувьцаат компанууд дахь төрийн өмчийн хувьцааныг худалдах зөвшөөрөл шийдвэрлэх -Дэд бүтцийн салбарт хувийн хэвшлийн эзлэх хувь, оролцоо нэмэгдэж байгаатай уялдуулан газрын, дулаан, холбоо, төмөр зам, авто зам, цэвэр, бохир усны хангамжийн салбарт дэх төрийн зохицуулалтын хууль эрх зүйн орчныг шинэчлэх, зохицуулах байгууллага, албаыг тогтоосоор бий болгох -Гүехий эмчид Засгийн газраас хувьчлахаар шийдвэрлэсэн дэд бүтцийн салбарын үйлдвэр, аж ахуйн нэгжийг хувьчлах эвслыг Төрийн болон орон нутгийн өмчийн гүехий хууль болон "Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл"-д заасны дагуу зохион байгуулах	2001 онд 2001 онд 2001-2002 онд 2001 онд 2002 онд 2001-2002 онд Тухай бүр	ТӨҮГ, ДБЯ ТӨҮГ, ДБЯ ТӨҮГ, ДБЯ ТӨҮГ, ДБЯ ТӨҮГ, ДБЯ ДБЯ ТӨҮГ
10	Дорож. Улст шаардлагатай хөрөнгийн бирэлийн эсвэлгээг хэлбэн шууршай, уян хатгай, орсодроонтэй болгох зүгээ хэмжээ авах	Бирэлийн үйл эсвэлгээг, бүтэц зохион байгуулалтыг "Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл"-д заасны дагуу өөрчлөн зохион байгуулах	2002 онд	СЗЯЯ, ТЕХ, УЦХ
		Бирэлэгч дэмжлэлын үзүүлэх үйлчилгээ стандартыг боловсруулж мөрдүүлэх	2001 онд	Харилцийн бирэлэг
		Бирэлийн үйлчилгээний тарифыг боловсронгуй болгох зүгээ хэмжээ авах	2001 онд	Харилцийн бирэлэг
		ХАА-н бэлэны үзүүлэх үйл эсвэлгээг Дэлхийн банктай бирэлэлцэн гэрээний дагуу үзүүлэгээг гүйцэтгүүлэх, үйл эсвэлгээг нь эсэ дүүлэх	2001-2003 онд	ТЕХ, СЗЯЯ

			Бүрэлийн үйл ажиллагаат домжих зорилгоор төрийн өмчит үйлдвэрийн газрыг хувьчлахад төрийн өмчит хувьцаат компанийн хэлбэрт оруулан эхлэл бүр 2.50 сая төгрөгөөс доошгүй хувьцаат хуваалцах эзэмшлээ байгуулах	Тухай бүр	ТӨХ
11	Тэр. Нийтийн сайбарын өөрчлөлт байгуулалт, хувьчлал		Нийтмийн сайбарт хувьчлал явуулах зорилгоор удирдлага, гүйцэтгэл, төрөөсийн гэрээний үүргийнхан загвар, журмыг боловсруулж Засгийн газарт оруулан батлуулж, эдгээр гэрээний үндсэн дээр ажиллуулах байгуулага, үйлчилгээ, эд хөрөнгийн жагсаалтыг Засгийн газарт танилцуулах	2001 онд	НХҮЯ, ХЗДХЯ ТӨХ
			Нэмэлт хөрөнгө оруулах замаар хувьчлах байгуулага, үл хөдлөх хөрөнгийн жагсаалтыг байгуулага бүрээр гаргаж нийтэд мэдээлэх, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах	2001 оны сүүлийн хагас жилд	ТӨХ, холбогдох яам, газруул
			Нийтмийн сайбарт хувьчлал явуулах хуулийн төслийг боловсруулж УИХ-д оруулах /Улсын Их Хурлын ажлын хэсэгтэй хамтарч/	2001 онд	ТӨХ, ХЗДХЯ, ЭМЯ, БСШУЯ
			Хувьчлагдаж байгуулагын ажилтангийн нийтмийн хамгаалын асуудлаар ццгээ зээлэгч хийх гэрээний загварыг боловсруулж холбогдох газраар батлуулан төрийн өмчийг хувьчлан авсан тухай бүр нь гэрээ байгуулж, гэрээний биелэлтэд хяналт тавьж ажиллах	2002 онд	ЭМЯ, БСШУЯ, ТӨХ
			Орон нутаг дахь нийтмийн хэлмэж, үйлчилгээний төвийн үйл ажиллагаат төрийн бус байгуулагаар гүйцэтгүүлэх талаар санаа боловсруулж, эрх бүхий байгуулагаар батлуулан мөрдүүлэх	2002 онд	НХҮЯ, ТӨХ
			Нийтмийн сайбарын хувьчлалын үр дүнд хувийн өмчийн өрөөдөө нэмэлт бий болгагаа холбогдуулан үйлчилгээний чанар, аюулгүй байдлын талаарх стандартыг боловсруулж мөрдүүлэх	2001 онд	БСШУЯ, ЭМЯ, СЗЗҮГ, ТӨХ
			Нийтмийн сайбарын хувьчлалын арга зүүд болон удирдлага, гүйцэтгэл, төрөөсийн гэрээний талаар гарын авлага бэлтгэж нийтийн хүргэл бөгөөк, зөв чиглэлээр сургалт, семинар зохион байгуулах	2002 онд	ТӨХ, ЭМЯ БСШУЯ
			Ашгийн бус, төрийн бий хуулийн этгээдийн өмчийн статусыг талаар бүсад орны туршлагыг судлан, өмчийн ийм төрөлтэй холбогдсон харилцааны эрх зүйн орчныг өөрийн онцлогт тулгуурлан боловсруулах	2002 онд	ТӨХ, ХЗДХЯ

12	**Зургаа. Төрийн өмчийн хувьчлалын талаарх мэдээлэл, сурталчилгааг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, мэдээллийн орчин үеийн техник, технологи ашиглан олон нийтэд өргөнөөр мэдээлэх ажлыг Төрийн өмчийн хөрөө зохион байгуулна**	Хувьчлалын маркетингийг аль болох өргөн хүрээнд явуулах замаар стратегийн хөрөнгө оруулагчдын сонирхлыг татах доорхи арга хэмжээ авах. Үүнд: -Гадаадын хөрөнгө оруулалтыг дэмжих зорилгоор үнэ цэнэтэй аж ахуйн нэгжийг гадаадын хөрөнгө оруулагчид хувьчлах чиг баримтлан энэ талаархи сурталчилгааг өргөн хүрээнд явуулах -Интернетийг ашиглан хувьчлалын ажлыг өргөн сурталчлах -Тухайн аж ахуйн нэгжийг хувьчлан авч болзошгүй хөрөнгө оруулагчтай шууд холбоо тогтоож, хувьчлалд оролцохыг урих, мэдээллээр түргэн шуурхай хангах -Хувьчлагдах аж ахуйн нэгжийн маркетингийн сурталчилгаанд гадаадын зөвлөхийг оролцуулах	Тухай бүр	ТӨХ
13	**Долоо. Хувьчлалын нийгэм, эдийн засгийн үр өгөөжийг дээшлүүлэх**	--Улс орны инээх салбарууд хувьчлагдаж байгаатай холбогдуулан нийгмийн нийтлэг эрх ашгийг нийцүүлэн шинээр гаргах стандарт, дүрэм, журам, хууль эрхийн актуудын жагсаалтыг гарган боловсруулах ажлыг зохион байгуулах, эрх бүхий байгууллагаар батлуулан мөрдүүлэх	2001-2002 онд	ДБЯ, ҮХЯ, ХЗДХЯ, ЭМЯ, БСШУЯ
14	Тухайн салбарт байгаа дангаар нөөрхох байдлыг задлах, шударга өрсөлдөөн үүсэх нөхцөлийг бүрдүүлэх	-Шударга бус өрсөлдөөнийг хянан зохицуулах албыг хуульд заасны дагуу бий болгох замаар зах зээл дээр үүсч буй шударга бус үйл ажиллагаатай тэмцэх ажлыг эрчимжүүлэх	2001 онд	СЭЗЯ, ТӨХ
		-Зах зээл дээр гарч буй шударга бус үйл ажиллагааг нийтэд мэдээлэж, зарлах ажиллагааг тогтмолжуулах ажлыг зохион байгуулах	Тухай бүр	СЭЗЯ, ХЗДХЯ
15	Хувьчлагдсан аж ахуйн нэгжүүд үйл ажиллагаагаа хууль тогтоомж, зах зээлийн нийтлэг дэг жаягт тохируулан явуулах боломжийг олгох үүднээс аж ахуйн үйл ажиллагааг бүртгэх, тусгай зөвшөөрөл олгох тогтолцоог боловсронгуй болгож, зөвшөөрлийн тоог цөөрүүлэх, давхардлыг арилгах, аль болох нэг цэгт төвлөрүүлэх чиглэлээр өөрчлөн сайжруулна.	Аж ахуй эрхлэх үйл ажиллагааг либералчлах зорилгоор төрөөс олгодог төрөл бүрийн зөвшөөрөл, лицензийн өнөөгийн байдлыг судалж, тоог багасгах чиглэлээр эрх зүйн орчинг бий болгох арга хэмжээ авах	2001 онд	ХЗДХЯ

16	Хувьчлалыг үр дүнтэй болгох, аж ахуйн нэжийн цаашдын үйл ажиллагаат үр ашигтай явуулах зорилгоор орчин үеийн санхүү, аудит, хууль, удирдлага, маркетинг болон бусад чиглэлээр зөвлөгөө өгөх үндэсний төвтөөсөө бүрдүүлэх, шинэ өмчлөгчидээс аж ахуйда оруулан байгуулалт хийхэд нь тереес бүх талын дэмжлэг туслалцаа үзүүлэх	Хувьчлалын дараахь өөрчлөн байгуулалт хийхэд нь шинэ өмчлөгч нарт туслах, зах зээлийн ерөнхөөний шударга байдлыг хангах үүднээс Засгийн газрын дэргэд хувьчлагдсан үйлдвэрийн газрын өөрчлөн байгуулалт, хувийн секторыг дэмжих үндэсний зөвлөлийг байгуулж төлөвлөгөөгөө ажиллуулах	2001 оны сүүлийн хагас жилд	ЗГ-ын ХЭГ, ТӨХ, холбогдох яам
		Өндөр хөгжилтэй орнуудад суралцан үндэсний боловсон хүчний мэдээллийн сан бүрдүүлэх үндэсний зөвлөхүүдийн хүчин чадлыг бүрэн дүүрэн ашиглаж хувьчлалын дараахь өөрчлөн байгуулалтыг дэмжих ажлыг тусгай төлөвлөгөөгөө зохион байгуулах	2001 онд	БСШУЯ, УХЯ, ТӨХ
		Хувьчлагдсан эд хөрөнгө, аж ахуйн нэгжүүдэй холбогдон шинэ өмчлөгчтэй байгуулсан гэрээний биелэлтийг гэрлэж Засгийн газарт тайлагнуулах	2001 оны эхний хагас жилд	ТӨХ, холбогдох яам, газрууд
17	**Байгаль орчныг хамгалах, ашиглуулах байдлыг хангах:** -үйлдвэр, аж ахуйн нэгжийг хувьчлахдаа шаардлагатай гэж үзвэл байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийлгэж, хүрээлэн байгаа орчинд учирч болзошгүй хортой нөлөөллийг тооцоолж, түүнийг багасгах, арилгах арга хэмжээг өөрчлөн байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулан хэрэгжүүлэх	Хувьчлах аж ахуйн нэгж, эд хөрөнгөтэй холбогдож байгаль орчин, ахуулгүй байдлын судалгаа гаргаж, үйлдвэрийн хорт хэлбэлүүдэ шийдэрлэх арга замын талаар санал боловсруулах, хувьчлах нөхцөл тусгах	Тухай бүр	БОЯ
		Хувьчлагдсан болон хувьчлагдахаар "Төрийн өмчийг 2001-2004 онд хувьчлах үндсэн чиглэл"-д тусгасан нүүрсний уурхайн ашиглалтын үед үүссэн байгаль орчны эвдрэлийг нөхөн сэргээх асуудлаа талаар санал боловсруулж шийдэрлэх	2002 онд	ДБЯ, ТӨХ, БОЯ
		Шаардлагатай гэж үзсэн аж ахуйн нэгжийг хувьчлах үед байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээг хийлгэх ажлыг зохион байгуулах	Тухай бүр	БОЯ
		Хувьчлалын үр дүнд ажлаас халагдах ажилтнуудын дахин сургалтыг зохион байгуулж, хувьчлалын сөрөг нөлөөллийг багасгах ажлыг зохион байгуулах	Тухай бүр	БСШУЯ, ЭМЯ, НХХЯ, ТӨХ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 5 дугаар сарын 2-ны өдөр **Дугаар 106** **Улаанбаатар хот**

Гадаадын хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтыг зохион байгуулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Гадаадын хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтыг 2002 оны П, Ш улиралд Улаанбаатар хотод зохион байгуулах нь зүйтэй гэж үзсэгй.

2. Гадаадын хөрөнгө оруулагчдын чуулга уулзалтын бэлтгэлийг ханган, түүнийг зохион байгуулах Засгийн газрын комиссын бүрэлдэхүүнийг хавсралт ёсоор батлсугай.

3. Комиссын дарга Ч.Ганзориг дор дурдсан арга хэмжээ авахыг даалгасугай:

а/чуулга уулзалтыг Дэлхийн банк, НҮБ-ын худалдаа, хөгжлийн байгууллага болон олон улсын эдийн засаг, үйлдвэр, худалдаа, хөгжлийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах;

б/чуулга уулзалтын бэлтгэлийг хангах, түүнийг зохион байгуулахтай холбогдсон ажлын гол гол чиглэлээр олон нийтийн байгууллага, худалдаа, үйлдвэрлэл эрхлэгчдийн төлөөллийг өргөнөөр оролцуулсан ажлын хэсэг байгуулан төлөвлөгөө гаргаж ажиллах.

4. Чуулга уулзалтын бэлтгэл ажлыг хангах, түүнийг зохион байгуулахтай холбогдон гарах зардлыг тухайн жилийн төсөвт туссан санхүүжүүлэхийг Санхүү, эдийн засгийн сайд Ч.Улаанд даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ҮЙЛДВЭР, ХУДАЛДААНЫ САЙД **Ч.ГАНЗОРИГ**

Засгийн газрын 2001 оны 106 дугаар тогтоолын хавсралт

ГАДААДЫН ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН ЧУУЛГА УУЛЗАЛТЫН БЭЛТГЭЛИЙГ ХАНГАХ, ТҮҮНИЙГ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАСГИЙН ГАЗРЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Дарга -Үйлдвэр, худалдааны сайд

Гишүүд: -Санхүү, эдийн засгийн дэд сайд;
-Гадаад хэргийн дэд сайд;
-Хүнс, хөдөө аж ахуйн дэд сайд;
-Байгаль орчны дэд сайд;
-Дэд бүтцийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
-Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын тэргүүн дэд дарга;
-Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга;
-Үйлдвэр, худалдааны яамны Худалдааны бодлого, хамтын ажиллагааны газрын дарга;
-Улсын гаалийн ерөнхий газрын дарга;
-Үндэсний татварын ерөнхий газрын дарга;
-Төрийн өмчийн хорооны дарга;
-Газрын тосны хэрэг эрхлэх газрын дарга;
-Ашигт малтмалын хэрэг эрхлэх газрын дарга;
-Үнэт цаасны хорооны дарга;
-Улаанбаатар хотын ерөнхий менежер;
-Стандартчилал, хэмжил зүйн үндэсний төвийн дарга.

Нарийн бичгийн дарга - Гадаад худалдаа, гадаадын хөрөнгө оруулалтын газрын дарга.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 5 дугаар сарын 10-ны өдөр **Дугаар 107** **Улаанбаатар хот**

Гаалийн татварын хувь, хэмжээг өөрчлөх тухай

Гаалийн тарифын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт, Засгийн газарт эрх олгох тухай 2001 оны 4 дүгээр сарын 26-ны өдрийн хуулийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Малын гоц халдварт өвчнөөс сэргийлэх зорилгоор 2001 оны 2 дугаар сарын 19-ний өдрөөс 2001 оны 8 дугаар сарын 19-ний өдөр хүртэлх хугацаанд импортолсон буюу импортлох вакцин, хаврын тариалалтад зориулж 2001 оны 5 дугаар сарын 1-ний өдрөөс 8 дугаар сарын 19-ний өдөр хүртэлх хугацаанд импортлох үрийн улаан буудай, бордоо, ургамал хамгаалалын бодист ногдуулах импортын гаалийн татварын хувь, хэмжээг тус тус "О" байхаар өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙД **Д.НАСАНЖАРГАЛ**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 24 (211)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *Монгол Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай*

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ:

- *Иргэний хамгаалалтын бэлэн байдлын зэргүүдэд шилжүүлэх тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2001 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2001 оны зургадугаар сарын 21 №24 (211)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

313. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2001 - 6 - 7 - ны хууль) 653

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

314. Монгол Улсын шүүхийн шүүгчийн зэрэг дэвийн тухай дүрэм батлах тухай Дугаар 48 654
315. Прокурорын албан тушаалын зэрэг дэвийн нэмэгдэл олгох журам батлах тухай Дугаар 49 656
316. Монгол Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай Дугаар 51 657
317. Байгын хорооны гишүүнээр батлах тухай Дугаар 52 657
318. Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл буцаах тухай Дугаар 56 657

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

319. Зарим шүүгчийг чөлөөлөх тухай Дугаар 134 658
320. Зарим шүүгчийг томилох тухай Дугаар 135 658

Дөрөв. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

321. Иргэний хамгаалалтын бэлэн байдлын зэргүүдэд шилжүүлэх тухай Дугаар 111 658
322. Лабораторийн харьяаллыг өөрчлөх тухай Дугаар 113 660

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 6 дугаар сарын 7-ны өдөр **Улаанбаатар хот**

ГАДААДЫН ИРГЭНИЙ ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт дор дурдсан агуулгатай 2 дахь заалт нэмсүгэй:

"2/Монгол Улсын олон улсын зорчигч, тээврийн хэрэгслийн харилцааны нэлттэй хилийн боомт дээр Монгол Улсад зорчигчид орох-гарах, дамжин өнгөрөх, зайлшгүй шаардлагатай тохиолдолд гарах виз олгох;"

2 дугаар зүйл. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"1.Монгол Улсад төрийн, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өөрөө удирдах байгууллагын урилгаар ирсэн болон зорчигчоос

бусад гадаадын иргэнийг урьж ирүүлсэн аж ахуйн нэгж, байгууллага, иргэн тэдгээрийг ирсэн өдрөөс нь хойш 7 хоногийн дотор Албанд бүртгүүлнэ."

3 дугаар зүйл. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Албаа" гэснийг "Албаны эвсвөөрлийг үндэслэн гадаад хэргийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага"; 26 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн "нийслэлд албанд, аймагт цагдаагийн байгууллагад" гэснийг "Албанд"; 14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 2, 3, 4, 5 дахь заалтын дугаарыг "3", "4", "5", "6" гэж тус тус өөрчилсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 6 дугаар сарын 7-ны өдөр **Дугаар 48** **Улаанбаатар хот**

Монгол Улсын шүүхийн шүүгчийн зэрэг дэвийн тухай дүрэм батлах тухай

Шүүхийн тухай хуулийн 6², 64 дүгээр зүйлийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын шүүхийн шүүгчийн зэрэг дэвийн тухай дүрмийг хавсралт ёсоор шинэчлэн батлаж, 2002 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2.Энэ тогтоол батлагдсантай холбогдуулан "Дүрэм батлах тухай" Улсын Их Хурлын 1996 оны 1 дүгээр сарын 19-ний өдрийн 5 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

Монгол Улсын Их Хурлын 2001 оны 48 дугаар тогтоолын хавсралт

МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ШҮҮГЧИЙН ЗЭРЭГ ДЭВИЙН ТУХАЙ ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.Монгол Улсын шүүхийн шүүгчийн зэрэг дэвийн тухай дүрэм нь шүүгчид зэрэг дэв, түүний нэмэгдлийг олгох, бууруулах, хүчингүй болсонд тооцох журмыг тогтооно.

2.Монгол Улсын шүүхийн шүүгчид шүүхийн тэргүүн түшээ, дэд түшээ, гүтгаар түшээ, детгөөр түшээ, тавдугаар түшээ гэсэн зэрэг дэв олгоно.

3.Шүүгчид зэрэг дэв олгохдоо албан тушаал, мэргэжлээрээ болон шүүгчээр ажилласан хугацаат үндэслэн олгох бөгөөд мэргэшлийн түвшин, ажил хэргийн чадвар, шүүгчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж байгаа байдлыг харгалзана.

4.Зэрэг дэв хүртсэн шүүгчид энэ дүрэмд заасан зэрэг дэвийн нэмэгдэл олгоно.

Хоёр.Шүүгчид зэрэг дэв олгох, бууруулах, хүчингүй болсонд тооцох журам

5.Монгол Улсын шүүхийн шүүгчийн зэрэг дэвийг дараахь журмаар олгоно:

Зэрэг дэв	Зэрэг дэв олгоход харгалзах үзүүлэлт				
	Албан тушаал	Ажилласан хугацаа		Мэргэжлийн түвшин, ажил хэргийн чадвар	Ёс зүйн хэм хэмжээг сахиж байгаа байдал
		Мэргэж-лээрээ	Үүнээс: шүүгчээр		
Тэргүүн түшээ	Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч	20	10	Мэргэжлийн түвшин, ажил хэргийн чадварын дүгнэлтээр "хангалттай" үнэлгээ авсан	Сахилгын шийтгэл сүүлийн 2 жилд хүлээгээгүй
	Улсын дээд шүүхийн танхимын тэргүүн шүүгч	25	16		
	Улсын дээд шүүхийн шүүгч	25	18		

Дэд түшээ	Улсын дэвд шүүхийн Ерөнхий шүүгч			-"-	-"-
	Улсын дэвд шүүхийн Танхимын тэргүүн шүүгч				
	Улсын дэвд шүүхийн шүүгч	20	15		
	Аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч	20	15		
	Аймаг, нийслэлийн шүүхийн шүүгч	21	18		
	Сумын, сум дундын, дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч	23	20		
Гутгаар түшээ	Улсын дэвд шүүхийн шүүгч			-"-	-"-
	Аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч	11	8		
	Аймаг, нийслэлийн шүүхийн шүүгч	14	11		
	Сумын, сум дундын, дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч	14	11		
	Сумын, сум дундын, дүүргийн шүүхийн шүүгч	16	13		
Дөт-гөөр түшээ	Аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгч			-"-	-"-
	Аймаг, нийслэлийн шүүхийн шүүгч				
	Сумын, сум дундын, дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч	8	5		
	Сумын, сум дундын, дүүргийн шүүхийн шүүгч	8	5		
Тав-дугаар түшээ	Сумын, сум дундын, дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгч	3		-"-	-"-
	Сумын, сум дундын, дүүргийн шүүхийн шүүгч	3			
	Туслах шүүгч		Шүүгчийг орлон ажиллах хугацаанд		

6.Монгол Улсын шүүхийн шүүгчийн тэргүүн түшээ зэрэг дэвийг Улсын дээд шүүхийн санал болгосноор Монгол Улсын Ерөнхийлөгч, бусад зэрэг дэвийг Улсын дээд шүүх, аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгчийн санал болгосноор Шүүхийн ерөнхий зөвлөл олгоно.

7.Шүүгчийн албан тушаалаас өөр албан тушаалд ажиллаж байгаад шүүгчээр томилогдвол тухайн албан тушаалын зэрэг дэв олгоно. Хэрэв зэрэг дэвийг хугацааны өмнө нэмэгдүүлэн олгох шаардлагатай гэж үзвэл Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгчийн саналыг үндэслэн Шүүхийн ерөнхий зөвлөлийн тогтоолоор, тэргүүн түшээ зэрэг дэвийг Улсын дээд шүүхийн санал болгосноор Ерөнхийлөгчийн зарлигаар олгож болно.

Шүүгчийн зэрэг дэвийг шүүгчээр томилснооc хойш 45 хоногийн дотор олгоно.

8.Шүүгч сахилгын шийтгэл хүлээсэн бол түүний зэрэг дэвийг нэг шатаар бууруулна. Ийнхүү зэрэг дэвийг нь бууруулсан шүүгчид хуучин зэрэг дэвийг буцааж олгох асуудлыг сахилгын шийтгэлгүйд тооцогдсоны дараа энэ дүрэмд заасны дагуу ердийн журмаар шийдвэрлэнэ.

9.Энэ дүрмийн 8-д зааснаас бусад тохиолдолд шүүгчийн зэрэг дэвийг бууруулахгүй.

10.Шүүгчийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу шүүгчийн албан тушаалаас нь огцруулсан бол шүүгчийн зэрэг дэв хүчингүй болсонд тооцогдоно.

Гурав.Шүүгчийн зэрэг дэвийн нэмэгдэл, түүнийг олгох, бууруулах журам

11.Шүүгчийн зэрэг дэвийн нэмэгдлийг түүний албан тушаалын цалингаас дараахь хувиар тооцож олгоно:

Зэрэг дэв	Тэргүүн түшээ	Дэд түшээ	Гутгаар түшээ	Дөтгөөр түшээ	Тавдугаар түшээ
Нэмэгдлийн хувь	35	33	31	28	25

12.Шүүгчийн зэрэг дэвийн нэмэгдлийг шүүгчийн албан тушаалд томилогдсон өдрөөс эхлэн сар бүр олгоно.

13.Шүүгч сахилгын шийтгэл хүлээж зэрэг дэв нь буурсан бол сахилгын шийтгэл хүлээсэн өдрөөс эхлэн нэмэгдлийг буурсан зэрэг дэвээр олгоно. Харин шүүхийн тавдугаар түшээ зэрэг дэвтэй шүүгч сахилгын шийтгэл хүлээсэн бол сахилгын шийтгэлтэй байсан хугацаанд зэрэг дэвийн нэмэгдэл олгохгүй.

14.Шүүгчийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу албан тушаалаас нь чөлөөлсөн бол түүнд зэрэг дэвийн нэмэгдэл олгохгүй.

15.Тэтгэвэрт гарсан шүүгч шүүгчийг орлон ажиллаж байгаа тохиолдолд урьд олгосон зэрэг дэвийн нэмэгдлийг түүнд олгоно.

16.Шүүгчийг орлон ажиллаж байгаа туслах шүүгчид шүүгчийн тавдугаар түшээ зэрэг дэвийн нэмэгдэл олгоно.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 6 дугаар сарын 7-ны өдөр **Дугаар 49** **Улаанбаатар хот**

Прокурорын албан тушаалын зэрэг дэвийн нэмэгдэл олгох журам батлах тухай

Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хуулийн 36 дугаар зүйл, Төрийн албаны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Прокурорын албан тушаалын зэрэг дэвийн нэмэгдэл олгох журмыг хавсралт ёсоор батлагдсугай.

3.Энэ тогтоолыг 2001 оны 7 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

Монгол Улсын Их Хурлын 2001 оны 49 дүгээр тогтоолын хавсралт

ПРОКУРОРЫН АЛБАН ТУШААЛЫН ЗЭРЭГ ДЭВИЙН НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ

1.Монгол Улсын Прокурорын байгууллагын тухай хуулийн 30, 36 дугаар зүйл, Төрийн албаны тухай хуулийн 8 дугаар зүйл, 28 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалтад заасныг үндэслэн прокурорт зэрэг дэвийн нэмэгдэл олгоно.

2.Зэрэг дэв бүхий прокурорт сар бүр түүний албан тушаалын цалингийн дор дурдсан хувьтай тэнцэх хэмжээний нэмэгдэл олгоно:

Зэрэг дэв	Төрийн хууль цаазын тэр-гүүн зөвлөх	Төрийн хууль цаазын ша-дар зөвлөх	Хууль цаазын итгэмжит зөвлөх	Хууль цаазын ахлах зөвлөх	Хууль цаазын зөвлөх
нэмэгдлийн хувь	25	23	21	18	15

3.Прокурорын албан тушаалын зэрэг дэвийг бууруулсан бол буурсан зэрэг дэвийн нэмэгдэл олгоно.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 6 дугаар сарын 8-ны өдөр **Дугаар 51** **Улаанбаатар хот**

Монгол Улсын Их Хурлын гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай

Монгол Улсын Их Хурлын сонгуулийн 22 дугаар тойрогт 2001 оны 5 дугаар сарын 20-ны өдөр явуулсан нөхөн сонгуулийн нэгдсэн дүнгийн тухай Сонгуулийн ерөнхий хорооны илтгэлийг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

сонгогдсон Данзандаржаагийн Туяагийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрсүгэй.

Монгол Улсын Их Хурлын гишүүнээр нөхөн

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 6 дугаар сарын 8-ны өдөр **Дугаар 52** **Улаанбаатар хот**

Байнгын хорооны гишүүнээр батлах тухай

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын гишүүний эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5 дахь заалт, өөрийнх нь гаргасан хүсэлтийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Улсын Их Хурлын гишүүн Д.Туяаг Нийгмийн бодлогын болон Төсвийн байнгын хорооны гишүүнээр тус тус баталсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 6 дугаар сарын 8-ны өдөр **Дугаар 56** **Улаанбаатар хот**

Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 40 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

Хувийн хамгаалалтын тухай хуулийн төсөлтэй уялдуулан хувийн бие хамгаалагчийг иргэний эрүүл мэндийн даатгалд заавал хамааруулахаар Монгол Улсын Засгийн газраас өргөн мэдүүлсэн Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд тусгагдсан асуудал нь Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтаар зохицуулагдаж байгаа, түүнчлэн хувийн бие хамгаалагчийг даатгалын бусад төрөлд хамааруулах эсэх асуудлыг нэг мөр шийдвэрлэх нь зүйтэй тул уг хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаасугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

в/Засгийн газар, Улсын байгнын онцгой комиссын шийдвэрүүдийг хэрэгжүүлэх ажлыг газар дээр нь хариуцан зохион байгуулах мэргэжлийн алба, мэргэжилтнүүдийн бэлэн байдлыг шуурхай хангуулж, халдварын бүс нутагт оруулж ажиллуулах арга хэмжээ авсугай;

г/иргэний хамгаалалтын бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн бүсэд малын гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, уг өвчинтэй тэмцэх мал эмнэлэг, ариун цэвэр, хорио цээрийн арга хэмжээний талаар сургалт, сурталчилгааг зохион байгуулах, гарын авлага, мэргэжил, арга зүйн удирдлага, заавар зөвлөмжөөр бүрэн хангах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд шуурхай мэдээлэх арга хэмжээ авч байсугай.

6. Гоц халдварт өвчний голомт, хорио цээрийн онцгой болон хязгаарлалтын бүсэд мөрден ажиллавал зохих дүрэм, журам, ариун цэврийн дэглэм, бусад хууль тогтоомжийн хэрэгжилтийн байдалд хяналт тавьж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн сайд Д.Насанжаргал, Улсын иргэний хамгаалалтын газрын дарга О.Уржин нарт даалгасугай.

7. Малын гоц халдварт өвчин хэрхэн тархаж, дамжиж байгааг судлан тогтоохыг Хууль зүй, дотоод хэргийн сайд Ц.Нямдорж, Тагнуулын ерөнхий газрын дарга М.Батсайхан нарт даалгасугай.

8. Малын гоц халдварт өвчний цагийн байдлын тухай мэдээг Засгийн газарт зохих журмын дагуу танилцуулж байхыг Батлан хамгаалахын сайд, Улсын байгнын онцгой комиссын дарга Ж.Гүррагчаад даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД **Ж.ГҮРРАГЧАА**

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2001 оны 5 дугаар сарын 23-ны өдөр **Дугаар 113** **Улаанбаатар хот**

Лабораторийн харьяаллыг өөрчлөх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 5-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Дархан-Уул аймаг дахь Хөрс, агрохимийн шинжилгээний улсын төв лабораторийг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Газрын хэрэг эрхлэх газрын харьяалалд шилжүүлж, газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа хийх үүрэг бүхий Хөрс, ургамал, экологийн шинжилгээний баазлабораторийг болгон ажиллуулахаар тогтоосугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД **Н.ЭНХБАЯР**

БАЙГАЛЬ ОРЧНЫ САЙД **У.БАРСБОЛД**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн эвлэл
Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.
☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 25 (212)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Хувийн хамгаалалтын тухай*
- *Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай*
- *Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрөх тухай*
- *Соёлын өвийг хамгаалах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2001 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2001 оны зургадугаар сарын 29 №25 (212

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

323. Хувийн хамгаалалтын тухай (2001-6-7-ны хууль) 661

324. Малын улмын сан, эрүүл мэндийг хамгаалах тухай (2001-6-7-ны хууль) 665

325. Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрөх тухай (2001-6-8-ны хууль) 673

326. Соёлын өвийг хамгаалах тухай (2001-6-8-ны хууль) 673

327. Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хууль хүчингүй болсонд тооцох тухай (2001-6-8-ны хууль) 680

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

328. Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнд нэмэгдэл, зэрэг дэв олгох журам батлах тухай Дугаар 50 680

329. Төрийн зарим байгууллагын удирдах албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт оруулах тухай Дугаар 53 682

330. Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөх тов тогтоох тухай Дугаар 54 682

331. Хөдөлмөрийн арбитрын дүрэм батлах тухай Дугаар 55 682

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 6 дугаар сарын 7-ны өдөр **Улаанбаатар хот**

ХУВИЙН ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь хувийн хамгаалалтын үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Хувийн хамгаалалтын тухай хууль тогтоомж

2.1.Хувийн хамгаалалтын тухай хууль тогтоомж нь Иргэний хууль[1], энэ хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:

[1] *Иргэний хууль- "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1995 оны № 1 дүгээрт нийтлэгдсэн.*

3.1.1."хувийн хамгаалалт" гэж хувийн хамгаалалтын үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд гэрээний үндсэн дээр үйлчлүүлэгчийн амь бие, эрүүл мэндийг гэмт халдлагаас хамгаалахын тулд энэ хуулиар зөвшөөрсөн үйл ажиллагаа явуулахыг;

3.1.2."бие хамгаалагч" гэж энэ хуульд заасан журмын дагуу хувийн хамгаалалтыг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр гүйцэтгэх эрхтэй этгээдийг;

3.1.3."хувийн хамгаалалтын байгууллага" гэж энэ хуульд заасан журмын дагуу эрх бүхий байгууллагаас хувийн хамгаалалт эрхлэх тусгай зөвшөөрөл авч, улсын бүртгэлд бүртгүүлсэн хуулийн этгээдийг;

3.1.4."үйлчлүүлэгч" гэж гэрээний үндсэн дээр хувийн хамгаалалт хийлгэж байгаа этгээдийг.

4 дүгээр зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ

4.1.Төрийн тусгай хамгаалалт, зэвсэгт хүчин, бусад цэрэг, тагнуул, цагдаагийн болон гэрээт харуул хамгаалалттай холбогдсон харилцаанаас бусад хувийн хамгаалалттай холбогдсон харилцааг энэ хуулиар зохицуулна.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Хувийн хамгаалалтын үйл ажиллагаа

5 дугаар зүйл. Хувийн хамгаалалт эрхлэх этгээдэд тавих шаардлага

5.1.Хувийн хамгаалалтыг энэ хуульд заасан журмын дагуу тусгай зөвшөөрөл авсан бие хамгаалагч, хуулийн этгээд эрхлэн явуулна.

5.2. Бие хамгаалагч нь 20 нас хүрсэн, эрүүл мэнд, бие бялдар, ёс зүйн шаардлага хангасан, хувийн хамгаалалтын сургалтад хамрагдаж зохих мэдлэг, даалгаа эзэмшсэн, гэмт хэрэг санаатай үйлдэж ял шийтгэгдэж байгаагүй, эрх зүйн бүрэн чадамжтай иргэн байна.

5.3. Хувийн хамгаалалт эрхлэх хуулийн этгээд нь үйл ажиллагаагаа явуулах бүтэц, зохион байгуулалт, боловсон хүчин, техник хэрэгсэл болон өөрийгөө санхүүжүүлэх чадвартай байна.

5.4. Хувийн хамгаалалт эрхлэх хуулийн этгээд нь 10-аас доошгүй бие хамгаалагчтай байна.

5.5. Хуулийн этгээд нь хувийн хамгаалалтыг бие хамгаалагчаар гүйцэтгүүлнэ.

5.6. Цагдаагийн байгууллагаас бие хамгаалагчаар ажиллах тусгай зөвшөөрөл авсан иргэн нь хувийн хамгаалалтын хуулийн этгээд үүсгэн байгуулах, эсхүл хувийн хамгаалалтын байгууллагад ажиллаж болно.

5.7. Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол гадаад улсын иргэн тусгай зөвшөөрөл авсны үндсэн дээр Монгол Улсын нутаг дэвсгэрт бие хамгаалагчаар ажиллаж болно.

6 дугаар зүйл. Хувийн хамгаалалт эрхлэх тусгай зөвшөөрөл олгох

6.1. Хувийн хамгаалалт эрхлэх тусгай зөвшөөрлийг аймаг, нийслэлийн цагдаагийн газар /хэлтэс/ олгоно.

6.2. Хувийн хамгаалалт эрхлэх тусгай зөвшөөрөл авахыг хүссэн иргэн аймаг, нийслэлийн цагдаагийн газар/хэлтэс/-т дараахь баримт бичгийг бүрдүүлж өгнө:

6.2.1. тусгай зөвшөөрөл олгохыг хүссэн өргөдөл;

6.2.2. иргэний үнэмлэх;

6.2.3. эрүүл мэндийн байгууллагын тодорхойлолт;

6.2.4. энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан сургалтад хамрагдсан болохыг нотолсон баримт бичиг.

6.3. Хувийн хамгаалалт эрхлэх тусгай зөвшөөрөл авахыг хүссэн хуулийн этгээд аймаг, нийслэлийн цагдаагийн газар /хэлтэс/-т дараахь баримт бичгийг бүрдүүлж өгнө:

6.3.1. тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл;

6.3.2. улсын бүртгэлийн гэрчилгээ;

6.3.3. бие хамгаалагч тус бүрийн эрүүл мэндийн тодорхойлолт, тэдгээрийн зөвшөөрөл;

6.3.4. энэ хуулийн 5.3-т заасан шаардлагыг хангасан болохыг нотолсон баримт бичиг.

6.4. Аймаг, нийслэлийн цагдаагийн байгууллага өргөдөл, холбогдох материалыг хүлээн авч 30 хоногийн дотор тусгай зөвшөөрөл олгох эсэх асуудлыг шийдвэрлэж, бичгээр хариу мэдэгдэнэ.

6.5. Дараахь тохиолдолд хувийн хамгаалалт эрхлэх тусгай зөвшөөрөл олгохоос татгалзана:

6.5.1. хувийн хамгаалалт эрхлэх тусгай зөвшөөрөл хүссэн иргэн энэ хуулийн 5. 2, хуулийн этгээд энэ хуулийн 5.3-т заасан шаардлага хангаагүй;

6.5.2. энэ хуулийн 6.2; 6.3.-т заасан баримт бичиг бүрдээгүй .

7 дугаар зүйл. Хувийн хамгаалалт эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох

7.1. Цагдаагийн байгууллага хувийн хамгаалалт эрхлэх тусгай зөвшөөрлийг дараахь тохиолдолд түдгэлзүүлнэ:

7.1.1. бие хамгаалагч гэмт хэрэгт холбогдсон бол гэм буруутай болох нь нотлогдох хүртэл ;

7.1.2. хувийн хамгаалалтын байгууллага энэ хуулийн 5.3.; 5.4; 5.5-д заасан шаардлага хангаагүй болох нь тогтоогдсон .

7.2. Бие хамгаалагч гэм буруугүй болох нь шүүхээр тогтоогдсон, хувийн хамгаалалтын байгууллага энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчлөө арилгасан бол тусгай зөвшөөрлийг сэргээнэ.

7.3.Тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох шийдвэр гаргахын өмнө цагдаагийн байгууллага бие хамгаалагч болон хуулийн этгээдийн удирдлагад урьдчилсан сануулга өгч болно. Сануулгад хуулийн ямар заалт зөрчсөнийг тодорхой зааж, гаргасан зөрчлийг арилгах хугацаат заана.

7.4. Дараахь тохиолдолд цагдаагийн байгууллага хувийн хамгаалалт эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгоно:

7.4.1 .энэ хуулийн 9.2 –ыг зөрчсөн;

7.4.2. бие хамгаалагч гэмт хэрэг үйлдсэн нь тогтоогдсон;

7.4.3. бие хамгаалагч эрх зүйн чадамжгүй болсон;

7.4.4. үйл ажиллагаатай нь холбогдуулан цагдаагийн байгууллагаас тавьсан шаардлагыг удаа дараа биелүүлээгүй;

7.4.5. хувийн хамгаалалтыг хууль зөрчсөн бусад хэлбэрээр эрхэлсэн;

7.4.6. энэ хуулийн 11.1.3-ыг зөрчсөн;

7.4.7. хуулийн этгээд татан буугдсан.

7.5. Хувийн хамгаалалт эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосон цагдаагийн байгууллагын шийдвэрийг хууль бус гэж үзвэл хувийн хамгаалалтын байгууллага болон бие хамгаалагч шүүхэд гомдол гаргаж болно.

8 дугаар зүйл. Хувийн хамгаалалтын тухай гэрээ

8.1. Хувийн хамгаалалт эрхлэх талаар үйлчлүүлэгч болон хувийн хамгаалалтын байгууллага, бие хамгаалагч бичгээр гэрээ байгуулна.

8.2. Энэ зүйлийн 1-д заасан гэрээ байгуулахдаа Иргэний хуульд заасан нийтлэг журмыг баримтлахаас гадна дор дурдсан зүйлийг гэрээнд тусгана:

8.2.1. цагдаагийн байгууллагаас олгосон тусгай зөвшөөрлийн дугаар, он, сар, өдөр;

8.2.2. хувийн хамгаалалтын төрөл, хэлбэр, гүйцэтгэх ажил, үүрэг, ашиглах техник, тусгай хэрэгсэл;

8.2.3. бие хамгаалагчийн тоо, тэдгээрийн ажиллах нөхцөл, хөдөлмөр хамгаалал;

8.2.4. хамгаалалт явуулах журам;

8.2.5.бие хамгаалагч үүргээ гүйцэтгэх явцад түүнд учирсан гэм хорыг арилгах нөхцөл.

8.3. Энэ зүйлийн 1, 2 дахь хэсэгт заасан нөхцөлийг хангаагүй гэрээг хүчин төгөлдөр бус гэж тооцно.

9 дүгээр зүйл. Хувийн хамгаалалтын үйл ажиллагааны төрөл

9.1. Хувийн хамгаалалт дараахь төрөлтэй байна:

9.1.1.хүний амь бие, эрүүл мэндийг хамгаалах;

9.1.2. хамгаалалтын хэрэгслийн зураг төсөл хийх, үгсрах, ашиглах үйлчилгээ явуулах;

9.1.3. гэмт халдлагаас хамгаалалт хийх асуудлаар үйлчлүүлэгчид хууль зүйн болон мэргэжлийн зөвлөгөө өгөх;

9.1.4. үйлчлүүлэгчээс зохион байгуулж байгаа хурал бусад арга хэмжээг хамгаалалтад авах;

9.1.5. үзвэр, үйлчилгээний арга хэмжээний хамгаалалт.

9.2. Бие хамгаалагч болон хувийн хамгаалалтын хуулийн этгээд нь шүүх, прокурор, цагдаа, татнуул, шүүхийн шийдвэр биелүүлэх зэрэг байгууллагаас бүрэн эрхээ хэрэгжүүлэхэд аливаа саад учруулахыг хориглоно.

9.3. Хувийн хамгаалалтын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авааг иргэн, хуулийн этгээд энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно.

9.4. Хамгаалалтын үйл ажиллагаа явуулж

байгаа бие хамгаалагч болон хуулийн эгтээд нь нийгмийн дэг журмыг сахиулахад туслалцаа үзүүлэх зорилгоор цагдаагийн байгууллагатай гэрээний үндсэн дээр ажилжак болно.

10 дугаар зүйл. Хувийн хамгаалалтын сургалтын агуулга, төлөвлөгөө

10.1 Хувийн хамгаалалтыг биечлэн гүйцэтгэх боловсон хүчнийг бэлтгэх, давтан сургах, мэргэжлийг нь дээшлүүлэх сургалтын агуулга, төлөвлөгөө болон сургалт явуулах эвшээрэл олгох, үйл ажиллагаанд нь хяналт тавих журмыг хууль зүй, дотоод хэргийн болон боловсрол, соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

10.2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан сургалтын үйл ажиллагааг иргэн, хуулийн этгээд эрхлэн явуулж болох бөгөөд түүний үйл ажиллагаанд цагдаагийн байгууллага хяналт тавина.

11 дүгээр зүйл. Бие хамгаалагчид хориглох зүйл

11.1. Бие хамгаалагчид дор дурдсан үйл ажиллагаа явуулахыг хориглоно:

11.1.1.үйлчлүүлэгчийн эвшээрэлгүйгээр түүний тухай мэдээллийг бусдад дамжуулах;

11.1.2. хувийн хамгаалалт эрхлэх эвшээрлийг бусдад шилжүүлэх;

11.1.3. галт зэвсэг ашиглах;

11.1.4. хувийн хамгаалалтыг энэ хуулийн 9.1-д зааснаас бусад төрлөөр явуулах;

11.1.5. нэг бүрийн тусгай хэрэгслийг бусдад шилжүүлэх;

11.1.6. төрийн тусгай хамгаалалт, зэвсэгт хүчин, бусад цэрэг, тагнуул, цагдаагийн харуул хамгаалалтын бүсэд хувийн хамгаалалт явуулах.

12 дугаар зүйл. Нэг бүрийн тусгай хэрэгсэл, мэх хэрэглэх

12.1. Бие хамгаалагчаас тавьсан хууль ёсны шаардлагыг эсэргүүцэнийг хүч хэрэглэхгүйгээр таслан зогсоох боломжгүй, эсхүл үйлчлүүлэгчийн амь бие, эрүүл мэндэд аюул учруулахаар бүлэглэн довтолсон үед зэвсэгүйгээр тулалдах мэх, дараахь нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэж болно:

12.1.1. гав;

12.1.2. хүлэг;

12.1.3. резинэн ба цахилгаан бороохой;

12.1.4.нулимс асгаруулагч, амьсгал боогдуулагчаар цэнэглэсэн буу, шүршүүр;

12.1.5. резинэн ба хуванцар сумтай буу.

12.2. Хүүхэд болон жирэмсэн болох нь илэрхий мэдэгдэж байгаа хүмүүст нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэхийг хориглоно.

12.3. Нэг бүрийн тусгай хэрэгсэл хэрэглэснээс хүний эрүүл мэндэд гэм хор учирсан бол бие хамгаалагч эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх арга хэмжээ авч, холбогдох байгууллага, албан тушаалтанд нэн даруй мэдэгдэнэ.

12.4. Бие хамгаалагч нэг бүрийн тусгай хэрэгсэл, зэвсэгүйгээр тулалдах мэх хэрэглэх, ашиглах зааврыг Улсын ерөнхий прокурор, хууль зүй, дотоод хэргийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

13 дугаар зүйл. Хувийн хамгаалалтын үйл ажиллагаанд тавих хяналт

13.1. Хувийн хамгаалалтын үйл ажиллагаа хууль тогтоомжид нийцэж байгаа эсэхэд цагдаагийн байгууллага хяналт тавина.

13.2. Цагдаагийн байгууллага энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан эрхээ хэрэгжүүлэхдээ зохих баримт бичиг шаардан гаргуулах, тайлбар авах эрхтэй.

14 дүгээр зүйл. Хувийн хамгаалалтын тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

14.1. Хувийн хамгаалалтын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол шүүх түүнд дараахь шийтгэл ногдуулна:

14.1.1. тусгай зөвшөөрөлгүйгээр хувийн хамгаалалтын үйл ажиллагаа эрхэлсэн хувь хүнийг 30000-40000, хуулийн этгээдийг 200000-250000 төгрөгөөр тус тус торгож, хууль бусаар олсон орлого, техник хэрэгслийг хураах;

14.1.2. энэ хуулийн 11.1.1; 11.1.2; 11.1.3; 11.1.5; 11.1.6; 12.2-ыг зөрчсөн гэм буруутай бие хамгаалагчийг 10000-50000, хуулийн этгээдийг 200000-250000 төгрөгөөр торгох.

14.2. Цагдаагийн байгууллагын эрх бүхий ажилтан хууль тогтоомжийг биелүүлэх талаар цагдаагийн байгууллагаас тавьсан шаардлагыг биелүүлээгүй гэж буруутай бие хамгаалагчийг 10000-30000, хуулийн этгээдийг 200000-250000 төгрөгөөр торгох шийтгэл ногдуулна.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 6 дугаар сарын 7-ны өдөр

Улаанбаатар хот

МАЛЫН УДМЫН САН, ЭРҮҮЛ МЭНДИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ

/Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь мал, тэжээвэр амьтны /цаашид "мал" гэх/ удмын сан, эрүүл мэндийг хамгаалахтай холбогдсон харилцаог зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах хууль тогтоомж

2.1. Монгол Улсын малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах хууль тогтоомж нь Үндэсн хууль[1], энэ хууль, тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Хуулийн нэр томъёо

3.1. Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурьдсан утгаар ойлгоно:

3.1.1. "үүлдэр, үүлдрийн болон үржилийн хэсэг" гэж хүний урьдчилан төлөвлөсөн ухамсарт үйл ажиллагаагаар бий болсон, нэг гарал үүсэлтэй, өөр дотор нь үржүүлэхэд тооны хувьд ханталттай, биологи, морфологи, аж ахуйн ашигтай шинжээрээ тухайн төрлийн малын бусад үүлдэр, үүлдрийн болон үржлийн хэсгээс ялгагдах өвөрмөц онцлогтой, үржлийн үнэт чанараа үр төлдөө баттай удамшуулдаг бүлэг малыг;

3.1.2. "цөм сүрэг" гэж тухайн үүлдэр, омог, хэвшлийн малын шилмэл хэсгийн жишиг тэнцэж үржлийн зориулалтаар шилэгдсэн сүргийн зохистой бүтэц бүхий бүлэг малыг;

3.1.3. "гойд ашиг шимт мал" гэж тухайн үүлдэр, омог, хэвшлийн малаас үржил, ашиг шимийн нэг буюу хэд хэдэн чанараар онцгой давуу болох нь баталгаажсан малыг;

3.1.4. "мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээ" гэж малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах зорилгоор хийж байгаа ашиг шим, үржлийн чанарыг сайжруулах, оношлогоо, шинжилгээ, тарилга, туулгалт, боловсруулалт, угаалга, эмчилгээ, мал, тэдгээрийн гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, малын тэжээлд хийж байгаа чанар, ариун цэврийн магадлан шинжилгээ, баталгаажуулалт, орчны эрүүл ахуйн үнэлгээ, мэдээ мэдээлэл, мэргэжлийн зааварчилга, зөвлөгөөг;

3.1.5. "малын өвчинтэй тэмцэх" гэж өвчин үүсгэх шалтгааныг илрүүлэн оношлох, өвчний халдварын хязгаарыг тогтоох, түүнийг таслан зогсоох, шинжлэн хянах, хорио цээрийн арга хэмжээ хэрэгжүүлэх, халдварын эх үүсвэр болж байгаа өвчтэй малыг ялган тусгаарлах, эмчлэх, нядлах болон устгах, халдварын голомтод цэвэрлэгээ, ариутгал, халдваргүйжүүлэлт, шавьж, мэрэгчдийн устгал хийх, нууц халдвар тээгч малыг илрүүлэх лабораторийн шинжилгээ хийх, голомтот болон сэжигтэй бүсэд байгаа малыг урьдчилан сэргийлж зохиомлоор дархлаа үүсгэх, паразитын эсрэг угаалга, туулгалт, боловсруулалт хийх зэрэг арга хэмжээг;

3.1.6. "урьдчилан сэргийлэх" гэж мал өвчний халдвар авах, биед эмгэг явц, хувиралт үүсч, өвчний шинж тэмдэг илрэхээс өмнө зохиомлоор дархлаа үүсгэх, нууц халдвар тээгч малыг илрүүлэх лабораторийн шинжилгээ хийх, өвчин үүсгэх шалтгаан нөхцөлийг зайлуулах, гадаад орчинд үүссэн байж болзошгүй халдварын бохирдлыг ариутган халдваргүйжүүлэх зэрэг үйл ажиллагаа;

3.1.7. "хорио цээр тогтоох" гэж богино хугацаанд тархан дэлгэрч улэмж хохирол учруулдаг өвчин гарсан үед халдварын тархалтыг голомтод нь хязгаарлан зогсоох, устгахад чиглэсэн иж бүрэн арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг;

3.1.8. "гоц халдварт өвчин" гэж улсын хил хязгаараас үл хамааран богино хугацаанд тархаж хүн, малын эрүүл мэндэд хохирол учруулж үндэсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх халдварт өвчнийг;

3.1.9. "өвчтэй болон халдварын голомтод байгаа малыг зайлшгүй шаардлагаар

[1] *Үндэсн хууль- "Ардын эрх" сонин, 1992 оны 1 дүгээр сарын 14-ний өдөр, №9 (313) дугаарт нийтлэгдсэн.*

нядлах, устгах" гэж нийтийн болон тухайн өмчлөгчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор малын халдварт болон гоц халдварт өвчний гаралтыг таслан зогсоох, цаашид тархан дэлгэрэхээс сэргийлэхийн тулд өвчтэй болон халдварын голомтод байгаа халдвар тараах магадлал бүхий малыг холбогдох дүрэм, зааврын дагуу нядлах, устгахыг;

3.1.10. "генийн сан" гэж малын удмын санг хамгаалах буюу үржилд ашиглах зорилгоор нөөцлөн хадгалж байгаа үр, хөврөл үрийг;

3.1.11. "ийлдсийн сан" гэж халдварт өвчин үүсгэгчийн хөдөлгөөнийг олон жилээр харьцуулан хянах зорилгоор Монгол Улсын нутаг дэвсгэрийн бүх хэсэг, малын төрөл, нас, хүйсийг төлөөлүүлэн малаас авч хадгалан жил бүр нөхөн сэлбэж байх цусны ийлдсийн цомгийг.

4 дүгээр зүйл. Төрийн болон нутгийн өөрөө удирдах байгууллагын бүрэн эрх

4.1. Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах асуудлаар Монгол Улсын Их Хурал дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.1.1. малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах төрийн бодлого, эрх зүйн үндсийг тодорхойлох, хэрэгжилтэд нь хяналт тавих;

4.1.2. малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагаа эрхэлдэг иргэн, өмчийн бүх хэлбэрийн хуулийн этгээдийг төрийн санхүү, зээл, татварын бодлогоор дэмжих.

4.2. Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах асуудлаар Засгийн газар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.2.1. малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах төрийн бодлого, хууль тогтоомжийг биелүүлэх цогцолбор арга хэмжээ боловсруулж хэрэгжүүлэх, энэ хуульд заасан зардлыг санхүүжүүлэх;

4.2.2. мал сүргийг байгалийн гамшиг, гэнэтийн бусад аюул, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх, ашиг шим, удамшлын чадавхийг нь сайжруулах арга хэмжээ авах;

4.2.3. төрөл, зүйлийн хувьд мөхөхөд хүрч байгаа малыг тусгайлан хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;

4.2.4. малын өвчинтэй тэмцэхэд шаардлагатай эм, бэлдмэлийн нөөц бий болгох, зарцуулах журам тогтоох;

4.2.5. малаас хүнд халдварлах өвчний үүсгэгчээр үйлдвэрлэл, туршилт явуулдаг байгууллагад хаалттай бүс тогтоох;

4.2.6. Монгол Улсын нутаг дэвсгэрт урьд өмнө нь гарч байгаагүй, нийгэм, эдийн засагт ихээхэн хохирол учруулахуйц өвчин болон оношгүүсгэгч нь тодорхойгүй өвчин гарсан тохиолдолд түүнтэй тэмцэх арга хэмжээ авах;

4.2.7. төрийн өмчийн цөм сүргийн удмын санг хамгаалах.

4.3. Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /цаашид "төрийн захиргааны төв байгууллага" гэх/ дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.3.1. малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэрийн биелэлтийг хангуулах;

4.3.2. мал эмнэлэг, үржлийн албыг бодлогын нэгдсэн удирдамжаар хангах;

4.3.3. шинжлэх ухаан, технологийн төслийг захиалах, хэрэгжилтэд нь хяналт тавих;

4.3.4. мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн болон малын үржлийн ажил, маллагаа, тэжээллэгийн технологийн холбогдолтой дүрэм, журам, норм, нормативыг батлах;

4.3.5. хорио цээр, хязгаарлалт тогтоох болон заавал мэдээлэх малын өвчний жагсаалт батлах;

4.3.6. малын шинэ үүлдэр, үүлдрийн болон үржлийн хэсэг, омог, хэвшил, өвчин үүсгэгчийн омог, эмчилгээний аргыг зохион бүтээсэн тухай асуудлыг хянан баталгаажуулах;

4.3.7. энэ хуулийн 4.3.6-д заасны дагуу баталгаажуулсан болон Монгол Улсад үржүүлж байгаа үүлдэр, үүлдрийн болон үржлийн хэсэг, омог, хэвшлийн малыг бүртгэх, хяналт тавих.

4.4. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.4.1. нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө, хөтөлбөр, төсөл, үйлчилгээний хөлсний норматив, малын өвчинтэй тэмцэхэд шаардлагатай эм, бэлдмэлийн нөөц бий болгох, энэ хуульд заасан болон бусад зардлыг баталж, хэрэгжилт, зарцуулалтад нь хяналт тавих.

4.5. Аймаг, нийслэл, сум, дүүргийн

Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

4.5.1. мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээнд тухайн нутаг дэвсгэр дэх малыг бүрэн хамруулах, ажил, үйлчилгээг гэрээ, захиалгаар гүйцэтгүүлэх;

4.5.2. энэ хуулийн 15.1.2-т заасан үйлчилгээний хэлс, 15.2.2, 15.2.3-т заасан зардал, 15.2.4-т заасан аймаг, нийслэл, сум, дүүргийн хяналтын болон аймаг, нийслэлийн мал эмнэлэг, үржлийн албад, тэдгээрийн дэргэдэх мал эмнэлэг, ариун цэвэр, бүтээгдэхүүний чанарын лабораторийн ажилтны цалин, үйл ажиллагааны зардлыг орон нутгийн төсөвт тусгах, хэрэгжилтэд нь хяналт тавих;

4.5.3. энэ хуулийн 15.1.2, 15.1.3-т заасан өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд хамруулах малын төрөл, тоо, шаардагдах зардлыг нэгтгэн төлөвлөх;

4.5.4. малаас хүнд халдварладаг өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, эрүүлжүүлэх арга хэмжээний хэрэгжилтийг хангуулах;

4.5.5. цөм сүргийг бүрдүүлэх, үржлийн мал бойжуулах, борлуулахад дэмжлэг үзүүлэх, хяналтад авах;

4.5.6. мал эмнэлэг, үржлийн холбогдолтой тайлан мэдээ гаргуулж, хяналт тавих;

4.5.7. малын хорио цээртэй халдварт өвчин гарсан болон гарч болзошгүй нутаг дэвсгэрийн тухай нийтэд зарлан мэдээлэх;

4.5.8. сум, дүүргийн дотор болон тэдгээрийн хоорондох малын шилжилт хөдөлгөөнд хорио цээрийн хяналт тавих арга хэмжээг зохион байгуулах;

4.5.9. байгалийн гамшиг, гэнэтийн аюул, халдварт өвчин зэрэг малд хор хөнөөл учруулах нөхцөл бий болсон үед түүнээс сэргийлэх, гарсан үр дагаврыг арилгахад иргэн, хуулийн этгээдийг дайчлах;

4.5.10. малын өвчинтэй тэмцэхэд шаардлагатай эм, бэлдмэлийн нөөцийг бүрдүүлэх, зарцуулах;

4.5.11. орон нутгийн өмчийн цөм сүргийн удмын санг хамгаалах;

4.5.12. өвчтэй малыг зайлшгүй шаардлагаар нядлах, устгах ажлыг сум, дүүргийн Засаг дарга хариуцан зохион байгуулах бөгөөд энэ хуулийн 14.1.4; 14.1.5; 14.2.1; 14.2.9 –д заасан үүргийн биелэлтийг үндэслэн 15.1.4; 15.2.2-т заасан хөрөнгийг олгох эсэх тухай шийдвэр гаргана.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагаа эрхлэх

5 дугаар зүйл. Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэгч байгууллага

5.1. Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах мэргэжлийн үйл ажиллагааг мал эмнэлэг, үржлийн төв; аймаг, нийслэлийн мал эмнэлэг, үржлийн албад; орон нутгийн үйлчилгээний нэгжүүд; мал эмнэлэг, ариун цэвэр, бүтээгдэхүүний чанарын лаборатори тус тус хэрэгжүүлнэ.

5.2. Мал эмнэлэг, үржлийн төвийг Засгийн газар; аймаг, нийслэлийн мал эмнэлэг, үржлийн албыг холбогдох Засаг дарга байгуулна.

5.3. Сум, дүүрэгт мал эмнэлэг, үржлийн орон нутгийн үйлчилгээний нэгжүүд ажиллана.

5.4. Мал эмнэлэг, үржлийн орон нутгийн үйлчилгээний нэгжүүд нь өмчийн аль ч хэлбэрийн хуулийн этгээд байж болно.

6 дугаар зүйл. Мал эмнэлэг, үржлийн хэрэгжүүлэгч байгууллагын эрх, үүрэг

6.1. Мал эмнэлэг, үржлийн хэрэгжүүлэгч байгууллага нь харъяалах нутаг дэвсгэрийнхээ хэмжээнд дараахь нийтлэг эрх, үүрэгтэй байна:

6.1.1. малын өвчинтэй тэмцэх, сэргийлэх болон үржлийн ажлын талаар жил бүр авах арга хэмжээг төлөвлөх, төсөл боловсруулах, захиалга хэрэгжүүлэх;

6.1.2. мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээний технологийг мөрдөж ажиллах;

6.1.3. мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнд чанар, мал эмнэлэг, ариун цэврийн үзлэг, шинжилгээ хийж, баталгаажуулан гэрчилгээ олгох;

6.1.4. малын өвчний оношийг зохих журмын дагуу тогтоох;

6.1.5. малын удмын сан, эрүүл

мэндийн холбогдолтой мэдээ, судалгаа гаргаж хэрэглэгчдийг мэдээллээр хангах;

6.1.6. мал бүхий иргэн, хуулийн этгээдэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх, шинжлэх ухаан, технологийн ололт нэвтрүүлэх.

6.2. Мал эмнэлэг, үржлийн төв нь энэ хуулийн 6.1 -д зааснаас гадна дараахь эрх, үүрэгтэй байна:

6.2.1. аймаг, нийслэлийн мал эмнэлэг, үржлийн албыг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

6.2.2. мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн болон малын үржлийн ажил, маллагаа, тэжээллэгийн технологийн холбогдолтой журам, заавар, норм, нормативын төсөл боловсруулж төрийн захиргааны төв байгууллагаар хянуулан Хөдөө аж ахуйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүнээр батлуулах;

6.2.3. малын генийн болон илдсийн сан, малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалахтай холбогдол бүхий мэдээллийн төгтолцоо бий болгож ажиллуулах;

6.2.4. малын өвчинтэй тэмцэх, сэргийлэх болон үржлийн ажлын талаар жил бүр авах арга хэмжээний эдийн засгийн тооцоо, эрсдэлийн үнэлгээ хийх;

6.2.5. төрийн захиргааны төв байгууллагын эрх олгосноор гадаад орны мэргэжлийн алба, байгууллагатай мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээний чиглэлээр хамтран ажиллах гэрээ, хэлцэл хийх.

6.3. Аймаг, нийслэлийн мал эмнэлэг, үржлийн алба нь энэ хуулийн 6.1 -д зааснаас гадна дараахь эрх, үүрэгтэй байна:

6.3.1. орон нутгийн үйлчилгээний нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах;

6.3.2. мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээний талаар аймаг, нийслэлийн Засаг даргатай гэрээ байгуулж ажиллах.

6.4. Орон нутгийн үйлчилгээний нэгж нь энэ хуулийн 6.1 -д зааснаас гадна дараахь эрх, үүрэгтэй байна:

6.4.1. орон нутагтаа байнга оршин сууж мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээг эрхлэх;

6.4.2. мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээний талаар сум, дүүргийн Засаг дарга, үйлчлүүлэгч иргэн, хуулийн этгээдтэй гэрээ байгуулж ажиллах;

6.4.3. малын өвчнөөс урьдчилан сэргийлэх шинжилгээ, тарилга, туулгалт, угаалга, боловсруулалт, ариутгал, халдваргүйжүүлэлтийг зохих журмын дагуу хэрэгжүүлэх;

6.4.4. нийт мал сүрэгт үзлэг хийж цем сүрэг, гойд ашиг шимт мал сонгон шалгаруулах, малын чанар сайжруулах, удмын санг хамгаалах;

6.4.5. цем сүрэг, хэзлтүүлэгч, гойд ашиг шимт малыг бүртгэлд авч гэрчилгээ олгон баталгаажуулах;

6.4.6. өвчтэй малыг хяналтад авч тусгаарлах, эмчлэх, шаардлагатай бол хорио цээр тогтоох, нядлуулах, устгуулах үндэслэлээ сум, дүүргийн Засаг даргад уламжлах.

7 дугаар зүйл. Мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээ эрхлэгчид тусгай зөвшөөрөл олгох, түдгэлзүүлэх, хүчингүй болгох

7.1. Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай[1] хуулийн15.11.8-д заасан мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрлийг зориулалтын техник хэрэгсэл, мэргэжлийн боловсон хүчин бүхий иргэн, өмчийн аль ч хэлбэрийн хуулийн этгээдэд олгоно.

7.2. Тусгай зөвшөөрлийг улсын болон бүс нутгийн хэмжээнд мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээ эрхлэх иргэн, хуулийн этгээдэд төрийн захиргааны төв байгууллага, орон нутагт эрхлэх иргэн, хуулийн этгээдэд сум, дүүргийн Засаг дарга тус тус олгоно.

7.3. Тусгай зөвшөөрөл авахад Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 11.1.1 - 11.1.4 дэх хэсэгт зааснаас гадна дараахь баримт бичгийг бүрдүүлнэ:

7.3.1. улсын болон бүс нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах тохиолдолд хяналтын төв албаны, орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулах тохиолдолд аймаг, нийслэлийн хяналтын албаны дүгнэлт.

7.4. Мал эмнэлэг, үржлийн мэргэжлийн ажил, үйлчилгээг малын эмч, мал зүйч гүйцэтгэнэ. Малын эмч нь мэргэжлээрээ ажиллах итгэмжлэлтэй байна.

7.5. Тусгай зөвшөөрөл олгох, түүний хугацааг сунгах, тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох болон тэдгээртэй холбогдон гарсан

[1] *Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай - "Төрийн мэдээлэл"-ийн 2001 оны № 6 дугаарт нийтлэгдсэн.*

маргааныг Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 6.2-6.4 дэх хэсэг, 12, 13, 14, 17 дугаар зүйлд заасны дагуу зохицуулна.

7.6. Энэ хуулийн 7.2 -т заасан тусгай зөвшөөрөл нь олгосон өдрөөс хойш 5 жилийн хугацаанд хүчинтэй байна.

7.7. Энэ хуулийн 7.4-т заасан итгэмжлэлийг төрийн захиргааны төв байгууллагаас томилсон мэргэжлийн баг олгоно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагааны улсын хяналт

8 дугаар зүйл. Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагааны улсын хяналтын байгууллагын тогтолцоо

8.1. Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагааны улсын хяналт /цаашид "улсын хяналт" гэх/ -ын алба /цаашид "хяналтын алба" гэх/ нь төв, орон нутгийн болон тусгай албадаас бүрдэнэ.

8.2. Хяналтын төв албыг Засгийн газар байгуулна.

8.3. Хяналтын орон нутгийн алба нь аймаг, нийслэлийн Засаг даргын дэргэдэх Хяналтын алба, сум, дүүргийн Засаг даргын тамгын газрын бүтцэд ажиллах мал эмнэлгийн болон үржлийн улсын байцаагчаас бүрдэнэ.

8.4. Улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагчийг Төрийн хяналт шалгалтын тухай[1] хуулийн 21 дүгээр зүйлийн 1-6 дахь хэсэгт заасны дагуу томилж, чөлөөлнө.

8.5. Хилийн боомт, гүний хяналтын салбар зэрэг шаардлагатай газар хяналтын тусгай алба ажиллана. Энэхүү тусгай алба нь Хяналтын төв албанд шууд харъяалагдана.

9 дүгээр зүйл. Улсын хяналт, түүний зохион байгуулалт

9.1. Улсын хяналт нь малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах талаар гарсан хууль тогтоомж, түүнд нийцүүлэн гаргасан эрх бүхий байгууллагын шийдвэрийн биелэлт, мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээний технологийн мөрдөлтийг хянан шалгаж, хангуулахад чиглэгдэнэ.

9.2. Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах улсын хяналтыг бүх шатны Засаг дарга зохион байгуулна.

9.3. Улсын хяналтыг улсын хэмжээнд улсын ерөнхий байцаагч, улсын ахлах байцаагч, улсын байцаагч; аймаг, нийслэлд улсын ахлах байцаагч, улсын байцаагч; сум, дүүрэгт болон хилийн боомт, гүний хяналтын салбар зэрэг газарт улсын байцаагч тус тус хэрэгжүүлнэ.

10 дугаар зүйл. Хяналтын албаны эрх, үүрэг

10.1. Хяналтын албаны улсын байцаагч нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 7, 8, 9 дэх хэсэгт заасан бүрэн эрхээс гадна дараахь эрх, үүрэгтэй байна:

10.1.1. мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээний технологийн мөрдөлтөд хяналт тавих;

10.1.2. өвчнөөр тайван бус нутгийн мал, тэдгээрийн байр, хашаа хороо, ус, бэлчээр, өвс тэжээлд болон малын гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүн бэлтгэх, боловсруулах, хадгалах, тээвэрлэх, худалдах явцад мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн үзлэг, шинжилгээ хийлгэсэн эсэхэд шалгалт хийх;

10.1.3. хүний эрүүл мэндэд хор учруулах малын өвчин тараах нь тогтоогдсон малын гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүнийг нийтийн хэрэгцээнд нийлүүлэх, эдгээр зүйлээр үйлдвэрлэл, үйлчилгээ явуулахыг таслан зогсоох, улсын хилээр нэвтрүүлэхийг хориглох, шаардлагатай үед хураах устгуулах буюу халдваргүйжүүлэх арга хэмжээ авахуулах;

10.1.4. мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлагыг хангахгүй байранд малын гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүн, малын тэжээл бэлтгэх, боловсруулах, хадгалахыг хориглох;

10.1.5. малын эм, бэлдмэл, өвчин үүсгэгч омог, үр, хөвөрөл үрийг үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх, худалдах, хэрэглэх явцад хяналт тавих;

10.1.6. халдвар тараах өвчтэй малыг үржилд ашиглахыг хориглох;

10.1.7. мал бүхий иргэн, хуулийн этгээдийн цөм сүрэг, гойд ашиг шимт малыг сонгон шалгаруулж баталгаажуулсан байдалд шалгалт хийх;

10.1.8. цөм сүргийн малын үүлдрийн ашиг шимийн чиглэлийг өөрчлөх, үржлийн мал, түүний үр, хөвөрөл үр, өвчин үүсгэгч омгийг гадаадад

[1] *Төрийн хяналт шалгалтын тухай - "Ардын эрх" сонин, 1995 оны 5 дугаар сарын 9-ний өдөр, №90 (1049) дугаарт нийтлэгдсэн.*

гаргах, гадаадаас авахад тусгай зөвшөөрөл авсан эсэхийг шалгах;

10.1.9. жишигт тэнцээгүй хэзлтүүлэгчийг үржлийн зориулалтаар ашиглах, удам угсаа доройтуулах үйл ажиллагаог хориглох;

10.1.10. цөм сүрэг, хээлтүүлэгч, гойд ашиг шимт малд үржлийн бүртгэл хөтөлж, баяжилт хийсэн байдлыг хянан шалгах;

10.1.11. малын гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүний чанарт хяналт тавих;

10.1.12. мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээ болон малын үр, хөвөрлөн үр, эм, бэлдмэл, мал эмнэлгийн зориулалттай багаж хэрэгсэл, өвчин үүсгэгчийг үргүүлж үржүүлэх үйлдвэрлэл эрхлэх, малын тэжээл үйлдвэрлэх, эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох малын гаралтай түүхий эдээр үйлдвэрлэл явуулах талаар иргэн, хуулийн этгээдээс гаргасан хүсэлтийг хянан үзэж дүгнэлт гаргах;

10.1.13. мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээ болон малын үр, хөвөрлөн үр, эм, бэлдмэл, мал эмнэлгийн зориулалттай багаж хэрэгсэл, өвчин үүсгэгчийг үргүүлж үржүүлэх үйлдвэрлэл эрхлэх, эм, эмнэлгийн хэрэгсэл импортлох тусгай зөвшөөрөл, малын эмчийн мэргэжлийн итгэмжлэлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгуулах үндэслэл, дүгнэлтээ тусгай зөвшөөрөл, итгэмжлэл олгох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлэх.

10.2. Хяналтын төв алба нь Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, энэ хуулийн 11.1 -д зааснаас гадна дараахь эрх, үүрэгтэй байна:

10.2.1. төрийн захиргааны төв байгуулагын эрх олгосноор мал эмнэлэг, үржлийн ажил, ариун цэвэр, хорио цээрийн талаар гадаадын байгуулагатай гэрээ, хэлэлцээр байгуулах;

10.2.2. мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, малын тэжээлийг импортлох эрсдэлийн үнэлгээ хийх;

10.2.3. аймаг, нийслэлийн улсын ахлах байцаагч, улсын байцаагчийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах.

10.3. Улсын хяналтын албаны байцаагч Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан баталгаагаар хангагдана.

10.4. Улсын хяналтын тусгай албаны байцаагч төрийн захиргааны төв байгуулагаас баталсан ялгах тэмдэг, дүрэмт хувцас хэрэглэнэ.

11 дүгээр зүйл. Мал эмнэлгийн хорио цээр тогтоох

11.1. Малын халдварт болон гоц халдварт өвчин гарсан тохиолдолд энэ хуулийн 5.1-д заасан холбогдох байгууллагын дүгнэлтийг үндэслэн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга хорио цээр тогтооно.

11.2. Хоёроос дээш аймгийн нутаг дэвсгэрт болон төмөр зам, нисэх, усан замын буудал, хилийн боомт, улсын чанартай авто болон мал тууврын замд гоц халдварт өвчин гарсан тохиолдолд мал эмнэлэг, үржлийн төвийн дүгнэлтийг үндэслэн Засгийн газар хорио цээр тогтооно.

11.3. Хорио цээр тогтоосон нөхцөлд тухайн шатны Засаг дарга хүн хүч, хөрөнгө гаргаж малын өвчинтэй төмцэх шаардлагатай арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

11.4. Хорио цээр тогтоосон нутаг дэвсгэрээс зайлшгүй шаардлагаар гарах хүн, тээврийн хэрэгсэлд хяналтын албанаас зөвшөөрөл авч, ариутгал, халдваргүйжүүлэлт хийлгэнэ.

11.5. Халдварт өвчний гаралтыг бүрэн таслан зогсоож мал эмнэлэг, ариун цэврийн арга хэмжээ авсны дараа хорио цээрийг түүнийг тогтоосон байгуллага, албан тушаалтны шийдвэрээр цуцална.

12 дугаар зүйл. Улсын хилээр мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн нэвтрүүлэх

12.1. Хилийн боомт буюу хил орчмын сум дахь улсын байцаагч нь мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, малын тэжээл, бусад зүйлээр дамжин мал, хүнд халдварладаг өвчин тус улсын хилээр нэвтрэхээс урьдчилан сэргийлж, зорчин өнгөрөх хөдөлгөөнд хяналт тавина.

12.2. Мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, малын тэжээлийг Монгол Улс, холбогдох орны эрх бүхий байгууллагын хооронд байгуулсан гэрээ, хэлэлцээрт заасан жүрмын дагуу мал эмнэлэг, үржлийн байгуулагад болон тухайн улсын эрх бүхий байгууллагаас олгосон гэрчилгээг үндэслэн улсын хилээр нэвтрүүлнэ.

12.3. Хилийн боомт дахь улсын байцаагч нь гадаад улсаас Монгол Улсад импортолж байгаа мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, малын тэжээлд тухайн улсын эрх бүхий байгууллагаас олгосон гэрчилгээг үндэслэн мал эмнэлэг, ариун

цэврийн импортын гэрчилгээ олгоно.

12.4. Монгол Улсын нутаг дэвсгэрт зэргэлдээ улсаас отроор мал нэвтрүүлэхийг хоёр улсын эрх бүхий байгууллагын хооронд байгуулсан хэлэлцээр, төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлийг үндэслэн хязгалтын төв албаны улсын байцаагч гаалийн болон хилийн хязгалтын байгууллагын эрх бүхий албан тушаалтныг байлцуулан шийдвэрлэнэ.

12.5. Гэрчилгээтэй боловч тээвэрлэлт, тууварлалтын явцад халдварт өвчний шинж тэмдэг илэрсэн мал, гэмтэж муудсан түүхий эд, бүтээгдэхүүн, малын тэжээлийг улсын хилээр нэвтрүүлэхийг хоригломо.

12.6. Энэ хуулийн 12.5-д заасан мал, гэмтэж муудсан түүхий эд, бүтээгдэхүүн, малын тэжээлд нэмэлт үзлэг, шинжилгээ хийлгэх зорилгоор 21 хүртэл хоног хил дээр саатуулах, бүрэн буюу тодорхой хэсгийг нь устгуулах замаар шийдвэрлэнэ.

12.7. Энэ хуулийн 12.5, 12.6-д хэсэгт заасан мал, гэмтэж муудсан бүтээгдэхүүнийг хилээр нэвтрүүлэхэд хянах, устгах журмыг төрийн захиргааны төв байгууллага батлана.

12.8. Хил орчмын нутагт малын гоц халдварт өвчин гарах үед хязгалтын төв албаны дүгнэлтийг үндэслэн хилийн гарцыг Засгийн газрын шийдвэрээр тодорхой хугацаанд хаах хүртэл арга хэмжээ авна.

12.9. Малын эрүүл мэндийн олон улсын байгууллагаас тогтоосон "А" жагсаалтын өвчний халдварын голомт бүхий улс, бүс нутгаас Монгол Улсад мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, малын тэжээл импортлох асуудлыг энэ хуулийн 10.2.2-т заасан эрсдэлийн үнэлгээг үндэслэн шийдвэрлэнэ.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах талаар иргэн, хуулийн этгээдийн эрх, үүрэг

13 дугаар зүйл. Иргэн, хуулийн этгээдийн эрх

13.1. Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах талаар иргэн, хуулийн этгээд дараахь эрх эдэлнэ:

13.1.1. мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээ хууль тогтоомжийн дагуу эрхлэх;

13.1.2. мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээ хийлгэх, үйлчлүүлэх албаа сонгох;

13.1.3. гойд ашиг шимт мал болон цөм сүргээс үржлийн мал бойжуулах, үр, хөврөл үр үйлдвэрлэх, худалдан борлуулах;

13.1.4. малаа зайлшгүй шаардлагаар нядлуулсан, устгуулснаас учирсан хохирлын асуудлыг сум, дүүргийн Засаг даргад тавьж шийдвэрлүүлэх;

13.1.5. шүүхээр мал эмнэлгийн асуудлаар магадлан шинжилгээ хийлгэх.

14 дүгээр зүйл. Иргэн, хуулийн этгээдийн үүрэг

14.1. Иргэн, хуулийн этгээд дараахь нийтлэг үүрэг хүлээнэ:

14.1.1. малыг нядлах, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, малын тэжээл бэлтгэх, боловсруулах ажлыг ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангасан байр, агуулах, орчинд хийж гүйцэтгэх;

14.1.2. мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүн, малын тэжээлийг аймаг, нийслэл, сумын нутаг дэвсгэрээс нөгөөд шилжүүлэх, нийтийн хэрэгцээнд нийлүүлэх, тээвэрлэх, хүлээн авах, улсын хилээр нэвтрүүлэхэд мал эмнэлэг, ариун цэврийн үзлэг, шинжилгээ хийлгэж гэрчилгээ авах;

14.1.3. мал эмнэлгийн хорио цээрийн дэглэмийг биелүүлэх;

14.1.4. малын өвчинтэй тэмцэх, удмын сан хамгаалах ажлыг зохион байгуулахад төрийн захиргааны төв байгууллага, эрх бүхий бусад байгууллагаас гаргасан шийдвэр, дүрэм, журмыг биелүүлэх;

14.1.5. малд халдварт өвчний шинж тэмдэг илэрсэн, гэнэт олноор хорогдсон тохиолдолд орон нутгийн үйлчилгээний нэгж, баг, хороонд удирдлагад 12 цагийн дотор мэдэгдэх.

14.2. Мал бүхий иргэн, хуулийн этгээд дараахь үүрэг хүлээнэ:

14.2.1. мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээнд малыг тогтоосон хугацаанд нь бүрэн хамруулах;

14.2.2. малын байр, орчны ариун

цэвэр, эрүүл ахуй, арчилгаа, маллагаа, тэжээллэг, эдэлгээ нь технологийн шаардлага хангасан байх;

14.2.3. малынхаа ашиг шим, үүлдэрлэг байдлыг сайжруулах;

14.2.4. эрүүл мал, баталгаажуулсан хээлтүүлэгчийг үржилд ашиглах;

14.2.5. цөм сүргийн болон гойд ашиг шимт малд тэнцэх тэмдэг, дугаар тавьж, үржлийн малын удмын бүртгэл хөтлөх;

14.2.6. сүрэг сэлбэх өсвөр хээлтүүлэгчийг цөм сүргээс бойжуулж, орон нутгийн үйлчилгээний нэгжээр үзлэг, шинжилгээ хийлгэж, магадлагаа авсны дараа үржилд ашиглах, хээлтүүлгийн нас гүйцсэн малыг нийлүүлэгт оруулах;

14.2.7. цөм сүргийн малын үүлдрийн ашиг шимийн чиглэлийг өөрчлөх, үржлийн мал, түүний үр, хөврөл үр, өвчин үүсгэгч омгийг гадаадад гаргах, гадаадаас авахдаа хяналтын төв албанаас зөвшөөрөл авах;

14.2.8. зайлшгүй шаардлагаар хэрэгжүүлэх арга хэмжээнд малаа тогтоосон хугацаанд нь хамруулаагүйгээс учирсан хохирол, энэ шалтгааны улмаас уг арга хэмжээг нөхөн авч хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг хариуцах;

14.2.9. малаа байгалийн гамшгаас хамгаалах таатай нөхцөл бүрдүүлэх.

ТАВДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

15 дугаар зүйл. Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах үйл ажиллагааны санхүүжилт

15.1. Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалахтай холбоотой дараахь зардлыг улсын төвлөрсөн төсвөөс санхүүжүүлнэ:

15.1.1. малын эрүүл мэндийн олон улсын байгууллагаас тогтоосон "А" жагсаалтын өвчинтэй тэмцэх арга хэмжээнд шаардагдах хөрөнгө;

15.1.2. малын боом, галзуу, брүцеллёз, сальмонеллёз, цусан халдвар, сүрьеэ, лейкоз, томуу, цусан суулга, листериоз, үхрийн дуут хавдар, хорт салст халуурал, эфемер чичрэг, адууны ям, халдварт цус багадах, уушиг гялтангийн хавьталт халдварт үрэвсэл, сахуу, бог малын дотрын халдварт хордлого, энтеробактериоз, брадзот, сохор догол, шөвөг яр, колибактериоз, ямааны годрон, гахайн ёлом өвчнүүдээс урьдчилан сэргийлэх, оношлоход шаардагдах эм, биобэлдмэлийн үнэ;

15.1.3. малын цусны шимэгчээр үүсдэг өвчин, хамуу, шимэгч хорхойтох өвчнөөс сэргийлэхэд хэрэглэх эмийн үнэ;

15.1.4. өвчтэй малыг зайлшгүй шаардлагаар устгасан тохиолдолд тухайн үеийн улсын дундаж үнийн 90 хувийг нөхөн төлөх, устгахад шаардагдах хөрөнгө;

15.1.5. малын генийн болон ийлдсийн санг бий болгож ажиллуулахад шаардагдах зардал;

15.1.6. энэ хуулийн 4.2.3, 4.2.6-д заасан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах зардал;

15.1.7. мал эмнэлэг, үржлийн төв болон хяналтын байгууллага, тэдгээрийн дэргэдэх мал эмнэлэг, ариун цэвэр, бүтээгдэхүүний чанарын лабораторийн ажилтны цалин, үйл ажиллагааны зардал.

15.2. Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалахтай холбогдон дараахь зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ:

15.2.1. энэ хуулийн 15.1.2-т заасан өвчнөөс урьдчилан сэргийлэх, оношлоход шаардагдах үйлчилгээний хөлс;

15.2.2. өвчтэй малыг зайлшгүй шаардлагаар нядлуулсан тохиолдолд орон нутгийн дундаж үнийн 40 хувийг нөхөн төлөхөд шаардагдах хөрөнгө;

15.2.3. цөм сүргийн малын удмын санг хамгаалах, аж ахуй, биологийн ашигтай шинж чанарыг нь бататган сайжруулах, малд явуулсан үржил селекцийн ажлын үр дүнг хянан магадлахад шаардагдах зардал;

15.2.4. аймаг, нийслэл, сум, дүүргийн хяналтын улсын байцаагч, аймаг, нийслэлийн мал эмнэлэг, үржлийн албаа, тэдгээрийн дэргэдэх мал эмнэлэг, ариун цэвэр, бүтээгдэхүүний чанарын лабораторийн ажилтны цалин, үйл ажиллагааны зардал.

15.3. Энэ хуулийн 15.1, 15.2-т зааснаас бусад тохиолдолд мал эмнэлэг, үржлийн ажил, үйлчилгээний төлбөрийг ажил, үйлчилгээг хэрэглэгч

иргэн, хуулийн этгээд хариуцна.

16 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

16.1. Малын удмын сан, эрүүл мэндийг хамгаалах хууль тогтоомж зөрчсөн этгээдэд түүний гэм бүруу, зөрчлийн шинж байдал, учруулсан хохирлын хэмжээг харгалзан эрүүгийн болон захиргааны хариуцлага хүлээлгэнэ.

16.2. Энэ хуулийн дор дурдсан заалтыг зөрчсөн этгээдэд улсын байцаагч дараахь захиргааны шийтгэл ногдуулна:

16.2.1. энэ хуулийн 6.1.3; 6.4.2; 14.2.4; 14.2.5-ыг зөрчсөн иргэн, албан тушаалтныг 10000, хуулийн этгээдийг 80000 хүртэл төгрөгөөр торгох;

16.2.2. энэ хуулийн 14.2.6; 14.2.8-ыг зөрчсөн иргэн, албан тушаалтныг 20000, хуулийн этгээдийг 150000 хүртэл төгрөгөөр торгох;

16.2.3. энэ хуулийн 14.1.5; 14.2.1-ийг зөрчсөн иргэн, албан тушаалтныг 50000 хүртэл, хуулийн этгээдийг 50000-80000 төгрөгөөр торгох;

16.2.4. энэ хуулийн 14.2.7-г зөрчсөн иргэн, албан тушаалтныг 20000, хуулийн этгээдийг 150000 хүртэл төгрөгөөр торгох;

16.2.5. энэ хуулийн 14.1.2-ыг зөрчсөн иргэн, албан тушаалтныг 5000-50000, хуулийн этгээдийг 50000-200000 төгрөгөөр торгох;

16.2.6. энэ хуулийн 14.1.1; 14.1.3; 14.1.4; 14.2.2-ыг зөрчсөн иргэн, албан тушаалтныг 50000, хуулийн этгээдийг 250000 хүртэл төгрөгөөр торгох;

16.2.7. энэ хуулийн 4.5.1; 6.1.1; 6.1.2; 6.1.5; 6.4.3; 6.4.6-г зөрчсөн иргэн, албан тушаалтныг 50000 хүртэл, хуулийн этгээдийг 20000-250000 төгрөгөөр торгох.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 6 дугаар сарын 8-ны өдөр **Улаанбаатар хот**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧӨӨР СОНГОГДСОН ГЭЖ ҮЗЭЖ БҮРЭН ЭРХИЙГ НЬ ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ

Нэгдүгээр зүйл. Монгол Улсын Үндсэн хуулийн гучин нэгдүгээр зүйлийн 4 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн хуулийн 13 дугаар зүйл, Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн хуулийн 41 дүгээр зүйлийн 2, 3, 4 дэх хэсэгт заасныг үндэслэн Нацагийн Багабандийг Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 6 дугаар сарын 8-ны өдөр **Улаанбаатар хот**

СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

Нийтлэг үндэслэл

1 дүгээр зүйл. Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь соёлын өвийг эрэн сурвалжлах, бүртгэх, судалж шинжлэх, зэрэглэл тогтоох, үнэлэх, хадгалж, хамгаалах, сурталчлах, сэргээн засварлах, өвлүүлэн уламжлуулах, өмчлөх, эзэмших, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл. Соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомж

2.1. Соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомж нь энэ хууль болон түүнтэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

2.2. Монгол Улсын олон улсын гэрээнд энэ хуульд зааснаас өөрөөр заасан бол олон улсын гэрээний заалтыг дагаж мөрдөнө.

3 дугаар зүйл. Түүх, соёлын дурсгалт зүйл

3.1. Түүхэн тодорхой орон зай, цаг үеийн аль нэг хэсгийг төлөөлж чадах түүх, соёл, шинжлэх ухааны ач холбогдол бүхий дараахь эд өлгийн зүйлийг өмчийн хэлбэр харгалзахгүйгээр түүх, соёлын дурсгалт зүйлд хамаарууна:

3.1.1. эртний хүний горомж, отог

бууц, оршин сууж байсан ул мөрийг хадгалсан соёлт давхарга, ашигт малтмал олборлож, боловсруулж, үйлдвэрлэл эрхэлж байсан газар, булш хиргисүүр, хөрсөн доорх шороон булш, нуущлагдсан бунхан, хадны агуй, хөмөг дэх оршуулга, тахилгын газар, бүх төрөл, хэлбэрийн хөшөө чулуу, хадны сүг зураг, бичээс зэрэг археологийн дурсгал;

3.1.2. эртний хот суурины үлдэгдэл, балгас, хэрэм, цайз болон уран барилгын цогцолбор, сүм дуган, хийд, гудамж, талбай, байшин барилга зэрэг уран барилгын дурсгал;

3.1.3. угсаатны хувцас, чимэглэл, гэр болон аж ахуйн тоног хэрэгсэл, хөдөлмөрийн багаж зэвсэг, хөгжмийн зэмсэг, түүнчлэн уламжлалт тоглоом наадам, шашин шүтлэгтэй холбогдолтой эд өлгийн зүйл;

3.1.4. сурвалж бичиг, гар бичмэл, барын болон хэвлэмэл ном судар зэрэг бичгийн дурсгал, гэрэл зураг, кино, дүрс бичлэг;

3.1.5. уран зураг, уран баримал, хөөмөл, цутгамал, сийлбэр, зэгэт наамал, хатгамал, цаасан шуумал, шавар болон вааран эдлэл зэрэг дүрслэх урлагийн бүх төрлийн бүтээл;

3.1.6. түүхэн хүмүүсийн амьдрал, үйл ажиллагаатай холбоотой байшин барилга, эд өлгийн зүйл, баримт бичиг;

3.1.7. түүх, соёлын дурсгалт газар;

3.1.8. эртний хүний болон сөнөсөн амьтан, ургамал, бичил биетний бүх төрлийн олдвор;

3.1.9. эрдэс, үнэт чулууны ховор олдвор;

3.1.10. эд өлгийн бусад зүйл.

4 дүгээр зүйл. Утга соёлын өв

4.1. Ард түмний билэг авъяас, мэдлэг, туршлага, эрдэм ухаан, ур чадварын тодорхой илэрхийлэл болон биет бусаар өвлөгдөн уламжлагдаж ирсэн түүх, угсаатны судлал, ардын билэг, зан үйл, ур хийц, арга барил, үрлаг, шинжлэх ухааны ач холбогдол бүхий дараахь оюуны соёлын үнэт зүйлийг утга соёлын өвд хамааруулна:

4.1.1. эх хэл, бичиг, түүний хүрээний соёл;

4.1.2. аман зохиол;

4.1.3. ардын уртын болон богино дуу, тууль, тэдгээрийг дуулах, хайлах арга барил;

4.1.4. хөдөлмөр, зан үйлийн холбогдолтой уриа дуудлага;

4.1.5. хөөмий, исгэрээ, аман болон тагнай ташилт зэрэг өгүүлэхийн эрхтний шүтэлцээт урлаг, тэдгээрийг илэрхийлэх арга барил;

4.1.6. үндэсний хөгжмийн зэмсгийг урлах,хөгжимдөх, аялгуу тэмдэглэх арга барил;

4.1.7. ардын уламжлалт бүжиг, бий, биелгээ;

4.1.8. уран нугаралт болон циркийн үзүүлбэрийг илэрхийлэх гоц авъяастны ур чадварын арга барил;

4.1.9. ардын гар урлалын дэг сургууль;

4.1.10. ардын ёс заншил, зан үйлийн уламжлал;

4.1.11. эрдэм ухааны уламжлал;

4.1.12. ардын бэлгэдэх ёсны уламжлал.

5 дугаар зүйл. Түүх, соёлын дурсгалт зүйлийн зэрэглэл, үнэлгээ

5.1. Түүх, соёлын дурсгалт зүйлийг түүх, соёл, шинжлэх ухааны ач холбогдлоор нь хосгүй үнэт, үнэт, ердийн гэж зэрэглэнэ.

5.2. Түүх, соёлын дурсгалт зүйлийн зэрэглэл, үнэлгээг холбогдох эрдэм шинжилгээний байгууллагын саналыг үндэслэн соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх мэргэжлийн зөвлөл тодорхойлно.

5.3. Түүх, соёлын дурсгалт зүйлийн зэрэглэлийг тодорхойлох мэргэжлийн зөвлөлийн бүрэлдэхүүн, ажиллах журмыг соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

5.4. Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн жагсаалт түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санал болгосноор Засгийн газар батална.

5.5. Түүх, соёлын үнэт дурсгалт зүйлийн болон утга соёлын өвийг ур чадварын өндөр түвшинд өвлөсөн билэг авъяастны жагсаалт, түүнд оруулах нэмэлт, өөрчлөлтийг мэргэжлийн зөвлөлийн санал болгосноор, соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална.

5.6. Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зарим зүйлийг "Дэлхийн соёлын өвийн жагсаалт"-д хамааруулах асуудлыг зохих журмын дагуу шийдвэрлүүлэх үүргийг соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хүлээнэ.

ХОЁРДУГААР БҮЛЭГ

Соёлын өвийн улсын бүртгэл-мэдээллийн сан

6 дугаар зүйл. Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн сангийн тогтолцоо

6.1. Соёлын өвийн улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн сан /цаашид "бүртгэл-мэдээллийн сан" гэх/ нь дараахь тогтолцоотой байна:

6.1.1. соёлын өвийг хадгалж байгаа байгууллага дахь бүртгэл-мэдээллийн сан;

6.1.2. аймаг, нийслэлийн бүртгэл-мэдээллийн сан;

6.1.3. улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн сан.

6.2. Аймаг, нийслэлийн соёлын өвийн бүртгэл-мэдээллийн сан нь Засаг даргын тамгын газарт, улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн сан нь соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэд тус тус байна.

7 дугаар зүйл. Бүртгэл-мэдээллийн сангийн бүрдэл

7.1. Бүртгэл-мэдээллийн сан нь тухайн түүх, соёлын дурсгалт болон оюуны соёлын үнэт зүйлийн тодорхойлолт, судалгаа шинжилгээний ажлын тайлан, гэрэл зураг, слайд, дуу болон дүрс бичлэгтэй хальс ба цахим зээрэнцэг, сэргээн засварлах ажлын товч тайлан зэргээс бүрдэнэ.

7.2.Бүртгэл-мэдээллийн сан нь тухайн түүх, соёлын дурсгалт зүйлийн зэрэглэлийг тодорхойлох, хадгалж хамгаалах, өвлүүлэх, түүнчлэн түүх, соёлын дурсгалт зүйл эвдэрч гэмтсэн, утга соёлын өв нь устсан, мартагдсан, тохиолдолд тэдгээрийг сэргээхэд шаардагдах бүрэн мэдээллийг агуулсан байвал зохино.

8 дугаар зүйл. Соёлын өвийг бүртгэх

8.1.Төрийн өмчлөлд байгаа түүх, соёлын дурсгалт зүйлийг бүртгэл-мэдээллийн санд заавал бүртгэнэ.

8.2.Хувийн өмчлөлд байгаа түүх, соёлын дурсгалт зүйлийг өмчлөгчийн хүсэлтийг үндэслэн бүртгэл-мэдээллийн санд бүртгэнэ.

9 дүгээр зүйл.Соёлын өвийг сурвалжлан олох, судалж шинжлэх

9.1. Түүх, соёлын дурсгалт зүйлийг сурвалжлан олох, судалж шинжлэх ажлыг холбогдох журмын дагуу мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллага эрхлэн явуулна.

9.2. Утга соёлын өвийг сурвалжлан олох, судалж шинжлэх ажлыг холбогдох журмын дагуу мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллага, иргэн эрхлэн явуулна.

9.3.Соёлын өвийг сурвалжлан олох, судалгаа шинжилгээ хийх журмыг соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлана.

8.3.Түүх, соёлын дурсгалт зүйлийн бүртгэлийг өмчлөгчийн хүсэлтээр нууцлах хадгалж болно.

8.4. Соёлын өвийг бүртгэл-мэдээллийн санд бүртгэх ажлыг аймаг, нийслэлийн Засаг дарга зохион байгуулна.

8.5. Бүртгэл-мэдээллийн санг бүрдүүлэх, соёлын өвийг үг санд бүртгэх журмыг соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

8.6. Түүх, соёлын хосгүй үнэт зүйлийн гэрчилгээг энэ хуулийн 5.4-т, утга соёлын өвийг өвлөсөн билэг авъяастны гэрчилгээг энэ хуулийн 5.5.-д заасан жагсаалтыг батлагдсан өдрөөс хойш 30 хоногийн дотор өмчлөгч, өзэмшигч болон авъяастанд олгоно.

8.7. Улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд бүртгэгдсэн түүх, соёлын дурсгалт зүйлийн тооллогыг 4 жил тутам соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага зохион байгуулна. Тооллого явуулах журмыг Засгийн газар тогтооно.

8.8. Аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн орон нутгийн түүх, соёлын дурсгалт зүйлийг хадгалж байгаа байгууллага дахь бүртгэл-мэдээллийн сангийн баяжуулалт, бүрдэлтэд хяналт тавьж судалгаа, тайлан, мэдээллийг зохих журмын дагуу улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд гаргана.

8.9. Хуульд өөрөөр заагаагүй бол түүх, соёлын дурсгалт зүйлийг олж илрүүлсэн этгээд энэ тухай холбогдох сум, дүүргийн Засаг даргын тамгын газарт 7 хоногийн дотор мэдэгдэнэ.

8.10. Монгол Улсын түүх, соёлтой холбогдох зүйлийг гадаадын байгууллага, иргэн, харъяалалгүй хүн өөрийн санаачилгаар өгсөн тохиолдолд түүнийг бүртгэх, үнэлэх журмыг соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

ГУРАВДУГААР БҮЛЭГ

Соёлын өвийг сурвалжлан олох, судалж шинжлэх, сурталчлах, ашиглах

ухааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

9.4. Төрийн өмчлөлд байгаа түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлд соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрснөөр холбогдох мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллага гэрээний үндэсэн дээр судалгаа, шинжилгээ хийж болно.

9.5. Мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллага хайгуул, судалгаа шинжилгээний ажил гүйцэтгэх явцдаа олж илрүүлсэн түүх, соёлын дурсгалт зүйлээ цаашид нарийвчлан судлах тохиолдолд давуу эрх эдэлнэ.

9.6.Соёлын өвийн судалгаа, шинжилгээний ажлын товч тайланг аймаг, нийслэлийн бүртгэл-мэдээллийн санд хадгалуулна.

9.7. Соёлын өвийн судалгаа, шинжилгээний ажлын нэгдсэн мэдээллийг соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жил бүр гаргаж улсын нэгдсэн бүртгэл-мэдээллийн санд хадгална.

10 дугаар зүйл. Соёлын өвийг сурталчлах, ашиглах

10.1. Төрийн өмчлөлд байгаа түүх, соёлын дурсгалт зүйлийг сурталчлах, судалгаа, шинжилгээ, сургалт явуулах зориулалтаар ашиглана.

10.2. Бүртгэл-мэдээллийн сан болон музей, номын сан зэрэг газарт хадгалагдаж байгаа соёлын өвийг сурталчлах, судалгаа шинжилгээ, сургалт явуулах зориулалтаар ашиглахдаа гэмтээх, үрэгдүүлэхийг хориглоно.

10.3. Төрийн өмчлөлд байгаа түүх, соёлын дурсгалт зүйлийг язгуур зориулалтаар ашиглахыг хориглоно. Энэ заалт түүх, соёлын дурсгалт зүйлд хамаарах барилга байшинд хамаарахгүй.

10.4. Сүм хийд шашин-номын үйл ажиллагаагаа эрхлэн явуулахад нь шаардлагатай музей, номын сан дахь түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг Төр, сүм хийдийн харилцааны тухай[1] хуулийн 11 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу хэрэглэх асуудлыг соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын санал болгосноор Засгийн газар шийдвэрлэнэ.

10.5. Түүх, соёлын дурсгалт зүйлийг хувилан олшруулах, загвараар нь бэлэг дурсгалын зүйл бэлтгэх, кино, дүрс бичлэг, гэрэл зураг авах, марк, ил захидал, цомог хийх жүрмыг Засгийн газар тогтооно.

10.6. Соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл түүний зөвшөөрснөөр эрх бүхий соёлын байгууллага бүртгэл-мэдээллийн сан бүртгэгдсэн соёлын өвийг өмчлөгч, үзэмшигчтэй нь гэрээ байгуулсны үндсэн дээр түр хугацаагаар дотоод, гадаадын үзэсгэлэнд тавьж, тогполтод хамруулж болно. Гэрээнд уг зүйлийг ашиглах нөхцөл, хугацаа, үнэ, даатгалын хэмжээ, өмчлөгч буюу үзэмшигчид төлөх хөлс, ашиглагч этгээдийн хүлээх хариуцлага, хамгаалалтын баталгаа зэрэг үндсэн болзлыг тусгана.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ

Түүх, соёлын дурсгалт зүйлийн хайгуул, малтлага, судалгаа

11 дүгээр зүйл. Хайгуул, малтлага, судалгааны ажлын үндсэн чиглэл, тэдгээрийг эрхлэн явуулах байгууллага

11.1. Түүх, соёлын дурсгалт зүйлийн хайгуул, малтлага, судалгааны ажил нь эрдэм шинжилгээний болон авран хамгаалах үндсэн чиглэлтэй байна.

11.2. Түүх, соёлын дурсгалт зүйлийн хайгуул, малтлага, судалгааг зөвхөн мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллага эрхлэн явуулна.

11.3. Түүх, соёлын дурсгалт зүйлийн хайгуул, малтлага, судалгаа хийх зөвшөөрлийг соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас тогтоосон мэргэжлийн эрдэм шинжилгээний байгууллага олгоно.

11.4. Түүх, соёлын дурсгалт зүйлийн малтлага, судалгаа хийх байгууллага ажлаа эхлэхдээ тухайн сум, дүүргийн Засаг даргад заавал мэдэгдэх, малтлага, судалгааныхаа зорилго, ач холбогдлын талаар танилцуулах үүрэг хүлээнэ.

11.5. Газар өмчлөгч, үзэмшигч нь энэ хуулийн 11.3 -т заасан зөвшөөрлийг үндэслэн түүх, соёлын дурсгалт зүйлийн хайгуул, малтлага, судалгаа хийх байгууллагад зориулалт бүхий газар олгоно.

11.6. Түүх, соёлын дурсгалт зүйлийн судалгаа шинжилгээний ажлын дэлгэрэнгүй тайланг 2 хувь үйлдэж, зөвшөөрөл олгосон мэргэжлийн эрдэм шинжилгээний болон малтлага явуулсан байгууллагад тус тус хадгална. Тайлан бүрэн эхээрээ хэвлэлд нийтлэгдээгүй тохиолдолд түүнийг ашиглах асуудлыг Зохиогчийн эрхийн тухай[2] хуулийн дагуу шийдвэрлэнэ.

11.7. Монгол Улсын хууль тогтоомжоор хориглоогүй бол түүх, соёлын дурсгалт зүйлийн хайгуул, малтлага, судалгаа гадаадын эрдэм шинжилгээний байгууллага, эрдэмтэдтэй хамтран гүйцэтгэж болно.

12 дугаар зүйл. Түүх, соёлын дурсгалт зүйлийн хайгуул, малтлага

12.1. Түүх, соёлын дурсгалт зүйлийн хайгуул, малтлагыг соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний тогтоосон жүрмын дагуу хийнэ.

12.2. Түүх, соёлын дурсгалт зүйлийн хайгуул, малтлага хийхэд геологийн ховор илэрц, эрдэсжилтийн онцгой тогтоц, усны эх, рашаан булаг, бурд зэрэг байгалийн унаган тогтоц, эмзэг хэсийг гэмтээхийг хориглоно.

12.3. Түүх, соёлын дурсгалт зүйлийн хайгуул, малтлагын ажил дууссаны дараа малтлага явуулсан газрыг ашул осолгүй болгон засаж, хамгаалалтад авна. Түүх, соёлын дурсгалт зүйлийн хайгуул, малтлага явуулсан тухай товч мэдээллийн хамт уг газрыг тухайн сум, дүүргийн Засаг даргад хүлээлгэн өгнө.

[1] *Төр, сүм хийдийн харилцааны тухай-"Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1993 оны № 6-7 дугаарт нийтлэгдсэн.*

[2] *Зохиогчийн эрхийн тухай- "Төрийн мэдээлэл" сэтгүүлийн 1993 оны № 4-5 дугаарт нийтлэгдсэн*

13 дугаар зүйл. Түүх, соёлын олдвор

13.1. Түүх, соёл, шинжлэх ухааны ач холбогдол бүхий үнэт зүйл оршин байгаа нутаг дэвсгэр, газрын хэвлий нь төрийн өмч мөн.

13.2. Эрдэм шинжилгээний хайгуул, малтлага, судалгааны ажлын явцад илрүүлсэн түүх, соёлын олдворыг илэрсэн өдрөөс хойш 1 жилийн дотор тухайн аймаг, нийслэлийн бүртгэл-мэдээллийн санд бүртгүүлнэ.

13.3. Түүх, соёлын олдворыг цаашид нарийвчлан судлах шаардлагатай нь тогтоогдвол энэхүү олдворын урьдчилсан тодорхойлолт, тайлбарыг тухайн аймаг, нийслэлийн бүртгэл-мэдээллийн санд өгч, олдворыг нарийвчлан судалгаа шинжилгээ хийх байгууллагад хүлээлгэн өгнө.

13.4. Нарийвчлан судалгаа, шинжилгээ хийсэн олдвор нь:

13.4.1. түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлд тодорхойлогдвол уг олдворыг эрдэнэсийн сан, улсын музейд;

13.4.2. түүх, соёлын үнэт болон ердийн дурсгалт зүйлд тодорхойлогдвол уг олдворыг судалгаа шинжилгээ хийсэн эрдэм шинжилгээний байгууллагын сан хөмрөг, улсын болон аймгийн музейд тус тус шилжүүлнэ.

ТАВДУГААР БҮЛЭГ

Түүх, соёлын дурсгалт зүйлийг өмчлөгч, эзэмшигчийн эрх, үүрэг

14 дүгээр зүйл. Түүх, соёлын дурсгалт зүйлийг өмчлөгчийн эрх, үүрэг

14.1. Түүх, соёлын дурсгалт зүйлийг өмчлөгч иргэн нь дараахь эрх эдэлнэ:

14.1.1. түүх, соёлын дурсгалт зүйлийг язгуур зориулалтаар ашиглах;

14.1.2. бүртгэл-мэдээллийн санд бүртгэгдсэн түүх, соёлын дурсгалт зүйлээ нийтэд дэлгэн үзүүлэх, сурталчлах, үзэсгэлэнд тавих, түүнээс олсон орлогоос авах;

14.1.3. түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйлийг хадгалж, хамгаалах, зайлшгүй сэргээн засварлах шаардлагатай тохиолдолд тогтоосон журмын дагуу улсаас санхүүгийн дэмжлэг авах.

14.2. Түүх, соёлын дурсгалт зүйлийг өмчлөгч иргэн нь дараахь үүрэг хүлээнэ:

14.2.1. түүх, соёлын дурсгалт зүйлийг аймаг, нийслэлийн бүртгэл-мэдээллийн санд бүртүүлэх;

14.2.2. бүртгэл-мэдээллийн санд бүртгэгдсэн түүх, соёлын үнэт дурсгалт зүйлийг худалдах, бэлэглэх, өвлүүлэх зэргээр өмчлөх эрхээ бусдад шилжүүлсэн тохиолдолд энэ тухайгаа аймаг, нийслэлийн бүртгэл-мэдээллийн санд мэдэгдэх;

14.2.3. түүх, соёлын дурсгалт зүйлийг хил нэвтрүүлэхэд энэ хуулийн 20.2, 20.3-т заасны дагуу зөвшөөрөл авах;

14.2.4. бүртгэл-мэдээллийн санд бүртгэгдсэн түүх, соёлын дурсгалт зүйл нь алдагдсан, үрэгдсэн тохиолдолд нэн даруй, боломжгүй бол энэ тухай мэдсэнээс хойш 7 хоногийн дотор тухайн аймаг, нийслэлийн Засаг дарга, цагдаагийн байгууллагад мэдэгдэх.

15 дугаар зүйл. Төрийн өмчлөлд байгаа түүх, соёлын дурсгалт зүйлийг эзэмшигчийн эрх, үүрэг

15.1. Түүх, соёлын дурсгалт зүйлийг эзэмшигч нь дараахь эрх эдэлнэ:

15.1.1. бүртгэл-мэдээллийн санд бүртгэгдсэн түүх, соёлын дурсгалт зүйлийг өмчлөгчтэй тохиролцсоны дагуу нийтэд дэлгэн үзүүлэх, сурталчлах, үзэсгэлэнд тавих, түүнээс олсон орлогын тодорхой хувийг авах;

15.1.2. түүх, соёлын дурсгалт зүйлийн зэрэглэлийг харгалзан холбогдох журмын дагуу тэдгээрийг түр солилцох, худалдаж авах;

15.1.3. түүх, соёлын дурсгалт зүйлийг сурвалжлан олж цуглуулах, шинэчлэн судлах.

15.2. Түүх, соёлын дурсгалт зүйлийг эзэмшигч нь дараахь үүрэг хүлээнэ:

15.2.1. энэ хуулийн 14.2.1, 14.2.3, 14.2.4.-т заасан үүрэг;

15.2.2. түүх, соёлын дурсгалт зүйлийг бүрэн бүтэн хадгалж, хамгаалах;

15.2.3. өмчлөгчийн зөвшөөрөлгүйгээр түүх, соёлын дурсгалт зүйлийг эзэмших, ашиглах эрхээ бусдад шилжүүлэхгүй байх.

16 дугаар зүйл. Түүх, соёлын дурсгалт зүйлийг худалдах

16.1. Түүх, соёлын дурсгалт зүйлийг худалдах, түр солилцох журмыг соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн тогтооно.

16.2. Хувийн өмчид байгаа түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг бусдад худалдах нөхцөлд өмчлөгчтэй тохиролцсоноор төр худалдан авна. Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийн үнийг харилцан тохиролцсоноор тогтоож төлөх бөгөөд энэ талаар маргаан гарвал шүүх шийдвэрлэнэ.

16.3.Түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг худалдах, бэлэглэх, өвлүүлэх зэргээр өмчлөх эрхээ гадаадын иргэн, харъяалалгүй хүнд шилжүүлэхийг хориглоно.

ЗУРГАДУГААР БҮЛЭГ

Соёлын өвийг хадгалж хамгаалах, өвлүүлэн уламжлуулах тогтолцоо

17 дугаар зүйл. Түүх, соёлын дурсгалт зүйлийг хадгалж, хамгаалах

17.1. Түүх, соёлын дурсгалт зүйлийн хадгалалт, хамгаалалтад соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон тухайн аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга хяналт тавина.

17.2. Түүх, соёлын дурсгалт зүйлийг тухайн орон нутагт нь хадгалах зарчим баримтална. Тухайн түүх, соёлын дурсгалт зүйлийн хадгалалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрлөөр улсын музейд шилжүүлэн хадгалж болно.

17.3. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн эрх зүйн хамгаалалтыг улсын, орон нутгийн, байгууллагын гэж ангилна. Улс, орон нутгийн хамгаалалтад байх түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн жагсаалтыг соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар тогтооно.

17.4. Төрийн өмчид байгаа үнэт металл, эрдэнийн үнэт чулуугаар хийсэн хосгүй үнэт дурсгалт зүйлийн жинхэнэ эхийг соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр эрдэнэсийн санд хадгална.

17.5. Эрдэнэсийн санд хадгалагдаж байгаа хосгүй үнэт дурсгалт зүйлийн хуулбарыг улсын болон тухайн аймаг, нийслэл, сумын музейд, бусад хосгүй үнэт дурсгалт зүйлийн жинхэнэ эхийг улсын музейд тус тус хадгална.

17.6. Эртний хот суурины үлдэгдэл, байшин барилга, уран барилгын цогцолбор зэрэг түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангах, харагдах сүр барааг хадгалах зорилгоор хамгаалалтын бүсийг Засгийн газар тогтооно.

17.7. Хамгаалалтын бүсэд байшин барилга барих, түүх, соёлын дурсгалт зүйлд хохирол учруулахуйц үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

17.8. Энэ хуулийн 17.6-д зааснаас бусад түүх, соёлын дурсгалт зүйл, археологийн дурсгал хадгалагдаж байгаа газар түүний хэвлийг хамгаалалтын бүсэд хамаарууль болно.

17.9. Соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, түүний аймаг, нийслэлийн Засаг дарга нь устах, эвдрэх, гэмтэх аюул учирч байгаа түүх, соёлын дурсгалт зүйлийг авран хамгаалах, сэргээн засварлах арга хэмжээг боловсруулж төвлөрсөн буюу орон нутгийн төсөв, сан, хандивын хөрөнгийн үндэсэн дээр хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна.

17.10. Хот суурин, барилга байгууламж барих, шинээр зам тавих, усан цахилгаан станц байгуулах, ашигт малтмалын хайгуул хийх, ашиглах, зэрэг аж ахуйн үйл ажиллагаа явуулахад зориулан газар олгоход түүх, археологийн мэргэжлийн байгууллагаар урьдчилан хайгуул, судалгаа хийлгэж, түүнээс зөвшөөрөл авна. Урьдчилан хайгуул хийлгэх, илэрсэн түүх, соёлын дурсгалт зүйлийг авран хамгаалах ажилд шаардагдах зардлыг барилга байгууламжийн захиалагч хариуцна.

17.11. Иргэн түүх, соёлын дурсгалт зүйлд аюул учирч байгаа, эсхүл учирч болзошгүй байдал олж илрүүлсэн бол энэ тухай холбогдох байгууллага, албан тушаалтанд нэн даруй мэдэгдэх, боломжтой бол хамгаалах арга хэмжээ авах үүрэгтэй.

17.12. Газрын хэвлийг ашиглах явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрвэл газрын хэвлийг ашиглагч нь ажлаа зогсоож энэ тухай сум, дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэнэ.

17.13. Түүх, соёлын үл хөдлөх дурсгалт зүйлийг соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын зөвшөөрөлгүйгээр хөдөлгөхийг хориглоно.

17.14. Түүх, соёлын хосгүй үнэт, үнэт дурсгалт зүйлийг өмчлөгч нь уг зүйлийг хадгалж, хамгаалах хэвийн нөхцөлийг хангана. Уг нөхцөлийг хангах боломжгүй бол эрдэнэсийн сан, улсын музейд хадгалуулж болно. Энэ тохиолдолд тэдгээрийг өмчлөгчтэй хийсэн гэрээний дагуу улсын даатгалд авна.

18 дугаар зүйл. Утга соёлын өвийг өвлүүлэн уламжлуулах

18.1. Соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон тухайн шатны Засаг дарга нь энэ хуулийн 5.5-д заасан жагсаалтад бүртгэгдсэн авъяастны өвлөсөн өвийг тухайн үндэстэн угсаатны түүх, уламжлал, ёс заншил, ахуй нөхцөлтэй нь уялдаатайгаар судалж, сурталчлах, өвлүүлэх, хамгаалах асуудлыг зохицуулна.

18.2. Соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь утга соёлын өвийг өвлөн тэзэгдийн авъяас билгийг хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэх, сурталчлах, билэг авъяастныг тодруулах зорилгоор 5 жил тутам улсын хэмжээнд ардын урлагийн их наадмыг зохион байгуулна.

19 дүгээр зүйл. Түүх, соёлын дурсгалт зүйлийг зөөж тээвэрлэх

19.1. Түүх, соёлын дурсгалт зүйлийг сурталчлах, судлах, хамгаалах зорилгоор хамгаалалтын найдвартай нөхцөлийг бүрдүүлсний үндэсэн дээр зөөж тээвэрлэнэ.

19.2. Түүх, соёлын дурсгалт зүйлийг зөөж

тээвэрлэх журмыг Засгийн газар тогтооно.

20 дугаар зүйл. Түүх, соёлын дурсгалт зүйлийг хилээр нэвтрүүлэх

20.1. Төрийн өмчлөлд байгаа түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг гагцхүү судалж шинжлэх, сурталчлах, сэргээн засварлах зорилгоор түүний хадгалалт, хамгаалалтын найдвартай нөхцөлийг бүрдүүлсний үндэсэн дээр Засгийн газрын тогтоосон хугацаа, эввшөөрөлтэйгээр улсын хилээр нэвтрүүлж болно.

20.2. Хувийн өмчид байгаа түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг эргүүлж авчрах нөхцөлтэйгээр судалж шинжлэх, сурталчлах, сэргээн засварлах, өмчлөгч өөрөө язгуур ахуйн хэрэглээний зориулалтаар ашиглахаар соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эввшөөрөлтэйгээр улсын хилээр нэвтрүүлж болно.

20.3. Түүх, соёлын үнэт дурсгалт зүйлийг эргүүлж авчрах нөхцөлтэй соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын эввшөөрлөөр түс тус гадаадад гаргаж болно.

20.4. Хууль бусаар гадаадад гаргасан түүх, соёлын дурсгалт зүйл, түүнчлэн энэ хуулийн 20.2, 20.3 -т заасны дагуу улсын хил гаргасан түүх, соёлын дурсгалт зүйл алдагдсан, үрэгдсэн тохиолдолд тэдгээрийг Монгол Улсын өмч болгон зарлах бөгөөд эргүүлж авчрах ажлыг соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуллага болон цагдаагийн байгуллага хууль тогтоомжид заасан журмын дагуу зохион байгуулна.

20.5. Шүүхийн шийдвэрээр төрийн өмчлөлд шилжүүлсэн болон хил нэвтрэх үед гаалийн байгууллагад хураагдсан түүх, соёлын дурсгалт зүйлийг соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуллага төрөл зүйлээр нь ялгаж хэлбэрийн байгуллагын сан хөмрөгт шилжүүлнэ.

21 дүгээр зүйл. Түүх, соёлын дурсгалт зүйлийг сэргээн засварлах

21.1. Түүх, соёлын дурсгалт зүйлийг сэргээн засварлах ажлыг соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас эрх олгосон мэргэжлийн байгуллага, иргэн судалгаа шинжилгээний үндэсэн дээр боловсруулсан сэргээн засварлах зураг төсөл, төсвийн дагуу гэрээгээр гүйцэтгэнэ.

21.2. Түүх, соёлын дурсгалт зүйлийг сэргээн засварлах ажлыг санхүүжүүлэх эх үүсвэр нь төвлөрсөн болон орон нутгийн төсөв, сан, байгууллага, иргэдээс оруулсан хандив, хөрөнгө оруулалт, түүх, соёлын дурсгалт зүйлийг өмчлөгчийн үйл ажиллагааны орлого байна.

ДОЛДУГААР БҮЛЭГ

Бусад зүйл

22 дугаар зүйл. Соёлын өвийг хамгаалахад идэвхтэй оролцсон иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг алдаршуулах, урамшуулах

22.1. Соёлын өвийг сурвалжлан олох, хадгалж хамгаалах, музей, архив, номын сангийн сан хөмрөгийг баяжуулах, алдагдсан, хууль бусаар хил нэвтрүүлсэн түүх, соёлын дурсгалт зүйлийг эрэн сурвалжлах, олж илрүүлэхэд хувь нэмэр оруулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг алдаршуулах, урамшуулах ажлыг соёл, шинжлэх ухааны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгуллага зохион байгуулна.

22.2. Иргэн, аж ахуйн нэгж, байгуллагыг алдаршуулах, урамшуулах журмыг Засгийн газар тогтооно.

23 дугаар зүйл. Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

23.1. Соёлын өвийг хамгаалах тухай хууль тогтоомж зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол мүүгч, сум, дүүргийн Засаг дарга, боловсрол, соёл, шинжлэх ухааны хяналтын улсын байцаагч гэм буруутай этгээдэд дараахь шийтгэл ногдуулна:

23.1.1. энэ хуулийн 8.1; 8.9; 11.4; 12.2; 12.3; 14.2; 15.2; 17.13 дахь заалтыг зөрчсөн бол иргэнийг 10000-20000, албан тушаалтныг 30000-60000, байгууллага, аж ахуйн нэгжийг 100000-250000 төгрөгөөр торгож, энэ хуулийн 12.2; 12.3; 17.13-т заасан зөрчлийг арилгуулах;

23.1.2. энэ хуулийн 9.4; 9.6; 13.2; 13.4 дэх заалтыг зөрчсөн бол иргэнийг 20000-50000, албан тушаалтныг 30000-60000 , байгууллага, аж ахуйн нэгжийг 80000-100000 төгрөгөөр торгох;

23.1.3. түүх, соёлын дурсгалт зүйлийг ашиглах, сурвалжлан олох, судалгаа шинжилгээ хийх, хувилан олшруулах, хуулбар хийх, хадгалж хамгаалах, зөөж тээвэрлэх журмыг зөрчсөн бол иргэнийг 20000-50000 , албан тушаалтныг 30000-60000, байгууллага, аж ахуйн нэгжийг 100000-150000 төгрөгөөр торгох;

23.1.4. энэ хуулийн 17.7; 17.10-ыг зөрчсөн бол 200000-250000 төгрөгөөр торгож, үйл ажиллагаг зогсоох, хууль бусаар олсон орлогыг хураах;

23.1.5. энэ хуулийн 20.3-ын дагуу түүх, соёлын үнэт, ердийн дурсгалт зүйлийг түр хугацаагаар улсын хилээр гаргаад тогтоосон хугацаандаа оруулж ирээгүй байгуллага, аж ахуйн нэгжийг 200000-250000 төгрөгөөр торгож, уг дурсгалт зүйлийг эрх бүхий байгууллагаас тогтоосон хугацаанд заавал авч ирүүлэх;

23.1.6. энэ хуулийн 16.3 дахь хэсгийг зөрчсөн бол тухайн түүх, соёлын хосгүй үнэт дурсгалт зүйлийг нь хурааж, иргэнийг 50000 хүртэл төгрөгөөр торгох.

МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 6 дугаар сарын 8-ны өдөр **Улаанбаатар хот**

ТҮҮХ,СОЁЛЫН ДУРСГАЛТ ЗҮЙЛИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 1994 оны 5 дугаар сарын 24-ны өдөр батлагдсан Түүх, соёлын дурсгалт зүйлийг хамгаалах тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Соёлын өвийг хамгаалах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 6 дугаар сарын 7-ны өдөр **Дугаар 50** **Улаанбаатар хот**

Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнд нэмэгдэл, зэрэг дэв олгох журам батлах тухай

Төрийн албаны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, 28 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалт, Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1."Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүний албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл, түүнийг олгох журам"-ыг 1 дүгээр, "Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүний төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, түүнийг олгох журам"-ыг 2 дугаар, "Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүний зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох журам"-ыг 3 дугаар хавсралтаар тус тус батлагдсугай.

2. Эрдмийн зэрэг, цол бүхий Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнд эрдмийн зэрэг, цолны нэмэгдэл олгоход Засгийн газраас батлагдсан "Төрийн албан хаагчид эрдмийн зэрэг, цолны нэмэгдэл олгох журам"-ыг баримталж байхаар тогтоосугай.

3.Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнд албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны болон зэрэг дэвийн нэмэгдэл олгохоД шаардагдах зардлыг Хүний эрхийн Үндэсний Комиссын жил бүрийн төсөвт тусгаж байхаар тогтоосугай.

4.Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнд олгох нэмэгдлийг 2001 оны 2 дугаар сарын 2-ны өдрөөс эхлэн тооцож олгосугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

Улсын Их Хурлын 2001 оны 50 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт

ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ГИШҮҮНИЙ АЛБАН АЖЛЫН ОНЦГОЙ НӨХЦӨЛИЙН НЭМЭГДЭЛ, ТҮҮНИЙГ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.Төрийн албаны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, 28 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалт, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнд албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл олгоход энэхүү журмыг мөрдөнө.

2.Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүний албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдэл нь тэдгээрт бүрэн эрхээ хараат бусаар хэрэгжүүлж, Үндэсэн хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад хуульд захирагдан хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг шударгаар хамгаалах үйл ажиллагаагаа явуулах өндөр хариуцлагатай албан үүргийг гүйцэтгэснийх нь төлөө төрөөс олгож байгаа урамшуулал, хараат бус байдлыг хангах баталгааны нэг мөн.

Хоёр. Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүний албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээ, түүнийг олгох

3.Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүний албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг зохих журмаар тогтоосон түүний албан тушаалын үндэсэн цалингийн 15 хувиар бодож сар бүр олгоно.

4.Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнд албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг бүрэн эрхийнх нь хугацаанд олгоно.

Улсын Их Хурлын 2001 оны 50 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ГИШҮҮНИЙ ТӨРИЙН АЛБА ХААСАН ХУГАЦААНЫ НЭМЭГДЭЛ, ТҮҮНИЙГ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1. Төрийн албаны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 4 дэх заалт, 28 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалт, Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн 22 дугаар зүйлд заасны дагуу Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнд төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл олгоход энэ журмыг мөрдөнө.

2. Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнд олгох төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл нь тэдний бүрэн эрхээ хараат бусаар хэрэгжүүлэх, хүний эрх, эрх чөлөө, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах үйл ажиллагаа явуулах баталгааны нэг мөн.

Хоёр. Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүний төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийн хэмжээ, түүнийг олгох

3. Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнд төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийг төрийн байгууллагад ажилласан хугацаог харгалзан түүний албан тушаалын үндсэн цалингаас дор дурдсан хувиар бодож олгоно:

Төрийн алба хаасан хугацаа /жилээр/	Төрийн алба хаасан хугацааны нэмэгдлийн хэмжээ /хувиар/
5-10	5
10-15	10
15-20	15
20-25	20
25-аас дээш	25

4.Төрийн алба хаасан хугацаанд дараахь хугацааг оруулан тооцно:

1/ төрийн албанд ажилласан;

2/ төрийн албанд ажиллах хугацаандаа мэргэжил, мэргэшлээ дээшлүүлсэн, аспирантур, докторантурт суралцсан;

3/ төрийн албанд ажиллах хугацаандаа жирэмсний, амаржсаны болон хүүль тогтоомжийн дагуу чөлөөтэй байсан.

5.Төрийн алба хаасан хугацааг Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүдийн хурлаар хэлэлцэн тодорхойлж, комиссын даргын тушаалаар нэмэгдэл олгох хувийг тогтоож байна.

6.Төрийн алба хаасан хугацааг тогтоох үндсэн баримт нь хөдөлмөрийн дэвтэр, нийгмийн даатгалын дэвтэр болно.

Улсын Их Хурлын 2001 оны 50 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт

МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ГИШҮҮНИЙ ЗӨРЭГ ДЭВ, ТҮҮНИЙ НЭМЭГДЭЛ ОЛГОХ ЖУРАМ

1. Энэ журмаар Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнд зөрөг дэв, түүний нэмэгдэл олгох асуудлыг зохицуулна.

2. Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнд Тэргүүн түшээ, дэд түшээ зөрөг дэв олгоно.

3. Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнд зөрөг дэв олгоход албан тушаал, төрийн алба хаасан хугацаа, урьд нь олгогдсон зөрөг дэв, ажил хэргийн чадварыг харгалзана.

4. Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүнийг зөрөг дэвийг Хүний эрхийн Үндэсний Комиссын санал болгосноор Монгол Улсын Ерөнхийлөгч олгоно.

5. Тэргүүн түшээ зөрөг дэвийн нэмэгдлийг үндсэн цалингийн 25 хувиар, дэд түшээ зөрөг дэвийн нэмэгдлийг үндсэн цалингийн 23 хувиар тус тус тооцож сар тутамд олгоно.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 6 дугаар сарын 7-ны өдөр | Дугаар 53 | Улаанбаатар хот

Төрийн зарим байгууллагын удирдах албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай Улсын Их Хурлын тогтоолд нэмэлт оруулах тухай

Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

"Төрийн зарим байгууллагын удирдах албан тушаалын ангилал, зэрэглэлийг тогтоох тухай" Улсын Их Хурлын 1995 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 42 дугаар тогтоол, мөн тогтоолын хавсралтын гарчиг болон эхний хэсэг дэх "Үндсэн хуулийн цэцийн" гэсний дараа ", Хүний эрхийн Үндэсний Комиссын"; мөн хавсралтын "Үндсэн хуулийн цэцийн ажлын алба" гэсэн хэсгийн дараа "Хүний эрхийн Үндэсний Комиссын ажлын алба" гэсэн 8 дахь хэсэг, түүнд "тэргүүн түшмэл" гэсэн ангиллын "АА-2" гэсэн зэрэглэлд хамаарах "ажлын албаны дарга", " эрхэлсэн түшмэл" гэсэн ангиллын "АА-5" гэсэн зэрэглэлд хамаарах "ахлах референт" гэсэн заалт тус тус нэмсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 6 дугаар сарын 8-ны өдөр | Дугаар 54 | Улаанбаатар хот

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөх тов тогтоох тухай

Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

товыг 2001 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн 15 цаг 00 минутад байхаар тогтоосугай.

Нацагийн Багабандийн Монгол Улсын Ерөнхийлөгчийн тангараг өргөх өдөр, цагийн

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 6 дугаар сарын 8-ны өдөр | Дугаар 55 | Улаанбаатар хот

Хөдөлмөрийн арбитрын дүрэм батлах тухай

Хөдөлмөрийн тухай хуулийн 118.8-д заасныг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

хавсралт ёсоор батлагдсугай.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА Л.ЭНЭБИШ

Хөдөлмөрийн арбитрын дүрмийг

Улсын Их Хурлын 2001 оны 55 дугаар тогтоолын хавсралт

ХӨДӨЛМӨРИЙН АРБИТРЫН ДҮРЭМ

Нэг.Нийтлэг үндэслэл

1.Хөдөлмөрийн хамтын маргааныг зуучлагчийн оролцоотой хэлэлцээд зөвшилцөлд хүрээгүй тохиолдолд энэхүү дүрмийг мөрдөнө.

2.Хөдөлмөрийн арбитрын /цаашид "арбитр" гэх/ үйл ажиллагааны зорилго нь хамтын гэрээ байгуулах, биелүүлэх, биелэлтэд хяналт тавих явцад тухайн гэрээгээр зохицуулах харилцааны талаар тодорхой шаардлага тавьж байгаа ажилтны төлөөлөгчид, хамт олныг төлөөлсөн үйлдвэрчний байгууллага болон ажил олгогч талуудын хооронд үүссэн маргааныг эвлэрүүлэхэд оршино.

3. Арбитр нь хөдөлмөрийн хамтын маргаан /цаашид хамтын "маргаан" гэх/-ыг хянан хэлэлцэхдээ талуудын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалж, тэдгээрийн төлөөлөгчийг оролцуулан зөвхөн маргаантай асуудлаар зөвлөмж гаргана.

4.Арбитр нь хамтын маргааны оролцогч талууд болон тухайн шатны Засаг даргын санал болгосон гурван арбитрчаас бүрдэх бөгөөд талууд тохиролцоонд хүрээгүй тохиолдолд Засаг дарга томилно.

5.Арбитрч нь хууль ёсыг дээдлэх, хөндлөнгийн нөлөөнд үл автах, шударга ёсыг хангах, ил тод, бодитой байх зарчмыг баримтлан ажиллаж, үйл ажиллагаандаа Хөдөлмөрийн тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж болон энэхүү дүрмийг дагаж мөрдөнө.

6.Хамтын маргааныг шийдвэрлэхэд оролцсон хугацаанд арбитрчийг үндсэн ажлаас нь чөлөөлж, дундаж цалин хөлстэй нь тэнцэх хэмжээний олговрыг хэрэв арбитрч нь хөдөлмөр эрхэлдэггүй бол ажлын хөлсийг хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 3 дахин нэмэгдүүлснээр тооцож маргааны оролцогч тал болох ажил олгогч нь олгоно.

7. Ажил олгогч нь арбитрчийг бичиг хэргийн техник хэрэгсэл, маргааныг хянан хэлэлцэх байр болон ажиллах нөхцөлөөр хангана.

Хоёр.Хөдөлмөрийн арбитрын болон маргааны оролцогч талуудын эрх, үүрэг

8.Арбитр нь дор дурдсан эрх эдэлнэ:

1/хамтын маргаантай холбоотой асуудлаар маргалдагч талуудаас тайлбар, тодорхойолт, маргааныг шийдвэрлэхэд шаардлагатай баримт бичиг, мэдээ, судалгаа холбогдох аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс гаргуулж авах,

2/ маргалдагч талуудын санал, хүсэлтийг сонсох ,

3/зуучлагч оролцсон хуралдааны материалтай танилцах, шаардлагатай бол мэргэжилтэн урьж зөвлөгөө авах, орчуулагч, шинжээч, магадлагч ажиллуулах, тэдэнд ажлын хөлс олгуулах асуудлыг шийдвэрлүүлэх .

9.Арбитр нь дор дурдсан үүрэг хүлээнэ:

1/хамтын маргаантай холбогдсон асуудлаар хуулиар тогтоосон нууцад хамаарах баримт бичиг, мэдээллийн нууцыг хадгалах,

2/арбитрын хурлаас гаргасан зөвлөмжийг маргааны оролцогчид тайлбарлах,

3/аж ахуйн нэгж, байгууллага, иргэнээс авсан баримт бичгийг асуудал шийдвэрлэгдсэний дараа буцаан өгөх.

10.Арбитрч өөрийг нь томилсон Засаг

даргад хамтын маргааныг шийдвэрлэсэн үр дүнгийн талаар танилцуулах үүрэгтэй.

11.Маргалдагч талууд дор дурдсан эрх эдэлнэ:

1/арбитрын хуралд биеэр оролцож тайлбар, үндэслэл, санал, хүсэлтээ гаргах, өөрийн төлөөлөгч, өмгөөлөгчийг хуралд оролцуулах,

2/арбитрын хурал болохоос өмнө маргаж байгаа зүйлийн талаар бичгээр тайлбар, тодорхойлолт гаргаж өгөх,

3/арбитрын хурлын тэмдэглэл, зөвлөмжтэй танилцах.

12.Маргалдагч талууд арбитрын хуралд хянан хэлэлцэж байгаа асуудлын талаар нотлох баримтыг гаргаж өгөх, арбитрчийн тавьсан шаардлагыг биелүүлэх үүрэг хүлээнэ.

Гурав.Хамтын маргааныг хөдөлмөрийн арбитраар хянан хэлэлцэх үйл ажиллагаа

13.Арбитрийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь арбитрийн хурал байх бөгөөд тухайн маргааныг эвлэрүүлэн зохицуулах үүрэг хүлээсэн гурван арбитрч нь маргааныг хэлэлцэхэд тэгш эрхтэй оролцох үүднээс дундаасаа аль нэгийгээ зөвхөн хурал даргалагчаар сонгоно.

14.Хурал даргалж байгаа арбитрч нь маргалдагч талууд, тэдгээрийн маргааны асуулгын талаар хуралд оролцогсдод эхэлж танилцуулна. Үүний дараа талууд санал зөрүүтэй асуудлаар өөрсдийн байр суурь, үндэслэлийг ажилтны төлөөлөгч дараа нь ажил олгогч талын төлөөлөгч тус тус танилцуулна.

15. Хамтын маргааныг арбитраар хэлэлцэх хуралд талуудаас тэнцүү тооны төлөөлөгчдийг оролцуулна. Маргалдагч тал тус бүр ахлагчаа томилох бөгөөд ахлагч нь өөрсдийн шаардлага, санал зөрүүтэй асуудлын үндэслэл, нөхцөл байдлыг нотолно.

16.Хурал дээр маргалдагч талуудад харилцан асуулт тавьж хариулт авах, тайлбар хийх, санал солилцох боломж олгоно. Хурал даргалж байгаа арбитрч нь талуудад маргаантай холбогдсон баримт, үзэлт болон шинжээчийн дүгнэлтийг танилцуулна.

17.Арбитр нь маргалдагч талуудаас хамааралгүйгээр холбогдох баримт, дүгнэлтийг бүх талаас нь судалж, маргалдагч талуудын үндэслэл, шаардлагыг сонссоны дараа тусгайлан зөвлөлдөж, олонхийн саналаар зөвлөмж гаргана. Арбитрч нь арбитрын хурлаар хэлэлцэж байгаа асуудлаар зөвлөмж гаргахад түдгэлзэх эрхгүй.

18.Хамтын маргаанд оролцогч талууд арбитрын зөвлөмжийг хүлээн авч хэрэгжүүлэхээр тохиролцоонд хүрсэн бол энэ тухай шийдвэрийг бичгээр гаргаж зөвлөмжийн заалт бүрийг хэрхэн биелүүлэх талаар уг шийдвэрт тусгана.

19.Арбитрын зөвлөмжийг маргаанд оролцогч талууд хүлээн зөвшөөрөөгүй буюу зөвшөөрөх боломжгүй гэж үзсэн тохиолдолд энэ тухайгаа арбитрч болон арбитрчийг томилсон Засаг даргад бичгээр мэдэгдэнэ.

20.Арбитр нь хурал болон хурлаас гадуур явагдсан бусад үйл ажиллагааны явцын тухай дэлгэрэнгүй тэмдэглэл хөтөлнө.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын
Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487



ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 26 (213)

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ:

- *Хэлэлцээр соёрхон батлах тухай*
- *Гэрээ соёрхон батлах тухай*

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ:

- *Монгол Улсын Төрийн хянан шалгах хорооны даргыг томилох тухай*
- *Зарим хүмүүсийг Төрийн хянан шалгах хорооны гишүүнээр томилох тухай*

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ:

- *Ардын болон гавьяат цол хүртээж, одон, медалиар шагнасан тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар

Улаанбаатар хот
2001 он

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Улаанбаатар хот 2001 оны долдугаар сарын 4 №26 (213)

Гарчиг

Нэг. МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

332. Хэлэлцээр соёрхон батлах тухай (2001-6-21-ний хууль) 686

333. Гэрээ соёрхон батлах тухай (2001-6-21-ний хууль) 686

Хоёр. МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

334. Монгол Улсын Төрийн хянан шалгах хорооны даргыг томилох тухай Дугаар 58 686

335. Зарим хүмүүсийг Төрийн хянан шалгах хорооны гишүүнээр томилох тухай Дугаар 59 686

Гурав. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

336. Жалелийн Хайруллад Монгол Улсын ардын эмч цол хүртээх тухай Дугаар 138 687

337. Балганы Бардоржид Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай Дугаар 139 687

338. Лхамжавын Сүхбаатарт Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай Дугаар 140 687

339. Дамдинжавын Жадамбаад Монгол Улсын гавьяат барилгачин цол хүртээх тухай Дугаар 141 688

340. Даржаагийн Бадарчид Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай Дугаар 142 688

341. Данзангийн Малчинхүүд Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай Дугаар 143 688

342. Дашнямын Цэрэндарьзавт Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай Дугаар 144 689

343. Мятавын Могноонд Монгол Улсын гавьяат хуульч цол хүртээх тухай Дугаар 145 689

344. Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай Дугаар 146 689

345. Жамбаагийн Батсүхийг "Шударга журам" медалиар шагнах тухай Дугаар 147 696

346. Вилли Лангег "Найрамдал" медалиар шагнах тухай Дугаар 148 696

347. В.Н.Финогеновыг "Найрамдал" медалиар шагнах тухай Дугаар 149 696

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 6 дугаар сарын 21-ний өдөр **Улаанбаатар хот**

ХЭЛЭЛЦЭЭР СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын Засгийн газар, Япон Улсын Олон улсын хамтын ажиллагааны банкны хооронд 2001 оны 3 дугаар сарын 26-ны өдөр байгуулсан Улаанбаатар хотын дөрөвдүгээр Дулааны цахилгаан станцыг шинэчлэх 2 дугаар төслийн зээлийн Хэлэлцээрийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батална.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2001 оны 6 дугаар сарын 21-ний өдөр **Улаанбаатар хот**

ГЭРЭЭ СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улс, Олон Улсын Хөгжлийн Ассоциаци хооронд 2001 оны 5 дугаар сарын 1-ний өдөр, Монгол Улс, Нордикийн Хөгжлийн Сан хооронд 2001 оны 5 дугаар сарын 9-ний өдөр тус тус байгуулсан Тээврийг хөгжүүлэх төслийн зээлийн Гэрээг Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон батална.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 6 дугаар сарын 21-ний өдөр **Дугаар 58** **Улаанбаатар хот**

Монгол Улсын Төрийн хянан шалгах хорооны даргыг томилох тухай

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Лхамсүрэнгийн Жавзмааг Монгол Улсын Төрийн хянан шалгах хорооны даргаар улируулан томилсугай.

2.Энэ тогтоолыг 2001 оны 6 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2001 оны 6 дугаар сарын 21-ний өдөр **Дугаар 59** **Улаанбаатар хот**

Зарим хүмүүсийг Төрийн хянан шалгах хорооны гишүүнээр томилох тухай

Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Лувсан-Очирын Дондог, Доржцэдэнгийн Дуламсүрэн, Самбуугийн Дэмбэрэл, Намсрайжавын Лувсанжав, Лувсанцэрэнгийн Пүрэвжав, Шадравын Түдэв нарыг Төрийн хянан шалгах хорооны гишүүнээр томилсугай.

2.Энэ тогтоолыг 2001 оны 6 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА **Л.ЭНЭБИШ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 6 дугаар сарын 15-ны өдөр | Дугаар 138 | Улаанбаатар хот

Жалелийн Хайруллад Монгол Улсын ардын эмч цол хүртээх тухай

Эрүүл мэндийн салбарт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж мэдрэлийн мэс заслын албыг бий болгож хөгжүүлэх, өвчний оношлогоо, эмчилгээний дэвшилтэт аргуудыг нэвтрүүлэх, мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд оруулж байгаа дорвитой хувь нэмрийг нь үнэлж П.Н.Шастины нэрэмжит Клиникийн төв эмнэлгийн мэдрэлийн мэс заслын зөвлөх эмч Жалелийн Хайруллад Монгол Улсын ардын эмч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 6 дугаар сарын 15-ны өдөр | Дугаар 139 | Улаанбаатар хот

Балганы Бардоржид Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай

Хүнсний аж үйлдвэрийн салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж шинэ бүтээл, оновчтой санал гаргаж, үйлдвэрлэлд нэвтрүүлэн хөдөлмөр хөнгөвчлөх, тоног төхөөрөмжийн үгсралт, засвар үйлчилгээг хугацаанд нь чанартай хийж үйлдвэрлэлийн жигд ажиллагааг хангахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Нийслэлийн үйлдвэрлэл, худалдааны "Талх чихэр" ХК-ийн засварчин Балганы Бардоржид Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 6 дугаар сарын 15-ны өдөр | Дугаар 140 | Улаанбаатар хот

Лхамжавын Сүхбаатарт Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай

Эрчим хүчний салбарт олон жил идэвх санаачилга, үр бүтээлтэй ажиллаж эрчим хүчний үйлдвэрүүдийн материаллаг баазыг бэхжүүлэх, техникийн шинэчлэл хийх, ажиллагсдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх, хөдөөг цахилгаан эрчим хүчээр хангахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Хөвсгөл аймгийн Эрчим хүчний үйлдвэрийн дарга Лхамжавын Сүхбаатарт Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 6 дугаар сарын 15-ны өдөр | Дугаар 141 | Улаанбаатар хот

Дамдинжавын Жадамбаад Монгол Улсын гавьяат барилгачин цол хүртээх тухай

Барилгын салбарт олон жил идэвх санаачилга, үр бүтээлтэй ажиллаж, хөдөлмөрийн хамт олныг чадамгай удирдан зохион байгуулж, барилга угсрах, материал бэлтгэх даалгаврыг тогтмол биелүүлэх, бүтээгдэхүүний чанарыг дээшлүүлж, барилгын салбарыг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Орхон аймгийн барилгын материал үйлдвэрлэлийн "Чингэлбөөнцагаан" ХХК-ийн захирал Дамдинжавын Жадамбаад Монгол Улсын гавьяат барилгачин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 6 дугаар сарын 15-ны өдөр | Дугаар 142 | Улаанбаатар хот

Даржаагийн Бадарчид Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай

Ерөнхий боловсролын сургуульд багш, захирлаар олон жил, үр бүтээлтэй ажиллаж удирдсан сургуулийн материаллаг баазыг бэхжүүлэх, багш нарын мэдлэг боловсрол, сурагчдын сурлага, хүмүүжлийн ажлын чанарыг дээшлүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Дорнод аймгийн Хэрлэн сумын нэгдүгээр дунд сургуулийн захирал Даржаагийн Бадарчид Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 6 дугаар сарын 15-ны өдөр | Дугаар 143 | Улаанбаатар хот

Данзангийн Малчинхүүд Монгол Улсын хүний гавьяат эмч цол хүртээх тухай

Эрүүл мэндийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж хүүхдийн өвчний эмчилгээ, оношлогооны дэвшилтэт аргуудыг нэвтрүүлж, олон зүүн хүүхдийг эмчлэн эдгэрүүлэх, хүүхдийн эндэгдлийг бууруулах болон мэргэжлийн боловсон хүчин бэлтгэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Эх нялхсын эрдэм шинжилгээний төвийн хүүхдийн ерөнхий зөвлөх эмч, Анагаах ухааны их сургуулийн багш Данзангийн Мачинхүүд Монгол Улсын гавьяат эмч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 6 дугаар сарын 15-ны өдөр | Дугаар 144 | Улаанбаатар хот

Дашнямын Цэрэндарьзавт Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээх тухай

Мэргэжлийн урлагийн байгууллагад олон жил идэвх санаачилга, үр бүтээлтэй ажиллаж жүжиг, киноны гол, туслах дүрүүдийг амжилттай бүтээж, тайз, дэлгэцийн болон хөшин урлагийг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлэн Нийслэлийн "Нүүдэл" театр хоршооны захирал Дашнямын Цэрэндарьзавт Монгол Улсын гавьяат жүжигчин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 6 дугаар сарын 15-ны өдөр | Дугаар 145 | Улаанбаатар хот

Мятавын Могноонд Монгол Улсын гавьяат хуульч цол хүртээх тухай

Шүүхийн байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж, шүүн таслах ажиллагаат хуулийн дагуу хийж, мэргэжлийн залуу боловсон хүчнийг сургаж дадлагажуулахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлэн Мятавын Могноонд Монгол Улсын гавьяат хуульч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ Н.БАГАБАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 6 дугаар сарын 15-ны өдөр | Дугаар 146 | Улаанбаатар хот

Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Аж ахуй, нийгэм, соёлын салбар, төрийн болон төрийн бус байгууллагад олон жил идэвх санаачилга, үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

СҮХБААТАРЫН ОДОНГООР:

Тогоочийн Гэндэн - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн иргэн, төр, захиргааны байгууллагын ахмад ажилтан

ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:

1. Михыбайн Аятхан - Баян-Өлгий аймгийн "Хангамж хан" ХХК-ийн зөвлөх

2. Бадамдоржийн Батхишиг - Монгол Улсын Ерөнхийлөгчийн эдийн засгийн бодлогын зөвлөх

3. Дондовын Самданмөнх - Архангай аймгийн Ахмадын хорооны дарга

4. Сандагийн Үржин - Дундговь аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн дарга

5. Амгалангийн Цоож - Өмнөговь аймгийн Засаг даргын дэргэдэх татварын хэлтсийн дарга

6. Мэндбаярын Цэнд-Аюуш - Нийслэлийн Хан-Уул дүүргийн өндөр настан, ахмад малын эмч

7. Рэнчингийн Ширэндэв - Нийслэлийн 52 дугаар дунд сургуулийн химийн багш

"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:

1. Галсангийн Авирмэд - Увс аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын албаны дарга

2. Чогжмаагийн Адъяа - Хэнтий аймгийн Хэрлэн сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн дарга

3. Бямбаагийн Алтанцэцэг - Нийслэлийн 70 дугаар цэцэрлэгийн багш

4. Чойжилжавын Баасанжав - Архангай аймгийн Прокурорын туслах прокурор

5. Күришбекийн Баделхан - Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын ахмадын хорооны дарга

6. Жунайн Бадрал - Нийслэлийн Баянгол дүүргийн эрүүл мэндийн нэгдлийн зөвлөх их эмч

7. Цэрэндуламын Базар - Монгол Улсын Засгийн газрын ахлах референт

8. Дамбачүлтэмийн Байлыхүү - Төрийн өмчийн хорооны даргын зөвлөх

9. Раднаагийн Бандий - Боловсрол, соёл, шинжлэх ухааны ямны "Боловсролын салбарын хөгжлийн хөтөлбөр"-ийн гүйцэтгэх захирал

10. Дандиагийн Барс - Хүнс, хөдөө аж ахуйн ямны мэргэжилтэн

11. Пунцагдашийн Батаа - Ховд аймгийн Жаргалант сумын "Мемо-Монголиа" ХХК-ийн ерөнхий захирал

12. Пунцагийн Батаахүү - Улсын нөөцийн газрын ахлах мэргэжилтэн

13. Лувсаннямын Батмөнх - АУИС-ийн эдийн засаг, хангамж эрхэлсэн дэд захирал

14. Сүрэнгийн Бат-Очир - УБТЗ-ын зорчигч тээврийн албаны дарга

15. Бэгзийн Бат-Өлзий - Улаанбаатар төмөр замын харьяа Дорноговь аймгийн Даланжаргалан сум дахь чулуун заводын дарга

16. Дамдинжавын Батсүх - Төрийн өмчийн хорооны төрийн өмчийн төлөөлөл, удирдлагын газрын дарга

17. Жанчивдоржийн Баярхүү - Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын ажилтан

18. Ойдовын Болд - Монголын үлгэрч, туульч, ерөөлч, магтаалчдын үндэсний төвийн тэргүүн

19. Ширнэнгийн Бороодой - Увс аймгийн Ховд сумын Засаг даргын Тамгын газрын дарга

20. Дамдинсүрэнгийн Буян-Өлзий - Нийслэлийн "Сүлжээ" ХК-ийн сүлжигч

21. Манханы Будээ - Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газрын байцаагч

22. Бавын Бямбаа - Өмнөговь аймгийн Ноён сумын Ахмадын хорооны дарга

23. Нямаагийн Бямбажав - Боловсрол, соёл, шинжлэх ухааны ямны соёл урлагийн сангийн гүйцэтгэх захирал

24. Пэрэнлэйн Бямбажав - Хөдөө аж ахуйн хоршоологчдын Увс аймгийн холбооны тэргүүн

25. Чойжавын Бямбажав - Ховд аймгийн Засаг даргын Тамгын газрын түшмэл

26. Дэлэггаравын Бямбасүрэн - Нийслэлийн 82 дугаар цэцэрлэгийн эрхлэгч

27. Жамцын Бямбасүрэн - Дорнод аймгийн Хэрлэн сумын 1 дүгээр дунд сургуулийн химич-биологийн багш

28. Цэзэхүүгийн Бярваа - Дорнод аймгийн Дулааны цахилгаан станцын хэлтсийн дарга

29. Шоонуугийн Вандансэнгээ - Хүүхэд залуучуудын театр киноны хүрээлэнгийн туслах найруулагч

30. Өлзийбатын Ганбаатар - Архангай аймгийн Ихтамир сумын дунд сургуулийн хичээлийн эрхлэгч

31. Тогмидын Гантөмөр - Нийслэлийн Баянзүрх дүүргийн Засаг дарга

32. Дашзэвэгийн Ганхуяг - Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын референт

33. Бямбадоржийн Гомбо - Дипломат байгууллагын үйлчилгээ, аж ахуйн газрын дарга

34. Цэвээний Гомбо - Нийслэлийн "Улаанбаатар хивс" ХК-ийн засварчин

35. Гэпилийн Гомбодорж - Хэнтий аймгийн Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Өнхөрхаан хотын захирагч

36. Дүгэрсүрэнгийн Даваадорж - Нийслэлийн прокурор

37. Сүрэнгийн Даваадорж - Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын түшмэл

38. Цэзэнгээгийн Даваанам - Увс аймгийн Улаангом сумын "Түшиг даатгал" компанийн захирал

39. Дамдинсамбуугийн Дагвадаш - Нийслэлийн 39 дүгээр дунд сургуулийн монгол хэл, уран зохиолын багш

40. Сүхээгийн Дамбасүрэн - Нийслэлийн 20 дугаар дунд сургуулийн зураг хөдөлмөрийн багш

41. Далхын Дамбий - Хөвсгөл аймгийн Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогч

42. Цэндийн Дамдин - Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын референт

43. Лхаасүрэнгийн Дамдинпүрэв - Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын санхүү эдийн засгийн бодлогын хэлтсийн төсвийн ерөнхий нягтлан бодогч

44. Хайдавын Дандийжав - Дорнод аймгийн Засаг даргын Тамгын газрын ажилтан

45. Сахабагийн Даукен - Баян-Өлгий аймгийн Буянт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн дарга

46. Даржаагийн Дашдорж - Хэнтий аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн дарга

47. Доржсовдын Дашзэвэг - Нийслэлийн "Монголын алт" ХХК-ийн үйлдвэрлэл эрхэлсэн захирал

48. Өлзий-Очирын Дашлхүндэв - Завхан аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга

49. Жамбын Дашням - Өмнөговь аймгийн Даланзадгад сумын өндөр настан, төр захиргааны байгууллагын ахмад ажилтан

50. Зундуйн Дашцэдэн - Булган аймгийн Бүрэгхангай сумын Засаг дарга

51. Сэр-Одын Доёддорж - Нийслэлийн 47 дугаар дунд сургуулийн хичээлийн эрхлэгч

52. Вандуйн Должин - Нийслэлийн 93 дугаар дунд сургуулийн хичээлийн эрхлэгч

53. Сандагийн Дорж - Өмнөговь аймгийн Баяндалай сумын Засаг даргын Тамгын газрын татварын улсын байцаагч

54. Одхүүгийн Дуламдорж - Баянхонгор аймгийн Богд сумын Засаг дарга

55. Цэдэвсүрэнгийн Дэлгэрбуян - Дундговь аймгийн Ахмадын хорооны дарга

56. Гончигчүлтэмийн Дэмбэрэл - Шуудан, цахилгаан холбооны газрын захиргаа, удирдлагын хэлтсийн дарга

57. Гүндсамбын Дэмбэрэл - Завхан аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын албаны улсын хянан байцаагч

58. Дашийн Жавзан - Хөвсгөл аймгийн Мөрөн сумын "Цацал" ХЭАА-н эзэн

59. Цэвэлийн Жадамбаа - Хэнтий аймгийн Хэрлэн сум дахь зам засвар арчлалтын "Харгуй" компанийн жолооч

60. Цэрэндоржийн Жамбалжамц - Булган аймгийн Гурванбулаг сумын Засаг даргын орлогч

61. Доржийн Жамсранжав - Улсын багшийн их сургуулийн харьяа Дорнод аймаг дахь багшийн коллежийн тэнхмийн эрхлэгч

62. Сандагдоржийн Жамьянсүрэн - Нийслэлийн "АПУ" ХК-ийн гүйцэтгэх захирал

63. Лхагвын Жаргал - Хэдөө аж ахуйн их сургуулийн эдийн засгийн факультетийн багш

64. Гомбожавын Жигжидсүрэн - Үйлдвэр, худалдааны улсын хяналтын албаны улсын ахлах байцаагч

65. Балжиннямын Зандраа - Өмнөговь аймгийн Засаг даргын Тамгын газрын хэлтсийн дарга

66. Очирбатын Зандраа - Сэлэнгэ аймгийн Хянан шалгах хорооны хянан байцаагч

67. Бат-Очирын Зоригт - МОНЦАМЭ агентлагийн сурвалжлагч

68. Маулетийн Зулькафиль - Монгол улсын их сургуулийн сэтгүүл зүйн тэнхмийн эрхлэгч

69. Раашийн Ишцог - Монгол Улсын Дээд

шүүхийн мэргэжилтэн

70. Ядамжавын Лосолсүрэн - "Их засаг" их сургуулийн төрүүлэн дэд захирал

71. Дамдинсүрэнгийн Лхагважав - Булган аймгийн Засаг даргын дэргэдэх статистикийн хэлтсийн мэргэжилтэн

72. Пэлжээгийн Лхамсүрэн - Нийслэлийн "Монгени" цогцолбор сургуулийн бага ангийн багш

73. Балжийн Магсаржав - Нийслэлийн Багануур дүүргийн Цахилгаан шугам сүлжээний газрын ээлжийн монтёр

74. Цэрэнгийн Мөнхөө - Дорнод аймгийн Хэрлэн сумын өндөр настан

75. Вангүрийн Мэргэнбаатар - "Монголросцветмет" нэгдлийн харьяа Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэрийн жолооч

76. Довдонгийн Мянгаа - Халдварт өвчин судлалын үндэсний төвийн сүрьеэгийн клиникийн эмнэлгийн зөвлөх эмч

77. Өлзийтийн Мяхлай - Булган аймгийн ахмадын хорооны дарга

78. Жамьяндоржийн Найгал - Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн нарийн бичгийн дарга

79. Насанбуянгийн Намсрай - Улсын Багшийн их сургуулийн математик-статистикийн факультетийн багш

80. Нямжавын Нансалжав - Шуудан, цахилгаан холбооны газрын ахлах мэргэжилтэн

81. Дашдондогийн Нацагсүрэн - Гадаадын хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагийн мэргэжилтэн

82. Лувсангийн Нэргүй - Нийслэлийн үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны "Улаанбаатар зочид буудал" ХК-ийн дэд захирал

83. Сэрээнэнхоролын Нямдолгор - Нийслэлийн "Талх чихэр" ХК-ийн ажилчин

84. Долгоржавын Ням-Осор - Улаанбаатар төмөр замын Замын 2 дугаар ангийн дарга

85. Даваагийн Ооргой - Нийслэлийн "Улаанбаатар хивс" ХК-ийн засварчин

86. Лувсанрэнчингийн Отгон - "Монголросцветмет" нэгдлийн харьяа Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэрийн ерөнхий маркшейдер

87. Мягмарын Отгонцэцэг - Нийслэлийн үйлдвэр, худалдааны "Говь" ХК-ийн ахлах эдийн засагч

88. Гончигийн Очирбат - Ховд аймгийн Жаргалант сумын 1 дүгээр дунд сургуулийн хичээлийн эрхлэгч

89. Юндэнгийн Очирхүрээ - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн өндөр настан, төр захиргааны ахмад ажилтан

90. Сангижанцангийн Өлзийбат - Нягтлан бодох бүртгэлийн "Мандах бүртгэл" дээд сургуулийн захирал

91. Лувсангийн Өнөр - Нийслэлийн 21 дүгээр дунд сургуулийн газар зүйн багш

92. Төмөрийн Өнөр - Ховд аймгийн шүүгч

93. Бяхарын Раднаа - Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Засаг дарга

94. Мөнхдалайн Ринчин - Цагаатгах ажлыг удирдан зохион байгуулах улсын комиссын харьяа улс төрийн хэлмэгдэгсдийн судалгааны төвийн захирал

95. Нацагийн Сандуйжав - Улсын ерөнхий прокурорын газрын хяналтын прокурор

96. Хүрлээгийн Санжмятав - Мал аж ахуйн эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан

97. Цэрэнтогтохын Сарантуяа - Дорнод аймгийн Хэрлэн сумын 10 дугаар цэцэрлэгийн эрхлэгч

98. Хурманбайн Смагуль - Баян-Өлгий аймгийн Өлгий сумын хүнсний "Азык" ХК-ийн слесарьч

99. Цэвэгийн Тавьхиа - Баян-Өлгий аймгийн Буянт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ажилтан

100. Цэвэгмидийн Тогтох - Өмнөговь аймгийн Засаг даргын дэргэдэх Мэргэжлийн хяналтын албаны улсын байцаагч

101. Цэрэнгийн Түмэн - Сэлэнгэ аймгийн прокурорын орлогч прокурор

102. Дагийжанчивын Түмээ - Булган аймгийн

Баян-Агт сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн дарга

103. Тудэвийн Тэрхэнбэ - Өвөрхангай аймгийн сум дундын 1 дүгээр шүүхийн нарийн бичгийн дарга

104. Ойдовын Хонгор - Төрийн өмчийн хорооны албаны дарга

105. Арсэдийн Хоогой - Баянхонгор аймгийн Буугаагаан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн дарга

106. Дамбасүрэнгийн Хуулин - Баянхонгор аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн ажлын албаны ажилтан

107. Самбуугийн Хүнийхүү - Нийслэлийн үйлдвэр, худалдааны "Хилэм-ОСТ" ХХК-ийн ерөнхий захирал

108. Содномцогийн Цогсүрэн - Төрийн өмчийн хорооны мэргэжилтэн

109. Тавхайн Цэвэлмаа - Нийслэлийн Баянгол дүүргийн өндөр настан

110. Чүлтэмийн Цэвэлмаа - Нийслэлийн Баянгол дүүргийн "Эрдмийн ундраа" боготолбор сургуулийн дэд захирал

111. Гэвээгийн Цэвээнжав - Увс аймгийн Засаг даргын дэргэдэх санхүүгийн хяналт шалгалтын албаны дарга

112. Даваагийн Цэгээнжав - Клиникийн 3 дугаар эмнэлгийн зүрхний мэс заслын тасгийн эрхлэгч

113. Сэрээтэрийн Цэдэнсодном - Өмнөговь аймгийн Даланзадгад сумын 1 дүгээр дунд сургуулийн математикийн багш

114. Лувсандаржаагийн Цэргээ - Хэнтий аймгийн Баянхутаг сумын Засаг дарга

115. Дэчингомбын Цэрэндолгор - Хэнтий аймгийн шүүхийн шүүгч

116. Лувсаншаравын Цэдэндорж - Мал эмнэлгийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан

117. Чанцалын Цэрэндулам - Нийслэлийн "Улаанбаатар хивс" ХК-ийн сургалтын инженер

118. Бадзийин Цэрэннамжил - МОНЦАМЭ агентлагийн дотоод мэдээллийн хариуцлагатай редактор

119. Ширхүүгийн Цэдэг - Завхан аймгийн Засаг даргын дэргэдэх нийгмийн даатгалын хэлтсийн орон тооны бус байцаагч

120. Цэрэндондовын Чанцаа - "Монгол даатгал" компанийн Завхан аймаг дахь салбарын захирал

121. Пунцагдоржийн Шагдар - МОНЦАМЭ агентлагийн Москва дахь суврагжлагч

122. Санжийн Шархүү - Сүхбаатар аймгийн нефть хангамжийн баазын мэргэжилтэн

123. Амгаагийн Ширэндэв - Нийслэлийн прокурорын газрын хяналтын прокурор

124. Галсангийн Элдэвсүрэн - Нийслэлийн Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын дарга

125. Бэх-Очирын Энх-Амгалан - Хөвсгөл аймгийн Бүрэнтогтох сумын Засаг даргын орлогч

126. Пүрэвдоржийн Энхтуяа - Сүхбаатар аймгийн Түмэнцогт сумын засаг дарга

127. Долгорсүрэнгийн Энхээ - Сэлэнгэ аймгийн шүүхийн шүүгч

128. Хандын Энэбиш - Баянхонгор аймгийн Засаг даргын Тамгын газрын мэргэжилтэн

129. Түдэвдоржийн Эрхэмбаатар - Эрүүл мэндийн яамны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга

130. Баатарын Ядамсүрэн - Увс аймгийн Улаангом сумын үйлдвэрлэл, үйлчилгээний "Алтан хөвийн оргил" ХХК-ийн жолооч

ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1.Цэнд-Аюушийн Алимаа-Нийслэлийн Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн нэгдлийн чанарын менежер

2. Хүрлээгийн Алтанзүрх - Нийслэлийн Баянгол дүүргийн ахлах прокурор

3. Цэдэнпилийн Алтанхуяаг - Нийслэлийн "Зоос гоёл" ХХК-ийн ажилчин

4. Содовын Алтанцэцэг - Дорнод аймгийн төв номын сангийн эрхлэгч

5. Мамилагийн Алтынай - Баян-Өлгий аймгийн Өлгий сумын хүнсний "Азык" ХК-ийн ерөнхий нягтлан бодогч

6. Самбуугийн Бааванхүү - Завхан аймгийн Цагаанхайрхан сумын Цэцэрлэг багийн Засаг дарга

7. Дэмбэрэлийн Баасанжав - "Монголросцветмет" нэгдлийн харьяа Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэрийн жолооч

8. Бавалын Баатар - Хэнтий аймгийн шүүхийн ерөнхий шүүгч

9. Лувсансодовын Батаа - Булган аймгийн

Гурванбулаг сумын хүний эмнэлэгийн бага эмч

10. Доржийн Батжаргал - Нийслэлийн "Сүлжээ" ХК-ийн оёдолчин

11. Осорын Бат-Өлзий - Хүүхэд залуучуудын театр, киноны хүрээлэнгийн жүжигчин

12. Хийровын Баяндай - Төрийн өмчийн хорооны мэргэжилтэн

13. Жамцдоржийн Баяраа - Өмнөговь аймгийн Баяндалай сумын Засаг дарга

14. Гонгорын Буяндэлгэр - Дундговь аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн байцаагч инженер

15. Дамдинсүрэнгийн Бямбахүү- Булган аймгийн Засаг даргын Тамгын газрын жолооч

16. Чүлтэмсүрэнгийн Бямбасүрэн - Дэлхийн эрүүл мэндийн байгууллагын төлөөлөгчийн газрын ажилтан

17. Банзрагчийн Ганбаатар - Өмнөговь аймгийн Даланзадгад сумын барилга үйлдвэрлэлийн "Говь гурван сайхан" ХК-ийн бригадын дарга

18. Шаравжамцын Ганбаатар - "Монголросцветмет" нэгдлийн харьяа Бор-Өндөрийн уулын баяжуулах үйлдвэрийн баяжуулах фабрикийн засварчин

19. Лхагвасүрэнгийн Ганболд - Булган аймгийн Бүрэгхангай сумын Засаг даргын Тамгын газрын дарга

20. Цэгмидийн Ганзориг - Дорнод аймгийн Хөгжимт драмын театрын бүжигчин

21. Жигжидийн Ганхуяг - Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газрын ахлах мэргэжилтэн

22. Баттогтохын Гомбогүр - Завхан аймгийн Цэцэн-Уул сумын Засаг даргын Тамгын газрын дарга

23. Бадамцоогийн Готовдорж - Өмнөговь аймгийн шүүхийн жолооч

24. Зундүй-Осорын Гүнсэндорж - Дорноговь аймгийн Засаг даргын Тамгын газрын жолооч

25. Цамбын Даш - Орхон аймгийн сум дундын шүүхийн нарийн бичгийн дарга

26. Дагвын Довдон - Увс аймгийн Засаг даргын Тамгын газрын мужаан, цахилгаанчин

27. Бадарчийн Должинжав - Булган аймгийн Хишиг-Өндөр сумын "Ариун-Хайрхан" ХХК-ийн механикч

28. Ванчинсүрэнгийн Доржготов - Нийслэлийн 73 дугаар дунд сургуулийн захирал

29. Чимэдийн Доржсонин - Хөвсгөл аймгийн Мөрөн сумын 5 дугаар багийн Засаг дарга

30. Пунцайн Дүүжий - Хөвсгөл аймгийн Улаан-Уул сумын Засаг даргын Тамгын газрын бичиг хэргийн эрхлэгч

31. Отгоны Дэмбэрэл - МҮЭ-ийн Өмнөговь аймгийн холбооны нягтлан бодогч

32. Омбоогийн Жамбалдорж - Архангай аймгийн Өндер-Улаан сумын дунд сургуулийн хичээлийн эрхлэгч

33. Дэлэгийн Жанцанхорол - Хүнс, хөдөө аж ахуйн яамны төрийн захиргааны удирдлагын газрын дарга

34. Нямжавын Жаргалсайхан - Эрүүл мэндийн яамны хэлтсийн дарга

35. Данзанжамцын Жаргалцэцэг - Хэнтий аймгийн Галшар сумын Засаг даргын Тамгын газрын үйлчлэгч

36. Ожилдайн Журай - Нийслэлийн "Талх чихэр" ХК-ийн ажилчин

37.*Янживын Зунгарав - Увс аймгийн Улаангом сумын Засаг даргын Тамгын газрын түшмэл

38. Түдэвийн Лувсанбүд - Хүнс, хөдөө аж ахуйн яамны Мэдээлэл хяналт-шинжилгээ, үнэлгээний газрын орлогч дарга

39. Сэрээтэрийн Лхамноржин - Завхан аймгийн Цагаанхайрхан сумын Засаг даргын Тамгын газрын бичээч, бичиг хэргийн эрхлэгч

40. Бавуудоржийн Махбал - Завхан аймгийн Цагаанхайрхан сумын Засаг даргын Тамгын газрын ерөнхий нягтлан бодогч

41. Дарийн Нармандах - Архангай аймгийн Өгийнуур сумын дунд сургуулийн бага ангийн багш

42. Дамдинсүрэнгийн Нацаг - Баянхонгор аймгийн сум дундын шүүхийн ерөнхий шүүгч

43. Намсрайн Норовсамбуу - Булган аймгийн Шуудан холбооны албаны ажилтан

44. Сэрээгийн Нямдорж - Өмнөговь аймгийн Гал түймэртэй тэмцэх албаны салааны захирагч

45. Ожингийн Нямсүрэн - Хэнтий аймгийн Дэлгэрэхаан сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн дарга

46. Тогтохын Нямсүрэн - Нийслэлийн "Зоос гоёл" ХХК-ийн чанар шалгагч

47. Жамбалдоржийн Оюун - Төрийн өмчийн хорооны мэргэжилтэн

48. Чойжилсүрэнгийн Оюунцэцэг - Гадаадын

-хөрөнгө оруулалт, гадаад худалдааны агентлагийн ахлах мэргэжилтэн

49. Дамдинсүрэнгийн Пүрэвдорж - Булган аймгийн Гурванбулаг сумын малчин

50. Хаянхирваагийн Пүрэвжав - Нийслэлийн "Улаанбаатар хивс" ХК-ийн зохион бүтээгч

51. Жамцын Роза - Нийслэлийн 13 дугаар дунд сургуулийн монгол хэл, уран зохиолын багш

52. Шагтавын Самбуу - Увс аймгийн Улаангом сумын 5 дугаар багийн Засаг дарга

53. Санжаажамцын Сурмаажав - Завхан аймгийн Идэр сумын Засаг даргын Тамгын газрын ажилтан

54. Чулууны Сүрэнжав - Хэнтий аймгийн Хэрлэн сум дахь зам засвар арчлалтын "Харгуй" компанийн ажилчин

55. Пэрэнлэйн Төмөрбаатар - Булган аймгийн Шүүхийн шүүгч

56. Санжийн Төмөрбаатар - Архангай аймгийн Төвшрүүлэх сумын дунд сургуулийн багш

57. Тогтохбаярын Төмөрбаатар - Архангай аймгийн Хайрхан сумын Иргэдийн төлөөлөгдийн хурлын тэргүүлэгчдийн дарга

58. Лувсанцэрэнгийн Тунгалаг - МОНЦАМЭ агентлагийн хяналтын техникч

59. Лувсанбалдангийн Туяа - Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн орос хэл, уран зохиолын багш

60. Лхамсүрэнгийн Уранчимэг - Булган аймгийн Нийтийн аж ахуйн газрын худгийн моторчин

61. Хишигтийн Уранчимэг - Нийслэлийн үйлдвэр худалдааны "Говь" ХК-ийн ажилчин

62. Цэвээний Хадхүү - Өмнөговь аймгийн Ханбогд сумын эрчим хүч дулааны хангамжийн "Хан дизель" орон нутгийн өмчит үйлдвэрийн газрын захирал

63. Дэмчигсүрэнгийн Хуяг - Нийслэлийн Багануур дүүргийн Цахилгаан, шугам сүлжээний газрын орлогч дарга

64. Санзайн Цэен - Өмнөговь аймгийн Дулааны цахилгаан станцын эдийн засагч

65. Отгоны Цэнд - Улсын ерөнхий прокурорын газрын үйлчлэгч

66. Дугарын Цэндсүрэн - Нийслэлийн "Улаанбаатар хивс" ХК-ийн ерөнхий механикч

67. Далхжавын Цэрэн - Хэнтий аймгийн Хэрлэн сумын худалдаа, үйлчилгээний "Өндөрхаан Уул" ХХК-ийн худалдагч

68. Төмөрпүрэвийн Цэрэннадмид - Нийслэлийн "Монгени" цогцолбор сургуулийн багш ангийн багш

69. Лхамсүрэнгийн Цэцгээ - Увс аймгийн Засаг даргын Тамгын газрын үйлчлэгч

70. Оригийн Цэцгээ - Нийслэлийн 47 дугаар дунд сургуулийн бага ангийн багш

71. Равдангийн Цэцгээ - Гэмтэл согог, сэргээн засалтын төв эмнэлгийн сэхээн амьдруулах тасгийн их эмч

72. Гомбодоржийн Цэцэгдарь - Эрүүл мэндийн яамны мэргэжилтэн

73. Пүрэвдоржийн Цэцэгмаа - Төрийн өмчийн хорооны мэргэжилтэн

74. Бадамдоржийн Цацэг- Очир - Төрийн өмчийн хорооны газрын дарга

75. Сумъяагийн Чагцаа - Нийслэлийн 13 дугаар дунд сургуулийн математикийн багш

76. Дашравдангийн Энхтуяа - Хүнс, хөдөө аж ахуйн яамны бичээч

77. Тэрбишийн Энхтуяа - Дорнод аймгийн Шүүхийн ерөнхий шүүгч

78. Маамуугийн Эрдэнэ - Увс аймгийн Улаангом сумын 1 дүгээр дунд сургуулийн дүү хөгжмийн багш

79. Данзангийн Эрдэнэбилэг - Өмнөговь аймгийн Сум дундын шүүхийн ерөнхий шүүгч

ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:

1. Лханаагийн Бат-Өлзий - Цагдаагийн ерөнхий газрын эрүүгийн цагдаагийн газрын 2 дугаар хэлтсийн тасгийн дарга, цагдаагийн ахмад

2. Оюунчимэгийн Болдбаатар - Цагдаагийн ерөнхий газрын криминалистик төвийн ахлах шинжээч, цагдаагийн ахлах дэслэгч

3. Дашхүүгийн Очгэрэл - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн Засаг даргын дэргэдэх цагдаагийн хэлтсийн эрүүгийн төлөөлөгч, цагдаагийн ахлах дэслэгч

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 6 дугаар сарын 15-ны өдөр **Дугаар 147** **Улаанбаатар хот**

Жамбаагийн Батсүхийг "Шударга журам" медалиар шагнах тухай

Эр зориг, авхаалж самбаа гарган галын аюулаас хүүхдүүдийн амь аварч, иргэний үүргээ нэр төртэй биелүүлсэн Дарханы төмөрлөгийн үйлдвэрийн Улаанбаатар хот дахь төлөөлөгчийн газрын нярав Жамбаагийн Батсүхийг "Шударга журам" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 6 дугаар сарын 19-ний өдөр **Дугаар 148** **Улаанбаатар хот**

Вилли Лангег "Найрамдал" медалиар шагнах тухай

Монгол Улсын шүүхийн байгууллагуудын материаллаг баазыг бэхжүүлэх, шүүгчдийн мэргэжлийг дээшлүүлэхэд оруулж буй хувь нэмрийг нь үнэлж ХБНГУ-ын Ханнс Зайделийн сангийн Монголын асуудал хариуцсан хэлтсийн орлогч дарга Вилли Лангег "Найрамдал" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2001 оны 6 дугаар сарын 19-ний өдөр **Дугаар 149** **Улаанбаатар хот**

В.Н.Финогеновыг "Найрамдал" медалиар шагнах тухай

Монгол Улс, ОХУ-ын хамтын ажиллагааг өргөжүүлэн бэхжүүлэх, уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн эдийн засгийн үр ашгийг дээшлүүлэхэд оруулж буй хувь нэмрийг нь үнэлж Монгол-Оросын хамтарсан уул уурхайн баяжуулах "Эрдэнэт" үйлдвэрийн Оросын талын "Зарубежцветмет" нэгдлийн ерөнхий мэргэжилтэн Василий Никитович Финогеновыг "Найрамдал" медалиар шагнасугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ **Н.БАГАБАНДИ**

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
Хаяг: «Төрийн мэдээлэл» эмхтгэлийн зөвлөл

Улаанбаатар-12 ☎ 329612
Төрийн ордон Индекс 14003

Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.

☎ 329487